



**“АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦИЙН II
БҮЛГИЙН (УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА
ХЭМЖЭЭ) ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ
СУДЛАХ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

(НҮБХХ-ийн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох
ажиллагааг дэмжих нь”
төсөл, Авлигатай тэмцэх газар 2014.05.05-
2014.07.04)

Гэрээний дугаар: Б\14-007

2014.07.09

ОРШИЛ

“Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн II бүлэг (Урьдчилан сэргийлэх арга хэмжээ)-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах” Зөвлөх үйлчилгээний энэхүү сонирхолтой ажлыг гүйцэтгэх боломж олгосон НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн хамт олон, Улсын Их Хурлын Тамгын газрын хэрэгжүүлж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл, уг төслийн захирал Д.Болдбаатар, НҮБХХ-ийн төслийн менежер Г.Золжаргал, Авлигатай тэмцэх газрын хамт олон, тус газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Б.Бат-Отгон, түүний дотор биднийг дэмжиж өдөр тутам хамтран ажилласан тус хэлтсийн комиссар С.Галбадрах, үнэтэй санал зөвлөмжөө өгсөн бүх хүмүүст гүн талархал илэрхийлж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүний “*Авлигатай тэмцэх дэлхийн хамгийн хүчтэй эрх зүйн зэвсэг*” хэмээн тодорхойлсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенци /Конвенци/- ийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2003 оны 10 дугаар сарын 31-ний 58/4 тоот тогтоолоороо баталсан байдаг. Монгол Улсын Их Хурал конвенцийг 2005 оны 10 дугаар сарын 27-нд соёрхон баталж, Конвенцийг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг 2006 оны 1 дүгээр сарын 11-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар хүргүүлж, улмаар Конвенци нь манай улсын хувьд 2006 оны 2 дугаар сарын 10-наас эхлэн дотоодын хууль, тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Энэхүү Конвенци нь авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд чиглэсэн хэм хэмжээг тогтоосон 8 бүлэг, 71 зүйлтэй олон улсын томоохон баримт бичиг бөгөөд өнөөдрийн байдлаар 170 улс нэгдэн ороод байна.

НҮБ-аас Конвенцийн хэрэгжилтийг хянах механизмыг боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг бөгөөд үүний нэг тод жишээ нь гишүүн улс орнууд Конвенцийн хэрэгжилтийн талаарх өөрийн үнэлгээг хийх явдал байдаг.

Монгол Улсын хувьд Конвенцийн 3 /Хэрэгт тооцох, хууль сахиулах/, 4 /Олон улсын хамтын ажиллагаа/ бүлгүүдийн хэрэгжилтийн үнэлгээг хийсэн байна. Тус улс Конвенцийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг 2015 онд хийхээр төлөвлөж байгаа бөгөөд энэхүү үнэлгээнд зохих бэлтгэл хангаж оролцох нь гишүүн орнуудын авлигын эсрэг хүсэл эрмэлзлэлийн чухал илэрхийлэл болдог. Үүнтэй холбогдуулан энэ удаа Конвенцийн 2/ Урьдчилан сэргийлэх арга хэмжээ/ болон 5 /Хөрөнгө буцаан олгох/ дугаар бүлгийн хэрэгжилтийн хөндлөнгийн, урьдчилсан үнэлгээг дотоодын шинжээчдээр хийлгэхээр шинжээчдийн багийн сонгон шалгаруулалтыг НҮБХХ-ийн санхүүжилтээр Улсын Их Хурлын Тамгын газар дээр хэрэгжиж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл, Авлигатай тэмцэх газраас зарласан.

Сонгон шалгаруулалтад “Эм Ди Эс энд Ассошейтс” ХХН-ийн баг шалгарч, 2014 оны 5 дугаар сарын 5-наас 7 дугаар сарын 4-ний хооронд зохих судалгаа хийж, энэхүү ажлын тайланг Та бүхэнд толилуулж байна.

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Конвенцийн “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэсэн нэртэй 2 дугаар бүлэг буюу 5-14 дүгээр зүйлийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа, тогтолцоог үр дүнтэй болгох, уялдаа холбоог хангах талаар санал, зөвлөмж бүхий дэлгэрэнгүй тайлан боловсруулахад оршино.

Судалгааны багийн ахлагчаар “Эм Ди Эс энд Ассошейтс” ХХН-ийн партнер Д. Дүгэржав, багийн гишүүнээр тус хуулийн фирмийн партнер Д.Мөнхгэрэл, туслах хуульч А.Мөнхзул, Б.Түвшинтунгалаг, И.Учралбаяр нар ажиллалаа.

Бид энэхүү зөвлөх үйлчилгээг үзүүлэхдээ мэдээлэл цуглуулах, харьцуулан дүгнэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлоход чиглэсэн судалгаа шинжилгээ хийх, нийтийн болох хувийн эрх зүйн байгууллагуудын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болсон судалгааны тайлан, статистик мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлэг, ярилцлага, Авлигатай тэмцэх газар болон нийтийн албаны бусад байгууллагаас хэвлэмэл болон цахим хэлбэрээр гаргуулж авсан мэдээлэл, бусад бичгийн нотлох баримтад үндэслэн Конвенцийн заалт бүрийн хэрэгжилтийг үнэлэх, үндэсний болон олон улсын эрх зүйн зохицуулалт, аргачлал, тэргүүн туршлага, нийтийн алба, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын практик үйл ажиллагаатай танилцах, “Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн II бүлгийн (Урьдчилан сэргийлэх арга хэмжээ) хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах” зөвлөх үйлчилгээний багийн тайлангийн төсөл, багийн урьдчилсан үнэлгээ, зөвлөмжийг холбогдох талуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлж, тайлангийн төсөл, түүнийг боловсронгуй болгох талаарх мэргэжилтнүүдийн саналыг авч, үнэлгээний тайланд тусгах, захиалагч, санхүүжүүлэгчийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулах, эдгээр ажиглалт, судалгаа, харьцуулалт дээр үндэслэн Конвенцийн заалт бүрийн эрх зүйн орчин, практик хэрэгжилтийн талаар дүгнэж, санал зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зэрэг арга зүй, аргачлалыг ашигласан болно.

Үнэлгээг гүйцэтгэхдээ нийтийн алба, түүнтэй адилтгах байгууллага хуульд заасан үүргийн дагуу цахим хуудсаараа нийтийн хүртээл болгосон мэдээ, мэдээлэл, эсхүл, төрийн зохих байгууллагаас гаргаж өгсөн нотолгоог үндэслэх, энэ нь үнэлгээ хийх үед хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцсэн байх, хөндлөнгийн үнэлгээ хараат бус байх зарчмыг баримталсан.

Хөндлөнгийн үнэлгээний хараат бус байдлыг хангах зорилгоор тодорхой төрийн байгууллагын удирдлага буюу ажилтантай уулзаж, нийтийн хүртээл болоогүй мэдээллийг авч ашиглахаас аль болох зайлсхийсэн. Авлигаас урьдчилан сэргийлэх үндсийн үндэс бол ил тод байдал мөн. Мэдээллийн технологийн эрин үед ил тод байдлыг харьцангуй хямд өртгөөр хангах хууль зүйн болон техникийн нөхцөл манай оронд бүрдсэн байна. Иймд Конвенцийн шаардлага, түүний заалт бүрийг Монгол Улс эрх зүйн орчны хувьд хэрхэн хангаж байгаа, Конвенц болон дотоодын хууль тогтоомж нь практикт хэрхэн хэрэгжиж байгааг иргэн бүр мэдэх, өөрийн түвшинд үнэлэх, төр засаг, цаашилбал, Нэгдсэн Үндэстний байгууллага хэдийд ч тольдож, үнэлж байх боломжийг Монгол Улсын

хуулийн хүрээнд хангахад цаашид ч бүх шатанд анхаарлын төвдөө байлгах шаардлага тавигдаж байна. Магадгүй аль нэг нийтийн алба хаагч “Бидэнтэй уулзалгүйгээр үнэлгээ хийлээ” гэж болох юм. Монгол Улсын иргэн бүр түүнтэй уулзаж мэдээлэл авах боломжгүй учир “Ажил хэрэг, шударга байдлаа нийтэд ил болго” гэсэн хандлагаар энэхүү үнэлгээний тайлан бэлтгэгдсэн болно.

Хоёр сарын хугацаанд асар их мэдээлэлтэй танилцсан. Гэвч бид уг судалгааг анх удаа хийж буй тул буруу ташаа, дутуу дулимаг зүйл байгааг үгүйсгэхгүй. Санал зөвлөмжөө өгч, шүүмжлэлээ өрнүүлэх нь хэн бүхэнд нээлттэй байх болно.

Энэхүү тайланг бэлтгэхэд ишлэл болгосон бүх цахим мэдээлэл, хэвлэмэл бүтээл, төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн мэдээлэл үнэн зөв, бодит байдалд нийцсэн гэж үзэж, тайланд ашигласан болно. Мөн энэхүү тайланд шаардлагатай мэдээллийг бүрэн олж цуглуулсан гэсэн баталгааг судалгааны баг өгөөгүй болно.

Тайланд тусгагдсан харьцуулалт, үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж санал нь тус “Эм Ди Эс энд Ассошейтс” ХХН-ийн зөвлөх үйлчилгээний багийн санал бөгөөд судалгааны ажлыг санхүүжүүлсэн НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Улсын их хурлын Тамгын газрын хэрэгжүүлж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл, Авлигатай тэмцэх газрын албан ёсны байр суурь, үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
**АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО,
ҮЙЛ АЖИЛЛАГАА
/5 дугаар зүйл/**

- 1.1. Оролцогч улс бүр нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжсэн, хууль дээдлэх ёс, нийтийн хэрэг болон нийтийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, үнэнч шударга, ил тод байх, хариуцан тайлагнах зарчмыг тусгасан авлигын эсрэг үр дүнтэй, уялдаа холбоо бүхий бодлогыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ. /Конвенцийн 5.1/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хууль (1992) –ийн Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” хэмээн нийтийн албаны үндсэн зарчмыг тодорхойлсон. Улмаар авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий **Авлигын эсрэг хууль** 2006 онд батлагдсан бөгөөд 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр тус хуульд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” гэсэн 2¹ дүгээр зүйл нэмж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах Улсын Их Хурлын бүрэн эрхийг хуульчилсан байна.

Монгол Улсын Их хурлын 2005 оны 25 дугаар тогтоолоор баталсан “**Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилт**”-д Авилгалыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх явдлыг хөгжлийн нэг гол болгон тодорхойлжээ (24-р зорилт). Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор “**Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтод Суурилсан Үндэсний Хөгжлийн Цогц Бодлого**” батлагдсан юм. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын **зорилгын хүрээнд авлига, хүнд суртлаас ангид** ардчилсан төрийн тогтолцоог төлөвшүүлэх **зорилт тавигдсан**. Уг баримт бичигт Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын **зургаан** тэргүүлэх чиглэлийг тодорхойлсны дотор “... улс төрийн ардчилсан тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хүнд суртлаас ангид, ил тод, хариуцлагатай, шударга тогтолцоог бүрдүүлнэ” хэмээн заасан байна.

Энэхүү баримт бичгийн “ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО” гэсэн долдугаар бүлэгт “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт нь эрх зүйн орчин, төр, засгийн байгууллагын тогтвортой үйл ажиллагаа, төрийн албаны ур чадвар, хариуцлагын тогтолцооноос шууд шалтгаална”. Төрийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, түүнд иргэд оролцох боломжийг хангах Стратегийн зорилт 2-ын хүрээнд “ парламентын хууль тогтоох үйл явцыг ил тод болгож, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх; Засгийн газрын хууль хэрэгжүүлэх чиг үүргийг төгөлдөржүүлэх; Авлигатай тэмцэх албыг бэхжүүлж, үйл

ажиллагааг нь дэмжих; төрийн өндөр албан тушаалтан үйл ажиллагаагаа олон нийтэд тайлагнах, тэдний өмнө хариуцлага хүлээх тогтолцоог боловсронгуй болгох; төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлах”-аар заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулиас бусад дээр дурдсан бодлогын баримт бичиг батлагдахаас өмнө буюу 2002 онд “**Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр**”-ийг Монгол Улсын Их хурал 41 дүгээр тогтоолоороо баталсан байна. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсад авилгалтай тэмцэх нөхцөл бүрдүүлэх, нийгэмд авилгалыг үл тэвчих уур амьсгалыг бий болгох, төр, засаг, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр авилгалаас урьдчилан сэргийлэх, улмаар түүний үүсч буй шалтгаан, нөхцөлийг хязгаарлах, арилгах зорилготойгоор батлагдсан байна. Тус хөтөлбөрийг 2002 -2010 онд хоёр үе шаттайгаар дор дурдсан үр дүнд хүрэхээр тооцжээ:

Нэгдүгээр үе шат: 2002.07.01 - 2005 он:

1. авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нь зайлшгүй чухал болох талаар улс төрийн бүх хүчин, Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар нэгдмэл байр суурьтай болж, энэ ажилд бүх нийтээр хүчээ нэгтгэх эхлэл тавих;
2. авилгалтай тэмцэх ажлын эрх зүйн орчныг шинэ нөхцөлд нийцүүлэх;
3. төр, засгийн байгууллагуудын шинэтгэлийг түргэтгэх
4. авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын өөрийн орны онцлогт тохирсон шинэ загвар бий болгон хэрэгжүүлэх, авилгалыг сааруулж, түүнийг үл тэсвэрлэх уур амьсгалын эхлэл тавих.

Хоёрдугаар үе шат: 2006-2010 он:

- 1.авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн хүчийг төвлөрүүлэх талаар эхний шатанд хүрсэн ололтоо улам бататгах;
2. авилгалыг үл тэсвэрлэх нийгмийн уур амьсгал бий болгох, авилгалтай холбоотой хэргийн илрүүлэлтийг сайжруулж, иргэд олон нийтийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх;
- 3.төр, иргэний хоорондын итгэлцлийг бэхжүүлэх чиглэлд мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гаргах.

Үндэсний хөтөлбөрийг

- 1/ Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох,
- 2/ Авилгалаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- 3/ Төрийн албыг боловсронгуй болгох,
- 4/ Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг хангах,
- 5/ Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас авах арга хэмжээ,
- 6/ Эдийн засгийг либералчлах,
- 7/ Авилгалтай тэмцэх ажилд иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх гэсэн чиглэлийн арга хэмжээнүүдээр хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Түүнчлэн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулан хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Их Хурлаас, ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батлахаар тус тус зааж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлыг жил бүр нэгтгэн дүгнэж, Улсын Их Хуралд

танилцуулж байх, Үндэсний зөвлөлийн үүргийг орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл гүйцэтгэж байхаар шийдвэрлэсэн байна.

Дээр дурьдсанаас гадна авилгыг хязгаарлахад шууд болон шууд бусаар нөлөөлөх хуулиудыг УИХ-аас баталсан байна. Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад зорилт бүхий Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 20012 оны 1 дүгээр сард төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 оны 6 дугаар сард, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилт бүхий Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2005 оны 12 дугаа сард батлан, улмаар 2011 онд зарчмын томоохон нэмэлт, өөрчлөлтийг хийсэн байна.

Монгол Улс нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжсэн, хууль дээдлэх ёс, нийтийн хэрэг болон нийтийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, үнэнч шударга, ил тод байх, хариуцан тайлагнах зарчмыг тусгасан авлигын эсрэг бодлого явуулах хүсэл зоригоо Үндсэн хууль, бусад хууль, төрийн эрх барих дээд байгууллагаас батлан гаргасан удаа дараагийн баримт бичгээрээ нотолсон гэж үзэж байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Б.Бат-Отгоны “АТГ-ын үйл ажиллагааны тухай мэдээлэл” илтгэлд /2013 он/ дурдсанаар Социологийн академиас 2004 онд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, авлигатай тэмцэх талаарх олон нийтийн санаа бодол” судалгаа хийсэн байна /Судалгааны багийн ахлагч Д.Ганхуяг/. Мөн АТГ-ын “Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл \2013 он\-д “Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжих хугацаа 2010 онд дууссантай холбогдуулан түүний биелэлтийн үр дүнг тооцох, авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, хөтөлбөрт дурдсан арга хэмжээний үр нөлөөг судлах зорилгоор Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Авлигатай тэмцэх газрын даргын хамтарсан тушаалын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн нэгдсэн тайлан гаргав” гэж дурдсан байна. АТГ-ээс ирүүлсэн “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлан”-ийн Дүгнэлт, санал хэсэгт Сонгуулийн

тогтолцоотой холбоотой санал, дүгнэлт гарсан байсан дотор дараах асуудлаар бүрэн болон хэсэгчлэн тусгагдсан хэрэгжилт байсан байна:

- Хандивын хязгаарлалт, хоригтой холбоотой дараахь асуудлуудыг сонгуулийн хууль тогтоомжуудаар нэг мөр зохицуулах, хэрэгжих механизм болон хариуцлагын тогтолцоог шинэчлэх шаардлага байна.
- Хувь хүн болон хуулийн этгээдээс өгөх хандивын хуулиар тогтоосон дээд хэмжээ нь нэг нэр дэвшигч, нам эвсэл тус бүрд нь өгч болох хандивын дээд хэмжээ юу, эсвэл тухайн сонгуулийн турш нэг этгээдээс өгч болох хандивын дээд хэмжээ юу, мөн нэг л удаа өгч болох хандивын дээд хэмжээ юу гэдэг нь ойлгомжгүй тул тодорхой болгох.
- Мөнгөн бус хэлбэрийн хандивт юу орох, түүнийг хэрхэн мөнгөн хэлбэрт оруулан тооцох вэ гэдгийг нарийвчлах. Бараа үйлчилгээг хэрхэн үнэлэх, хямдралтай үйлчилгээний хямдруулсан хэсгийг хандивт хэрхэн тооцох зэрэг тодорхой аргачлалуудыг бий болгох.
- Хандивыг тайлагнах журмыг тодорхой болгох, ялангуяа олон нийтэд ил тод тайлагнадаг байхаар журамлах.
- Харин нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулиар тогтоосон хэмжээ, хязгаарт багтаан хэнээс, ямар хандив авсныг, хэрхэн яаж зарцуулсныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянах үүргийг хуулиар хянан шалгах эрх нь олгогдсон Үндэсний аудитын газарт шилжүүлэх нь зүйтэй юм. Ингэснээр нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн хандив, зарцуулалт нь хуулийн дагуу байгаа эсэхийг хянан, шалгаж тогтоох боломжтой юм.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох дараах саналууд байна.
 - Сонгуульд нэр дэвшиж буй хүнд өгөх хандивыг тухайн нам, эвслээр нь дамжуулж өгдөг байх, хуульд заасан журмын дагуу хэрхэн зарцуулах асуудлыг нам, эвсэл нь шийдвэрлэж нийтэд мэдээлдэг байх. Энэ нь сонгогдсон хүний хувьд гуравдагч этгээдээс хараат болох, бусдад өртэй байх нөхцлийг хаах боломжтой юм. Ингэснээр авлига, хээл хахуулиас ангид төрийн түшээ байх нэг нөхцлийг хангана.
 - Улс төрийн нам, эвсэл нь санхүүжилтийн эх үүсвэр, хандивын хэмжээ, зарцуулалтаа хуульд заасны дагуу үнэн, зөв тайлагнаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлээгүй бол төсвөөс УИХ-д авсан суудлын санхүүжилт авах эрхийг нь хасдаг байх. Ингэснээр нам, эвслийн сонгуулийн зардалд хяналт тавих нэмэлт нөхцлийг бүрдүүлнэ.
 - Нам, эвсэл нь дотоод дүрэм, журмынхаа дагуу нэр дэвших хүсэлтэй гишүүдээсээ их хэмжээний татаас авч сонгуулийн кампанит ажлын санхүүжилтээ бүрдүүлдэг байдлыг хуулиар хориглож, сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг өөрчлөх асуудлыг судлах шаардлагатай. Энэ нь сонгогдсон хүний хувьд гуравдагч этгээдээс хараат болох, бусдад өртэй байх нөхцлийг хааж, тэдний өмнөөс улс төрийн аливаа шийдвэр гаргах шалтгаан нөхцлийг арилгана.

- Хүний хүчин зүйлээс хамаарсан механик ажиллагааг халж сонгуулийн автоматжуулсан системийг шинээр нэвтрүүлэх шаардлагатай байна.

Эдгээр санал, зөвлөмж нь 2011 оны 12 сард батлагдсан Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд дараах байдлаар тусгагдсан байна. Сонгуулийн зардлын дансыг нэм эвсэл, түүнчлэн тойрогт нэр дэвшигч тус бүр дээр данс нээж тодорхойлоход Сонгуулийн Ерөнхий Хороо, Аудитын газарт бичгээх мэдэгдэн, нийтэд зарлахаар хуульчилсан. Санал хураалт дууссанаас хойш 15 хоногт багтаан нам эвсэл, бие даагч, нэр дэвшигч өөрийн сонгуулийн зардалд аудитын дүгнэлт гаргуулсан байна. Үүнийг зөрчсөн буруутай тодорхой этгээдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хариуцлага тооцох хэлбэрийг автоматжуулсан хэлбэрээр тоолох.

2013 оны 9 сард Эдийн Засгийн Хөгжлийн Яамнаас “Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтуудын Хэрэгжилтийн Үндэсний Тав дахь Илтгэл”-ийг зохион байгуулж тайлан гаргасан байна. Тус тайлангийн Зорилт буюу Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх 24 дүгээр зорилтын хүрээнд хэд хэдэн ажил хэрэгжүүлсэн, Монгол Улсын Авлигын Индекс 2009 оноос 2011 онд 0,01 пунктээр буурсан, Авлигын хэлбэрийн үзүүлэлт 0,02 пунктээр буурсан, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)-ийг шинээр, Эрүүгийн хууль (2011, 2012)-д нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч энэхүү ерөнхий дүгнэлтээр “дүгнэх боломжгүй” –г дурьдсан байна.

Холбогдох төрийн байгууллага Авлигатай тэмцэх хөтөлбөрт тодорхой түвшинд үнэлгээ хийж, санал зөвлөмж нь хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-д зааснаар салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэн үйл ажиллагааны ил тод байдлаа хангах төрийн байгууллагын хууиар тогтоосон шаардлага хангагдахгүй байна.

Конвенцийн 5 дугаар зүйлийн 1-д заасан нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжсэн, хууль дээдлэх ёс, нийтийн хэрэг болон нийтийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, үнэнч шударга, ил тод байх, хариуцан тайлагнах зарчмыг тусгасан авлигын эсрэг бодлого нь тодорхой цаг хугацаагаар тодорхойлогдсон зорилт, үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлсон богино болон дунд, урт хугацааны хөтөлбөрийн баримт бичгээр тодорхойлогдох нь төрийн үйл ажиллагаанд түгээмэл байна. Гэтэл 2010 онд хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш өнөөдрийн байдлаар шинээр хөтөлбөр батлагдаагүй байна.

Авлигын эсрэг хоёр дахь бодлогын баримт бичгийг боловсруулах чиглэлээр Авлигатай тэмцэх газар 2013 онд хөгжлийн байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран эрчимтэй ажилласан байна.

Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо 2013 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлаг, Азийн сангийн “Засаглал ил тод байдлыг дэмжих” төсөл, Мерси Кор Монгол байгууллагын дэмжлэгтэйгээр, Авлигатай тэмцэх газартай хамтран “Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөрийн төсөл, үзэл баримтлалын хамт боловсруулсан байна.

Тус холбоо нь нийслэл, 21 аймагт үйл ажиллагаа явуулдаг өөрийн салбаруудыг зохион байгуулж, хөтөлбөрийн төслийг улс орон даяар хэлэлцүүлэх ажлыг 2013 оны 11 дүгээр сарын 12-наас 12 сарын 11-ний өдрүүдэд буюу нэг сарын хугацаанд үндсэн гурван хэлбэрээр хийжээ:

1. Зөвлөлдөх уулзалт: Хөтөлбөрийн хэрэгжилтэд голлох үүрэгтэй оролцох буюу авлигад илүү өртсөн салбар-Төрийн байгууллага, авлигын эсрэг үйл ажиллагаа явуулах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг оролцуулсан зөвлөлдөх уулзалтыг 10-50 оролцогчтойгоор нийт 13 удаа 247 хүнийг хамруулан зохион байгуулсан.
2. Хэлэлцүүлэг. Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт иргэдийн, төрийн албан хаагчдын гэсэн хоёр ангиллаар тус бүр 40-50 хүнийг хамруулсан хэлэлцүүгийг орон даяар зохион байгуулж, 2107 иргэн, 1136 төрийн албан хаагчийг оролцуулан нийт 3243 оролцогчтой 60 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж санал авсан байна. Нийтдээ 75 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 3313 хүн оролцсон нь хоёр дахь хөтөлбөр маань олон нийтийн хүсэл зоригийг шингээсэн бодлогын баримт бичиг болох магадлалатай байна.

Зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийн явцад авлигын өнөөгийн нөхцөл байдал, хөтөлбөрийн үндсэн агуулга, үзэл баримтлал, иргэд, байгууллагаас гаргаж байгаа саналын талаарх мэдээллийг телевиз, радио, сонин хэвлэлээр төв, орон нутагт өргөнөөр мэдээлсэн байна. Тухайлбал, EAGLE TV, MN25, TV5, PARLAMENT TV, SCH TV, MNC телевизүүдээр цацагдсан зөвлөлдөх уулзалтуудаас хийсэн мэдээ, сурвалжлага, нэвтрүүлж, тухайн мэдээллийн CD бичлэгийг хийж, хөтөлбөрийн төслийн талаарх мэдээллийг тусгасан “CRAZY POINT” сэтгүүлийн нэг дугаарыг гаргасан байна.

Тус хөтөлбөрийн төсөл одоогоор Ерөнхийлөгчийн тамгын газар, АТГ-т хянагдаж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Авилгалтай тэмцэх үндэсний хэмжээний үйл ажиллагааг эрчимтэй явуулах үүднээс Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тасралтгүй байдлыг хангах

- “Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөрийг нэн даруй өргөн барьж, Улсын Их хурлаар батлуулах
- Хөтөлбөрөөр дэвшүүлэх зорилт, зорилгыг оновчтой тодорхойлж, тухайн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүнг үнэлэх үзүүлэлтийг нарийвчлан тусгах
- Монгол төрийн 2002 оноос хойшхи авлигатай тэмцэх бодлого, зорилт, хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж, 2002-2010 онд хэрэгжүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн тайланг АТГ, Засгийн газрын ХЭГ-ыг цахим хуудсанд байршуулан олон нийтийн мэдээллийг сайжруулах
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-д заасны шаадлагын дагуу бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг байнга шинэчилж, олон нийтэд нээлттэй болгож байх

1.2. Орлоцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй практик үйл ажиллагааг тогтоож, хөхиүлэн дэмжихийг чармайна. /Конвенцийн 5.2/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуулиар 15 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газар
Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага байхаар хуульчлан эрх зүйн байдлыг тодорхойлсон болно.

Авлигын эсрэг хуульд олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны ойлголтыг өгч, улмаар уг үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх субъектийг хуульчилсан байна. Тус хуульд олон нийтийг **соён гэгээрүүлэх үйл ажиллагааг** “олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолбор” \3.1.5\ гэж тодорхойлсон бөгөөд **соён гэгээрүүлэх үйл ажиллагааг** хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийтлэг үүргийг УИХ, бусад төрийн байгууллага, түүний дотор албан болон албан бус боловсролын байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэл, түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын хүрээнд хуульчилсан байна. /Хуулийн 5 дугаар зүйл/

Мөн түүнчлэн авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг авлигаас **урьдчилан сэргийлэх** үйл ажиллагаа гэж тодохойлж. \3.1.6\,Төрийн байгууллага Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх чиглэлээр хүлээх нийтлэг үүрэг,түүний дотор бодлого боловсруулах шийдвэр

гаргахад олон нийтийн оролцоо, төрийн хяналт, төсвийн орлого, түүний зарцуулалтын ил тод, нээлттэй байдалыг хангах, хяналтын тогтолцоонд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын гаргасан шийдвэр нээлттэй байх, аливаа төрийн байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах зэргийг хуульчилсан байна. /Хуулийн 6 дугаар зүйл/

Авлигатай тэмцэх тухай хуулиар түүний үйлчлэлд хамаарах этгээдийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг дараах байдлаар тусгасан байна. /Хуулийн 7 дугаар зүйл/:

- албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;
- бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;
- албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;
- төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;
- албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;
- албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;
- үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

Авилгын үйлдэл нь гэмт хэргийн нэг төрөл болохын хувьд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтад хамаарч тус хуулиар тодорхойлсон гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурлана. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээ буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээ буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх **тусгай арга хэмжээ**, тодорхой этгээд гэмт хэрэг үйлдэхээс болон давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх **нэг бүрчилсэн арга хэмжээ** гэсэн төрлүүдтэй байхаар хуульчилсан байна. Тус хуулиар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд Хууль зүйн сайдаар, аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар толгойлуулсан орон тооны бус зохицуулах зөвлөл зохицуулахаар зааж, зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор заасан. Шаардлагатай бол тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөлийг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллуулах боломжийг хуулиар нээж өгсөн.

Зохицуулах зөвлөл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд дор дурдсан хэлбэрээр уялдуулан зохицуулахаар хуульд заасан байна:

- яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга болон хууль сахиулах төв байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг гаргуулж авах;
- Төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны зөвлөлгөөнийг тодорхой хугацаанд зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хэлэлцэн, цаашид авах арга хэмжээг хамтран төлөвлөх;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах;
- гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцөлийн талаархи статистик мэдээг солилцох;
- гэмт хэргийн байдалд хамтран дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээний чиглэлийг тогтоох;
- гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн бодлого болон Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал өгөх.

Дээр дурдсанаас үзвэл Монгол Улсын холбогдох хуулиар авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй практик үйл ажиллагааг тогтоож, хөхиүлэн дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж үзэж байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газартай хамтран 2008 оноос яам, агентлаг, аймаг, нийслэлийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн. Тухайлбал:

Он	Төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллага				Нийт
	Яам	Агентлаг	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Төрийн өмчит бо- лон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	
2008 он	11	15	-	-	26
2009 он	11	42	1	-	54
2010 он	11	42	22	-	75
2011 он	11	42	22	-	75
2012 он	16	28	22	10	76
2013 он					

- Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2013 үйл ажиллагааны тайлангаас:

Соён гэгээрүүлэх чиглэлээр

- Энэ оны хувьд шударга ёсыг бага наснаас нь төлөвшүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд гол зорилтот бүлгийнхээ нэгийг бага болон өсвөр насны хүүхдүүд гэж тодорхойлон эхний хагас жилд эдгээр насны бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн ажлуудыг хийж эхлүүлсэн. Хүүхэд багачуудад шударга ёсны зан үйл төлөвшүүлэх зорилгоор АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хэвлүүлсэн “Шударга мазаалайнууд”, “Найзын яриа” номд дурдсан **утга санаа, агуулгыг түгээн дэлгэрүүлэхээр** “Зуны даалгавар” арга хэмжээг зохион байгуулав.
- 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын болон ИТХ-ын ажлын албаны авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “Эрх бүхий албан тушаалтан Танаа” **гарын авлагыг** боловсруулж, тэдэнд авлигын эсрэг хууль тогтоомжийг өөрийн байгууллагадаа хэрэгжүүлэн ажиллахад нь арга зүйн туслалцаа үзүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөтөч болох зорилгоор бэлтгэв.
- Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх, чиг үүргийн талаар тодорхой ойлголт өгөх зорилгоор “Монгол Улсын Их Хурлын гишүүн Танаа” **гарын авлагыг боловсруулж**, “Засаглал, ил тод байдлыг дэмжих төсөл”-ийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.
- Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын хувьд шударга байдлын түвшиний ерөнхий үнэлгээ 2008, 2010, 2012 онуудад хийсэн судалгааны дүнгээр жил ирэх тутам буурч байгаа байдал нь ёс зүй, ёс суртахуун, зан төлөвийн хувьд шударга бус байдалтай эвлэрэх, түүнд дасан зохицох, төлөвших хандлагатай байна хэмээн үзэж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд ёс зүйг дээшлүүлэх тал дээр анхаарал хандуулах, шат дараалсан төлөвлөгөөт арга хэмжээ зохион байгуулах санал боловсруулсан шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагад үндэслэн тус хэлтсээс Хүүхдийн төлөө газартай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхлүүлсэн.
- Олон нийтэд чиглэсэн бас нэг арга хэмжээ нь дэлхийн шилдэг эрэн сурвалжлах сэтгүүлчдийн бэлтгэсэн авлигын нийгэмд үзүүлж байгаа хор хөнөөлийг таниулах зорилгоор бэлтгэсэн баримтат кинонуудыг эх хэлнээ хөрвүүлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж байна.
- Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан таниулах ажилд мэргэжлийн урлагийн байгууллагуудыг татан оролцуулах зорилгоор

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын Драм ангийн уран бүтээлчидтэй хамтран “Төлөөс” жүжгийг теле хэлбэрээр бүтээхэд продюсерийн үүрэгтэйгээр оролцсон.

- Авлигын эсрэг олон улсын өдөр 12 дугаар сарын 9-ний өдрийг угтсан арга хэмжээг энэ оны хувьд харьцангуй эрт буюу 6 сарын өмнөөс эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага-2013” улсын уралдааны удирдамжийг боловсруулж, өдөр тутмын “Өнөөдөр, “Өдрийн сонин”-д мэдээлсэний зэрэгцээ байгууллагын цахим хуудсаар дамжуулан, Хэлтсийн ажилтнууд хариуцсан байгууллагуудын ЭБАТ-уудтай холбогдож мэдээлэх замаар нийт төрийн байгууллагуудад хүргэх арга хэмжээг авч байна.
- StAR санаачлага байгууллагын АТГ, ХЗЯ, ТЕГ, УПЕГ, ЦЕГ, МУИС-ХЗС, Хууль сахиулах их сургуулиудын багш ажилтнуудыг хамруулсан “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа”, “Эрх зүйн талаарх хамтын ажиллагаа” сэдэвт **сургалтыг** 05 дугаар сарын 6, 7, 9, 10-ны өдрүүдэд зохион байгуулж сургалтын материалыг англиас орчуулах, сургалт явуулах төсвийн төслийг боловсруулжээ.
- Тиймээс Авлигатай тэмцэх газар, Мерси кор олон улсын байгууллагатай хамтран “Шударга нийгмийн төлөө хамтдаа” аяныг зохион байгуулсан.
- **Сошиал медиа**
Хүмүүсийн хандлага, зан төлөвийг өөрчлөх зорилгоор сошиал маркетингийг ашигладаг туршлага дэлхий дахинд байдаг. Тус аяны хүрээнд сошиал медиа чиглэлээр хүүхэд залууст зориулсан www.Хамтдаа.mn вэйб сайт, Хамтдаа.мн Фэйсбүүк хуудсуудыг ажиллуулж эхэлсэн.
- **Уралдаан, тэмцээн**
 1. “Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэхэд оюутан залуусын оролцоо” сэдэвт Нийслэлийн аварга шалгаруулах парламентийн мэтгэлцээний тэмцээнийг 2013 оны 11 дүгээр сарын 05-аас 11 сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тэмцээний National time news (NTN) телевиз бүтэн нэвтрүүлэг хийж 11 сарын 21-нд олон нийтийн хүртээл болгосон.
 2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам /Асуудал ба шийдэл/ сэдэвт онол арга зүйн бага хурлыг 2013 оны 12 дугаар сарын 01-ний өдөр МУИС-ийн ОУХСургуулийн лекцийн танхимд амжилттай зохион байгуулсан байна. Тус онол арга зүйн бага хурлыг НҮБ-аас санхүүжүүлсэн байна.
 3. Дизайн сонирхогч залууст зориулж “Авлигаас ангид нийгэм” зурагт хуудасны уралдааныг 2013 оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 07-ний өдрийг хүртэл зохион байгуулсан бөгөөд тус уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг Хамтдаа.мн фэйсбүүк хуудсанд тавьж олны хүртээл болгож байна. Цаашид зурагт хуудас болгон хэвлүүлж төрийн байгууллагуудаар тараах зорилготой байна.

- Оюутан залууст зориулсан лекц /Шударга хүний долоон дадал/ Хүүхэд залуучуудад шударга ёсыг сурталчилан таниулж, өдөр тутмын амьдралдаа мөрдлөг болгон хэвшүүлэхэд түлхэц өгөх зорилготой “Шударга хүний долоон дадал” лекцийг Азийн сангийн санхүүжилттэйгээр ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, их дээд сургуулиудын оюутан залууст илтгэл тависан. Илтгэлийг нийт 4900 гаруй оюутан залуус сурагчдыг лекцэнд хамруулсан байна.
- **Дууны ая, клип**
Шударга нийгмийн дуу хоолой болгох зорилготой амьд хөгжмийн чиглэлээр дуу дуулдаг COMPASS хамтлагтай хамтран “Хамтдаа” хэмээх нэртэй 3 минутын дууг бүтээсэн. Цаашид клипжүүлэх төлөвлөгөөтэй байгаа.
- **Хэвлэл, нийтлэл**
МУОНРТ-ийн “Студи 600”-д нэвтрүүлэг. Тус телевизтэй хамтран 2013 оны 12 дугаар сарын 04-ний өдөр “Шударга нийгмийн төлөө хамтдаа” шууд нэвтрүүлгийн зохион байгуулалтыг хариуцаж ажилласан. Үүнд: ЕБС-ийн 105 дугаар дунд сургуулийн 100 сурагчийг оролцуулж, COMPASS хамтлаг “Хамтдаа” дууг дуулж, Лектор Ү.Амарбат “Шударга хүний долоон дадал” лекц тавьсан, Н.Энхбадралт “Амьдрал биднийг өөрчлөхөөс өмнө бид амьдралыг өөрчилнө” сэдэвт илтгэлийг тавьж нэвтрүүлэгт орсон.
- Шударга нийгмийн төлөө хамтдаа “Парад” алхаа
- Дэлхий нийтийн залуусийн өдөр 12 дугаар сарын 07-нд “Шударга нийгмийн төлөө хамтдаа” парад алхааг зохион байгууллаа. Тус парад алхааг Зориг сан төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Парад Централ таур төвийн урд талбайгаас МУИС-ийн хоёр дугаар байрны урд талбай дээр очиж “Хамтдаа” хэмээх үг бүтээж цааш Засгийн газрын 5 дугаар байранд очиж хаалтын арга хэмжээг хийлээ.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр

- 2013 онд урьдчилан сэргийлэх чиглэлээр нэн тэргүүний зорилтоо авлигын шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх, орон нутагт авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр улам ойр ажиллаж арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол хангах, төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг илүү бодит үр дүнд хүрэхүйцээр төлөвлөхөд илүү анхаарах зэрэг асуудлууд гэж тодорхойлсон.
- Чиг үүргийн дагуу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг боловсрууллаа.
- Оюутанд олгох үндэсний тэтгэлэг 70200 төгрөгтэй холбоотой гомдол, мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга гарч байсантай уялдуулж мэдээллийн мөрөөр энэхүү тэтгэлэгтэй холбоотой асуудлыг шалгах удирдамжийг Газрын даргаар батлуулан нийт 20 сургуулийг **хамарсан хяналт, шалгалтын ажлыг УССГХ** дангаар хийж гүйцэтгэсэн.
- Хөдөө, орон нутгийн иргэд-олон нийттэй уулзаж санал хүсэлтийг нь сонсох, төрийн болон төрийн өмчит байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх

төрийн байгууллагуудын иргэдэд үйлчилгээ үзүүлэх хэсгүүдэд ажиллаж иргэдийн хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг сурталчлах зорилгоор орон нутаг, холбогдох **төрийн байгууллагууд дээр тогтмол ажиллаж тус бүр** зөвлөмж хүргүүлсэн.

- Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд баталсан төлөвлөгөөний дагуу ажиллав.
- Баянзүрх дүүрэгт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх “Нэг сарын аян”-ныг дүүргийн нутаг дэвсгэр дээрх төрийн байгууллагууд, орон нутгийн өмчит хуулийн этгээдийг хамруулан зохион байгуулсан бөгөөд аяны хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль сурталчлах, нийтийн албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэхтэй холбоотой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарч, дүүргийн удирдлага болон авлигаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтныг мэдээлэл арга зүйгээр хангах, сургалтад хамруулах замаар хамтарч ажиллав.
- Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газраас “Нээлттэй дүүрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах талаарх хүсэлтийн дагуу тус дүүрэгт ажиллаа.
- Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Өмчийн харилцааны газарт Азийн сан, АТГ, Нийслэлийн засаг даргны тамгын газартай хамтран 2013-2014 онд хэрэгжүүлэх сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “ХАМТДАА” төслийн хүрээнд нилээд ажил гүйцэтгэсэн байна.
- 2013 онд нийт 60 гаруй гомдол, мэдээллийг хүлээн авч холбогдох шалгалтын хийж дууссан байна. Үүнээс гадна хүлээн авч зохих шалгалтыг явуулж байгаа гомдол, мэдээллийн нэгдсэн мэдээллийн сантай болох зорилгоор гомдол мэдээллийн нэгдсэн цахим бүртгэлийг суулгуулан 67 гомдол, мэдээллийн шаардлагатай мэдээллүүдийг шийдвэрлэлтийн хамт бүртгээд байна.
- “Нийслэл, дүүргийн өмч газрын харилцааны албадын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаа.

Орон нутагт чиглэсэн орон нутгийн байгууллагуулын оролцоог хангасан, идэвх санаачлага дээр тулгуурласан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын илүү их үр дүнтэй, далаацтай хэлбэр, төрөл үгүйлэгдэж байна.

2001 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 25 тоот “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” зарлигаар, Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан Улсын хэмжээний

зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажиллах журамыг 2 дугаар хавсралтаар баталсан байна. Тус журам 2004 оны 03 сарын 04-ий Дугаар 29 зарлигаар нэмэлт орсон болно.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигын шалтгаан нөхцлийг арилгахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээний ажил, арга хэмжээг тодорхой судалгаан дээр тулгуурласан байх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан урьдчилан сэргийлэх ажлын тодорхой төрлүүдийг сонгож, тодорхой зорилготой байх.
- Орон нутагт дээрх ажил илүү өргөн цар хүрээтэй явагдах тогтолцоог бүрдүүлэх

1.3. Оролцогч улс бүр холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээгээ авлигаас урьдчилан сэргийлж, түүнтэй тэмцэхэд хангалттай байгаа эсэхийг нь тодорхойлох зорилгоор тогтмол үнэлж дүгнэж байхыг чармайна. /Конвенцийн 5.3/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуульд зааснаар АТГ нь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг. /Хуулийн18.1.3/. Авлигын шалтгаан, нөхцөл байдал, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээрх судалгаа шинжилгээг тогтмол хугацаанд хийж, зохих ёсоор харьцуулан дүгнэж ирсэн байна. Энэ талаар энэхүү хэсгийн “практик орчин” гэсэн хэсэгт тодорхой авч үзэх болно. Судалгааны дүн, олон нийтийн санал, авлигын төлөв байдал, практикт тулгамдсан асуудал, олон улсын шилдэг туршлагыг харгалзан эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр төрийн эрх бүхий байгууллагын зүгээс эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох талаар зохих хүчин чармайлт гарган ажиллаж байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо өмнө батлагдсан хуулиудын хэрэгжилтийн байдал, зохицуулалтын давхардал, зөрчил, хийдлийг тодорхойлон арилгах, шаардлагатай шинэ зохицуулалтыг бий болгох чиглэлээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах буюу, эрх зүйн орчны хувьд тодорхой зохицуулалтгүй байсан харилцааны тухайд шинээр хуулийн төсөл боловсруулж батлуулах зэрэг шаардлагатай арга хэмжээ авч байна.

Авлигын эсрэг хууль нь 2006 оны 07 сарын 06-ы өдөр батлагдсан бөгөөд үүнээс хойш тус хуульд нийт 4 удаа буюу : 2008 оны 05 сарын 29-ий өдөр, 2012 оны 01 сарын 19-ий **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан, 2012 оны 05 сарын 18-ны өдөр, батлагдаж, 2014 оны 01 сарын 24-ий өдөр тус тус** нэмэлт өөрчлөлт оруулжээ. Тус нэмэлт, өөрчлөлтүүдээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг батлах Улсын Их Хурлын, хөтөлбөрийг биелүүлэх, биелэлтийг холбогдох

байгууллагад тайлагнах төрийн байгууллага, албан тушаалтны, Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон гүйцэтгэх ажил явуулахаас бусад үйл ажиллагаанд хяналт тавих Олон нийтийн зөвлөлийн, Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг зэргийг тус тус шинээр хуульчилсан байна.

Түүнчлэн хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах, түүнийг мэдүүлэх, тус мэдүүгүүдийг шалгах журам, тус мэдүүлгийг үнэн зөв, бүрэн мэдүүлээгүй албан тушаалтанд мэдүүлээгүй эд хөрөнгийн хэмжээнд нийцүүлэн хүлээлгэх хариуцлагыг тогтоох, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, авилгалын эсрэг тодорхой үйл ажиллагаа явуулж байгаа зарим албан тушаалтны нийгмийн асуудал зэрэгтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгон нарийвчлан зохицуулсан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2012 оны 01 сарын 19-ий өдөр шинээр батлагдсан. Дагаж мөрдөх хугацааны хувьд Монгол Улсын Ерөнхийлөгч 2012 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хориг тавьсан бөгөөд 2012 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсанаар 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн . Тус хуулийг баталснаас хойшхи 2 жилийн хугацаанд нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, албан тушаалтнаас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт, албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа албан тушаалтанд тавих хязгаарлалт, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн хүрээтэй холбоотой зохицуулалтыг илүү тодорхой болгож, ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн ойлголтыг шинээр хуульчилсан байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 оны 06 сарын 16-ы өдөр шинээр баталсан. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд 2 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

2012 оны 08 сарын 17-ы өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас концессын зүйл, концессын гэрээтэй холбоотой шаардлагатай мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбогдсон зохицуулалтыг хийжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль нь 2005 оны 12 дугаар сарын 01-ий өдөр шинээр батлагдаж, 2006 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн бөгөөд 9 жилийн хугацаанд 2007, 2009, 2010, 2011 онд 5 удаа, нийт 9 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалтанд хамаарах ажил үйлчилгээний хүрээг илүү тодорхой болгож нэмэлт оруулсан. Тухайлбал, Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцаа, хууль тогтоомжоор олгосон эрхийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх улсын чанартай авто замын засвар, арчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа, Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон

бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг тус тус энэ хуулиар зохицуулахгүйг нэмэлтээр оруулсан.

Худалдан авах ажиллагаан дахь олон нийтийн оролцоог илүү хангах чиглэлээр Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, заавар, жишиг баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтлах, сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болохоор тус тус хуульчилжээ. Мөн түүнчлэн Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулах хуулийн зохицуулалтыг нэмсэн байна.

Хуулиар эрх олгосон худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага байж, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион бэргийг тусгасан байна. айгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байхаар хуульчилсан. Хуульд тухайн байгууллагын эрх хэмжээг хуульчилсан.

Авлигын Эсрэг Үндэсний Хөтөлбөрийн Хэрэгжилтэд Хийсэн Судалгааны үр дүнгийн талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 1.1-ийн Практик шаардлагад дурьдсан болно. /22-р хуудсыг харна уу/

Монгол Улс хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж нь авлигаас урьдчилан сэргийлж, түүнтэй тэмцэхэд хангалттай байгаа эсэхийг нь байнга үнэлж дүгнэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах буюу шаардлагатай хуулийг шинээр баталж, эрх зүйн орчныг сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авч байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хууль тогтоомжийн боловсронгуй болгохдоо хүчин төгөлдөр хуулиудын уялдааг хангах, нэр томъёог нэгтгэх арга хэмжээг хамтад нь авах нь зүйтэй

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Авлигын эсрэг хуульд зааснаар АТГ нь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг. \Хуулийн18.1.3\ АНХны судалгааг

2009 онд хийснээс хойш одоогоор 3 удаагийн судалгааны тайлан гараад байна.

- **2009 оны Авлигын Индексийн судалгааг** Авлигатай Тэмцэх Газраас зохион байгуулж Тайлангийн хураангуй үр дүнг 2009 оны 12 сарын 09-ий өдөр Авлигатай Тэмцэх Газрын цахим хуудсанд байршуулсан байх бөгөөд дэлгэрэнгүй үр дүнг өөрийн цахим хуудсандаа байршуулаагүй байна. Хураангуй үр дүнгээс үзвэл:
 - Батлагдсан аргачлалын дагуу түүнд дурдсан үзүүлэлтүүдээр авлигын индексийг тооцоход 0.64 гарч байна. Цаашид авлигын индексийг хоёр жил тутам тооцож түүний өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тооцож үнэлэлт дүгнэлт өгөхөд индексийн ач холбогдол оршиж байгаа юм.
 - Авлигын индексийг бүрдүүлэгч авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт 0.74 гарч байна. Авлигын цар хүрээний үзүүлэлтийг тус бүрээр нь авч үзвэл олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт 0.75 гарч байна. Өөрөөр хэлбэл, олон нийт, шинжээчид дунджаар Монгол Улсад авлига түгээмэл байна гэж 75.0 хувь нь үзжээ.
- **2011 оны Авлигын Индексийн судалгааг** Авлигатай Тэмцэх Газраас зохион байгуулж Тайлангийн хураангуй үр дүнг 2011 оны 12 сарын 09-ий өдөр Авлигатай Тэмцэх Газрын цахим хуудсанд байршуулсан байх бөгөөд Дэлгэрэнгүй үр дүнг 2013 оны 10 сарын 30-нд байршуулсан байна. Уг тайлангийн дүгнэлт хэсэгт: “Авлигын цар хүрээний үзүүлэлтийн олон нийт, шинжээчдийн 79.0 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байна гэж үзсэн нь 2009 оныхоос 4.0 пунктээр нэмэгджээ. Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт 0.02 гарч байгаа нь улсын нэгдсэн төсвийн зарлагын 2.1 хувьтай тэнцэх хэмжээний хохирол авлигын гэмт хэргийн улмаас учирсан байна.” гэсэн байна.
- **2013 оны Авлигын Индексийн судалгааг** Авлигатай Тэмцэх Газраас зохион байгуулж Тайлангийн үр дүнгийн талаар товч үр дүнг 2013 оны 12 сарын 26-ы өдөр Авлигатай Тэмцэх Газрын цахим хуудсанд байршуулсан байх бөгөөд 2014 онд хэвлэж олон нийтэд хүртээл болгосон. Уг тайлангийн дүгнэлт хэсэгт: “Авлигын Индекс 2013 оны байдлаар 0.65 гарч 2011 оныхоос 0.02 пунктээр өссөн нь Монгол Улс дахь авлигын түвшин 0.02 пунктээр буурсан болохыг харууллаа. Авлигын цар хүрээ өөрчлөгдөөгүй буюу цааш өргөжөөгүй байгаа бол Авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.03 пунктээр өссөн эерэг дүнтэй байна.” гэж тодорхойлсон.

Авлигын индексийн судалгаагаар авлигын нөхцөл байдал бага боловч сайжирч байна.

Авлигын индексийн 2013 оны судалгааны хэсэгт Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолд зааснаар “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн үзүүлэлтийг Судалгаа шинжилгээний алба 5 дахь удаагаа тооцон гаргах ажлын хүрээнд цуглуулсан мэдээллийг программд оруулан, холбогдох тооцооллыг хийж, үр дүнг гарган олон нийтэд мэдээлсэн болно. – гэсэн байна.

АТГ-аас 2012 онд УИХ-д өгсөн танилцуулгадаа: “Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн

гаргасан журмын дагуу 2012 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг улсын хэмжээнд 2 удаа зохион байгуулсан бөгөөд хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, хадгалдаг байгууллага, мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтад тогтмол баяжилт хийж, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, хадгалах эрх бүхий /шинээр томилогдсон/ албан тушаалтнуудад заавар, зөвлөмж өгөх, гарын авлагаар хангах зэргээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж тасралтгүй хамтран ажилладаг байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, албан тушаалтны нэрсийн жагсаалт, Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх албан тушаалтны нэрсийн жагсаалтыг тус тус гарган, Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх тайлан, мэдээ, бүртгэлийн 6 төрлийн маягыг хөтлөх зааврыг боловсруулж батлуулан хэрэгжүүлж байна. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам, мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмыг газрын даргын тушаалаар батлуулан тэдгээрийг төрийн болон нутгийн захиргааны 112 байгууллага, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж газрын цахим хуудсанд байршуулж нийтийн хүртээл болгосон байна.

Нийтийн албан тушаалтнууд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ээ анх удаа бүртгүүлэв. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтээр Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлбэл зохих 253 албан тушаалтнаас 252 нь буюу 99.6 хувь нь мэдүүлгээ хуулийн хугацаанд бүртгүүлсэн байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэж, төрийн болон нутгийн захиргааны 121 төв байгууллагаас мэдүүлгийн зөвлөлийн Шүүхийн Сахилгын Хороонд бүртгэж, хүлээн авсан мэдүүлгийн тоог нэгтгэхэд улсын хэмжээнд 2012 оны 8 дугаар сарын 15-ны байдлаар **45000 орчим** албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахаас **99,79** хувь нь мэдүүлгээ бүртгүүлсэн ба 7 албан тушаалтан хугацаа хожимдуулж бүртгүүлсэн, **96** албан тушаалтан мэдүүлгээ гаргаж өгөөгүй байна. Мэдүүлгийн эхний бүрдүүлэлтээр хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлээгүй 64, хугацаа хожимдуулж мэдүүлсэн 25 албан тушаалтанд Авлигын эсрэг хуулийн холбогдох заалтыг үндэслэн хариуцлага тооцуулах албан бичгийг төрийн болон нутгийн захиргааны 39 байгууллагын удирдах албан тушаалтанд хүргүүлсэн. Нийт 89 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаас хүндэтгэн үзэх шалтгаантай /хүнд өвчний улмаас удаан хугацаанд чөлөөтэй байгаа/ 3, төрийн өмчийн 20-49 хувийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах ажилтан 4, ажлаас чөлөөлөгдсөн, шилжсэн 14 албан тушаалтан, нийт 21 албан тушаалтанд хариуцлага тооцох боломжгүй гэсэн хариу ирүүлсэн байна. Хариуцлага тооцох 68 албан тушаалтнаас 66 албан тушаалтанд буюу 1 албан тушаалтанд халах, 1 албан тушаалтанд цалинг 3 сарын хугацаанд 20 хувиар бууруулах, 53 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл, 7 албан тушаалтанд анхааруулах, 4 албан тушаалтанд бүрэн эрхийг нь түтгэлзүүлэх арга хэмжээг авсан байна. Мэдүүлгийн шинэчилсэн бүрдүүлэлтээр мэдүүлгээ гаргаж өгөөгүй болон хугацаа

хожимдуулж бүртгүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцуулахаар 27 байгууллагын удирдах албан тушаалтанд албан бичиг хүргүүлэх ажлыг зохион байгуулсан ба 22 байгууллагаас ажлаас халсан-4, цалинг бууруулсан-1, сануулсан- 26, анхааруулсан-18, хариуцлага тооцох боломжгүй-12 албан тушаалтан, нийт 61 албан тушаалтанд хариуцлага тооцсон талаар хариу ирүүлсэн байна.

АТГ 2013 онд Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны төв **111** байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын нэгдсэн сургалт, семинарыг 2013 оны 01 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Тус нэгдсэн сургалтаар хууль тогтоомж, мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянах, цахим програмын талаар сургалтыг хийсэн. Сургалтанд **111** байгууллагын **114** мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнууд оролцохоос **106** эрх бүхий албан тушаалтан оролцсон. Мөн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны **46** байгууллагад мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан шинээр томилогдсон бөгөөд тэднийг цахим програмд бүртгэж, мэдүүлгийн болон хууль тогтоомжийн талаар заавар зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан.

Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “ЭБАТ-тай ярилцах цаг” уулзалт, сургалтыг байгууллага дээрээ 7 хоног тутамд /11 удаа/ тогтмол зохион байгуулж байгаа ба одоогоор **274** эрх бүхий албан тушаалтан хамрагдсан байна.

Мөн тус газраас Нийгмийн дэвшлийн эмэгтэйчүүдийн холбоотой хамтран хэрэгжүүлж буй “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” сэдэвт хууль тогтоомж, мэдүүлгийн чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтанд оролцож **31** сургагч багшид сургалт зохион байгуулсан. Тус сургалтанд босоо тогтолцоотой, салбар нэгж, мэдүүлэг гаргагч олонтой агентлагууд болон Шүүхийн ерөнхий зөвлөл, Прокурор зэрэг 18 байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудыг сургагч багшаар бэлтгэсэн.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны **111** байгууллагад мэдүүлгийн бүрдүүлэлтийг цахим хэлбэрээр зохион байгуулах, тайлан мэдээ ирүүлэх, цахимаар мэдүүлгээ гаргах болон эрх бүхий албан тушаалтан нарыг ажиллах боломжоор хангуулах тухай, авлигаас урьдчилан сэргийлэх хүрээнд мэдүүлгийн цахим бүрдүүлэлтийн талаар болон дээрх хууль, тогтоомжийг сурталчлах сургалт, сурталчилгааг аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулахад шаардлагатай зардал, төсвийг төлөвлөж, зохион байгуулах асуудлаар, цахим бүрдүүлэлтийн үйл ажиллагаа хангалтгүй явагдаж байсан зарим байгууллагын удирдлагад “Ажил эрчимжүүлэх тухай” албан бичгийг хүргүүлж мэдүүлгийн цахим бүрдүүлэлтийг шуурхай зохион байгуулах зэрэг тус тус албан бичгийг хүргүүлэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

Эрх бүхий албан тушаалтнаар үр бүтээлтэй олон жил ажиллаж байгаа, Авлигын эсрэг хууль, Ашиг сонирхлын хууль тогтоомжийг өөрийн байгууллагад үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байгаа Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Ховд, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гаалийн Ерөнхий газар, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газар, Үндэсний Статистикийн Хорооны мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг урамшуулан баярын бичиг, үнэ бүхий зүйл, мөнгөн шагналаар шагнах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Мэдүүлгийг цахим хэлбэрээр авах програм нэвтрүүлэх зэргээр шинээр гарсан эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар Авлигатай тэмцэх газар болон төрийн байгууллагуудын зүгээс зохих хүчин чармайлт гаргаж байна.

Судалгааны явцад төрийн бүх байгууллагууд мэргэжлийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай шинэ хууль батлагдаж мөрдөгдөөд гаруй 3 жил болж байхад хэрэгжүүлэх талаар жигд анхаарал тавихгүй байна. Тухайлбал, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу үйл ажиллагааны ил тод байдал; хүний нөөцийн ил тод байдал, төсөв, санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн үндсэн 4 чиглэлээр мэдээллээ цахим хуудсандаа байршуулах үүргээ хангалтгүй биелүүлж байгаа нь энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд маш их бэрхшээлтэй байлаа.”

ЗӨВЛӨМЖ:

- Авлигын эсрэг шинээр батлагдсан хуулиудын заалт бүрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг тайлагнуулж авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажил хэрэг болгох;
- Хуульд заасан 4 чиглэлээр цахим хуудсандаа байршуулбал зохих мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж тухай бүр шинэчилж байх.

1.4. Оролцогч улсууд энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өөр хоорондоо болон холбогдох олон улсын ба бүс нутгийн байгууллагатай эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн аль тохирох байдлаар хамтран ажиллана. Ийм хамтын ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, төсөлд оролцох ажил багтаж болно. /Конвенцийн 5.4/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авилгалын эсрэг НҮБ-ын Конвенцийг 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай Монгол Улсын хуулиар баталсан.

Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод 2010 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан “Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон үүсгэн байгуулах тухай хэлэлцээр”-т нэгдэн орох тухай Монгол Улсын хуулиар нэгдэн орсон болно.

Авлигатай тэмцэх газар нь авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох бүрэн эрхтэй \Авлигатай тэмцэх тухай хуулийн 18.4.17\ Одоогийн байдлаар Монгол Улс 28 улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээтэй. Гэсэн хэдий ч эдгээрийн ихэнх нь хуучин социалист орнуудтай байгуулсан бөгөөд орчин үеийн шаардлагад төдийлөн нийцэхгүй болсон.

Оролцогч улсууд энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өөр хоорондоо болон холбогдох олон улсын ба бүс нутгийн байгууллагатай эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн аль тохирох байдлаар хамтран ажиллахад шаардлагатай бүрэн эрх Авлигатай тэмцэх газарт дээр дурдсан хуулиар олгогдсон нь Конвенцийн үзэл санаанд нийцэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хоёр хөрш, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөн хүрээнд хөгжүүлж байгаа бусад гол гол улсуудтай хэрхэн хамтран ажиллаж, шаардлагатай мэдээлэл, туршлага солилцох талаарх хоёр талын хүлээн зөвшөөрсөн, илүү тодорхой баримт бичгийн түвшинд хүртэл хөгжүүлэх.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Монгол Улс авлигатай тэмцэх чиглэлээр олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох талаар зохих хүчин чармайлт гаргаж байгаа нь АТГ-ээс ирүүлсэн “Хамтрагч байгууллагуудын танилцуулга” баримт бичгээс харж болхоор байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний Истамбулын үйл ажиллагааны төлөвлөгөө:

- Тус байгууллагын Истамбулын үйл ажиллагааны төлөвлөгөөний санал асуулгын тайланг хэлэлцэх зорилгоор оролцогч улсуудын төлөөлөгчид 2013 оны 9 дүгээр сарын 23-наас 25-ны хооронд Франц Улсын Парис хотод хуралдсан байна. Уг хуралд Монгол Улсыг төлөөлж АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Б.Бат-Отгон оролцсон.
- Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Ази, Номхон далайн орнуудын авлигын эсрэг санаачлага:
 - АТГ нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг дэмжих зорилготой Монголд Улсын Авлигатай тэмцэх үүрэг амлалтын байдлын тухай тайланг боловсруулж, дээрх хоёр байгууллагын зохион байгуулсан 12 дахь удаагийн бүс нутгийн семинарын хэлэлцэх асуудал болгож хүргүүлсэн.
 - Дээрх хоёр байгууллагын 12 дахь удаагийн бүс нутгийн семинар 2013 оны 7 дугаар сарын 24-нөөс 25-ны өдрүүдэд Тимор-Лесте Улсын Дили хотод зохион байгуулагдсан. Уг семинарын хэлэлцсэн асуудлуудын нэг нь авлигатай тэмцэх байгууллагын чадавхийг бэхжүүлэх асуудал байсан бөгөөд энэхүү сэдвийн хүрээнд оролцогчдод дээрх байгууллагын Индонези Улсад зохион байгуулсан семинарын үеэр яригдсан сайн туршлагауудыг танилцуулсан. Энэхүү сайн туршлагауудтай танилцсаны үр дүнд АТГ

нь авлигын хэргээр мэргэшсэн прокурор ажиллуулах асуудлыг судалж байна.

- Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачлага: Авлигатай тэмцэх газар нь хулгайлагдсан хөрөнгийг мөрдөх, буцаан авах чиглэлээр үйлчилдэг Монгол Улсын хууль эрх зүйн өнөөгийн орчинг олон улсын байдалтай харьцуулан дүн шинжилгээ хийлгүүлэх, гадаад улстай дээрх чиглэлээр хамтран ажиллахад зөвлөгөө авах, мөрдөн байцаагч нарт сургалт зохион байгуулах зорилгоор Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачлага (Stolen Asset Recovery Initiative-StAR) байгууллагад хамтран ажиллах албан хүсэлтийг 2012 оны 12 дугаар сард тавьж, уг албан хүсэлтийг тус байгууллага хүлээж авч, хоёр байгууллага 2013 оны туршид үр дүнтэйгээр хамтран ажилласан.
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Евразийн өрсөлдөх чадварын хөтөлбөр: Тус хөтөлбөрөөс төр, хувийн хэвшил хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх сонирхлоо илэрхийлэн төслийн саналыг боловсруулж, Эдийн засгийн хөгжлийн яаманд ирүүлсэн. Энэхүү төслийн талаар хөтөлбөрийн ажилтантай АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Б.Бат-Отгон уулалт хийж цаашдын хамтын ажиллагааны чиглэлийн талаар санал солилцсон байна.

ЗӨВЛӨМЖ:

- Олон улсын хурал, семинар, арга хэмжээнд оролцсоны дагуу ямар төсөл хөтөлбөр хамтын ажиллагааг эхлүүлсэн, хөгжүүлсэн, ямар шинэ туршлагыг Монголд нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзсэн талаар оролцогч бүр тухайн үед нь тайлан бичих буюу жилийн эцсийн тайландаа тодорхой зүйл заалт болгон тусгаж байх
- Төсөв санхүүгийн хүндрэлийн улмаас тодорхой төсөл хөтөлбөрт оролцож амждаггүй бол энэ тухайгаа тайланд тусгаж байх

Авлигатай тэмцэх газар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын хөгжлийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай авлигатай тэмцэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж байна:

- Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-тай ардчилал сайн засаглалын чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж байна. Тус агентлагийн санхүүжилтээр АНУ-ын Азийн сан “Засаглал, ил тод байдлыг дэмжих” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү төслийг АТГ нь хамтран хэрэгжүүлэхээр тохиролцож, 2012 оны 12 сард Азийн сантай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан. Тус агентлагийн санхүүжилтээр Мерси Кор байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар нь “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо /APPEAL/” төслийг хэрэгжүүлж байна. АТГ нь APPEAL төслийг хамтран хэрэгжүүлэхээр тохиролцож,

Мерси Кор байгууллагатай харилцан ойлголцлын санамж бичгийг 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан байна.

- АНУ-ын Азийн сантай “Засаглал, ил тод байдлыг дэмжих” төслийн хүрээнд байгуулсан санамж бичгийн хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж байна. Үүнд:
 - Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон нийтийн анхаарлыг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хандуулж, тэдний авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, санал санаачлагыг уялдуулан зохицуулж, бодит үр дүнд чиглүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөрийг боловсруулах, олон нийтээр хэлэлцүүлэн санал авах ажилд Азийн сан дэмжлэг үзүүлж, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, түүний орон нутаг дахь салбар зөвлөлүүдтэй хамтран ажилласан.
 - сэтгүүлчдэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалт, ном товхимолын тоог нэмэгдүүлэх ажлыг Азийн сангийн дэмжлэгээр АТГ нь хэрэгжүүлж байна.
 - Мөн Азийн сангийн дэмжлэгтэйгээр дараах төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллаж эхлээд байна. Үүнд: Зориг сан, Демо ардчилалын боловсрол төв, Монголын нутгийн удирдлагын холбоо, Глоб Интернешнл төв, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, Захиргааны шинэ санаачлага, Монголын эмэгтэйчүүдийн сан, Эмэгтэй удирдагч сан, Ил тод байдал сан, Хэвлэлийн хүрээлэнгийн хойд бүсийн төв, Монголын залуучуудын холбоо, бие даасан судлаачид зэрэг болно.
- Мерси Кор ОУ-ын Байгууллага: АТГ нь тус байгууллагын дээр дурьдсан 15 аймагт байрлах салбарууд, тэдний нөөц бололцоог түшиглэн, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн үйл ажиллагаагаа явуулж байна. Хоёр байгууллагын хамтын ажиллагаа дараах хэлбэрээр явагдаж байна. Үүнд:
 - “Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөрт олон нийтийн санал дүгнэлтийг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг Мерси Кор байгууллага нь өөрийн салбар байрлах 15 аймагт зохион байгуулсан.
 - АТГ-ын ажлын хэсэг албан томилолтын хүрээнд тухайн аймгийн иргэд, ТББ-уудтай уулзалт зохион байгуулахад Мерси Кор байгууллагын орон нутгийн салбарууд идэвхтэй хамтран ажилласан.
 - Зорилтот аймаг, сумдын Засаг дарга нарт авлигын эсрэг төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, авлигын эсрэг үйл ажиллагааны сайн туршлага бүхий ном хэвлүүлж гаргахаар хоёр байгууллага тохиролцсоны дагуу “Сайн туршлага” номыг хэвлэн гаргах ажлын хэсгийн хамтран байгуулж, үйл ажиллагаагаа эхлээд байна.

- АТГ нь орон нутагт салбар нэгжгүй тул авлигын эсрэг хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг сургагч багш нарын тусламжтайгаар явуулах нь үр дүнтэй арга болдог. Энэ ажлыг АТГ Мерси Кор байгууллагатай хамтран хэрэгжүүлж, 60 сургагч багшыг бэлтгэхэд оролцсон.
- Мерси Кор байгууллагын салбар байрлах 15 аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс (НХҮХ)-т авлигын эсрэг төлөвлөгөө боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар (НХҮЕГ)-ын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 1/799 тоот албан даалгавар холбогдох аймгийн НХҮХ-т хүргэгдсэн. НХҮЕГ-ын даргын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 146 тоот тушаал батлагдаж, ажлын хэсэг байгуулагдсан.
- Авлигын хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчил зэрэг сэдвээр он-лайн сургалтыг хөдөө орон нутагт ажиллах сургагч багш нарт зориулж хийсэн.
- Сайн засаглалыг бэхжүүлэх, авлигыг үл тэвчих хандлагыг залуусын дунд төлөвшүүлэхэд чиглэсэн “Шудрага нийгмийн төлөө хамтдаа” аянг залуусыг өргөнөөр хамруулан зохион байгуулж өндөрлөсөн бөгөөд залуучуудад зориулсан веб сайт, facebook хуудас ажиллуулж байна. Энэхүү аяныг зохион байгуулахад АТГ болон Мерси Кор байгууллагаас гадна МАОЭНХ, Зориг сан, Азийн сан зэрэг байгууллагууд хамтран оролцсон.
- АТГ нь Транспэрэнси Интернэшнл-Монгол байгууллагатай 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон. Үүнд:
 - Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх
 - Мэдээлэгчийг хамгаалах
 - Соён гэгээрүүлэх
 - Төрийн зарим салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх
 - Сургалт зохион байгуулах болон бусад
- Нээлттэй нийгэм форум
 - “Авилгалын индекс” /2002 он, 2003 он/. Уг судалгааг Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим хийж гүйцэтгэсэн.
 - “Улс төрчдийн авилгалын индекс” /2003 онд/ Уг судалгааг Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим хийж гүйцэтгэсэн.
- Дэлхийн банк: Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем /PIAIDIS/-ийг Дэлхийн банкны засаглалыг дэмжих төслийн санхүүжилтээр Хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем /AIDIS/-ийг нэвтрүүлэх ажлыг 2010 оны 05-11 дүгээр сард, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем /PIAIDIS/-ийг бий болгох ажлыг 2012 оны 11 дүгээр

сараас 2013 оны 05 дугаар сард тус тус хийж гүйцэтгэсэн. Энэхүү систем нь Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм, Судалгаа шинжилгээний програм, Олон нийтийн веб сайт, Системийн удирдлагын програм гэсэн 4 хэсгээс бүрдсэн цогц програм;

- Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-ны 05 дугаар тогтоолоор баталсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 2.8, 2.9-д тус тус заасныг үндэслэн “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем”-ийг ашиглалтанд оруулсан;
 - Мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлэх www.meduuleg.iaac.mn, төрийн өндөр албан тушаалтнуудын мэдүүлгийг иргэд, олон нийтэд ил тод нээлттэй байх www.xacxom.iaac.mn гэсэн цахим хуудсуудыг ажиллуулж байна;
 - Авлигатай тэмцэх газраас 2013 онд албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр анх удаа авч эхэлсэн.
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр:
 - Авилгалын эсрэг НҮБ-ын Конвенц. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан.
 - Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг Монгол Улсын хуулиар 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон батласан.
 - Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн III, IV бүлгийн хэрэгжилтийн тухай олон улсын шинжээчдийн дүгнэлт 2011 онд гарсан. АТГ нь дүгнэлтэд орсон зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын алба болон НҮБХХ-ийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газартай хамтран ажиллах төлөвлөгөөний төсөл боловсруулан дээрх 2 байгууллагад хүргүүлсэн.
 - “Монгол дахь Авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь” /1999 он/ Монгол Улсын Засгийн газрын захиалгаар Төслийн үндсэн баг болон дэмжих баг гүйцэтгэсэн бөгөөд Я.Шуурав /доктор, профессор/ багийн ахлагчаар ажилласан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр
 - “Үндэсний шударга ёсны үнэлгээ” /2001 он/. Уг үнэлгээг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Ардчилсан засаглалын институцуудын чадавхийг дээшлүүлэх төсөл хийж гүйцэтгэсэн.
 - “Авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь” харьцуулсан судалгааг /1999-2002/ НҮБ-ын “Сайн засаглал хөтөлбөр” хийж гүйцэтгэсэн.
 - Азийн хөгжлийн банк: Монголын засаглалын үнэлгээ /2004 он/ судалгааг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн.

Монгол Улс авлигатай тэмцэх чиглэлээр олон улсын болон бус нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох талаар зохих хүчин

чармайлт гаргаж байна. Түүнчлэн Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын хөгжлийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай авлигатай тэмцэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахад зохих анхаарал тавьж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигатай тэмцэх дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний чадавхийг бэхжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, хэрэгжилтийн байдлыг тайлан мэдээлэлдээ тодорхой тусгах;
- АТГ нь хөдөө орон нутагт өөрийн салбар нэгжгүй учир аймаг, орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, үр дүнгийн талаарх мэдэллээ нийтэд хүргэх, сайн туршлагыг нэвтрүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙГУУЛЛАГА

/6 дугаар зүйл/

2.1. Орлоцогч улс бүр авлигаас дор дурдсан арга хэлбэрээр урьдчилан сэргийлэх байгууллага буюу байгууллагуудыг /аль тохирохыг/ байлгах явдлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хангана:

(а) энэхүү конвенцийн 5 дугаар зүйлд дурдсан бодлогыг хэрэгжүүлэх, зохих тохиолдолд уг бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, уялдуулан зохицуулах; /Конвенцийн 6.1.а/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцийн авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага байлгахыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хангана гэсэн заалт нь **Авлигын эсрэг хуульд**¹ “Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн”. /15.1/ Авлигатай тэмцэх газар нь дараах чиг үүргийн хүрээнд хуулиар тогтоосон тодорхой үйл ажиллагаа явуулахаар хуульчлагдсан:

- Олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх /18.1/
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах /18.2./

¹ Авлигын эсрэг хууль 2006.07.06

- Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан өөрийн эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллана. /18.3./

Авлигтай тэмцэх газар хуулиар тогтоосон дараах бүрэн эрхийг хэрэгжүүлж байна. /18.4./

- авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;
- авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;
- авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;
- аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;
- авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
- авлигын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах;
- хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;
- чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах;
- өөрийн байгууллага, ажилтныхаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;
- гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэнд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулан авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;
- хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;
- өөрийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн гэрч, бусад этгээдийг шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтад авахуулах;
- хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;
- хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;
- мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

- хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;
- авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.

Авлигатай тэмцэх газар нь үйл ажиллагаандаа дараах үндсэн зарчмыг баримтална: /16.1./

- Авлигатай тэмцэх газар нь нэгдмэл удирдлагатай, бие даасан байх бөгөөд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус, ил тод байх, нууцыг чанд сахих зарчмыг баримтална.
- Аливаа албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

Авлигын эсрэг хуулиар дагуу авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн нийт байгууллагын хүлээх нийтлэг үүргийг хуульчилсан. Үүнд: /6.1./

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан нийтлэг үүрэг;
- тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх;
- төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;
- төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх;
- тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах;
- төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх;
- төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;
- авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах;
- төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах;
- төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;
- иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

- бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах;
- авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих;
- энэ хуулийн 2¹ дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах.

Мөн түүнчлэн тус хуулиар аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон болно.

Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог Улсын Их Хурал батлах бөгөөд урьдчилан сэргийлэх, судалгаа дүн шинжилгээний, хяналт шалгалтын, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлын, захиргааны чиглэлийн үндсэн бүтэцтэй байхаар буюу байгууллагын дотоод бүтцийг хуулийн түвшинд зохицуулсан нь Авлигатай тэмцэх газрын ач холбогдлыг илэрхийлж байна.

Авлига нь гэмт хэргийн нэг төрөл болохын хувьд түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хууль сахиулах бусад байгууллагын чиг үүрэгтэй холбоотойгоор хуульчлагдсан байна. **Прокурорын байгууллагын тухай хуулийн**² 26 дугаар зүйлд заасны дагуу прокурор нь гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар мэдэгдэл бичих эрхтэй бөгөөд прокурорын мэдэгдлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан нь мэдэгдэлд дурдсан шалтгаан, нөхцлийг арилгах арга хэмжээ авч, мэдэгдэлд заасан хугацаанд албан ёсоор хариу өгөх үүргийг /26 дугаар зүйл/, **Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн**³ 190 дүгээр зүйлд Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг тусгасан бөгөөд Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт нь хавсаргахаар заасан байна. **Цагдаагийн албаны тухай хуулиар** Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд доор дурдсан эрх хэмжээг хэрэгжүүлнэ: /9.2./

- гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;
- гэмт хэрэг, зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;
- цагдаагийн алба хаагч биечлэн, эсхүл техник хэрэгсэл ашиглан нийтийн эзэмшлийн газарт хяналт тавих, эргүүл ажиллуулах;

² Прокурорын байгууллагын тухай хууль 2002.07.04

³ Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002.01.10

- мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах;
- гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах.

Гэмт хэргээс урьчилан сэргийлэх хуулиар Авилгын үйлдэл нь гэмт хэргийн нэг төрөл болохын хувьд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтад хамаарч тус хуулиар тодорхойлсон гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурлана. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээ буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээ буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ, тодорхой этгээд гэмт хэрэг үйлдэхээс болон давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ гэсэн төрлүүдтэй байхаар хуульчилсан байна. /5, 6-р зүйл/

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Энэ талаар 5 дугаар зүйл буюу 1 дүгээр бүлэгт илүү дэлгэрэнгүй оруулсан бөгөөд урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилт, түүнийг үйл ажиллагаандаа уялдуулах зохицуулах ажлыг авлигатай тэмцэх газар нь тухайн байгууллагын ЭБАТ-аар дамжуулан хэрэгжүүлдэг болох нь “Эм Ди Эс Энд Ассошэйтс” ХХН буюу манай байгууллагын 2013 онд хийсэн Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд хийсэн үнэлгээнээс харагдсан.

Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаанд Авлигатай тэмцэх газрын талаарх эерэг хандлага нь 2013 оны 3-р сарын судалгаанаас ажиглагдаж байна. Хэдийгээр 2012 оны 11 сараас хойш авлигын эсрэг авах арга хэмжээг Авлигатай тэмцэх газар удирдан зохион байгуулах хэрэгтэй гэж үзэх оролцогчдын тоо буураад байсан ч судалгаанд оролцогчдын дийлэнх нь авлигатай тэмцэх ажлыг Авлигатай тэмцэх газар удирдах нь зүйтэй гэж итгэсэн хэвээр байна. Мөн түүнчлэн авлигатай тэмцэх ажлыг иргэний нийгэм, засгийн газар удирдах хэрэгтэй гэсэн оролцогчид мөн байна. харин дээд түвшиний авлигатай тэмцэх ажлын хувьд байдал эсэргээрээ буюу Засгийн газар 2 дугаарт харин иргэний нийгэм 3 дугаарт жагссан байна. Судалгаанд оролцогчдын 13.8 хувь нь дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг засгийн газар удирдах ёстой гэсэн бол 8,2 хувь нь иргэний нийгэм энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэсэн байна. Түүнчлэн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг үнэлэх үнэлгээнд мөн эерэг хандлага гарсаар байна. Тус байгууллагын үйл ажиллагааг “сайн” болон “маш сайн” гэж дүгнэх оролцогчдын тоо 2010 оны 3-р сард 7,8 хувь байсан бол 2013 оны 3-р сарын байдлаар 20,3 хувь болж өссөн байна. Судалгаанд оролцогчдын Авлигатай тэмцэх газарт итгэх итгэл 2011 оны 04 дүгээр сард 27 хувь буюу хамгийн доод үзүүлэлттэй байсан бол 2013 оны 03-р сарын байдлаар 40,6 хувь хүрч нэмэгдсэн байна. Ийнхүү эерэг үзүүлэлттэй байгаа нь сүүлийн жилүүдэд Авлигатай тэмцэх газр ын үйл ажиллагаа

идэвхижсэнтэй холбоотой байж өолох юм. Өмнөх жилүүдэд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа жижиг хээл хахуулийн хэргээр хязгаарлагдахаа больсон байна. Авлигатай тэмцэх газар хараат бус шударга хууль сахиулах байгууллага хэмээн үзэх оролцогчдын тоо 2010 оны 3-р сард 21,7 хувь байсан нь 2013 оны 3-р сар гэхэд 30,4 хувь болж өсчээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь авлига болон дээд түвшний авлигын эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээг Авлигатай тэмцэх газар удирдан зохион байгуулах хэрэгтэй гэж үзсэн хэвээр байгаа бөгөөд Авлигатай тэмцэх газарт итгэх итгэл 2011 оны 5-р сард 27 хувь байсан нь 2013 оны 3-р сарын байдлаар 40,5 хувь болж өссөн байна.

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны хэрэгжилтийг судлах зорилгоор тус байгууллагаас 2013 онд гаргасан нэгдсэн тайлан болон хэлтсүүдийн тайланг судлаж үзэв. **Авлигатай тэмцэх газраас 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаас**⁴: Авлигатай тэмцэх газар нь 2013 онд авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд иргэний нийгмийн байгууллага болон олон нийтийг татан оролцуулах, өсвөр үе, залуучуудад шударга ёсны үзлийг зөв төлөвшүүлэх, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт, шалгалтыг хууль тогтоомжийн шаардлагад бүрэн нийцүүлэн сайжруулах, үр дүнд хүргэх, байгууллага, албан хаагчийн аюулгүй байдал, дотоодын хяналт шалгалтын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, олон улсын туршлагад тулгуурлан судалгаа шинжилгээний ажлын аргачлалыг улам боловсронгуй болгох, хууль дээдлэх зарчмыг эрхэмлэж, авлигын гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын үр дүнг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд хэлтэс, албадын хамтын ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, албан хаагчид, ажилтнуудын ажлын үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажилсан гэсэн байна.

Мөн конвенцийн 5 дугаар зүйлд дурдсан бодлогыг хэрэгжүүлэх, зохих тохиолдолд уг бодлогын хэрэгжилтийг судлах зорилгоор зарим хууль тогтоох байгууллагуудын 2013 онд хэрэгжүүлсэн ажлын тайлангаас авлигатай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлуудыг судлахад **Хууль зүйн яамны 2013 оны үйл ажиллагааны товч тайлан**⁵: “Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Хууль зүйн сайдын тушаалаар нийт 29 ажлын хэсэг байгуулагдан дор дурдсан хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:
Хууль зүйн сайдын А/114 дүгээр тушаалаар Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий Дэд зөвлөлийг байгуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2013 оны төлөвлөгөөг боловсруулан ТНБД-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

⁴ Авлигатай тэмцэх газраас 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан

⁵ Хууль зүйн яамны 2013 оны үйл ажиллагааны товч тайлан, www.moj.gov.mn/news/aj/ХУУЛЬ_ЗҮЙН_ЯАМНЫ_2013_ОНЫ_ҮЙЛ_АЖИЛЛАГААНЫ_ТОВЧ_ТАЙЛАН.html

- Өсвөр үеийнхнийг гэмт хэргээс урдчилан сэргийлэх чиглэлээр архидалт, хар тамхидалт, мансуурахын хор хөнөөлийн талаар Монголын Скаутын холбоотой хамтран сарын аян зохион байгуулсан. Хил, гаалиар зорчигчдод чиглэсэн хар тамхи, мансууруулах бодисыг зөөж, тээвэрлэх эрсдлээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны материалыг бэлтгэж, нийтлүүлэх, богино хэмжээний шторкийг Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран хийж байна зэрэг ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна.
- **Прокурорын байгууллагын 2013 онд хийсэн ажлын товч тайлан⁶:**
 - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр харьяа прокурорын газрууд 788 мэдэгдэл бичиж, 531 удаа яриа таниулга, мэдээлэл, зөвлөгөөн зохион байгуулан 103586 хүнийг хамруулсан байна.
 - Прокурор эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 202 судалгаа хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн шалгалтанд 216 удаа оролцож, хууль сурталчлах чиглэлээр сонин хэвлэлд 177, радио, телевизэд 158 удаа мэдээ, мэдээлэл өгчээ.
- **Цагдаагийн Ерөнхий газрын 2013 оны үйл ажиллагааны тайлангаас⁷:**
 - Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 6431 алба хаагчдын 2012 онд мэдүүлсэн хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч, нэгтгэн тайланг хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.
 - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад анх орох болон албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 63 алба хаагчийн урьдчилсан мэдүүлэгт дүгнэлт гаргуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

- Практик хэрэгжилт хэсэгт зарим хууль сахиулах байгууллагуудын тайланг судлах явцад тайлангуудад авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой тусгагдаагүй байна. Энэ тухай уг чиглэлээр хийсэн ажлын хэрэгжилтийг үнэлэх боломжгүйд хүргэж байна.
- Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг цахим хуудсандаа байршуулах эсвэл байгууллагуудын жилийн эцсийн тайланд нэг зүйл болгон оруулж хэвшүүлэхийг зөвлөж байна.

⁶ Прокурорын байгууллагын 2013 онд хийсэн ажлын товч тайлан, <http://prokuror.mn/?p=6361>

⁷ Цагдаагийн Ерөнхий газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан
<http://www.google.mn/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=1&ved=0CCkQFjAA&url=http%3A%2F%2Fwww.police.gov.mn%2Fmedia%2F13.docx&ei=87aCU6CcPMPLsASn3YCYBA&usq=AFQjCNEC5RQkWXgrVPLRWP6MffZgrJamHg> 20

2.1. (b) авлигаас урьдчилан сэргийлэх талаархи мэдлэгийг нэмэгдүүлж, түгээх; /Конвенцийн 6.1.b/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуульд⁸ /5, 6-р зүйл/-д Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын талаар мэдлэгийг нэмэгдүүлэх олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр **аж ахуй нэгж, байгууллага, иргэн нь** Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах, Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах зэрэг үүрэгтэй. Харин авлигаас **урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага нь** тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх, Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх, тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах, авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах зэрэг болон бусад үүргийг хүлээдэг. **Ийнхүү иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагуудын үүргийг тусгаж өгсөн нь конвенцийн авлигаас урьдчилан сэргийлэх талаархи мэдлэгийг нэмэгдүүлж, түгээх гэсэн заалт хэрэгжих эрх зүйн орчин бүрдсэн байна.**

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Авлигатай тэмцэх газар болон Авлигатай тэмцэх газрын хэлтсүүдийн авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, түгээх чиглэлээр авлигатай тэмцэх газар нь

- Төрийн албан хаагчид
- ЭБАТ
- Олон нийтэд
- Судалгаа шинжилгээ хийх зэргээр сургалт, хөтөлбөр зохион байгуулдаг. Мөн энэ чиглэлээр дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах, хийсэн ажлуудыг

⁸ Авлигын эсрэг хууль 2006.07.06

судлах үүднээс 2013 онд гаргасан Авлигатай тэмцэх газрын болон хэлтсүүдийн тайланг судалж үзэхэд

- **Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайлан⁹:** “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага”, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагчид зориулсан гарын авлага”, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” гарын авлагыг тус тус боловсруулж хэвлүүлэн тараасан, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын тамгын газрын ажилтнуудад хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар сургалтыг зохион байгуулсан. Албан тушаалтнууд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ цахимаар хэрхэн мэдүүлэх тухай болон хуулийн хугацааг сануулсан /баннер/ сурталчилгааг өдөр тутмын 5 сонин, 4 сайт, мөн хуулийн хугацааг сануулсан, цахим бүрдүүлэлтийг сурталчилсан видео сурталчилгааг телевизүүдээр нэвтрүүлсэн бөгөөд сурталчилгааны цацалтанд хяналт тавьж ажилласан байна.
- **Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл¹⁰:** Бизнес эрхлэгч, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэнтэй хамтарч ажиллах үр дүнтэй ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт шударга ёсны чиглэлээр хичээл оруулах талаар боловсрол шинжлэх ухааны яамтай 2013 онд хамтран ажиллах нь авлигыг үл тэвчих үзлийг сурагчдад төлөвшүүлэх, шударга ёсыг түгээн дэлгэрүүлэхэд оруулах чухал хувь нэмэр болох болно.
- **Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайлан¹¹:** Соён гэгээрүүлэх чиглэлээр шударга ёсыг бага наснаас нь төлөвшүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд гол зорилтот бүлгийнхээ нэгийг бага болон өсвөр насны хүүхдүүд гэж тодорхойлон Хүүхэд багачуудад шударга ёсны зан үйл төлөвшүүлэх зорилгоор “Шударга мазаалайнууд”, “Найзын яриа” номд дурдсан утга санаа, агуулгыг түгээн дэлгэрүүлэхээр “Зуны даалгавар” арга хэмжээг зохион байгуулсан. 21 аймгийн ИТХ-ын ажлын албаны авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “Эрх бүхий албан тушаалтан Танаа” гарын авлага, Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх, чиг үүргийн талаар тодорхой ойлголт өгөх зорилгоор “Монгол Улсын Их Хурлын гишүүн Танаа” гарын авлагыг боловсруулан хэвлүүлсэн байна. Мөн олон нийтэд чиглэсэн бас нэг арга хэмжээ нь дэлхийн шилдэг эрэн сурвалжлах сэтгүүлчдийн бэлтгэсэн авлигын нийгэмд үзүүлж байгаа

⁹ Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайлан

¹⁰ Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл

¹¹ Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайлан

хор хөнөөлийг таниулах зорилгоор бэлтгэсэн баримтат кинонуудыг эх хэлнээ хөрвүүлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын Драм ангийн уран бүтээлчидтэй хамтран “Төлөөс” жүжгийг теле хэлбэрээр бүтээж дууг зохиолгон дуулуулсан нь Авлигатай тэмцэх газрын түүхэнд анхны удаа захиалж бүтээсэн дуу болсон. “Шударга нийгмийн төлөө хамтдаа” аяныг зохион байгуулсан. Чиг үүргийнхээ дагуу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг боловсруулсан. Төрийн байгууллагуудын иргэдэд үйлчилгээ үзүүлэх хэсгүүдэд ажиллаж иргэдийн хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг сурталчлах зорилгоор 2013 оны 01 дүгээр сарын 03–наас 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл 20 аймагт ажилласан ба ажлын тайланд үндэслэн 20 аймаг тус бүр зөвлөмж хүргүүлэн ажилласан байна. эдгээрээс үзвэл тус газар нь урьдчилан сэргийлэх, авлигын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, түгээх чиглэлээр хангалттай ажил хийсэн байна.

• **Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаанаас¹²:**

Авлигын эсрэг иргэдийн авах арга хэмжээ

- Авлигыг мэдээлэх шууд утас байдаг талаарх мэдлэг 2011 оноос хойш нилээд буурсан бөгөөд 29 хувь орчим байгаа нь 2011 оны 4-р сараас хойш 20 хувиар буурсан үзүүлэлт юм. Түүнчлэн авлигыг мэдээлэх хүсэлтэй иргэдийн тоо 2010 оны 3-р сард 20,5 хувь байснаа 2013 оны 3-р сард 15,5 хувь болж буурсан байна. 2010 оноос хойш хээл хахууль өгөхгүй гэж оролцогчдын тоо харьцангуй тогтвортой буюу 34 хувь байна. Мөнгө байвал өгнө гэх оролцогчдын тоо ч мөн адил тогтвортойгоор нэг хэвэндээ байна. Судалгаанд оролцогчдын тал хувь нь авлигыг мэдээлэх гол байгууллагаар Авлигатай тэмцэх газрыг нэрлэсэн бол авлигын хэргийг удирдлагын түвшний хэн нэгэнд мэдээлэх хүсэлтэй оролцогчдын тоо сүүлийн үед нэмэгдсэн байна. 2013 оны 3-р сарын байдлаар хахууль өгсөн гэх өрхийн тоо 9 хувь буурсан бол мэдүүлсэн хахуулийн дундаж хэмжээ 2012 оны 11-р сард 391,000 төгрөг байсан нь 2013 оны 3-р сард 297,000 болж буурсан байна.
- Авлига хээл хахуультай холбоотой өрхийн тоо 12-оос 9 хувь хүртэл буурсантай холбоотойгоор ажил мэргэжлээр ангилсан авлигын хэргийн тоо мөн буурчээ. Хамгийн их авлигад өртдөг ажил мэргэжлийн хувьд бага зэрэг өөрчлөлт гарсан ч бараг хэвэндээ байна. багш нарын хувьд бага зэрэг буурсан нь улиралын чанартай байж болно. Холбогдох хэргийн тоо буурах хэрээр түүврийн алдаа өндөр болж байсны улмаас цааш нь дундаж хахуулийн хэмжээг мэргэжлээр тооцож гаргагүй болно.

¹² Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа

ЗӨВЛӨМЖ:

- Урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйлчилгээнд буюу хаалга, мэдээллийн самбар, веб сайтад энэ талаар тогтмол мэдээлэх цонхтой болгох, иргэдэд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг таниулан улмаар авлига өгөхгүйгээр төрийн байгууллагуудаар үйлчлүүлэх боломжтойг ухуулан таниулах.
- Иргэдэд хамгийн их бухимдуулж, хүндрэл, чирэгдэл учруулдаг салбаруудруу чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг илүү цэгцтэй бодлогын хүрээнд явуулах, үйл ажиллагаа төсөв төлөвлөгөөг нь илүү иргэдэд ил тод болгох.
- Хүүхэд залуусыг бага наснаас нь төлөвшүүлж, ёс зүйн боловсрол олгож, авлигыг үл тэвчих, шударга ёсыг эрхэмлэх үзэлтэй болгох зорилгоор 12 жилийн сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгах.

2.2. Орлоцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага буюу байгууллагуудыг чиг үүргээ үр дүнтэйгээр, аливаа зүй бус нөлөөллөөс ангид биелүүлэхэд шаардлагатай хараат бус байдлаар эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хангана. Шаардлагатай материаллаг нөөц болон мэргэшсэн ажилтнаар хангахаас гадна тухайн ажилтныг чиг үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдаж болох бэлтгэлээр хангах нь зүйтэй. /Конвенцийн 6.2/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцид заасан авлигаас урьдчилан сэргийлэх байгууллагын чиг үүргээ үр дүнтэй биелэхэд шаардлагатай хараат бус байдлыг Авлигын эсрэг хууль болон төсвийн тухай хуулиар хангаж өгсөн байна. Тухайлбал **Авлигын эсрэг хуулиар**¹³ Авлигатай тэмцэх газрын бүтэц /17-р зүйл/ Авлигатай тэмцэх газрын албан хаагчид тавигдах шаардлага тэдгээрээс тангараг өргөх /20-р зүйл/, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох, чөлөөлөх, түтгэлзүүлэх харилцааг хуульчилсан.

Авлигатай тэмцэх газар нь үйл ажиллагаандаа дараах үндсэн зарчмыг баримталхаар хуульчилсан нь тус байгууллага хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахыг илэрхийлж байна:

- Авлигатай тэмцэх газар нь нэгдмэл удирдлагатай, бие даасан байх бөгөөд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус, ил тод байх, нууцыг чанд сахих зарчмыг баримтална.
- Аливаа албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

Мөн тус хуулийн 28, 29,30, 31, 32 дугаар зүйлүүдээр тус бүр Улс төр, Нийгэм, Эдийн засаг, Хууль зүйн болон бусад баталгааг хангахаар хуульчилж өгсөн

¹³ Авлигын эсрэг хууль 2006.07.06

байна. Харин **Төсвийн тухай хуульд**¹⁴ зааснаар Авлигатай тэмцэх газрын даргыг Төсвийн ерөнхийлөн захирагч /14.1.14/, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга тус байгууллагын төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийг олгож /14.4.10/ хуульчилсанаар тус байгууллага нь хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах боломжийг хангаж байна. Авлигатай тэмцэх газраас илрүүлсэн авлигын гэмт хэрэгтэй холбоотой хэргийг шалгуулахаар шилжүүлдэг эрх бүхий байгууллага буюу шүүх Прокурор, Цагдаагийн байгууллагуудын мэргэшсэн ажилтнаар хангагдах байдал, ажилтныг чиг үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах бэлтгэлээр хангах эрх зүйн орчныг бүдсэн эсэхийг салбарын холбогдох хуулийг судлахад **Цагдаагийн албаны тухай хуульд**¹⁵ Цагдаагийн албан хаагч, ажилтныг бэлтгэх сургалтын байгууллага, сургалт зохион байгуулах бүс нутаг /15-р зүйл/, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, санал боловсруулах үүрэг бүхий судалгааны төв /16-р зүйл/, албан хаагчийн агсамж /28-р зүйл/, Алба хаагч, ажилтны баталгаа /37-р зүйл/, Цагдаагийн алба хаагчид олгох нөхөн олговор, тусламж /38-р зүйл/, мөн бусад баталгааг /39-р зүйл/ зааж өгсөн байна. **Прокурорын байгууллагын тухай хуульд**¹⁶ Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, дагнасан болон дүүргийн прокуроруудын Эдийн засгийн баталгаа /34-р зүйл/ болон бусад баталгаа /37-р зүйл/, Прокурорын байгууллагын боловсон хүчний сургалтыг /48 дугаар зүйл/ хуульчилж өгсөн бол **Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн**¹⁷ 23 дугаар зүйлээр Шүүгчийн эдийн засгийн баталгааг тус тус хуульчилж өгсөн байна. **Энэ нь хууль сахиулах байгууллага буюу Авлигын хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд аливаа зүй бус нөлөөллөөс ангид, хараат бус байж шударга шийдвэр гаргах эрх зүйн тогтолцоо бүрдсэн байна гэж үзэхээр байна.**

Авлигатай тэмцэх газар хуульд заасан чиг үүргээ орон нутагт хэрэгжүүлэхдээ цаг үеийн шинжтэйгээр буюу тодорхой хугацаанд орон нутагт ажиллах хэлбэрээр хэрэгжүүлж байгаа нь Конвенцийн “чиг үүргээ үр дүнтэйгээр” биелүүлэх гэсэн агуулгад төдийлөн нийцэхгүй байна. Нөгөө талаар, орон нутагт ажиллах дээр дурьдсан үйл ажиллагааны хэлбэр нь ихээхэн цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулахад хүргэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигатай тэмцэх газрын ажилтныг бэлтгэх, тэдгээрийг мэргэшүүлэх, давтан сургалтанд хамруулах нэгдсэн системтэй холбоотой зохицуулалтыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.
- Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрхийг орон нутагт хэрэгжүүлэх бүтэц /ажилтан/-ийн асуудлыг нарийвчлан судлаж зохих түвшинд шийдвэрлэх

¹⁴ Төсвийн тухай хууль 2011.12.23

¹⁵ Цагдаагийн албаны тухай хууль 2013.07.05

¹⁶ Прокурорын байгууллагын тухай хууль 2002.07.04

¹⁷ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012.03.07

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- **Авлигатай тэмцэх газраас 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаас** ¹⁸ : Авлигатай тэмцэх газрын 2013 онд ажилтан албан хаагчиддаа үзүүлсэн тусламж дэмжлэг, сургалтуудыг судлахад
 - Хангамжийн чиглэлээр: Ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон сууцны нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд онцгой анхаарч “Ажилтнуудад нийтийн орон сууц худалдан авахад туслалцаа үзүүлэх, орон сууцны нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинээр боловсруулан батлуулж, энэ журмын хүрээнд нийт 48 албан хаагчид нийт 2.0 тэр бум төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.
 - Сургалтын чиглэлээр: Авлигатай тэмцэх газрын хүний нөөцийн чадавхийг сайжруулах ажлын хүрээнд 14 албан хаагчийг худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх бүхий ажилтны сертификат олгох сургалтад, 9 албан хаагчийг Мөнгө угаахын эсрэг олон улсын байгууллагаас зохион байгуулсан Хууль сахиулах байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх” сургалтад, 2 албан хаагчийг ОХУ-ын Москва хотоо зохион байгуулагдсан “ Мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, дүн шинжилгээний арга тусгай технологи-интернет тагнуул” сэдэвт сургалтад, 1 албан хаагчийг БНСУ-ын Сөүл хотоо зохион байгуулагдсан Олон улсын авлигатай тэмцэх салбарыг мэргэжилтнүүдэд зориулсан 14 хоногийн сургалтад, 3 албан хаагчийг БНХАУ-д зохион байгуулагдсан Авлигын эсрэг олон улсын байгууллагуудын холбооны 5 дугаар уулзалт, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулснаас гадна Санхүүгийн анхан шатны мэдлэг олгох сургалтад 40 албан хаагчийг хамруулав. Мөн Дэлхийн банк, НҮБ-ын МБГХТГ-ын хамтарсан төсөл болох Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачлагатай хамтран ажиллах хүрээнд Улаанбаатар хотноо зохиогдсон “Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах”, “Эрх зүйн харилцан туслалцаа хүссэн захидал боловсруулах” сэдэвт сургалтыг бие даан зохион байгуулж тус газрын 25 бусад хууль сахиулах байгууллагуудын 35 албан хаагчид нийт 60 албан хаагчийг уг сургалтад хамруулан ажилласан. Мөн нийт 20 албан хаагчид гүйцэтгэх ажлын анхан шатны мэдлэг олгох 45 хоногийн 117 цагийн сургалтыг зохион байгуулсан.
 - Албан хаагчдын албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах чиглэлээр: Чингэлтэй дүүргийн Спорт цогцолбортой байгуулсан гэрээний дагуу 7 хоногийн “Лхагва” гараг бүр ажилтан, албан хаагчдын биеийн тамирын болон албаны бэлтгэл сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 900 шахам албан хаагчдыг хамруулсан.
 - Байгууллагын албан хаагчдын мэргэшил, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр: Албан хаагчдыг Австри улсын Вена хотод Олон Улсын Авлигын эсрэг академийн зуны сургалт, БНСУ-д Авлигын эсрэг Иргэний эрхийн хорооноос зохион байгуулсан авлигатай тэмцэх чиглэлд судалгаа хийдэг мэргэжилтнүүдийн сургалт, БНХАУ-ын Жинан хотод Авлигын эсрэг олон улсын байгууллагуудын холбооны 5 дугаар

¹⁸ Авлигатай тэмцэх газраас 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан

сургалт, ОХУ-ын Москва хотод Евроазийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн дэргэдэх Олон улсын санхүүгийн хяналт, сургалт арга зүйн төвөөс зохион байгуулсан “Мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, дүн шинжилгээний арга тусгай технологи-интернет тагнуул” сэдэвт сургалтанд тус тус хамруулсан.

- **Авлигатай тэмцэх газрын сүүлийн 3 жилийн Цалингийн сангийн өсөлт бууралт**

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	2012	2013	2014	Тайлбар
1	Сангийн яам	432,386.6	432,386.6	1,832,152.9	
2	Хууль зүйн яам	256,198.9	256,198.9	371,806.0	
3	Авлигатай тэмцэх газар	7,996.2	7,996.2	15,374.9	
4	Шүүхийн ерөнхий зөвлөл	19,085.0	19,085.0	58,437.0	
5	Прокурор	17,437.4	17,437.4	18,838.4	

ЗӨВЛӨМЖ:

- Байгууллагуудын тайланд ЭБАТ-ын тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлыг оруулах, авлигатай тэмцэх чиглэлээр хийсэн ажлыг дэлгэрэнгүй нотлох баримтын хамт оруулж байвал дараа дараагийн судалгаа хийхэд хялбар болох боломжтой байна;
- Авлигатай тэмцэх газрын хүний нөөцийн ур чадварыг тодорхойлох боломжтой болох;
- Авлигатай тэмцэх газар өөрөө сонирхолын зөрчлийн мэдэгдэл, нөлөөлийн мэдүүлэг гаргадаг эсэх талаарх мэдээлэлээ ил болгох.

- 2.3. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд нь бусад оролцогч улсад тусалж болох эрх бүхий байгууллага буюу байгууллагуудын нэр, хаягыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлнэ; /Конвенцийн 6.3/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигаас урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд нь бусад оролцогч улсад тусалж болох эрх бүхий байгууллага буюу байгууллагуудын нэр, хаягыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлэх талаар хууль тогтоомжид тодорхой заагаагүй байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэхэд Авлигатай тэмцэх газар, эрх зүйн туслалцааны гэрээний хүрээнд тухайн гэрээнд тодорхойлсоноор Хууль зүйн яам эсхүл Улсын Ерөнхий Прокурорын газар Конвенцийн 6.3-т заасан үүргийг тодорхойлох зохицуулалтыг хийж үүнийгээ Нэгдсэн Үндэсний байгууллагын холбогдох газарт мэдээлэлсэн тухай Авлигатай тэмцэх газар манай багт албан ёсоор мэдэгдсэн болно.

Иймд авлигаас урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд бусад оролцогч улсад тусалж туслалцаа үзүүлэх байгууллагыг тодорхойлох гэсэн Конвенцийн 6.3 дах заалт хэрэгжсэн гэж үзэхээр байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

НИЙТИЙН АЛБА

/7 дугаар зүйл/

- 3.1. Оролцогч улс бүр нийтийн албан тушаал, зохих тохиолдолд түүнчлэн сонгогддоггүй нийтийн бусад албан тушаалтныг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх талаар дор дурдсан тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэхийг зохих тохиолдолд, эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн чармайна:**
- (а) үр ашигтай, ил тод байх болон мэдлэг чадвар, эрх тэгш байдал, авъяас зэрэг бодит шалгуурын зарчимд үндэслэсэн; /Конвенцийн 7.1.a/**

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн ил тод байх, иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх, төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх гэсэн зарчим нь Конвенцийн сонгогддоггүй албан тушаалтныг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, чөлөөлөх тал дээр ил тод байх болон мэдлэг, чадвар, эрх тэгш байдал, авъяас зэрэг бодит шалгуурын зарчимд үндэслэсэн байх гэсэн хэсэгтэй нийцэж байна үзэж байна. Харин төрийн алба тогтвортой байх, төрийн албан хаагч албан тушаал дэвших карьерийн бодлогын талаар хуульд тодорхой зохицуулалт байхгүй байна.

Мөн дээрх хуульд Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэшсэн байх явдал мөн / 10.1/, Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно

/16.1/ гэж заасан Конвенцийн мэдлэг чадвар, авъяас, эрх тэгш байдлын зарчимд нийцүүлэн төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах эрх зүйн орчин бүрдсэн.

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 17 дугаар зүйлийг үндэслэн “Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах тухай журам”-ыг Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн дугаар 63 тогтоолыг 2013 оны 7-р сарын 1-ний өдрийн дугаар 86 тогтоолоор хүчингүй болсонд тооцон “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ыг, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ыг 2009 оны 99 дүгээр тогтоолоор тус тус баталсан. Мэргэшлийн шалгалтыг орчин үеийн мэдээлэл технологийн давуу байдалд тулгуурлан зохион байгуулж эхэлсэн. Жилд ганц удаа зохион байгуулдаг байсан хуучин тогтолцоо /2009 оноос өмнө хэрэгжиж байсан/-с татгалзан төрийн захиргааны албаны сул орон тоо гарсан даруйд ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг үндэслэн нөөцийн сангаас нөхөх, ийм боломж байхгүй үед нийтэд нээлттэй зарлан тухай бүр шалгалт зохион байгуулах ажлыг эхлүүлсэн байна.

Мөн үүний зэрэгцээ мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдээс 3 иргэний нэрийг нэг албан тушаалд сонголт хийлгэх үүднээс дэвшүүлдэг байсан зарчмыг өөрчлөн зөвхөн 1 иргэнийг ажил албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлдэг болгосон нь сонгон шалгаруулалтын үр дүнг бодит болгож байна.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8 дэх хэсгийг үндэслэн төрийн тусгай албан хаагч бүхий дор дурдсан 9 байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журмуудыг Төрийн албаны зөвлөлөөс 2010 онд батлан мөрдүүлж байна. Үүнд:

- Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоолоор “Тагнуулын ерөнхий газрын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”;
- Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 60 дугаар тогтоолоор “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”;
- Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Зэвсэгт хүчний жанжин штаб болон түүний харъяа анги, байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”;
- Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 92 дугаар тогтоолоор “Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”;
- Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 96 дугаар тогтоолоор “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”;
- Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 20 дугаар тогтоолоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын

төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”;

- Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор “Гаалийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”;
 - Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 50 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх газрын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”;
 - Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”.
- /Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангаас/

Төрийн жинхэнэ албан тушаалд дараах тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно /16.2/ :

1. хуульд өөрөөр заагаагүй бол **Эрүүгийн хуульд** заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээд ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дуусаагүй;

2. хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалаас сахилгын шийтгэлээр халагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй;

3. хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол;

4. хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол;

5. гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

6. хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

Төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтыг **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд** тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

2. Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3. Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд

тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны акт гаргахыг хориглоно. Энэхүү захиргааны акт гаргах хязгаарлалт нь төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан албан тушаалтанд хамаарахгүй. Эдгээр хязгаарлалт болон төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулж ажилтан авах талаар тогтоосон журмыг /17.1, 17.4/ зөрчиж иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг төрийн албаны төв байгууллага хүчингүйд тооцож, буруутай албан тушаалтанд шүүгч хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Төрийн албаны зөвлөл нь дараах албан тушаалд томилогдох нэг ажилтныг Улсын Их Хурлаас тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн талаархи дүгнэлтээ уг ажилтныг томилох эрх бүхий байгууллагад өгнө:

- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга;
- Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;
- төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;
- Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын төсвийн шууд захирагч;
- агентлагийн дарга цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон зэвсэгт хүчний байгууллагаас бусад ;
- Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга;
- аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга.

Төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт **Төрийн албаны тухай хуульд** заасан журмаар хэрэгжинэ:

- Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө. /17.1./
- Төрийн албаны тухай хуулийн төрийн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага, төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзлыг хангасан Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхтэй. /17.2./
- Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх хүсэлтэй, төрийн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан иргэдийг өрсөлдүүлэн шалгаруулах зорилгоор тэднээс төрийн албаны мэргэшлийн шалгалт /цаашид “мэргэшлийн шалгалт” гэх/ авч онооны дэс дарааллаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэнэ. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа нэг иргэнийг төрийн албаны төв байгууллага сонгон түүнийг томилох эрх бүхий этгээдэд нэр дэвшүүлнэ. /17.3/
- Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж

байгаа албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина. /17.4./

- Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй. /17.5./
- Мэргэшлийн шалгаруулалтаар шалгарсан иргэнийг зохих албан тушаалд томилсон тухай төрийн холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаж баталгаажуулна. /17.6./

Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө: / 24.1/

- тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;
- төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;
- өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаарт хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц болон төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосон хугацаа дуусмагц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргаагүй нь захиргааны санаачлагаар түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй. /24.2/

Шүүгчийн албан тушаал эрхлэх, Прокуророор ажиллах Монгол Улсын иргэний хувьд **Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд** заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцэн гэрчилгээ авсан бол Төрийн албан хаагчийн мэргэшлийн шалгалтаас чөлөөлөгддөг. Харин Шүүгчийн албан тушаал болон Прокуророор ажиллаж байгаа этгээд төрийн жинхэнэ албаны өөр албан тушаалд шилжиж ажиллахад төрийн албаны мэргэшлийн шалгалт өгдөг журамтай. /17.9, 17.10/

Төрийн албаны тухай хуулийн энэ заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай. Хуульч сонгон шалгаруулах тухай хууль нь 2012 оны 3-р сарын 7-ны өдөр хүчингүй болсонд тооцогдсон. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс дагаж мөрдөнө. Иймд энэхүү заалтыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19.6-д заасан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үндсэн дээр хуульч нь өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллана.” гэсэн заалтыг дагаж мөрдөнө гэж ойлгож байна.

Үндсэн хуулийн цэцийн есөн гишүүний хувьд гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их хурал

зургаан жилийн хугацаагаар томилно гэж **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн** 3 дугаар зүйлийн 1-т заасан байдаг.

Шүүгчдийн хувьд анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар тус тус Ерөнхийлөгч томилно гэж **Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн** 15.1-д заасан байдаг.

Конвенцид заасан “үр ашигтай” гэсэн зарчим нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд тусгагдаагүй, төрийн алба тогтвортой байх, төрийн албан хаагч албан тушаал дэвших карьерийн бодлогын талаар тодорхой зохицуулалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Албан тушаалтныг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх “үр ашигтай” тогтолцоог бий болгох чиглэлээр Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.
- Төрийн албаны тухай хуулийн 17.9-д Хуульч сонгон шалгаруулах тухай хууль нь хүчингүй болсон тул энэхүү алдааг залруулах нь зүйтэй.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, сонгон шалгаруулалтын зарыг дараах цахим хуудаснаас харах боломжтой :

www.csc.gov.mn

Төрийн албаны зөвлөл нь дараах газруудад салбар зөвлөлтэй:

- ✓ Эдийн засгийн хөгжлийн яам
- ✓ Хөдөлмөрийн яам
- ✓ Уул уурхайн яам
- ✓ Соёл, спорт аялал жуулчлалын яам
- ✓ Зам тээврийн яам
- ✓ Эрүүл мэндийн яам
- ✓ Эрчим хүчний яам
- ✓ Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
- ✓ Хууль зүйн яам
- ✓ Сангийн яам
- ✓ Барилга, хот байгуулалтын яам
- ✓ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
- ✓ Гадаад харилцааны яам
- ✓ Боловсрол, шинжлэх ухааны яам
- ✓ Байгаль орчин, ногоон хөгжлийн яам

- ✓ Батлан хамгаалах яам
- ✓ Улсын бүртгэлийн ерөнхий газар
- ✓ Нийслэл дэх салбар зөвлөл
- ✓ Цагдаагийн ерөнхий газар
- ✓ Хил хамгаалах ерөнхий газар
- ✓ Төрийн өмчийн хороо
- ✓ Тагнуулын ерөнхий газар
- ✓ Татварын ерөнхий газар
- ✓ Онцгой байдлын ерөнхий газар
- ✓ Мэргэжлийн хяналтын газар
- ✓ Зэвсэгт хүчний жанжин штаб
- ✓ Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар
- ✓ Гаалийн ерөнхий газар
- ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- ✓ Хэнтий аймаг
- ✓ Хөвсгөл аймаг
- ✓ Ховд аймаг
- ✓ Увс аймаг
- ✓ Төв аймаг
- ✓ Сэлэнгэ аймаг
- ✓ Сүхбаатар аймаг
- ✓ Өмнөговь аймаг
- ✓ Өвөрхангай аймаг
- ✓ Орхон аймаг
- ✓ Завхан аймаг
- ✓ Дундговь аймаг
- ✓ Дорнод аймаг
- ✓ Дорноговь аймаг
- ✓ Дархан – Уул аймаг
- ✓ Говьсүмбэр аймаг
- ✓ Говь-Алтай аймаг
- ✓ Булган аймаг
- ✓ Баянхонгор аймаг
- ✓ Баян-Өлгий аймаг
- ✓ Архангай аймаг

Төрийн захиргааны байгууллагууд сул ажлын байр гармагц ажлын байрны захиалгаа Төрийн албаны зөвлөлд хүргүүлдэг тул Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар ажлын байрны зар гардаг байна. Иймд иргэн бүр энэхүү зартай танилцахтай боломжтой байгаа нь ил тод байдлыг хангаж байна гэж үзэж байна.

Иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцд бүртгэх, нөөцийн сан бүрдүүлэх, нөөцийн сангаас албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар 2009 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Төрийн албаны зөвлөл “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам” баталсан байна.

- Төрийн жинхэнэ албан тушаалд орох иргэний нөөцийн зарыг дараах цахим хаягнаас харна уу:

<http://103.11.193.90/test/web/resadvert.php>

- **Төрийн албаны тухай хуульд** “төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх нэмэгдэл баталгаагаар хангагдана” гэж заасан. Гэвч бодит байдал дээр шинэ Засгийн газар байгуулагдсанаар өөрчлөгддөг, шинэ дарга нар бусад төрийн албан тушаалтнуудыг сольдог мөн байдал сонгууль бүхийн дараа давтагдсан хэвээр байна. Зарим нэгэн төрийн байгууллагын удирдах албан тушаалтан шалтгаангүйгээр ажилчдаа халдаг талаар, ашиг сонирхол нэгтэй хүмүүсээ төрийн албан тушаалд томилдог талаарх мэдээллийг дараах цахим хуудаснаас харж болно:

- <http://sonin.mn/news/gemt-hereq/15163>
- <http://news.gogo.mn/r/134505>

Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалттай холбогдсон маргаан харьцангуй цөөн гардаг бөгөөд гол төлөв сонголт хийж нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой байдаг. Тухайлбал, улс төрийн дарамт, шахалт, танил тал харах, баг бүрдүүлэх нэрийн дор төрийн албан хаагчдын боловсрол, мэргэжил, мэргэшил, мэдлэг чадвар, туршлагыг үгүйсгэх хандлага гарч байдаг.¹⁹

Төрийн албаны шинэтгэл хэд хэдэн үе шаттайгаар явагдаж иржээ. Энэ хугацаанд шинэтгэлийн үндсэн гурван үе шатыг (1. Монгол Улсын төрийн байгууллагын шинэ бүтэц, тогтолцоог бүрдүүлэх, үүнтэй холбогдсон эрх зүйн болон бодлогын хүрээ заагийг бий болгох, 2. Ардчилсан нийгэм дэх төрийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх шинэ үеийн төрийн албыг бүрдүүлэх, 3. Засаглалын институцын чадавхи, үйл ажиллагааных нь үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх) дамжиж хэрэгжсэн бөгөөд **Төрийн албаны тухай хуулийн 2008 оны нэмэлт, өөрчлөлтөөр** Төрийн албаны шинэтгэлийн дараагийн шинэ үе шат эхэлж байна гэж үзэж байна²⁰

Энэ үе шат нь төрийн албыг улс төрөөс хараат бус байлгаж, гагцхүү мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн, тогтвортой байх “Мерит” тогтолцоог төрийн албанд бүрдүүлэхэд чиглэгдэж, төрийн албаны төв байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, түүний идэвхтэй оролцоотойгоор уг зорилтыг хангах агуулгыг хадгалж байна. Төрийн албаны зөвлөлөөс дэлхийн улс орнуудын нийтлэг жишиг, чиг хандлагыг харгалзан үзэж:

- төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин хөлс, шагнал, урамшуулал, нийгмийн баталгаа;
- төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулах, томилох, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх;

¹⁹ Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангийн 17-р хуудас

²⁰ Төрийн албаны зөвлөл

- төрийн албаны сургалт, хөгжил, дадлагажуулалт, сэлгэн ажиллуулах;
- төрийн жинхэнэ албанд тавигдах тусгай шаардлага;
- гүйцэтгэлийн үнэлгээ;
- төрийн байгууллагуудын бүтцийн тогтвортой байдлыг хангах зэрэг чиглэлээр мерит зарчмыг хэрэгжүүлэх ажлыг улам гүнзгийрүүлж, тэдгээрийг өөр хоорондоо нягт харилцан уялдаатай тогтолцоо болгох шат дараалсан арга хэмжээний талаар ойрын хугацаанд нэн тэргүүнд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний чиглэлийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлэхээр ажилласан байна.²¹

ЗӨВЛӨМЖ:

- Шинэ дарга томилогдоход “өөрийн” хүнээ албан тушаалд томилдог байдлыг цэгцлэх шаардлагатай. Төрийн албан хаагчид шахалт үзүүлэн өөрөөр нь ажлаас чөлөөлөгдөх өргөдөл бичүүлэх явдал нилээн түгээмэл байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн “тогтвортой байх” зарчмыг зөрчиж байна. Иймд Төрийн албан хаагчийн карьерийн бодлогыг тодорхойлж хуульчлан батлах нь зүйтэй.

- 3.1. **(b) ялангуяа авлигад өртөмтгий гэж тооцогдох нийтийн албан тушаалд хувь хүнийг сонгон авах, сургах, мөн зохих тохиолдолд тэдгээр хувь хүнийг өөр албан тушаалд шилжүүлж байх талаар хангалттай журмыг багтаасан; /Конвенцийн 7.1.b/**

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуулийн 18.1.6-д Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх гэж заасан байдаг боловч Конвенцийн авлигад өртөмтгий гэж тооцогдох нийтийн албан тушаалд ажиллаж буй албан тушаалтныг сургах, шилжүүлэхтэй холбоотой найрийвчилсан тусгай зохицуулалт Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 22.2-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.” гэж заасан.

²¹ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангийн 56-р хуудас

1997 оны 12-р сарын 24-ний өдрийн Засгийн газрын тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчийг сэлгэн ажиллуулах журам баталсан байна. Энэхүү журамд зааснаар төрийн захиргааны албан тушаалны дэс түшмэлээс эрхэлсэн түшмэлийн ангилалд ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах ба сэлгэн ажиллуулах хугацаа нь **Төрийн албаны тухай хуульд** заасан хугацааны дотор байх ба талуудын хооронд хийгдэх гэрээнд хугацааг тохирно. Сэлгэн ажиллуулах доод хугацаа нь 7 хоногоос багагүй байна.

Мөн энэхүү журмаар дараах зүйлүүдийг зохицуулсан байна.

- Төрийн захиргааны албан хаагчийг сэлгэн ажиллуулахдаа Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2–т заасны дагуу өөрийнх нь зөвшөөрлийн үндсэн дээр шийдвэрлэнэ.
- Сэлгэн ажиллаж буй албан хаагч нь зэрэгцэн ажиллаж зөвлөх, хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх, шууд орлон ажиллах зэрэг хэлбэрээр ажиллах ба энэ асуудлыг талуудын хооронд хийгдэх гэрээнд тодорхой тусгана.
- Сэлгэн ажиллах албан хаагчийн ажиллаж буй үндсэн болон хүлээн авагч (очиж ажиллах) байгууллага, тэдгээр байгууллагууд тухайн албан хаагчийн хүлээх үүрэг, эрх, хариуцлагын талаар гэрээ байгуулан ажиллана. Гэрээнд тухайн албан хаагчийн ажиллах хугацаа, ажлын арга хэлбэр, гүйцэтгэх ажлын зорилго, чиглэл, ажиллах хугацааны цалин, томилолт, байрны зардлыг хаанаас гаргах, тухайн хугацаанд гарч болох хариуцлагын асуудлыг яаж шийдвэрлэх, ажлын эцсийн үр дүнг хэрхэн үнэлж дүгнэх зэрэг асуудлыг тодорхой тусгах бөгөөд гэрээнд талууд болон төрийн захиргааны албан хаагч гарын үсэг зурж баталгаажуулна.
- Сэлгэн ажиллаж буй албан хаагч нь ажлын зайлшгүй шаардлагаар албан тушаалыг шууд орлон ажиллах тохиолдолд боловсон хүчнийг өөрийн санаачилгаар томилох, чөлөөлөх болон өмч, хөрөнгө захиран зарцуулахгүй. Зайлшгүй тохиолдолд зөвхөн тухайн байгууллагын удирдлага (хуулиар эрх үүрэг нь тодорхойлогдсон удирдлага)– ын шийдвэрийн үндсэн дээр гүйцэтгэнэ.
- Аймаг, нийслэлээс сум, дүүрэгт, аймаг хооронд төрийн захиргааны албан хаагчийг сэлгэн ажиллуулахад энэ журмыг баримтална. Тодорхой ажил гүйцэтгэх болон асуудлыг шийдвэрлэж буй арга барилыг судлах зорилгоор аймаг, нийслэлийн хооронд заавал сэлгэн ажиллуулахгүйгээр судлах, харилцан танилцах зэргээр ажиллаж болно.
- Яамдын ижил төрлийн чиг үүрэг гүйцэтгэдэг (төрийн нууцад хамаарах асуудал эрхэлдгээс бусад) албан хаагчдыг яам хооронд сэлгэн ажиллуулахад энэ журмыг баримтлах ба хоёр талын саналын үндсэн дээр шийдвэрлэнэ.
- Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан маргааныг төрийн албаны тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ гэж заасан.

Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах талаар зохицуулсан байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах /22 дугаар зүйл/

- Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно.
- Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.
- Энэ зүйлийн 2-т заасан төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авна.
- Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах журмыг Төрийн албаны төв байгууллага тогтооно.

Дээрх хуулийн зохицуулалт нь хэтэрхий ерөнхий байх тул тэр бүр авлигаас урьдчилан сэргийлэх болон авлигыг бууруулж чадахгүй гэж үзэж байна. Мөн **Гаалийн байгууллага, Татварын алба, Прокурорын байгууллага болон Шүүх байгууллагын салбарын хуулинд сэлгэн ажиллуулах талаар Төрийн албаны дээр дурдсан ерөнхий зохицуулалтын хүрээнд доорх хэдэн ерөнхий зохицуулалтыг оруулсан байна:**

Гаалийн тухай хууль

Гаалийн удирдах төв байгууллагын дарга гаалийн алба хаагчийг томилох, чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, төр засгийн шагналд тодорхойлох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. /271.1.10/

Гаалийн улсын байцаагчийг гаалийн газар, хороодод 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. /274.3./

Прокурорын байгууллагын тухай хууль

Хуульд зааснаас бусад тохиолдолд прокурорыг ажлаас чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно. /35.1./

Татварын ерөнхий хууль

Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь татварын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан татварын улсын байцаагчийн бүрэн эрхээс гадна үндэсний татварын албаны ажилтнуудыг томилох, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэж ажиллуулах, шагнаж урамшуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. /27.6.9/

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль

Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болно. /10.2./

өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэхийг хориглох; /20.4.3./

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль

9.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах нийтлэг үүрэг хүлээнэ. /9.1.1/

Конвенцийн “авлигад өртөмтгий гэж тооцогдох нийтийн албан тушаал” гэдэгт ямар ажил, албан тушаал хамааруулах талаарх ойлголтыг тодорхойлоогүй, авлигад өртөмтгий албан тушаалд сонгон авахад тавигдах шаардлага, мөн тэрхүү ажилтныг сургах, сэлгэн ажиллуулах чиглэлээр зохицуулсан нарийвчилсан хуулийн зохицуулалт болон журам байдаггүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- Төрийн албаны тухай хуулийн 22.2 болон Гаалийн тухай хуулийн 274.3 заалтууд дах төрийн албан хаагчийг 2 жил хүртэлх хугацаагаар сэлгэн ажиллуулж болно, гаалийн байцаагчийг 2 жил хүртэлх хугацаагаар сэлгэн ажиллуулж болно гэсэн хоёр заалт нь давхцаж байна. Гаалийн байцаагч нь төрийн албан хаагч мөн тул Төрийн албаны тухай хуулиараа зохицуулагдана гэж үзэж байна. Иймд дээрх хоёр хуулийн давхардлыг арилгах
- Мөн авлигад хамгийн их өртөх эрсдэлтэй байгууллагууд салбарынхаа хуулинд яг ямар албан тушаал дээр ажиллаж байгаа албан хаагчдаа хэдэн жил тутамд сэлгэн ажиллуулах талаар нарийвчлан оруулж өгөх нь зүйтэй.
- Судалгаагаар газрын алба хамгийн авлигад өртөмтгий салбар гэж тооцогддог. Тэдэнд чиглэсэн эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- **Шүүхийн ерөнхий зөвлөл:**
ШЕЗ-ийн даргын захирамжаар бүрэн эрхийн хугацаа нь дууссан Ерөнхий шүүгчийн болон сул орон тоо гарсан шүүгч, Ерөнхий шүүгчийн нийт 75 орон тоонд 10 удаа сонгон шалгаруулалт зарлаж, Шүүхийн мэргэшлийн хорооны хуралдааныг /цаашид “ШМХ” гэх/ 10 удаа зохион байгуулсан байна. Анхан шатны шүүхийн шүүгчийн нийт 25 орон тоонд сонгон шалгаруулалт зарлахад нийт 308 нэр дэвшигч бүртгүүлснээс ШМХ-ны шалгалтанд 158 нэр дэвшигч орсноос 39 нэр дэвшигч

тэнцээгүй байна. Анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн нийт 21 орон тоонд сонгон шалгаруулалт зарлахад нийт 46 нэр дэвшигч бүртгүүлсэнээс ШМХ-ны шалгалтанд орсон 1 нэр дэвшигчийг анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй гэж дүгнэлт гаргажээ. Анхан шатны Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн нийт 6 орон тоонд сонгон шалгаруулалт зарлахад нийт 35 нэр дэвшигч бүртгүүлсэнээс ШМХ-ны шалгалтанд 26 нэр дэвшигч орсноос 19 нэр дэвшигч тэнцээгүй байна. Анхан шатны Захиргааны хэргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн 1 орон тоонд сонгон шалгаруулалт зарлахад нийт 4 нэр дэвшигч бүртгүүлсэнээс бие дааж 3, ШМХ-ны шалгалтанд 1 нэр дэвшигч орж тэнцэнэ гэсэн үнэлгээ авсан байна.

Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн нийт 9 орон тоонд сонгон шалгаруулалт зарлахад нийт 54 нэр дэвшигч бүртгүүлсэнээс ШМХ-ны шалгалтанд 30 нэр дэвшигч орсноос 10 нэр дэвшигч тэнцээгүй байна.

Давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн нийт 10 орон тоонд сонгон шалгаруулалт зарлахад нийт 11 нэр дэвшигч бүртгүүлсэнээс ШМХ-ны шалгалтанд 17 нэр дэвшигч орсноос 4 нэр дэвшигч тэнцээгүй, байна.

УДШ-ийн шүүгчийн 3 орон тоонд сонгон шалгаруулалт зарлахад нийт 11 нэр дэвшигч бүртгүүлсэнээс ШМХ-ны шалгалтанд 8 нэр дэвшигчийг хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тэнцэнэ гэсэн дүгнэлт гарчээ.

2012 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанаас Монгол Улсын Ерөнхийлөгчид 76 нэр дэвшигчийг өргөн мэдүүлсэнээс 76 хүнийг шүүгч болон Ерөнхий шүүгчээр томилж, өөрөө хүсэлт гаргасан 2, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн болон эрүүл мэндийн байдлаас албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон 14 шүүгчийг тус тус чөлөөлж, 22 шүүгчийг сэлгэн ажиллуулж, шүүгчийн албан тушаалаас 3 шүүгчийг огцруулах зарлиг гарсан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл 2013 оны тайлангаа цахим хуудсандаа байршуулаагүй байх тул мэдээллийг авч чадсангүй.

- Улсын ерөнхий прокурорын 2011 оны 2-р сарын 25-ны өдрийн дугаар 46 тушаалаар “Прокурорыг сэлгэн ажиллуулах, дэвшүүлэн томилоход мөрдөх журам”-ыг баталсан байна.
- **Гаалийн ерөнхий газар**

Гаалийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай ил тод болгох, ажлын давхардлыг арилгах, гаалийн хяналтын зохистой орчныг бүрдүүлэх, бүртгэл тооцоог сайжруулах, улсын төсвийг орлогыг цаг тухайд нь төвлөрүүлэх, эрсдэлд суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, ажлын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байна.

ГЕГ-ын удирдлагаас ГЕГ-ын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан Гаалийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэх зорилгоор олон жил харьяа гаалийн газар, хороодод хилийн боомтод ажилласан ГУАБ, ГУБ нарыг ажилласан жил, ажилдаа гаргасан амжилт бүтээл, ар гэрийн нөхцөл байдал зэрэг тодорхой шалгуурыг

үндэслэн Улаанбаатар хотод шилжүүлэх, Улаанбаатар хотод олон жил ажилласан ажиллагсдыг хөдөө орон нутагт сэлгэн ажиллуулсан байна.

2013 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар 1089 ГУБ ажиллаж байгаа ба үүнээс 302 ГУБ Гаалийн байгууллагын нэгж, гаалийн газар, хороонд сэлгэн ажиллахад хамрагдсан байна. Энэ нь нийт ажиллаж буй ГУБ-ын 27,7% нь болно.²²

Авлигад өртөх эрсдэлтэй төрийн байгууллагууд албан хаагчдаа сэлгэн ажиллуулах журам баталсан байдаг талаарх хүснэгт

№	Байгууллага	Журам баталсан эсэх /Он, сар, өдөр/	Цахим хуудсандаа байрлуулсан эсэх	Тайлбар
1	Шүүхийн ерөнхий зөвлөл			Сэлгэн ажиллуулах журам батлагдсан байдаг эсэх талаарх хариу өгөөгүй боловч тайландаа сэлгэн ажиллуулсан тухай мэдээллээ тайлагнасан байна.
2	Улсын ерөнхий прокурор	2011.02.25-нд батлагдсан	Байрлуулсан байна	
3	Гаалийн ерөнхий газар	Баталсан гэв	Байрлуулаагүй	Албан тоотоор хүсэлт явуулбал өгнө гэсэн хариу өгсөн.
4	Татварын ерөнхий газар	Баталсан гэв	Байрлуулаагүй	Албан тоотоор хүсэлт явуулбал өгнө гэсэн хариу өгсөн.
5	Цагдаагийн ерөнхий газар	Баталсан гэв	Байрлуулаагүй	2011 онд баталсан. Албан тоотоор хүсэлт явуулбал өгнө, бид энэ журмыг хэрэгжүүлж эхлээгүй байгаа гэсэн өгсөн.
6	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар			Хариу өгөөгүй

Дээрх зургаан төрийн байгууллагын дөрөв нь “Сэлгэн ажиллуулах журам” баталсан, хоёр нь баталсан эсэх нь тодорхойгүй байна. Шүүхийн ерөнхий зөвлөл

²² Гаалийн ерөнхий газрын 2013 оны гүйцэтгэлийн тайлан <http://customs.gov.mn/2014-03-24-06-24-11/2014-03-24-06-24-25>

журам баталсан эсэх нь тодорхойгүй боловч үйл ажиллагааны тайландаа сэлгэн ажиллуулсан албан хаагчдын тоо баримтыг дурдсан байсан.

Авлигатай тэмцэх газраас Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны “Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалт”-ыг ирүүлсэн байна:

**АВЛИГАД ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Албан тушаал	Эрсдэлд хамаарал бүхий хариуцдаг ажил
➤	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	СБТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Тендер, төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг ахлаж, гэрээ байгуулахад оролцдог.
➤	СБТГ-ын Хуулийн хэлтсийн дарга	Төсөл сонгон шалгаруулалт, гэрээ байгуулахад оролцдог.
➤	ТЗУГ-ын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга	Төсөл сонгон шалгаруулалт, гэрээ байгуулахад оролцдог.
➤	Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр хариуцдаг.
➤	Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	- Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, “Цаа бугын аж ахуйг сэргээх,

		цаачин иргэдийн амьдралын түвшинг сайжруулах” үндэсний хөтөлбөр, - Малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, үржлийн сайжруулагч мал импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл олгох ажлыг тус тус хариуцдаг.
➤	Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	“Монгол мал” үндэсний хөтөлбөр хариуцдаг
➤	Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	Малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, тусгай зөвшөөрөл олгох ажлыг хариуцдаг.
➤	Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	- “Чацаргана” үндэсний хөтөлбөр, - Таримал ургамлын үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг тус тус хариуцдаг.
➤	Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	- Тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, - Таримал ургамлын үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг тус тус хариуцдаг.
➤	Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	Таримал ургамлын үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг хариуцдаг.
➤	Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	Ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, худалдах тусгай зөвшөөрөл олгох ажлыг хариуцдаг.
➤	Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр хариуцдаг.
➤	Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	“Загас” дэд хөтөлбөр хариуцдаг.
➤	Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	- Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл, - Тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг тус тус хариуцдаг.
➤	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	“Монгол Улсыг үйлдвэржүүлэх” үндэсний хөтөлбөр хариуцдаг.
➤	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	“Хэвлэлийн үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр хариуцдаг.

➤	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	“Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” үндэсний хөтөлбөр хариуцдаг.
➤	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг хариуцдаг.
➤	Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл болон Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг тус тус хариуцдаг.

Энэхүү жагсаалт мэт тодорхой үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих нь зүйтэй байна.

Төрийн албаны тухай хуулийн 37.4-т хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх журмыг төрийн албаны төв байгууллага тогтоохоор гэж заасан байдаг. Энэхүү заалтыг үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс 2004 оны 6-р сарын 15-нд “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам” баталсан. Энэхүү журмын дагуу төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөдөг. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг нь албан тушаалын баталгаажсан тодорхойлолт, төрийн албан хаагчийн анкет, нэмэгдэл хуудас, хувь хүний намтар, бүтээлийн жагсаалт, ажил байдлын тодорхойлолт, төрийн жинхэнэ албанд орсон тухай нотлох баримт бичиг, эзэмшсэн боловсрол, мэргэжлийн гэрчилгээ, дипломын зохих журмын дагуу баталгаажуулсан хуулбар, хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад материал, биеийн зураг, албан хаагчийн танилцуулга, албан тушаалын карт зэрэг баримт бичгээс бүрддэг. Төрийн албаны тухай хуулийн 37.4-т заасан тоо бүртгэл хөтлөх талаар Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмаар зохицуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Дээрх хүснэгтэд дурдсан зургаан төрийн байгууллагыг хамгийн их авлигад өртөх эрсдэлтэй гэж үздэг. Иймд энэхүү байгууллагууд албан хаагчдаа тогтмол хугацаанд сэлгэн ажиллуулснаар авлигаас урьдчилан сэргийлж чадна гэж үзэж байгаа учир сэлгэн ажилуулах журам баталсан бол тэрхүү журмаа идэвхитэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй байна.
- Төрийн байгууллагууд өөрийн байгууллагад авлигад өртөх эрсдэлтэй ажлын байрны жагсаалт батлан, тэрхүү албан тушаалд хувь хүн шалгаруулж авах тусгайлсан журам батлах, тухайн хүний ажилд авсны дараа эсхүл ажилд сонгон шалгаруулсны дараа тусгайлсан сургалтанд хамруулдаг байх.
- Авлигатай тэмцэх газрын хувьд авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалтнуудыг ажилд орох үед хамрагдах сургалтын хөтөлбөр бэлдэж, зохион байгуулах

3.1. (с) оролцогч улсын эдийн засгийн хөгжлийн түвшинг харгалзан хангалттай урамшуулал, тэгш шударга цалингийн түвшинг дэмжсэн;
/Конвенцийн 7.1.с/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн албаны тухай хуулийн 19.2-д Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтад хамруулах, цол, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, шагнаж урамшуулах, албан тушаал бууруулах асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан Конвенцийн энэхүү заалтын ерөнхий шаардлагад нийцэж байна гэж үзэж байна.

Төрийн албан хаагчийн цалин хөлс нь /28.2/:

- улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс;
- төрийн захиргааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс;
- тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын , мэргэшлийн зэргийн нэмэгдлээс;
- үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, үр чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ.

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишгийг тогтоохдоо төрийн адил албан тушаалд адил хэмжээний цалин хөлс тогтоох болон төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь нийгмийн амьжиргааны дундаж түвшин болон хувийн хэвшилд ажиллагчдын албан тушаалын цалингийн дундаж түвшинтэй уялдсан байх шаардлагад нийцүүлнэ гэсэн хуулийн заалт нь Конвенцийн **эдийн засгийн хөгжлийн түвшинг харгалзан хангалттай урамшуулал, тэгш шударга цалингийн түвшинг дэмжсэн** байх гэсэн шаардлагатай нийцүүлсэн байна гэж үзэж байна.

Мөн төрийн албан хаагч нь цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж авах баталгаагаар хангагдана гэсэн заалт нь мөн л Конвенцийн шаардлагад нийцэж байна гэж үзэж байна.

Төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно./20.4/

Конвенцийн дээрх заалттай холбоотой Төрийн албаны тухай хуулиас зарим заалтыг дурдвал:

Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно. /28.5./

Дор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишгийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно /28.6./:

- сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
- төрийн захиргааны албан хаагч;
- зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан;
- үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч.

Улс төрийн болон Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн төв байгууллагын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, шүүхийн шинжилгээний байгууллагын дарга зэрэг тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдлийн хэмжээ, зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн хууль тогтоомжоор тогтооно. /28.7/

Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл олгох журам, хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. /28.8./

Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. /28.9./

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно. /28.10./

Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор нь төрийн тусгай албаны төрөлд хамаардаг тул жишээ болгон хуулиар тэдэнд эдийн засгийн ямар баталгаа олгодог талаар дор дурдъя:

Авлигын эсрэг хуульд Эдийн засгийн баталгааг дараах байдлаар хангахаар заасан байна. /29-р зүйл/

- Авлигатай тэмцэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.
- Авлигатай тэмцэх газрын төсвийг улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.
- Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно.
- Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажлын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.
- Авлигатай тэмцэх газрыг ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, албан хаагчийг орон сууцаар хангах, авлигатай тэмцэх үйл ажиллагааны явцад туслалцаа үзүүлсэн этгээд, гэрчийг хамгаалах, тэдгээрт санхүүгийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.
- Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.
- Авлигатай тэмцэх газарт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчид аминдаа орон сууц барих, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгнө.
- Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нь Засгийн газрын гишүүнтэй адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар тогтоосон шүүгчийн эрх зүй, эдийн засаг, нийгмийн хамгаалалт зэрэг хараат бус, халдашгүй байдлын баталгааг ямар нэг хэлбэрээр дордуулсан хууль тогтоомж, захиргааны акт гаргахыг хориглоно /20.3./ гэж заасан бөгөөд Шүүгчийн хараат бус байдлыг баталгаагаар Шүүгчийн эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн эдийн засгийн болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцоог энэ хууль болон бусад хуулиар бүрдүүлж, хангана /20.4.6./ гэжээ.

Шүүгчийн эдийн засгийн баталгаа /23-р зүйл/

- Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна.
- Тухайн шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэж байна.
- Шүүгч нь ажлын ачаалал, бүтээмж, шийдвэрийн чанар зэрэгтэй уялдсан нэмэгдэл авах бөгөөд уг нэмэгдэл нь Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг гурваас таван жилд дүгнэх шалгуур үзүүлэлтийн үр

дүнгээс хамаарах ба нэмэгдлийн хэмжээ үндсэн цалингийн 50 хувь хүртэл байна.

- Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй.
- Тавин таван насанд хүрсэн шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэврээ тогтоолгож болно.
- Шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.
- Хуульд заасан нас, болзолын дагуу өндөр насны тэтгэвэрт гарсан шүүгчид сүүлийн нэг жилийн цалингийн дундажаар тооцон 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг олгоно.
- Шүүгчийн тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.
- Шүүгчийн ээлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд шүүгчээр ажилласан таван жил тутамд ажлын гурванедрийн нэмэгдэл амралт олгоно.
- Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.
- Шүүгч ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл төрсөн нутагтаа амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардлыг шүүхийн төсвөөс авто замын зорчигч тээврийн зардлаар тооцож олгоно.

Прокурорын байгууллагын тухай хуулиар Прокурорын Эдийн засгийн баталгааг дараах байдлаар хуульчилсан байна. /34-р зүйл/

- Прокурорын байгууллагын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.
- Прокурорын байгууллагын төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.
- Прокурорын цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ. Прокурорын албан тушаалын цалингийн сүлжээ, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.
- Прокурорын байгууллагыг ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техникийн хэрэгсэл, ажилтныг орон сууцаар хангах зэрэг үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцлийг бүрдүүлэхэд төрийн захиргааны байгууллага бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- Прокурорын байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан прокурорт аминдаа орон сууц барих болон амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь зориулан төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгнө.
- Улсын Ерөнхий прокурор нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаадаа тохирсон цалин авна.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа /11 дүгээр зүйл./

Улсын байцаагч Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, түүнд олгох цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэвэр, тэтгэмжээс гадна дор дурдсан нэмэгдэл баталгаагаар хангагдана:

- хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлж явахдаа хот, суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчсон тохиолдолд хувиас гарсан зардлыг тогтоосон журмын дагуу тухайн байгууллага нь нөхөн олгох;
- хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлж яваад хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны туршид, тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын цалингийн зөрүүг тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа хугацааны туршид тус тус авах;
- хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон тохиолдолд түүний албан тушаалын гурван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг хохирогчийн ар гэрт олгох.
- байгаль орчин, хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдах. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцасны загвар, ялгах тэмдгийг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;
- бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн, дарамталсан, амь нас, эрүүл мэндэд нь бодит аюул заналхийлсэн бол цагдаагийн байгууллагаар аюулгүй байдлаа хангуулах арга хэмжээ авахуулах.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн албан хаагчийн урамшуулал, цалингийн талаар олон хуульд янз бүрээр томъёолж оруулсан нь давхардал үүсгэж байна. Төрийн албаны хуульд үндсэн зохицуулалтаа тусгаж, бусад хуульд зөвхөн онцлогтой нь уялдсан урамшуулал, цалинтай холбоотой зохицуулалтыг тусгах

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Засгийн газар 2012 оны 3-р сарын 16-нд Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай тогтоол гаргасан. Энэ тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалинг 2012 оны 2-р сарын 1-ээс 80 төгрөгөөр, тус оны 5-р сарын 1-ээс 23 хувиар нэмсэн байна. Ингэснээр төрийн албан хаагчдын дундаж цалин 630,000 төгрөгт хүрсэн байна.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2013 оны 7-р сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолоор Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай шийдвэр гарсан. Энэхүү шийдвэрээр:
 - Хяналтын шатны шүүхийн ерөнхий шүүгчийн цалин 4.5 сая төгрөг
 - Хяналтын шатны шүүхийн шүүгчийн цалин 4.2 сая төгрөг
 - шатны шүүхийн ерөнхий шүүгчийн цалин 4.0 сая төгрөг
 - Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн цалин 3.9 сая төгрөг
 - Анхан шатны шүүхийн ерөнхий шүүгчийн цалин 3.8 сая төгрөг
 - Анхан шатны шүүхийн шүүгчийн цалинг 3.7 сая төгрөгөөр тогтоосон байна. Энэхүү шийдвэрийн эх хувийг доорх цахим хаягаар орж үзнэ үү:

http://www.judcouncil.mn/index.php?option=com_content&view=article&id=566:2013-07-19-01-24-36&catid=89&Itemid=291

- Засгийн газар 1995 оны 6-р сарын 14-ний өдөр Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам баталсан байна.

Төрийн албан хаагчид шагнал, урамшуулал олгох журамд албан тушаалын үүргээ бүрэн биелүүлж, өндөр амжилт гаргасан төрийн албан хаагчид ажлын үр дүнг нь үнэлж төрийн байгууллагын захиргаа, эрх бүхий албан тушаалтан дараах шагналаар шагнаж урамшуулна гэж заажээ:

- Мөнгөн шагналаар шагнах
- Эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах
- Улирлын ажлын дүнгээр болон онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсний төлөө мөнгөн урамшил олгох
- Ажлын үр дүн, гаргасан амжилтыг нь нийтэд мэдээлж алдаршуулах, хүндэт дэвтэрт бичих, жуух, баярын бичгээр шагнах, тэргүүний ажилтан цол олгох
- Дээд шатны байгууллагын шагналд тодорхойлох

Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох тухай журамд Их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг, эрдэм шинжилгээний байгууллагад болон судалгаа шинжилгээ, тушилтын үндсэн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа эрдмийн зэрэг цолтой төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр нэмэгдэл олгож байна гэж заажээ:

- Доктор зэрэгтэй бол албан тушаалын сарын цалингаас 20 хувь бодно

- Профессор цолтой бол албан тушаалын сарын цалингаас 10 хувь бодно
- Дэд доктор зэрэгтэй бол албан тушаалын сарын цалингаас 15 хувь бодно\
- Дэд профессор цолтой бол албан тушаалын сарын цалингаас 5 хувь бодно

Дээр дурдсанаас бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингийн 15 хувиар, дэд докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингийн 10 хувиар тус тус тооцож нэмэгдэл олгоно.

Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журамд Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн ажилтны төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно гэж заажээ:

- 5-10 жил ажилласан төрийн албан хаагчид 5 хувиар
- 11-15 жил ажилласан төрийн албан хаагчид 10 хувиар
- 16-20 жил ажилласан төрийн албан хаагчид 15 хувиар
- 21-25 жил ажилласан төрийн албан хаагчид 20 хувиар
- 26 ба түүнээс дээш ажилласан төрийн албан хаагчид 25 хувиар


Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журамд Мэргэшлийн зэргийн сарын нэмэгдлийн доод хэмжээг төрийн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээнээс дор дурдсан хувиар тогтооно гэж заажээ:

- I мэргэшлийн зэрэгтэй төрийн албан хаагчид 15 хувиар
- II мэргэшлийн зэрэгтэй төрийн албан хаагчид 10 хувиар
- III мэргэшлийн зэрэгтэй төрийн албан хаагчид 5 хувиар

Цалингийн сангийн өсөлт бууралтыг сүүлийн 3 жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй харьцуулсан хүснэгтийн дор харуулав.²³

²³ Эх сурвалжийг Олон улсын валютын сангаас авав.

ДНБ болон Цалингийн Сангийн өсөлт бууралтын харьцуулалт



Цалингийн сангийн өсөлт бууралт²⁴

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	2012	2013	2014	Тайлбар
1	Сангийн яам	432,386.6	432,386.6	1,832,152.9	
2	Хууль зүйн яам	256,198.9	256,198.9	371,806.0	
3	Авлигатай тэмцэх газар	7,996.2	7,996.2	15,374.9	
4	Шүүхийн ерөнхий зөвлөл	19,085.0	19,085.0	58,437.0	
5	Прокурор	17,437.4	17,437.4	18,838.4	

2013 онд Шүүгчдийн цалинг нэмсэн явдлыг маш оновчтой шийдвэр болсон гэж үзэж байна. Үндсэн хуульд шүүгчийг хараат бус байж, гагцхүү хуулинд захирагдана гэж заасан байдаг. Үндсэн хуулийн дагуу шүүгч нь хараат бус байхын тулд хангалттай эдийн засгийн баталгаагаар хангагдах ёстой тул тэдний цалинг нэмсэн явдлыг Конвенцид нийцэж байна гэж үзэж байна.

Төрийн албан хаагчийн цалингийн өнөөгийн түвшин, тэдний амьжиргаанд хүрэлцэхээргүй байна гэж үзэж байна. Цалин бага байгаа учир төрийн байгууллагын албан тушаалтан авлигад өртөх магадлал маш өндөр юм. Иймд Конвенцийн шаардлагад нийцэхгүй байна гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн албан хаагчийг авлигаас урьдчилан сэригйлэх нэг гол хэрэгсэлт нь тэдгээрийн цалин хөлс болох зарчмыг нийт төрийн албан хаагчдын хүрээнд бүрэн хэрэгжүүлэх

- 3.1. (d) тэднийг нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх шаардлагыг хангахуйц боловсролын болон сургалтын хөтөлбөрийг хөхиүлэн дэмжсэн, түүнчлэн чиг үүргээ биелүүлэхэд нь гарч болзошгүй авлигын эрсдлийн талаархи мэдлэгийг нь дээшлүүлэх мэргэшсэн бөгөөд зохих тусгай сургалтаар хангасан. Ийм хөтөлбөр нь холбогдох салбарт мөрддөг ёс зүйн дүрэм, стандартаас иш татсан байж болно. /Конвенцийн 7.1.d/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн албаны тухай хуульд Төрийн байгууллага нь төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ, Төрийн албаны зөвлөл нь төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангана, мөн Авлигын эсрэг хуульд сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх гэж заасан байдаг нь Конвенцийн нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх шаардлагыг хангахуйц боловсролын болон сургалтын хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих эрх зүйн үндсийг тодорхойлсон гэж үзэж байна.

Төрийн байгууллага нь авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах, төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах үүрэг хүлээнэ.

Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. /Авлигын эсрэг хуулийн 18.1.5, 18.2.1/

Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсролын хуульд авлигыг үл тэвчих хүмүүжил олгох агуулга тодорхой тусгагдаагүй байна.

Монгол Улсын хууль тогтоомжид Конвенцийн төрийн албан хаагчаас нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх шаардлагыг хангахуйц боловсролын болон сургалтын хөтөлбөрийг хөхиүлэн дэмжсэн зохицуулалт байдаггүй байна. Авлигын эсрэг хуулиар

Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудад авлигатай тэмцэх, хөрөнгө орлогын мэдүүлгээ хэрхэн мэдүүлэх талаар сургалт явуулах үүргийг өгсөн нь Конвенцийн чиг үүргээ биелүүлэхэд нь гарч болзошгүй авлигын эрсдлийн талаархи мэдлэгийг нь дээшлүүлэх мэргэшсэн бөгөөд зохих тусгай сургалтаар хангасан байх шаардлагад нийцэж байна гэж үзэж байна. Авлигатай тэмцэх газрын сургалт явуулдаг ажилтнууд нь авлигын чиглэлээр мэргэшсэн байдаг тул мэргэжлийн түвшинд төрийн албан хаагчид сургалт явуулдаг гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн албаны тухай хуулинд төрийн албанд анх орж байгаа иргэдийг сургалтанд хамруулдаг байх, уг сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх, гарч болзошгүй авлигын эрсдлийн талаарх зохих агуулгыг тусгасан байх шаардлагатай.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх ажлын явцад тухайн төрийн байгууллагын даргын тушаалаар нэг эрх бүхий ажилтан томилдог ба тухайн ажилтан нь Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэгч урин өөрийн байгууллага дээр авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар сургалт тогтмол хугацаанд зохион байгуулдаг. Авлигатай тэмцэх газар мэдүүлгийн бүрдүүлэлтийн чиглэлээр 2013 онд давхардсан тоогоор 200 орчим байгууллагын 1423 эрх бүхий албан тушаалтан, 9557 мэдүүлэг гаргагч, нийт 10980 албан тушаалтныг хамруулсан сургалтыг зохион байгуулж ажилласан.²⁵
- Авлигатай тэмцэх газар нь хүний нөөцийн чадавхийг сайжруулах ажлын хүрээнд энэхүү тайлангийн Хоёрдугаар бүлгийн 2 дах хэсэг буюу Конвенцийн 6 дугаар зүйлийн 2-ийн практик хэрэгжилтэд дурдсан сургалтанд албан хаагчдаа хамруулсан байна. Төрийн албаны зөвлөлийн дэргэд Төрийн албаны институт ажилладаг. Энэхүү институт нь төрийн байгууллага чиг үүргээ, төрийн албан хаагч албан үүргээ, төрийн албаны зөвлөл хуулиар тогтоосон бүрэн эрхээ үр ашигтай, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах, судалгаа хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх төрийн үйлчилгээний байгууллага юм. Уг институт нь доорх чиглэлээр төрийн албан хаагчдад сургалт явуулдаг:
 - Байгууллагын стратегийн төлөвлөлт
 - Байгууллагын гүйцэтгэлийн удирдлага
 - Байгууллагын өөрчлөлт хөгжил
 - Байгууллагын хүний нөөцийн хөгжил

²⁵ Авлигатай тэмцэх газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан

- Байгууллагын удирдах ажилтны манлайлал
- **Төрийн албаны ёс зүй, соёл** ²⁶
- Удирдлагын академи нь Монгол улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор Төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, нийтийн албан хаагчдыг сургах, давтан сургах, нийтийн албаны хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах үүрэг бүхий Удирдлагын академийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулагдсан.²⁷
Удирдлагын академи нь төрийн албан хаагчийн ёс зүй гэсэн хичээл заадаг. Энэ хичээлээр авлигыг үл тэвчих хандлагын талаар ордог байх магадлалтай тул Удирдлагын академаас ёс зүйн хичээлийн хөтөлбөртэй танилцах талаар хүсэлт тавьсан боловч хөтөлбөрийг танилцуулах боломжгүй гэсэн хариу өгсөн юм. Ёс зүйн хичээлийн хүрээнд төрийн албан хаагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлдэг байвал зохино.

Авлигатай тэмцэх газраас ажилчдаа мэргэшүүлэх олон төрлийн сургалтанд идэвхтэй хамруулдаг, мөн түүнчлэн бусад төрийн албан хаагчийг авилгаас ангид байх сургалт явуулдаг боловч системтэй, тодорхой хөтөлбөр бүхий сургалт үгүйлэгдэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Харин төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институт нь удирдлагын чиглэлийн сургалт голчлон заадаг бөгөөд нийтийн албан хаагчийг давтан сургах гол чиг үүрэгтэй Удирдлагын академийн ёс зүйн хичээлийн агуулгад авлигаас урьдчилан сэргийлэх, гарч болзошгүй авлигын эрсдэлийн талаарх зохих агуулгыг оруулах
- Төрийн албаны институт, Удирдлагын академтэй Авлигатай тэмцэх газрын зүгээс хамтран ажиллан, сургалтын агуулыг Конвенцийн заалтад нийцүүлэх арга хэмжээ авах
- Авлигатай холбоотой байж болох, эсхүл ёс зүйн шаардлага зөрчсөн ажилтныг ёс зүйн сургалтанд албан ёсоор суулгах арга хэмжээ авч болохыг судалж шийдвэрлэх **/Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29.7/**
- Авлигаас ангид байх ёс зүйг төлөвшүүлэх сургалтыг системтэй, тодорхой хөтөлбөрийн дагуу явуулах

3.2. Оролцогч улс бүр нийтийн албан тушаалд нэр дэвших, сонгох шалгуурыг тогтоох зорилгоор хууль тогтоох болон захиргааны зохих

²⁶ Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас

http://csc.gov.mn/main/index.php?option=com_content&view=article&id=462&Itemid=53

²⁷ Удирдлагын академийн цахим хуудас <http://www.naog.gov.mn/about/intro>

арга хэмжээг энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг мөн авч үзнэ. /Конвенцийн 7.2/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улс нийтийн албан тушаалд нэр дэвших, сонгох шалгуур түүний журам болон захиргааны арга хэмжээг хуулиар тогтоож өгсөн байдаг. Энэ нь Конвенцийн шаардлагад нийцэж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5 болон 23.6-д Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлж тус байгууллага нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг ажлын 10 өдөрт багтаан хянан үзээд тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ гэж заасан байдаг.

Төрийн албан хаагчид тавигдах ерөнхий болон тусгай шаардлагын талаар энэхүү дүгнэлтийн 3.1-ийн (а)-д тодорхойлсон байгаа тул тэндээс харна уу.

Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагч удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон, Монгол Улсын харьяатаас гарсан зэрэг үндэслэлээр төрийн албанаас хална. /25.1/

Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг, төрийн жинхэнэ албан хаагчийн хориглох үйл ажиллагаа, төрийн албан хаагч, иргэнээс мэргэшлийн шалгалт авах, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, түүнийг томилох, чөлөөлөх, албан тушаалд дэвшүүлэх, албан тушаалаас бууруулах зэрэг асуудлаар хууль тогтоомж, стандартыг зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдсон шударга бус тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглосныг зөрчсөн болон албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна /26.1/:

- сануулах;
- албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

Дээрх сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй. /26.2./

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар Шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл зохион байгуулна гэж заасан байна. /10.1/

Шүүгчийн сонгон шалгаруулалт нь дараах журмаар явагддаг:

1. Ерөнхий шүүгч нь шүүгч хүсэлтээрээ чөлөөлөгдөх, өндөр насны тэтгэвэрт гарах бол уг орон тоо гарахаас нэг сарын өмнө, үүнээс бусад үндэслэлээр шүүгчийн сул орон тоо гарсан бол тухайн өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор энэ талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ. /10.3/
2. Шүүхийн ерөнхий зөвлөл дээрх мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх болзол, журам, нэрээ дэвшүүлэхийг хүссэн этгээдийн өргөдлийг хүлээн авах, бүртгэх, шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон зарыг нийтлэх ба цахим хуудсандаа байрлуулна. /10.4./
3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан болзлыг хангасан иргэн өргөдөл, хуульд заасан баримт бичгээ бүрдүүлэн Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ. /11.2./
4. Шүүхийн ерөнхий зөвлөл нь нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авч, бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан, нэр дэвшигчийг бүртгэж тухайн шүүхийн болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ. /11.4, 11.5/
5. Нэр дэвшигчийн талаар олон нийтээс хуульд заасан шаардлага хангасан хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгаж, бодитой санал дүгнэлт гаргаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдэд Шүүхийн мэргэшлийн хорооны ажлын алба танилцуулна. /11.6./
6. Шүүхийн ерөнхий зөвлөл нь нэр дэвшигчийн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх үнэлгээг гаргуулахаар холбогдох материалыг Шүүхийн мэргэшлийн хороонд хүргүүлнэ. /11.7/
7. Нэр дэвшигч нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх үнэлгээг Шүүхийн мэргэшлийн хороо бүртгэл дууссанаас хойш 14 хоногийн дотор гарган Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ. /12.1/
8. Хуульчдын холбоо нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ. /12.2./
9. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан баримт бичиг, нэр дэвшигчийн талаар олон нийтээс хуульд заасан шаардлага хангасан хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг судлан үзэж, нэр дэвшигч бүртэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулж дүгнэлт гаргана. /13.1/
10. Шүүхийн ерөнхий зөвлөл нь дээрх дүгнэлт, Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ болон Хуульчдын холбооны дүгнэлтийн хамт шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг үнэлгээний дүнгээр эрэмбэлж гарган, илээр санал хураан олонхын санал авсан хүний нэрийг ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. /13.2./
11. Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн

- шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар тус тус Ерөнхийлөгч томилно. /15.1./
12. Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигчийг судлан үзэж, түүнийг томилох буюу томилохоос татгалзах шийдвэрийн аль нэгийг гаргана. /15.2./
 13. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно. /15.3./
 14. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг гурван жилийн хугацаагаар томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно. /15.4./
 15. Ерөнхийлөгч шүүгчийг томилсон тухай зарлиг гаргана. /15.5./

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31.1 болон 31.2-д Шүүгч зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон шүүгчийн ёс зүйг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн бол холбогдох сахилгын болон хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ, Шүүгчийн алдаа, гаргасан зөрчлөөс хувь хүн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг Иргэний хуульд заасан үндэслэлийн дагуу төр хариуцан арилгана гэж заасан байдаг.

Шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. /32.1/ Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ. /32.2/

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар шүүгчид дараах журмаар хариуцлага хүлээлгэнэ:

1. Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Ёс зүйн хороонд гомдол гаргана. /33.1/
2. Дээрх гомдлыг Ёс зүйн хороо заавал хянан үзнэ. /33.2/
3. Ёс зүйн хорооны гишүүн гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгана. /34.1/
4. Ёс зүйн хороо гомдол, хүсэлтийг шалган шалгалтын дүнг Ёс зүйн хорооны гурван гишүүн хянаж, сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай тогтоол гаргана /34.2/
5. Ёс зүйн хороо сахилгын хэргийг 30 хоногийн дотор нийт гишүүний олонхын ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. /35.1/
6. Ёс зүйн хороо сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана /36.1/ :
 - a. сахилгын шийтгэл ногдуулах;
 - b. сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох;
 - c. сахилгын хэргийг дахин шалгуулах;
7. Ёс зүйн хорооны шийдвэрийг гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор гомдол гаргагчид болон сахилгын хэрэгт холбогдсон шүүгчид хүргүүлнэ. /36.2/
8. Шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол түүнд дор дурдсан сахилгын арга хэмжээний аль нэгийг авна /37.1/ :
 - a. сануулах;

- b. зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах;
 - c. огцруулах.
9. Шүүгчид сахилгын арга хэмжээ оногдуулсан тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. /37.2./

Прокурорын байгууллагын тухай хууль

Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвараар шаардлага хангасан, хуульчийн мэргэжлээр гурваас доошгүй, эсхүл прокурорын туслах ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, хорин гурван нас хүрсэн Монгол Улсын иргэнийг прокуророор томилно. /39.1./

Аймаг, нийслэлийн болон дагнасан прокуророор хуульчийн мэргэжлээр таваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно. /39.2./

Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор гучин таван нас хүрсэн, хуульчийн мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно. /39.3./

Прокурор хууль болон байгууллагын дотоод журмыг зөрчсөн, прокурорын ёс зүйн хэм хэмжээ, хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь сахилгын шийтгэл оногдуулна /44.1./:

- сануулах;
- албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- албан тушаал бууруулах;
- ажлаас халах.

Прокурорын шийдвэр хүчингүй болсон буюу өөрчлөгдсөн нь түүний гэм буруугаас шалтгаалсан бол сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно. /44.2./

Прокурорын ёс зүй зөрчсөнөөс бусад үндэслэлээр аймаг, нийслэл, дагнасан болон дүүргийн прокурор нь сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэлийг харьяа прокурорт оногдуулж болно. /44.3./

Прокурорын сахилгын дүрмийг Ерөнхийлөгч батална. /44.4./

Прокурор сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш нэг сарын дотор дүүргийн прокурор оногдуулсан бол нийслэлийн прокурорт, аймаг, нийслэл болон дагнасан прокурор оногдуулсан бол Улсын ерөнхий прокурорт, Улсын ерөнхий прокурор оногдуулсан бол шүүхэд тус тус гаргана. /44.5./

Прокурор гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноор Улсын ерөнхий прокурор түүнийг ажлаас нь хална. /44.6./

Цагдаагийн албаны тухай хууль

Цагдаагийн албаны тухай хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн цагдаагийн алба хаагчид ял шийтгэл хүлээлгэхээргүй бол Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон цагдаагийн албаны ёс зүйн дүрмийг баримтлан сахилгын хариуцлага ногдуулна. /41.1./

Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль нь батлагдаагүй байгаа, гэвч Цагдаагийн албаны тухай хуулийн 41.1-дэх заалтад энэ хуулийг иш татсан байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, албан үүрэгтэй нь холбогдуулан алба хаагч, түүний хамаарал бүхий этгээдийг болон тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн үндэслэлээр цагдаагийн албанаас чөлөөлөгдсөн иргэнийг заналхийлсэн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. /41.2./

Гаалийн тухай хууль

Гаалийн улсын байцаагч албан үүрэгтээ хайнга хандсан, эсхүл гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор гаалийн байгууллагад өгөх бичиг баримтаас өөр бичиг баримт мэдүүлэгчээс шаардах болон бусад хэлбэрээр бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн гаалийн хууль тогтоомж, өргөсөн тангарагаа зөрчсөн тохиолдолд дараахь сахилгын шийтгэлийг ногдуулна /284.1./:

- сануулах;
- зэрэг дэвийг 1 жил хүртэл хугацаагаар бууруулах;
- албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах;
- гаалийн улсын байцаагчийн эрхийг хасах;
- гаалийн албанаас халах.

Дээрх сахилгын шийтгэлийг гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан ногдуулах бөгөөд сахилгын шийтгэлийг дэс дараалан хэрэглэх шаардлагагүй. /284.2./

Гаалийн болон бусад хууль тогтоомж зөрчсөн гаалийн байгууллагын албан тушаалтан, гаалийн улсын байцаагчид сахилгын, захиргааны, эрүүгийн болон бусад хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хүлээлгэнэ. /290.1./

Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар Гаалийн улсын байцаагчийн албан тушаалд иргэнийг ороход мэргэшлийн шалгалт авах болзол журам баталсан байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль

Хуульчийн мэргэжлийн шалгалтын зорилго нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх авахыг хүссэн этгээдийн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагаанд оролцох, хууль зүйн туслалцаа үзүүлэх хангалттай мэдлэг, чадвар эзэмшсэн эсэхийг тогтооход чиглэнэ. Хуульчийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд тэгш эрх, шударга ёсыг хангах, ил тод байх, хууль дээдлэх, олон нийтийн итгэлийг даах, хараат бус байх зарчмыг баримтална. /7.1, 7.2/

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн хуульчид Мэргэжлийн хариуцлагын хороо дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ /29.1./:

- хаалттай болон нээлтэй сануулах;
- шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;
- хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;
- хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй хүчингүй болгох.

Зөрчил гаргасан хуульчид өөрт нь ганцаарчлан сануулахыг хаалттай сануулах, нийтэд зарлаж сануулахыг нээлттэй сануулах гэнэ. /29.2./

Мэргэжлийн хариуцлагын хорооноос хуульчийн шүүхэд төлөөлөх эрхийг болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай түдгэлзүүлсэн бол уул хугацаа дуусгавар болсноор тухайн эрх болон зөвшөөрөл сэргээгдэнэ. /29.3./

Хуульчийн шүүхэд төлөөлөх эрх болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй түдгэлзүүлсэн бол хариуцлага тооцсон өдрөөс хойш зургаан сар тутамд шүүхэд төлөөлөх эрх болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээх асуудлыг Хуульчдын холбооны Ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны дүгнэлтийг үндэслэн Мэргэжлийн хариуцлагын хороо шийдвэрлэнэ. /29.4./

Мэргэжлийн хариуцлагын хорооноос хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгосон бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дахин олгогдохгүй. /29.6./

Мэргэжлийн хариуцлагын хороо ёс зүйн болон нөлөөллийн сургалтад албадан суулгах нэмэгдэл шийтгэлийг ногдуулж болох бөгөөд уг сургалтын зардлыг шийтгэл хүлээгч этгээд өөрөө хариуцна. /29.7./

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн албаны тухай хуулийн 26.2-д “Энэ зүйлийн 26.1-д заасан сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй” гэсэн заалт нь Гаалийн тухай хуулийн 284.2-д “284.2.Энэ хуулийн 284.1-д заасан сахилгын шийтгэлийг гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан ногдуулах бөгөөд сахилгын шийтгэлийг дэс дараалан хэрэглэх шаардлагагүй.” гэсэн хоёр хуулийн заалт нь хуулийн давхардал үүссэн байна. Гаалийн байгууллага нь төрийн албанд хамаарах тул Гаалийн тухай хуулийн энэхүү заалтыг хасан Төрийн албаны тухай хуулиас иш хийх;
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29.7-той төсөөтэй байдлаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулан “ёс зүйн сургалтад албадан суулгах” шийтгэлийн төрлийг нэвтрүүлэх.

ПРАКТИК ОРЧИН

- Авлигатай тэмцэх газрын 2013 оны тайлант хугацаанд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 10490 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас 10338 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, 152 мэдүүлэг хянагдаж байгаа юм байна.

Хянан шийдвэрлэсэн урьдчилсан мэдүүлгийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 7282-р нэмэгдсэн буюу 3,1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тус газарт ирүүлсэн урьдчилсан мэдүүлгийн 40-41 хувийг хөдөө, орон нутгаас ирүүлсэн мэдүүлэг эзэлсэн байна.

Мөн албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг тус газраар хянуулахгүйгээр хууль зөрчин томилсон 320 гаруй этгээдийн тушаал, шийдвэрийг хүчингүй болгож, шийдвэрлэсэн байна.

Хяналт шалгалтын үр дүнгээр зөрчил гаргасан нийт 89 нь буюу 35 хувь нь орон нутаг дахь байгууллагын, 166 нь буюу 65 хувь нь Улаанбаатар хот дахь байгууллагуудын, нийт 255 албан тушаалтанд 43 хувь буюу 110-т нь ХАСМХОМ-ийн, 18 хувь буюу 45-т нь өргөдөл, гомдлын, 39 хувь буюу 100-д нь мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар тус тус хариуцлага тооцуулсан байна.

Хариуцлага тооцуулсан нийт 255 албан тушаалтаны 26 нь ажлаас халсан, 22 нь албан тушаал бууруулсан, 94 нь албан тушаалын цалинг 3 хүртэл сарын хугацаанд 30 хувиар бууруулсан, 95 нь сануулсан, 18 нь бусад арга хэмжээ гэсэн тоон үзүүлэлттэй байна.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайлангаар зөрчил гаргасан **37** албан тушаалтнаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан зэрэг шалтгааны улмаас **2** мэдүүлэг гаргагчид хариуцлага тооцох боломжгүй байсан. **31** албан тушаалтанд “Сануулах”, **2** албан тушаалтанд ажлаас “Халах” сахилгын арга хэмжээг тус тус авахуулсан байна.²⁸
- УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд ИТХ-ын Төлөөлөгчдийг чадавхижуулах үндэсний хэмжээний сургалтыг зохион байгуулж буй бөгөөд 2014 оны 2-р сарын 17-нд Булган, Дундговь, Дорнод аймгийн ИТХ-ын нийт Төлөөлөгчдийн сургалт болсон. Төслийн нэгж, аймгийн ИТХ-ын ажлын албатай хамтран 7 сэдвийн 24 цагийн чадавхижуулах сургалтыг зохион байгуулан 3 аймгийн 900 гаруй ИТХ-ын Төлөөлөгчид сургалтанд хамрагдсан байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн үндэсний сургалтыг дараах 7 сэдвийн дор явуулсан байна: “Нутгийн өөрөө удирдах байгууллагын Үндсэн хуулийн ба эрх зүйн үндэс”, “Иргэдийн оролцоо, иргэдтэй харилцах”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг зохион байгуулах”, “Орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлага”, “Авлигаас урьдчилан сэргийлэх”, “Байгаль орчин – ногоон хөгжил”, “Хүний эрх ба жендэр”.²⁹

²⁸ Авлигатай тэмцэх газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан

²⁹ Эх сурвалжийг <http://www.khural.mn/n/rc>

Ийнхүү төрийн албан хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ажил хийж байгаа нь сайшаалтай байна.

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тайланг үзэн дараах байгууллагууд хариуцлага хүлээлгэсэн байна:
 - Цагдаагийн ерөнхий газар 2013 оны хувьд үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 15 алба хаагчид цолны мөнгийг хасахаар, 50 алба хаагчийн цалинг тодорхой хувиар бууруулахаар, 57 алба хаагчийн цолыг нэг шат бууруулахаар, 15 алба хаагчийн офицер цолыг хурааж цагдаагаар томилон ажиллуулах, 5 алба хаагчийг албан тушаал бууруулан сахилгын шийтгэл оногдуулсан байна.³⁰
 - Авлигатай тэмцэх газар 2013 оны хувьд хяналт шалгалтын ажлын чиглэлээр сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан 18 хүнд холбогдох 17 материал, захиргааны зөрчил гаргасан 4 хүнд холбогдох 5 материалд албаны шалгалтыг явуулж, боловсон хүчний судалгаагаар 20 хүнд холбогдох 20 материалыг танилцуулж нийтдээ 42 хүнд холбогдох 42 материалд холбогдох шалгалтыг явуулсан байна.³¹
 - Шүүхийн ерөнхий зөвлөл 2012 оны хувьд Тайлангийн хугацаанд шүүхийн Тамгын 1 хэлтсийн даргад сахилгын арга хэмжээ ногдуулсан байна. Ажлын албаны 3 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан бөгөөд цаашид ажлын сахилгы бат, ёс хэм хэмжээг чанд сахих чиглэлээр анхааран ажиллах болно.³²
 - Гаалийн ерөнхий газар 2013 оны хувьд Ёс зүйн хороог ГЕГ-ын даргын тушаалаар байгуулж, ёс зүй болон сахилгын зөрчил гаргасан ажилтнуудыг тусгай хө-төлбөрийн дагуу сургалтад хамруулсан байна.³³
 - Улсын ерөнхий прокурорын газар 2013 онд үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандсан, алдаа дутагдал гаргасан, прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үндэслэлээр 19 прокурор Улсын Ерөнхий прокурорын тушаалаар сахилгын арга хэмжээ авагдсанаас ажлаас халагдсан 5, албан тушаал бууруулсан 1, цалингийн тодорхой хувь хассан 8, сануулах сахилгын шийтгэл хүлээсэн прокурор 3 байна.³⁴

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны тайлан цахим хуудсанд нь байхгүй байх тул танилцаж чадсангүй.

³⁰ Цагдаагийн ерөнхий газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан

³¹ Авлигатай тэмцэх газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан

³² Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2012 оны үйл ажиллагааны тайлан

³³ Гаалийн ерөнхий газрын 2013 оны гүйцэтгэлийн тайлан

³⁴ Прокурорын ерөнхий газрын 2013 оны үйл ажиллагааны товч тайлан

<http://prokuror.mn/?p=6361>

ЗӨВЛӨМЖ:

- Тайлангаа цахим хуудсандаа байршуулж хэвших

3.3. Оролцогч улс бүр сонгогддог нийтийн албан тушаалд нэр дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг мөн авч үзнэ. /Конвенцийн 7.3/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцийн дагуу сонгогддог нийтийн албан тушаалтанд хамаарах арга хэмжээ нь Монгол Улсын хувьд **Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулиудаар** зохицуулагддаг болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль

Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байдаг. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэн анхан шатны сонгуулиар Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана.

Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол дахин сонгууль явуулна. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. /Монгол Улсын Үндсэн хуулийн 31-р зүйл/

Улсын Их Хурлын сонгууль

Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ,

чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно. /Монгол Улсын Үндсэн хуулийн 21-р зүйл/

Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгууль

Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгууль нь тухайн аймаг, сум, дүүрэгт байнга оршин сууж байгаа иргэд нутгийн өөрөө удирдах байгууллагаа өөрсдийн төлөөлөгчдөөр бүрдүүлэх үндсэн арга юм. Сонгууль нь ээлжит, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль гэсэн төрөл зүйлтэй байна.

Гурван сонгуулийн хуулийг давхардсан заалтуудыг хүснэгтээр харууллаа.

№		Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай	Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай	Тайлбар
1	Зарчим	- хууль дээдлэх; - ил тод байдлыг хангах; - шударга ёсыг сахих; - маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шударга шийдвэрлэх; - сонгогчдын эрх, сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хуулийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх. /9.1/	- хараат бус, - нээлттэй, - ил тод, - хариуцлагатай, - иргэдэд хүртээмжтэй - асуудлыг тал бүрээс нь хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж олонхийн саналаар шийдвэрлэх /3.1/	- нийтээрээ, - чөлөөтэй, - тэгш, - шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох /5.1./	Эхний хоёр хуулийн ил тод зарчим нь Конвенцийн ил тод байх зарчимд нийцэж байна гэж үзэж байна. Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн зарчимд Конвенцийн ил тод байх зарчмыг суулгаж өгөөгүй байгаа нь Конвенцийн заалтад нийцүүлээгүй байна гэж үзэж байна.
2	Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа	Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ /10.1./ :	Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ /10.1./ :	Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ /10.1./ :	Гурван хуулинд санхүүжилтийн талаар маш дэлгэрэнгүй

		<ul style="list-style-type: none"> • сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал, нэр дэвшигч, улс төрийн нам, хамтарсан намуудын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх, нэр дэвшигчийн хамгаалалтын зардал, түүнчлэн саналын хуудас, сонгуулийн дүн, мэдээний маягт, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, сонгуулийн хэсгийн хороод /цаашид “сонгуулийн хороод” гэх/-ын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, лац, сонгогчийг бүртгэх, санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, программ хангамж, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл болон тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, санал хураалтын дүнгийн мэдээ дамжуулах зардал; • саналын хайрцаг хийх, хүргэх, сонгуулийн хэсгийн хороодын ажиллах болон санал авах байрыг тохижуулах зардал; • сонгуулийн тухай хууль тогтоомж болон сонгууль зохион 	<ul style="list-style-type: none"> • сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх, түүнчлэн саналын хуудас, бие даан нэр дэвшигчийг дэмжигч-сонгогчдын гарын үсэг цуглуулах маягт, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн дүн, мэдээний маягт, сонгуулийн тойргийн болон салбар, хэсгийн хороодын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, лац, санал авах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, программ хангамж, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл болон тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх зардал; • саналын хайрцаг хийх, сонгуулийн хэсгийн хороодын ажиллах болон санал авах байрыг тохижуулах зардал; • сонгуулийн тухай хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын 	<ul style="list-style-type: none"> • сонгуулийн тухай хууль тогтоомж, түүнийг сурталчилсан материал хэвлэх, тамга, тэмдэг, лац, тусгай тэмдэг тавих хэрэгсэл, сонгуулийн техник хэрэгслийн сэлбэг, техник, тоног төхөөрөмж, тэдгээрийг худалдан авах, саналын хайрцаг хийх болон тэдгээрийг тээвэрлэх, хүргэх зардал; • сонгуулийн тухай хууль тогтоомж, заавар, гарын авлагыг хэвлэх, тэдгээрийг аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хороо /цаашид “сонгуулийн хороод” гэх/, сонгогч, шаардлагатай бусад этгээдэд хүргэх, сурталчлах, тайлбарлан таниулах, сонгогчдыг бусад мэдээллээр хангах арга хэмжээний зардал; • сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал; • онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал; • нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт болон түүний зарцуулалтыг хянахад гарах зардал; • дахин санал хураах, ээлжит бус, нөхөн болон дахин 	<p>суулгаж өгсөн байна. Мөн захиргааны арга хэмжээний талаар дотоодын хуулидаа суулгаж өгөх гэсэн Конвенцийн шаардлагад нийцүүлсэн байна гэж үзэж байна. Гэвч хуулийн заалтууд хоорондоо давхардал үүссэн байна.</p>
--	--	--	---	--	--

		<p>байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх зардал;</p> <ul style="list-style-type: none"> • сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал; • сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал; • Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн улс төрийн нам, хамтарсан намууд болон нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал; • дахин болон нэмэлт санал хураах, ээлжит бус болон дахин сонгууль явуулах зардал; • сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн хороонд ажилласан хугацааны 	<p>авлага хэвлэх, хүргэх зардал;</p> <ul style="list-style-type: none"> • сонгуулийн тойргийн болон салбар, хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүний сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал; • сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал; • нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал; • дахин санал хураах, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль явуулах зардал; • сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүний тухайн сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал; • сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал; • онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал; 	<p>сонгууль явуулах зардал;</p> <ul style="list-style-type: none"> • саналын хуудас, сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх, тээвэрлэх, хүргэх зардал; • сонгогчийн бүртгэл, сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагаанд техник хэрэгсэл, программ хангамж ашиглах, түрээслэх, тэдгээрийг хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, татан авах зардал; • сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал. <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцоог боловсруулж Улсын Их Хуралд хүргүүлнэ. /10.2./</p> <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцоог Улсын Их Хурал хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж, шийдвэрлэнэ. /10.3./</p> <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ /10.4./ :</p> <ul style="list-style-type: none"> • нэр дэвшигч, нам, эвслийн сонгуулийн ажил эрхэлсэн ажилтан, нэр дэвшигчийн шадар 	
--	--	---	---	--	--

		<p>мөнгөн урамшуулал, хоолны зардал;</p> <ul style="list-style-type: none"> • сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал; • гадаад улсад байгаа иргэдийн санал авахтай холбогдон гарах зардал; • онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал; • Улсын Их Хурлаас баталсан сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал. <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, улсын бүртгэлийн байгууллагын төсөвт тусгана /10.2/ :</p> <ul style="list-style-type: none"> • сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, хэвлэх, тээвэрлэж хүргүүлэх, татан авах зардал; • сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, түүнийг цахим хуудаст байрлуулах, хэвлэх, хүргэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал; 	<ul style="list-style-type: none"> • Улсын Их Хурлаас баталсан бусад зардал. <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг улсын бүртгэлийн байгууллагаас гаргасан хүн амын тоонд түшиглэн тооцон гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр батална. /10.2./</p> <p>Тойргийн болон салбар, хэсгийн хороодын ажиллах болон санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө. /10.3./</p> <p>Тойргийн болон салбар, хэсгийн хороодыг ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна. /10.4./</p> <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлд төрийн аудитын төв болон орон нутгийн байгууллага аудит</p>	<p>туслагч, түүнчлэн сонгуулийн хорооны гишүүний болон ажиглагчийн үнэмлэх, бие даан нэр дэвшигчийг дэмжигч-сонгогчдын гарын үсэг зуруулах маягт, сонгуулийн дүн мэдээний маягт, сонгуулийн хорооны албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлэх, тээвэрлэх, хүргэх зардал;</p> <ul style="list-style-type: none"> • сонгуулийн хороодын ажиллах болон санал авах байрыг тохижуулах зардал; • сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал; • сонгууль зохион байгуулахтай холбогдуулж хууль тогтоомжид заасны дагуу тухайн аймаг, сум, дүүргийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр, дүрэм, журмыг хэвлүүлэх, хүргүүлэх, сурталчлах зардал; • сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүний тухайн сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал; • сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал. <p>Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, түүний итгэмжлэгдсэн</p>	
--	--	--	--	---	--

		<ul style="list-style-type: none"> • улсын бүртгэлийн байгууллагын ажилтан болон итгэмжлэгдсэн ажилтны зардал, мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал; • улсын бүртгэлийн байгууллагын ажилтан болон итгэмжлэгдсэн ажилтны сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал; • сонгогчдыг бүртгэх, санал авах техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын ажилтны томилолт, унааны зардал, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий мэдээлэл технологийн шуурхай багийн мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал; • дахин болон нэмэлт санал хураах, ээлжит бус болон дахин сонгууль явуулах тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагаас гаргах зардал; • онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал болон сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал. <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, цагдаагийн байгууллагын төсөвт тусгана /10.3/ :</p>	<p>хийж, дүгнэлт гаргана. /10.5./</p> <p>Энэ хуулийн 10.3-т заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 10.4-т заасныг зөрчсөн Засаг даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно. /10.6./</p>	<p>ажилтны болон сургалт зохион байгуулах, тоног төхөөрөмжийг сонгуулийн хороонд хүргэх, сонгуулийн хорооноос татан авах, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, түүнтэй холбогдох бусад зардал болон цагдаагийн хамгаалалтын зардлыг тухайн байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ. /10.5./</p> <p>Аймаг, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид сонгууль зохион байгуулахтай холбогдсон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцоог боловсруулж аймаг, сум, дүүргийн Хуралд хүргүүлнэ. /10.6./</p> <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцоог аймаг, сум, дүүргийн Хурал хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж, шийдвэрлэнэ. /10.7./</p> <p>Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигч, нам, эвслийн сонгуулийн ажил эрхэлсэн ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, түүнчлэн сонгуулийн хорооны гишүүний болон ажиглагчийн үнэмлэх, бие даан нэр дэвшигчийг дэмжигч-сонгогчдын гарын үсэг зуруулах маягт,</p>	
--	--	--	---	--	--

		<p>• санал авах байрын хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн зардал;</p> <p>• цагдаагийн албан хаагчийн томилолт, мөнгөн урамшуулал, хоолны зардал.</p> <p>Улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан хүн амын тоонд түшиглэн тооцон гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр батална. /10.4/</p> <p>Сонгуулийн хороодын ажиллах болон санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө. /10.5./</p> <p>Сонгуулийн хороодыг ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна. /10.6./</p> <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжих зардлын гүйцэтгэлд төрийн аудитын төв болон орон нутгийн</p>		<p>сонгуулийн дүн мэдээний маягт зэрэг сонгуулийн баримт бичгийн загварыг батлах ба хууль тогтоомж, дүрэм, журам, гарын авлага, материал, тамга, тэмдэг, лац, бусад шаардлагатай хэрэгслийг холбогдох сонгуулийн хороонд хүргүүлэх ажлыг зохион байгуулна. /10.8./</p> <p>Сонгуулийн хорооны ажиллах, санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит буюу тэдгээр өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө. /10.9./</p> <p>Сонгуулийн хороог ажлын байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна. /10.10./</p> <p>Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлд төрийн аудитын төв байгууллага, Сонгууль зохион байгуулахтай холбогдсон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлд орон нутгийн аудитын байгууллага аудит хийж, дүгнэлт гаргана. /10.11./</p> <p>Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10.9, 10.10-т заасныг зөрчсөн</p>	
--	--	---	--	--	--

		байгууллага аудит хийж, дүгнэлт гаргана. /10.7./ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 10.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 10.6-д заасныг зөрчсөн Засаг даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно. /10.8./		албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 10.9-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно. /10.12./	
3	Сонгуулийн төрийн хөтөлбөр	Нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт улсын төсвөөс санхүүжилт шаардагдах аливаа зорилт, арга хэмжээ, түүнчлэн мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбогдсон эрх олгох, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлогоос иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх, эсхүл зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх, түүнчлэн үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх,	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан мөрийн хөтөлбөрт мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбогдсон эрх олгох, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлогоос иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх, эсхүл зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх, түүнчлэн үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх, эсхүл ажлын байранд зуучлах, ажилд	Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасан сонгуулийн мөрийн хөтөлбөрт мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбогдсон эрх олгох, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлогоос иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх, эсхүл зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх, түүнчлэн үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулинд санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоог төрийн аудитын байгууллага ар хянуулсан байна гэж заасан байдаг бол Улсын Их Хурлын сонгуулийн тухай болон Аймаг, сум, дүүргийн иргэдийн

		<p>эсхүл ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон амлалт, түүнчлэн Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамааралгүй асуудлыг тусгахыг хориглоно. /32.2./</p> <p>Нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг төрийн аудитын байгууллагаар хянуулсан байна. /32.3./</p>	<p>оруулах зэрэг амлалт авахаар тусгахыг хориглоно. /34.3./</p> <p>Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ тусгагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн байна. /34.4./</p> <p>Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг хөндлөнгийн хяналтын байгууллагаар хянуулсан байна. /34.7./</p>	<p>үйлчилгээ үзүүлэх, эсхүл ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авахаар тусгахыг хориглоно. /33.3./</p> <p>Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ тусгагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд[6] заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн байна. /33.4./</p> <p>Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг хөндлөнгийн хяналтын байгууллагаар хянуулсан байна. /33.6./</p>	<p>төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулинд санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг хөндлөнгийн хяналтын байгууллага ар хянуулсан байна гэж заасан байгаагаараа өөр байгаа юм.</p>
4	Сонгуулийн зардал	<p>Сонгуулийн ерөнхий хороо нэг нэр дэвшигч, намаас сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг сонгуулийн жилийн гуравдугаар сарын нэгний дотор тус тус тогтооно. /41.1./</p> <p>Сонгуулийн ерөнхий хороо нэг нэр дэвшигч, намаас сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээнд багтаан намын сонгуулийн зардлыг тухайн нам нь, нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тухайн нам болон нэр</p>	<p>Сонгуулийн ерөнхий хороо тойрогт нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, хүн амын тоо зэргийг харгалзан тойрог тус бүрээр, түүнчлэн нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний дотор тус тус тогтооно. /37.1./</p> <p>Сонгуулийн ерөнхий хороо тойрогт нэг нэр дэвшигчээс сонгуульд</p>	<p>Сонгуулийн ерөнхий хорооноос аймаг, сум, дүүргээр тогтоосон ерөнхий хязгаарт багтаан аймаг, сум, дүүргийн Хурлын сонгуулийн сум, баг, хороонд нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө аймаг, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид батална. /42.1./</p> <p>Сонгуулийн ерөнхий хорооноос аймаг, сум, дүүргээр тогтоосон ерөнхий хязгаарт</p>	

		<p>дэвшигч тус тус хариуцна. /41.2./ Сонгуулийн ерөнхий хороо нэг нэр дэвшигч, намаас сонгуулийн зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн намыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно. /41.3./</p>	<p>зарцуулах зардлын дээд хэмжээнд багтаан нам, эвслийн сонгуулийн зардлыг тухайн нам, эвсэл нь, нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тухайн нам, эвсэл болон нэр дэвшигч тус тус хариуцах бөгөөд бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлаа өөрөө хариуцна. /37.2./ Энэ хуулийн 37.1-д заасан сонгуулийн зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно. /37.3./</p>	<p>багтаан аймаг, сум, дүүргийн Хурлын сонгуулийн сум, баг, хороонд нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээнд багтаан нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тухайн нам, эвсэл болон нэр дэвшигч өөрөө хариуцах бөгөөд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлаа өөрөө хариуцна. /42.2./ Сонгуулийн ерөнхий хорооноос аймаг, сум, дүүргээр тогтоосон ерөнхий хязгаарт багтаан аймаг, сум, дүүргийн Хурлын сонгуулийн сум, баг, хороонд нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, хэтрүүлсэн зардлыг улсын орлого болгон нөхөн төлүүлнэ. /42.3./</p>	
5	Сонгуулийн зардлын данс	<p>Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам нэр дэвшигчийг бүртгүүлснээс хойш тав хоногийн дотор сонгуулийн зардлын</p>	<p>Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлж Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор</p>	<p>Нам, эвсэл нэр дэвшигчдээ аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 42.1 нь</p>

		<p>сан байгуулан банкинд данс нээлгэж, Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана. /42.1./</p> <p>Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам нэр дэвшигчийг бүртгүүлснээс хойш тав хоногийн дотор сонгуулийн зардлын сан байгуулан банкинд данс нээлгэж, Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана. /42.1./</p> <p>Сонгуулийн зардлын сангийн дансанд тухайн нэр дэвшигчийн өөрийн болон нэр дэвшүүлсэн намын хөрөнгө, талархан дэмжигч нам, байгууллага, иргэдээс оруулсан мөнгөн хандивыг төвлөрүүлж, мөн дансаар дамжуулан зарцуулна. /42.2./</p> <p>Нэр дэвшигч Сонгуулийн зардлын сангийн өөр данс нээлгэхийг хориглоно. /42.3./</p> <p>Сонгуулийн зардлын санд төвлөрсөн хөрөнгийг сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчийн бичиг хэрэг, шуудан,</p>	<p>тойрогт нэр дэвшигчдээс бусад нам, эвслээс нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын нэг дансыг банкинд нээлгэн, Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана. /38.1./</p> <p>Тойрогт нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшигч тус бүр дээр, түүнчлэн бие даан нэр дэвшигч нь өөрийн сонгуулийн зардлын дансыг тойргийн хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор банкинд нээлгэн, Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана. /38.2./</p> <p>Нам, эвслийн тойрогт нэр дэвшигчдээс нам, эвслээс бусад нэр дэвшигч нь энэ хуулийн 38.1-д зааснаас өөр данс, тойрогт нэр дэвшигч нь энэ хуулийн 38.2-т зааснаас өөр данс нээлгэхийг тус тус хориглоно. /38.3./</p> <p>Энэ хуулийн 38.1, 38.2-т заасан дансанд нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, дэмжигч байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж, мөн дансаар дамжуулан зориулалтаар нь зарцуулна. /38.4./</p> <p>Энэ хуулийн 38.1, 38.2-т заасан дансанд төвлөрсөн хөрөнгийг</p>	<p>нам, эвслийн сонгуулийн зардлын нэг дансыг банкинд нээлгэн, аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороо болон орон нутгийн төрийн аудитын байгууллагад бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана. /43.1./</p> <p>Нам, эвсэл нь сум, баг, хороонд шууд нэр дэвшигч тус бүр дээр, түүнчлэн бие даан нэр дэвшигч нь өөрийн сонгуулийн зардлын дансыг холбогдох сонгуулийн хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор банкинд нээлгэн, аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороо болон орон нутгийн төрийн аудитын байгууллагад бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана. /43.2./</p> <p>Нам, эвсэл болон нэр дэвшигч энэ хуулийн 43.1, 43.2-т зааснаас өөр сонгуулийн зардлын данс нээлгэхийг хориглоно. /43.3./</p> <p>Энэ хуулийн 43.1, 43.2-т заасан дансанд нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, дэмжигч байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж, мөн дансаар дамжуулан зориулалтаар нь зарцуулна. /43.4./</p> <p>Сонгуулийн зардлын дансанд төвлөрсөн хөрөнгийг нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг</p>	<p>Конвенцийн сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлын зарчимд нийцэж байна гэж үзэж байна. Мөн хуулийн бусад заалтууд нь Конвенцийн захиргааны арга хэмжээний холбоотой заалтыг хуулиндаа суулгаж өгөх шаардлагад нийцэж байна гэж үзэж байна. Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 38.1, 38.2 Конвенцийн сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлын зарчимд нийцэж байна гэж үзэж байна. Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 43.1, 43.2 дах заалт нь Конвенцийн сонгуулийн санхүүжилтийн ил тод</p>
--	--	---	--	--	---

		<p>холбоо, унааны болон албан томилолт, хөлс, мөнгөн урамшуулал зэрэг зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна. /42.4./ Сонгуулийн зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, түүнийг зарцуулсан тухай тайлангийн загвар болон данс нээх, хаах, бүртгэл, тайланг хөтлөх журмыг Сонгуулийн ерөнхий хороо Монголбанкттай хамтран батална. /42.5./ Энэ хуулийн 42.2-42.4-т заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 42.1, 42.2, 42.4-т заасныг зөрчсөн намыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох ба энэ хуулийн 42.1-д заасан данснаас гадуур өгсөн, энэ хуулийн 42.3-т заасныг зөрчиж нээлгэсэн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг хурааж, улсын орлого болгоно. /42.6./</p>	<p>нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагчийн бичиг хэрэг, шуудан, холбоо, унааны болон албан томилолт, хөлс, урамшуулал зэрэг зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна. /38.5./ Энэ хуулийн 38.3-38.5-д заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 38.4, 38.5-д заасныг зөрчсөн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох ба энэ хуулийн 38.1, 38.2-т заасан данснаас гадуур өгсөн, энэ хуулийн 38.3-т заасныг зөрчиж нээлгэсэн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг хурааж, улсын орлого болгоно. /38.6./ Энэ хуулийн 38.3, 38.4-т заасныг зөрчсөн нь нэр дэвшигчийг</p>	<p>сурталчлах, сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагчийн бичиг хэрэг, шуудан, холбоо, унааны болон албан томилолт, хөлс, урамшуулал зэрэг зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна. /43.5./ Энэ хуулийн 43 дугаар зүйлд заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох ба энэ хуулийн 43.1, 43.2-т заасан данснаас гадуур өгсөн, энэ хуулийн 43.3-т заасныг зөрчиж нээлгэсэн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг хурааж, улсын орлого болгоно. /43.6./ Энэ хуулийн 43.3, 43.4-т заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасна. /43.7./</p>	<p>байдлын зарчимд нийцэж байна гэж үзэж байна. Хуулиуд хоорондоо мөн давхардал үүссэн байна.</p>
--	--	---	--	---	---

		нэрийн жагсаалтаас хасах үндэслэл болно. /38.7./	
--	--	---	--

Иргэн, хуулийн этгээдийн сонгуулийн сурталчилгаанд өгөх хандивын дээд хэмжээг Монгол Улсын сонгуулийн тухай хууль тогтоомжид тусгасан байдлыг харуулбал:

Хуулийн нэр	Иргэн	Хуулийн этгээд
Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль	1 000 000 ₮	3 000 000 ₮
Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль	1 000 000 ₮	3 000 000 ₮
Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	5 000 000 ₮	10 000 000 ₮

Дээрх хүснэгтийг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангаас иш татсан болно.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн хууль нь анх 1992 оны 4-р сарын 4-ний өдөр батлагдаж, 2005 оны 12-р сарын 29-ний өдөр шинэчлсэн найруулагдсан нь 2011 оны 12-р сарын 15-ны өдөр дахин шинэчлэн найруулагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа юм. **Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль** нь 2007 оны 1-р сарын 18-ний өдөр батлагдсан нь 2012 оны 9-р сарын 14-ний өдөр Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон шинэчлэн найруулагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. **Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль** нь 1993 оны 2-р сарын 15-ны өдөр батлагдан 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдөр шинэчлэн найруулагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Шинэ хуулиар иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандивын дээд хэмжээ нь доорх байдлаар өөрчлөгдсөн байна.

Хуулийн нэр	Иргэн	Хуулийн этгээд
Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль	1 000 000 ₮	3 000 000 ₮
Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль	1 000 000 ₮	3 000 000 ₮
Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	10 000 000 ₮	50 000 000 ₮

ЗӨВЛӨМЖ:

- Дээрх гурван сонгуулийн хуулиуд нь заалтууд нь хоорондоо давхцаж байгаа бөгөөд үүнийг нэгдсэн байдлаар нэг хууль болгон шинэчлэн найруулж тусгай, онцлог зохицуулалтуудыг нь дотор нь ялгаж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.
- Эсхүл нэг хуулиасаа ишлэл хийх нь зүйтэй гэж үзэж байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “Намын сонгууль эрхэлсэн байгууллага санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногт багтаан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ” гэж заасны дагуу сонгуульд оролцсон намууд Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлснийг тус байгууллага өөрийн цахим хуудсаараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуульд оролцсон нэр дэвшигч, намуудын сонгуулийн зардлын тайланг нийтэд зарласан байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2013 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НЭР ДЭВШИГЧ, НАМЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН

/мян.төг./

Орлого, зарлагын нэр		Ардчилсан нам	Монгол Ардын нам	Монгол Ардын Хувьсгалт нам	ДҮН	
Орлого	1	Намын хөрөнгө	0	565000	20	565020
	2	Нэр дэвшигчийн хөрөнгө	0	0	0	0
	3	Талархан дэмжигч намын хандив	0	0	0	0
	4	Хуулийн этгээдээс өгсөн хандив	3133710.1	288000	75415	3497125.1
	5	Иргэдээс өгсөн хандив	3498437.9	2377703.6	740420.9	6616562.4
	ОРЛОГЫН ДҮН		6632148	3230703.6	815855.9	10678707.5
Зардал	1	Сонгуулийн төрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах	667370	1227062.1	170210.4	2064642.5
	2	Нэр дэвшигчийг сурталчлах	1454689.3	2485100.5	220934.4	4160724.2
	3	Сонгуулийн уулзалт, хурал цуглаан зохион байгуулах	136386.6	270723	46099.8	453209.4
	4	Бичиг хэрэг	2566.2	39968.7	2406.2	44941.1
	5	Шуудангийн зардал	14780.9	1339.5	2761.1	18881.5
	6	Холбооны зардал	888	292387.1	0	293275.1
	7	Унааны зардал	631042.6	453825.6	16237.6	1101105.8

8	Албан томилолтын зардал	122492.7	34618.8	48481.5	205593
9	Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчийн хөлс, мөнгөн урамшуулал	3601914	263647.2	308640	4174201.1
ЗАРДЛЫН ДҮН		6632130.3	5068672.5	815771	12516573.8
Өглөг		0	1838274.5	0	1838274.5
Үлдэгдэл		17.7	305.7	84.9	408.3

Монгол улсын ерөнхийлөгчийн 2013 оны сонгуульд оролцсон нэр дэвшигч, намын сонгуулийн зардлын нэгдсэн тайлангийн дэлгэрэнгүйг доорх цахим хаягаар орж үзнэ үү:

<http://www.gec.gov.mn/details/817>

- Мөн гадны ажиглагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулийн талаар өөрсдийн ажиглалтын урьдчилсан дүн, дүгнэлтээ гаргасан байна. Үүнээс дурдвал:

Сонгуулийг ажиглахаар гадаадын олон улсын өргөн бүрэлдэхүүнтэй баг ирсэн нь сонирхол татаж байсан бол одоо тэд манай сонгуулийг хэрхэн үнэлж, дүгнэж байгаа нь анхаарал татах болов.

Хамгийн олон хүний бүрэлдэхүүнтэй баг ирүүлсэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн Газраас дараах дүгнэлтийг гаргажээ.

Тэд дүгнэлтдээ, “Сонгуулийн санал авах өдөр сонгогчид саналаа чөлөөтэй өгсөн бөгөөд саналаа нууцаар гаргах зарчим байнга хангагдаагүй хэдий ч ажиглалт хийгдсэн сонгуулийн хороодын 99 хувь нь эерэг үнэлгээ авлаа” гэцгээжээ.

Мөн “Бүх шатны сонгуулийн хороод сонгуулийн техникийн асуудлуудыг үр дүнтэй удирдсан нь ерөнхийдөө сонгуулийн оролцогч талуудын итгэлийг хүлээв. СЕХ, аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн сонгуулийн хороод шаардлагатай бэлтгэл ажлыг хуульд заасан хугацаанд нь хангасан”-ыг илтгэлдээ тэмдэглэжээ.

Үүнээс гадна “Өрсөлдөгчид сонгуулийн сурталчилгаагаа саад тотгоргүй явуулсан бөгөөд тэдний зохион байгуулсан цуглааны үеэр ямар нэг осол зөрчил гараагүй болно” гээд “Сонгуулийн санал авах өдөр тайван, амгалан болж, ажиглалт хийгдсэн санал авах байруудад бараг бүгдээрээ эерэг үнэлгээ авлаа. Зарим нэг зөрчлийг үл тооцвол сонгуулийн санал тоолох үйл явц ерөнхийдөө эерэг үнэлгээ авсан” гэж ажиглагчид дүгнэжээ.

Олон улсын ажиглагчид сонгуулийн хороодын үйл ажиллагааг дүгнэхдээ, “Бүх доод шатны сонгуулийн хороодыг хуульд заасан хугацааны дотор бүрдүүлсэн. Бүх шатны сонгуулийн хороод сонгуулийн үйл

ажиллагааны асуудлуудыг үр дүнтэй удирдсан бөгөөд ерөнхийдөө сонгуулийн оролцогч талуудын итгэлийг хүлээсэн” гэдгийг тэд онцолжээ. Түүнчлэн “СЕХ анхан шатны сонгуулийн хороодын дарга нарт сургалт явуулж тэдгээр хүмүүс нь холбогдох доод шатны хороодын гишүүдэд адилхан сургалт явуулсан байна. Энэхүү сургалтад нь олон улсын багийн ажиглагчид эерэг үнэлгээ өгсөн”-ийг дурдаад, “Монгол Улсад байгаа сонгогчдод зориулан 1,893,207 саналын хуудсыг хуульд заасан хугацаанд хэвлүүлсэн”-нийг дүгнэлтдээ тэмдэглэжээ гэж СЕХ-ны хэвлэл, мэдээллийн төлөөлөгч мэдээлэв.³⁵

Нам, эвслийн нэр	Нам, эвслийн өөрийн хөрөнгөнөөс	Хуулийн этгээдээс өгсөн хандив	Иргэдээс өгсөн хандив	Бусад орлого	Нийт орлогын дүн
МУНН	4.000.000	15.000.000	11.578.100	0.0	30.578.100
Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	1.500.000	0.0	3.005.000	0.0	4.505.000
Иргэний зориг нам	0.0	51.685.700	153.352.600	0.0	205.038.300
Ардчилсан нам	0.0	320.058.900	1.597.176.400	4.162.765.100	6.080.000.000
МОНАРХ	482.000	0.0	1.250.000	0.0	1.732.000
МАХН	526.615.000	66.500.000	150.001.100	200.000.000	943.116.400
Иргэний эвсэл	205.249.600	15.774.000	83.910.000	190.493.700	495.427.300
ДҮН	737.846.900	469.018.600	2.000.272.800	4.553.258.800	7.760.397.100

2008 оны сонгуулийн зардлын тайлангаас үзэхэд сонгуулийн санхүүжилтийн орлогын нийт үнийн дүнгийн 40 хувь нь хуулийн этгээд болон иргэдээс өгсөн хандив, “бусад” гэсэн орлого нь нийт орлогынхоо 59 хувийг эзэлж байна. Сонгуулийн хууль тогтоомжоор бол сонгуулийн санхүүжилтийн эх үүсвэрийг нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө болон хандив байхаар заасан байдаг. Гэтэл дээрх дүнгээс харахад нам эвслийн өөрийн хөрөнгө болон хандив нь нийлээд нийт санхүүжилтийн дүнгийн дөнгөж 41 хувийг эзэлж байна. Бусад орлого гэдэгт ямар эх үүсвэр бүхий орлого байгаа нь ойлгомжгүй юм. Энэ нь хэдийгээр хандивын дээд хэмжээг хуулиар хязгаарлан тогтоосон ч хандивыг хэрхэн тооцоолох, хянах вэ гэдэг асуудлыг орхигдуулсантай холбоотой байж болох юм.³⁶

- **Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 40.2-т** “Нам, эвслээс нэр дэвшигч нь санал хураалт дууссан өдрөөс хойш 15 хоногт багтаан өөрийн сонгуулийн зардлын тайлангаа нам, эвсэлдээ гаргаж өгөх бөгөөд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.” Гэж заасны дагуу сонгуульд оролцсон намууд Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлснийг тус

³⁵ Эх сурвалжийг www.olloo.mn

³⁶ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангийн 91-р хуудас

байгууллага өөрийн цахим хуудсаараа Улсын Их Хурлын 2012 оны сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг нийтэд зарласан байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ,
ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Сар өдөр	Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн нэр	Орлого	Зарлага
ҮИИ/27	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	30352.5	30334.5
ҮИИ/27	Монголын уламжлалын нэгдсэн нам	152250	151965
ҮИИ/27	Монгол ардын нам	14471847.1	14252447
ҮИИ/27	Иргэний зориг ногоон нам	1293467.4	1289953.8
ҮИИ/27	Монголын социал дэмократ нам	302150.6	298211
ҮИИ/30	Ардчилсан нам	16192643.1	16141128.4
ҮИИ/30	МАХН-МҮАН-ын шударга ёс эвлэл	3056157	3034576.3
ҮИИ/31	Монголын ногоон нам	102049.8	102165.2
ҮИИ/08	Эх орон нам	387277	378800.5
ДҮН		35988194.5	35679581.7
ҮИИ/25	А.Баясгалан /16 дугаар тойрог/	2904.5	2904.5
ҮИИ/25	Ш.Адъяаа /16 дугаар тойрог/	216700	216652.5
ҮИИ/25	С.Ганбаатар /19 дүгээр тойрог/	221116.4	216767.2
ҮИИ/27	Ж.Мөнхтөр /19 дүгээр тойрог/	198318	198318
ҮИИ/27	Ж.Энхжаргал /7 дугаар тойрог/	230000	229995.6
ҮИИ/27	Д.Мөнхцэцэг /22 дугаар тойрог/	6497.5	6497.5
ҮИИ/28	Г.Дашдэмбэрэл /20 дугаар тойрог/	5990	5990
ҮИИ/28	Ц.Мөнхбаяр /26 дугаар тойрог/	7580.8	7580.8
ҮИИ/30	Ц.Даваасүрэн /17 дугаар тойрог/	80020	80001.2
ҮИИ/02	Х.Болорчулуун /7 дугаар тойрог/	218000	217973.1
ҮИИ/06	П.Төмөрбаатар /26 дугаар тойрог/	792.9	792.9
ДҮН		1187920.1	1183473.3
НИЙТ ДҮН		37176114.6	36863055

Улсын их хурлын 2012 оны сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүйг доорх хаягаар орж үзнэ үү:

<http://www.gec.gov.mn/details/494>

- **Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45.2-т** “Нам, эвслээс нэр дэвшигч нь санал хурааж дууссан өдрөөс хойш 15 хоногт багтаан өөрийн сонгуулийн зардлын тайлангаа нам, эвсэлдээ гаргаж өгөх бөгөөд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг санал хураалт дууссан өдрөөс хойш 20 хоногийн дотор гаргаж аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороонд ирүүлнэ.”

Гэж заасан байна. Энэхүү заалтын дагуу аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороодын цахим хуудсыг хайсан боловч олдсонгүй.

- Хандив бол Монгол улсад улс төрийн нам, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилтийн гол эх үүсвэр болдог. УИХ-ын 2008 оны сонгуулийн санхүүжилтийн улс төрийн намуудын нийт орлогын дүнг харуулбал дараах байдалтай байсан байна:

Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэсэн “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл 2009” судалгааны дүнгээс үзэхэд “Улс төрийн хүрээн дэх авлига их түгээмэл буюу 4.54 /Үнэлгээг 5 онооны эрэмбээр гаргаж, дундаж үзүүлэлтээр тооцсон байна./ байна” хэмээн шинжээчид үзжээ. Уг судалгаагаар улс төрийн хүрээнд байгаа авлигын хэлбэрүүдэд “намд хандив өгөх”, “улс төрийн зорилгоор хууль бус хандив авах, өгөх” зэрэг хэлбэрүүд нь 4.4 гэсэн үзүүлэлтээр эхний байрт багтсан байна. Мөн улс төрийн хүрээнийхэнд хээл хахууль өгөх, авах хамгийн дэлгэрсэн аргад 4.6 гэсэн үнэлгээгээр “сонгуулийн болон бусад үйл ажиллагааны санхүүжилт өгөх” арга хэмжээг судалгаанд оролцогчид онцолжээ. Улс төрийн хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ 2009 оны байдлаар дараахь үзүүлэлттэй байна.

Хүчин зүйлс	Үнэлгээ
Улс төрийн хүрээн дэх бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	5.0
Улс төрийн намын томилгоо	4.71
Намын санхүүжилтийн механизм	4.57
Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.5
Одоогийн сонгуулийн тогтолцоо	4.14
ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79

Эдгээр олон улсын болон дотоодын судалгааны дүнгүүд нь улс төрийн намд байгаа авилгын түвшинг харуулж байгаа бөгөөд сонгуулийн болон улс төрийн намын санхүүжилттэй холбоотой авилга манай улсын хувьд нэн тулгамдсан асуудал болж байгааг харуулж байна. Хандивын талаарх хуулиар тогтоосон журмыг зөрчиж хандив авч зарцуулсан нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасахаар сонгуулийн хуульд заасан байна. Бодит байдал ийм байхад сүүлийн сонгуулиар хандивын хоригийг зөрчсөн талаар нам, эвсэл, нэр дэвшигч болон сонгогчдын зүгээс ямар нэгэн гомдол, санал гараагүй байна.³⁷

Зөвхөн дансаар дамжуулан хандив авч, түүнийг зарцуулах тухай хуулийн заалт хэрэгжиж буй эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Сонгуульд оролцсон намууд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулиар заасан сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх зохицуулалтаа хэрэгжүүлдэг гэж үзэж байна. Ийнхүү хүргүүлсэн тайланг Сонгуулийн ерөнхий хороо цахим хуудсаараа нийтэд мэдээлдэг нь

³⁷ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангаас 8-р хуудас

Конвенцийн сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангаж байна гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороод, нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан нийтэд ил тод болгох шаардлагатай;
- Судалгааны дүнгээр сонгуулийн хандивыг авлигын нэг хэлбэр болгодог гэж үзэж буй талаар судалгаа хийх.

3.4. Оролцогч улс бүр ил тод байдлыг хөхиүлэн дэмжих болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэхийг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн чармайна. /Конвенцийн 7.4/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2012 оны 1-р сарын 19-ний өдөр батлагдаж 2012 оны 5-р сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү хуулийн зорилт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино. Монгол Улс энэ хуулийг батлан нийтээр мөрдөж эхэлсэн нь Конвенцийн ил тод байдлыг хөхиүлэн дэмжих болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх бэхжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Конвенцийн энэхүү шаардлагатай холбоотой **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд** дараах шинэ зохицуулалтыг бий болгожээ:

Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ. /6.4./

Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ. /6.5./

Төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авах үүрэгтэй /7.2/:

хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах /7.2.2/;

Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй. /8.2./

Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно. /8.3./

Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана. /8.4./

Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй. /23.3./

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна. /25.1/

Мөн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах; /29.2.1./ хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн **23.3-т** заасан хугацаанаас удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулж хариуцлага хүлээлгэхээр заасан байна. /29.2.2./

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах үйл ажиллагаанд хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх зарчмыг хуульчилсан /5.1./

Энэ хууль төрийн байгууллага 4 чиглэлээр мэдээллээ цахим хуудсандаа байршуулж байхаар хуульчилсан болно. /Энэ тухай Конвенцийн 10,13 дугаар зүйлээс харна уу/

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо, Хууль сахиулахын их сургууль хамтран “Нийтийн эрх зүйн хэм хэмжээний хэрэглээ, анхаарах зарим асуудал” сэдэвт онол практикийн бага хурлыг 2014 оны 3-р сарын 31-ний өдөр Хуульчдын танхимд зохион байгуулжээ. Уг хуралд Гадаад харилцааны яам, Авилгатай тэмцэх газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар болон дүүргүүдийн Цагдаагийн хэлтсийн төлөөлөл оролцсон байна.

Бага хурлын үеэр ХСИС-ийн багш, ахлах дэслэгч Т.Азжаргал “Үндсэн хууль нийтийн эрх зүйн үндсэн эх сурвалж болох нь” сэдвээр илтгэл тавьж, Үндсэн хуулийг зөрчсөн цөөнгүй асуудал байгааг дурьджээ. Тодруулбал, Улсын төсвөөс гадуур 250 сая төгрөгийг тойрогтоо зарцуулах нэрийдлээр авах, “Чингис” бонд нэрийн доор улсын өрийг дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрүүлж 60

хувь болгож батлах, асуудал, УИХ-ын гишүүний нууц данс илрэх, УИХ-ын гишүүний эрхийг түдгэлзүүлэх гэх мэт үйлдлийг онцолсон байна.

ХСИС-ийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад Н.Мөнхзул “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэглээ, анхаарах асуудал” илтгэлийг хэлэлцүүлсэн.

Тэрбээр илтгэлээрээ “Сонирхлын зөрчил гэсэн ойлголт нэг талаас нийтийн албан тушаалтны ёс зүйн шаардлага, нөгөө талаас авлигын сүүдэр, шалтгаан болж яригдсаар ирсэн. Нийтийн албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэхэд хувийн сонирхол зүй бусаар нөлөөлсөн үед авлига бий болдог нийтлэг зүй тогтол байдаг. Сонирхлын зөрчил нь авлига биш, харин авлига бий болгох хөрс суурь, шалтгаан болдог. Тиймээс сонирхолын зөрчлийг зохицуулах нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх томоохон механизмд тооцогддог” гэдгийг онцоллоо. Мөн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд “нийтийн алба” гэсэн нэр томъёог хуульчлах, ашиг сонирхлын зөрчилд өртөж болзошгүй албан тушаалын жагсаалт гаргах, хувийн ашиг сонирхлын зөрчлийн мэдээлэл хүлээн авах, хариуцлага тооцох механизмыг тодорхойлох, нэгдсэн судалгаа, тайлан, хяналт бий болгох, “Offshore”-той холбоотой харилцаанд хязгаарлалт тогтоох, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйг төлөвшүүлэх шаардлагатай байгааг дурдсан юм.³⁸

Ил тод байдлыг хөхиүлэн дэмжих, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэдий ч бодит байдал дээр мэдээлэл нь олон нийтэд бүрэн хүрэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн албан хаагч “off shore” бүсэд, гадаадад нээсэн дансаа мэдүүлдэг байх талаар хуульд нэмэлт оруулах
- Авлигын эсрэг эрх зүйн шинэ орчинд нийцүүлэн “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага: MNS 6285:2011”-ыг нэн даруй шинэчлэхийг зөвлөж байна. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын зүгээс төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжүүлэх болон асуудал хариуцсан ажилтнуудыг чиглүүлэх, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг төлөвлөгөөндөө тусган эрчимтэй зохион байгуулах нь зүйтэй байна.

³⁸ Эх сурвалжийг <http://shuud.mn/?p=341728>

ДӨРӨВ ДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ
/8 дүгээр зүйл/

4.1. Авлигатай тэмцэхийн тулд оролцогч улс бүр нийтийн албан тушаалтныхаа дунд шударга, үнэнч, хариуцлагатай байх явдлыг бусад зарчмын хамт эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хөхиүлэн дэмжинэ. /Конвенцийн 8 дугаар зүйлийн 8.1./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улс Үндсэн хуулийн түвшиндээ төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг хуульчилсан байна. Уг хуулийн 46 дугаар зүйлд: “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч/ төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагч/ Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно” гэж заасан.

Төрийн албаны тухай хууль /2002/ нь Монгол Улсын төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавих шаардлага, төрийн алба хаах болзол, журам, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, баталгаа, төрийн албаны төв байгууллагын чиг үүргийг тогтоон зохицуулахад орших /хуулийн 1 дүгээр зүйл/ бөгөөд хуулийн 3.2-“Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино” гэж тодорхолсон.Тус хуулийн “Төрийн албаны зарчим” гэсэн 4 дүгээр зүйлд нийт 7 зарчим дурдсанаас нь дор дурдсан зарчимууд конвенцийн 8 дугаар зүйлтэй уялдаатай гэж үзэхээр байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн.
- ил тод байх зарчим
- ард түмэнд үйлчлэх;
- хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах.

Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан 4.1-ийн “шудрага ёс” гэх хэсэг, 4.2.3-ийн “ард түмэнд үйлчлэх” - гэсэн зарчмууд нь “шудрага”, “үнэнч” гэх зарчмуудыг илэрхийлж, конвенцийн 8 дугаар зүйлтэй нийцэж байна. Төрийн албаны тухай хуулийн 4.2.7-ийн “хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах” - гэсэн зарчим нь төрийн албан хаагчийг шууд утгаараа

“хариуцлагатай байна” гэж заагаагүй ч Иргэний хуулийн 498 дугаар зүйл болох Байгууллага, албан тушаалтан бусдад гэм хор учруулсны хариуцлагын зохицуулалтыг хэргэлж, учирсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч буюу Төр хүлээж, 498 дугаар зүйлийн 498.5-д заасны дагуу гэм хорыг арилгасан байгууллага буюу Төр өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээд буюу төрийн албан тушаалтнаас шаардаж гаргуулах замаар төрийн албан хаагчийг хариуцлагатай байлгах зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт байх тул Төрийн албаны тухай хуулийн 4.2.7 дахь хэсэг конвенцийн шаардлагад нийцэж байна.

Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албанд анх орохдоо төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөдөг. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд: “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”.

Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг нь “эх орон, ард түмнийхээ төлөө буюу үнэнч байх”, “үнэнч шударгаар” гэсэн хэсгүүд нь конвенцийн “үнэнч байх”, “шударга байх” зарчмуудад нийцүүлж өргөж байх ба “тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” гэсэн хэсэг нь “хариуцлагатай байх” зарчимд тус тус нийцэж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2012 он/ Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах зорилготой. Энэхүү хуулийн 6 дугаар зүйлд Нийтийн албан тушаалтны үйл ажиллагааны зарчмыг заасан. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т: “Албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахина” гэх хэсэг, 6.2-т: “Албан тушаалтан нь хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ” гэсэн хэсгүүд нь нийтийн албан тушаалтан шударга, хариуцлагатай байх конвенцийн дээрх зарчимтай нийцэж байна. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т: “Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна” мөн 6.4-т: “Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ” гэх хэсгүүд нь конвенцийн “үнэнч байх” зарчимд нийцэж байгаа болно.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Төрийн Албаны Зөвлөлийн 2013 оны ажлын тайлангийн хуудас 58, 1.4.1 дэх хэсгээс үзвэл 2013 онд Төрийн албаны зөвлөлд нийт 395 өргөдөл, гомдол ирүүлснийг төрөлжүүлж, бүлэглэж авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Ажлаас халагдсан-124
- Төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалт, дүгнэлт, нөөц, томилгоо-66
- Мэргэшлийн шалгалт, шалгуур, дүгнэлт, нөөц, томилгоо-79
- ТАХ-ийн хууль бус, ёс зүйгүй байдлын тухай-40
- Төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалттай холбогдолтой-21
- Сахилгын шийтгэл ногдуулсан-13
- Тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлстэй холбоотой-13
- Албан тушаал бууруулсан-9
- Өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн-7
- Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой-5
- 11-11 ТӨВ-өөс ирсэн мэдээлэл-16

Эдгээр өргөдөл, гомдлыг судлан үзэж, холбогдох байгууллага, албан тушаалтан, Салбар зөвлөлд харьяалалын дагуу өгч шийдвэрлүүлснээс гадна Төрийн албаны зөвлөл, түүний ажлын алба хариу өгч шийдвэрлэсэн байна. Эдгээрээс 2013 онд үндэслэлгүйгээр албан тушаал бууруулсан маргаан 1, мөн үндэслэлгүйгээр албан тушаалаас халсан 4, нийт 5 гомдлыг хянан шийдвэрлэх журмын дагуу Төрийн албаны зөвлөлөөс тусгайлан комисс томилон ажиллаж дүгнэлт гаргасан.

Он	Нийт өргөдөл гомдлын тоо	МАРГААН	ТАТХ-ийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хянан шийдвэрлэсэн маргаан	Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн	Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн
2012 он	234		16	4	12
2013 он	395		5	-	5
Зөрүү	101		9	-	7

Төрийн албаны зөвлөлөөс маргаан хянан шийдвэрлэсэн тухай дээрх 5 шийдвэрийн биелэлтийн хэрэгжилтийн явц дараах байдалтай байна. Үүнд:

- Зөвлөлийн шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан шууд биелүүлсэн 2
- Зөвлөлийн шийдвэрийг Захиргааны хэргийн шүүхээр хууль зүйн үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн 2,

- Зөвлөлийн шийдвэрийг Захиргааны хэргийн шүүхэд хууль зүйн үндэслэлтэй эсэхийг хянан шалгаж байгаа 1 байна.

Маргаан хянан шийдвэрлэлтийн байдалд хийсэн дүгнэлтэд тулгуурлан Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчиж байгаа нийтлэг зөрчлийг арилгах, албан тушаалтнуудыг төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдуулан гаргах шийдвэрээ хуулийн дагуу гаргах, хууль бус үйлдэл, үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах зэрэг арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдлаа хэмээн дүгнэсэн байна.

Хариуцлагатай байх зарчмын хүрээнд “Хууль тогтоогчид, төрийн өндөр албан тушаалтан болон шүүгчдэд ажил үүргээ гүйцэтгэхдээ тодорхой хэмжээний халдашгүй байдал эдлэх нь зүй ёсны асуудал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ энэхүү халдашгүй байдлын хамрах хүрээ, хэмжээний асуудал нь ихээхэн маргаантай байдаг. Зарим нь халдашгүй байдлыг хууль тогтоогчдын үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулах зорилгод чиглэдэг ардчилсан тогтолцооны цөм асуудал гэж үздэг бол нөгөө хэсэг нь хууль хүн бүхэнд тэгш үйлчлэх ардчиллын тулгуур зарчмыг алдагдуулж байна гэж үздэг. Халдашгүй байдал нь иргэдээс сонгогдсон төлөөлөгчид хууль тогтоох байгууллагад эрүүгийн болон иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээх эрсдэлгүйгээр чөлөөтэй үг хэлэх, нэр төрийг нь аливаа гүжир гүтгэлгээс хамгаалах, тохиолдлын байдлаар албадан саатуулах, цагдан хорих, тэдний хувьд улс төрийн сэдэлтэй мөрдөх ажиллагаа явуулахаас сэргийлэх зорилготой байдаг. Хуулийн ийм хамгаалалт нь төрийн өндөр албан тушаалтнуудад давуу байдал олгосон хэрэг бус харин тэдэнд албан үүргээ саадгүй гүйцэтгэх таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ юм. Улс төрчдийн халдашгүй байдал нь ардчилсан тогтолцоог хамгаалах зорилготой болохоос биш хуулиас дээгүүр, аль эсхүл хууль үйлчилдэггүй хүмүүсийн давхарга үүсгэх зорилготой бус юм³⁹.

Энэхүү үзэл баримтлал нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн (29.2 дугаар зүйл), Ерөнхийлөгч (36 дугаар зүйл), Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний (42 дугаар зүйл) халдашгүй байдлыг хуулиар хамгаалахыг заасан. Бусад хуулиар халдашгүй байдал, баталгаа эдэлдэг албан тушаалд Улсын дээд шүүхийн шүүгч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, элчин сайд, прокурор зэрэг орж байна. Монгол Улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн гишүүн орны хувьд авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор халдашгүй байдлыг тэнцвэртэй хэрэглэх үүрэг хүлээсэн болно. Уг конвенцийг 2006 онд соёрхон баталсан тул дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил заавал мөрдөх эрх зүйн акт юм⁴⁰.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлын хувьд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг анх 1997 оны 2 дугаар сарын 6-

³⁹ Монгол Улсад Ардчиллыг Бэхжүүлэхэд Үндсэн Хуулийн Гүйцэтгэсэн Үүрэг Дүн Шинжилгээ хуудас 50

⁴⁰ Монгол Улсад Ардчиллыг Бэхжүүлэхэд Үндсэн Хуулийн Гүйцэтгэсэн Үүрэг Дүн Шинжилгээ мөн хуудас 51

нд батлагдсан Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу зохицуулж байв. Уг хуулийн 13.2-д зааснаар: 1) энэ хуулийн 10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар баривчлагдсан; 2) эрх бүхий байгууллага Улсын Их Хурлын гишүүнд холбогдох эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлж өгөхийг Улсын Их Хурлаас хүссэн тохиолдолд Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэж байсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг 2006 оны 1-р сарын 26-нд баталснаар гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хороодын болон Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэх болсон. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Төрийн байгуулалтын байнгын хороонд хамаарах бөгөөд Улсын Их Хурал, түүний гишүүний бүрэн эрхтэй холбогдсон асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Уг хуульд “эрх бүхий байгууллага гишүүнийг баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 3 цагийн дотор нэн даруй мэдэгдэнэ” гэж заажээ.

Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын тухай хуулийн 6.9.1 дэх заалт буюу “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулах бөгөөд Улсын Их Хурал гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдөр авч хэлэлцээд Үндсэн хуулийн заалтын агуулгыг хэт явцууруулан, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нийтлэг зарчимд харшилсан шинж агуулсан гэсэн үндэслэлээр уг заалтыг түдгэлзүүлэх шийдвэр гаргасах боловч Улсын Их Хурлын тухай хуулийн 6.9.1-д “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан” бол гэдэг үндэслэлийг дахин хуульчилсан байна.

Улсын Их Хурлын гишүүний эдэлдэг халдашгүй байдлын хүрээг хумих арга хэмжээг тууштай авах шаардлагатай бөгөөд зөвхөн албан үүргээ гүйцэтгэх үед нь л үйлчилдэг байхаар зохицуулах нь Монгол Улсын ардчилсан тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болно. Энэ нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хүрээнд олон улсын шинжээчдийн хийсэн дүгнэлттэй нийцэж байна. Бид Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаалах тухай Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийг Үндсэн хуулиас хасах, эсхүл хүрээг нь багасгахыг зөвлөмж болгож байна. Монгол Улсын хөгжлийн өнөөгийн түвшинд улс төрийн сэдэлтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрсдэл нь авлигын болон өөрөө өөртөө зориулан шийдвэр гаргах эрсдэлээс хамаагүй бага байна. Наад зах нь авлигын хэрэгт холбогдсон тохиолдолд халдашгүй байдал үйлчлэхгүй байхаар өөрчилж болох юм. Өөр нэг шинэтгэл нь 29.3 дэх заалтын дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэдгийг болиулах зохицуулалт байж болно. Халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж Үндсэн хуульд заасан тул Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр нэлээд зүйлийг хийх боломжтой. Гэхдээ үүний тулд нэмж судалгаа хийх хэрэгтэй. Үүнтэй төстэй шинжилгээг халдашгүй

байдал эдэлж байгаа төрийн бусад албан тушаалуудын хувьд хийж, холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар шинэтгэл хийх нь зүйтэй хэмээн үзэж байна⁴¹.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн өндөр албан тушаалтны бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэсэн заалттай уялдуулан нарийвчлан судлах.

4.2. Ялангуяа, оролцогч улс бүр нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх ёс зүйн дүрэм буюу стандартыг өөрийн институцийн болон эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд хэрэглэхийг чармайна. /Конвенцийн 8.2/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг заасан байх бөгөөд 13.1.5-т: "төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;" – гэж төрийн жинхэнэ албан тушаалтанг төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, стандартыг сахиж мөрдөх үүрэг ногдуулсан байна. Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т: "Энэ хуулийн 5.1.2-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно." – хэмээн Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрмийг Засгийн газар тогтоохоор заасан нь Монгол Улс Захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрэм буюу стандартыг өөрийн эрх зүйн тогтолцоондоо оруулсан нь харагдаж байна.

Харин Төрийн Улс төрийн албан тушаалтан болон Төрийн тусгай албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, стандартын хувьд Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т: "Энэ хуулийн 5.1.1, 5.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно" – хэмээн тухайн салбар институцийг зохицуулж буй хуулиар тодорхойлхоор заасан.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн Газраас 2010 онд 288 дугаар тогтоол батлаж,

⁴¹ Монгол Улсад Ардчиллыг Бэхжүүлэхэд Үндсэн Хуулийн Гүйцэтгэсэн Үүрэг Дүн Шинжилгээ мөн хуудас 46

тогтоолын хавсралтаар “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм” батласан. Тус ёс зүйн дүрмээр “шударга ёсны”, “хууль дээдлэх”, “тэгш байдал”, “хариуцлага хүлээх”, “олон нийтэд үйлчилэх” гэсэн үндсэн гол зарчмуудыг төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа баримтлах бөгөөд шударга ёсны зарчмын хүрээнд: хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах; хууль дээдлэх зарчмын хүрээнд: төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг ямагт дээдлэн сахих; тэгш байдлын зарчмын хүрээнд: бусад төрийн албан хаагч болон үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцан байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах; хариуцлага хүлээх зарчмын хүрээнд: албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх; олон нийтэд үйлчлэх зарчмын хүрээнд: төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллах зэрэг зүйлсийг эрхэмлэн дээдэлж, төрийн бодлого, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг үзүүлэхээр заасан байна. Үүнээс үзвэл Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрэм буюу стандартыг Монгол Улс өөрийн эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд хэрэглэж байгаа нь харагдаж байх тул Конвенцийн дээрх заалтыг Төрийн захиргааны албан тушаалтан буюу тус интитуцийн хүрээнд хангаж байна гэж дүгнэж болохоор байна.

- “Төрийн Улс төрийн албан тушаалтан болон Тусгай албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, стандартыг хууль тогтоомжоор тогтооно”- хэмээн Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасан. Үүнээс Улс төрийн албан тушаалтан дотроос Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ийн Гишүүн, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд зэрэг албан тушаалтнуудын ёс зүйн дүрмийг холбогдох интитуцийн хуулиудаас шүүж үзвэл:
 - Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23-т: “УИХ-ын гишүүний бүрэн эрх нь хууль, гишүүний ёс зүйг чанд сахих”, 12 дугаар зүйлийн 12.4.3-т: “Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 24 дүгээр зүйлийн 24.3.2-т: “Ёс зүйн дэд хороо нь гишүүний ёс зүй, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэгийг сахиулах асуудлыг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй” – гэсэн зохицуулалтаас өөрөөр гишүүний ёс зүйн хэм хэмжээ, стандартыг тодорхой заагаагүй. УИХ-ын Гишүүний Ёс зүйн дүрмийг 2009 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолын хавсралтаар батласан байх бөгөөд тус тогтоолыг Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг үндэслэл болгосон байна. УИХ-ын Гишүүний Ёс зүйн дүрмийг УИХ-ын тогтоолоор баталсан нь Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасан “ Улс төрийн албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно” – гэсэнтэй нийцэж байна.

Харин:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд Ерөнхийлөгчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоосон, тодорхойлсон зохицуулалт байхгүй, харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хууль (2012 он)-ийн 25 дугаар зүйлийн 25.2-т нам дангаар нэр дэвшүүлэх тохиолдолд: “тухайн хүний Ерөнхийлөгч байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, эх орон, ард түмний тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэл, шударга ёс, хууль дээдлэх ёс, Ерөнхийлөгчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадварыг харгалзан үзэх”- шаардлагатайг дурьдсан нь Ерөнхийлөгчийн ёс зүйг зохицуулсан цорын ганц зохицуулалт болсон байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд ёс зүйн дүрэм, дагаж мөрдөх хэм хэмжээ стандарт байхгүй байна.
- Ерөнхий сайд болон засгийн газрын гишүүний ёс зүйн тухайд Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т: “Засгийн газрын гишүүн нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх, төрийн зүтгэлтний ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, төрийн болон албаны нууцыг хадгалах үүрэгтэй.” – гэж Засгийн газрын гишүүн нь ёс зүйн хэм хэмжээг чанд сахих үүрэгтэй гэсэн хэдий ч ерөнхий сайд, засгийн газрын гишүүний ёс зүйн хэм хэмжээ, стандарт тус хуулиар зохицуулаагүй байна. Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлд дурьдагдсан “төрийн зүтгэлтний ёс зүйн хэм хэмжээ” гэдэг нь ямар хэм хэмжээ болох нь тодорхойгүй бөгөөд Засгийн газрын гишүүний ёс зүйн дүрэм батлагдаагүй байна.

“Төрийн Улс төрийн албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, стандартыг хууль тогтоомжоор тогтоох тухай” Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг бүрэн хэрэгжихгүй байна.

- Төрийн Тусгай албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, стандартыг хууль тогтоомжоор тогтоосон байдлыг авч үзвэл дараах албан тушаалтнуудын ёс зүйн дүрмийг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан, дарга батлана гэсэн байна:
 - Гаалийн тухай хуулийн 274 дүгээр зүйлийн 274.4-т: “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.”- гэсэн ба 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Гаалийн Ерөнхий Газрын Даргын 534 дугаар тушаалын хавсралтаар “Гаалийн Улсын Бйцаагчийн Ёс Зүйн Дүрэм” батлагдсан байна.
 - Авлигын эсрэг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т: “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ёс зүйн болон сахилгын дүрмийг Авлигатай тэмцэх газрын дарга батална.” – гэсний дагуу Авлигатай тэмцэх газрын даргын 2008 оны 39 дүгээр тушаалын хавсралтаар “Авлигатай Тэмцэх Газрын Албан Хаагчийн Ес Зүйн Дүрэм” батлагдсан байна.
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.7-т : “Хорих байгууллагад ажиллах иргэний эрүүл мэнд, бие

бялдар, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар тогтооно.” – гэсний дагуу 2008 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Даргын дугаар А/32 тушаалын Хасвралтаар “Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллагын Ажилтны Ёс Зүйн Дүрэм” батлагдсан байна.

- Тахарын албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т: Тахарын албаны алба хаагчийн ёс зүйн дүрмийг Тахарын албаны төв байгууллагын дарга батална. Тахарын албаны алба хаагчийн ёс зүйн дүрэм холбогдох эх сурвалжаас хайхад одоогоор олдохгүй байгаагаас үзэхэд батлагдаагүй гэж үзэхээр байна.
- Төв банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.14-т: Монголбанкны Ерөнхийлөгч нь Монголбанкны ажилтны ёс зүйн дүрмийг батлах эрхийг эдлэнэ. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 164 дүгээр тушаалын хавсралтаар “Монгол Банкны Ажилтны Ёс Зүн Дүрэм” батлагдсан байна.
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7-д: “Хорооны ажилтны ёс зүйн дүрмийг баталж, биелэлтэд нь хяналт тавих эрхийг Хороо эдлэнэ.” – гэсний дагуу Санхүүгийн зохицуулах Хорооны 2007 оны 11 сарын 29-ний 179 дүгээр тогтоолын хавсралтаар “Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын Байцаагчийн Дүрэм” батлагдсан байна.
- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9-т: “Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь Улсын Их Хурлаас баталсан сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.” – гэсний дагуу Улсын Их Хурлын 2008 оны 05 сарын 06-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар “Сонгуулийн Хорооны Гишүүний Ёс Зүйн Дүрэм”-ийг батласан байна.
- Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн тусгай албан хаагчаас Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн төв байгууллагын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, шүүхийн шинжилгээний байгууллагын дарга, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг Төрийн тусгай албан хаагч хаагчидын удирдах түвшний албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, хэм хэмжээ, стандартыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулаагүй, тодорхойлоогүй, харин Цагдаагийн байгууллага, Тагнуулын байгууллагуудын албан хаагчидын ёс зүйн дүрэм, стандарт хууль тогтоомжид тусгагдаагүй, ёс зүйн хэм хэмжээ, стандарт хэрхэн зохицуулагдаж байгаа нь тодорхойгүй байна.

Төрийн тусгай албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, стандартыг хууль тогтоомжоор тогтоох тухай Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг бүрэн хэрэгжихгүй байна.

Нийтийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт түүнийг боловсруулах шатнаас эхлэх бөгөөд боловсруулах шатанд дараах зүйлийг анхаарах шаардлагатай:

- Ажилтнууд ёс зүйн дүрмийг боловсруулах, хэрэгжүүлэх бүр шатанд оролцох
- Дүрмийг сахиулах механизмыг бие болгох
- Дүрмийг мөрдөх явдал нь ажил мэргэжлийн ахиц дэвшилд хамаатай байхаар тооцох
- Дүрмийн загвар болон бүтэц нь байгууллагын тодорхой хэрэгцээнд нийцсэн байна

Тухайн салбар ангилалын нийтийн албан хаагч ёс зүйн чухам ямар хүрээнд үйл ажиллагаагаа явуулах тухай мэдээллээр иргэд, байгууллагыг хангах нь чухал ач холбогдолтой.

Нэг талаас иргэд байгууллагын зүгээс хөндлөнгийн хяналт тавих боломжтой болно, нөгөө талаас нийтийн албан хаагчид хамгаалалттай болох юм. Дүрмийн хэрэгжилтийн бас нэг гол нөхцөл бол тухайн салбар ангилалын нийтийн албан хаагчийг аргачилалаар хангах зохих дадалд сургах явдал юм. Гэтэл ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг дүгнэх дээрх үзүүлэлтүүдийн талаар мэдээлэл хомс тул дүгнэлт хийх боломгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн улстөрийн болон тусгай албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нэн даруй тогтоож, дүрмийг батлах.
- Ёс зүйн дүрмийг ил тод болгох
- Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаар зөрчлийн асуудлаас гадна тодорхой мэдээллийг тайланд тусгаж байх

4.3. Энэ зүйлийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор оролцогч улс бүр Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 51/59 дугаар тогтоолын хавсралтад орсон Нийтийн албан тушаалтны ёс зүйн олон улсын дүрэм зэрэг бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагын холбогдох санаачлагыг зохих тохиолдолд, эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн анхааралдаа авна. /Конвенцийн 8 дугаар зүйлийн 8.3./

ЭРХЗҮЙН ОРЧИН

1996 оны 12 сарын 12-ы өдрийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны тухай” НҮБ-ын Ерөнхий Хурлын 82 дахь ээлжит хурлын 51/59 тоот актын хавсралт. Нийтийн Албаны Ёс Зүйн тухай Олон Улсын Дүрэм⁴²:

I. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

1. Үндэсний хуульд заасанчлан, Нийтийн алба хаагч нь нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн, хариуцлагатай ажлын байр болно. Түүнчлэн, нийтийн алба хаагчийн бүрэн эрх нь тухайн улсын засгийн газрын ардчилсан бүтцийн дагуу нийтийн ашиг сонирхолд зориулагдсан байна.
2. Хууль болон захиргааны бодлогын дагуу нийтийн алба хаагчийн ажил, үүрэг, гүйцэтгэл нь үр ашигтай, үр дүнтэй, шудрага үнэнч байдлыг хангах ёстой. Нийтийн алба хаагч нь өөрт оногдсон ажил үүргээ хэрэгжүүлэх явцдаа үргэлж үр дүнтэй, үр ашигтай байх арга, хэлбэрийг эрэлхийж ажиллана.
3. Нийтийн алба хаагч нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэх явцдаа болон олон нийттэй харилцах үедээ боловсон, шудрага, алагчлалгүй байдлыг хангах үүрэгтэй. Тэд аль нэг бүлэг иргэдэд зохисгүй давуу эрх олгох, ялгаварлан гадуурхах, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэтрүүлэн ашиглахгүй байх үүрэгтэй.

II. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛДӨӨН

4. Нийтийн албан хаагч нь өөрийн эрх мэдлээ өөрт, эсвэл өөрийн гэр бүлийн хүмүүсд, эсвэл санхүүгийн давуу байдал бий болгох зорилгоор ашиглахгүй. Нийтийн албан хаагч нь өөрийн албан тушаал, чиг үүрэг, албан үйл ажиллагаанд харшлах, түүнийг доройтуулах ямар нэгэн гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд оролцох, албан тушаал олж авах, эсвэл санхүүгийн харилцааны болон үүнтэй адил ямар нэгэн ашиг сонирхолд автахгүй.
5. Нийтийн албан хаагч нь өөрийн албан тушаалд тавигдсан шаардлагын хүрээнд, хууль болон захиргааны бодлогын дагуу, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох санхүүгийн орлого бий болгож буй аливаа хувийн бизнес, худалдаа, санхүүгийн болон бусад үйл ажиллагаагаа дэлгэж мэдээллэх үүрэгтэй. Нийтийн албан хаагчийн хувийн болон нийтийн ашиг сонирхлын хооронд ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилдөөн илэрсэн, үүссэн тохиолдолд үүсэн нөхцөл байдлын хүрээнд тухайн ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, арилгах үүрэгтэй.

⁴² НҮБ-ын Олон Нийтийн Албаны албан ёсны цахим хуудсанаас орчуулав:
<http://www.unpan.org/DPADM/StandardsCodes/InternationalCodeofConduct/tabid/1290/language/en-US/Default.aspx>

6. Нийтийн албан хаагч нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэх явцдаа болон ажлын үр дүнд нийтийн мөнгө, хөрөнгө, ажил үйлчилгээ, мэдээллийг өөрийн албан ажил, албан үүрэгтэй холбоогүйгээр ашиглахыг хориглоно.
7. Хууль тогтоомж болон захиргааны бодлогод заасны дагуу нийтийн албан хаагч нь өөрийн албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа өмнөх ажлын байрнаас ямар нэгэн давуу тал өөрт бий болгохгүй.

III. ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

8. Нийтийн алба хаагч өөрийн албан тушаал, захиргааны бодлого болон хуулиар зааж, шаардсаны дагуу мэдэгдэх шаардлагад нийцүүлэн, хувийн хөрөнгө болон орлогыг түүнчлэн эхнэр болон өөрийн асран хамгаалалтанд байгаа этгээдүүдийн мэдээллийг хүргэнэ.

IV. БЭЛЭГ СЭЛТ БОЛОН БУСАД ШАН ХАРАМЖ АВАХ

9. Нийтийн алба хаагч нь албан үүрэг, ажил хэргээ гүйцэтгэхэд эсвэл хэрэг шийдвэрлэхэд нөлөөлж болзошгүй ямар нэг бэлэг сэлт болон бусад шан харамж шууд болон шууд бус замаар авах, авхыг хүсэхийг хориглоно.

V. МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ

10. Нийтийн албан хаагчийн эзэмшилд байгаа нууцын асуудлууд нь ажил үүргээ гүйцэтгэх явцад, эсвэл шудрага ёсны шаардлагаар болон үндэсний хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд дэлгэхгүй. Тус хязгаарлалт нь ажил үүргээсээ чөлөөлөгдсөнөөс хойш ч үргэлжилнэ.

VI. УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

11. Хууль болон захиргааны бодлогод заасны дагуу Нийтийн алба хаагчийн албан тушаалын ажил үүргээс гадуурх улс төрийн болон бусад үйл ажиллагаа нь хүлээсэн үүрэг, гүйцэтгэвэл зохих албан үүргээ шудрагаар гүйцэтгэхэд, нийтийн сонирхлыг бууруулахгүй байх ёстой.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

НҮБ-ын Ерөнхий Хурлаас баталсан Нийтийн Албаны Ёс Зүйн тухай Олон Улсын Дүрэмд жишиг болгосон, суурь зарчим, зохицуулалтыг Үндэсний хууль тогтоомж, ёс зүйн дүрэмтэй харьцуулвал:

- Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээ, дүрэм, стандарттай хийсэн харьцуулалт.
 - ОУ-ын ёс зүйн дүрмээр зохицуулж буй Ерөнхий зарчмын хүрээнд: “Нийтийн алба хаагч нь нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн, хариуцлагатай ажлын байр болно, ... бүрэн эрх нь нийтийн ашиг сонирхолд зориулагдсан байна.”, “... хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх”, “...ажил, үүрэг, гүйцэтгэл нь үр ашигтай, үр дүнтэй, шудрага үнэнч байдлыг

хангах ёстой”, “...боловсон, шудрага, алагчлалгүй байдлыг хангах үүрэгтэй” – гэсэн бол Төрийн захиргааны алба хаагчийн ёс зүйн дүрмээр Төрийн захиргааны албан хаагч нь “нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх⁴³”, “... хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх⁴⁴”, “төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх⁴⁵”, “бусад төрийн албан хаагч болон үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцан байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах⁴⁶” – гэж тус тус зохицуулсан нь ОУ-ын Ёс зүйн дүрмийн Ерөнхий зарчим хэсэгтэй нийцэж байна.

- ОУ-ын ёс зүйн дүрмээр зохицуулж буй Ашиг сонирхлын зөрчилдөөний хүрээнд: “Нийтийн албан хаагч нь өөрийн эрх мэдлээ өөрт, эсвэл өөрийн гэр бүлийн хүмүүсд, эсвэл санхүүгийн давуу байдал бий болгох зорилгоор ашиглахгүй.”, “...албан тушаал, чиг үүрэг, албан үйл ажиллагаанд харшлах, түүнийг доройтуулах ямар нэгэн гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд оролцох, албан тушаал олж авах, эсвэл санхүүгийн, харилцааны болон үүнтэй адил ямар нэгэн ашиг сонирхолд автахгүй. ”, “ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох санхүүгийн орлого бий болгож буй аливаа хувийн бизнес, худалдаа, санхүүгийн болон бусад үйл ажиллагаагаа дэлгэж мэдээллэх үүрэгтэй.”, “...ашиг сонирхлын зөрчилдөөн илэрсэн, үүссэн тохиолдолд үүссэн нөхцөл байдлын хүрээнд тухайн ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, арилгах үүрэгтэй”, “... нийтийн мөнгө, хөрөнгө, ажил үйлчилгээ, мэдээллийг өөрийн албан ажил, албан үүрэгтэй холбоогүйгээр ашиглахыг хориглоно.”, “... албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа өмнөх ажлын байрнаас ямар нэгэн давуу тал өөрт бий болгохгүй.” – гэсэн бол Төрийн захиргааны алба хаагчийн ёс зүйн дүрмээр Төрийн захиргааны албан хаагч нь “... албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөхгүй ...⁴⁷”, “өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах⁴⁸”, “өөрийн өмчийн байдал, тэдгээрт орсон өөрчлөлт, орлогын талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх⁴⁹”, “төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг албаны бус зорилгоор ашиглахгүй байх⁵⁰” – гэж тус тус зохицуулсан нь ОУ-ын Ёс зүйн дүрмээс бага зэргийн зөрүүтэй, мөн дутуу зохицуулалттай байна.

⁴³ Төрийн Захиргааны Албан Хаагчийн Ёс Зүйн Дүрэм 4.1.1.

⁴⁴ Мөн Дүрмийн 4.1.4.

⁴⁵ Мөн Дүрмийн 4.1.5.

⁴⁶ Мөн Дүрмийн 4.1.3

⁴⁷ Мөн Дүрмийн 5.1.5.

⁴⁸ Мөн Дүрмийн 5.1.4.

⁴⁹ Мөн Дүрмийн 5.1.1.

⁵⁰ Мөн Дүрмийн 5.2.5.

Тухайлбал нийтийн албан хаагч нь ажлаас чөлөөлөгдсөн ч өмнөх ажил, албан тушаалаасаа ямар нэгэн байдлаар давуу байдал олж авахгүй байх тухай зохицуулалт, хувийн болон нийтийн үйл ажиллагааны хооронд ашиг сонирхлын зөрчилдөөн үүссэн тохиолдолд тухайн зөрчилдөөнийг нөхцөл байдалд нь тохируулан бууруулах, арилгах үүргийг нийтийн албан хаагчид үүрэг болгосон зохицуулалт дутагдалтай байна.

- ОУ-ын ёс зүйн дүрмээр зохицуулж буй Хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбогдуулан “Нийтийн алба хаагч өөрийн албан тушаал, захиргааны бодлого болон хуулиар зааж, шаардсаны дагуу мэдэгдэх шаардлагад нийцүүлэн, хувийн хөрөнгө болон орлогыг түүнчлэн эхнэр болон өөрийн асран хамгаалалтанд байгаа этгээдүүдийн мэдээллийг хүргэнэ.” – гэж заасан. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмээр хөрөнгө орлогын мэдүүлгийг “өөрийн өмчийн байдал, тэдгээрт орсон өөрчлөлт, орлогын талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх үүрэгтэй⁵¹” – гэж зохицуулсан. ОУ-ын ёс зүйн дүрэм болон УИХ-ын Байнгын хорооны баталсан маягтын дагуу өөрийн өмчийн байдлаас гадна эхнэр болон өөрийн асран хамгаалалтанд байгаа этгээдүүдийг мөн хамааруулсан нь үндэсний ёс зүйн дүрэмд тусгагдаагүй байна.
- ОУ-ын ёс зүйн дүрмээр зохицуулж буй Бэлэг сэлт болон бусад шан харамж авах асуудлаар: “Нийтийн алба хаагч нь албан үүрэг, ажил хэргээ гүйцэтгэхэд эсвэл хэрэг шийдвэрлэхэд нөлөөлж болзошгүй ямар нэг бэлэг сэлт болон бусад шан харамж шууд болон шууд бус замаар авах, авахыг хүсэхийг хориглоно.” – гэж заасан бол Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмээр: “албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхгүй байх.⁵²” – гэж хориглосон үйлдлийг өргөн хүрээнд зохицуулсан ч шан харамж авхаар завдах, санал тавих зэрэг асуудлыг зохицуулалтгүй үлдээжээ.
- ОУ-ын ёс зүйн дүрмээр зохицуулж буй Мэдээллийг нууцлах тухай зохицуулалт нь “Нийтийн албан хаагчийн эзэмшилд байгаа нууцын асуудлууд нь ажил үүргээ гүйцэтгэх явцад, эсвэл шудрага ёсны шаардлагаар болон үндэсний хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд дэлгэхгүй. Тус хязгаарлалт нь ажил үүргээсээ чөлөөлөгдсөнөөс хойш ч үргэлжилнэ.” – гэсэн бол үндэсний ёс зүйн дүрмээр “албан үүргээ гүйцэтгэж байхдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх⁵³” – гэж заасан нь ерөнхий байдлаараа утга ижил боловч тухайн мэдээллийг албан тушаал, ажлын байрнаасаа

⁵¹ Төрийн Захиргааны Албан Хаагчийн Ёс Зүйн Дүрэм 5.1.1.

⁵² Мөн Дүрмийн 5.1.5.

⁵³ Мөн Дүрмийн 5.2.4.

чөлөөлөгдсөнөөс хойш хугацаанд ч үргэлжлүүлэн хадгалах асуудлыг орхигдуулсан байна.

- ОУ-ын ёс зүйн дүрмээр зохицуулж буй Улс төрийн үйл ажиллагааны талаарх зохицуулалт Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэмд тусгагдаагүй, харин Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д: “албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, төрийн бус болон шашны үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох”, 15.1.14-д: “Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч, хөрөнгийг дайчлах, албаны унаа ашиглах нь төрийн албан хаагчийн хориглох зүйлд хамаарна” – гэж заасан байна.

ОУ-ын ёс зүйн дүрэмд тусгагдсан зарим ач холбогдол бүхий зохицуулалтууд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэмд тусгагдаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг Нийтийн албаны ёс зүйн тухай Олон Улсын стандарт дүрмийн шаарлагатай зүйл, заалт, улмаар Авлигын хуулийн дүгээр зүйлийн агуулгад нийцүүлэх.

- 4.4. **Оролцогч улс бүр нийтийн албан тушаалтан нь чиг үүргээ биелүүлэх явцад өөрт нь мэдэгдсэн авлигын үйлдлийн талаар эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог тогтоох асуудлыг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ. /Конвенцийн 8.4./**

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлэх үүргийг Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т тусгасан.

Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан; төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч; төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах

болон компанийн эрх бүхий албан тушаалтан; олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал; улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан; Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч; бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч нь албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй⁵⁴ ба энэхүү заалтад заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй.

Мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс авах бол Авлигын эсрэг хуулийн 9.1-д зааснаар иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болох талаар Авлигын эсрэг хуулинд тусгасан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх харилцаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль (1997)-иар зохицуулагдах бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах талаар тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т: “Иргэн гэмт хэргийн талаар олж мэдсэн зүйлээ холбогдох байгууллагад мэдээлэх.” – гэж зохицуулсан ба тухайн мэдээллийг төлбөртэй авч болдог. Тухайн гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл нь үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд цагдаагийн байгууллага төлбөрийг олгодог⁵⁵ бөгөөд цагдаагийн байгууллага мэдээллийн нууцыг чанд хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах үүрэгтэй⁵⁶.

2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар “нөлөөллийн мэдүүлэг”-ийг Шүүгч хэрэг маргаан хянан шийдвэрлэх явцдаа хөтлөж байх тухай зохицуулалтыг оруулсан. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т: “нөлөөллийн мэдүүлэг” гэж хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хэрэг, маргааны шийдвэрлэлттэй холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан, эрүү, иргэн, захиргааны хэргийн материалд хавсаргагдах баримт бичгийг.” – гэж тодорхойлсон ба 22 дугаар зүйлд Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журмыг зохицуулсан. Шүүгч нь нөлөөллийн мэдүүлэгийг дараах журмаар хөтлөнө:

- Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээр хүлээн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлгийг хөтөлнө.
- Шүүгч нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар хэрэг үүсгэсэн даруйд тухайн хэргийн оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулна.

⁵⁴ Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.

⁵⁵ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2


⁵⁶ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5

- Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн шүүгч нөлөөллийн мэдүүлгийг хэргийн материалд хавсарган, хувийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.
- Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн 22.3-т заасан нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан тухайн этгээдийн үйлдэл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзвэл түүнийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ


АТГ-ийн Хяналт шалгалтын албанд 2013 оны байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авсан байна. Хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн 216 буюу 69,4 хувийг хувь хүн, иргэнээс, 48 буюу 15.4 хувийг төрийн байгууллага, төрийн өмчит компани, аж ахуйн нэгжээс, 29 буюу 9,3 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, 18 буюу 5,7 хувийг нэргүй мэдээлэл эзэлж байна.

Графикаар үзүүлэхэд:




Өргөдөл, гомдол, мэдээллийг агуулгын хэлбэрээр нь авч үзвэл албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн, бусдад давуу байдал олгосон талаар 79 буюу 23,2 %-ийг, хууль тогтоомж зөрчсөн, хууль бус үйлдэл гаргасан талаар 64 буюу 20,5 %-ийг, албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан талаар 95 буюу 30,5 %-ийг, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулах болон үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн талаар 48 буюу 15,4 %-ийг, бусад 25 буюу 8,3 %-ийг тус тус эзэлж байна.

Графикаар үзүүлэхэд:



Тайлант хугацаанд ирүүлсэн нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллээс 282 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн, одоо 29 өргөдөл, гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй. Хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдлоос 189 буюу 67,2 хувийг хуулийн хугацаанд буюу 30 хоногт, 93 буюу 32,8 хувийг хугацаа сунгаж хянан шийдвэрлэсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 114-р нэмэгдсэн буюу 1,1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна



Хянан шийдвэрлэсэн 282 өргөдөл, гомдол, мэдээллийг зөрчлөөр нь авч үзвэл: Албан тушаалтны буруутай үйл ажиллагааг илрүүлж, хариуцлага тооцуулахаар шийдвэрлэсэн 45 буюу 15,9 хувийг, Зөрчлийг арилгуулахаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлсэн 48 буюу 17,2 хувийг, Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар анхааруулсан буюу шаардлага хүргүүлсэн 51 буюу 18,1 хувийг, Гомдолд дурьдсан асуудал нь тогтоогдоогүй буюу зөрчил илрээгүй 53 буюу 18,7 хувийг, Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэс

болон Цагдаагийн байгууллагад харъяаллын дагуу шилжүүлсэн 26 буюу 9,2 хувийг, Төрийн байгууллагад харъяаллын дагуу шилжүүлсэн 47 буюу 16,6 хувийг, Хуульд заасан үндэслэлээр буцаасан 12 буюу 4,2 хувийг тус тус эзэлж байна.

Графикаар үзүүлэхэд:

Шийдвэрлэсэн 282-г хувиар илэрхийлбэл



Өргөдөл, гомдол, мэдээллээс хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлын талаар гомдол гаргагчид албан бичгээр хариу хүргүүлсэн 185 буюу 65,6 хувийг, амаар буюу утсаар 97 буюу 34,4 хувийг эзэлж байна. Мөн нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллээс 151 нь буюу 48,5 хувийг орон нутаг дахь байгууллага албан тушаалтантай холбоотой өргөдөл, гомдол эзэлсэн байна.

Авилгалтай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн Хэрэгжилтийн Дүн Шинжилгээний 2012 оны Тайланд Авлигатай тэмцэх газар 2007 оны 9 дүгээр сараас эхлэн албан тушаалын гэмт хэргийн шинжтэй болон төрийн байгууллагуудын ажилтнуудын хүнд суртал, чирэгдлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах “1969 утас”-ыг ажиллуулж эхэлсэн гэх бөгөөд өнгөрсөн хугацаанд 3000 гаруй гомдол, мэдээллийг хүлээн авчээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн шинжтэй 2000 орчим гомдол, мэдээлэлд байцаан шийтгэх ажиллагаа явуулж, гэмт хэргийн шинжгүй буюу төрийн байгууллагуудын ажилтнуудын хүнд суртал, чирэгдэл, ёс зүйд холбогдох 1000 гаруй гомдол, мэдээлэлд дурдсан зөрчлийг арилгуулахаар газар дээр нь ажиллажээ. Түүнчлэн “Нийгмийн толь” сонинд “1969 мэдээлж байна” буланг ажиллуулж, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг тоймлон багцалж, олон нийтэд хүргэхийн зэрэгцээ 1969 мэдээллийн мөрөөр сурвалжлага бэлтгүүлэн төрийн байгууллага дахь хүнд сурталыг арилгах,

албан хаагчийн ёс зүйг сахиулах чиглэлээр тухай бүр зохицуулалт хийж байсан байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгжид ил тод нээлттэй болгох, тэднээс ирүүлсэн санал гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөх зорилгоор “Гаалийн лавлах-1281” утасны лавлах үйлчилгээг 2008 оны 7-р сараас эхлэн бий болгосноор иргэн, аж ахуйн нэгж байгууллага гаалийн холбогдолтой мэдээ, мэдээлэлд түргэн шуурхай хариулт авахаас гадна гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн явцад гардаг зарим хүнд суртал, гаалийн улсын байцаагч нарын хууль бүс үйлдлийн талаархи санал, гомдлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой болсон. Мөн байгууллагын цахим хуудсаар дамжуулан асуулт, хариулт өгөх боломжтой болсон байна. Харьяа гаалийн газар, хороод ч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мэдээлэл олж авах тогтолцоог хялбаршуулан лавлах утасны үйлчилгээг нэвтрүүлсэн байна.” – гэжээ. Түүнчлэн, авлигад өртөх эрсдэл бүхий байгууллагуудын цахим хуудас⁵⁷ болон Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны цахим хуудсанд⁵⁸ судалгаа хийхэд Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын авлигатай холбоотой шуурхай мэдээлэл авах болон тухайн байгууллагын ажилтан, албан хаагчийн ёс зүйгүй үйлдлийн талаар гомдол, мэдээлэл өгөх зориулалт бүхий тусгай дугаар ажиллуулдаг байна. Зарим төрийн эрх бүхий байгууллагуудад тусгай дугаар байх ч лавлагаа, зөвлөгөөний чиглэлийн байх ба дийлэнх эрх бүхий төрийн байгууллагуудад нийтийн албан хаагчийн хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчил, авлигын асуудлыг мэдээлэх тусгай дугаар ажиллуулаагүй байна.

Үүнээс харвал, авлигын талаар болон ёс зүйн хэм хэмжээ, стандарт зөрчсөн нийтийн албан хаагчийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог эрх зүйн баримт бичгийн түвшинд оновчтой тодорхой зохицуулаагүй гэж үзэхээр байна.

Олон нийтэд нээлттэй байгаа мэдээллийн хүрээнд авлигын үйлдлийн талаар эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог тогтоох тухай Конвенцийн заалт практик хэрэгжилтийн түвшинд хангалтгүй гэж дүгнэхээр байна.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигын үйлдлийн талаар мэдээлэх журмыг хөнгөвчлөх, хялбаршуулах тогтолцоог бүрдүүлэх, түүнийхээ тухай олон нийтэд нээлттэйгээр мэдээлж байх нэгдсэн зөвлөмж, журам гаргаж мөрдүүлэх асуудлыг Авлигатай тэмцэх газрын түвшинд шийдвэрлэх

⁵⁷ Авлигатай тэмцэх газрын цахим хуудас: <http://www.iaac.mn/> болон Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас: <http://www.police.gov.mn/>, мөн Гаалийн ерөнхий газрын цахим хуудас: <http://customs.gov.mn/>

⁵⁸ Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим хуудас: <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=60>

4.5. Оролцогч улс бүр зохих тохиолдолд болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн, нийтийн албан тушаалтан нь чиг үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлого зэргийнхээ талаарх зохих эрх бүхий байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог тогтоохыг чармайна. /Конвенцийн 8.5./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хууль (1992) –ийн Хорин есдүгээр зүйлийн 1-т: “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын **Их Хурлын гишүүн нь** Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.⁵⁹” – хэмээн УИХ-ын гишүүний давхар албан тушаал эрхлэх асуудлыг тодорхойлсон бөгөөд Гучин нэгдүгээр зүйлийн 8-д “Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.” – хэмээн давхар албан тушаал эрхлэх асуудлыг Үндсэн хуулинд зохицуулсан.

МУ-ын Их Хурлын Гишүүний давхар албан тушаал хаших асуудлыг Үндсэн хуулиас гадна **МУ-ын Их Хурлын тухай хууль** (2006)-иар зохицуулсан байдаг. Гишүүний бүрэн эрхэд: “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах⁶⁰” – эрх хамаарах бөгөөд гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хавсран гүйцэтгэж болох ажил, албан тушаал нь “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн; улс төрийн намын сонгуульт албан тушаал; төрийн бус байгууллагын сонгуульт албан тушаал; багшлах болон эрдэм шинжилгээний ажил⁶¹” – гэж давхар хашиж болох ажил, албан тушаалын талаар зохицуулсан байна. УИХ-ын гишүүний давхар ажил, албан тушаалын талаар зохицуулсан дараагийн хууль нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012 он) юм. Тус хуулийн 18 дугаар зүйлд Нийтийн албан хаагчийн давхар хашиж болох ажил, албан тушаалыг жагсаасан ба уг жагсаалтаас бусад ажил, албан тушаал хашихыг хориглосон болно. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т Улсын Их Хурлын болон **Засгийн газрын гишүүний** давхар эрхэлж болох ажил, албан тушаал нь

- хууль болон олон улсын гэрээгээр зөвшөөрсөн ажил;

⁵⁹ МУ-ын Үндсэн Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 /Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/

⁶⁰ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.25

⁶¹ Мөн хуулийн 36.1

- нийтэд тустай үйл ажиллагаанд чиглэсэн ажил;
- багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
- хуульд заасан бол өөр өөрийн чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын болон Засгийн газрын албан тушаал;
- Хууль тогтоомжоор зөвшөөрсөн олон улсын байгууллага дахь албан тушаал. – болно.

УИХ-ын гишүүний давхар эрхэлж болох ажлыг УИХ-ын тухай хуулиар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулиар Үндсэн хуульд зааснаас өргөн хүрээнд хуульчилсан байх бөгөөд эдгээр хуулиудын зохицуулалт ч өөр хоорондоо зөрчилтэй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.” – гэж Ерөнхийлөгчийг ямар нэгэн өөр ажил, албан тушаал эрхлэхийг хориглосон.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7-д “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол Улсын Их Хурлаас байгуулагдах хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг, түүнчлэн хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлах, санал оруулахыг хориглоно.” – гэсэн.

Нийтийн албан хаагчийн хүрээнд давхар албан тушаал эрхэлж болохгүй тухай зохицуулалт нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012 он)-д дэлгэрэнгүй зохицуулагдсан бөгөөд тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно” гээд төрийн ажил, албан тушаалын ангилж дараах байдлаар хуулийн зохицуулалт хийсэн:

- Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно⁶².
- Зэвсэгт хүчний албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно⁶³.
- Энэ хуулийн 18.2-18.4-т /УИХ-ын болон Засгийн газрын гишүүний эрхэлж болох ажил, албан тушаал, ҮХ-ийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөн албаны албан тушаалтан, Зэвсэгт хүчний албан

⁶² Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18.3.

⁶³ Мөн хуулийн 18.4.

тушаалтан/ зааснаас бусад албан тушаалтан дараах ажлыг давхар эрхэлж болно⁶⁴.

- Хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;
- Багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
- Ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг.
- Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно⁶⁵.
- Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол Улсын Их Хурлаас байгуулагдах хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг, түүнчлэн хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлах, санал оруулахыг хориглоно⁶⁶.

Нийтийн албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй бөгөөд уг танилцуулга хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ⁶⁷.

Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд нийтийн албан хаагч нь албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил эрхлэх талаарх зохих эрх бүхий байгууллагад мэдүүлж байх арга хэмжээний талаарх зохицуулалт нь Авлигын эсрэг хуулиар, хориглосон, хязгаарласан зохицуулалтууд нь бусад холбогдох төрийн албаны тухай хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Монгол Улсын Их Хурлын тухай зэрэг хуулиудаар зохицуулагдсан байна.

Ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох зохицуулалтыг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлд хориглох хэлбэрээр тусгасан.

Хуульд өөрөөр заагаагүй бол албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно. /20.1/ Эрх бүхий албан тушаалтнуудын

⁶⁴ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18.5.

⁶⁵ Мөн хуулийн 18.6. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

⁶⁶ Мөн хуулийн 18.7.

⁶⁷ Мөн хуулийн 19 дүгээр зүйл

хувьд буюу Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй⁶⁸.

Дээрх үүргийг тухайн албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд энэ зүйлд заасан үүргийг нийтийн албанаас чөлөөлөгдсөний дараа хоёр жилийн хугацаанд мөн биелүүлэх үүрэгтэй. Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглох” тухай асуудлыг 20 дугаар зүйлийн 20.5-д тусгасан байна.

Хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлого авахтай холбоотой харилцааг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15, 16, 17, 22 дугаар зүйлүүдээр зохицуулсан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлээр “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглосон болно.⁶⁹”, мөн “Хууль тогтоомжоор болон Засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авахыг хориглосон⁷⁰.”

Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт нь Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг шууд хориглосон. Гэхдээ энэхүү “хориглолтод албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг болон албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй” байхаар дээрх хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан. Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс

⁶⁸ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйл

⁶⁹ Мөн хуулийн 15 дугаар зүйл 15.1.

⁷⁰ Мөн хуулийн 15 дугаар зүйл 15.2.

авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Мөн бэлэг авсанд тооцох зохицуулалт тус зүйлийн 16.7-д дараах байдлаар заасан байна “Албан тушаалтан бэлэг авахаас өмнөх хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн бэлэг өгөгч этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно.”

Хандив авахтай холбогдсон хязгаарлалт нь дээрх хуулийн 17 дугаар зүйлд тусгагдсан ба Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглодог. Энэхүү хязгаарлалтад хамаарахгүй буюу Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг авч болдог⁷¹. Албан тушаалтан нь аливаа хандив авхаар бол дээд шатны албан тушаалтанд мэдэгдэж, зөвшөөрөл авах үүрэгтэй байдаг. Дээрх байдлаар хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглосон хязгаарлалтыг мөн зүйлийн 17.4-т тусгасан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд Бусад орлогын хязгаарлалтыг тусгасан. Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олж болно⁷². Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа бол Засгийн газрын гишүүний цалин авна.

Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

- шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах;
- холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах;

⁷¹ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2

⁷² Мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1

- холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах;
- холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэх.

Авлигын эсрэг хуулиар төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан, олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан зэрэг нь хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэгтэй. Уг мэдүүлгийн маягт УИХ-ын хууль зүйн байнгын хороо батлахаар хуульчилсан. Тус маягтын дагуу холбогдох албан тушаалтан үндсэн цалин, урамшуулал, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хандивын орлого, бусад орлого, өөрт байгаа хөрөнгө зээл буюу орон сууц, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, мал аж ахуй, газар, үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл, хадгаламж, бэлэн мөнгө, харилцах данс, картны үлдэгдэл, авлага, зээл, компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт, эрх, патент, тусгай зөвшөөрөл зэрэг зүйлс хамаарна.

Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг дараах журмаар гаргахаар хуульчилсан:

- Мэдүүлэг гаргагч нь хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахдаа Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу "... өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй." ба мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй⁷³.
- Хэрэв хуулинд заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлэх тухай зохицуулалтыг Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасан болно.
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг олон нийтэд нээлттэй байлгах, эрх бүхий албан тушаалтнуудын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хэвлэн нийтлэх ба цахим мэдээллийн

⁷³ Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3

сүлжээнд байрлуулах, хэрэгжилтэнд хяналт тавих асуудлыг Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлд дэлгэрэнгүй зохицуулсан болно.

2013 онд Алигатай тэмцэх газраас 2000 орчим мэдүүлэг гаргагчийг хамарсан хяналт шалгалт хийсэн байна. Үүний үр дүнд ногдуулсан хариуцлагыг авч үзвэл:

Хариуцлага тооцуулсан байдлыг хяналт шалгалтын төрөл, хариуцлагын хэлбэр, албан тушаалтны харъяаллаар нь үзүүлбэл:

Д/д	Үзүүлэлт	Сануулсан	Цалингуулуулсан	Албан тушаал бууруулсан	Ажлаас халсан	Бусад	Бүгд	Эзлэх хувь
1	Мэдүүлгийн хяналт шалгалтаар	25	61	11	13		110	43%
2	Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар	5	20	6	10	4	45	18%
3	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар	65	13	5	3	14	100	39%
	Нийт дүн	95	94	22	26	18	255	100%
Үүнээс	Улаанбаатар хот дахь байгууллагын албан тушаалтан	59	74	14	16	3	166	65%
	Орон нутаг дахь байгууллагын албан тушаалтан	36	20	8	10	15	89	35%

Хяналт шалгалтын үр дүнгээр зөрчил гаргасан нийт 255 албан тушаалтанд хариуцлага тооцуулснаас 89 нь буюу 35 хувь нь орон нутаг дахь байгууллагын, 166 нь буюу 65 хувь нь Улаанбаатар хот дахь байгууллагуудын албан тушаалтан байна.

Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой зөрчлийн 82 хувийг Авлигатай тэмцэх газрын тодорхой түвшний хяналт шалгалтаар илрүүлсэн нь тус байгууллагаас хуульд заасан нэг гол чиг үүргээ зохих түвшинд хэрэгжүүлж байгааг илэрхийлж байна.

Авлигын эсрэг хуулиар хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг нээлттэй байлгах /25 дугаар зүйл/ түүнийг хянан шалгах /26 дугаар зүйл/, бүртгэх, хадгалах /24 дүгээр зүйл/ харилцааг нарийвчлан тогтоосон байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Авлигатай тэмцэх газрын 2013 оны үйл ажиллагааны товч тайланд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын чиглэлээр хийсэн судалгаанд дараах зүйлсийг тусгасан.

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлбэл зохих 278 төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтны мэдүүлгийг цаасан болон цахим хэлбэрээр хуулийн хугацаанд 100 хувь хүлээн авч бүртгэн, нууцлалыг ханган хадгалж байна.

Мэдүүлгийг цахим хэлбэрээр авч эхэлсэнтэй холбоотой Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өндөр түүнтэй адилтгах албан тушаалтнууд болон Авлигатай тэмцэх газрын мэдүүлэг гаргагчдын цахим шуудангийн хаягийг бүртгэн авч Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд оруулах ажлыг зохион байгуулж, мэдээлэл, сурталчилгааны ажлыг бүхий л хэлбэрээр зохион байгуулж ажилласан.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлсэн **239** албан тушаалтны 2012 оны мэдүүлгийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд болон тус газрын Олон нийтийн веб сайт /www.хасхот.iaас.mn/-д байршуулж иргэд, олон нийтэд нээлттэй болгосон.

Тайлангийн хугацаанд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 111 байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2013 оны тайлан мэдээг цаасаар болон цахим хэлбэрээр гаргуулан авч нэгтгэсэн. Улсын хэмжээнд **47142** мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс **47127** мэдүүлэг гаргагч буюу 99,97 хувь нь бүртгүүлсэн. Үүнээс 47105 мэдүүлэг гаргагч хуульд заасан хугацаандаа мэдүүлгээ бүртгүүлсэн. 22 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулж, 15 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ огт гаргаж өгөөгүй тул хуульд заасны дагуу 31 албан тушаалтанд “сануулах”, 2 ажилтанд “ажлаас халах” хариуцлага ногдуулсан байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд 2013 онд хийх мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу **2560** орчим мэдүүлэг гаргагчийг хамруулсан төрийн 7 байгууллага, түүний салбар нэгжүүдэд мэдүүлгийн бүрдүүлэлтийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Тайлангийн хугацаанд мэдүүлгийн бүрдүүлэлт, бүрдүүлэлтийг цахим хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой мэдүүлэг гаргагч олонтой байгууллагуудын 555 эрх бүхий албан тушаалтныг хамруулсан програмын дадлагын сургалтыг гүйцэтгэгч тал болох “Ай Эн Ай” ХХК-ийн мэргэжилтнүүдийн хамт зохион байгуулсан.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хугацаанд нийт 200 орчим байгууллагын **1423** эрх бүхий албан тушаалтан, **9557** мэдүүлэг гаргагч, нийт **10980** албан тушаалтныг хамруулсан сургалтыг зохион байгуулсан.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд 2013 онд нийт **557** албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгаснаас **533** албан тушаалтны мэдүүлгийг хянан шалгах ажиллагааг дуусгаж, 24 албан тушаалтны мэдүүлгийг шалгаж байна.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн болон өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар нийт **255** албан тушаалтанд хариуцлага тооцуулснаас ажлаас халсан **26**, албан тушаал бууруулсан **22**, албан тушаалын цалинг 3 хүртэл сарын хугацаанд 30 хүртэл хувиар бууруулсан **94**, сануулсан **95** тус тус байна

2013 онд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **10490** этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас **10338** этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлээд хариуг холбогдох байгууллагад хүргүүлсэн, одоо **152** урьдчилсан мэдүүлэг хянагдаж байна.

Хянаж хариу хүргүүлсэн **10338** этгээдийн урьдчилсан мэдүүлгээс Ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан нийт **2800**, хянах боломжгүй үндэслэлээр **1780** мэдүүлгийг буцаан хүргүүлсэн байна.

Мөн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **52** этгээд нь тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлснээр уг этгээдүүдийг нийтийн албанд томилоогүй болно.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр хууль зөрчин томилсон тохиолдолд хууль бус тушаал шийдвэрийг хүчингүй болгох талаар холбогдох байгууллагад анхааруулснаар **320** гаруй хууль бус тушаалыг хүчингүй болгож, урьдчилсан мэдүүлгийг дахин хянасан байна.

1996 оны Авилгалтай тэмцэх тухай хуулиар албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, олон нийтэд мэдээлэх тогтсон систем бүрдээгүй байсан. Авлигын эсрэг хууль 2006 онд шинээр батлагдан Авлигатай тэмцэх газар байгуулагдсанаар хөтөлбөрт тусгасан албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх хадгалах, хяналт тавих, олон нийтэд

мэдээлэх, зохион байгуулах арга хэлбэр тодорхой болж хөрөнгө, орлогын мэдүүлгийн тогтолцоог бий болгож, хяналт тавих механизм бүрдсэн.

Албан тушаалтнуудын оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн байдлыг 4 жилийн байдлаар харьцуулж /хүснэгт-1/ үзүүлбэл⁷⁴:

Үзүүлэлт		2009 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг	2010 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг	2011 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг	2011 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг	2012 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг
Бүртгүүлбэл зохих мэдүүлэг гаргагчийн тоо		54604	56832	58251	45858	47142
Бүртгүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн тоо		54468	56763	58187	45762	47127
Үүнээс	Хугацаандаа мэдүүлсэн	54453	56714	58162	45755	47105
	Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	15	49	25	7	22
Огт бүртгүүлээгүй мэдүүлэг гаргагчийн тоо		136	69	64	96	15
Үүнээс	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч	98	61	50	83	16
	Бүртгүүлээгүй бусад мэдүүлэг гаргагч	38	8	14	20	21
Бүрдүүлэлтийн хувь		99.75	99.87	99.89	99.79	99.97

Авлигатай тэмцэх газар судалгааны дүнг УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан тухай 2014 оны 05 сарын 08-ны өдрийн мэдээлэл дээр доорх зүйлсийг тодотгосон байна.

Судалгааг хийхдээ Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан

⁷⁴ Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайлан 2 дугаар зүйл

сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаардаг этгээдийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийн мэдээллийн санд тулгуурлан, Төрийн өмчийн хорооноос холбогдох баримт материалуудыг гаргуулан авсны үндсэн дээр хийсэн байна. Төрийн нарийн бичгийн дарга нар, захиргааны удирдах албан тушаал хашиж байгаа хүмүүс ойролцоогоор 2-3 компанид, хамгийн дээд талдаа 5 компанийн ТУЗ-д гишүүнээр ажилладаг юм байна гэдэг нь судалгаанаас харагдаж байна.

Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд, энэхүү судалгаа, мэдээллийг ирүүлэх нь АТГ-ын хүлээсэн нэг гол үүрэг. Хараат бус гэдгээр төрийн албан хаагч биш хүмүүс аваад, тэр хүмүүс нь ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс ороод ирчихсэн байна. Түүнийг нь Төрийн өмчийн хороо томилж байгаа нь буруу. Иймд нэн даруй ашиг сонирхлын хуулийг зөрчөөгүй томилгоо хийх үүргийг Засгийн газарт өгөх хэрэгтэй. Тийм сонирхолтой хүмүүсийг төрийн өмчийн зүгээс ч хувийн зүгээс ч оруулж болохгүй. ТУЗ-д төрийн төлөөлөл болж намын гишүүн байх боломжгүй. Төрийн төлөөлөлдөө тийм хориг тавьж байгаа бол хараат бусдаа мөн адилхан хоригоо тавих хэрэгтэй. Энэ асуудал дээр хууль өөрчлөх шаардлагатай бол Хууль зүйн байнгын хороо хууль санаачилъя. Хууль зөрчсөн зүйлээ нэн даруй өөрчлөх бичгийг явуулах нь зүйтэй гэсэн санал хэллээ.

Нийтийн албан тушаалтан нь чиг үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлого зэргийнхээ талаарх зохих эрх бүхий байгууллагад мэдүүлж байх Конвенцийн шаардлага, нийтийн албан тушаалтан Хөрөнгө, орлогын мэдүүлгээ Авилгалтай тэмцэх газар мэдээлж байх Авилгын эсрэг хуульд Нийтийн албан хаагчид мэдүүлгээ гаргаж хэвшиж байгааг тусгасан байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх, түүнчлэн санаатай болон болгоомжгүйгээр худал мэдээлэх үйлдлийг бууруулах чиглэлээр зөвхөн хариуцлага тооцохоос гадна нөлөөллийн тодорхой ажил зохион байгуулах.

4.6. Орлоцогч улс бүр энэ зүйлийн дагуу тогтоосон ёс зүйн дүрэм буюу стандартыг зөрчсөн нийтийн албан тушаалтанд сахилгын буюу бусад арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг авч үзнэ. /Конвенцийн 8.6./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Ёс зүйн дүрэм зөрчсөн Нийтийн албан тушаалтанд сахилгын шийтгэл болон бусад арга хэмжээ авах асуудлыг Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын

зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хуулиудад, тухайн ажил, албан тушаалд дагаж мөрдөх ёс зүйн дүрэм, сахилгын дүрмүүдэд доорх байдлаар зохицуулсан байдаг.

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг зохицуулахдаа тус хуулийн 13 дугаар зүйл болох Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг буюу “төрийн албаны болон төрийн албан хаагчийн **ёс зүйн хэм хэмжээ**, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүрэг” –ээ зөрчсөн болон албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:

- сануулах;
- албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйл болох Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий албан тушаалтан дараах сахилгын шийтгэл хүлээлгэнэ⁷⁵:

- хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуулинд заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;
- Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцсон, хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана /8.1/, Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй. /8.2/, Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно. /8.3/, Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. /9.1/, Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах

⁷⁵ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2

үүрэгтэй. /19.1/, Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно. /21.3/, Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалт зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. /21.4/-т заасан үүргээ биелүүлээгүй, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн 23.3-т заасан хугацаа буюу жил бүрийн 02 дугаар сарын 15-наас удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

- Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт, Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт, Хандив авахтай холбогдсон хязгаарлалт, Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт зөрчсөн, Албан тушаалтан албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд авах арга хэмжээг аваагүй, Албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа хязгаарлалтад хамаарах этгээдтэй гэрээ, контракт байгуулсан, зөвшөөрөл олгосон, илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах;
- Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт, Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох, Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт, Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалтад заасныг зөрчсөн, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах тухай зүйлд заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах.

Энэхүү сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргүүлэх, үүнтэй холбогдох журмыг Авлигатай тэмцэх газар батлах хуулийн зохицуулалт байна.

Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 129 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар Төрийн Захиргааны Албан Хаагчийн Ёс Зүйн Дүрмийн Хэрэгжилтийг Зохион Байгуулах, Ёс Зүйн Зөрчлийг Хянан Шийдвэрлэх Журам батлагдсан. Энэхүү журмаар төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагч /цаашид “Гомдол, мэдээлэл гаргагч” гэх/-ийн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Төрийн захиргааны албан хаагч бүхий төрийн байгууллага бүрт төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын, орон тооны бус Ёс зүйн хороо ажиллах бөгөөд Ёс зүйн хороо нь 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж, Ёс зүйн хорооны даргыг дотороосоо томилно. Ёс зүйн хороо нь дараахь эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

- төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;
- гомдол, мэдээлэлд холбогдох төрийн захиргааны албан хаагч болон түүний харьяалах төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг шаардан авах;
- гомдол, мэдээллийн нууцлалыг хадгалах, шаардлагатай гэж үзвэл, гомдол, мэдээлэл гаргагчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахуулахаар холбогдох байгууллагад хандах;
- гомдол, мэдээллийг шалгасан тухай дүнг хуралдаанаараа хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт гаргах бөгөөд энэхүү дүгнэлт нь аливаа албан тушаалтан, улс төрийн хүчний нөлөөлөлд автаагүй, нотлох баримтад үндэслэгдсэн байх;
- гомдол, мэдээллээс гадна хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр, түүнчлэн өөрийн санаачлагаар болон байгууллагын удирдлагын шийдвэрээр ёс зүйн зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах.
- Ёс зүйн хороо нь төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан хүснэгтийн дагуу хагас болон бүтэн жилээр гаргаж, мөн оны 7 дугаар сар болон дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяалах аймаг, нийслэл, яам, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд, тухайн салбар зөвлөл нь нэгдсэн дүнг мөн сарын 20-ны дотор Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороонд yoszui@csc.gov.mn хаягаар тус тус ирүүлнэ.
- Төрийн байгууллагууд төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг 2.6-д заасан хүснэгтийн дагуу хагас болон бүтэн жилээр гаргаж, мөн оны 7 дугаар сар болон дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор yoszui@csc.gov.mn хаягаар Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороонд ирүүлнэ.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.6, 2.7-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо нь төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг жил гаргах чиг үүрэгтэй бөгөөд 2012 оны судалгааны ажлын тайланг авч үзвэл:

Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг бүртгэн нэгтгэх, шинжилгээ, дүгнэлт хийх замаар төрийн албан хаагчдын ёс зүйн боловсрол, соёлыг дээшлүүлэх чиглэлээр анхааран ажиллаж ирлээ.


Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан

шийдвэрлэх журам”-ын 2.6, 2.7-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо нь төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг 2013 оны бүтэн жилийн байдлаар авч нэгтгэн ажиллаа.

Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороод 2013 онд нийт 118 ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэсэнийг дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:
Хүснэгт №1

2013 он	Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэл					Ёс зүйн зөрчлийг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр				Ёс зүйн зөрчлийг анх буюу давтан үйлдсэн	
	Журмын 1.2		Журмын 2.2.5			Сахилгын шийтгэлийн төрөл				Анх	Давтан
	Гомдлоор	Мэдээллээр	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн	Ёзүйн хорооны санаачилгаар	Байгууллагын удирдлагын шийдвэрээр	ТАТХ-ийн 26.1.1	ТАТХ-ийн 26.1.2	ТАТХ-ийн 26.1.3	Ёс зүйн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах шаардлагатай		
Удирдах ажилтан	5	1	-	2	4	2	5	2	3	10	2
Гүйцэтгэх ажилтан	18	10	5	14	59	55	33	11	7	79	27
НИЙТ	23	11	5	16	63	57	38	13	10	89	27
	118					118				118	

Ёс зүйн зөрчлийг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулан үзвэл:



Дээрх зургаас харахад ёс зүйн зөвчлийн хэмжээ буурсан байгаа харагдаж байгаа хэдий ч “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам” дагаж мөрдөгдсөнөөс хойш 2011 болон 2012 онд төрийн захирааны байгууллагуудад 618 ёс зүйн хороод байгуулагдан эдгээр ёс зүйн хороодод **2498** төрийн албан хаагч орж ажиллаж байсан бол 2013 онд эдгээр ёс зүйн хороодын тоо буурсан. 2013 оны ёс зүйн болон Салбар зөвлөлүүдээс мэдээнээс үзэхэд ёс зүйн хороодын үйл ажиллагаа болон ёс мэдээ өмнөх хоёр жилийнхтэй харьцуулан үзэхэд 15-20 хувиар буусан үзүүлэлтэй харагдаж байна.

Энэ нь Төрийн байгууллагын бүтэц орон тоо өөрчлөгдөх, шинээр ажлын байр бий болох нөхцөлд тухайн байгууллагын дэргэдэх Ёс зүйн хорооны үйл ажиллагаа доголдох, тогтвортой ажиллахгүй байх, бүрэлдэхүүнгүй болсон тул үйл ажиллагаа явуулахгүй байх зэрэг нөхцөл байдал бий болсон нь ажил хэрэгт сөргөөр нөлөөлөхөд хүргэж байна.⁷⁶ гэжээ.

Дээрх хүснэгт бүхий судалгаанаас үзэхэд 2013 онд Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос нийт 118 албан тушаалтны ёс зүйн зөрчилд хариуцлага ногдуулсан байх бөгөөд үүнээс 89 нь анх удаа, 29 давтан ёс зүйн зөрчил гаргасан байна. Энэ нь албан тушаалтанаас ёс зүйн зөрчлийг давтан үйлдсэн хувь маш өндөр гэж үзэхээр байна.

⁷⁶ Авлигатай тэмцэх газраас 2014 оны 06 сарын 06-ны өдөр цахим шуудангаар бидэнд ирүүлсэн мэдээлэл.

ЗӨВЛӨМЖ:

- Нийтийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагын үр нөлөөтэй хэлбэрийг сонгоход ач холбогдол бүхий нарийвчилсаг судалгаа хийх, зөрчил нь ёс зүйн зөрчил гэдэг утгаар ёс зүйн зөрчил гаргасан нийтийн албан хаагчийг хамт олны өмнө буруу шаах, олон нийтэд мэдээлэх зэрэг тухайн хүний нэр хүндэд халдсан арга төрөл бүрийн арга хэмжээг түлхүү хэрэглэх нь зүйтэй байна.
- Ёс зүйн хороодын үйл ажиллагааг идэвхижүүлэх, сургалт зөвлөгөөг сайтар өгөхөд анхаарч ёс зүйн хэсэгчилсэн сургалтуудыг Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институтээрээ дамжуулан зохион байгуулах талаар энэ онд онцгойлон анхаарах

ТАВДУГААР БҮЛЭГ

НИЙТИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ, НИЙТИЙН САНХҮҮГ УДИРДАХ

/9 дүгээр зүйл/

5.1. Оролцогч улс бүр ил тод байх, өрсөлдөөний зарчим, шийдвэр гаргах бодит шалгуурт үндэслэсэн бөгөөд авлигаас урьдчилан сэргийлэх зэрэгт үр дүнтэй үйлчлэхүйц нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зохих тогтолцоог тогтоох талаар шаардлагатай арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна. Ийм тогтолцоог хэрэглэхэд босго үзүүлэлтийг харгалзаж болох бөгөөд уг тогтолцоонд тухайлбал дараах зүйл хамаарна:

(а) тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж, ирүүлэхэд хангалттай хугацаа олгох зорилгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам болон гэрээнд хамаарах мэдээллийг, түүний дотор тендерийн урилга болон гэрээ байгуулах эрх олгох талаарх холбогдох буюу тохирох мэдээллийг олон нийтэд тараах; /Конвенцийн 9.1.a/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцийн Ил тод байх, өрсөлдөөний зарчим, шийдвэр гаргах бодит шалгуурт үндэслэх чиглэлээр **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд** ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг /6.1./ баримталахаар заасан бөгөөд Тендерт оролцогчдын хүрээг өргөжүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, захиалагчийг мэдээллээр хангах зорилгоор тус хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагаанд оролцохыг сонирхогч хуулийн этгээд, иргэний бүртгэлийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага тухайн Засгийн газрын гишүүний эрхлэх хүрээний асуудлаар хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэхээр /51.1./ заасан байна. Харин **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг мэдээллийн ил тод

байдлын нэг төрөл болгон хуульчилсан /6.1./ бөгөөд Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага, бүх шатны шүүх, прокурорын байгууллага, Улсын Их Хурлаас байгуулдаг /Засгийн газраас бусад/ байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажлын алба, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд /3.1./, **Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн** 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага, олон нийтийн радио, телевизийн байгууллага зэрэг байгууллагууд нь энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээд байхаар хуульчилсан. Эдгээр байгууллагууд нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан байна:

- Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, энэ тухай цахим хуудсандаа байрлуулах болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх;
- Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;
- Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулах;
- Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулан тухай бүр шинэчлэх;
- Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх;
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх.

Харин тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж ирүүлэхэд хангалттай хугацаа олгох чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг Захиалагч үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр, 10,000,000.001 төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, 100,000.001 төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээний тендерийн урилгыг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэлхээс гадна тендер дүнг тухай бүр мэдэх боломжоор хангаж тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил

тод, нээлттэй зарлаж, сонирхсон шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготойгоор өөрийн веб хуудсанд тендер шалгаруулалтын этгээдэд саадгүй олгох боломжийг хуульчилж өгсөн байна. /17, 21 дүгээр зүйл/ Үүнээс гадна Захиалагч тендерт оролцогчдод тендер бэлтгэж ирүүлэх хангалттай, ижил хугацаа олгож тендер хүлээн авах эцсийн хугацааг тендер шалгаруулалтыг анх зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн тооцох хугацаа, Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулах /24.5/, гэрээ байгуулах эрх олгох /29 дүгээр зүйл/, эрх олгосноос хойш 5 хоногийн дотор гэрээ байгуулна зэргийг нарийн хуульчилж өгсөн байна. харин **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд** тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулах, тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэж байхыг хуульчилж өгсөн байна. /10-р зүйл/ **Эдгээрээс үзэхэд Конвенцийн тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж, ирүүлэхэд хангалттай хугацаа олгох зорилгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам болон гэрээнд хамаарах мэдээллийг, түүний дотор тендерийн урилга болон гэрээ байгуулах эрх олгох талаарх холбогдох буюу тохирох мэдээллийг олон нийтэд тараах чиглэлээр Монгол Улсад эрх зүйн орчин бүрдсэн байна гэж үзэж байна.**

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ


Улсын Их Хурал худалдан авах ажиллагааг зохицуулахад чиглэсэн анхны бие даасан хуулийг 2000 онд батлаж улмаар 2005 онд шинэчлэн найруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг баталсан юм. Түүнчлэн 2005 онд батлагдсан дээрх хуульд 2007 оны 2 сар, 2009 оны 7 сар, 2010 оны 6, 2011 оны 02, 06 сард 2, 2011 оын 12 сар, 2012 оны 05 сард тус тус нэмэлт өөрчлөлт оржээ. Эдгээр хуулиуд нь Монгол Улсад худалдан авах ажиллагааны шинэ тогтолцоог үүсгэн бэхжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд эл ажиллагааны ил тод байдлыг хангахад ч мөн хувь нэмэр оруулсан юм.

- **e-procurement.mn сайт:** Шинэчлэлийн Засгийн газраас төрийн худалдан авах ажиллагааны талаар авч хэрэгжүүлсэн шинэлэг бодлогын үр дүнд Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 6 дугаар тогтоолоор Монгол улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах Мэргэжлийн байгууллага болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Худалдан авах ажиллагааны газар” байгуулагдаж, 2013 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс нийт 65 хүний бүрэлдэхүүнтэйгээр төрийн худалдан авах ажиллагааны үйл явцыг шуурхай, нийтэд хүртээлтэй, ил тод зохион байгуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах үүднээс худалдан авах ажиллагааны цахим

тогтолцоог бий болгох зорилтыг Сангийн яамнаас тавиад ажиллаж байна. Энэхүү ажлын эхлэл болгож юуны өмнө томоохон хэмжээний тендерийн зар, үр дүнг мэдээлж байх, энэ чиглэлийн мэдээллийн бааз бий болгох, мөн худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журам, заавар, жишиг бичиг баримтаар олон нийтийг хангах, тендер шалгаруулалттай холбоотой асуудлаар онлайн хэлэлцүүлэг зохион байгуулах, сонирхсон этгээдүүдэд мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх зорилго бүхий энэхүү вэб хуудсыг ажиллуулж байна. Тус веб сайт нь оноос эхлэн ажиллаж эхлэсэн бөгөөд Монголын Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцооны талаарх мэдээллийг буюу яам, агентлаг, төрийн өмчит хувьцаат компани, төслийн нэгжүүдээс зарласан Бараа, ажил, зөвлөх үйлчилгээ, зөвлөхөөс бусад үйлчилгээ гэсэн тендерүүдийг зарлагч байгууллагууд өөрсдийн зарлах тендер шалгаруулалтын зар, үр дүнтэй холбоотой өгөгдлийг оруулж, мэргэжлийн эрх бүхий байгууллагаас уг өгөгдөл зохих хууль, журмын дагуу алдаагүй зөв оруулсан эсэхэд хяналт тавьж, зарлах зөвшөөрөл олгох зарчмаар ажилладаг байна. Мөн тус сайтад тавигддаг зар нь сайтын мэдээллийн сангийн архивт хадгалагдан үлддэг учир он сараар нь түүн харах боломжтой байна.

- **Сангийн сайдын 2012 оны 301 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам” байна.**
- **Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны эхний хагас жилийн зорилт, биелэлт, үр дүнгээс:**
Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд 247 ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төсөл, арга хэмжээг зохион байгуулахаас гэрээ байгуулсан 53, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн 39, үнэлгээ хийгдэж буй 13, тендер зарласан 28, тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 15, нийт 148 арга хэмжээ буюу 60 хувийг зохион байгуулаад байна. Холбогдох яам, агентлагаас техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл ирүүлээгүй 59, нууцын зэрэглэлд хамаарах 9, 2013 оны төсвийн хуулиар батлагдсан төсвөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн 28, тендер зарлагдахгүй 3, нийт 99 төсөл арга хэмжээ буюу 40 хувийг хэрэгжүүлээгүй байна.
- **Сургалтын хувьд e-procurement.mn:** Сайтад сургалт семинар гэсэн цонхтой бөгөөд тус цонхонд
 - Сургалтын байгууллага
 - Сургалтын хуваарь
 - Сургалтын бүртгэл
 - Салбараар мэргэшсэн гэрчилгээ эзэмшигчийн бүртгэл
 - Сургалтын материал
 - Онлайн шалгалт зэрэг цэсүүд байна.
- Конвенцийн Худалдан авах ажиллагааны тендерт оролцох этгээдэд тендерээ бэлдэж ирүүлэхэд хангалттай хугацаа олгох зорилгоор тендерийн урилга болон гэрээ байгуулах эрх олгох талаар холбогдох

мэдээллийг худалдан авах ажиллагааны нэгдсэн сайдаас судлах зорилгоор e-procurement.mn сайтруу орж худалдан авах ажиллагааны урилгаас нэгийг нь нээж үзэхэд тендерт оролцогчид хангалттай хугацаа буюу 30 хоногийн хугацаа, тендерийн төрөл, санхүүжилтийн эх үүсвэр тендерийн бичиг баримт бусад мэдээлэл авах хаяг зэргийг оруулсан байна.



The screenshot shows the website interface for e-procurement.mn. The main content area displays the following information:

- Тендерийн нэвтрэл** (Tender Access)
- Тендерийн төрөл** (Tender Type): Бараа (Goods)
- Тендерийн үйлчилгээ** (Tender Service): Зөвлөхөөс бусад үйлчилгээ (Other than consulting)
- Тендерийн үйлгын статус** (Tender Status): Хүлээж авах хугацаа дуусаагүй (Waiting period not over)
- Хүлээж авах хугацаа дууссан** (Waiting period over)
- Захиалагч** (Contractor): Яандууд (Individuals)
- Агентлагууд** (Agents): Төрийн өмчийн ХК (State-owned LLC)
- Төсөл** (Project): Архив (Archive)
- Тендер** (Tender)

The main content area also displays the following information:

- Захиалагч:** ТӨХ-Дулааны III шалгиган станц
- Тендерийн төрөл:** Бараа
- Тендер шалгаруулалтын дугаар:** М-18-2014
- Санхүүжилтийн эх үүсвэр:** Өөрийн хөрөнгөөр
- Тендер зарласан огноо:** 2014-06-13
- Тендер хүлээж авах эцсийн хугацаа:** 2014-07-14 10 0
- Тендерийн бичиг баримт бусад мэдээлэл авах хаяг:** Хануул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 3-р хороо, ДЦС-ЗТӨХК-ний өрөөл №3, Хангажийн хөлтэс, утас: 341990, 70111304, факс: 976-11-341990, 344111

Эдгээр тайлан мэдээллүүдээс хархад Монгол Улс нь худалдан авах ажиллагааны ил тод байдал ба өрсөлдөөний зарчим, бодит шалгуурыг үндэслэдэг болох нь харагдаж байна.

- **E-procurement.mn** сайтад тавигдсан худалдан авах ажиллагааны зарыг он оноор нь судлаж үзэхэд 2011 онд 36, 2012 онд 28, 2013 онд 198, 2014 оны 06 сарын байдлаар нийт 152 зар тавигдсан байна.
- **Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаанаас⁷⁷:**

Авлигад өртсөн салбарууд /Агентлагууд/

Авлигад хамгийн их өртсөн таван агентлаг /буюу салбар/-ын жагсаалтад өнгөрсөн онтой харьцуулахад өөрчлөлт орсон байна. Цааш нь нарийвчлан авч үзэх үүднээс уул уурхайн салбарыг хоёр хэсэгт хуваасан болно: төрийн өмчийн болон хувийн компаниуд. Үүний үр дүнд төрийн өмчийн уул

⁷⁷ Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа, 17-р хуудаас

уурхайн компаниуд “уул уурхайн салбар” гэсэн ерөнхий нэрээр 2007 оноос хойш эрэмблэгдэж ирсэн хоёрдугаарт байранлаа үлдсэн бол хувийн уул уурхайн компаниуд ёсдүгээр байранд оржээ. Үүнээс хархад өнгөрсөн судалгаануудын турш төрийн өмчийн уул уурхайн компаниуд олны анхааралд байсаар байна.

Мэргэжлийн хяналтын газар эхний тавд багтаж байснаа хойшилж наймдугаар байранд жагссан бол Гааль эргээд эхний тавд жагссан байна. 2006 оны 03-р сараас 2013 оны 11-р сарын хооронд хамгийн их авлигад өртсөн салбаруудыг хүснэгтээр харуулав.

	Нэгдүгээрт	Хоёрдугаарт	Гуравдугаарт	Дөрөвдүгээрт	Тавдугаарт
2006/03	Газрын алба	Гааль	Уул уурхай	Шүүх	Цагдаа
2006/09	Газрын алба	Гааль	Уул уурхай	Шүүх	Цагдаа
2007/03	Газрын алба	Гааль	Уул уурхай	Шүүх	Бүртгэл, лиценз
2007/09	Газрын алба	Уул уурхай	Гааль	Бүртгэл, лиценз	Шүүх
2008/03	Газрын алба	Уул уурхай	Гааль	Бүртгэл, лиценз	Шүүх
2008/09	Газрын алба	Уул уурхай	Гааль	Шүүх	Прокурор
2009/03	Газрын алба	Уул уурхай	Шүүх	Гааль	Прокурор
2009/09	Газрын алба	Шүүх	Цагдаа	Прокурор	Уул уурхай
2010/03	Газрын алба	Уул уурхай	Улс төрийн нам	Гааль	Парламент
2010/09	Газрын алба	Уул уурхай	Шүүх	Гааль	Улс төрийн нам
2011/04	Газрын алба	Уул уурхай	Шүүх	Гааль	Улс төрийн нам
2012/11	Газрын алба	Уул уурхай	Орон нутгийн худалдан авалт, тендер	Мэргэжлийн хяналтын газар	Улс төрийн нам
2013/03	Газрын алба	Төрийн өмчийн уул уурхайн компани	Орон нутгийн худалдан авалт, тендер	Улс төрийн нам	Гааль

- **Төрийн байгууллагуудын цахим хуудсанд суурилсан мэдээллийн ил тод байдлын судалгаанаас: /Хэсэгчлэн авав/**

	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зүйл заалт	Мэдээлэл байршуулсан	Мэдээлэл байршуулаагүй	Булантай ч мэдээлэл байршуулаагүй	Хамаар ахгүй
Худалдах авах ажиллагааны ил тод байдал	Худалдан авах ажиллагааны бодлого /10.1.1/	11	35	2	-
	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах	28	19	1	-

	журам, тендерийг урилга /10.1.2/				
	Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл /10.1.3/	6	42	-	-
	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /10.1.4/	10	38	-	-
	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан /10.1.5/	21	26	1	-
	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн /10.1.7/	2	43	3	-

Дээрх хүснэгт нь яам агентлаг, Улсын Их хурлаас байгуулагддаг байгууллагууд буюу нийт 48 байгууллыг хамарсан бөгөөд эдгээрээс Конвенцийн тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж, ирүүлэхэд хангалттай хугацаа олгох зорилгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам болон мэдээллийг олон нийтэд тараах чиглэлээр “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийг урилга”-ыг цахим хуудсандаа байршуулсан эсэх талаар судлахад 28 байгууллага байршуулсан байсан бол 19 байгууллага энэ талаар мэдээлэл байршуулаагүй байсан байна. Харин Конвенцийн болон гэрээ байгуулах эрх олгох талаарх холбогдох буюу тохирох мэдээллийг олон нийтэд тараах чиглэлээр Тендерт оролцогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үндэслэл”-ийн талаар цахим хуудсандаа мэдээлэл байршуулсан эсэх талаар судлахад 6 байгууллага /Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Гаалийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий

газар, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо/ мэдээлэл байршуулсан бусад нь буюу 42 байгууллага цахим хуудсандаа энэ талаар мэдээлэл оруулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигатай тэмцэх газрын зүгээс Худалдан авах ажиллагаа түүний дотор орон нутгийн худалдан авах ажиллагаа буюу тендерийн талаар зохих арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Учир нь дээрх судалгаанаас үзвэл орон нутгийн худалдан авалт, тендер нь Авлигад хамгийн их өртсөн салбарын жагсаалтын гуравдугаарт 2012, 2013 онд тогтвортой нэрлэгдсэн байна.

5.1. (b) тендерт оролцох нөхцөл, түүний дотор сонгон шалгаруулах ба эрх олгох шалгуур, тендер шалгаруулалтын дүрмийг урьдчилан тогтоож, тэдгээрийг нийтлэх; /Конвенцийн 9.1.b/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг зүйлд заасан үзүүлэлтээр үнэлэхээр хуульчилсан байдаг бөгөөд Захиалагч тухайн тендер шалгаруулалтад тавигдах чадавхийн шалгуур үзүүлэлт, шаардлагыг тус хуульд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана. Захиалагч дээр шаардлагыг хангаагүй тендерийн материалаас татгалзах эрхтэй бөгөөд “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгодог. Дээрх дурьдсан шалгуур үзүүлэлтүүдээс дурьдвал:

- Ерөнхий нөхцлийг магадлах /14-р зүйл/

Дараахь нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ:

- төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;
- Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;
- төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;
- сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52^{1.1}-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон;
- тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн,

- эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
- илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг энэ хуулийн 52¹.1-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон;
- сүүлийн 3 жилийн хугацаанд авилгалын гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон.
- Санхүүгийн чадавхийг үнэлэх /15-р зүйл/
 - Захиалагч тендерт оролцогчоос гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхитайгаа баталсан нотолгоо ирүүлэхийг шаардаж болно.
 - Захиалагч санхүүгийн чадавхийн шаардлагыг тендерийн, эсхүл урьдчилсан сонголтын баримт бичигт тусгана.
 - Санхүүгийн чадавхийг дараахь баримт бичгээр нотолж болно:
 - ✓ харилцагч банкны мэдэгдэл;
 - ✓ тендерт оролцогчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт;
 - ✓ зөвлөхийн орон тоо, цалин, бусад зардлын тооцооны хүснэгт;
 - ✓ тендерт оролцогчийн сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний жилийн борлуулалтын талаархи мэдээлэл.
 - Энэ хуулийн 15.3-т заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх баримт бичгийг тендерийн баримт бичигт заана.
- Техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх /16-р зүйл/

Тендерт оролцогчийн техникийн чадавхи, туршлагыг ажил, бараа, үйлчилгээний агуулга, онцлог, тоо хэмжээг харгалзан дараахь үзүүлэлтийн аль нэгийг үндэслэн тогтооно:

- тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар;
- сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт;
- сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үйлчилгээ, тэдгээрийн үнийн дүн, хугацаа болон худалдан авагчдын жагсаалт, шаардлагатай бол бараа, үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи өмнөх худалдан авагчдын тодорхойлолт;
- тендерт оролцогчийн багаж, техник хэрэгслийн тодорхойлолт, үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмжийн жагсаалт;
- чанарын хяналтыг шууд, эсхүл туслан гүйцэтгэх гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх чанарын хяналтын арга хэмжээ;
- нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт, эсхүл гэрэл зураг, тэдгээрийн үнэн болохыг гэрчилсэн баримт бичиг;
- барааны хувьд эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ, үйлдвэрлэгчийн итгэмжлэл.

- Энэ хуулийн 16.1-д заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичиг, тэдгээрт тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт заана.

Мөн сонгон шалгаруулах ба эрх олгох шалгуур тендер шалгаруулалтын дүрмийг нийтлэх чиглэлээр тус хуульд хангалттай тусгаж Конвенцийн тус заалтыг биелэлтийг хангасан байна гэж үзэж байна. Тухайлбал:

Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх чиглэлээр

Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэх бөгөөд тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлаж сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

- Тендерийн урилгад дараахь мэдээллийг тусгана: /21.5/
 - захиалагч байгууллагын тодорхойлолт;
 - худалдаж авах бараа, ажил, үйлчилгээний товч агуулга;
 - тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл авах, тендер ирүүлэх хаяг;
 - тендерийн баримт бичгийн үнэ;
 - тендер шалгаруулалтад тавих тусгай шаардлага;
 - тендер хүлээн авах эцсийн хугацаа;
 - тендер нээх хугацаа;
 - гадаадын этгээдийг оролцуулах эсэх;
 - давуу эрх олгох эсэх.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд 3.1-д заасан байгууллага худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчилэх зэрэг арга хэмжээг авч байхаар тусгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль: 21.4-т Захиалагч тендерийн урилгыг худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготой вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох зэргийг вэб хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ. /52.1.12/

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль: Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх /10.1.2./

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулах болон эрх олгох шалгуур, тендер шалгаруулалтын дүрэм зэрэг шалгаруулалтын нөхцлийг урьдчилан тогтоох чиглэлээр Сангийн яамнаас дараах журмуудыг батлан гаргасан бөгөөд эдгээрээс конвенцийн заалтын хэрэгжилтийг хангаж байна гэж үзэж байна.

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам /ЗГ-ын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны 115 дугаар тогтоол/
- Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд санал авах жишиг баримт бичиг /Сангийн сайдын 2013 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 39 дугаар тушаал/
- Тендерийн үнэлгээний заавар /Сангийн сайдын 2012 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаал/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам /Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 264 дугаар тушаал/
- Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар /Сангийн сайдын 2008 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 249 дугаар тушаал/
- Тендер шалгаруулалтын явц, үр дүнг хянаж зөвшөөрөл олгох журам /Сангийн сайдын 2007 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 145 дугаар тушаал/
- Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал /Сангийн сайдын 2007 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн 81 дугаар тушаал/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг тайлагнах журам /Сангийн сайдын 2007 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 04 дугаар тушаалын хавсралт/
- **Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны үйл ажиллагааны тайлангаас⁷⁸:** Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд 247 ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төсөл, арга хэмжээг зохион байгуулахаас гэрээ байгуулсан 53, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн 39, үнэлгээ хийгдэж буй 13, тендер зарласан 28, тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 15, нийт 148 арга хэмжээ буюу 60 хувийг зохион байгуулаад байна. Холбогдох яам, агентлагаас техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл ирүүлээгүй 59, нууцын зэрэглэлд хамаарах 9, 2013 оны төсвийн хуулиар батлагдсан төсвөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн 28, тендер зарлагдахгүй 3, нийт 99 төсөл арга хэмжээ буюу 40 хувийг хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Олон нийтийн зүгээс тендер хэлбэрийн төдий ил тод явагддаг. Цаагуураа тендерийн ялагч урьдаас тодорхой байдаг гэсэн шүүмжлэл байсаар байна.
- Хуулийн хэрэгжилтийг хангах төрийн бусад худалдан авах ажиллагааны талаар үйл ажиллагааны тайландаа тодорхой тусгаж, цахим хуудсандаа хуулийн хугацаанд тавьж хэвшүүлэх

⁷⁸ Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан, <http://www.e-tender.mn/uploads/files/download140703150539.pdf>

5.1. (с) дүрэм буюу журмыг зөв хэрэглэсэн эсэхийг дараа нь нягтлан шалгахыг хөнгөвчлөн дэмжих зорилгоор, нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэрийг гаргахад бодит бөгөөд урьдчилан тогтоосон шалгуурыг хэрэглэх; /Конвенцийн 9.1.с/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэрийг гаргахад бодит шалгуурыг болгож захиалагч бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг ашиглан гүйцэтгэгчийг сонгон гэрээ байгуулахаар заасан байна. /7.1./

- нээлттэй тендер шалгаруулалтын журам;
- тендер шалгаруулалтын онцгой журам;
- зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам.
- олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам.

Мөн тус хуульд Худалдан авах ажиллагааны журмыг сонгох /8.1./ тендер шалгаруулалтыг багцад хувааж явуулахад тавигдах шаардлага /8.7./, ерөнхий нөхцлийг магадлах /14-р зүйл/, санхүүгийн чадвахийг үнэлэх /15-р зүйл/, Санхүүгийн чадвахийг үнэлэх /16-р зүйл/, тендерийн хянан үзэх /27-р зүйл/, тендерийг үнэлэх /28-р зүйл/ арга зэргийг хуульчилсан байна. Мөн тус хууль нь 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон өргөн баригдсан бөгөөд тус төслөөр Үнийн өрсөлдөөнийг чанарын өрсөлдөөнд шилжүүлж, тендерийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн чанар, гүйцэтгэгчийн чадавхи байх бөгөөд хамгийн өндөр үнэлгээ авсан оролцогчдыг шалгаруулах, тендер зарлах, материал хүлээн авах, шалгаруулах болон тендертэй холбоотой маргаан, гомдлыг шийдвэрлэх хугацааг богиносгох, тухайн тендерийн процессыг хурдасгах мөн түүнчлэн тендерийг чанартай гүйцэтгэсэн, хугацаанд нь хүлээлгэн өгсөн эсэхээс хамааран компаниудыг эрэмбэлж нийтэд мэдээлэх, асуудлыг хуульд шинээр тусгасанаас гадна тендерт оролцогч болон оролцохыг сонирхогч компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан худалдан авалтын мэдээллийн нэгдсэн санг бий болгох зэрэг шинэлэг зохицуулалтуудыг тусгасан байна.

Энэ нь конвенцийн нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэрийг гаргахад бодит бөгөөд урьдчилан тогтоосон шалгуурыг хэрэглэх гэсэн заалтийн шаардлагыг хууль тогтоомжоороо хангаж байна гэж үзэж байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- ***Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайлангаас:*** ⁷⁹Иргэд байгууллагуудаас 2013 онд ирүүлсэн

⁷⁹ Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайлан

гомдол мэдээллийн 48,5 хувь нь орон нутагтай холбоотой гомдол мэдээлэл байсан бөгөөд тэр дундаа Орон нутагт сонирхлын зөрчлийн хуулийн хэрэгжилт бүрэн дүүрэн хэрэгжихгүй байгаа ялангуяа хамаарал бүхий этгээдүүд буюу төрсөн ах, дүү, гэр бүлийн гишүүд нэг дор ажиллаж байгаа, хамаарал бүхий этгээд нь тендерт оролцож төсвийн хөрөнгийг хууль бусаар зарцуулсан, өөртөө болон бусдад давуу байдал олгосон, сонирхлын зөрчилтэй томилгоо хийсэн байна.

- **Захиргааны хэргийн шүүхийн цахим хуудаснаас** ⁸⁰ : Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн хэргүүдийн мэдээллээс хархад 2004 оны 08 дугаар сарын 20-ноос 2011 оны 04 дүгээр сарын 06-ны хооронд 2264 хэргийн шийдвэр тавигдсанаас 84 хэрэг нь худалдан авах ажиллагаатай холбоотой хэрэг байна.

Нийтлэлүүд:

Худалдан авах ажиллагааны газрыг татан буулгавал таарна

- Олонхи гишүүн тендерийн будлианыг зохицуулах цаг болсон учраас 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдөр өргөн баригдсан Бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дэмжих нь зүйтэй гэж үзсэн. Гэхдээ төслийн зарим заалтыг өөрчлөх саналтай гишүүд ч байв.

Я.Санжмятав сайдын компани тендер будлиантуулсан уу

- Худалдан авах ажиллагааны газраас өнгөрсөн дөрөвдүгээр сарын 1-нд Дорноговь аймгийн МСҮТ-ийн дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендер зарлажээ. Уг тендерт найман компани материалаа явуулснаас “Тобэм” ХХК, БЦХ ХХК тус тус шаардлага хангаж, шалгаруулалтад тэнцсэн байна. Ингээд шалгарсан хоёр компанийн нэг буюу “Тобэм” ХХК нь үнийн дүнгээр тендерт ялсан аж. Гэвч Худалдан авах ажиллагааны газраас “БХЦ” ХХК-ийг ялуулахаар улайрч, тендер зарлахаас тав хоногийн өмнө зөвхөн “Тобэм” ХХК-д Худалдан авах ажиллагааны газраас танай компани тендерийн баримт бичгийн шаардлагуудыг хангаагүй тул тендерт шалгараагүй гэх албан бичгийг ирүүлжээ. Гэтэл эх сурвалжийн мэдээлж байгаагаар тендер шалгаруулалтад Хөдөлмөрийн сайд Я.Санжмятавын компани орсон гэх мэдээлэл байгаа юм. Үүнийг судлаж үзвэл ХААГ-ын дэд дарга Н.Булгантамир гэх залуу Я.Санжмятав сайдтай хамаатан бол ХААГ-ын дарга Д.Энхжаргал Д.Тэрбишдагва гишүүний хүн, ТБД Андууд ХХК-д олон жил ажилласан нэгэн гэх. Энэ мэтчилэн Худалдан авах ажиллагааны газрын цус ойртсон байдал нь тендерийг зориуд будлиантуулж, өөрийн компаниа зүтгүүлэх гэсэн оролдлого хэмээн хардах хүн цөөнгүй байгаа юм. 2013 онд Сангийн яаманд Худалдан авах ажиллагааны газрын тендер шалгаруулалттай холбоотой 40 гаруй гомдол санал иржээ.
Эх сурвалж: <http://www.eagle.mn/content/read/3335.htm>

⁸⁰ Захиргааны хэргийн шүүхийн цахим хуудас, <http://www.admincourt.gov.mn>

Эдгээр баримтуудаас үзэхэд худалдан авах ажиллагааг хангалттай хуульчилж өгсөн ч худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, эрх олгох процесс зарим тохиолдолд шударга бус болдог байна.

ЗӨВЛӨМЖ:

- Тендер шалгаруулалтын үр дүн үйл явцыг хуулиар хатуу зааж хариуцлагыг чангаруулах;
- Тендерт оролцогчдод сургалт зохион байгуулах;
- Үнэлгээний хорооны гишүүдэд тавигдах шаарлага хариуцлагыг чангатгах;
- Тендер шалгаруулалттай холбоотой гарч байгаа маргаан, зөрчилтэй холбоотойгоор хуулийн холбогдох заалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал асуулга явуулах.

5.1. (d) энэ хэсэгт заасны дагуу тогтоосон дүрэм буюу журмыг мөрдөөгүй тохиолдолд хуулиар хамгаалуулах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх дотоодын хяналтын үр дүнтэй тогтолцоо, түүний дотор давж заалдах үр дүнтэй тогтолцоо; /Конвенцийн 9.1.d/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар Тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ захиалагч зөрчсөн гэж үзвэл тендерт оролцогч энэ тухай мэдсэнээс хойш гомдол гаргах, тус гомдолыг захиалагч хүлээн авч шийдвэрлэх /54-р зүйл/, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд ямар байгууллага, албан тушаалтанд ямар хугацаанд гомдол гаргах, тус гомдлыг хүлээн авсан байгууллага хэдий хугацаанд багтаан хянан шийдвэрлэх зэргийг нарийн хуульчилж өгсөн байна. / 55-р зүйл/ Ийнхүү тендерт оролцогч нь дээр дурдсан байгууллагуудын шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхэд гомдол гаргаж /56-р зүйл/ болохоор заасан нь тус Конвенцийн тогтоосон дүрэм буюу журмыг мөрдөөгүй тохиолдолд хуулиар хамгаалуулах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх нөхцлийг тендерт оролцогчид хуулиараа олгосон байна. Гэсэн хэдий ч тендерийн маргаан нь олон шат дамжлагаар явж хамгийн багадаа 1 жил үргэлжилэхээр байгаа нь тухайн төсөл, ажил, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Тендерийн талаарх маргааныг богино хугацаанд шийдвэрлэх чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны эхний хагас жилийн зорилт, биелэлт, үр дүн тайлангаас⁸¹:
 - Албан хэрэг хөтлөлт, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт: Худалдан авах ажиллагааны газарт 2013 ирсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан, холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, шийдвэрлэлтэнд нь хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд газрын даргын нийт 277 тушаал гарснаас хүний нөөцийн холбогдолтой 87, удирдлага зохион байгуулалттай холбоотой тушаал 190, Төсвийн ерөнхийлөн захирагч нартай хамтарсан тушаал одоогоор гараагүй байна. Мөн харилцагч байгууллагуудаас нийт 1517 албан бичиг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба хариутай 137 албан бичигт тухай бүр зохих журмын дагуу хариу өгч, 85 албан бичгийг холбогдох байгууллагад уламжилж, 2760 албан бичиг төлөвлөн бусад байгууллагуудад хүргүүлсэн. Иргэд, хуулийн этгээдийн санал гомдлыг авах зорилгоор санал хүсэлтийн хайрцгийг ажиллуулан, ирсэн 5 санал хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэн ажилласнаас гадна Шинэчлэлийн Засгийн газрын 11-11 төвд ирсэн тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 7 санал, 4 хүсэлт, 6 гомдлыг шуурхай шийдвэрлэж тухай бүр зохих хариуг хүргүүлэн ажилласан. Мөн тус байгууллагын эрхлэх асуудалд хамаарахгүй 9 санал, гомдол, хүсэлтийг холбогдох газруудад уламжилсан.
- Захиргааны хэргийн шүүхийн цахим хуудсанд⁸² 2004.08.20-оос 2011.04.06 хүртэл нийт 2264 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Үүнээс 84 хэрэг нь тендертэй холбоотой маргааныг шийдвэрсэн байна.

Эдгээр эх сурвалжаас хархад иргэд байгууллагууд санал гомдлоо Худалдан авах ажиллагааны газар, болон шүүхэд хандан шийдвэрлүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

- Худалдан авах ажиллагааны нөхцөл байдлын талаар олон нийт, нийтийн албан тушаалтны гэсэн 2 ангилалаар судалгаа хийж харьцуулан дүгнэж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх

5.1. (e) бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтантай холбогдох асуудлыг зохицуулах арга хэмжээ, тухайлбал нийтийн өмчийн хөрөнгөөр тодорхой бараа, ажил, үйлчилгээ худалдан

⁸¹ Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны эхний хагас жилийн зорилт, биелэлт, үр дүн тайлангаас, <http://www.e-tender.mn/uploads/files/download140703150539.pdf>

⁸² Захиргааны хэргийн шүүхийн цахим хуудас, <http://www.admincourt.gov.mn>

авах ажиллагаанд ямарваа ашиг сонирхол байгаа эсэхээ мэдүүлэх, үзлэг шалгалтын журам, бэлтгэл сургалтын шаардлага; /Конвенцийн 9.1.e/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагчийн үүрэгт тендерт оролцогч гэр бүлийнх нь гишүүн, эсхүл тендерт оролцогч хуулийн этгээдэд гэр бүлийнх нь гишүүн ажилладаг буюу цалин хөлс авдаг зэрэг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөл байвал өөрийн шууд харьяалан удирдах албан тушаалтанд мэдэгдэж, тухайн тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажиллагаанд оролцохгүй байх үүрэг хүлээлгэсэн. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь захиалагч болон тендерт оролцогчдыг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдэнд сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй байхаар заасан. Мөн тендер шалгаруулалтыг зохион байгуулах зорилгоор захиалагчийн байгуулсан үнэлгээний хорооны гишүүний чиг үүрэг, хорооны гишүүнд орсон албан тушаалтанд тавигдах шаардлагыг хуульчилсан бөгөөд Үнэлгээний хорооны гишүүнийг томилох, түүний ажиллах журам, зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулахаар заасан байна. **Үүгээрээ худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтны үзлэг шалгалт хийх журам, бэлтгэж сургах талаарх шаардлага ашиг сонирхолоо мэдүүлэх Конвенцийн шаардлагыг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж үнэлж байна.** Харин Үнэлгээний хорооны гишүүнийг томилох, түүний ажиллах журам, зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулахаар заасны дагуу тухайн журам болон Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах хүмүүст зориулсан сургалт, түүнд хамрагдсан хүмүүсийн талаарх мэдээллийг хайсан боловч Сангийн яамны цахим хуудаснаас уг мэдээлэл олдоогүй. Гэвч энэхүү үнэлгээг хийж байгаа бидний хувьд энэ чиглэлээр тодорхой сургалт явагдсан, үнэлгээний хорооны гишүүдийг бэлтгэсэн тухай албан бус мэдээлэл дээрээ үндэслэн үнэлсэн болно. Түүнчлэн **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд** өөрийн албан үүргээ биелүүлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх чиглэлээр Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй гэж заасан нь үнэлгээний хорооны гишүүнд нэгэн адил хамаарах бөгөөд албан тушаалтан албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд авах арга хэмжээ болон Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах ерөнхий зохицуулалтыг зааж өгсөн байдаг.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- **Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал, 2013 оны 12 дугаар сард хийсэн судалгааны тайлангаас⁸³:**

Төрийн байгууллагын тендер явуулах болон гэрээ байгуулах ажиллагаанд компанийн зүгээс авлигатай хэр их тохиолддог вэ гэсэн асуултанд бизнес эрхлэгчидийн 50 хувь нь төрийн байгууллага дахь авлига бизнест шууд нөлөөлж байна гэж мэдэгдсэн. Энэ хувь нь 2013 оны 5 дугаар сарын үзүүлэлтээс 7 хувиар дээгүүр байв. Гэхдээ үүний үр нөлөө аажмаар буурч байгаа нь харагдаж байна. Авлига “ихээр” нөлөөлж байна гэж мэдэгдсэн хүний тоо 2012 оны 12 дугаар сард 35.2 байснаа 2013 оны 10 дугаар сард 21.8 болж буурчээ. /14-р хуудас/

Хувийн хэвшилд авлига буурсан гэж үзэж байгаа хүний тоо 3.1 хувиар буурсан. Гэтэл авлига нэмэгдсэн гэдэгт итгэж байгаа хүний тоо 4.2 хувиар өссөн байна. Судалгаанд оролцогчдын олонх нь авлигыг бууруулахад засгийн газрын үүрэг ролийг сөрөг байдлаар харсан хэвээр байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан хүмүүсийн 63.9 хувь засгийн газраас авч буй арга хэмжээг “бараг үр нөлөөгүй” буюу “огт үр нөлөөгүй” гэж тооцдог.

Дээрх судалгаанаас үзвэл *худалдан авах ажиллагааны 50 хувь нь шударга явагддаггүй гэж бизнес эрхлэгчид хариулсан бөгөөд үүнд Үнэлгээний хороонд ажиллаж буй хүмүүс мэргэшлийн өндөр түвшинд, аливаа сонирхлын зөрчилгүйгээр оролцож чаддаггүй байдал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэх талтай байна.* Гэхдээ үүнийг үнэлгээний хороонд ажилласан хүмүүсийн дунд нэргүй асуулга явуулж, тэдэнд тулгардаг бэрхшээл, нийгмийн ямар бүлгийн зүгээс /тендерт оролцогчид, эсхүл дарга нар гм\ хөндлөнгөөс нөлөөлдөг эсэх талаарх судалж, үр дүнгээр зохих арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Бидэнд үнэлгээний хорооны гишүүд хөндлөнгийн нөлөөллийн мэдүүлэг гаргадаг эсэх тухай мэдээлэл олдоогүй болно.

- **Монгол Улсын Үндэсний Аудитын газрын 2013 оны гүйцэтгэсэн ажлын тайлангаас⁸⁴:**

Улсын Их Хурлын 2013 оны намрын чуулганаар 2014 оны төсвийг хэлэлцэх үеэр Ерөнхий сайдын зүгээс улсын төсвөөс санхүүжүүлсэн олон барилгыг хэд хэдэн жил дамнаж буй боловч ашиглалтанд ороогүй. Дуусаагүй барилгын төсөв нь анх төсөвлөснөөс 2-8 дахин өссөнийг шүүмжилсэн. Эдгээр 272 дуусаагүй барилгыг Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэйгээр тусгаж, зохих судалгаа шалгалт хийх үүргийг Улсын Их Хурлын тогтоолоор Үндэсний аудитын газарт өгсөн байна. Энэ дагуу Үндэсний Аудитын газраас хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгааныг тогтоох, гүйцэтгэл, хэрэгжилтийн явц байдалд дүн шинжилгээ хийсэн байна. ҮАГ-ын тайлангаас үзвэл дүн шинжилгээнд хамрагдсан нийт 272 төсөл арга хэмжээнээс 490,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 144 төсөл, арга хэмжээ 2014 оны Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаж

⁸³ Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал ном, 16-р хуудас

⁸⁴ Монгол Улсын Үндэсний Аудитын газрын 2013 оны гүйцэтгэсэн ажлын тайлан, <https://docs.google.com/viewer?url=www.parliament.mn/files/download/69450&chrome=true>

хэрэгжүүлэх боломжтой. Үүнээс 80,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 37 объект 2014 онд ашиглалтанд орох боломжтой байна. Хөгжлийн банкаар дамжуулан эх үүсвэрийг нь шийдвэрлэх зам гүүрийн 15 төсөл, Барилгын хуульд заасан шаардлагыг хангаж 2015 оны төсөвт тусгах боломжтой 81 төсөл, арга хэмжээ байна. Улсын төсвөөс санхүүжилт авах шаардлагагүй 23 объект байгаагаас гадна, зориулалтыг нь өөрчилж худалдах замаар улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийг нөхөн төвлөрүүлэх 9 объект байна гэж үзжээ. **Дүн шинжилгээнд хамрагдсан 272 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хууль, тогтоомж, журмын 51 заалт нийтлэг байдлаар зөрчигдсэн ба давхардсан тоогоор 1034 зөрчил бүртгэгджээ. Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 15.2-т заасныг зөрчиж, зураг төсөл нь бэлэн болоогүй нийт 196 төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн улсын хөрөнгө оруулалтын жагсаалтанд тусгаж баталсан нь дээрх 272 объектын дийлэнх буюу 72.1 хувийг эзэлж байна** хэмээн уг тайланд дурдаад “дуусаагүй барилгын” шалтгааныг Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хянаж баталгаажуулах, техникийн нөхцөл хангах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, барилга объектыг барьж ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих зэрэг хөрөнгө оруулалтыг эзэмших бүх үе шатанд нэгдсэн бодлого зохицуулалтгүй, мөрдөж буй хууль, журам, стандартууд уялдаа холбоогүй байгаагийн зэрэгцээ захиалагч, гүйцэтгэгч, зураг төсвийн болон холбогдох мэргэжлийн байгууллагууд, төрийн албан хаагчдын ажил хариуцах чадвар, хариуцлага сул, хууль журам мөрддөггүй, хяналт тавьж хариуцлага тооцдоггүй байдал давамгайлж ужгирсан нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах үндсэн шалтгаан болж байна. Үүнээс гадна төсөл, арга хэмжээний зургийн даалгавар, зураг төсөл, төсөвт өртгийг алдаатай тооцоолж дутуу боловсруулах, нэмэгдэл зураг төсөв зохиох, тэдгээрт дур зоргоороо өөрчлөлт оруулах замаар төсөвт өртгийг нэмэгдүүлж дараа оны төсвийн тухай хуульд тусгуулах жишиг тогтсон байна. Түүнчлэн тендерт бага үнээр ялж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангаж зохион байгуулах шатанд захиалагчийн хяналтыг сулруулж, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөв зохиогч, баталгаажуулагч байгууллагууд хамтран төсөвт өртгийг нэмэгдүүлдэг, зарим тохиолдолд гүйцэтгээгүй ажлыг баталгаажуулж санхүүжилт олгодог явдал байна. Барилгын төсөвт өртгийг нэмэгдүүлдэг эдгээр зохисгүй үзэгдлийг таслан зогсоох шаардлагатай байна. Эдгээр дүн шинжилгээний аудитын дүнд илэрч бүртгэгдсэн хууль, журам, гэрээний зөрчлүүд нь ажил хариуцсан төрийн албан хаагчид, байгууллагуудын санаачилга, мэргэжлийн ур чадвар, гүйцэтгэлийн сахилга бат, хариуцлагатай холбоотой учир Засгийн газар тодорхой дүгнэлт хийж холбогдох арга хэмжээ авах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Зураг төсөл нь батлагдаагүй барилгыг төсөвт тусган батална гэдэг нь УИХ мөн хууль зөрчсөн гэж үнэлэгдэхээр байна. Мэдээж хэрэг, УИХ-аас байгуулагдсан ҮАГ нь ийм дүгнэлт хийх нь зохимжгүй. Олон жил он дамжиж төсвийг “сааж” байгаа 272 барилгын 72 хувийг зураг төсөлгүйгээр эх үүсвэрийг нь төсөвт тусгах үе шат бүрт оролцсон төрийн албан хаагчид бүгдээрээ УИХ-ыг хуурсан уу? гэдгийг холбогдох төрийн байгууллагуудаас олон нийт асуух эрхтэй. Олон жил ужгирсан энэ үзэгдэл авлигаас ангид байсан уу гэдгийг авлигаас урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах бүрэн эрх олгогдсон АТГ-аас бас асуух ёстой

байх. Гол нь цаашид ийм зөрчил гаргахгүй байх нэгдсэн ойлголтонд хүрч, ижил тэгш, хууль ёсны, шударга шаардлагыг оролцогч бүр өөртөө, бие биедээ тавих нь зүйтэй.

- Тендерт оролцогчдод, тендерийн үнэлгээний гишүүдэд зориулсан сургалт мэдээлэл хангалтгүй байна. “Дуусаагүй барилгын” гэх энэ асуудалд Авлигатай тэмцэх газрын зүгээс хэрхэн анхаарч ямар арга хэмжээ авсан тухай мэдээлэл байхгүй байна.
- Сангийн яамны сүүлийн 3 жилийн тайлангаас Худалдан авах ажиллагааны тухай хийсэн ажлын талаар мэдээллийг 2014 оны 06 дугаар сарын 27-нд, Тендерийн үнэлгээний хороонд ажиллах хүмүүст сургалт явуулдаг эсэх талаарх мэдээллийг 2014 оны 06 дугаар сарын 30-нд тус тус Сангийн яамны сайтаас хайж үзсэн боловч олдоогүй.
- Тендерийн хорооныхноос гадна тендерт оролцогчдын мэдлэг мэдээллийг дээшлүүлэх явдал нэгэн адил чухал байна. Бидэнд энэ талаар тодорхой мэдээлэл олдоогүй болно.

Зохих эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэдэг нь сайн хэрэг. Харин баталсан хуулиа тендерт оролцогч компанийн эрх бүхий албан тушаалтан, Үнэлгээний хорооны гишүүнээс эхлээд УИХ-ын гишүүн бүр ягштал хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хамгийн бага үнийн шалгуурыг хуульчилсан нь яам хийгээд тендер авах эрмэлзэлтэй оролцогчдын хувьд төсөвтөө багтааж үүргээ биелүүлэх боломжгүйд хүргэдэг байх магадлалтай тул хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай;
- Үнэлгээний хороонд ажилласан хүмүүсийн дунд нэргүй асуулга явуулж, тэдэнд тулгардаг бэрхшээл, нийгмийн ямар бүлгийн зүгээс \тендерт оролцогчид, эсхүл дарга нар гм\ хөндлөнгөөс нөлөөлдөг эсэх талаарх судалж, үр дүнгээр зохих арга хэмжээ авах
- Тендерт оролцогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх системтэй арга хэмжээ авах шаардлагатай;
- Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхолын мэдүүлгийг бичгээр гаргаж хэвших, энэ тухай олон нийтэд нээлттэй тоо баримтаар мэдээлж хэвшүүлэх.
- Тендерт оролцогч компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээний хорооны гишүүнээс эхлээд УИХ-ын гишүүн бүр авлигыг үл тэвчих хандлагаар худалдан авах ажиллагаа, төсөв батлах ажиллагаанд хуулиа дээдэлж, УИХ-аас хууль ёсны шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх

5.2. Оролцогч улс бүр нийтийн санхүүгийн удирдлагад ил тод байх, хариуцан тайлагнах явдлыг хөхиүлэн дэмжих талаар зохих арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна. Ийм арга хэмжээ нь дараах зүйлийг бусад зүйлийн хамт хамарна:

(а) үндэсний төсөв батлах ажиллагаа; /Конвенцийн 9.2.а/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуулиар төрийн байгууллагад энэ хуулийн авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх /6.1.4/ төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх үүрэг хүлээлгэсэн бөгөөд ингэснээр санхүүгийн удирдлагын ил тод байдал хангагдах нөхцлийг бүрдүүлсэн байна. Улсын төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр **Төсвийн тухай хуульд** Тухайн жилийн улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийг боловсруулан батлах цагалбарыг тогтоосон. Тухайлбал, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагч жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор жилийн төсвийн төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх зэргээр хуульчилж өгсөн байна. Төсвийн төслийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэх шаардлагыг ч хуульчилсан. **Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай** хуульд зааснаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн төслийг нэгтгэн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт мэдүүлэх бөгөөд Засгийн газар нь төсвийн төслийг ерөнхийлөн захирагч тус бүрээр хэлэлцэж 10 дугаар сарын 1-ний өмнө УИХ-д өргөн мэдүүлдэг байна. Хуульд заасанчлан Улсын Их Хурал нь улсын төсвийг 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор хэлэлцэн баталдаг. **Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд** зааснаар улсын төсвийг хэлэлцэх, батлах үйл явцыг нээлттэй хэлэлцдэг. Сум, хороо багийн түвшинд орон нутгийн төсвийг хэрхэн төлөвлөх зарцуулах талаар хэлэлцүүлэг явуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Мөн **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд** төрийн байгууллагууд төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах зохицуулалтыг тусгасан байна.

- Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх:
 - тухайн жилийн төсвийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;
 - өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор;
 - дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор.
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангах;

- Санхүүгийн тайланд нь хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;
- Тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 14 өдрийн дотор энэ тухай цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;
- Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;

зэрэг үүргийг хуульчилсан байна. Энэ нь төсвийн ил тод байдлыг хангах талаарх Конвенцийн дээр дурдсан заалтын шаардлагыг хангах чухал алхам болсон.

ЗӨВЛӨМЖ:

- Үндэсний төсөв батлах үйл ажиллагаанд илүү олон талыг оролцуулах талаарх санаачлагыг улам өргөжүүлэх;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах техник, зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх;
- Уг хуулийн олон нийтэд өргөн сурталчлах ажлыг Авлигатай тэмцэх газар тэргүүлэх зохион байгуулах арга хэмжээ авах.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангаас⁸⁵:**

УИХ-ын үйл ажиллагааг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх болон телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг УИХ-ын Тамгын газар зохион байгуулж байна. 2002 оноос “Сансар” кабелийн телевизийн харъяа парламентын сувгаар, 2009 оноос албан ёсны парламентын суваг ажиллаж байна.

2010 онд Засгийн газрын яам, агентлаг, тусгай газрууд, орон нутгийн төр, захиргааны байгууллагуудаас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг (мөн Авлигын эсрэг хууль тогтоомжийг) хэрэгжүүлсэн талаар Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн тайлангуудыг судалж үзэхэд “Төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах, зарцуулах үйл ажиллагаа ил тод, олон нийтийн хяналттай байх, төсвийн зарцуулалтын тайланд хяналт тавих механизм бүрдүүлэх” гэсэн заалтын хэрэгжилтийг тун хангалтгүй тайлагнасан, ихэнх тохиолдолд тайлагнаагүй байжээ.

Харин жилирэх бүр улсын төсвийг нээлттэй болгох талаар зарим ахиц гарч байна. Тухайлбал, 2007 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн төслийг УИХ-аас хэлэлцэж байх явцад уг төслийг анх удаа Сангийн яамны вэб сайтад тавьж ил

⁸⁵ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлан, 71, 72, 73-р хуудас

тод болгожээ. “Олон улсын төсвийн түншлэл” байгууллагаас хоёр жил тутам гаргадаг Нээлттэй төсвийн индекс тогтоох судалгаагаар Монгол Улс 2006 оны боломжит 100-аас 18 оноо, 2008 онд 36 оноо авсан бол 2010 онд 60 оноо авсан нь Төв Азийн бүс нутагтаа өндөр, дэлхийн дунджаас (42) нилээд дээгүүр үзүүлэлт болжээ. Энэ нь Засгийн газар урьд өмнө нийтэлж байгаагүй төсвийн баримт бичгүүдээ, түүний дотор 2007 онд улсын төсвийн төслөө, 2008 онд жилийн эцсийн төсвийн тайлангаа нийтэд танилцуулж эхэлсэнтэй холбоотой ажээ. Түүнчлэн 2008-2010 оны хугацаанд улсын төсвийн төслийн баримт бичгээ 50 хуудаснаас 300 хуудас болгож, улмаар төсвийн орлого, зарлагын тухай илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг болсон байна. Гэхдээ иргэдэд зориулж хялбаршуулсан, тодорхой салбар, орон нутгийн иргэдэд зориулж, хяналт тавихад зориулсан төсвийн мэдээлэл хэрэгтэй байна.

Төсвийн шинэчлэлийн ил тод байдлыг хангах зорилгоор 2008 оноос Сангийн яамны төсвийн бодлогын газраас Төсвийн ил тод байдлын мэдээллийн www.iltod.gov.mn сайтыг нээн ажиллуулжээ. Өмнөх жилүүдэд тус сайт заримдаа шинэчлэгдэхгүй саатаж байсан боловч өнөөдөр үйл ажиллагаа нь тогтворжоод байна. Уг цахим хуудсанд төсөвт байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв, хуваарийн өөрчлөлт, төсвийн байгууллага тус бүрийн дунд хугацааны төсвийн талаар тухай бүр байршуулах болсон. Энэхүү цахим хуудсанд 2009 оны хувьд УИХ-аар батлагдсан төсөв ба төсвийн гүйцэтгэлийг, 2010 оны хувьд батлагдсан төсөв, төсвийн хуваарийн хамт тус тус байршуулжээ. Мөн төсвийн сар бүрийн гүйцэтгэл, жилийн эцсийн гүйцэтгэлийг тус цахим хуудсанд байршуулж байна.

Уг сайтаар дамжуулан Монгол Улсын төсөвтэй холбоотой эрхзүйн баримт, олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, тэдгээртэй байгуулсан албан хэлэлцээ, төсөв боловсруулах үйл явц, төсвийн тоон мэдээ, статистик, бодлогын шинж чанартай судалгаа, танилцуулгуудаас эхлээд тодорхой нэг төсвийн байгууллагын төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Гэхдээ түүнийгээ олон түмэнд хүргэх, танилцуулах талаар олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудад ханддаггүй, зүгээр л тайлан мэдээллээ тавиад орхидог, иргэдэд чухам ямар мэдээлэл хэрэгтэй талаар судалж тодруулах, хоёр талын холбоо тогтоох талаар учир дутагдалтай гэж үзэхээр байна. Өнөөдрийн байдлаар уг цахим хуудас http://www.iltod.gov.mn/?page_id=78 илүү өргөн агуулгатайгаар тогтмол мэдээлэл өгч байна. Мөн аймаг, нийслэл, дүүрэг бүрийн төсвийн талаарх мэдээллийг <http://iltodtusuv.wordpress.com/> цахим хуудаснаас авах боломжтой.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд 2010 оноос төсвийн асуудлыг удаа дараа нээлттэй хэлэлцүүлж эхэлсэн. 2012 оноос эхлэн орон нутгийн төсвийг батлахад иргэдийн оролцоог хангах чиглэлээр нийслэл болон аймаг, сум, багийн түвшинд хэлэлцүүлгүүийг зохион байгуулж байгаад олон нийт сэтгэл хангалуун байгаагаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевизийн мэдээллүүд нотолж байна.

Манай иргэний нийгмийн байгууллагууд улсын, салбарын болон орон нутгийн төсөвт олон тооны мониторинг хийж гүйцэтгэх болсон. Эдгээр бараг бүх тохиолдолд олон улсын байгууллагууд төсөл шалгаруулах журмаар санхүүжүүлж байна. Тэд тодорхой төсөв, сан, хөрөнгө оруулалт, худалдан авалтыг сонгон авч мэдээлэл цуглуулан төсвийн зарцуулалт, хүрсэн үр дүнг

үнэлж дүгнэсний үндсэн дээр хууль тогтоогчид, шийдвэр гаргагчдаас эхлэн олон нийтэд хандсан олон тооны зөвлөмж гаргасан байдаг.

Энэхүү судалгааны явцад Төсөв боловсруулсан, батлуулсан, тодотгол хийсэн, ЗГ-ын нэгдсэн тайлан гаргасан талаарх мэдээллийг Сангийн яамны цахим сангаас хайж нилээд цаг хугацаа өнгөрсний дараа www.iltod.mn санг олж мэдсэн. Энэ нь бидний энэ чиглэлээрх туршлага, мэдээлэл дутмаг байгааг харуулсан. **Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлийн судалгаа, ажиглалт хийх талаар ТББ, хөндлөнгийн байгууллагууд мэргэшихэд харьцангуй урт хугацаатай гэрээ байгуулах замаар чадавхижуулах, өрсөлдөөнийг бий болгох талаар төрийн байгууллагууд анхаарах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрснээ энэ дашрамд тэмдэглэж байна.** Бид 2 сарын хугацаанд Конвенцийн бүхэл бүтэн 10 зүйлийн хэсэг, заалт бүрээр үнэлгээ хийхэд манай багийнхан бүгд илүү цагаар хангалттай ажилласан боловч бидний олж мэдээгүй олон мэдээлэл гарч ирсээр л байлаа. АТГ, төрийн байгууллагын зүгээс энэхүү ажлын даалгаврыг наанадаж 6 сараас нэг жилийн хугацаатай өгч, мэдээлэл цуглуулах, ажиглалт хийх, хэвлэлийн мэдээлэл дээр анализ хийх, тодорхой бүлгийг хамруулсан асуулга судалгаа хийх боломж олгосон бол тайлангийн чанарт бодитой нөлөөлөх байсныг тэмдэглэж байна.

Бид үнэлгээ хийх явцдаа Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан 4 чиглэлээр мэдээллээ хэрхэн ил тод болгосныг яам, агентлаг, Улсын Их хурлаас байгуулагддаг нийт 48 төрийн байгууллагын цахим хуудсанд суурилсан бяцхан судалгаа хийсэн. Үүнээс худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаарх хуулийн шаардлагыг хэрхэн хангасныг дараах хүснэгтэд харуулав.

Төрийн байгууллагуудын цахим хуудсанд суурилсан мэдээллийн ил тод байдлын судалгаанаас: /Хэсэгчлэн авав/

	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зүйл заалт	Мэдээлэл байршуулсан	Мэдээлэл байршуулаагүй	Булантай ч мэдээлэл байршуулаагүй	Хамаарах гүй
Төсөв, санхүүгийн ил тод байдал	Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл /9.1.1/	36	12	-	-
	Жилийн эцсийн санхүүгийн тайлан /9.1.2/	34	11	3	-
	Аудитын дүгнэлт /9.1.3/	35	13	-	-
	Төсөвт нэмэлт өөрчлөлт орсон /9.1.4/	2	45	1	-
	зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээ/9.1.5/	1	43	2	2

Хүснэгтээс үзвэл эдгээр 48 байгууллагаас тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийн талаарх мэдээллийг 12 байгууллага цахим хуудсандаа байршуулаагүй, жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 11 байгууллага байршуулаагүй, аудитын дүгнэлтээ 13 байгууллага /Тагнуулын ерөнхий газар, Цөмийн энергийн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Байгаль орчин ногоон хөгжлийн яам, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Иргэний нисэхийн ерөнхий газар, Газрын тосны газар, Мал эмнэлэг үржлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Үндэсний аудитын газар, Монгол банк. Энд *Italic*-аар тэмдэглэсэн байгууллагуудын хувьд төрийн нууцтай холбоотойгоор уг мэдээллийг тусгах нь хамааралгүй байж болох юм. Нөгөө талаар ҮАГ –ын тайланд аль байгууллага аудит хийх нь тодорхойгүй байж болох юм гэж үзэв/ байршуулаагүй байлаа. Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээг цахим хуудсаараа мэдээлэх хуулийн шаардлагыг ердөө нэг байгууллага хангасан байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

ЗӨВЛӨМЖ:

- Тагнуулын ерөнхий газар, Цөмийн энергийн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб зэрэг байгууллагын төсвийн мэдээлэл нь төрийн нууцтай холбоотой байдаг бол Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар тогтоосон шаардлагаас чухам аль заалт нь хамааралтай болохыг судалж, шаардлагатай бол зарим заалт эдгээр байгууллагуудад хамаарахгүй байхаар уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
- Үндэсний аудитын газрын санхүүгийн тайланд аль байгууллага аудит хийх талаарх зохицуулалтыг хийдэлтэй орхих нь зөв үү гэдгийг судалж шийдвэрлэх. Шардлагатай бол Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зарим шаардлага тус байгууллагад хамаарахгүй гэдэг өөрчлөлтийг нэмж оруулах
- Монгол банкны цахим хуудас нь улс орны санхүү, эдийн засгийн байдлын талаарх баялаг мэдээлэлтэй цаг үеэ мэдэрсэн маш сайн сайт гэж үнэлэгддэг. Гэвч Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар шаардсан мэдээлэл тэнд байдаггүй. Бид 2013 оны эцсээр хийсэн үнэлгээнд ч энэ талаар дурдаж байсан. Хэрэв Төв банкны онцгой статустай холбоотойгоор мэдээлэл нь нууц байх ёстой бол уг хуульд энэ талаар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.
- Төрийн дээд байгууллагууд хуулиа мөрдөөгүй гэдэг үнэлгээг дахин дахин өгөх нь нь манай багийн хувьд ч тун зохимжгүй байлаа.

5.2. (b) орлого, зарлагыг цаг тухайд нь тайлагнах; /Конвенцийн 9.2.b/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төсвийн тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай зэрэг хуулиудад төсөв, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах талаар тодорхой заасан байдаг ч орлого зарлагыг цаг тухайд нь тайлагнах эрх зүйн орчин бүрдээгүй байлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч 2014 ны эхээр **“Шилэн дансны тухай”** хуулийн төсөл санаачилсан бөгөөд нэг удаа УИХ-аас буцаагдсаны эцэст 2014 оны 7 дугаар сарын 3-ны өдөр батлагдлаа. Уг хуулийн гол үзэл баримтлал нь Улс болон орон нутгийн төсвийн орлого, зарцуулалт, мөнгөн гүйлгээ, тайлагнал болон өр, зээл, батлан даалт, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой шийдвэр, үйл ажиллагаа “цогц байдлаар” олон нийтэд нээлттэй, ил тод болгох явдал бөгөөд ингэснээр төсвийн гүйлгээ бүрт иргэний хяналтын тогтолцоо бүрдэж, татвар төлөгчдийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах төсвийн удирдлагын тогтолцоо бүрдэхэд томоохон нөлөө үзүүлж, төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангасан эрх зүйн нэгдмэл орчин бүрдэнэ. Нөгөө талаар татвар төлөгчдийн хөрөнгө болон төрийн өмчийн хөрөнгийг үр ашиггүй зүйлд захиран зарцуулах байдал багасах бөгөөд авлига, хээл хахуулийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлж, **өмнө нь тухайн төрийн байгууллагын төсвийн талаар жилийн дүнгээр нэгдсэн тоог мэддэг байсан олон нийт түүний задаргааг өдөр бүр ажиглан хянах боломжийг бүрдүүлж байгаагаараа “Шилэн дансны тухай” хууль авлигаас урьдчилан сэргийлэх түүхэн ач холбогдол бүхий хууль болсон гэж үзэж байна.**

Түүнчлэн **Шилэн дансны тухай хууль батлагдсанаар орлого, зарлагыг цаг тухайд нь ил тод болгох Конвенцийн шаарлагыг эрх зүйн орчны хувьд манай улс хангаад байна.** Уг хуулийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх бөгөөд энэ хугацаанд хэрэгжих орчныг бүрдүүлэх, мэдээллийн технологийн шийдэл, хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын ажилтнуудыг бэлтгэх, хуулийн сурталчлах, иргэд, ТББ-ын мэдээллийг сайжруулж сурталчлах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг Засгийн газраас авах чиглэлүүд тодорхойлогджээ.

Шилэн дансны тухай хуульд зааснаар уг хуулийн 3.1.1-3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлж байхаар тусгасан байна. /Хуулийн төслийн 6.1/

link: <http://www.parliament.mn/law/project/409/category/1>

- Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;
- Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;
- Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн

дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

➤ Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.

Үүнтэй холбоотойгоор Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд цаг хугацааг нийцүүлэх арга хэмжээг хамтад нь шийдвэрлэх байх гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах техникийн нөхцлийг байгууллага бүр бүрдүүлэх. Үүнд, Сангийн яам, Мэдээллийн технологийн газар, төв орон нутгийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, санхүүгийн болон мэдээллийн технологи хариуцсан ажилтнуудын нэгдсэн ойлголт чухал тул хуулийг сурталчлах, хэрэгжилтийн хангах эрх зүй, зохион байгуулалтын ажлыг шахуу төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай
- Энэхүү хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн оролцоог хангахад чиглэсэн гарын авлага, сурталчилгааны мэдээлэл, материал бэлтгэх, түгээхэд АТГ, СЯ, ХЗЯ, Мэдээллийн технологийн газар зэрэг байгууллага бүр өөрийн чиг үүргийн дагуу шаардлагатай арга хэмжээ авах, энэ оны 12 дугаар сард хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хэрхэн хангагдсан талаар хэлэлцүүлэг хийж, ажлын уялдааг хангах
- Хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох субъектүүд орлого, зарлагаа цаг тухайд нь ил тод болгон хуулиа хэрэгжүүлэх нь авлигаас урьдчилан сэргийлэх чухал алхам болно.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Хууль дөнгөж батлагдаад байгаа бөгөөд 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдөх учир хэрэгжилтийн талаарх ажиглалт, анхны мэдээллийг наанадаж ирэх оны 2 дугаар сараас хойш цуглуулж судлах боломжтой болно.

ЗӨВЛӨМЖ:

- Орлого зарлага бүр олон нийтэд ил тод болгох техник технологийн, хүний нөөцийн нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ эртнээс авах нь зүйтэй.

5.2. (с)нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоо; /Конвенцийн 9.2.с/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн аудитын тухай хуульд зааснаар тус хуулийг төрийн аудитын байгууллагаас улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргахад дагаж мөрдөнө /4.1/. Төрийн аудитын байгууллагын тогтолцоо нь төрийн аудитын дээд байгууллага, түүний харьяа төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагаас бүрдэнэ. Төрийн аудитын дээд байгууллага нь Үндэсний аудитын газар, төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллага нь аудитын төрөл болон нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулагдсан аудитын байгууллага байна /6.1/. Харин **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд** нягтлан бодох бүртгэлийн зарчмыг /4.1./

- Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх;
- Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;
- Бүртгэл, тайлангийн үзүүлэлт энгийн, тодорхой, ойлгомжтой байх;
- Бүртгэл, тайлангийн тоо, мэдээг аргачлалын хувьд өнгөрсөн, ирээдүйн тоо, мэдээтэй зэрэгцүүлж болохоор зохиох;
- Удирдлагын болон зардлын бүртгэлд өөрийн онцлогт тохирсон оновчтой сонголт хэрэглэх;
- Тасралтгүй байх гэж заасан байна.

Аудитын тухай хуульд⁸⁶ зааснаар “аудитын үйл ажиллагаа” гэж аудитын байгууллагаас гэрээний дагуу хуулийн этгээд, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, үйл ажиллагааны тайланг хянаж дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ. /3.1/ Аудитын үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна: /4.1/

- Хуулийн этгээд, хувиараа аж ахуй эрхлэгч иргэний санхүүгийн тайланг захиалагч, үйлчлүүлэгчийн хүсэлтээр хянаж баталгаажуулах;
- Санхүүгийн байдлыг судалж төлөвлөх, хөрөнгө оруулалт, зээл, тооцооны төрөл бүрийн төсөл, төлөвлөгөө, хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ боловсруулахад нь тусалж үйлчлэх;
- Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх, нөхөн хөтлөх, тайлан гаргах, өртгийн болон удирдлагын бүртгэлийг зохион байгуулахад нь туслах, зөвлөгөө өгөх;
- Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг зохион байгуулахад нь туслах;
- Аж ахуйн нэгж, байгууллагад менежментийн асуудлаар зөвлөгөө өгөх;
- Үнэт цаас гаргахтай холбогдсон эдийн засгийн тооцоо, судалгааны үндэслэлийг хянаж дүгнэлт гаргах;

⁸⁶ Аудитын тухай хууль

➤ Аудитын үйл ажиллагааны хүрээнд хамруулахаар хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа
Эдгээр үйл ажиллагааг дараах үндэслэлээр явуулна. /6-р зүйл/

- хуульд санхүүгийн тайлангаа заавал баталгаажуулахаар заасан;
- аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, удирдах ажилтан аудит хийлгэх тухай хүсэлт гаргаж гэрээ байгуулсан;
- захиалагчийн аудит хийлгэх тухай шийдвэрийг үйлчлүүлэгч хүлээн авч аудитын байгууллага сонгон гэрээ байгуулсан.

Компанийн тухай хуульд⁸⁷ Нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоог бий болгох чиглэлээр Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт хэмээх зүйлийг оруулсан бөгөөд үүнд Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно. /94.1/ Харин Хувьцаат компанийн дүрэмд аудиторыг заавал ажиллуулахаар заасан /94.2./ бөгөөд аудитын шалгалтын үүрэг, хариуцлага, давтамж, хориглох зүйл, ТУЗ-тэй харилцах харилцаа зэргийг зааж өгсөн байна. **Компанийн засаглалын кодекс**⁸⁸-т Хөндлөнгийн аудитын байгууллага /аудитор/ нь аудитын ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд, холбогдох дүрэм журам, стандартын дагуу, хараат бусаар, хэн нэгний нөлөөнд авталгүйгээр, бодитой эрхлэн явуулна. /Кодексийн 7.2/

- Дээрх нөхцөл, байдалд харшлах зүйл бүхий аудиторыг сонгох боломжийг хаасан байна. Энэ талаар аудитортой байгуулах гэрээнд нарийвчлан тусгаж хяналтыг хэрэгжүүлдэг байна;
- Хөндлөнгийн аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн дүрмийг чанд баримтлах бөгөөд компанийн удирдлагын болон хяналтын багц эзэмшигчдийн зүгээс санал болгосон, тэдгээрийн хувийн сонирхлыг тусгасан гэрээ байгуулахыг хориглоно.
- Хөндлөнгийн аудиторууд нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож аудитын шалгалтын тайлантай холбоотой хувьцаа эзэмшигчдийн асуултад хариу өгдөг байна;
- Хөндлөнгийн аудиторуудын санаатай, санамсаргүй алдааны улмаас аудитын шалгалтын тайланг ашиглагч этгээдэд хохирол учирвал хөндлөнгийн аудитор нь учирсан хохирлыг барагдуулах үүрэг хүлээдэг, хүлээх хариуцлагын талаар тэдгээртэй байгуулах гэрээнд тодорхой тусгасан байна;
- Нийтэд хүргэсэн мэдээлэл нь санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллээс зөрүүтэй байгаа нь шалгалт хийх явцад тогтоогдвол аудиторууд уг мэдээллээ залруулахыг шаардах үүрэгтэй бөгөөд залруулах үүргийг компанийн гүйцэтгэх удирдлага хүлээнэ;
- Хөндлөнгийн аудиторууд нь шалгалтын явцад илэрсэн компани, түүний гүйцэтгэх удирдалыг гаргасан зөрчлийг нуун дарагдуулалгүйгээр ТУЗ, ХНХ-д мэдээлдэг байна;

⁸⁷ Компанийн тухай хууль

⁸⁸ Компанийн засаглалын кодекс, Санхүүгийн зохицуулах хороо, 2014.05.07

- Хөндлөнгийн аудиторын дүгнэлтэд тухайн компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвартай эсэх талаар тухайлан заасан байна. Хөндлөнгийн аудиторууд нь шалгаж буй компанийнхаа төлбөрийн чадварын талаар онцлон дүгнэлт гаргах ёстой бөгөөд энэ асуудал нь ихээхэн ноцтой үр дагавартай байдаг учраас хариуцлагатай хандан, онцгой анхаарал хандуулах ёстой. Хөндлөнгийн аудиторууд нь компанийн төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргахаас зайлсхийх, хариуцлага хүлээхгүйн тулд тодорхой бус, хоёрдмол санаатай, ерөнхий дүгнэлт гаргах ёсгүй;
- Хөндлөнгийн аудитын үйлчилгээний хөлсийг зөрчил илрүүлснээс хамаарч багасгах, эсхүл гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны талаар эерэг дүгнэлт гаргаснаас хамаарч ихэсгэдэг байж болохгүй хэмээн заасан байна.

Эдгээрээс үзэхэд **Конвенцийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоог Монгол Улс нь эрх зүйн тулгуур зарчмаараа дамжуулан бэхжүүлэх зохих алхамууд хийсээр байна.**

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- **Үндэсний аудитын газрын 2013 оны үйл ажиллагааны тайлангаас⁸⁹:**

Үндэсний Аудитын газар, аймаг, нийслэлийн аудитын газрууд улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргадаг бөгөөд 2013 онд Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаа явуулж нийт гүйцэтгэлийн 311, санхүүгийн тайлангийн аудит 4099, эрсдлийн болон нийцлийн аудит 196, нийтдээ 4606 аудит хийж зөрчил гаргасан 682 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар холбогдох дээд албан тушаалтанд санал явуулж 607 албан тушаалтанд хариуцлага тооцож, 65 асуудлыг хууль хяналтын байгууллагад хянуулахаар шилжүүлжээ. Үүнээс үзвэл төрийн аудитын байгууллага өөрийн системийн хүрээнд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх талаар зохих хүчин чармайлт гаргаж байна. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, Засгийн газрын тухай хуулийн дагуу төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа ТББ-ын болон төрийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд аудит хийх ажлыг ҮАГ хариуцаж байгаа. Ингэхдээ ҮАГ хувийн аудитын байгууллагыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр уг ажилд оролцуулж байгаа нь нөөц бололцоог дайчлах сайн туршлага юм. Гэсэн хэдий ч Компанийн тухай хуульд зааснаар төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанид төрийн төлөөллийг хэрэгжүүлэх, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулахаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулахаар заасан. **Уг “бусад харилцаа” гэдэгт төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ын хөндлөнгийн аудитороо сонгох эрх хамаарч байгаа боловч тухайн компани ҮАГ-аас**

⁸⁹ Үндэсний аудитын газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан,
<https://docs.google.com/viewer?url=www.parliament.mn/files/download/69450&chrome=true>

сонгосон хувийн аудитын байгууллагаар аудит хийлгэж байгаа нь Компанийн тухай хууль болон Төрийн аудитын хууль, тэдгээрийн хэрэгжилтийн механизмыг судалж, зохицуулалтыг боловсронгуй болгох замаар давхардал, хийдлийг арилгах шаардлагатайг харуулдаг.

Дээр дурдсан “дуусаагүй барилгын асуудал” бол 1-2 жилд болсон асуудал биш. Төрийн аудитын байгууллага энэ хооронд асуудлыг зохих ёсоор анхаарлын төвд тавьсан уу, яагаад зураг төсөлчгүй байхад бараг 200 зуун барилга, объектод төсвийн мөнгө аваад ажлаа гүйцээгээгүй тухай асуудлыг УИХ дээр яригдах хүртэл хүлээж байсан бэ гэдэг асуудал байна. Эхний ээлжинд хэдэн төрийн байгууллагатайгаа ажиллаад төрийн мөнгийг төсөвт хуваарилуулан авсан хувийн хэвшлийн байгууллагуудыг анхаарлын гадна орхисон юм биш биз гэсэн асуудал байна. **Энэ нь Конвенцийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоог эрх зүйн хувьд бүрдүүлж байгаа боловч практик дээр төрийн аудитын байгууллагын үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна гэж үзэхэд хүргэж байна.**

- Төрийн байгууллагуудын цахим хуудсанд суурилсан мэдээллийн ил тод байдлын судалгаанаас⁹⁰: /Хэсэгчлэн аваг/

	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зүйл заалт	Мэдээлэл байршуулсан	Мэдээлэл байршуулаагүй	Булан тайч мэдээлэл байршуулаагүй	Хамаар ахгүй
Төсөв, санхүүгийн ил тод байдал	Аудитын дүгнэлт/9.1.3/	35	13	-	-

Судалгаанд хамрагдсан 48 байгууллагаас 35 байгууллага нь 2013 аудитын дүгнэлтээ цахим хуудсандаа байршуулсан байсан бол 13 байгууллага /Тагнуулын ерөнхий газар, Цөмийн энергийн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Байгаль орчин ногоон хөгжлийн яам, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Иргэний нисэхийн ерөнхий газар, Газрын тосны газар, Мал эмнэлэг үржлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Үндэсний аудитын газар, Монгол банк/ нь байршуулаагүй Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шаардлагыг хангаагүй байв. Гэхдээ **төрийн байгууллагууд цахим хуудсандаа мэдээллээ байршуулах явдал 2013 оны сүүлчээр тус “Эм Ди Эс энд Ассошейтс” хуулийн фирмийн багаас судалгаа хийж, зөвлөмж өгөх үетэй харьцуулбал ахицтай байгаад бид сэтгэл хангалуун байлаа.**

Нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоог эрх зүйн орчны хувьд бүрдүүлж, төрийн аудитын

⁹⁰ Төрийн байгууллагуудын цахим хуудсанд суурилсан мэдээллийн ил тод байдлын судалгаа 2014

тогтолцоог бүрдүүлсэн боловч хэрэгжилт жигд биш, ил тод байдлыг хангах явдал төдийлөн хангалттай биш байна.

ЗӨВЛӨМЖ:

- Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа ТББ болон төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хийх төрийн аудитын хүртээмжийг өргөжүүлж, энэ талаарх мэдээллийг нэмэгдүүлэх
- Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ын хөндлөнгийн аудиторроо сонгох эрхийн талаарх Компанийн тухай хууль болон Төрийн аудитын хууль, тэдгээрийн хэрэгжилтийн механизмыг судалж, зохицуулалтыг боловсронгуй болгох замаар давхардал, хийдлийг арилгах шаардлагатай
- Төрийн байгууллага бүр санхүүгийн болон үйл ажиллагааны талаарх аудитын дүгнэлтээ хуульдт заасан хугацаанд цахим хуудсандаа байршуулж хэвших

5.2. (d) эрсдлийн удирдлага, дотоодын хяналтын үр дүнтэй бөгөөд үр ашигтай тогтолцоо; /Конвенцийн 9.2.d/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Дотоод хяналтын чиглэлээр Сангийн сайдын 2009 оны 182 дугаар тушаалаар “Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх журам”-ыг, 2010 онд 116 дугаар тушаалаар “Дотоод аудит явуулах заавар”-ыг тус тус батлан гаргасан байна. Мөн Сангийн яамнаас 2013 онд “Улсын салбарын дотоод аудитын гарын авлага”-ыг Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн хүрээнд гаргасан байна. Эдгээр журам, заавар, гарын авлагад Конвенцийн заалтын хэрэгжилтийг хангах талаар хэрхэн тусгасныг авч үзье.

“Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх журам”⁹¹-ын зорилго нь санхүү, төсөв, хөрөнгө оруулалт, зээл, тусламж, худалдан авах үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, тухайн байгууллага, нэгжийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулахад чиглэсэн байна. Дотоод аудитын үйл ажиллагаа нь дараах хүрээг хамарч үнэлэлт, дүгнэлт өгнө.

⁹¹ Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх журам 2009.07.28

- санхүү, мөнгөний дотоод аудит, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцын төлөвлөлт, удирдлага, зарцуулалт болон үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, бүтээгдэхүүний ерөнхий ангийн өртөг зардал, тэдний бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт, мөнгөн хөрөнгө болон төсөв, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, удирдлагын мэдээллийн системийн дотоод аудит явуулах;
- үйл ажиллагааны эрсдлийг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөмж өгөх, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн дотоод хяналт, боловсон хүчний хариуцлага, мэдлэг чадвар шаардлагын түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлэлт өгөх;
- санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт;
- төрийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт;
- санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, нягтлан бодох бүртгэл, тайлан, мэдээллийн системийн шуурхай үнэн зөв, найдвартай байдал;
- нөөцийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;
- төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн ерөнхий менежер, төсөвт байгууллагуудад дотоод аудитын чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- дотоод болон хөндлөнгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах;

Ийнхүү тус журмаар дээр үйл ажиллагаануудад үнэлэлт өгснөөр нь конвенцийн авлигаас урьдчилан сэргийлэх дотоод аудитын хяналттай байх явдлыг хангахад чиглэгдсэн байна гэж үзэж байна.

“Дотоод аудит явуулах заавар⁹²” нь Улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг зохион байгуулах, төрийн сангийн үйл ажиллагаа, бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ худалдан авах, зээл, тусламжийн хөрөнгийн үр ашиг, төсвийн тэнцлийн харилцаа зэрэг төсөв, санхүүтэй холбоотой /цаашид төсөв санхүүгийн гэх/ үйл ажиллагаа батлагдсан журмын дагуу явагдаж байгаа эсэхэд дотоод хяналт тавих, арвилан хэмнэлт, үр ашиг болон учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, биелэлтийг хангахад хэсэгчилсэн ба бүрэн хэмжээний дотоод аудит явуулж, дүнг тайлагнах, удирдлагыг ерөнхий арга зүй, зөвлөмжөөр хангах зорилготой бөгөөд агуулгын хувьд конвенцийн дотоод аудитын хяналттай байх явдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Тус зааврын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн сангийн дотоод аудитын хамрах хүрээ”-нд Төрийн сангийн санхүүжилт, төлбөр тооцоо, данс бүртгэл, тайлагналтын үйл явцыг дараах байдлаар авч үзнэжээ:

- Төрийн сангийн нэгдсэн дансны ба улсын төсвийн харилцах дансны үлдэгдэл, Засгийн газрын тусгай сангууд, бусад мөнгөн хөрөнгийн урсгал гүйлгээний дүн мэдээг тулган хянах;
- Төрийн сангийн төлбөр тооцооны баримтын бүрдэл;
- Төсвийн байгууллагын дансны орлого, зарлагын гүйлгээг
- Төрийн сангийн нэгдсэн дансанд бүртгэгдсэн төсөвт байгууллагуудын өдөр тутам хийгдэж байгаа орлого, зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн

⁹² Дотоод аудит явуулах заавар 2010.05.20

хуваарийн дагуу цаг хугацаанд нь, үнэн зөв бүртгэж, түүнд өдөр тутам хяналт тавьж байгаа эсэх, гүйлгээний залруулгыг шалгах;

- Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдлийн мэдээг үнэн зөв тогтмол гаргаж, мөнгөн хөрөнгийн урсгалыг зөв удирдаж засгийн газраас гаргасан бонд, хадгаламжийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн тооцооллыг цаг тухайд нь хийж бүртгэлжүүлсэн эсэх;
- Монгол банкинд байршиж буй Төрийн сангийн нэгдсэн дансны орлого, зарлагын гүйлгээ болон арилжааны банкинд байршуулсан бэлэн мөнгөний харилцах дансны үлдэгдлийг өдөр тутам нийлж, өдрийн баримтанд хавсаргаж дансны хуулгыг үндэслэн гүйлгээ баланс гаргаж байгаа эсэх;
- Хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг хэрхэн тогтоосон байдал хүүг цаг хугацаанд нь данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх;
- Тэнцлийн гадуурх дансны бүртгэлийг шалгах;
- Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар аргачилал, санхүүгийн тайлангийн маягт аргачиллын талаар гаргасан Сангийн сайдын 2009 оны 137 тоот тушаалын биелэлтийг төрийн сан болон орон нутгийн төрийн санд хэрхэн хэрэгжүүлж байгааг байдал;

Гадаад, дотоодын зээл тусламж, өрийн удирдлагын талаар дараах байдлаар авч үзсэн:

- Гадаад дотоодын зээл тусламжийн дансны өрийн үлдэгдлийг Засгийн газрын болон төсвийн нэгтгэсэн тайлангийн өр авлагын дансны үлдэгдэлтэй тулган шалгах, тооцоо нийлж баталгаажуулсан эсэх;
- Зээл, тусламжтай холбоотой гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн данс бүртгэлд бүрэн тусгасан эсэхийг ерөнхий журналтай тулган шалгаж, тохируулга хийсэн эсэх;
- Зээлийн болон өрийн үлдэгдэлд хүү алданги тооцсон тооцооллыг гэрээний дагуу, үнэн зөв, цаг хугацаанд нь хийж, данс бүртгэлд тусгасан эсэх;
- Зээл тусламжийн хөрөнгөөр буй болсон хөрөнгө, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх, орлогод бүртгэж үр ашигтай ажлуулж байгаа байдал;

хэмээн зааж өгсөн нь Конвенцийн хувийн байгууллагын данс, шаардлагатай санхүүгийн тайланг аудит, магадлан итгэмжлэлийн зохих журамд хамруулах гэсэн заалтыг дотоодын хяналтаар хангасан байна.

“Улсын салбарын дотоод аудитын гарын авлага⁹³”-д дотоод аудитын албаны бүтэц зохион байгуулалт, аудиторын ажлын чиг үүрэг, эрсдэлд суурилсан дотоод аудитыг хэрхэн явуулах талаар түүнийг үе шат бүрээр нарийвчлан тусгаж өгснөөс гадна нийцлийн болон гүйцэтгэлийн дотоод аудитыг хэрхэн хийх талаар арга зүйн бүлгүүдийг багтаасан байна.

Эдгээр заавар, журам, гарын авлага нь Конвенцийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж байна гэж үзэж байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

⁹³ Улсын салбарын дотоод аудитын гарын авлага 2013

Төрийн байгууллага бүр харьцангуй хараат бус дотоод аудитын нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Гэсэн хэдий ч Төрийн байгууллагуудын эрсдлийн удирдлага, дотоод аудитын чиглэлээр хийсэн ажлын талаар мэдээлэл хомс байлаа. Бидний мэдэж байгаагаар Хууль зүйн яам дотоод аудитын хороог хараат бус гишүүнтэйгээр байгуулан банк зэрэг эрсдлийн удирдлагыг эхний ээлжинд хэрэгжүүлсэн хувийн хэвшлийн туршлагад суурилан тодорхой судалгаа хийж зарим ажлуудыг хийж туршиж байгаа тухай мэдээлэл байна.

2013 оны эцсээр “Эм Ди Эс энд Ассошейтс” хуулийн фирмийн багийн хийсэн **Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний тайланд:** “Бидний үнэлгээнд хамрагдсан 51 байгууллагаас 2013 онд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст 24 төрийн албан хаагчийг яллагдагчаар татаж, тогтоол үйлдсэн байна. Эдгээр байгууллагад нийт 4635 төрийн албан хаагч ажиллаж байгаатай харьцуулбал 200 төрийн албан хаагч тутмын нэг нь авлигын хэрэгт холбогдсон байгаа нь ноцтой үзүүлэлт гэж үзэж байна. Эдгээрээс зөвхөн хоёр холбогдогчтой нэг хэрэг ИНЕГ-н дотоод хяналтаар, 7 хэрэг бусад байгууллага, иргэдийн гомдлоор, 8 хэрэг АТГ-н шалгалтаар илэрсэн байна” гэснээс үзвэл төрийн албан хаагчийн үйлдсэн АТГ-ын харьяалан шалгадаг эрүүгийн хэргийн 5 хүрэхгүй хувийг тухайн байгууллагын дотоод хяналтаар илрүүлснийг бид **төрийн байгууллагын дотоод хяналт үүргээ хангалттай биелүүлдэг гэж үзэхгүй байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн байгууллагуудын дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг тогтворжуулах, үр нөлөөг дээшлүүлэх, дотоод аудитын чиглэлээр хийсэн ажлыг жилийн эцсийн тайландаа тодорхой тусгадаг болгож хэвшүүлэх
- Төрийн байгууллагууд эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх, тухайн байгууллагын онцлог чиг үүрэгтэй уялдуулсан эрсдлийн удирдлагын бодлого, зайны хяналтыг хэрэгжүүлэх шалгуур, системийг боловсруулж хэрэгжүүлэх
- Тухайн төрийн байгууллагын албан хаагч авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон тохиолдолд дотоод хяналтаараа илрүүлж чадсан эсэхийг дотоод хяналтын нэгжийн ажлын гол үзүүлэлт болгон үнэлдэг байх
- Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын чиглэлээрх төрийн байгууллагуудын туршлага солилцох, дотоод хяналт хариуцсан ажилтнуудын давтан сургалтыг АТГ-ийн зүгээс Төрийн удирдлагын академитэй хамтран системтэйгээр зохион байгуулж байх

**5.2. (e) зохих тохиолдолд, энэ хэсэгт тогтоосон шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд засаж залруулах арга хэмжээ; /Конвенцийн 9.2.e/
ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Төрийн аудитын тухай хуулиар⁹⁴ хууль тогтоомж зөрчигчид дараах хариуцлагыг хүлээлгэхээр заасан байна.

Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага /28-р зүйл/

- Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.
- Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ:
 - аудитад хамрагдсан байгууллагын санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт өгөх боломжгүй тохиолдолд;
 - төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд.

Аудитын тухай хуульд⁹⁵ /19-р зүйл/

Аудитор дараахь үүрэг хүлээнэ:

- аудитын үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд, хууль тогтоомж, батлагдсан стандартын дагуу явуулах;
- аудит хийж болохгүй нөхцөл байдал байгаа бол уг үйл ажиллагааг явуулахаас татгалзах эсхүл бусад аудитор, мэргэжилтэнг нэмж оруулах шаардлагатай байвал үйлчлүүлэгч буюу холбогдох аудитын байгууллагад нэн даруй мэдэгдэх;
- бусад мэргэшсэн нягтлан бодогчийн нэр хүндийг гутаах үйлдэл хийхгүй байх;
- аудит хийх явцад олж авсан аливаа мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, хуульд зааснаас өөр тохиолдолд бусдад мэдээлэхээс татгалзах. Энэ нь аудиторын үүрэг гүйцэтгэхийг больсноос хойш нэгэн адил хүчинтэй байна;
- үйлчлүүлэгч хүсвэл шалгалтын дүн, санхүүгийн тайлан баталгаажуулсан дүгнэлтийн хууль зүйн үндэслэлийг тайлбарлаж өгөх;

Үйлчлүүлэгч байгууллага дараахь үүрэг хүлээнэ: /11.1.4/

- шалгалтын явцад илэрсэн бүртгэл хөтлөлтийн болон санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчлийг шуурхай залруулах;

Аудитор, аудитын байгууллагад хүлээлгэх хариуцлага /33-р зүйл/

- Аудитын тухай хууль тогтоомж зөрчсөн аудитор, аудитын байгууллагад эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд дор дурдсан шийтгэл ногдуулна:

⁹⁴ Төрийн аудитын тухай хууль 2003.01.03

⁹⁵ Аудитын тухай хууль 1997.05.01

- энэ хуулийн 21, 30 дугаар зүйлийг зөрчсөн бол аудиторыг 30000-40000 төгрөгөөр, аудитын байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгох;
- санхүүгийн тайланг буруу баталгаажуулсан зэрэг аудитын үйл ажиллагааны зарчмыг зөрчиж хангалтгүй үйлчилгээ үзүүлсний улмаас захиалагч, үйлчлүүлэгч ба бусад этгээдэд эд хөрөнгийн хохирол учруулсан бол уг хохирлыг аудитын байгууллагаар нөхөн төлүүлж, аудиторыг 40000-50000 төгрөгөөр, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох
- энэ хуулийн 17 дугаар зүйлийг зөрчсөн бол энэ үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж, иргэнийг 20000-30000 төгрөгөөр, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр тус тус торгоно.
- Энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Захиалагч, үйлчлүүлэгчид хүлээлгэх хариуцлага /32-р зүйл/

- Энэ хууль бусад хууль тогтоомж зөрчсөн захиалагч, үйлчлүүлэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:
 - тайлангаа баталгаажуулахаас зайлсхийсэн бол албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;
 - санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахад санаатайгаар саад учруулсан бол албан тушаалтныг 30000-40000 төгрөгөөр, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;
- дээрх дурьдсан үйлдэл нь аудитын байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан бол уг хохирлыг гэм буруутай албан тушаалтан буюу байгууллагаар нөхөн төлүүлнэ.

Хууль тогтоомж зөрчигч бусад этгээдэд хүлээлгэх хариуцлага /33 дугаар зүйл/

- Үйлчлүүлэгчтэй ажил төрлийн холбоотой албан тушаалтан ба байгууллага нь санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахад шаардлагатай баримт, бусад материалыг танилцуулах, тайлбар гаргаж өгөхөөс татгалзаж аудитын үйл ажиллагаанд саад учруулсан бол шүүх албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгоно.
- Аудитын үйл ажиллагаа явуулах эрхгүй этгээд энэ төрлийн үйл ажиллагаа явуулсан бол шүүх олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 40000-50000, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгоно.
- Аудитын үйл ажиллагаа явуулах лиценз, зөвшөөрөлгүйгээр энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчлийг давтан үйлдсэн хуулийн этгээдийг татан буулгах асуудлыг шүүх холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- Шүүх энэ хуулийн 36 дугаар зүйлийг зөрчсөн гэм буруутай иргэнийг 25000-50000 төгрөгөөр, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгоно.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль⁹⁶д хууль тогтоомж зөрчигчид дараах хариуцлагыг хүлээлгэхээр заасан байна. /25-р зүйл/

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөн албан хаагчийг зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна.

⁹⁶ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 2011.06.16

- Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн албан хаагчийг эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 25.1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас хална.
- Энэ хуулийн 25.2-т заасныг зөрчсөн шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг шүүгч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Конвенцийн 9.2-т заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, засаж залруулах арга хэмжээг хуульчлан тогтоосон байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Үндэсний аудитын газрын 2013 оны үйл ажиллагааны тайлангаас⁹⁷:

2013 онд нийт зөрчил гаргасан 682 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар холбогдох дээд албан тушаалтанд санал явуулж 607 албан тушаалтанд хариуцлага тооцож, 65 асуудлыг хууль хянаалтын байгууллагад хянуулахаар шилжүүлсэн байна.

Төрийн төв байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2013 оны үнэлгээний тайлангаас⁹⁸: Үнэлгээнд хамрагдсан 50 байгууллагаас 2013 онд Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 16 хэрэгт, 24 төрийн албан хаагчийг яллагдагчаар татаж, тогтоол үйлдсэн байна. Эдгээр байгууллагад нийт 4635 төрийн албан хаагч ажиллаж байгаатай харьцуулбал энэ онд 200 төрийн албан хаагч тутмын нэг нь авлигын хэрэгт холбогдсон байгаа нь ноцтой үзүүлэлт гэж үзэж байна. Эдгээрээс зөвхөн хоёр холбогдогчтой нэг хэрэг ИНЕГ-н дотоод хяналтаар, 7 хэрэг бусад байгууллага, иргэдийн гомдлоор, 8 хэрэг Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн байна.

Төсөв батлах журам, нягтлан бодох бүртгэл, аудитын стандартыг зөрчсөн тухай болон түүнд хариуцлага хүлээлгэсэн тухай нэгдсэн цэгцтэй мэдээлэл байхгүй байна. Түүнчлэн нийтийн санхүүгийн улирдлага, эрсдлийн удирдлагын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл хомс байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төсөв батлахад олон нийтийн оролцоог хэрхэн хангаж буй талаар Сангийн яам тусгайлсан тайлан гаргадаг байх;
- Орлого зарлагыг цаг тухайд нь тайлагнадаг байх Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн болон техникийн нөхцлийг хангаж Конвенцийн шаардлагыг практикт эхнээс нь сайн хангах;
- Төрийн аудитын, Аудитын, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн тухай статистик мэдээллийг ил болгох;
- Нийтийн санхүүгийн эрсдлийн удирдлагын үр дүнтэй арга, аргачлал, тогтолцоог бий болгох үе шаттай арга хэмжээ авах;
- Зайны хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр төрийн байгууллага бүр тодорхой арга хэмжээ авах.

5.3. Оролцогч улс бүр улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байж болох иргэний эрх зүйн болон захиргааны арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна; /Конвенцийн 9.3/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар ⁹⁹ Конвенцийн улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах чиглэлээр Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх зарчмыг баримтлана. /4.1/ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болох бөгөөд Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцахаар /7.5, 7.6/ зааж батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулахыг аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчийн үүрэг /19.1.2/ болгон хуульчилсан байна. Харин тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр **Аудитын тухай хуульд** ¹⁰⁰ Аудитын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах зарчим болгон аудитын үйл ажиллагаа гүйцэтгэсэн этгээд шалгалт, магадлан шинжилгээ, баталгаажуулалтыг буруу хийснээс холбогдогч талд хохирол учруулбал өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх зарчмыг баримтлахаар зааж /5.5/ Аудитын тухай хууль тогтоомж зөрчсөн Аудитор, аудитын байгууллагад хүлээлгэх хариуцлагыг Аудитын байгууллагын тухай хуулиар дор дурдсанаар тодорхойлсон:

- Санхүүгийн тайланг буруу баталгаажуулсан зэрэг аудитын үйл ажиллагааны зарчмыг зөрчиж хангалтгүй үйлчилгээ үзүүлсний улмаас захиалагч, үйлчлүүлэгч ба бусад этгээдэд эд хөрөнгийн хохирол учруулсан бол уг хохирлыг аудитын байгууллагаар нөхөн төлүүлж, аудиторыг 40000-50000 төгрөгөөр, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох; /31.1.2./

Монгол Улсын Засгийн газар 2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийг Гэмт хэргийн тухай хууль болгон шинэчлэн найруулж УИХ-д өргөн бариад байна. Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг

⁹⁹ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2001.12.13

¹⁰⁰ Аудитын тухай хууль 1997.05.01

хангахад чиглэсэн, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг түүнд хүлээлгэх ял шийтгэлийг хэрхэн тодорхойлсныг дараах хүснэгтэд харуулав:

№	Эрүүгийн хууль ¹⁰¹ /233-р зүйл/	Гэмт хэргийн тухай хуулийн төсөл ¹⁰² /23.2-р зүйл/
	Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах	Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах
Объектив тал	<p>1. Аж ахуйн нэгж, байгууллагаас эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, түүнчлэн тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний үнэмлэх, гадаад паспорт, хувийн бусад баримт бичгийг ашиглах буюу бусдад ашиглуулах зорилгоор хуурамчаар үйлдсэн, ашигласан, борлуулсан бол</p> <p>2. Хуурамч баримт бичиг ашиглаж аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд үлэмж хэмжээний хохирол учруулсан, эсхүл энэ хэргийг байнга үйлдсэн бол</p>	<p>Тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний, албаны, жолооны үнэмлэх, боловсролын үнэмлэх, диплом, гадаад паспорт, төрийн шагнал, хүний хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн, эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон, төлбөр, тооцоо хийснийг баталсан баримт бичгийг хуурамч болохыг мэдсээр байж ашиглах, эсхүл бусдад ашиглуулахаар хуурамчаар үйлдсэн, ашигласан, худалдсан бол</p> <p>2. Энэ гэмт хэргийг үйлдэж бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан бол</p>
Ял, албадлагын арга хэмжээ	1. - хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох	1. - дөрвөн зуун тооцооны нэгжээс дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох

¹⁰¹ Эрүүгийн хууль 2002.01.03

¹⁰² Гэмт хэргийн тухай хуулийн төсөл

	<p>- нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>2. - хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</p> <p>- гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах</p> <p>- таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ</p>	<p>- нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах</p> <p>- нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2. - дөрвөн зуун тооцооны нэгжээс арван дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</p> <p>- нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах</p> <p>- нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ</p>
--	--	---

Дээрх хүснэгтээс үзэхэд Эрүүгийн хуульд заасан обектив тал Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд дэлгэрэнгүй /ялгааг тодруулан харуулав/ болсон бөгөөд хариуцлагын хувьд шинээр “зорчих эрхийг хязгаарлах” гэсэн албадлагын арга хэмжээ нэмэгдсэн байна.

№	Захиргааны хариуцлагын тухай хууль ¹⁰³	Зөрчлийн тухай хуулийн төсөл ¹⁰⁴ /10.14-р зүйл/
	-	Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчих
Объектив тал	-	<p>1. Иргэн, хуулийн этгээд нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн тайлан гаргаагүй, санаатайгаар санхүүгийн баримтыг устгасан, алга болгосон, нуусан бол</p> <p>2. Санхүүгийн тайлангаа энэ хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад тушаагаагүй бол</p>

¹⁰³ Захиргааны хариуцлагын тухай хууль 1992.11.27

¹⁰⁴ Зөрчлийн тухай хуулийн төсөл

Шийтгэл	-	1. - нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг таван сая төгрөгөөр тус тус торгох шийтгэл хүлээлгэнэ. 2. - таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр тус тус торгох шийтгэл хүлээлгэнэ.
---------	---	---

Одоогийн үйлчилж байгаа Захиргааны хариуцлагын тухай хуульд нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байж болох захиргааны арга хэмжээг зааж өгөөгүй байна. Харин Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд төгрөгийн худалдан авах өнөөгийн чавратай харьцуулбал тун бага хэмжээний торгууль хүлээлгэхээр заасан байдаг. Зөрчлийн тухай хуулийн төсөлд энэ талаар хэрхэн тусгасныг дээр харуулав. Энэ нь **Конвенцийн 9.3 дугаар зүйлийн шаардлагыг одоогийн хууль тогтоомжоороо хангалттай хэмжээнд хангаагүй байгаа ч батлагдахаар хэлэлцэж байгаа Зөрчлийн тухай хуулийн төсөл, Шилэн дансны тухай хууль батлагдсанаар энэ талаар Конвенцийн шаардлага хангагдана гэсэн хүлээлттэй байгаа.**

Авлигын журмаар авсан мөнгөн хөрөнгийг тухайн албан тушаалтан өөрийн нэрээр бус гэр бүлийн гишүүн, ойр дотнын хүмүүс, зарим тохиолдолд гэр бүлийн харилцаатай хүний нэрээр тэдгээрийн дансанд байршуулсан тухай мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нилээд гарах болсон \жишээ нь, УТЕГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн дарга асан Гансүхийн хэрэг гм\.

Санхүүгийн аливаа гүйлгээг зөвхөн өөрийн нэрээр хийхийг хатуу хуульчилсан зарим орон байдаг. Жишээ нь, БНСУ-ын Real Name Financial Transaction Act-ыг судалж, үүнтэй төсөөтэй зохицуулалтыг бий болгох нь нягтлан бодох бүртгэлийн үнэн зав байх зарчмыг бодит утгаар бий болгож, авлига, мөнгө угаах явдлыг илрүүлэх, таслан зогсооход хамгийн чухал алхам болно гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Санхүүгийн гүйлгээ бүрийг зөвхөн уг гүйлгээний үр дүнг шууд хүртэх этгээдийн нэрээр хийх шаардлагыг хуульчлах. Энэ талаар БНСУ-ын Real Name Financial Transaction Act зэрэг олон улсын туршлагыг судалж хуульчлах нь авлигаас урьдчилан сэргийлэх үндсийн үндэс болно

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Монгол Улс улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байж болох иргэний эрх зүйн болон захиргааны арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах талаарх Конвенцийн 9.3-т заасныг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх хангалттай тодорхой мэдээлэл олдоогүй. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэмэгдсэн өртгийн албан татварын хуурамч падан худалдан авч татвар төлөхөөс зайлсхийсэн хэрэгт 2000 орчим аж ахуйн нэгж холбогдон мөрдөн байцаах албанд шалгагдаж байгаа гэсэн мэдээлэл цацагдаж, жил дамнан шуугиж байгаа ч энэ талаар илүү тодорхой мэдээллийг энэхүү судалгааг хийх 2 сарын хугацаанд нухацтай судалж амжаагүй гэдгээ илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үндэсний татварын ерөнхий газрын цахим хуудсанд хэд хэдэн удаа хандсан боловч тус агентлагийн сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны тайлан олдоогүй. Иймд энэ чиглэлээрх судалгааг цаашид нягтлах нь зүйтэй гэж үзэж байна.

Хуурамч бичиг баримт үйлдэх нь татвараас зайлсхийх, үүргээс чөлөөлөгдөх, эдлэх ёсгүй эрхийг эдлэх сэдэлтэй байх нь цөөнгүй. Татварын ерөнхий хуульд уг хууль бус үйлдэлд хүлээлгэх иргэний болон захиргааны хариуцлагыг тодорхойлсон байдаг.

ЗӨВЛӨМЖ:

- Улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн байдал татварын хяналт шалгалтаар хэрхэн илэрдэг талаархи мэдээллийг ил тод болгох
- Авлига, хээл хахуулын болон татвар төлөхөөс зайлсхийх, мөнгө угаах гэмж хэргийн илрүүлэлт, энэ төрлийн гэмт хэргүүдийн хувьд нэг нь нөгөөгийнхөө суурь болох магадлалын талаар АТГ, ҮТЕГ, холбогдох бусад байгууллагын харилцан мэдээлэл солилцох, ажлын уялдааг хангах талаар зохистой арга хэмжээ авч, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэх шаардлагатай.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ

/10 дугаар зүйл/

6.1. Авлигатай тэмцэх хэрэгцээг харгалзан үзэж оролцогч улс бүр нийтийн захиргаандаа, түүний дотор зохион байгуулалт, чиг үүргээ хэрэгжүүлэх болон шийдвэр гаргах явцдаа ил тод байдлыг сайжруулахад шаардлагатай

байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн зохих тохиолдолд авна. Эдгээр арга хэмжээнд бусад зүйлийн хамт дараах зүйл багтана.

(а) нийтийн захиргааныхаа зохион байгуулалт, чиг үүргээ хэрэгжүүлэх болон шийдвэр гаргах явц, түүнчлэн хувийн амьдрал, хувийн мэдээ баримтыг хамгаалахыг зохих ёсоор харгалзахын сацуу иргэдийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр, эрх зүйн актын талаарх мэдээллийг зохих тохиолдолд олж авах боломжийг иргэдэд олгосон дүрэм буюу журам батлах; /Конвенцийн 10.1.а/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцийн энэхүү шаардлагыг **Монгол Улс Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар** хангаж байгаа юм. Энэ хууль нь 2011 оны 6-р сарын 11-ний өдөр батлагдаж мөн өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ хуулийн зорилт нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна /3.1./:

- Улсын Их Хурлын Тамгын газар;
- Ерөнхийлөгчийн Тамгын газар;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба;
- төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага;
- бүх шатны шүүх, прокурорын байгууллага;
- Улсын Их Хурлаас байгуулдаг /Засгийн газраас бусад/ байгууллага;
- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажлын алба, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага;
- олон нийтийн радио, телевизийн байгууллага.

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ /7.1./:

- эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; /7.1.1/

Энэ заалт нь Конвенцийн нийтийн захиргааныхаа зохион байгуулалт, чиг үүргийн мэдээллийг авах боломжоор иргэдийг хангасан байх шаардлагыг хангаж гэж үзэж байна.

- үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; /7.1.4./

Энэ заалт нь эрх зүйн актын талаарх мэдээллийг зохих тохиолдолд олж авах боломжийг иргэдэд олгосон байх шаардлагыг хангаж байна гэж үзэж байна.

- шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; /7.1.5./

Энэ заалт нь Конвенцийн шийдвэр гаргах явц, иргэдийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэрийг зохих тохиолдолд олж авах боломжийг иргэдэд олгох шаардлагыг хангасан байна.

Дурдсан хуульд төрийн байгууллагаас нийтэд ил тод болговол зохих мэдээллийг хуульчилснаас гадна иргэн хуулийн этгээд хүсэлт гарган авч болох мэдээлэл, түүнийг өгөх журмыг мөн тогтоосон. Иргэн, хуулийн этгээд нь *хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад* дараах мэдээллийг энэ хуулийн 3.1-д заасан байгууллагаас авах эрхтэй /11.1./:

- тухайн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ, контракттай холбоотой мэдээлэл;
- тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлтэй холбоотой мэдээлэл;
- тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл.

Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын холбогдох албан тушаалтан иргэнд энэ хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно. /11.2./

Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах шаардлагыг хангасан байна /11.3./:

- хүсэлт гаргагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсгээ зурсан байх;

- хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол нэр, хаяг буюу цахим шуудангийн хаяг, улсын бүртгэлийн дугаараа бичиж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсгээ зурсан байх.

Иргэн энэ хуулийн 11.3.1-д заасны дагуу хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зуруулж болох бөгөөд хүсэлтийг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана. /11.4./

Дараах тохиолдолд мэдээллийг бусдад задруулахыг хориглоно /18.1./:

- тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа;
- тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой;
- хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай;
- тухайн мэдээлэл нь олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах явцтай холбоотой.
- хууль тогтоомжид заасан бусад.

Дээрхээс үндэслэн Монгол Улс Конвенцийн 10.1.а заалтыг эрх зүйн зохицуулалтаараа хангаж байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Хууль тогтоомж, УИХ, ЗГ-ын шийдвэр, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон төрийн байгууллагуудын эрх зүйн акт болон эрх зүйн мэдээллүүд www.legalinfo.mn цахим санд нийтэд хүрдэг болсоор 10 гаруй жил болж байна. ***Хууль зүйн мэдээллийн албан ёсны энэхүү цахим сан бий болсон нь насанд хүрсэн бараг бүх хүн, хот хөдөөгүй гар утас ашигладаг болсон өнөө үед гар утас, компьютераараа эрх зүйн мэдээллийг цаг, орон зайн хязгааргүйгээр авах, судалгаа шинжилгээ хийх, үйл ажиллагаандаа ашиглах, мөрдөх хэрэгцээг зохих ёсоор хангасан цахим ертөнцөд суурилсан эрх зүйн шинэтгэлийн хувьсгалын энтэй томоохон үйл явдал болсон юм.*** Уг цахим санг байнга боловсронгуй болгох, шинэчлэх, улам баяжуулах ажил Хууль зүйн яам зэрэг төрийн холбогдох байгууллагын анхаарлын гадна байгаагүйн тод жишээ нь саяхан хуульчдын өдрөөр www.legalinfo.mn гар утасны аппликейшний нээлт болсон явдал нотолж байна. Хэдийгээр зарим мэдээлэлд техникийн шинжтэй алдаа гарах, мэдээллийг хожуу байршуулах зэрэг доголдол гардгийг үгүйсгэхгүй ч хуульч, судлаачид оюутнууд, төрийн албан хаагчдын хувьд маш үнэ цэнтэй мэдээллийг агуулдаг юм.

Анх Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж хяналт тавих Үндэсний зөвлөлийн 2003 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан “Авилгалын эсрэг үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-ний есдүгээрт Улсын Их Хурал, орон нутгийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэгдэх бодлогын чанартай томоохон хууль тогтоомж, шийдвэрийн төслийг олон нийтийн сонорт хүргэж урьдчилан хэлэлцүүлдэг журам тогтоож мөрдүүлэх чиглэлээр “Орон нутгийн болон үндэсний түвшинд хэлэлцэн батлах хууль тогтоомж, бодлого шийдвэрийн төслийн талаар олон нийтийн нээлттэй сонсгол хэлэлцүүлгийг /public hearing/ нэвтрүүлж, холбогдох хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах” арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байдаг. Харин 2006 онд шинэчлэн батлагдсан Авлигын эсрэг хуулиар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тодорхойлж, нэр томъёог тайлбарласан төдийгүй авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийг хуульчилж өгснөөр уг хөтөлбөрийн энэхүү заалт хэрэгжих үндэс тавигдсан гэж үзэхээр байна. 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль батлагдсанаар шийдвэрийн төслөө олон нийтэд танилцуулах, саналыг нь авч тусгах ажилд бодит ахиц гарсан.

Тухайлбал, 2010 оны 12 дугаар сард Авилгатай тэмцэх газрын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг үнэлэх “Төрийн байгууллагын ил тод нээлттэй байдал” веб орчинд хийх мониторинг”-н дүнгээс харахад худалдан авах үйл ажиллагаатай холбоотой журмын дагуу ил тод, нээлттэй мэдээлсэн байх ёстой 8 төрлийн баримт бичгээс дөнгөж 4 төрлийн баримт бичгийг цахим хуудсандаа байрлуулсан хувь 26 хувьтай буюу маш хангалтгүй гэсэн дүгнэлт гарч байсан¹⁰⁵ бол өнөөдөр төрийн байгууллагууд, парламентын сайтуудад тавигддаг хууль, төрийн эрх бүхий байгууллагуудын шийдвэрийн төслийн тоо эрс өссөн. УИХ-д өргөн баригдсан хуулийн төслүүд www.parliament.mn байнга таигдаж байна. Шийдвэрийн төслийг цахим хуудаснаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулах /7.1.5/ хуулийн заалтыг манай судалгааны багийнхан 2013.06.27-ны өдрийн байдлаар тандахад судалгаанд оролцсон 48 байгууллагын 3 нь тодорхой эрх зүйн актын төслөө цахим хуудсандаа байрлуулсан байлаа. Энэ нь цахим байдлаар байрлуулах хуулийн хугацаа дуусмагц уг мэдээллийг арилгадагтай холбоотой гэж үзэж байна. **Хууль, эрх зүйн актын төсөл, ер нь хуулиар ил болгох шаардлага тавьсан мэдээллийг цахим хуудсандаа архивлан хадгалах цаг хугацааг хуульчлан тогтоох нь судалгаа мониторингийн болон цаашлаад түүнэх ач холбогдолтой гэж үзэж байна.**

Мөн Төрийн байгууллагууд доорх цахим хуудсуудаар дамжуулан иргэдэд дээр дурдсан хуулиар заасан мэдээллийг олон нийтэд хүргэх тенхикийн нөхцөл бүрдсэн болно:

- Батлан хамгаалах яам: <http://www.mod.gov.mn/>
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам: <http://mne.mn/v3/>
- Гадаад харилцааны яам: <http://www.mfa.gov.mn/>
- Сангийн яам: <http://mof.gov.mn/>
- Хууль зүйн яам: <http://www.moj.gov.mn/>
- Уул уурхайн яам: <http://www.mm.gov.mn/>
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам: <http://www.mofa.gov.mn/new/>

¹⁰⁵ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангийн 63-р хуудас

- Барилга, хот байгуулалтын яам: <http://www.mcup.gov.mn/>
- Боловсрол шинжлэх ухааны яам: <http://www.meds.gov.mn/frontpage>
- Хөдөлмөрийн яам: <http://www.mol.gov.mn/>
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам: <http://www.khun.gov.mn/>
- Зам тээврийн яам: <http://mrt.gov.mn/>
- Соёл, спорт, аялал, жуулчлалын яам: <http://mcst.gov.mn/>
- Эдийн засгийн хөгжлийн яам: <http://www.med.gov.mn/mn/>
- Эрчим хүчний яам: <http://energy.gov.mn/>
- Хүүхдийн төлөө үндэсний газар: <http://www.nac.gov.mn/home.shtml;jsessionid=7BA8FED42EF6FFAFC71399BA58363117>
- Тагнуулын ерөнхий газар: <http://www.gia.gov.mn/>
- Цөмийн энергийн газар: <http://nea.gov.mn/>
- Худалдан авах ажиллагааны газар: <http://www.e-procurement.mn/>
- Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газар: <http://itpta.gov.mn/>
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар: <http://inspection.gov.mn/>
- Улсын бүртгэлийн ерөнхий газар: <https://burtgel.gov.mn/>
- Архивын ерөнхий газар: http://www.archives.gov.mn/index.php?option=com_contact&view=contact&id=1&Itemid=151
- Онцгой байдлын ерөнхий газар: <http://nema.gov.mn/>
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар: <http://www.afccp.gov.mn/>
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар: <http://cd.gov.mn/>
- Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар: <http://www.immigration.gov.mn/>
- Стандартчилал, хэмжил зүйн газар: <http://www.masm.gov.mn/>
- Зэвсэгт хүчний жанжин штаб: <http://gsmaf.gov.mn/#&slider1=2>
- Оюуны өмчийн газар: <http://www.ipom.gov.mn/>
- Цаг уур орчны шинжилгээний газар: <http://www.icc.mn/namem/>
- Иргэний нисэхийн ерөнхий газар: <http://www.mcaa.gov.mn/>
- Ашигт малтмалын газар-цахим хуудас нь ажиллахгүй байсан
- Гаалийн ерөнхий газар – цахим хуудас нь ажиллахгүй байсан
- Татварын ерөнхий газар: <http://www.mta.mn/>
- Газрын тосны газар: <http://www.pam.gov.mn/home.shtml;jsessionid=68DF9DA193190DD0EACA6B7E8DCAA27A>
- Төрийн өмчийн хороо: <http://www.spc.gov.mn/mn/index.php>
- Цагдаагийн ерөнхий газар: <http://www.police.gov.mn/>
- Хил хамгаалах ерөнхий газар: <http://bpo.gov.mn/>
- Мал эмнэлэг, үржлийн газар: <http://dvab.gov.mn/>

- Нийгмийн даатгалын ерөнхий газар: <http://www.ndaatgal.mn/>
- Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар: <http://www.halamj.gov.mn/>
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн: <http://nifs.gov.mn/>
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар: <http://www.gazar.gov.mn/eland/branch/101/>
- Хөрөнгө оруулалтын газар: <http://investmongolia.com/>
- Улаанбаатар хот: <http://www.ulaanbaatar.mn/>
- Архангай аймаг: <http://arkhangai.gov.mn/>
- Баян-Өлгий аймаг: <http://www.bayan-olgi.gov.mn/>
- Баянхонгор аймаг: <http://www.bayankhongor.gov.mn/>
- Орхон аймаг: <http://www.erdenet.mn/>
- Сэлэнгэ аймаг: <http://selenge.gov.mn/>
- Булган аймаг: <http://www.bulgan.gov.mn/home/start/>
- Говь-Алтай аймаг: <http://www.govi-altai.gov.mn/>
- Төв аймаг: <http://tov.gov.mn/>
- Увс аймаг: <http://www.uvs.gov.mn/>
- Говьсүмбэр аймаг: <http://www.govisumber.gov.mn/>
- Дархан-Уул аймаг: <http://www.govisumber.gov.mn/>
- Ховд аймаг: <http://www.khovd.gov.mn/home/>
- Хөвсгөл аймаг: <http://khovsgol.gov.mn/>
- Дорнод аймаг: <http://www.dornod.mn/>
- Дорноговь аймаг: <http://www.dornogovi.gov.mn/>
- Хэнтий аймаг: <http://khentii.mn/index.html>
- Сүхбаатар аймгийн цахим хуудас ажиллахгүй байсан
- Завхан аймаг: <http://www.zavkhan.gov.mn/>
- Өмнөговь аймаг: <http://www.omnogovi.gov.mn/home.shtml>
- Өвөрхангай аймаг: <http://uvurkhangai.mn/>
- Дундговь аймаг: <http://www.dundgovi.gov.mn/dundgobi/index.php?pid=56>
- 2014 онд шинээр байгуулагдсан Тахарын ерөнхий газар цахим хуудас нээгээгүй байна.

Жишээ болгон Хууль зүйн яамны цахим хуудсыг авч үзье. Мэдээллийн ил тод байдлын цэстэй, үүнд үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв санхүүгийн, худалдан авах ажиллагааны зэрэг ангиллаар хуулиар тавьсан мэдээллийн цэсийг байршуулсан байна. Үйл ажиллагааны ил тод байдлын хэсэгт үйл ажиллагааны товч тайлангаа байршуулсан байна. Цахим хуудасны “Танилцуулга” хэсэгт яамны эрхэм зорилго, бүтэц зохион байгуулалтыг харуулсан. Эрх зүйн актын буланд хууль тогтоомжууд, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүйн сайдын тушаал, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, эрх зүйн туслалцааны гэрээ, үндэснийн хөтөлбөрүүд гэсэн хэсгүүдтэй байгаа нь Конвенцийн зохион байгуулалт, чиг үүрэг, эрх зүйн актын талаарх мэдээллийг олж авах боломжийг иргэдэд олгосон байх гэсэн

шаардлагыг хангасан байна. Гэвч шийдвэр гаргах явц болон иргэдийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэрийг олж авах боломжийг иргэдэд олгосон байх гэсэн шаардлагыг хангаагүй байна, эсхүл шийдвэрийн төслүүдийг тухай бүрт нь устгадаг байх магадлалтай.

Манай судалгааны баг 2013 оны сүүлчээр хийсэн судалгааны дүнгээр **Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Стандарт, хэмжил зүйн газарт** хандан дараахь зөвлөмжийг өгсөн. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаар мэдээлэл, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангахтай холбоотойгоор уг хуулийн 7 дугаар зүйл, 8.1 дэх хэсэг, 9, 10 дугаар зүйлд заасан мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн санг үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах нийтлэг журмыг боловсруулж, Засгийн газраар батлуулах, мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах чиглэлээр төрийн байгууллагуудын дунд сургалт зохион байгуулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх бүрэн эрхтэй. Засгийн газар 2014 оны эхээр уг журмыг баталсан. Гэхдээ төрийн байгууллагуудын цахим хуудасны агуулга, загвар нь олон нийт мэдээлэл хайхад хялбар, ойлгомжтой, агуулгын хувьд хуульд заасан шаардлагыг бүрэн хангахуйц байх шаардлагатай байна. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага: MNS 6285:2011” нь 2012 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль шинээр батлагдсан, Авилгын эсрэг хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө батлагдсан, хэдийгээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль уг стандарт батлагдах үед буюу 2011 оны 6 дугаар сард батлагдсан боловч уг хуулиар тодорхойлсон агуулгыг энэхүү стандартыг батлахдаа харгалзан үзээгүй байна гэж дүгнэхээр байна. Иймд авлигын эсрэг эрх зүйн шинэ орчинд нийцүүлэн дээр дурдсан “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага: MNS 6285:2011”-ыг нэн даруй шинэчлэхийг зөвлөж байна. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын зүгээс төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжүүлэх болон асуудал хариуцсан ажилтнуудыг чиглүүлэх, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг төлөвлөгөөндөө тусган үргэлжлүүлэн зохион байгуулах нь зүйтэй байна. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Стандарт, хэмжил зүйн газар нь хууль шинэчлэгдсэн байхад түүнтэй үйл ажиллагаагаа уялдуулж, тодорхой ажлыг төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэх талаар анхаарал тавиагүйг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна” гэж дурдсан байна.

Түүнээс хойш энэ чиглэлээр зохих байгууллагууд анхааралдаа авч стандартыг шинэчлэн асуудлаар АТГ холбогдох байгууллагын удирдлагатай уулзан хөндлөнгийн үнэлгээний дүнгээр тодорхой ажил хийгдэж байгаад бид талархаж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан 4 чиглэлээрх мэдээллийг цахим хуудсанд 10 хүртэл жилээр архивлан хадгалах заалтыг хуульд нэмж оруулах
- Төрийн байгууллагуудын цахим хуудсанд тавигдах мэдээллийн стандарт баталсан “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага: MNS 6285:2011”- ыг шинэ дурдсан 2 хуулийн агуулгад нийцүүлэн хэрэглэхэд хялбар, ойлгомжтой болгон шинэчлэн батлах ажлыг яаравчлах

6.1. (b) шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг хөнгөвчлөн дэмжихийн тулд захиргааны журмыг зохих тохиолдолд хялбарчлах; /Конвенцийн 10.1.b/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хууль

Мэдээллийн ил тод байдал дараах төрөлтэй байна: /6.1/

- үйл ажиллагааны ил тод байдал;
- хүний нөөцийн ил тод байдал;
- төсөв, санхүүгийн ил тод байдал;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал.

Энэхүү хуулиар улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүрэгтэй мөн иргэнийг хүлээн авч уулзах байр, хүсэлтийг хүлээн авах цагийн хуваарийг тогтоож нийтэд мэдээлнэ гэж заасан байдаг. /14.1, 14.2/ Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллага өөрт хадгалагдаж байгаа мэдээллийг хууль бусаар устгах, иргэдээс мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хориглоно. /14.3./ Мөн иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргаж болох бөгөөд цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргасан тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь цахим баримт бичиг үйлдэн, тоон гарын үсэг зурах бөгөөд түүнд өөрийн иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, холбогдох байгууллагад цахим шуудангаар ирүүлсэн байна. /15.1, 15.2/ Мэдээллийг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд өгөх тохиолдолд тухайн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурах бөгөөд хүсэлт гаргагчид мэдээллийг цахим шуудангаар хүргүүлнэ. /15.3./ Цахим хэлбэрээр мэдээлэл өгөхөд энэ хуулийн 11-14 дүгээр зүйлд заасан журмыг баримтална. /15.4./

Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд 8.2.7-д олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэнэ гэж заасан байна.

Дээрх хуулийн заалтууд нь Конвенцийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг хөнгөвчлөн дэмжих шаардлагад нийцэж байна гэж үзэж байна. Цахим хуудсандаа мэдээллүүдээ тавина гэдэг нь олон нийтийг байгууллагын мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх боломжийг хөнгөвчилсөн гэж үзэж болно. Энэ талаар өмнөх бүлэгт тодорхой дурдсаныг харна уу.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн 6.1-д заасан дөрвөн төрлийн мэдээллийн ил тод байдлыг байгууллага тухай бүрд нь цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулах үүрэгтэй. 2013 оны Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ хийх явцад дийлэнх байгууллагууд цахим хуудсаараа дээрх дөрвөн чиглэлээр мэдээллээ ил тод байдлаа тавигдаагүй байсан боловч энэ жилийн хувьд судалгаанд хамрагдсан бараг бүх байгууллага “ил тод байдал” гэсэн булан цахим хуудсандаа байрлуулсан байна.

Иргэддээ нээлттэй, тунгалаг төрийг цогцлоохын тулд хүнд суртлыг халж, хурдан шуурхай үйлчилгээг эрхэмлэж иргэдийн саналыг дараах 10 сувгаар хүлээн авч, түүнд тодорхой хариулт өгөхөөр Шинэчлэлийн Засгийн Газар “11 11 ТӨВ”-ийг 2012 онд байгуулсан байна. Бүрэн автоматжсан системийг ашигласнаар иргэдээс ирэх санал хүсэлт, шүүмжлэл, гомдол, талархал нэг бүрийг алдахгүй хүлээн авч холбогдох байгууллагад шилжүүлэн түүний хяналт, хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгдөг байна. Төрийн байгууллагуудад иргэдээс өгөх давхардсан санал хүсэлт, шүүмжлэл, гомдол, талархалыг “11 11 ТӨВ” дамжуулан өгснөөр уг давхардсан асуудлыг нэг асуудал болгон нэгтгэдэг давуу талтай. Тус төв дээр байрлах санал бичих машин (Киоск) ашиглан иргэд өөрийн санал хүсэлтээ хурдан шуурхай оруулах боломжтой. 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн мэдээллээс үзвэл Засгийн газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах “11 11” төвд тухайн 7 хоногт 900 гаруй санал хүсэлт, талархал, гомдол, шүүмжлэл ирсний ихэнхийг боловсрол, эрүүл мэндийн салбартай холбоотой асуудлууд эзэлж байна. Сурагчийн дүрэмт хувцас, зарим цэцэрлэг, сургууль анги засвар болон хуримтлалын мөнгө авч байгаа тухай орон сууцны хангамж гэх мэт төрөл бүрийн мэдээлэл ирдэг байна¹⁰⁶. **Энэхүү 11 11 төвөөр иргэдээс саналыг нь авсанаар Конвенцийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг хөнгөвчлөх алхам болсон гэж үзэж байна. Иймд “11 11 төв”-ийн мэдээлэл нь тухайн цаг үед иргэд юунд санаа зовж байгааг илтгэх барометр гэж үзэж болохоор байгаа тул АТГ-ын зүгээс уг төвийн мэдээлэлд тогтмол анхаарч байх нь авлигаас урьдчилан сэргийлэх**

¹⁰⁶ Эх сурвалжийг <http://11-11.mn/>

сигнал авах нэгэн гарц байх бүрэн магадлалтай байна. “Олны үг ортой” гэдэг үгийн учир үүнд орших биз.

Ерөнхий сайд Н.Алтанхуяг долоо хоног бүрийн пүрэв гарагт сэтгүүлчидтэй 30 минутын уулзалт хийж хэвшсэн. Ард түмний дуу хоолой болдог сэтгүүлчид иргэдийн санал хүсэлтийг дамжуулах асуулт тавих боломжтой байдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн санаачлагаар 2009 оны 12 дугаар сарын 15 нд “Иргэний танхим” байгуулагдан үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. “Иргэний танхим”-ын зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн төсөл, хөтөлбөрүүд нийгмийн тулгамдсан асуудлуудыг ард нийтээр хэлэлцүүлж иргэдийн санал бодол байр суурийг тусгах, төрийн бодлого боловсруулах, хууль тогтоох шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар нээлттэй, хяналттай, хариуцлагатай иргэний нийгмийг төлөвшүүлэхэд оршино. Иргэний танхим нь 2012 оны байдлаар нийт 78 хэлэлцүүлэг уулзалт, 3418 иргэнд, 2011 оны байдлаар 98 хэлэлцүүлэг уулзалт, 4781 иргэнд үйлчилжээ.¹⁰⁷

Нийслэлийн хувьд иргэдийн саналыг сонсох, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргах явдлыг хялбаршуулах үүднээс интернет болон мессежээр санал хураалт авсан нь иргэдээ сонсох харьцангуй зардал, цаг хэмнэсэн чухал арга хэмжээ юм. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Та Автомашины улсын дугаарын хязгаарлалтыг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна уу?” гэсэн албан ёсны санал асуулгыг Мобикомын санамсаргүй сонгогдсон 202 мянган хэрэглэгч рүү мессеж илгээх болон нийслэлийн Лавлагаа мэдээллийн төвийн 12 00 тусгай дугаарын утсаар хүлээн авсан.¹⁰⁸

Ховд аймгийн урдирдлагууд долоо хоног бүхийн лхагва гаригт “Төрийн мэдээллийн цаг” нэвтрүүлэгт тус аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн дарга нар мэдээлэл хийдэг болжээ. Мөн пүрэв гариг бүрт орон нутагт хийгдэж буй ажлын явцын талаар “Бүтээн байгуулалтын цаг-аар мэдээлж байна.¹⁰⁹

2014 оны 5-р сарын 28-ны өдрийн Нийслэлийн засаг дарга “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хэрэгжүүлэх тухай захирамж гаргасан байна. Энэхүү хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг авч үзвэл:

- Төрөөс иргэдэд үзүүлдэг үйлчилгээнүүдийг Цахим хэлбэрт шилжүүлэх
- Иргэдийн цахим нэг цонх бий болгох
- Ухаалаг төхөөрөмжид зориулсан аппликейшн гаргах
- Шилэн дансны тогтолцоо бий болгох
- Шилэн тендерийн тогтолцоо бий болгох
- Зөрчилтэй шийдвэрүүдийг ялгаж, хүчингүй болгох ажлыг зохион байгуулах

¹⁰⁷ Эх сурвалжийг <http://www.president.mn/mongolian/node/521>

¹⁰⁸ Эх сурвалжийг <http://www.ulaanbaatar.mn/content/show/6306>

¹⁰⁹ Эх сурвалжийг Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны 7 хоног тутмын мэдээллийн “Шинэчлэлийн цонх” сэтгүүлээс

- Зөрчилтэй шийдвэрүүдийг хүчингүй болгосон талаар иргэд, олон нийтэд тухай бүр мэдээлэх
- Төрийн үйлчилгээг хаанаас ч, хэзээ ч, юугаар ч авах боломж бүрдүүлэх
- Улаанбаатар хотыг бүхэлд нь утасгүй интернетжүүлэх
- Ухаалаг гар утас, төхөөрөмжүүдэд зориулагдсан аппликейшнүүд боловсруулах
- Зэрэг ажлуудыг хийнэ гэж төлөвлөсөн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.ulaanbaatar.mn/content/show/8240> энэхүү цахим хуудаснаас авах боломжтой.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлэх газрын байршлыг цахим хуудсандаа байршуулсан нь иргэдэд чөлөөтэй, хүндрэлгүй харах боломжийг бүрдүүлсэн байна.

2014 оны 2-р сарын 14-ний 36 дугаар тогтоолын хавсралтаар “Засгийн газраас зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөрийн хүрээнд баригдсан “Буянт-Ухаа 1” хорооллын орон сууцанд иргэдээс захиалга журам” баталсан байна. Энэхүү журмаар зорилтот бүлгийн иргэдийг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогын хүрээнд “Төрийн орон сууцны корпораци” (цаашид ТОСК гэх) ТӨҮГ-ын захиалгаар барьж ашиглалтад оруулсан “Буянт-Ухаа 1” хорооллын орон сууцанд төрийн албан хаагчид болон зорилтот бүлгийн иргэдээс захиалга авах, худалдан борлуулахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршиж байгаа юм.

- Төрийн албан хаагч, зорилтот бүлгийн иргэдээс захиалга авах, гэрээ байгуулах ажиллагааг дараах зарчмаар явуулсан байна: /5.1./
 - Төрийн албан хаагч, зорилтот бүлгийн иргэдэд хуваарилагдсан орон сууцны талбайн хэмжээ, тоо ширхэгийг ТОСК өөрийн цахим хуудсаар зарлана.
 - ТОСК-аас орон сууцны захиалгын хүсэлтийг цахимаар хүлээн авах хугацааг тодорхой өдөр, цаг, минутаар хязгаарлах бөгөөд энэ хугацаанд 5.1.3-т заасан захиалгын хүсэлтийг төрийн үйлчилгээний цахим машинд бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан иргэдийн дунд захиалгын гэрээ байгуулах сонголтыг хийнэ;
 - Энэхүү журмын шалгуурыг хангасан, байр худалдан авах сонирхолтой иргэн төрийн үйлчилгээний цахим машинд захиалгын хүсэлтийн маягт бөглөж, бүртгэлийн дугаар бүхий өргөдлийн маягтыг хэвлэн авна;
 - Энэхүү журмын 5.1.2-т заасан хугацаанд төрийн үйлчилгээний цахим машинд захиалгын хүсэлтийн маягт бөглөж, бүртгэлийн дугаар авсан иргэдийн тоо нь тухайн бүлэгт хуваарилах орон сууцны тооны хязгаараас хэтэрсэн тохиолдолд тооны хязгаарт багтаан орон сууц худалдан авах иргэдийн нэрсийг сугалаагаар тодруулна.
- Сугалаа явуулах журмыг ТОСК баталж, өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ. 5.2.

- Гэрээ байгуулах эрх авсан этгээд нь энэхүү журмын 4 дүгээр бүлэгт заасан нийтлэг шаардлагыг хангаж байгаа эсэхийг ТОСК хянан үзэж, шаардлага хангасан этгээдтэй орон сууцны захиалгын гэрээ байгуулна. /5.3./
- Захиалгын гэрээ байгуулж, урьчилгаа төлбөрөө төлсөн иргэд үлдэгдэл төлбөрөө банкны зээлээр төлөх асуудлаар банк болон банк бус санхүүгийн байгууллагад хандана. /5.4./

Хэдийгээр зарим нэг хэл ам дагуулсан ч гэлээ дээрх зарчмаар орон сууцны захиалгыг цахим хэлбэрээр авсан нь төрийн байгууллагын хүнд суртлаас сэргийлсэн, иргэд орон сууц захиалах боломжийг хөнгөвчилсөн маш үр дүнтэй арга хэмжээ болсон.

Дээрх практик хэрэгжилтүүд нь Конвенцийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг хөнгөвчлөн дэмжих шаардлагад нийцэж байна гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн байгууллагын цахим хуудсандаа хуулиар тавихыг шаардсан мэдээллийг хуулийн хугацаанд, бүрэн тавьж хэвшихийн зэрэгцээ утас, интернетээр мэдээлэл авах бүх боломжийг дайчлах;
- Нэг цэгийн үйлчилгээ, цахим ТҮЦ гэх мэт санаачлагыг өргөжүүлэх
- Нийслэлийн “ухаалаг Улаанбаатар” санаачлагын явцыг үнэлж бусад аймаг, сум, дүүргийг түгээн дэлгэрүүлэх.

6.1. (с) төрийн захиргаанд нь авлига гарах эрсдлийн талаарх тогтмол илтгэлийг багтааж болох мэдээллийг хэвлэн нийтлэх; /Конвенцийн 10.1.c/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуулийн 18.1.3-д авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх, 18.1.5-д Авлигатай тэмцэх газар авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, 18.1.6-д авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх, 18.1.7-д төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх, 18.2.1-д хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах зэрэг бүрэн эрхтэй болохыг заажээ.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигын эсрэг хуульд Авлигатай тэмцэх газар болон төрийн байгууллагууд судалгааны дүнг үндэслэн авлига гарах эрсдлийг бууруулах тодорхой арга арга хэмжээг зорилтот бүлэгт чиглүүлэн авдаг байх үүргийг нэмж тусгах

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Авлигын эсрэг хуульд зааснаар Авлигатай тэмцэх газар нь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх хүлээсэн үүргийн дагуу анхны судалгааг 2009 онд хийснээс хойш одоогоор 3 удаагийн судалгааны тайлан гаргасан байна. Энэхүү судалгааг дүгнэлтийн 1.3 дахь хэсгийн Практик хэрэгжилтээс харна уу.

Авлигатай тэмцэх газрын сүүлийн гурван жилд дараах нийтлэл, мэдээллүүдийг хэвлэн нийтэлсэн байна:

2011 онд

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад шударга ёс, ил тод байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийн нэгжтэй хамтран өдөр тутмын сонинд тогтмол булан ажиллуулах ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулалт явуулж, “Өнөөдөр” сониныг шалгаруулан хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд “Өнөөдөр” сонинд 10 хоног тутамд “Далайд дусал нэмэр” булан нээж, 4 өгүүлэл нийтлүүлсэн.

Жил жилийн үйл ажиллагааны тайланг хэвлүүлэн, олон нийтийн хүртээл болгох нь Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, авлигатай тэмцэх ажлын талаар бодитой, үнэн зөв ойлголтыг иргэдэд хүргэх, байгууллагын тухай эерэг ойлголтыг нийгэмд бий болгох ач холбогдолтой гэж үзсэн уг ажлыг уламжлал болгон зохион байгуулдаг байна. Авлигатай тэмцэх газар тайлан-мэдээллийн эхийг бэлтгэхийн зэрэгцээ хэвлэлийн компаниудаас сонгон шалгаруулалт хийж, холбогдох гэрээг байгуулж мэдээллээ нийтэд хүргэдэг байна. “Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл-2010” номыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн нэгжийн санхүүжилтээр 1000 ширхэг хэвлүүлэв. /Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2011 онд хийсэн ажлын тайлангаас/

2012 онд

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг нийт төрийн албан хаагчдад таниулан сурталчлах арга хэмжээний хүрээнд “Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхтгэл”-ийг нэгтгэн хянаж, хэвлүүлсэн байна. Түүнчлэн хуулийг таниулах чиглэлээр “Ашиг сонирхлын зөрчлийн хууль ба 100 асуулт, хариулт” бяцхан ном, албан тушаалтанд тавигдах 12 төрлийн хориглолт, хязгаарлалт тус бүрийг танилцуулсан “Нийтийн албан тушаалтан Танд үүнийг хориглоно” хэмээх товхимлыг боловсруулан, эхийг бэлтгэж, тус бүр 25000 ширхэгийг хэвлүүлэн нийтийн албан тушаалтны гарын авлага болгон түгээсэн байна. /Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2012 онд хийсэн ажлын тайлан/

2013 онд

Шударга ёсыг бага наснаас нь төлөвшүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд гол зорилтот бүлгийнхээ нэгийг бага болон өсвөр насны хүүхдүүд гэж тодорхойлон эхний хагас жилд эдгээр насны бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн ажлуудыг хийж эхлүүлжээ. Хүүхэд багачуудад шударга ёсны зан үйл төлөвшүүлэх зорилгоор АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хэвлүүлсэн “Шударга мазаалайнууд”, “Найзын яриа” номд дурдсан утга санаа, агуулгыг түгээн дэлгэрүүлэхээр “Зуны даалгавар” арга хэмжээг зохион байгуулсан байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх, чиг үүргийн талаар тодорхой ойлголт өгөх зорилгоор “Монгол Улсын Их Хурлын гишүүн Танаа” гарын авлагыг боловсруулж, “Засаглал, ил тод байдлыг дэмжих төсөл”-ийн дэмжлэгтэйгээр хэвлүүлжээ.

Дизайн сонирхогч залууст зориулж “Авлигаас ангид нийгэм” зурагт хуудасны уралдааныг 2013 оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 07-ний өдрийг хүртэл зохион байгуулж тус уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг Хамтдаа.мн фэйсбүүк хуудсанд тавьж олны хүртээл болгосон. Цаашид зурагт хуудас болгон хэвлүүлж төрийн байгууллагуудаар тараах юм байна.

Дээрх тэмцээнүүдийн зарлалын постерийн эх бэлтгэлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, постер хэвлүүж, МУИС-ийн салбар сургуулиуд, Отгонтэнгэр их сургууль, Шихихутуг, ШУТИС, Удирдлагын академи, Монгол дээд сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Соёмбо дээд сургууль зэрэг төрийн болон хувийн өмчийн 20 гаруй их дээд сургуулиудад зарлал тараажээ.¹¹⁰

Авлигатай тэмцэх газраас хуульд заасан судалгааг тогтмолжуулан олон нийтийн мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн энэхүү ажлын хүрээнд олон нийтлэлүүдийг хэвлүүлсэн байдаг. Цахим ертөнц хөгжсөнтэй холбогдуулан тус байгууллага судалгаа, илтгэлүүдээ цахим ертөнц, зурагт, радио олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэж байна. Гэвч судалгааны дүгнэлт дээр суурилсан дараагийн алхамыг тодорхойлж авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, зорилтот бүлэг /эрсдэл бүхий төрийн байгууллага, салбар/-т чиглэсэн үр дүнтэй ажил үгүйлэгдэж байна.

Судалгаа явуулах хөндлөнгийн байгууллагыг яадавхижуулах, өрсөлдөөн бий болгох нь зүйтэй байна. Судалгааны агуулга тогтмол байх нь харьцуулалт хийх, өөрчлөлтийг орхигдуулах эрсдэлтэй байна.

¹¹⁰ Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2013 оны тайлангаас

ЗӨВЛӨМЖ:

- Судалгааны дүнгээр Авлигатай тэмцэх газар, төрийн холбогдох байгууллага тодорхой арга хэмжээ авч байх нь зүйтэй. Газрын алба, уул уурхайн салбар нь хамгийн их авлигад өртсөн гэсэн дүгнэлт удаа дараагийн судалгаагаар нотлогдсон байтал уг салбарт чиглэсэн авлигаас урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээг Авлигатай тэмцэх газар, Газрын алба, Нийслэлийн засаг дарга, Уул уурхайн яам авсан бэ гэдэг талаар бидэнд мэдээлэл олдоогүй.
- Түүнчлэн Авлигатай тэмцэх газрын зүгээс авлига гарах эрсдлийг хожим нь тодорхойлж, дүгнэх биш, урьдчилан тооцож, угтуулсан арга хэмжээ авч байх шаардлагатай. Жишээ нь, тухайн аль нэг яам өндөр үнийн дүнтэй, хэд хэдэн тендер зарлах гэж байгаа бол яамны холбогдох /авлигад өртөж болзошгүй/ албан тушаалтан, Худалдан авах ажиллагааны газар, үнэлгээний хорооны хүмүүстэй уулзалт, ярилцлага хийх \мэдээж дотоод ажилд нь оролцохгүй\, хуулийн холбогдох заалтыг сануулсан захидал илгээх гэх мэт арга хэмжээ авах нь авлигаас урьдчилан сэргийлэх хүчтэй хэрэгсэл болно гэж үзэж байна
- Тодорхой төрийн байгууллага том хэмжээний худалдан авалт хийж байгаа, олон тооны ажилтан шалгаруулж авч байгаа зэрэг ажлыг зохион байгуулах явцад тухай бүр нь Авлигатай тэмцэх газар зохих мэдээлэлтэй байж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд, шаардлагатай тохиолдолд зохих хяналт явуулж байгаа талаар олон нийтэд мэдээлдэг байж болохоор байна.
- Дээрх зорилгоор томоохон худалдан авалт хийж байгаа төрийн байгууллага, Төрийн албаны зөвлөл зэрэг холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох, байнгын ажиглалт хийх ажилтан томилох, аргачлал гарган ашиглах зэрэг арга хэмжээ авч болох юм.
- Олон нийтийн дунд АТГ-ын чиг үүргийг ойлгосон, хүндэтгэсэн хандлага дээшилж байгааг судалгаа нотолж байна. Дээр дурдсан зөвлөмжүүд нь тус газрын энэхүү зэрэг нэр төрд үндэслэж байгаа бөгөөд жорыг нь хэтрүүлж болохгүй гэдгийг хатуу санах нь зүйтэй. АТГ-ын ажилтны ялимгүй ч гэлээ хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, ёс зүйгүй үг, үйлдэл бүр тус байгууллагыг хүндэтгэх хандлагыг “үл итгэх, эсхүл айдас”-ын хандлага болгон эргүүлэх аюултайг онцлон тэмдэглэж байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ШҮҮХ, ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГАД ХАМААРАХ АРГА ХЭМЖЭЭ

/11 дүгээр зүйл/

7.1. Оролцогч улс бүр шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэлд шүүхийн шийдвэрлэх үүрэгтэйг харгалзан шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын үнэнч шударга байдлыг бэхжүүлэх,

тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр авна. Эдгээр арга хэмжээнд шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын ёс зүйн дүрэм багтаж болно. /Конвенцийн 11.1/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Шүүхийн бие даасан байдал

Үндсэн хууль /1992 он/-ийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.” гэж шүүхийн эдийн засгийн баталгааг Үндсэн хуулийн хэмжээнд баталгаажуулсан байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга **2012 онд** батлагдсан. Уг хуулийн “Шүүхийн бие даасан байдал” гэсэн 6 дугаар зүйлд Шүүх бие даасан төсөвтэй байх, шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангахаар зааж, улмаар тус хуулийн 28 дугаар зүйлд шүүхийн төсөв улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх, шүүхийн төсвийг шууд УИХ-д мэдүүлэх, шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглох тухай нарийвчилсан зохицуулалтыг оруулсан байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дээрх 6 дугаар зүйлд шүүхийн бие даасан байдалтай холбоотой бусад дараах зохицуулалт тусгагдсан:

1. Шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас бие даасан байх бөгөөд шүүх эрх мэдлийг аливаа байгууллага, этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ.
 2. Шүүхийн бие даасан байдлын зарчмыг алдагдуулсан, дордуулсан хууль тогтоомж болон захиргааны акт гаргахыг хориглоно.
 3. Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, энэхүү ажиллагаатай холбоотой заавар өгөх, удирдамжаар хангах, шүүгчид тодорхой хэрэг, маргааныг нэр заан хуваарилах зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглоно.
 4. Шүүх өөрийн захиргаатай байх ба түүний чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тамгын газар хэрэгжүүлэх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.
 5. Шүүх нь шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий шүүхийн ажилтантай байх бөгөөд шүүхийн ажилтны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.
 6. Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо хүрэлцэхүйц хэмжээнд байна.”
- “Шүүхийн бие даасан байдлыг хангах улс төр, хууль зүй, эдийн засгийн болон бусад баталгаа, нөхцөлийг төрөөс хангана.” хэмээн Шүүхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 д заасан бөгөөд Шүүхийн улс төр, хууль зүйн баталгаа /27 дугаар зүйл/, Шүүхийн эдийн засгийн баталгаа /28 дугаар зүйл/, Шүүхийн зохион байгуулалтын баталгаа /29 дүгээр зүйл/, Шүүхийн аюулгүй байдлын баталгаа /30 дугаар зүйл/-г хуульчилан тогтоосон байна.

Шүүхийн улс төр, хууль зүйн баталгаа /27-р зүйл/

- Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно.
- Шүүгч, шүүх бүрэлдэхүүний хэрэг, маргаан шийдвэрлэхдээ гаргасан алдааны улмаас бусдад учирсан хохирлыг төр хариуцаж, улсын төсвөөс нөхөн төлнө.
- Шүүхийг үл хүндэтгэсэн, шүүн таслах ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэсэн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, зөрчигдсэн эрх, нэр төрийг нь Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу сэргээнэ.
- Шүүгч болон шүүхээс шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэгтэй шүүхийн ажилтан нь улс төрийн нам, хөдөлгөөний гишүүн байхыг хориглоно.

Шүүхийн эдийн засгийн баталгаа /28-р зүйл/

- Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна.
- Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд Монгол Улсын шүүхийн төсөв нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.
- Шүүхийн төсөв Улсын дээд шүүхийн, аймаг, нийслэлийн шүүхийн, дагнасан шүүхийн болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвөөс тус тус бүрдэнэ.
- Шүүхийн ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлнэ.
- Шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.
- Шүүх нь гадаад, дотоодын хувь хүн, хуулийн этгээдээс аливаа хэлбэрээр хандив, санхүүгийн туслалцаа авахыг хориглох бөгөөд үүнд Монгол Улсын олон улсын гэрээгээр нийлүүлэх эд хөрөнгө, зээл, тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөр хамаарахгүй.

Шүүхийн зохион байгуулалтын баталгаа /29-р зүйл/

- Шүүх өөрийн байртай байна.
- Нүүдэллэн ажиллаж байгаагаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг зөвхөн шүүх хуралдааны танхимд хийнэ.
- Шүүх, шүүгч нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулахад шаардагдах байнгын болон нүүдэллэн ажиллах байр, иргэдийг хүлээн авах болон шүүх хуралдааны танхим, тээвэр, холбоо, мэдээллийн болон тусгай зориулалтын техник хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж, хамгаалалтаар хангагдсан байх бөгөөд тэдгээрийн стандарт, нөхцөлийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.
- Шүүхийн байранд шүүн таслах ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Шүүхийн аюулгүй байдлын баталгаа /30-р зүйл/

Шүүхийн байр төрийн хамгаалалтад байна. /30.1/ “Шүүх хуралдааны журам сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудснаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үүргийг тахарын алба гүйцэтгэнэ” гэж заасны дагуу Тахарын албаны тухай болон Гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулиудыг өнгөрсөн онд баталж энэ оноос дагаж мөдрөж байгаа нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах шинэлэг зохицуулалт болсон юм.

Шүүгчийн хараат бус байдал

Үндсэн хууль /1992 он/-ны тавин нэгдүгээр зүйлд бүх шатны шүүгчийг томилох журам, шүүгчид тавих шалгуурыг дор дурдсанаар тогтоосон болно:

1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.

2. Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.

3. Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.

Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй тухай, Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллахыг Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлд хуульчилсан байна.

Улсын их хурал 2012 оны 3 сарын 7-нд анх удаа **Шүүгчийн эрх зүйн байдлын тухай бие даасан хууль** баталсан нь шүүгчийн хараат бус байдлыг хангах төр засгийн хүсэл эрмэлзлэлийн нэгэн баталгаа болж, тэднийг авлигаас урьдчилан сэргийлэх чухал алхам болсон. Уг хуулиар Шүүгчийн хараат бус байх зарчим, баталгаа \20 дугаар зүйл\ -г тогтоосон байна:

- Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана.
- Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулна.

- Энэ хууль болон бусад хуулиар тогтоосон шүүгчийн эрх зүй, эдийн засаг, нийгмийн хамгаалалт зэрэг хараат бус, халдашгүй байдлын баталгааг ямар нэг хэлбэрээр дордуулсан хууль тогтоомж, захиргааны акт гаргахыг хориглоно хэмээн хуульчилжээ.

Шүүгчийн хараат бус байдлыг дараах баталгаагаар хангахаар мөн дээр дурьдсан зүйлд заасан байна:

- Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгайлан зааснаас өөр үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлахыг хориглох;
- шүүгчийн бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас өөр үндэслэл, журмаар түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглох;
- өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэхийг хориглох;
- хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хугацаагүй томилогдож, хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны болон гурав дахь этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй, огцрохгүй байх;
- хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд аливаа дайчилгаа болон цэргийн жинхэнэ албанд татахгүй байх;
- шүүгчийн эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн эдийн засгийн болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцоог энэ хууль болон бусад хуулиар бүрдүүлж, хангана.
- Улсын дээд шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч нь гадаадад байх, зорчих хугацаанд дипломат эрх ямба эдэлнэ.
- Шүүгчийн хараат бус байдалд хуульд зааснаас бусад үндэслэл, журмаар халдсан, үл хүндэтгэсэн хэн боловч хууль зүйн хариуцлага хүлээнэ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох /21-р зүйл/, Шүүгчийн эдийн засгийн баталгаа /23-р зүйл/, Шүүгчид хориглох зүйл /27-р зүйл/, Шүүгчийн иргэний эрхэд тавих хязгаарлалт /28-р зүйл/, Шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт /29-р зүйл/, Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг /30-р зүйл/-тэй холбоотой дор дурдсан тодорхой зохицуулалтыг хуульчилжээ:

Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох /21-р зүйл/:

- Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус, бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.
- Дээрх хориглосон заалтыг зөрчсөн этгээдэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүсэлтийг үндэслэн эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмын дагуу харьяалах шүүх дараах хариуцлага хүлээлгэнэ: /38.1./
- Иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;

- Төрийн байгууллагын албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалаас нь чөлөөлөх буюу огцруулах арга хэмжээ авах;
- Улс төрийн нам, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээдийн удирдлага, эрх баригч болон тухайн хууль бус нөлөөлөх, халдах үйл ажиллагааг төлөвлөсөн, зохион байгуулсан, үйлдсэн, оролцсон, мэдсэн боловч таслан зогсоох арга хэмжээ аваагүй аливаа ажилтан, этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл уг байгууллагыг албадан татан буулгах буюу татан буулгахгүйгээр гэм буруутай этгээдийг 30 хүртэл хоногоор баривчлах.
- Шүүгчээс хянан шийдвэрлэж байгаа болон хянан шийдвэрлэсэн хэргийнх нь талаар өөрийг нь холбогдуулан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан тайлбар, мэдүүлэг авахаар шаардахыг хориглоно.
- Шүүгч нь хэргийн оролцогчоос бусад этгээдэд хэргийн материалыг танилцуулах үүрэг хүлээхгүй.

Шүүгчийн эдийн засгийн баталгаа /23-р зүйл/

- Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна.
- Тухайн шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэж байна.
- Шүүгч нь ажлын ачаалал, бүтээмж, шийдвэрийн чанар зэрэгтэй уялдсан нэмэгдэл авах бөгөөд уг нэмэгдэл нь энэ хуулийн мэргэшлийн үнэлгээний үр дүнгээс хамаарах ба нэмэгдлийн хэмжээ үндсэн цалингийн 50 хувь хүртэл байна.
- Дээр дурьдсан нэмэгдэл олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулж Улсын Их Хурал батална.
- Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй.
- Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.
- Шүүгч ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл төрсөн нутагтаа амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардлыг шүүхийн төсвөөс авто замын зорчигч тээврийн зардлаар тооцож олгоно.

Шүүгчид хориглох зүйл /27-р зүйл/

- Шүүгчид Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд[3] заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтаас гадна дараах зүйлийг хориглоно:
 - Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглах;

- албан ажлын хэрэгцээнд зориулсан материал, техник, санхүү, мэдээллийн хэрэгслийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар ашиглах;
- шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хуульд зааснаас бусад хэлбэрээр оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх;
- шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон бусад иргэн, хуулийн этгээдээс шууд ба шууд бусаар тусламж авах, үйлчлүүлэх, ямар нэгэн давуу байдал, хөнгөлөлт, мөнгөн болон бусад урамшуулал, хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авах;
- өөрийн болон гэр бүлийнх нь, түүнчлэн албан байгууллагынх нь эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байх;
- шүүгч нь Ерөнхий шүүгч, шүүгчтэй гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн холбоотой бол тухайн шүүхэд ажиллах;
- өөрөө, эсхүл итгэмжлэгдсэн этгээдээр дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, тэдгээрийн холбоо, нэгдлийн удирдах бүрэлдэхүүнд зохион байгуулалт, эрх зүйн аливаа хэлбэрээр түр болон байнга оролцох;
- Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр багшлах, эрдэм шинжилгээний болон бусад ажил эрхлэх;
- шинжлэх ухаанаас бусад гадаад улсын засаг төр, олон нийтийн болон бусад байгууллагын хүндэт, тусгай цол, шагнал, одон, тэмдэг авах;
- Монгол Улсын олон улсын гэрээгээр болон гадаад улсын шүүх, олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцан тохиролцсоноос өөр гадаад улс, олон улсын болон гадаадын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр гадаад улсад зорчих;
- Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаад улсын холбогдох шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад Монголын Улсын нутаг дэвсгэрт оршин байгаа гадаад улсын болон олон улсын байгууллага, түүний салбар нэгжийн удирдах бүрэлдэхүүнд орох;
- шүүгч багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;
- шүүгч улс төрийн аливаа байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага, сонгуульд нэр дэвшигчийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийнх нь сурталчилгаанд оролцох, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт олж өгөх, хандив өгөх;

- хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах;
- шүүгч нь хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоох;
- Баяр ёслолын арга хэмжээ, албан томилолтын болон албан ёсны бусад арга хэмжээтэй холбогдуулан бусдаас шүүгчид өгсөн бэлэг, дурсгалын зүйлийг төрийн өмчид тооцох бөгөөд хуулиар тогтоосон журмаар өөрөө худалдан авах саналаа гаргаагүй бол шүүгч тэдгээрийг өөрийн ажиллаж байгаа шүүхэд акт, баримттайгаар хүлээлгэн өгнө.

Шүүгчийн иргэний эрхэд тавих хязгаарлалт /28-р зүйл/

- Шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус, халдашгүй байдлын үндсэн зарчмаас хамааран шүүгчийн хувийн буюу иргэний эрхэд дараах хязгаарлалт тогтооно:
 - улс төрийн намд харьяалагдах;
 - улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллага болон иргэдэд улс төр, шашны асуудлаар байр сууриа илэрхийлэх;
 - хөдөлмөрийн маргаанаа зохицуулах зорилгоор албан үүргээ орхих буюу зогсоох.

Шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт /29-р зүйл/

- Шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол оролцохоос татгалзах, эсхүл уг болзошгүй нөхцөл байдал үүсч болохыг шүүх ажиллагаанд оролцогчдод мэдэгдэж, тэдгээрийн татгалзан гаргах санал тавих боломжийг хангах үүрэгтэй.
- Шүүгчид шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсны дараа хоёр жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг /30-р зүйл/

- Шүүгч нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

Шүүхийн захиргааны тухай хууль 2012 онд шинээр батлагдсан нь шүүхийн Ерөнхий зөвлөл, бүх шатны шүүхийн тамгын газрын хараат бус байдлыг хангах чухал ач холбогдолтой болсон.

Ерөнхий зөвлөлийн чиг үүрэг /5-р зүйл/

- Ерөнхий зөвлөл нь энэ хуулийн 3.2-т зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах;
 - шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах;
 - шүүгчийг хуульчдаас шилж олох;
 - шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
 - шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх.

- Ерөнхий зөвлөл нь анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд ажлаа тайлагнана.
- Ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. /6.1/
 - Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлэх;
 - шүүхийн эдийн засаг, санхүү, хөдөлмөр, ажлын нөхцөлийн болон бусад баталгааг хангах ажлыг зохион байгуулах, шаардлагатай бол эдийн засаг, нийгмийн хамгааллын болон материал, техник хангамж зэрэг асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;
 - шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, эрх зүйн бусад актын төсөл боловсруулах, санал өгөх, хууль санаачлагчид уламжлах;
 - Улсын дээд шүүхээс бусад шүүхийн байршлыг тогтоох, шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг боловсруулан Засгийн газартай зөвшилцөн Монгол Улсын Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/-д уламжлах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;
 - шүүхийн зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох асуудлыг судалж, санал, шийдвэрийн төсөл боловсруулан холбогдох байгууллагад уламжлах;
 - Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу холбогдох ажиллагааг явуулах;
 - шүүхийн байрны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журам баталж мөрдүүлэх;
 - шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах;
- **Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчим /4.1./**
Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:
 - бие даасан, хараат бус байх;
 - шүүн таслах ажиллагаанд оролцох, нөлөөлөхийг хориглох;
- **Шүүхийн захиргааны ажилтны ёс зүй /29.1./**
Шүүхийн захиргааны ажилтан нь төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг дүрэм, хэм хэмжээг мөрдөхөөс гадна ёс зүйн дараах ерөнхий шаардлагыг биелүүлж ажиллана:
 - шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны талаар тухайн хэргийн оролцогч, сонирхогч этгээдэд аливаа зөвлөгөө, мэдээлэл өгөхгүй, аливаа хэлбэрээр бусдад зуучлахгүй байх
 - шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар хувийн таамаглал, урьдчилсан дүгнэлтээ бусдад илэрхийлэхгүй байх;
 - хэргийн оролцогчтой хувийн харилцаа тогтоохгүй байх;
 - ажлын бус цагаар шүүхийн нэр хүндэд харшлах аливаа зохисгүй байдлыг гаргахгүй байх;
 - шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа байгууллагад ажиллаж байгаадаа хүндэтгэлтэй хандаж, ажлын байр, олон нийтийн дунд биеэ зөв авч явах.

Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014 оны 1/08 –р тогтоолын хавсралтаар Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм батлагдсан.

- **Шүүгчийн баримтлах зарчим /1.3./**

Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, хараат бус байх, үүрэг ажилдаа хариуцлагатай хандах, нууцыг задруулахгүй байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ.

- **Бие даасан, хараат бус байдлыг хадгалах /3.1./**

- Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж, түүний эрхлэх бусад үйл ажиллагаа, хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ.
- Шүүгч хэргийн оролцогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй хувийн харилцаа тогтоох, шууд болон шууд бусаар тусламж авах, хувьдаа ашиг олох, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгөөр үйлчлүүлэх зэрэг хууль бус хангамж эдлэх зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгохыг хориглоно.
- Шүүгч нь бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
- Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх явцад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг оролдсон аливаа этгээдийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүрэгтэй.
- Шүүгч нь хэргийг хараат бусаар хянан шийдвэрлэх үүргээ зөрчихгүйгээр бусадтай хууль хэрэглээний талаар санал солилцож болно.

- **Хэргийн оролцогчтой харилцах /3.2./**

- Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна.
- Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдад хүнлэг бус хандах, хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан шинжтэй үйлдлийг гаргаж болохгүй.
- Шүүгч нь хэргийн оролцогчдод хэрэг, маргаанаа эвлэрэн шийдвэрлэх талаар зөвлөн дэмжих эрхтэй боловч өөрт болон хамаарал бүхий этгээддээ ашигтай шийдвэр гаргуулах хүсэлт тавих зэргээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.
- Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана.

- **Ашиг сонирхол, хөрөнгө, орлогоо мэдүүлэх /4.1./**

Шүүгч нь өөрийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдүүлнэ.

- **Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаа /4.2./**
 - Шүүгч хууль эсхүл энэ дүрэмд хориглосноос бусад тохиолдолд шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаанд оролцож болно.
 - Шүүгч шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг даалгавар өгөхийг хориглоно.
 - Шүүгч нь шүүгчийн албан үүргээс бусад дараах агуулга бүхий үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:
 - Арилжааны аливаа хэлбэрийн зар сурталчилгаанд оролцох;
 - Хуулиар зөвшөөрснөөс бусад ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах;
 - Шүүгч нь өөрийн хамаарал бүхий этгээддээ хууль зүйн зөвлөгөө өгөх, баримт бичиг боловсруулах, хянах ажиллагаа явуулж болох боловч тэдгээрийн хуульчаар ажиллаж болохгүй.
 - Шүүгч өөрийн болон гэр бүлийн гишүүн, албан байгууллагынх нь эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байхыг хориглоно.
- **Бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл хүлээн авах /4.5./**
 - Шүүгч албан үүргээ биелүүлсэн болон биелүүлээгүйн төлөө өөрөө эсхүл өөрийн хамаарал бүхий этгээдээр дамжуулан бусдаас төлбөр, бэлэг, зээл, өв хөрөнгө, хандив, үйлчилгээ, урамшуулал бусад үнэ бүхий зүйл авахыг хориглоно.
 - Баяр ёслолын арга хэмжээ, албан томилолтын болон албан ёсны бусад арга хэмжээнд бусдаас өгсөн шагнал, урамшуулал, бэлэг, дурсгалын зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу өөрөө худалдан авах санал гаргах бөгөөд санал гаргаагүй тохиолдолд өөрийн ажиллаж байгаа шүүхэд холбогдох баримтаар хүлээлгэн өгнө.
 - Шүүгч өөрийн шүүгчийн нэр хүндийг ашиглан боловсрол, шашин, хандив, олон нийтийн байгууллагын ажиллагаанд зориулан зээл авах, хандив тусламж авахад биечлэн оролцохыг хориглоно.
- **Шүүгчийн улс төрийн үйл ажиллагаа /4.9./**

Шүүгч улс төрийн дараах үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:

 - Улс төрийн байгууллагад манлайлах үүрэг гүйцэтгэх, гишүүн байх, эсхүл албан тушаал хаших;
 - Улс төрийн байгууллага болон нийтийн албан тушаалд нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд оролцох, хандив өгөх, энэ талаар уриалах;
 - Улс төрийн байгууллага болон нийтийн албанд нэр дэвшигчийн санхүүжүүлсэн, зохион байгуулсан, санаачилсан арга хэмжээнд дэмжиж оролцох, тэдний өмнөөс илтгэл тавих, үг хэлэх;
 - Нийтийн албан тушаалд нэр дэвшигчийг олон нийтийн өмнө дэмжих, эсхүл эсэргүүцэх
 - Улс төрийн байгууллагаас дэмжлэг, хандив хүсэх, хүлээн авах, ашиглах;

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2009 оны 31 дүгээр захирамжийн хавсралт Шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм

- **Гурав. Шүүхийн ажилтны ёс зүйн ерөнхий шаардлага /3.1./**
 - Шүүхийн байгууллагад ажиллаж байгаа хэн нэгний хувийн болон гэр бүлийн байдал, ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингийн талаар аливаа мэдээллийг бусдад тараахгүй байх;
 - Хэргийн оролцогчидтой хувийн харьцаанд орохгүй байх;
- **Шүүхийн ажилтны мэргэжлийн ёс зүйн шаардлага /4.1./**
 - Шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны талаар тухайн хэргийн оролцогч, сонирхогч этгээдэд мэргэжлийн зөвлөгөө өгөхгүй, аливаа хэлбэрээр бусдад зуучлахгүй байх;
 - Шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нь хэргийн нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч зэрэг хэргийн оролцогчидтой төрөл садан, найз нөхдийн болон ойр дотны харилцаатай бол сонирхолын зөрчилтэй гэдгээ шүүгч, тамгын газар, хэлтэс, албаны даргад бичгээр мэдэгдэж, тухайн хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүх хуралдаанд оролцохоос татгалзах;
 - Эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар хувийн таамаглал, урьдчилсан дүгнэлтээ бусдад илэрхийлэхгүй байх;
 - Удирдах албан тушаалтан, Ерөнхий шүүгч, шүүгчийн хууль бус аливаа шаардлага, хүсэлтээс татгалзах, энэ талаар холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдэгдэх;
- **Ёс зүйн бусад шаардлага**
 - Хөрөнгө орлогын мэдүүлгээ зохих журмын дагуу хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж өгөх

Мэдээллийн технологий дээр суурилсан санамсаргүй байдлаар хэрэг, маргааныг шүүгчид хуваарилах зарчмыг шүүхийн практикт нэвтрүүлэх техник, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь шүүгчийн хараат бус байдлыг хангах чухан алхам болж хэвшсэн.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг анх удаа 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан нь хүний эрхийг хангах, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэх бодитой алхам болсон бөгөөд тус хууль нь иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх болон уул захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад гол зорилго нь оршидог. Улмаар “Шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуульд аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх, түүний бүрэн эрх, ерөнхий шүүгчийн бүрэн эрх, дагнасан шүүхийн үйл ажиллагааг зохицуулсан бусад асуудлыг нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан нь Монгол улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдан ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна. /Эх сурвалж

http://www.admincourt.gov.mn/main/index.php?option=com_content&view=article&id=1&Itemid=2 /

2013 оны 1-р сарын 24-ний өдөр Шүүх байгуулах тухай хууль батлагдаж 2013 оны 4-р сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Энэхүү хуулиар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяаллаар Захиргааны хэргийн анхан шатны 1-20 шүүх болон Монгол Улсын засаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийн харьяаллаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг байгуулсан байна.

Монгол Улс шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэлд шүүхийн шийдвэрлэх үүрэгтэйг харгалзан шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын үнэнч шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр авах хууль зүйн орчин бүрдсэн байна. Эдгээр арга хэмжээнд шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын ёс зүйн дүрэм багтаж байгаа бөгөөд ёс зүйн дүрмээ Шүүгчийн болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу шинэчлэн батлаад байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн албаны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Прокурорын байгууллагын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Нийтийн албанд нийтийн ба хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тухай, Авилгын эсрэг зэрэг холбогдох хуулиудад төрийн албан хаагчийн үүрэг, түүнд хориглох, хязгаарлах зүйл, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулж буй талаар, мөн Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай зэрэг хуулиудад тусгагдсан мэдээллийг ил тод болгох цагалбар, хугацааны хувьд хэрхэн уялдаж, хэрэгжих боломж хангагдаж байгаа талаарх давхардал, хийдэл, зөрчлийн судалгаа хийж, аль хууль нь тухайн харилцааг зохицуулах гол хууль болох, бусад хуульд хэрхэн давхардалгүйгээр ишлэл хийх талаар нухацтай анализ хийж, хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах арга хэмжээ авах.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Шүүгч, шүүхийн ажилтнуудын мэргэшил, мэдлэгийн түвшин, ажил хэргийн чадварыг эрх зүйн онолын чиг хандлагыг нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, эрх зүйн онолын мэдлэгийг бататгаж, хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, ёс зүйг эрхэмлэх хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн “Шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнуудын сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө”-г Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2008 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 32 дугаар захирамжаар баталсан байна.

МУ-ын шүүхийн ажлын тайланг 2002 оноос эхлэн АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөр”-ийн дэмжлэгтэйгээр ном болгон хэвлүүлж, төр засгийн холбогдох байгууллага, албан тушаалтан, хуулийн их, дээд сургууль, номын сан, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудад тараасан байна. Ийнхүү Улсын Дээд шүүхээс тайланг хэвлэн гаргаж нийтэд хүргэж хэвшсэн бөгөөд ийм хэвлэл гардаг талаар судлаачид болон хуульчид мэддэг болсон байна.

Авлигатай холбоотой эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн мэдээг нэгтгэн судалгаа гаргах, ялын бодлогыг тодорхойлох ажлыг хагас, бүтэн жилээр УДШ-ийн Эрүүгийн танхим, судалгааны төвтэй хамтран “МУ-ын Дээд Шүүхийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэн нийтийн хүртээл болгосон байна.

Монгол Улсад 2010 оны байдлаар Улсын Дээд шүүхэд 17 шүүгч, Захиргааны хэргийн 22 шүүхэд 57 шүүгч, давж заалдах шатны 22 шүүхэд 101 шүүгч, анхан шатны 38 шүүхэд шүүхэд 254 шүүгч (*нийт 429*) тус тус ажиллаж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байсан.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 10.2-т Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна гэж заасан.

Шүүх байгуулах тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 12-р сарын 18-ны өдөр “Зарим шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай”, “Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай” 198, 199 дугаар зарлиг гаргасан байна. Энэхүү зарлигаар чөлөөлөгдсөн болон томилогдсон шүүгчдийн тоон мэдээллийг хүснэгтээр харуулав.

№	Шүүх	Чөлөөлөгдсөн шүүгч	Томилогдсон шүүгч
1	Аймаг, Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаал	92	
2	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн албан тушаал	6	4
3	Сум, сум дунд, дүүргийн Ерөнхий шүүгч, шүүгчийн албан тушаал	201	
4	Аймаг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаал	59	
5	Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаал		45
6	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаал		48
7	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаал		53

8	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаал		52
9	Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаал		56
10	Сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаал		141

Мэргэшлийн хороо 2002-2010 онд дараахь байдлаар шүүгч сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулжээ. Үүнд:

№	Он	Оролцогч	Тэнцсэн	Тэнцээгүй
1.	2002 он	31	27	4
2.	2003 он	38	25	13
3.	2004 он	213	118	95
4.	2005 он	-	-	-
5.	2006 он	103	85	18
6.	2007 он	109	94	15
7.	2008 он	100	86	14
8.	2009 он	22	14	8
9.	2010 он	89	84	5

Шүүгч сонгон шалгаруулах Мэргэжлийн хорооны тайлангаас үзвэл 2004 онд зах байгуулсантай холбогдуулан шүүгчдийн тоог нэмэгдүүлснийг эс тооцвол шүүгчдийн тоо дорвитой нэмэгдээгүй явж ирсэн. Харин дээр дурдсан хуулиудыг хэрэгжүүлэх хүрээнд 2014 онд анхан шатны шүүхийн 37 шүүгч, давж заалдах шатны шүүхийн 22 шүүгч, сум дундын шүүхийн 11 шүүгчийн сонгон шалгаруулалт зарлаж шүүгчээр томилсон.

Улсын Их Хурлын 2013 оны 1-р сарын 24-ний өдрийн дугаар 12 өдрийн “Шүүгчийн орон тоо батлах тухай” тогтоолоор “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоол; “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 64 дүгээр тогтоол; “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 44 дүгээр тогтоол; “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 59 дүгээр тогтоол; “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 97 дугаар тогтоол; “Шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээ тогтоох тухай” Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 77 дугаар тогтоол; “Шүүгчийн орон тоо тогтоох тухай” Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцон давж заалдах шатны шүүхийн шүүгч болон анхан шатны шүүхийн шүүгчдийн орон тоог шинэчлэн баталсан байна.

Энэхүү тогтоолоор Иргэний хэргийн давж заалдах шаатны шүүхэд 88 шүүгч, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд 88 шүүгч, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 26 шүүгч, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 92 шүүгч, Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 92 шүүгч,

Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 93 шүүгч, Сум дундын шүүхэд 227 шүүгчийн орон тоо баталсан байна. Ингэснээр 2014 оны 6-р сарын байдлаар Улсын Дээд шүүхэд 25 шүүгч ажиллаж байгааг оролцуулан Монгол Улс нийт 731 шүүгч ажиллахаар орон тоо баталсан байна.

Шүүгчийн ёс зүйн талаарх иргэдийн гомдол, түүнийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг дор харуулж байна.

№	Он	Өргөдлийн тоо	Сахилгын шийтгэл ногдуулсан
1.	2002 он	18	-
2.	2003 он	95	19
3.	2004 он	126	12
4.	2005 он	139	8
5.	2006 он	110	06
6.	2007 он	143	13
7.	2008 он	148	13
8.	2009 он	127	17
9.	2010 он	103	3

2010 онд ажиллаж байсан 429 шүүгчийн тоонд харьцуулбал гомдлын мөрөөр сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч бараг байхгүй \3\-тэй адил байна. Энэ нь иргэд үндэслэлгүй гомдол гаргадаг уу, эсхүл сахилгын хороо шүүгчдээ хамгаалсан шийдвэр гаргадаг уу, бүр эсхүл иргэд авлигатай бүр эвлэрчихсэн үү гэсэн асуулт тавихад хүргэж байна. АТГ-т 2013 оны 9 дүгээр сард иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэлд хийсэн дүн шинжилгээний тайланд Авлигатай тэмцэх газарт 2013 оны 9 дүгээр сард нийт **59** гомдол, мэдээлэл ирсэн нь 8 дугаар сард хүлээн авсан гомдлоос 11-ээр буюу 18,6 хувиар өссөн байх бөгөөд агуулгаар нь авч үзвэл эдгээр 59 гомдлоос Шүүх шийдвэр гаргахдаа нэг талыг барьсан тухай гомдол 1, хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг шүүх баримтлаагүй тухай гомдол 1 байсан бол 2013 оны 10 дугаар сард нийт 56 өргөдөл, гомдол ирснээс гомдол, мэдээлэлд дурдсан асуудалд холбогдох этгээдээр ангилхад 3.1 хувь нь шүүх эрх мэдлийн хүрээний байгууллагад хамаарсан тухай судалгаа гарчээ. 2014 оны 1 дүгээр улиралд хүлээн авсан гомдол, мэдээллийн шинжилгээний тайланд Төрийн байгууллагаас ирүүлсэн материалын 11.1 хувийг шүүх эрх мэдлийн хүрээний байгууллагаас ирүүлсэн, гомдол мэдээллийн 4.8 хувь нь шүүх эрх мэдлийн байгууллагад хамаарсан байна. Ёс зүйн асуудлаар хариуцлага хүлээсэн шүүгчийн тоо цөөн, шүүгчийн ёс зүйтэй холбоотойгоор АТГ-д хандах явдал мөн цөөн байгаа нь сайн үзүүлэлт байж болох талтай. **Гэвч шүүх авлигад өртөмтгий салбаруудын нэлээд дээгүүрт ордгийг удаа дараагийн судалгаа харуулдаг. Иймд шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлж байсан талуудыг оролцуулсан илүү нарийвчилсан ажиглалт, ярилцлага, судалгаа явуулах шаардлагатай байна. Магадгүй, шүүгчийн ёс зүйн асуудлыг илчлэх нь хэзээ нэгэн цагт өөрт болон үр хүүхдэд муугаар нөлөөлнө гэж үздэг ч байж болох талтай. Ямартай ч нэг талаас судалгааны дүн, нөгөө талаас сахилгын хорооны шийдвэр, шүүгчийн талаар гомдол гаргахгүй шахам байгаа эсрэг тэсрэг нөхцөл байдлын шалтгааныг тогтоох нь зүйтэй.**

ЗӨВЛӨМЖ:

- Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлж байсан талуудыг оролцуулсан илүү нарийвчилсан ажиглалт, ярилцлага, судалгаа явуулах шаардлагатай байна. Магадгүй, шүүгчийн ёс зүйн асуудлыг илчлэх нь хэзээ нэгэн цагт өөрт болон үр хүүхдэд муугаар нөлөөлнө гэж үздэг ч байж болох талтай. Ямартай ч судалгаа ба сахилгын хорооны шийдвэр, шүүгчийн талаар гомдол гаргахгүй шахам байгаа эсрэг тэсрэг нөхцөл байдлын шалтгааныг тогтоох нь зүйтэй
- Авлига буурахгүй байсаар байгааг судалгаа нотлоод байхад Төрийн албан хаагч, ялангуяа хууль сахиулах байгууллагын ажилтны хууль бус буюу ёс зүйн асуудлаар АТГ болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагын нэгдсэн ойлголтын үндсэн дээр иргэд гомдол гаргах, мэдээлэх явдал хангалтгүй байдгийн шалтгааныг тогтоох, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор харьцангуй урт хугацаанд хэд хэдэн үе шаттай асуулгын судалгаа, ажиглалт, тандалт хийх, тодорхой тохиолдолд туршилт хийх зэрэг төрөл бүрийн арга зүйд тулгуурласан бодитой судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх

7.2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу авсантай адил үр нөлөөтэй арга хэмжээг шүүхийн тогтолцоонд хамрагддаггүй атлаа шүүхийн байгууллагатай адил хараат бус эрх зүйн байдалтай прокурорын байгууллага бүхий тэрхүү оролцогч улсын прокурорын байгууллагад нэвтрүүлэн хэрэглэж болно. /Конвенцийн 11.2/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд зааснаар Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох бөгөөд Прокурорын хараат бус эрх зүйн байдлыг Прокурорын байгууллагын тухай хууль (2002)-иар зохицуулсан. Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, **бие даасан, хараат бус**, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн тул Конвенцийн дээрх заалтад бүрэн хамаарна.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлд Прокурорыг гадны нөлөөнд үл автах зарчмыг Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гадны нөлөөнд үл автан, гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг удирдлага болгоно¹¹¹, Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бусад

¹¹¹ Прокурорын байгууллагын тухай хуулийн 6.1.

байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч хөндлөнгөөс оролцож, дарамт шахалт үзүүлж болохгүй¹¹² - гэсэн байна.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан прокурорын хүлээх үүрэгт Прокурор нь төрийн албан хаагчийн болон прокурорын ёс зүйн хэм хэмжээг сахих, хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэгтэй.

Прокурор хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд Улс төрийн баталгаа /33 дугаар зүйл/, Эдийн засгийн баталгаа /34 дүгээр зүйл/, Нийгмийн баталгаа /35 дугаар зүйл/, Хууль зүйн баталгаа /36 дугаар зүйл/ болон Бусад баталгаа /37 дугаар зүйл/-г хуулиар зохицуулсан байдаг.

“Прокурорын байгууллагын төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байхыг¹¹³”, “Прокурорын байгууллагыг ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техникийн хэрэгсэл, ажилтныг орон сууцаар хангах зэрэг үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцлийг бүрдүүлэхэд төрийн захиргааны байгууллага бүх талын дэмжлэг үзүүлнэ¹¹⁴” – гэж Прокурорын байгууллагын тухай хуульд заасан.

Прокурор албан тушаалд томилогдохдоо: “Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг чанд сахиж, прокурорын байгууллагын нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, гадны нөлөөнд үл автах, хуулийг нэг мөр хэрэглэх зарчмыг гүнээ хүндэтгэн, албаны үүргээ үнэнч шударгаар биелүүлж, прокурорын ёс зүй, нэр хүндийг өндөрт өргөж явахаа тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангарагаасаа няцвал хуульд заасан хариуцлагыг хүлээнэ” гэж тангараг өргөдөг төрийн жинхэнэ албан хаагч юм. Төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулсан хориглох зүйл, ашиг сонирхлын зөрчилдөөнтэй холбоотой хуулийн зохицуулалтыг өдөр дутмын үйл ажиллагаандаа чандлан дагаж мөрдөх үүрэгтэйгээс гадна Прокурорын ёс зүйн дүрэм үүнд хамаарна.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42^{1.5}-т “Прокурорын ёс зүйн дүрэм, Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална” – гэж заасны дагуу Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралтаар Прокурорын ёс зүйн дүрмийг баталсан. Уг дүрэмд зааснаар Прокурорын ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэхэд дараах зарчмыг баримтална¹¹⁵.

- Хуулийг хүндэтгэн дээдэлж, чанд сахин биелүүлэх
- Прокурор гадны нөлөөнд үл автах

Прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад баримтлах ёс зүйн хэм хэмжээ:

- Прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч, түүний өмгөөлөгчтэй харилцахдаа ямарваа ялгавартай байдал гаргахгүйгээр тэдэнд хүндэтгэлтэй хандаж тухайн хэргийг шударга, зөв шийдвэрлүүлэх итгэл үнэмшлийг төрүүлж чадахуйц мэдлэг, харьцааны соёлтой байна¹¹⁶.

¹¹² Прокурорын байгууллагын тухай хуулийн 6.2.

¹¹³ Прокурорын байгууллагын тухай хууль 34.2

¹¹⁴ Прокурорын байгууллагын тухай хууль 34.4

¹¹⁵ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 2.2.2, 2.2.4 дэх заалт.

¹¹⁶ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 3.1

- Прокурор нь хувийн сонирхлын үүднээс харъяаллын бус, бусдын хяналтанд байгаа хэрэг, материалтай танилцах, зөвлөгөө өгөх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шинжээч нарт өөртөө ашигтай болон үндэслэлгүй шийдвэр гаргуулах хүсэлт тавихыг цээрлэж, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцож, дарамт шахалт үзүүлэхгүй байна¹¹⁷.
- Прокурор нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг, материалын талаар урьдчилан дүгнэлт гаргах саналаа илэрхийлэхээс зайлсхийж, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хэрэг, материалын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлэхгүй байна¹¹⁸.
- Гэр бүлийн гишүүн, төрөл садангийн болон ойр дотно харилцаатай хүмүүс, өмнө нь ажиллаж байсан, эрх ашгийг нь ямар нэг хэлбэрээр хамгаалж байсан байгууллагатай холбогдсон эрүү, иргэн, захиргааны хэрэг, материалыг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй¹¹⁹.
- Прокурор хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч, сэжигтэн, яллагдагчийг яллах, цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлыг адил тэнцүү тогтоолгох үүргийг хангаж, хэт нэг талыг барьж асуудалд хандахгүй байх¹²⁰.
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хэргийг аль нэг талд нь ашигтай шийдвэрлэх талаар бусдад урьдчилан амлалт өгөхгүй байх¹²¹.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай хуулийн заалтыг хэлбэрэлтгүй мөрдөх¹²².

Хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн бусад үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ:

- Прокурор дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно:
 - Прокурорын хяналтын чиг үүрэгтэй холбогдолгүй асуудлаар байгуулсан аливаа хороо, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох¹²³;

¹¹⁷ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 3.3

¹¹⁸ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 3.4

¹¹⁹ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 3.6

¹²⁰ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 3.7

¹²¹ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 3.10

¹²² Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 3.12

¹²³ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.1.1

- Багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэхдээ тэдгээр байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох¹²⁴;
- Прокурор нийгэм, соёлын арга хэмжээнд оролцохдоо уг үйл ажиллагаа, арга хэмжээ нь прокурорын байгууллагын нэр хүндэд харшлахаар бол түүнээс татгалзана¹²⁵.
- Албан үүргээ хэрэгжүүлэхэд харшлах, эсхүл сөргөөр нөлөөлөх, прокурорын албан тушаалыг ямар нэг байдлаар ашиглахыг санаархсан аливаа хэлцэл, үйл ажиллагаанаас зайлсхийнэ¹²⁶.
- Прокурорын албан тушаалд харшлах үндэслэл бүхий хөрөнгө оруулалт, бизнесийн бусад ашиг сонирхлоос татгалзана¹²⁷.
- Албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан аливаа мэдээллийг өөрийн санхүүгийн эх үүсвэр болгон ашиглахгүй¹²⁸.
- Прокурор нь Авлигын эсрэг хуулийн зөвшөөрөгдсөн хүрээнд бэлэг авч болох боловч эрхэлж буй ажил, албан тушаалтайгаа холбоотойгоор бусдаас хандив, тусламж, зээл хүсэх, шан харамж, бэлэг авах, ямар нэг байдлаар хувьдаа давуу байдал олж авах, мөн түүнчлэн түүхт ой, баяр ёслолыг тохиолдуулан аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс бэлэг сэлт, үнэ бүхий зүйл авахыг хориглоно¹²⁹.
- Хэргийн оролцогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүн болон өмгөөлөгчтэй хувийн харьцаа тогтоож, тэднээр дайлуулах, үйлчлүүлэх, ажил гүйцэтгүүлэхгүй байх¹³⁰.
- Прокурор багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй¹³¹.

Прокурорын улс төрийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалт:

- Прокурор улс төрийн дараах үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:
 - Бүх шатны улс төрийн сонгуулийг зохион байгуулах байгууллагын бүрэлдэхүүнд орох¹³²;

¹²⁴ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.1.2

¹²⁵ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.2

¹²⁶ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.3

¹²⁷ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.4

¹²⁸ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.5

¹²⁹ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.6

¹³⁰ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.7

¹³¹ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 4.8

¹³² Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 5.1.1

- Улс төрийн аливаа байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаал эрхлэх¹³³;
- Улс төрийн сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намд хөрөнгө мөнгө олж өгөхөөр амлах, зуучлах, хандив өргөх, бусад туслалцаа үзүүлэх¹³⁴;
- Улс төрийн байгууллага, нэр дэвшигчийг дэмжиж, эсвэл эсэргүүцэж нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох¹³⁵.

Прокурор биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээ:

- Албан үүргээ хэрэгжүүлэх болон эрх бүхий байгууллагаас шаардсанаас өөр тохиолдолд бусдын зан төлөв, ёс суртахуун, нэр төр, алдар хүндийн талаар тодорхойлохгүй¹³⁶.
- Эрдэм шинжилгээний ажил эрхлэх, багшлах, зохиол бүтээл туурвих, хэвлэн нийтлэх, гэрээ хэлцэл байгуулахад прокурорын албан тушаал, прокурорын байгууллагын нэр хүндийг ашиглахаас зайлсхийнэ¹³⁷.
- Дүрэмт хувцастай яваа үедээ, түүнчлэн албан үүрэг гүйцэтгэж явах үедээ буюу ажлын байранд, эсхүл байцаан шийтгэх ажиллагааны явцад хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчтэй ууж согтуурах, мансуурахыг хориглоно¹³⁸.

Прокурорын хууль тогтоомжид заасны дагуу өөрийн болон гэр бүлийнхээ хөрөнгө, орлогыг үнэн зөвөөр мэдүүлж байх үүрэгтэй¹³⁹. Хэрэв прокурорын талаар үндэслэлгүй нийтлэл хэвлүүлсэн, нэвтрүүлсэн тохиолдолд тухайн прокурор, эсвэл түүний эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага шүүхэд хандаж прокурорын нэр хүндийг сэргээлгэх, эд хөрөнгийн бус гэм хорын хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй¹⁴⁰. Прокурорын ёс зүйн зөрчил гэж энэ дүрмээр тогтоосон прокурорын ёс зүйн хэм хэмжээг санаатай буюу санамсаргүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг хэлнэ¹⁴¹.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Авлигатай тэмцэх газар байгуулагдаж хуулиар харъяалуулсан хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулж ирснээс хойшхи хугацаа /2007 оны 9 дүгээр

¹³³ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 5.1.2

¹³⁴ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 5.1.3

¹³⁵ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 5.1.4

¹³⁶ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 6.2.

¹³⁷ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 6.3.

¹³⁸ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 6.4.

¹³⁹ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 7.1.

¹⁴⁰ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 8.1.

¹⁴¹ Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 268 дугаар зарлигийн хавсралт Прокурорын ёс зүйн дүрмийн 9.1.

сарын 7-ноос/-нд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, шүүхээр шийдвэрлүүлсэн албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл 3 ботийг хэвлүүлэн гаргаж нийтийн хүртээл болгожээ. Энэ нь шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, оюутан, багш судлаач нарт албан тушаалын гэмт хэргийн шүүхийн практикийг харьцуулан судлах, тэдгээрт бодит дүгнэлт хийх, цаашилбал шүүхийн практик тогтоход ихээхэн ач холбогдолтой юм¹⁴².

Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар УЕП-ын газарт хэвлэл мэдээллийн алба байгуулан ажиллуулж, орон нутгийн прокурорын газруудад хэвлэл мэдээллийн салбар байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд 2006 онд прокурорын байгууллагаас иргэд олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харилцах асуудлын талаар тусгай журам гарган ажиллаж байна. Мөн прокурорын байгууллагын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааны талаар мэдээллийг нийтэд мэдээлэх, сурталчлах, ил тод байлгах зорилгоор Прокурорын байгууллагын вэбсайт, танилцуулгыг хийж, “Прокурорын мэдээлэл” сэтгүүлийг улирал тутам гаргаж орон нутгийн прокуроруудад хүргүүлэн ажиллаж байгаа юм байна¹⁴³.

Энэхүү үнэлгээ хийх явцад манай багийн хийсэн төрийн байгууллагуудын цахим хуудсанд суурилсан судалгааны хүрээнд Улсын Ерөнхий прокурорын газрын <http://prokuror.mn/> цахим хуудсыг 2014 оны 7-р сарын 7-ны өдрийн 14 цаг 50 минутанд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар шаардсан мэдээллүүдээ нийтэд мэдээлдэг эсэхэд нь ажиглалт хийлээ. **Үйл ажиллагааны ил тод байдлын хувьд** харилцах утас байгаа боловч Прокурорын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, шийдвэрийн төсөл, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт явц зэрэг мэдээлэл байхгүй, эрх зүйн актын булантай боловч дотор нь мэдээлэл байсангүй. **Хүний нөөцийн ил тод байдлын тухайд** сул орон тооны зар, албан хаагчийн ёс зүйн дүрэм, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зэрэг мэдээлэл байхгүй байна. **Төсөв, санхүүгийн ил тод байдлын хувьд** тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсөвт нэмэлт өөрчлөлт орсон байдал зэрэг мэдээллүүд мөн байхгүй байв. **Худалдан авах ажиллагааны ил тод байдлын тухайд** сар сарын архиваас нилээн хайж үзэхэд тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлтийн мэдээлэл байх боловч тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан, худалдан авч ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон хяналт, шалгалтын дүн зэрэг хуулиар шаардсан мэдээллүүдийг нийтэд ил тод болгоогүй байна. Улсын ерөнхий прокурорын газрын хувьд дээрх байдлаар дүгнэхэд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шаардлагад нийцүүлж мэдээллээ нийтэд ил тод болгодоггүй гэж үзэж байна.

¹⁴² Авлигатай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн Хэрэгжилтийн Дүн Шинжилгээний Тайлангийн Хөтөлбөрийн заалт 4-ийн “и” хэсгийн 5 дахь догол мөр

¹⁴³ Авлигатай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн Хэрэгжилтийн Дүн Шинжилгээний Тайлангийн Хөтөлбөрийн заалт 4-ийн “к” хэсгийн 3, 4 5 дахь догол мөр

Улсын Ерөнхий прокурорын газар нь өмнөх онуудын үйл ажиллагааны тайлангаа цахим хуудсандаа байрлуулаагүй байсны улмаас Конвенцийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хомс байлаа.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын байгууллагаас 2013 онд хийсэн ажлын товч тайланд бодлогын түвшинд анхаарч ажилласан ажлуудын дунд Прокурорын байгууллагаас гаргасан заавар, журмуудын хэрэгжилтийг хангуулах, доод шатны прокурорын шийдвэрт гаргасан гомдлыг дээд шатны прокурор хууль тогтоомжийн дагуу шалгаж, шийдвэрлэх, хариуцлага тооцдог болгох арга барил тогтоох, прокурорын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох, сургалтуудын чанар, үр дүнг сайжруулах, нийт прокурор ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг ажлууд хийгдсэн нь бидний судалгааны ажлын хүрээнд багтаж байна.

Прокурорын байгууллага 2013 онд прокурорын үндсэн хяналттай холбогдуулан 13950 гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн оныхоос 8.5 хувиар өссөн гэх ба төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдээс прокурорын байгууллагад гаргасан 719 өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн байна.

Үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандсан, алдаа дутагдал гаргасан, прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үндэслэлээр 19 прокурор Улсын Ерөнхий прокурорын тушаалаар сахилгын арга хэмжээ авагдсанаас ажлаас халагдсан 5, албан тушаал бууруулсан 1, цалингийн тодорхой хувь хассан 8, сануулах сахилгын шийтгэл хүлээсэн прокурор 3 байна. ***Прокурорын байгууллага нь шүүхтэй харьцуулбал босоо удирдлагатай, нэгдсэн тогтолцоо бүхий байдгаараа онцлогтой . Энэ онцлог нь Улсын Ерөнхий прокурорын өөрийнх нь прокуроруудыг авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг тууштай тэмцэх хүсэл эрмэлзлэлээс нийт салбарын хэмжээнд болон прокурорын хяналт дор үйл ажиллагаа явуулдаг төрийн албан хаагчдын авлигаас ангид байх явдал ихээхэн шалтгаална.*** Энэ үүднээс үзвэл шүүхтэй харьцуулбал ёс зүйн болон мэргэжлийн зөрчлийн улмаас сахилгын шийтгэл хүлээлгэсэн хүний тоо цөөнгүй байгаа нь ажиглагдаж байна. Улсын хэмжээнд 455-459 прокурор үйл ажиллагаа явуулдаг байна.

Уг товч тайланд дурдсанаар Прокурор эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 202 судалгаа хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн шалгалтанд 216 удаа оролцож, хууль сурталчлах чиглэлээр сонин хэвлэлд 177, радио, телевизэд 158 удаа мэдээ, мэдээлэл өгчээ. 2013 онд Прокурорын байгууллага хуулийн заалтыг хангуулах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар дэвшүүлсэн зорилтоо хангаж, шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдэх өөрчлөлт, шинэчлэлтийн талаар тодорхой бодлого баримталж ажилласан нь зохих үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн байна¹⁴⁴.

¹⁴⁴ Прокурорын Ерөнхий Газрын цахим хуудас: <http://prokuror.mn/?p=6361>

ЗӨВЛӨМЖ:

- Цахим хуудсаа мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай зэрэг хуулийн шаардлагын дагуу мэдээллээ наанадаж сүүлийн 3 жилийн байдлаар бүрэн байршуулахыг УЕПГ-т зөвлөж байна
- Авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий голлох байгууллагуудын нэгийн хувьд УЕПГ нь үйл ажиллагааныхаа тайланд Конвенцийн 11.1, 11.2-т заасан шаардлагын дагуу болон байгууллага системийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төрийн байгууллагуудын авлигын эсрэг хамтын ажиллагаа, ажлын уялдааг хангахад оруулсан хувь нэмрийн талаар тодорхой бүлэг болгон тусгаж байх

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХУВИЙН ХЭВШИЛ

/12 дугаар зүйл/

8.1. Оролцогч улс бүр хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг сайжруулах, түүнчлэн ийм арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд үр нөлөөтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг гаргуулахгүй байх нөлөө үзүүлэхүйц иргэний эрх зүйн, захиргааны болон эрүүгийн зохих хариуцлагыг оногдуулах арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ. /Конвенцийн 12.1/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн ¹⁴⁵ 4.1-д аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх, 10.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад, төсөвт байгууллага нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн санхүүгийн тайлангаа гаргана.16 дугаар зүйлд Нягтлан бодох бүртгэлийн стандартыг, 18 дугаар зүйлд Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын тогтолцоотой холбогдох харилцааг зохицуулсан:

- 18.2. Дотоодын нягтлан бодох бүртгэлийн хянан шалгагчийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага томилж болно.
- 18.3. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт хариуцсан албан тушаалтны эрх, үүргийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэртээ тодорхойлно гэдгийг заасан.

¹⁴⁵ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2001.12.13

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн ногдуулах хариуцлагыг 23дугаар зүйлд тодорхойлсон байна.

Компанийн тухай хуулиар¹⁴⁶ Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ. /81.2/ Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавина, /79.4.2/ Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавина, /81.4.1/ Сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг хийх журам /92 дугаар зүйл/ зэргийг хуульчилж өгсөн байна. **Аудитын тухай хуулиар**¹⁴⁷ аудитор нь аудит хийж болохгүй нөхцөл байдал байгаа бол уг үйл ажиллагааг явуулахаас татгалзах эсхүл бусад аудитор, мэргэжилтэнг нэмж оруулах шаардлагатай байвал үйлчлүүлэгч буюу холбогдох аудитын байгууллагад нэн даруй мэдэгдэхийг, аудиторт хориглох үйл ажиллагаа, Аудиторын эрхийн хязгаар /Хуулийн 21/ зэргийг зааж өгсөн байна. Хариуцлагын хувьд хууль тогтоомж, ёс зүйн дүрмийг зөрчсөн нягтлан бодогч, аудиторт дараах сахилгын шийтгэлийг ногдуулахаар хуульчилсан байна:

- сануулах;
- аудитын үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;
- мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хасах.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2007 онд баталж, 2014 оны 5 дугаар сарын 7-ны өдөр шинэчлэн найруулж баталсан **Компанийн засаглалын кодекс**¹⁴⁸-т дараах заалтууд осон байдаг: Хөндлөнгийн аудитын хяналт /7.2/

- Хөндлөнгийн аудитын байгууллага /аудитор/ нь аудитын ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд, холбогдох дүрэм журам, стандартын дагуу, хараат бусаар, хэн нэгний нөлөөнд авталгүйгээр, бодитой эрхлэн явуулна. Аудитор нь компанийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарын онцлогийг сайн мэддэг байвал зохино. Аудитор нь тухайн компанийн нягтлан бодох бүртгэлийг хөтөлдөг, компанид удирдлагын болон татварын асуудлаар зөвлөгөө өгдөг бол түүнийг хараат бус гэж үзэхгүй бөгөөд уг нөхцөл, байдалд буй аудиторыг сонгох боломжийг хаасан байна. Энэ талаар аудитортой байгуулах гэрээнд нарийвчлан тусгаж хяналтыг хэрэгжүүлдэг байна;
- Хөндлөнгийн аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн дүрмийг чанд баримтлах бөгөөд компанийн удирдлагын болон хяналтын багц эзэмшигчдийн зүгээс

¹⁴⁶ Компанийн тухай хууль 2011.10.06

¹⁴⁷ Аудитын тухай хууль 1997.05.01

¹⁴⁸ Компанийн засаглалын кодекс 2014.05.07

санал болгосон, тэдгээрийн хувийн сонирхлыг тусгасан гэрээ байгуулахыг хориглоно.

- Хөндлөнгийн аудиторууд нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож аудитын шалгалтын тайлантай холбоотой хувьцаа эзэмшигчдийн асуултад хариу өгдөг байна;
- Хөндлөнгийн аудиторуудын санаатай, санамсаргүй алдааны улмаас аудитын шалгалтын тайланг ашиглагч этгээдэд хохирол учирвал хөндлөнгийн аудитор нь учирсан хохирлыг барагдуулах үүрэг хүлээдэг, хүлээх хариуцлагын талаар тэдгээртэй байгуулах гэрээнд тодорхой тусгасан байна;
- Тухайн компанийн хууль тогтоомжийн дагуу нийтэд хүргэсэн мэдээлэл нь санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллээс зөрүүтэй байгаа нь шалгалт хийх явцад тогтоогдвол аудиторууд уг мэдээллээ залруулахыг шаардах үүрэгтэй бөгөөд залруулах үүргийг компанийн гүйцэтгэх удирдлага хүлээнэ;
- Хөндлөнгийн аудиторууд нь шалгалтын явцад илэрсэн компани, түүний гүйцэтгэх удирдлагын гаргасан зөрчлийг нуун дарагдуулалгүйгээр ТУЗ, ХНХ-д мэдээлдэг байна;
- Хөндлөнгийн аудиторын дүгнэлтэд тухайн компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвартай эсэх талаар тухайлан заасан байна. Хөндлөнгийн аудиторууд нь шалгаж буй компанийнхаа төлбөрийн чадварын талаар онцлон дүгнэлт гаргах ёстой бөгөөд энэ асуудал нь ихээхэн ноцтой үр дагавартай байдаг учраас хариуцлагатай хандан, онцгой анхаарал хандуулах ёстой. Хөндлөнгийн аудиторууд нь компанийн төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргахаас зайлсхийх, хариуцлага хүлээхгүйн тулд тодорхой бус, хоёрдмол санаатай, ерөнхий дүгнэлт гаргах ёсгүй;
- Хөндлөнгийн аудитын үйлчилгээний хөлсийг зөрчил илрүүлснээс хамаарч багасгах, эсхүл гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны талаар эерэг дүгнэлт гаргаснаас хамаарч ихэсгэдэг байж болохгүй.

Зөрчлийн тухай хуулийн төсөл¹⁴⁹

- Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчих /10.14-р зүйл/
1.Иргэн, хуулийн этгээд нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн тайлан гаргаагүй, санаатайгаар санхүүгийн баримтыг устгасан, алга болгосон, нуусан бол нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг таван сая төгрөгөөр тус тус торгох шийтгэл хүлээлгэнэ.

2.Санхүүгийн тайлангаа энэ хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад тушаагаагүй бол таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр тус тус торгох шийтгэл хүлээлгэнэ.

Гэмт хэргийн тухай хуулийн төсөл¹⁵⁰

¹⁴⁹ Зөрчлийн тухай хуулийн төсөл

¹⁵⁰ Гэмт хэргийн тухай хуулийн төсөл

- Зохиомлоор, эсхүл зориуд дампуурах /18.13-р зүйл/

1.Эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, үүрэг, эд хөрөнгийн мэдээ сэлт, түүний хэмжээ эсхүл байрлаж байгаа газар, эсхүл эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, үүргийн тухай бусад мэдээлэл, бусад хүнд эзэмшүүлэхээр эд хөрөнгө шилжүүлсэн, эд хөрөнгө өгсөн эсхүл устгасныг нуусан, эсхүл хуулийн этгээд эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгчийн эдийн засгийн үйл ажиллагааг илэрхийлсэн нягтлан бодох бүртгэлийн эсхүл бусад тооцооны баримт бичгийг нуусан, устгасан, өөрчилсөн бол дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээр дурдсан хуулиудаас үзэхэд **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтууд нь Конвенцийн хувийн хэвшлийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн хяналт шалгалтыг сайжруулах, Компанийн тухай хуулийн болон Аудитын тухай хууль, Компанийн засаглалын кодекс дурдсан холбогдох заалтууд нь хувийн хэвшлийн байгууллагуудын хөндлөнгийн хяналт шалгалтын жишгийг сайжруулахад чиглэгдсэн байна.** Харин Аудитын тухай хуулийн хууль, тогтоомж, ёс зүйн дүрмийг зөрчсөн нягтлан бодогч, аудиторт хүлээлгэх сахилгын шийтгэл, Зөрчлийн тухай хуулийн төслийн Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчих буюу 10.14, Гэмт хэргийн тухай хуулийн төслийн Зохиомлоор, эсхүл зориуд дампуурах буюу 18.13-т заасан хэсгүүд нь нягтлан бодох бүртгэлийн болон хөндлөнгийн жишгийг сайжруулах арга хэмжээг зохих тохиолдолд биелүүлээгүй тохиолдолд үр дүнтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг хийхгүй байлгах иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлагыг хүлээлгэх хэмжээг заасан байх Конвенцийн шаардлагыг хууль тогтоомждоо нийцүүлэн хэрэгжүүлсэн байна гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон хөндлөнгийн аудитын хяналтын талаар холбогдох хууль тогтоомжид илүү дэлгэрэнгүй хуульчлах.
- Аудитын тухай хуульд аудитор болон аудитын байгууллага аудит хийх явцдаа авлигын шинжтэй зөрчил илэрвэл зохих байгууллагад мэдээлэх үүргийн талаар заалт байхгүй байгааг олон улсын жишигт нийцүүлэн нэмж оруулах.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- **Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал, 2013 оны 12 сард явуулсан судалгаанаас¹⁵¹:**

Хувийн хэвшилд авлига “их” байна гэж үзэх оролцогчдын тоо 2012 оны 12 дугаар сард 9.7 хувь байснаа 2013 оны 10 дугаар сард 5.8 хувь болж буурчээ. Компаниуд хувийн хэвшлийн тендер болон гэрээ байгуулах үйл ажиллагаанд хэр их авлигатай тулгардаг талаар асуухад эерэг байдал ажиглагддаг. 2012 оны 12 дугаар сард судалгаанд оролцогчдын 24.8 хувь нь “тийм” гэж хариулж байсан бол ингэж хариулж байгаа оролцогчдын тоо дөнгөж 14.5 хувь болоод байна. Хувийн хэвшлийн тендер болон гэрээ байгуулах үйл ажиллагаанд авлигатай огт тулгардаггүй гэж байгаа оролцогчдын тоо 2013 оны 5 дугаар сард 4.5 хувь байснаа 2013 оны 10 дугаар сард 10.3 хувь болж нэмэгдсэн байна \18-р хуудас\.

Компаниудын зөвхөн 21.2 хувь нь өөрийн үйл ажиллагааны явцад авлигатай “байнга” буюу “ойр ойрхон” тулгардаг гэж үзсэн байна. Энэ нь өмнөх судалгаатай харьцуулбал илүү сайн үзүүлэлт юм. (2013 оны 5 дугаар сард оролцогчдын 24.5 хувь ингэж үзэж байв.) /19-р хуудас/

Төрийн байгууллагуудын дотор “төрийн үйлчилгээ” авлигад хамгийн өртөмтгий салбар гэдгээ тодорхой харуулав. 2013 оны 5 дугаар сард судалгаанд оролцогчдын 54.8 хувь үүнийг авлигад хамгийн өртөмтгий салбар гэж үзэж байсан бол 10 дугаар сард энэ нь нийт оролцогчдын 67.6 хувь болж хамгийн дээд байранд оров. Барилгын салбар мөн дээрх үзүүлэлтээр дээшилж 2013 оны 5 дугаар сард 47.3 хувиас 10 дугаар сард 58.2 хувь болж, жагсаалтын авлигад хамгийн их өртөмтгий салбарын 3 дугаарт, уул уурхайн салбар 59.4 хувьтайгаар энэ удаад авлигад хамгийн их өртсөн салбарт ороогүй.

Ерөнхийдөө бизнесийн орчны зүгээс авлигад хандах хандлага 2013 оны 5 дугаар сард хийсэн судалгаанаас хойш нэг их өөрчлөгдсөнгүй. Судалгаанд оролцогчдын талаас дээш хувь (51.6 хувь) нь авлигын эсрэг хууль зөвхөн хээл хахууль авдаг этгээдэд хамаарч үйлчлэх ёстой гэж үзсэн хэвээр байна. Хээл хахууль авдаг болон өгдөг этгээд шийтгэл хүлээх ёстой гэж үздэг судалгаанд оролцогчдын тоо 2013 оны 5 дугаар сард 36.4 хувь байснаа 10 дугаар сард 41.8 болж өсөв. Энэ өсөлт нь 5 дугаар сард тодорхой үзэл бодол илэрхийлээгүй хүмүүсийн үзүүлэлтээс болсон байх магадлалтай. /21-р хуудас/

2012 оны 1 дүгээр сар болон 2013 оны 5 дугаар сарын судалгааны дүнтэй адилаар судалсан компаниудын тал орчим (48.8 хувь) нь “хэрэв авлига буурвал” бизнесийн ашиг орлого өснө гэж үзэж байна. Хэдийгээр орлого нь ийнхүү өсөх боломжтой байсан ч авлигатай тэмцэх арга хэмжээ авсан компанийн тоо 12.4 хувь болж буурав. Харин арга хэмжээ аваагүй компанийн тоо 74.5 хувьд хүрэв. Цаашилбал, авлигын хэргийг зохих байгууллагад мэдээлсэн компанийн тоо буурах талруу өөрчлөгдсөн. Компаниудын 8.8 хувь авлигын хэргийн талаар мэдээлсэн гэж байхад мэдээлээгүй компанийн тоо 83.6 хувь болж өсөв. /22-р хуудас/

¹⁵¹ Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал ном 2013, 20-р хуудас

Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг сайжруулах, түүнчлэн ийм арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд үр нөлөөтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг гаргуулахгүй байх нөлөө үзүүлэхүйц иргэний эрх зүйн, захиргааны болон эрүүгийн зохих хариуцлагыг оногдуулах арга хэмжээг хуульчилсан боловч эдгээр хуулийн хэрэгжилтийг харуулсан мэдээлэл хомс байна. Тухайлбал, дээр дурдсан хуулиудад заасан захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тоо, хэрхэн илрүүлсэн, аудиторт ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн тухай мэдээлэл байхгүй байна. Үндэсний татварын ерөнхий газрын цахим хуудсанд тус байгууллагын тайлангууд байгаагүй учир нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөрчлийн төрөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл олдоогүй.

Е-тайлан нэвтрүүлсэн талаар СЯ-ны тайлан мэдээллээс үзэх гэсэн боловч 2014.06.27-ны байдлаар сангийн яамны цахим хуудсанд тайлан байгаагүй. Эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар зохих арга хэмжээ авсан боловч практик дээр хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэл түгээх талаар олон нийт танилцах, үнэлэх боломжгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг сайжруулахтай холбоотой Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Компанийн тухай хуулийн тодорхой зохицуулалтын хэрэгжилтийн талаар судалгаа үнэлгээ хийх;
- Хуулийн хэрэгжилтийн талаар холбогдох төрийн байгууллага чиг үүргийнхээ дагуу статистик мэдээллийг ил тод болгох арга хэмжээ авах шаардлагатай.

8.2. Эдгээр зорилгод хүрэх үүднээс дараах арга хэмжээг бусад арга хэмжээний хамт авч болно:

(а)хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих; /Конвенцийн 12.2.а/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуульд зааснаар иргэн хуулийн этгээд нь

- Олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: /5.1./
 - Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус

байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах;

- төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;
 - авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах;
 - сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх;
 - албан бус боловсролын байгууллага болон сургуулиас гадуурх сургалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад тайлбарлан таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлэх;
 - хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.
- Авлигаас урьдчилан сэргийлэх талаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9,10 дугаар зүйлд заасан эрх, нийтлэг үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ: /6.5./
 - төрийн бус байгууллага гишүүнийхээ ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа ил тод мэдээлж байх;
 - хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааныхаа ёс зүйн зарчмуудыг тогтоож, дагаж мөрдөх.

Мөн Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх, /18.1.6./ аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах, /18.4.4./ зэргээр хамтран ажилладаг байна.

Гаалийн тухай хуульд зааснаар Гаалийн байгууллага нь иргэн хуулийн этгээдтэй дараах байдлаар хамтран ажиллахаар заасан байна.

- Гаалийн байгууллага нь гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгч болох бөгөөд /12.1./ гадаад худалдааны барааны статистик мэдээллийг төлбөртэй ашиглуулж болно гэж заасан байна. /15.2./
- Иргэн, хуулийн этгээд нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гаалийн байгууллага, албан тушаалтны амаар болон бичгээр гаргасан

шийдвэр, эс үйлдэхүй /цаашид “шийдвэр” гэх/-н шалтгаан, үндэслэлийн талаар мэдээлэл авах эрхтэй. /10.1./

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийг ийнхүү хандивласан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцно. /19.10./ Мөн 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлнэ. /19.8./ Тодорхой нутаг дэвсгэрийн усны нөөцийг нэмэгдүүлэх, усны найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор байгалийн усны чанарыг сайжруулах, гол, горхийг нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийт орлогод ногдох албан татварыг тухайн арга хэмжээнд зарцуулсан хэмжээгээр хөнгөлнө. /19.11./ хэмээн зааж энэ чиглэлээр хамтран ажиллахаар заасан байна.

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага мөн. /3.1./ Тус байгууллага нь Иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах талаар **Цагдаагийн албаны тухай хуульд**¹⁵² дараах байдлаар тусгасан байна. /25-р зүйл/ Тухайлбал:

- Нутгийн захиргааны байгууллагаас харьяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахад нь цагдаагийн байгууллага мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана.
- гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэний туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна.
- Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд иргэн, хуулийн этгээд дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.
- Цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоох, тэдгээрийг арилгуулах талаар иргэн, хуулийн этгээдэд хүлээсэн үүргийнх нь хүрээнд шаардлага тавьж биелэлтийг шалгах, шаардах, шаардлагатай танилцуулга, материалыг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнээс үнэ төлбөргүй гаргуулан авна.
- Цагдаагийн байгууллага зохих сургалтад хамрагдаж тэнцсэн, хэвлэл, мэдээллийн байгууллагаас цагдаагийн үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэхээр тусгайлан томилогдсон ажилтантай хамтран ажиллана. Энэ нь иргэн, хуулийн этгээдээс хүний эрх, эрх чөлөө, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээлэл авах эрхийг хязгаарлахгүй.

Иргэн, байгууллага, албан тушаалтны үүрэг, туслалцаа /Хуулийн 26 дугаар зүйл/

¹⁵² Цагдаагийн албаны тухай хууль 2013.07.05

- Иргэн, байгууллага, албан тушаалтан нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн хууль ёсны ажиллагаанд саад учруулахгүй байх, өөрийн хэн болохыг тодорхойлсон буюу холбогдох баримт бичгийг шалгуулах үүрэгтэй.
- Иргэн, байгууллага, албан тушаалтан доор дурдсан чиглэлээр цагдаагийн байгууллагад туслалцаа үзүүлнэ:
 - гэмт хэрэг, зөрчил гарах нөхцөл бүрдүүлэхгүй байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
 - гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд оролцох;
 - гэмт хэрэг, зөрчил гарсан болон үйлдэхээр бэлтгэж байгаа, үйлдсэн этгээдийн талаар цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлэх;
 - гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх.
- Энэ хуулийн 26.2.2-т заасан ажиллагаанд идэвхтэй оролцсон иргэнд холбогдох хуульд заасны дагуу урамшил олгож болно.
- Иргэн, байгууллага, хамт олон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр хууль тогтоомжид заасны дагуу цагдаагийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж болно.
- Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Энэхүү хуулийн дээрх заалт нь Конвенцийн хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих чиглэлээр хангалттай хуульчилсан байна.

Цагдаагийн албаны тухай хуульд гэмт хэрэг, зөрчил гарсан болон үйлдэхээр бэлтгэж байгаа, үйлдсэн этгээдийн талаар цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх зэргээр иргэн, байгууллага, албан тушаалтны зүгээс цагдаагийн байгууллагад туслалцаа үзүүлэх талаар тусгаж, эдгээр үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон иргэнд холбогдох хуульд заасны дагуу урамшил олгож болохоор заасан байна /уг хуулийн 26.2.2, 26.3/. Авлигын гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, үйлдсэн этгээдийн талаар иргэн цагдаагийн байгууллагад хандалгүйгээр шууд АТГ-т мэдээлэл өгөх зэрэг Цагдаагийн албаны тухай хуульд заасан дээрх туслалцаа АТГ-т үзүүлсэн иргэнд АТГ урамшил олгох боломжийг Авлигын эсрэг хуульд тусгаагүй байна. Түүнчлэн татвар төлөхөөс зайлсхийх үйлдэл нь авлига, мөнгө угаах хэрэгтэй зарим тохиолдолд холбоотой байх магадлал өндөр тул татвар төлөхөөс зайлсхийсэн тухай мэдээлэл өгсөн иргэнийг ч урамшуулдаг байх зохицуулалтыг Татварын ерөнхий хууль, Гаалийн хуульд оруулсан байх нь хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих иглэлээр хангалттай хуульчилсан байх Конвенцийн 12.2.а-д заасан шаардлагыг бүрэн хангах ач холбогдолтой гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр зохих судалгаа хийх;
- Авлигын гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн этгээдийн талаар үнэн зөв, шуурхай мэдээлэл өгөх зэргээр авлигатай тэмцэх байгууллагад туслалцаа үзүүлсэн иргэнд урамшил олгож болох бүрэн эрхийг тус байгууллагад олгох чиглэлээр Авлигын эсрэг хуульд зохих нэмэлт оруулах;
- Дээрхтэй төсөөтэй зохицуулалтыг Гаалийн болон Татварын ерөнхий хуульд оруулах боломжийг судалж шийдвэрлэх.

АТГ-ын 2013 оны тайланд тус байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих чиглэлээр тодорхой ажил тусгагдаагүй байна. Харин “Авлигагүй эрүүл нийгмийн төлөө хамтдаа” сэдэвт үндэсний чуулганыг МҮХАҮТанхимын Үзэсгэлэнгийн Их танхимд зохион байгуулсан байна. Авлигагүй эрүүл бизнесийн орчинг бүрдүүлэхэд хувийн хэвшил иргэний нийгэм, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх, тэднийг дуу хоолой, хүчин чармайлтаа нэгтгэн хамтран ажиллахыг уриалах, авилгыг бууруулж таслан зогсооход хэрхэн хувь нэмрээ оруулах талаар хамтран ярилцаж, үндэсний хэмжээнд авлигыг бууруулах чиглэлээр сурталчлан таниулах зорилготойгоор болсон уг чуулганд МҮХАҮТанхим, Азийн сан, АТГ, Монгол дахь НҮБ, МОНПАК бүлэг Чуулганд Азийн сан, МҮХАҮТанхим, Танхимын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв, УИХ дахь МОНПАК бүлгийн ахлагч, УИХ-ын гишүүн Р. Бурмаа, ТЕГ, ГЕГ, УНДЕГазар, АОЭХолбоо, Бизнесийн зөвлөл, СЕО клуб, хувийн хэвшил иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлүүд оролцож, Монголд авлигыг хэрхэн бууруулах, харилцан ярилцах, мэдээллээ солилцох, цаашид хамтарч ажиллах санал санаачлага гарган тодорхой зөвлөмж гаргаж, холбогдох төрийн байгууллагад гардуулахаар болсон байна. Чуулганы үеэр УИХ-ын гишүүн, Монпак бүлгийн ахлагч Р.Бурмаа "Хүнд суртлыг ил тод байдлаар арилгана. Аливаа албан байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал шийдвэр нээлттэй ил тод байх ёстой. Шилэн дансны тухай хуулийн төсөл яригдаж байгааг мэдэж байгаа байх \энэ чуулганы дараа Шилэн дансны тухай хууль батлагдсан\ Хэрвээ тус хууль дэмжигдвэл мэдээлэл ил тод байхаас гадна татварын тайлан, тендерийн зарцуулалт гээд бүх зүйлийг ил тод болгоод өгнө. Ер нь Авлигын тухай хуулийн хариуцлага өндөр байх ёстой. Хэдхэн төгрөгийн торгуулийн хариуцлага нь үр дүнтэй механизм болж чаддаггүй. Үүний оронд төрийн албанд тангараг өргөн ажилласан төрийн албыг хувьдаа урвуулан ашигласан нь тогтоогдвол дахин төрийн албанд ажиллахгүй байхаар дүрэм журам тусгаж өгвөл илүү үр дүнтэй байна" гэв.

Мөн АТГ-ын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн дараг Б.Бат-Отгон: “Хувийн хэвшил, иргэний нийгэм, төрийн хамтын ажиллагаа шударга нийгмийг тогтооход авлигын эсрэг үйл ажиллагаанд ямар чухал вэ гэдэг талаар цуврал хэлэлцүүлгүүдийг бид өмнө нь зохион байгуулсан. Энэ удаагийн чуулганы гол зорилго бол авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг төрийн байгууллага, төрийн албан хаагчдад чиглэсэн сургалт гэж ойлгож болно. Гэхдээ дан ганц төрийн байгууллагад холбоотой бус авлигаас ангид байхад хувийн хэвшлийн оролцоо ч чухал байдгийг энэ удаа онцолж байгаа. Аливаа бизнес эрхлэгч үйл ажиллагаагаа явуулахдаа төрийн байгууллагатай байнга харилцаа үүсгэж байдаг. Тиймээс төрийн албан хаагчид хүнд сурталтай байна, хээл хахууль нэхэж байна, авлигад өртөмтгий байна гэсэн шүүмжлэл гаргаад байдаг хувийн хэвшлийнхэн өөрсдөө авлигын эсрэг санаачлагатай ажиллах, шаардлагатай” гэжээ¹⁵³. Бид энэхүү судалгааны явцад Сангийн яам болон Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын тайлангаас аудиторчид авлигын хэрэг гарсан байж болзошгүй нөхцөл байдлын талаар мэдээлж байсан эсэх талаар мэдээлэл хайсан боловч тайлангууд нь олдоогүй. **Хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн хэвшлийн байгууллага хоорондын авлигын эсрэг хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих чиглэлээрх ажил практик дээр эхлэлийн төдий байна.**

- Тангараг өргөсөн төрийн албан хаагч төрийн албыг хувьдаа урвуулан ашигласан нь тогтоогдвол дахин төрийн албанд ажиллуулахгүй байх зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмж оруулах
- Шударга нийгмийг тогтоох, авлигын эсрэг үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийг оролцоог өргөжүүлэх талаар АТГ-аас гадна ТЕГ, ҮТЕГ, ГЕГ, УНДЕГазар зэрэг холбогдох төрийн байгууллагуудыг татан оролцуулж, үндэсний зөвшилцлөлийг бий болгох;
- Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд, банк санхүүгийн байгууллагуудыг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд түлхүү оролцуулах чиглэлээр АТГ нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж, Компанийн засаглалын кодекс зэрэг зохистой засаглалыг дэмжсэн бодлогын баримт бичигт энэ зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал солилцох, ажил хэрэг болгох;
- Төрийн албан хаагчид хүнд сурталтай байна, хээл хахууль нэхэж байна, авлигад өртөмтгий байна гэсэн шүүмжлэл гаргаад байдаг хувийн хэвшлийнхэн өөрсдөө авлигын эсрэг санаачлагатай ажиллах, шаардлагатайг өргөнөөр сурталчлах.

8.2. (b)хувийн холбогдох байгууллагуудын үнэнч шударга байдлыг хамгаалахад чиглэсэн стандарт, журам, түүний дотор бизнесийн болон холбогдох бусад мэргэжлийн төлөөлөгчдийн үйл ажиллагааг зөв, нэр төртэй, зохистойгоор явуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнчлэн аж ахуйн нэгж хоорондын болон тэдгээрийн гэрээний

¹⁵³ <http://politics.news.mn/content/183216.shtml>-Авлигын хариуцлага өндөр байх ёстой

журмаар төртэй харилцах бизнесийн сайн дадлыг хэвшүүлэн хэрэглэхийг дэмжихэд чиглэсэн ёс зүйн дүрэм боловсруулахыг хөхиүлэн дэмжих;
/Конвенцийн 12.2.b/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Компанийн тухай хуульд ¹⁵⁴ зааснаар Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах /83.6./ бөгөөд компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна. /83.1, 83.8/ Мөн Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал, эсхүл гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн гишүүн нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно гэж заасан байна. /83.5/ Мөн Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. /84.1/ Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна. /84.2/ Тус эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

- хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;
- үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;
- компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;
- шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх;
- өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;
- компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

Түүнчлэн Компанийн тухай хуулийн 12-р бүлэгт сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх журмыг тодорхойлсон байна. Энэ нь **Компанийн тухай хуульд хувийн байгууллагуудын удирдах албан тушаалтан ажил үүргээ зохих зөвшөөрлийн дагуу үнэнч шударгаар биелүүлэх нөхцлийг хуульчилсан гэж үзэж байна. Гэвч хуульд “үнэнч шударгаар” гэдэг үг шууд тусгаагүй байгаад бид шүүмжлэлтэй хандаж байна.**

¹⁵⁴ Компанийн тухай хууль 2011.10.06

Компанийн засаглалын кодекст¹⁵⁵ Гүйцэтгэх удирдлага ба удирдлагын багийн гишүүд компанийн төлөө үнэнч шударгаар ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана /6.1.3/ гэж заасан нь нь компанийн удирдлага нь төрийн ашиг сонирхолыг харгалзан үйл ажиллагаагаа удирдана гэдгийг тодорхойлсон боловч “төртэй харилцах бизнесийн сайн дадал” гэж юу болохыг тодорхойлсон хэрэг биш юм.

Ёс зүйн дүрмийг боловсруулахыг хөхиүлэн дэмжих чиглэлээр Аудитын тухай хуульд¹⁵⁶ Мэргэшсэн нягтлан бодогч ёс зүйн дүрэмтэй байна. /15.3./ Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд¹⁵⁷ Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага үнэлгээчний ёс зүйн дүрмийг баталж, мөрдүүлнэ. Үнэлгээчний ёс зүйн дүрэм нь олон улсын үнэлгээний стандартад нийцсэн байна. /12.1, 12.2/ Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд¹⁵⁸ Татварын мэргэшсэн зөвлөх нь татварын мэргэшсэн зөвлөхийн ёс зүйн дүрмийг мөрдөх үүрэгтэй. /16.1.6./ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд¹⁵⁹ Монгол Улсын үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагын бүрэн эрхийг Хороонд бүртгүүлсэн хуулийн этгээд хэрэгжүүлнэ. /69.1/ Энэхүү байгууллага нь зохицуулалттай хуулийн этгээд болон энэ хуулийн 35.1-д заасан эрх авсан мэргэжилтнүүдээс бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий мэргэжлийн холбоо, хөрөнгийн бирж, үнэт цаасны тооцооны байгууллага болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага байна. /69.2/ мөн Бакны тухай хуулиар банкны ТУЗ-ын гишүүн, гүйцэтгэх удирдлага, Монголбанкны ажилтанд ёс зүйн шаардлага тавьсан зэргээр тус тус хуульчилсан нь эдгээр хуулиудын хүрээнд Конвенцийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж байна гэж үзэж байна.

Хуульд заасны дагуу Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн ёс зүйн дүрмийг Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институт, Татварын мэргэшсэн зөвлөхийн ёс зүйн дүрмийг Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн удирдах зөвлөлөөс тус тус баталжээ. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу байгуулагдсан Арилжаа эрхлэгчдийн холбоо нь гишүүдийнхээ ёс зүйн дүрмийг шинэчлэхээр ажиллаж байгаа юм байна.

Компанийн засаглалын кодексийн “оролцогч талууд” гэсэн 10 дугаар бүлэгт төрийн тухай тусгаагүй байгаад бид шүүмжлэлтэй хандаж байна.

ЗӨВЛӨМЖ:

¹⁵⁵ Компанийн засаглалын кодекст 2014.05.07

¹⁵⁶ Аудитын тухай хууль 1997.05.01

¹⁵⁷ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль 2010.01.21

¹⁵⁸ Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль 2012.12.27

¹⁵⁹ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013.05.24

- Компанийн эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаагаа “үнэнч, шударгаар” явуулах чиглэлээр Компанийн тухай хуульд тодорхой заах. Эхний ээлжинд Компанийн засаглалын кодексийн тав, зуравдугаар бүлэгт оруулах чиглэлээр АТГ-ыг зүгээс СЗХ-той зөвлөлдөх, зохих арга хэмжээ авах, Монголбанктай ч энэ чиглэлээр хамтран ажиллах
- Компанийн засаглалын кодекс, Банкны салбарын компанийн засаглалын баримт бичигт хувийн байгууллагуудын төртэй харилцах бизнесийн сайн дадлын талаар илүү тодорхой тусгах, энэ талаар OECD-ийн зарчмыг судалж нэвтрүүлэх

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Компанийн засаглалын үнэлгээний 2011 оны тайлангаас¹⁶⁰:
 - *IFC болон Компанийн засаглалын хөгжлийн төвөөс хийсэн үнэлгээнд Монголын хөрөнгийн биржийн TOP 20 индекст багтсан 20 компанийг хамруулсан бөгөөд ерөнхий үнэлгээгээр Монгол Улс нийт 100 оноо авахаас ерөнхий дундаж буюу 27,5% оноог авсан нь компанийн сайн засаглалын хэрэгжилтийг хангахын тулд их зүйлийг хийх шаардлагатай ба компанийн засаглалын асуудал Монгол Улсын хувьд эхний шатанд байгаа, сайжруулах хэрэгтэйг харуулж байна гэж үзсэн.*
 - Компанийн засаглалын үнэлгээг үндэслэн дараах зөвлөмжийг өгсөн байна.
КЗ-ын хөгжил нь онолоос практикт, “ярианаас үйл ажиллагаанд” шилжих замаар явах шаардлагатай бөгөөд анхны алхамуудыг хэрэгжүүлэхдээ дараах дөрвөн чухал асуудалд анхаарал төвлөрүүлэх:

- ✓ Энэхүү тайланг компаниуд, зөвлөхүүд, худалдааны танхим, зохицуулагчид болон сонирхож байгаа бусад оролцогчид эсвэл компанийн сайн засаглалын үр шимийг хүртэгчдийн өргөн хүрээнд танилцуулан сурталчлах, оролцогч бүх талуудад компанийн сайн засаглалын гүнзгийрүүлсэн сургалт зохион явуулахыг зөвлөмж болгож байна.
- ✓ КЗ-тай холбогдол бүхий хууль тогтоомж, зохицуулалтуудын уялдаа нийцлийг боловсронгуй болгох ба наад зах нь бүх хууль тогтоомж, дүрэм журмыг сахин мөрддөг болох
- ✓ Нээлттэй, тл тод байдлыг бүрэн утгаар нь хангах явдлыг дэмжих үүднээс үүнтэй холбогдсон бодлого, үйл ажиллагаа, материалуудыг боловсруулан гаргах. Энэ нь компанийн засаглалын өмнө нь баримталж ирсэн арга барилд гүн шингэсэн байдлыг өөрчлөхөд чиглэгдэх бөгөөд хялбар ажил биш юм. Нээлттэй ил тод байдлыг ихээхэн хэмжээгээр хэрэгжүүлж чадсанаар бизнест ямар нэг хохирол учруулахгүй гэдгийг бодитойгоор харуулах шаардлагатай.

¹⁶⁰ Компанийн засаглалын үнэлгээний 2011 оны тайлан

- ✓ Компанийн бүтэц, бодлого болон үйл ажиллагааны журмыг тодорхой болгох замаар ТУЗ-ын хүлээсэн үүрэг хариуцлагыг бүрэн хэрэгжүүлэх. Үүнд хувь хүн бүрийн нөлөө чухал ба Монголын бизнесийн удирдагчдын оролцоо, чин эрмэлзэл нэн чухал ач холбогдолтой байх болно.


Нэн түрүүнд чухалчлан авч үзэх тодорхой асуудлууд

Хууль тогтоомж болон зохицуулалт

- ✓ Компанийн дүрэм нь компанийн тухай хуулийн заалтуудаар тавигдаж байгаа шаардлагыг ямар нэг хэмжээгээр бууруулах эсвэл хасаж үл болохыг баталгаажуулах
- ✓ Компанийн засаглалыг бодитой хэрэгжүүлэх чадварийг баталгаажуулах үүднээс компанийн засаглалын мониторинг болон эрх мэдэл, хүч бололцоо авах хориг арга хэмжээг өргөжүүлэн тодорхой болгох
- ✓ Компанийн засаглалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль тогтоомж болон зохицуулалтын шаардлагуудыг бодитой, нүдэнд харагдахуйц, тайлагнах боломжтой байдлаар сахин мөрдүүлэхийг Зохицуулалт хариуцсан байгууллага хариуцахыг баталгаажуулах

Компанийн засаглалын үнэлгээний 2011-д дурдсанаас үзвэл, ёс зүй, хариуцлагын хувьд:

Компаниараа сайн иргэн байхад компанийн үүрэг улам бүр чухлаар тавигдах болж байна. Компани нь ажиллагсад, захиралууд болон гүйцэтгэх удирдлагын дагаж мөрдөх ёс зүйн кодекстой байх бөгөөд энэ нь компанид ажиллаж байгаа хүмүүс өөрсдийн үйл ажиллагаа болон компанийн нэрийн өмнөөс явуулах бизнесийг хэрхэн яаж явуулахыг тодорхойлдог. Ёс зүйн кодекс нь компанид ажиллаж байгаа хүмүүс компанийн нэр хүндийг хэрхэн хамгаалах чиглэл нь болдог.



В.8 Ажиллагсадын дагаж мөрдөх Ёс зүйн/үйл ажиллагааны бичмэл Кодекс компанид байна уу?

В.9 захиралууд болон удирдлагын дагаж мөрдөх Ёс зүйн кодекс компанид байна уу?

В.10 Ёс зүйн кодексийг хэрэгжүүлж байгааг нотлох баримт байна уу?

В.11 Компанид авлигал/хээль хахуультай тэмцэх бодлого болон хөтөлбөр байна уу?

В.12 компанид илэрсэн хууль бус болон ёс зүйгүй үйлдлийн талаар ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэх механикм байна уу? гэсэн асуудлаар судлахад:

Судалгаанд хамрагдсан TOP 20 индекст хамрагдсан компаниудын 85% Ёс зүйн кодексыг танилцуулаагүй ба зарим компанийн Ёс зүйн кодексыг үзэхээр хандахад /В.8/ нэвтрэх вебсайт нь ажиллахгүй байна. Олонхи компани Ёс зүйн кодексыг захирлууд, ахлах удирдлага болон ажиллагсад даган мөрдөх эсэх талаар тодорхой мэдээлэл өгөөгүй /В.9/. Түүнчлэн нийт тохиолдлын 99%-д Ёс зүйн кодексийг хэрхэн хэрэгжүүлдэгийг нотлох баримт туйлын хангалтгүй байна.

Судалгаанд хамрагдсан компаниуд авлигатай тэмцэх сайн бодлого, механизмгүй /В.11 ба В.12/ байсан ба ёс зүйтэй холбогдсон асуудлаар өгсөн өгөгдлүүд нь туйлын хангалтгүй байв. Хэрэв тийм бодлого, механизмтай байсан бол авлигатай тэмцэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хэвлэл мэлээлэл болон нийтлэсэн баримт бичгүүдэд дурдсан байх ёстой ба ёс зүйн кодекстой байгаа болон ёс зүйн сургалтад бүх хүмүүсийг хамруулсан талаар баримт нотолгоо байх ёстой юм. **Авлигатай тэмцэх идэвхитэй үйл ажиллагаа явуулахын тулд хууль бус болон ёс зүйгүй үйлдлийн талаар компанид мэдээлэл хүргэх боломжийг хангах ТУЗ болон аудитын хороотой харилцан итгэмжлэгдсэн механизмтай байх ёстой. Олон компаниуд болон улс оронд шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн “аюулгүй байдлыг нь хамгаалах” болон тэдэнд баталгаа өгөх “мэдээлэгч” механизмтай байх шаардлага тавьдаг.**

- **Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааны тайлангаас:**

Танай байгууллага авлигатай тэмцэх ямар нэг бодлогын баримт дүрэм журамтай юу? гэсэн санал асуулгад доорх байдлаар хариулсан байна.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
12 сар 2012	9,7%	74,8%	15,5%
5 сар 2013	14,2%	70,6%	15,2%
10 сар 2013	19,4%	73,6%	7,0%

Авлигатай тэмцэх ямар нэг бодлогын баримт дүрэм журам баталж мөрдүүлсэн гэсэн хариулт 2012 оны 12 дугаар сард 9.7 хувьтай байсан бол 2013 оны 10 сард 19,9 хувьд хүрсэн нь зохих ахиц ажиглагдаж байгааг харуулав.

Авлигыг бууруулах хамгийн шилдэг гурван аргын дотор “бизнесээ шударгаар явуулах” нь хамгийн шилдэг арга замд тооцогдоно гэснийг судалгаанд оролцогчдын 60 хувь дэмжсэн болно. Үүний эсрэгээр “хахууль хэдийд ч өгөхгүй байх” болон “төр засгийн байгууллагад байгаа авлигыг зохих албан тушаалтанд мэдэгдэх” гэдэг арга зам дэмжлэг авахгүй байна. “Хахууль өгөхгүй байх”-ыг 2012

оны 12 дугаар сард 34.2 хувь нь дэмжиж байсан бол 2013 оны 10 дугаар сард 27.9 хувийн дэмжлэг авав. “зохих албан тушаалтанд мэдэгдэх” 10 дугаар бард дөнгөж 17.3 хувийн дэмжлэг авав. Судалгаанд оролцогчид (21.2 хувь) хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж мэдээлэл өгөх нь илүү үр түнтэй гэж үзэх болов. “авлигад автагдсан албан тушаалтны эсрэг компанит ажил явуулах” гэсэн арга мөн илүү дэмжигдэж одоо оролцогчдын 33.6 хувийн дэмжлэг авав. Энэ үзүүлэлт 2013 оны 5 дугаар сараас хойш ийнхүү сайжирсан нь 2012 оны УИХ-ын сонгууль болон 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой байж болох юм. \24-р хуудас\

- **Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангаас¹⁶¹:**

Олон улсын бизнесийн ажиллагаанд гадаадын албаны хүмүүсийг хахуульдахын эсрэг тэмцэх тухай OECD-ийн 1997 оны конвенцид дэлхийн 40-өөд орон /Япон, Солонгос зэрэг/ нэгдэн орсон байна. Энэхүү Конвенцийн нэгдэн орох нь OECD-тай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нэгэн чухал чиглэл бөгөөд авлигын эсрэг тусламж дэмжлэг авахад тус дэмтэй.

Монгол Улсын гадаад эдийн засгийн харилцаа өргөжиж, худалдаа хөрөнгө оруулалт нэн өсч байгаа нь олон улсын бизнесийн хүрээнд гадаадын албан тушаалтантай холбогдох авлигын эрсдэл манай оронд улам өндөр байх магадлалыг лавшруулж байгааг бодолцон тус конвенцид элсэх талаар шуурхай ажиллах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

- Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагууд, Татварын мэргэшсэн зөвлөхүүдийн байгууллага, Арилжаа эрхлэгчдийн холбоо, Банкуудын холбоо зэрэг ёс зүйн дүрэмтэй байгууллагууд ёс зүйн дүрмийн хэрэгжилт, дүрмээ зөрчсөнд хүлээлгэх хариуцлагын талаар цахим хуудсандаа тогтмол мэдээлж хэвшүүлэх
- Хувийн байгууллагуудын төртэй харилцах бизнесийн сайн дадлын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх
- Тодорхой мэргэжлийн хүрээний ёс зүйн дүрэмд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой тусгах
- Хувийн хэвшил түүний дотор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн авлигаас урьдчилан сэргийлэх бодлогын талаар мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, тийм бодлого боловсруулж мөрдөх явдлыг хөхиүлэн дэмжих
- Энэ чиглэлээр Авлигатай тэмцэх газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж Компанийн засаглалын кодекст нэмэлт оруулж төртэй харилцах сайн дадал, авлигатай тэмцэх бодлогын талаар тодорхой тусгах

¹⁶¹ Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангын 11-р хуудас

8.2. (с) хувийн байгууллагуудын дунд ил тод байдлыг хөхиүлэн дэмжих, түүний дотор зохих тохиолдолд компани, аж ахуйн нэгж байгуулж, удирдахтай холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг ялгаж тогтоох арга хэмжээ; /Конвенцийн 12.2.с/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Компанийн ялангуяа хувьцаат компанийн ил тод байдлыг **Компанийн тухай хуулиар**¹⁶² Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад тогтоосон хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй. /95.2/ компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах үүрэгтэй байхаар заасан байна. /79.3.2./ **Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар**¹⁶³ Хөрөнгийн бирж нь үнэт цаасны арилжааг тогтоосон хугацаанд тасралтгүй, ил тод, алдаагүй, шударгаар зохион байгуулах, шаардлагатай бэлтгэлийг өөрийн эх үүсвэрээр бүрэн хангах үүрэгтэй. /49.1.6./ Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаасны зах зээлд шударга, үр ашигтай, өрсөлдөөн бүхий, ил тод байдлыг хэвшүүлэхэд шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авах, үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааны шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах чиглэлээр зөвлөмж гаргах бүрэн эрхтэй /63.1.4, 65.1.2/ байхаар хуульчилсан байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2013.12.12-ны 505 дугаар тогтоолоор **“Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”**-ыг баталсан. Энэхүү журмын зорилго нь үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчидэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулахад орших бөгөөд үнэт гаргагч нь нийтэд хагас жил, жилийн эцсийн байдлаар болон тогтмол нээлттэй мэдээллэхээр Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хороо болон хөрөнгийн биржийн холбогдох журамд заасан аливаа мэдээллийг цаг тухайд нь нэгэн зэрэг, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй гэж заасан байна /1.1, 1.2/. **Банкны тухай хуулийн** 38 дугаар зүйлд зааснаар Банк нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын дотор, аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлдэг байхаас гадна дараахь мэдээллийг нийтлэх, **өөрийн цахим хуудсанд байрлуулах** зэргээр шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор нийтэд мэдээлэх үүрэгтэй:

- банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагын гарын үсгээр баталгаажуулсан ажлын тайлан;
- хуулийн этгээдийн зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн;

¹⁶² Компанийн тухай хууль 2011.10.06

¹⁶³ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013.05.24

- санхүү, бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналт;
- нөлөө бүхий /энгийн хувьцааны 5-аас дээш хувь/ хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, түүний орлогч, ерөнхий нягтлан бодогч, банкны нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүдийн нэр;
- банкиг өөрчлөн байгуулах хэлбэр, хугацаа, хэрэгжүүлэх арга, шинээр үүсэх хуулийн этгээдийн зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр, байршил, банкны эрхлэх үйл ажиллагааны төрөл, санхүүгийн үйл ажиллагааны үндсэн баримтын тухай;
- банкны холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээ; банкны эрсдэлийг тодорхойлоход шаардлагатай гэж Монголбанкнаас үзсэн бусад мэдээлэл¹⁶⁴.

Дээрхээс үзвэл **хувийн байгууллагуудын ил тод байдлыг хөхиүлэн дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр тодорхой алхам хийгдэж байна. Компанийн тухай хуульд**¹⁶⁵ Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээх бөгөөд Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй. Мөн хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэж заасан байна. /9.1, 9.2, 9.3/. Энэ нь компани, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагатай холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн хариуцлагыг ялгаж тодорхойлсон явдал юм. Мөн тус хуульд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна /Хуулийн 9.4/. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна. /Хуулийн 9.5/ хэмээн заасан нь буруутай үйл ажиллагаа явуулсан, компанийн болон өөрийн эд хөрөнгийг зааглаагүй хувьцаа эзэмшигчийн өөрийн бүх хөрөнгөөр компанийн өр төлбөрийг хариуцах үүргийг тодорхойлсон. Энд “Буруутай үйл ажиллагаа” гэдэгт авлига өгөх явдал мөн хамаарна гэж үзэж байна. Иймд Компанийн тухай хуулийн 9.4, 9.5-д заасныг зөрчиж, авлига өгсөн, авсан компанийн удирдлага, хувьцаа эзэмшигч нь компанийн өр төлбөрийг ч өөрийн хувийн хөрөнгөөр хариуцах боломжийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

¹⁶⁴ <http://www.legalinfo.mn/law/details/108?lawid=108>- Банкны тухай хууль

¹⁶⁵ Компанийн тухай хууль 2011.10.06

ЗӨВЛӨМЖ:

- Хувийн байгууллагууд мэдээллээ ил тод болгохыг шаардсан зохицуулалт нилээд хуульд тусгагдсан боловч төрөөс “хөхиүлэн дэмжих” механизм тодорхой хуульчлагдаагүй байх тул хэрхэн хөхиүлэн дэмжих вэ гэдэг чиглэлд анхаарал хандуулах нь зүйтэй.
- Худалдан авах ажиллагаанд оролцох компаниудад “бага үнийн” шалгуур тавихаас илүүтэйгээр “хуулиар тогтоосон мэдээллээ ил тод болгосон, засаглал сайтай, биржид бүртгэлтэй” гэдэг шалгуурт давуу байдал олгосон зохицуулалтыг бий болгох нь авлигаас урьдчилан сэргийлэх чухал алхам болно. Тендерт гол төлөв ардаа “сайн авилгач мотортой” биржид бүртгэлгүй, гол нь санхүүгийн мэдээллээ ил тод болгох үүргийг хуулиар хүлээдэггүй ХХК оролцдог болохыг хэдийгээр бүх 272 барилга, объектын тендерийг авсан компаниудын мэдээлэл хэвлэлээр бүрэн хэмжээнд цацагдаагүй ч “дуусаагүй барилгын” гэх дуулианд холбогдсон компаниуд дотор биржид бүртгэлтэй, TOP 20 индекст багтсан компанийн нэр сонсогдохгүй байгаагаар нотлогдох талтай байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Монголын хөрөнгийн биржийн тайлан олдоогүй.
- **Компанийн засаглалын үнэлгээний тайлан 2011-ээс:**¹⁶⁶

ОЕСД Зарчим V ба Хэсэг Г – нээлттэй ил тод байдал

Компанийн засаглалын бүтэц нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, өмчлөл, засаглалтай холбоотой бүх материалыг цаг хугацаанд нь үнэн зөв нийтэд нээлттэй байлгана. Энэхүү нийтэд нээлттэй байх мэдээлэл дараах мэдээлэл материал хамрагдах ба гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.

1. Компанийн санхүү болон үйл ажиллагааны үр дүн, Компанийн зорилт
2. Гол гол хувьцаа өмчлөгчид болон санал өгөх эрх
3. ТУЗ-ын гишүүд болон гүйцэтгэх албан тушаалын цалин урамшууллын бодлого
4. Нэгдмэл сонирхолтой этгээдийн үйл ажиллагаа
5. Төсөөлөх боломжтой эрсдлийн хүчин зүйлүүд
6. Ажиллагсад болон бусад оролцогч талуудтай холбоотой асуудлууд
7. Засаглалын бүтэц, бодлого, ялангуяа компанийн засаглалын кодексийн агуулга буюу хэрэгжүүлж байгаа бодлого, хэрэгжилтийн үйл явц

Одоогийн болон ирээдүйн эзэмшигчид нь өөрсдийн болон өмчлөлийн бүрэн эрх төгс мэдээллийн үндсэн дээр хэрэгжүүлэхийн тулд тогтмол, үнэн зөв, харьцуулж болох аль болох тодорхой мэдээлэл авах шаардлагатай. Мэдээллийн нээлттэй

¹⁶⁶ Компанийн засаглалын үнэлгээний тайлан 2011, 55-р хуудас

байдлыг хангах дэглэм нь ил тод байдлыг хангах үндэс суурь бөгөөд тэр утгаараа зах зээлд итгэл төрүүлэх зах зээлийн нэн чухал хүчин зүйл юм. Компаниуд болон зохицуулагчид тийм учраас “юуг нээлттэй мэдээлэх ёстой вэ” гэж асуудаг. Хэрэглэгчид эдийн засгийн шийдвэр гаргахад хэрэгтэй бүх мэдээлэл нээлттэй байх шаардлагатай. Мэдээлэл бол шийдвэр гаргахад нөлөөлдөг үндсэн материал учир хагас дутуу эсвэл буруу байвал шууд нөлөөлнө. Үндсэн хүчин зүйлүүдийг нээлттэй болгох олон янзын хэрэгсэл зохицуулагчид байдаг. Гэхдээ, хуульд заасан хэмжээнд мэдээллийг нээлттэй болгоно гэдэг бол хамгийн наад захын шаардлагыг биелүүлж байгаа хэрэг. Энэ бол дэлхийн олон компаниудын хувьд зөвлөмж болгох сайн арга зам биш бөгөөд ердийн практикт компаниуд үүнээс илүү мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй байлгадаг.

Компаниуд хөрөнгө босгохын тулд хөрөнгө оруулагчдын итгэлийг олох явдал туйлын чухал учир хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон вэбсайтаар дамжуулан мэдээллийн ил тод байдлыг хангах нь чухал байдаг юм. Хөрөнгө оруулагчид өндөр түвшинд бэлтгэгдсэн мэдээллийг компаниудаас авч чадсанаар компаниуд өртөг багатай хөрөнгө оруулалт татах боломж нь нээгдэнэ. Ил тод байдлыг бодитой хэрэгжүүлж чадах хүчтэй дэг журам нь компаниудад зах зээлд суурилсан хяналт тавих боломжийг харуулах ба хувьцаа эзэмшигчдийн хувьд мэдээллийн үндсэн дээр эрхээ хэрэгжүүлэх боломжтой байдаг. **Компани өөрсдийн нээлттэй мэдээлэх бодлогыг боловсруулж, нийтийн хүртээл болгон нийтлэх хэрэгтэй ба ингэснээр мэдээллийг нээлттэй байлгахар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж байгааг харуулахаас гадна хувьцаа эзэмшигчид болон зах зээлд оролцогсдыг байнгын мэдээллээр хангаж байгаа явдал юм.**

Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг зохих түвшинд хангах асуудал Монголын компаниудын хувьд норм болон хэвшээгүй байна.

Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах шаардлага Монголын хууль тогтоомжид тусгагдсан байдаг, тухайлбал Компанийн тухай хууль, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журам, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн стандарт зэргийг дурдаж болно. Түүнчлэн, компанийн засаглалын тухай Монголын кодекст энэ талаар баримтлах тэргүүн туршлагатай холбогдсон хэд хэдэн зөвлөмж орсон. Энэ бүх хэрэгслүүд нь нээлттэй байдлыг хангах шаардлагын цогц бүрдэл бөгөөд энэ нь дийлэнх улс оронд мөрдөгддөг.

Хүснэгт 16. Нээлттэй, ил тод байдлыг хангах шаардлагын хэрэгжилт

хэмжүүр	оноо %
Энэ хэсгийн авч болох дээд оноо	30.00
Дээд зэргийн хэрэгжилт*	11.73
Доод хэрэгжилт*	1.77
Дундаж*	5.40

Дээрхи хүснэгтээс харахад Монголд нээлттэй, ил тод байдлыг хангах хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүний тод илэрхийлэл бол боломжит 30%-ийн дундаж оноо дөнгөж 5.4% байгаа үзүүлэлт юм. **Компаниуд ер нь мэдээллийг хамгийн бага, олонх тохиолдолд хуульд заасан**

шаардлагад хүрэхгүй хэмжээнд өгч байна. Тийм учраас, наад зах нь хуульд заасан шаардлагыг хангах үүднээс компаниудад зориулсан хяналтын хуудас (checklist) боловсруулан гаргах нь зүйтэй болов уу.

Үнэлгээний 32 асуулт нь энэ хэсэгт холбоотой гол гол асуудлуудыг хамруулсан, тухайлбал, Жилийн тайлан, компанийн вэбсайтын чанар болон агуулга, гол гол асуудлын мэдээллийг нээлттэй болгох- аудитор болон аудитын тайлан, мөн том хувьцаа эзэмшигчид ба нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл, компанийн бодлого болон үйл ажиллагаа орж байгаа юм.

Одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээллийн гол эх сурвалж нь ХЭХ (энэ талаар А хэсэгт авч үзсэн) болон жилийн ажлын тайлан, компанийн вэбсайт бөгөөд эдгээр материаллаг цогцоороо хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудад бүх материаллаг болон холбогдох мэдээллийг өгч чадна.

Гэхдээ, дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн жилийн тайлан байхгүй үед, мэдээллийн нээлттэй байдлыг хангах одоогийн дэглэм тохиромжтой арга барил биш гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Хөрөнгө оруулагчид холбогдох материалыг цуглуулан, тороор шүүрдэн ялгаж мэдээлэл авч цаг заваа зарцуулахгүй бөгөөд судалгааны багынхан ийм маягаар ажлаа гүйцэтгэсэн юм.

Монголд компанийн засаглалын тухай ойлголтыг зөвхөн компанийн засаглалын гол тоглогчид (захирлууд, хувьцаа эзэмшигчид болон зохицуулагчид) төдийгүй, бусад нөлөөлөгчдийн хувьд (хэвлэл, мэдээлэл аудиторууд, хувьцаа эзэмшигч бүлгүүд) гүнзгийрүүлэх хэрэгтэй. Бүх бүлэг бүрт тохирсон сургалт явуулахыг зөвлөмж болгож байна.

Компанийн захирлууд нь өөрсдийн үүрэг хариуцлагыг ухамсарлаж, ТУЗ-ын сайн бодлого, практикийг олж илрүүлэн нэвтрүүлэх чадвартай байх ёстой. Зохицуулагчид нэгэнт олгогдсон эрх мэдэлтэй, зохих хориг арга хэмжээ авах эрхтэй учир компанийн засаглалын эрх зүй, зохицуулалтын тавигдаж байгаа шаардлагын хэрэгжилтэд үр дүнтэй, нүдэнд үзэгдэхүйц мониторинг хийж, хяналт тавихын чухлыг ухамсарлах хэрэгтэй. Бусад орны хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг хэрэгжүүлэхэд авч байгаа арга хэмжээний талаар зохицуулагчид илүү сайн мэдлэгтэй байх шаардлагатай. Тухайлбал, **компанийн засаглалтай холбоо бүхий ямар нэг асуудал гарлаа гэхэд түүнийг зохих ёсоор мэдээлэх хэвлэл мэдээллийн чадавхийг бэхжүүлэх сургалт зохион явуулахыг зөвлөмж болгож байна.** Хувьцаа эзэмшигчид өөрсдийн үндсэн эрх, тэдгээр эрхээ бодитой хэрэгжүүлэх талаар илүү сайн мэдлэгтэй байх хэрэлтэй.

Сургалтын хөтөлбөр боловсруулах өргөн боломж Монголын КЗХТ, Худалдааны танхим бизнесийн холбоод, ТТБ болон ОУСК-д байна.

1. Хууль тогтоомж болон зохицуулалтын хүрээнд заавал дагаж мөрдөх тодорхой асуудлуудыг зарим үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахгүй байгаа ба ямар ч байсан хөндлөнгийн ажиглагчийн үзэж байгаагаар тэр бүр дагаж мөрдөхгүй байна. Хууль тогтоомжийг дагаж төрдөх явдлыг сайжруулах, КЗ-ын кодекс болон компанийн тухай хуулийн заалтыг заавал ягштал дагаж мөрдөх шаардлагатай байна. Жишээ нь хоёр компани хуульд заасан хугацаанд ХЭХ-ыг зарлан хуралдуулаагүй байна. Хуулийг

практикт хэрэгжүүлээгүй энэ зөрчилд зохицуулалтын ямар нэг арга болон санал авсан үр дүн нь тодорхойгүй байна. Зарим компани ХЭХ-ын хурлын тэмдэглэл болон санал хураалтын явцын талаар тодорхой холбогдох баримт бичгийг бэлтгэхгүй эсвэл нийтэд мэдээлэхгүй байна. Олон тооны компани заавал гаргах ёстой улирлын тайланг гаргаж нийтлэхгүй байна.

Аудитын хуулийн дагуу компаниуд нь бие даасан аудитын тайлан гаргаж байх шаардлагатай. Гэхдээ, олонхи тохиолдолд, аудиторын хараат бус байдлыг төдийлөн авч үзэхгүй байна. Компанийн тухай хуулийн дагуу компаниуд нь сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн талаар баримтлах бодлого боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөх шаардлагатай. Судалгаанд хамрагдсан олонхи компани үүнийг дагаж мөрдөхгүй байна.

2011 оны байдлаар Компанийн засаглалын кодексийг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж байв. Энэ нь олонхи тохиолдолд, кодексийг хэрэгжүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн ба үүнтэй холбогдон ямар нэг тайлбар алга байна. Монголын Компанийн засаглалын кодекс “дотоод хяналтын журмыг баталж, хэрэгжүүлэх механизмтэй” байхыг ТУЗ-д зөвлөмж болгосон. Хэрэв тийм механизм, бодлоготой бол тэр нь компанийн баримт бичгээс харагдахгүй байна.

Компанийн засаглалыг сайжруулахад эерэг болон сөрөг хөшүүрэг бий болгоход зохицуулагчид болон хөрөнгийн бирж бодитой үүрэг гүйцэтгэнэ. Тэд компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх шаардлага тавьж, мөрдүүлэх ёстой. СЗХ-ны нэгж болох Компанийн засаглалын үндэсний Зөвлөл нь хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд, СЗХ болон МХБ-ийн КЗ-ын үйл ажиллагаанд анхаарал төвлөрүүлэн, хяналт тавьж, тавигдаж байгаа шаардлагыг хэрэгжүүлэх боломжтой.

Өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад өгч байгаа мэдээлэл нь ерөнхийдөө хагас дутуу эсвэл өнгөцхөн бэлтгэгдсэн эсвэл иж бүрэн нарийвчлал хомс байна. Компанийн тухай, түүний санхүүгийн байдал, гүйцэтгэл, өмчлөл болон засаглалтай холбогдсон материалыг цаг хугацаанд нь үнэн зөв гарган мэдээлж байх шаардлагатай. Санхүү болон санхүүгийн бус мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах асуудлыг сайжруулах шаардлагатай.

Судалгаанд хамрагдсан компаниудын хувьд мэдээлэл хаанаас авах, түүнд нь нэвтрэхэд хүндрэлтэй байсан ба энэ нь материалыг хэд хэдэн газраас цуглуулах шаардлага гарч байсантай холбоотой. Чанартай бэлтгэгдсэн, компанийн вэбсайтад байршуулсан мэдээлэл нь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад онцгой ач холбогдолтой ба сайн мэдээлэл нь компанийн хэмжээнд мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлнэ. Тийм мэдээлэл нь бусад улс оронд заавал дагаж мөрдөж байгаагийн адил Жилийн ажлын иж бүрэн тайлан орох бөгөөд түүнд санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэнд аудиторын шалгалтын тайлан, компанийн тодорхой стратеги, учирч байгаа бизнесийн эрсдэл, санхүүгийн завсрын мэдээлэл, компанийн КЗ-ын бүтцийг тайлбарласан компанийн засаглалын тайлан, компаниас КЗ-ын Кодексийн шаардлагыг ямар байдлаар нэвтрүүлж байгаа болон хэрэв КЗ-ын кодексийн заалтыг мөрдөөгүй бол бодитой тайлбарыг өгөх ёстой. Түүнчлэн, компанийн вэбсайтад байршуулсан

мэдээлэлд том хувьцаа эзэмшигчдийн талаархи иж бүрэн мэдээлэл болон компанийн засаглал, компани хувьцаа эзэмшигчдийн харилцаа, мэдээллийн нээлттэй байдлыг ханган түгээх, сонирхлын зөрчил болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл, дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцохтой холбогдсон компанийн бодлогыг хамруулан оруулна. Дэлхийн хэмжээнд чанартай сайн бэлтгэгдсэн гэж үзэх компанийн засаглалын тайлан ямар бүтэцтэй байгааг компани бүр судлан үзэж, захирлууд, хувьцаа эзэмшигчид болон боломж чавадхитай хувьцаа эзэмшигчдэд ижил төстэй нарийвчлалыг өгөх хэрэгтэй.

Компаниуд, компанийн ТУЗ, түүний хувь гишүүд, гүйцэтгэх удирдлага КЗ, мэдээллийн нээлттэй байдлыг хангах ажилдаа үнэлгээ хийж, шинэчлэлийн хөтөлбөр боловсруулах хэрэгтэй. Хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчид наад зах нь чанартай боловсруулсан жилийн тайлан, цаг үеийн мэдээллийг цаг хугацаанд нь технологийг буюу \компанийн вэбсайтыг ашиглан авч байх боломж олгохыг компаниас шаардах хэрэгтэй.

Монголын ТУЗ-ийн үйл ажиллагааг дэлхийн хэмжээнд тавигддаг ТУЗ-ийн үүрэг хариуцлагатай харьцуулж үзэхэд, Монгол дахиад л хоцорч явна. ТУЗ-ийн бүрэлдэхүүн, бүтэц, ТУЗ-ын бодлого, журам болон практик үйл ажиллагааны дэлхийн тэргүүн туршлагын нарийн ширийн зүйлийг Монголын ТУЗ мэдэх шаардлагатай. ТУЗ-ийн хороодын бүтцийн асуудал дээр хүлээх үүрэг хариуцлага нь компанийн гүйцэтгэх удирдлагаас өөр гэдгийг захирлууд тодорхой мэдэж байх шаардлагатай. **Тэд нар компанийн удирдагч гэдэг утгаараа компанийн сайн засаглал болон ёс зүйг эрхэмлэх “үлгэр дууриалыг дээрээс” тогтоон харуулах ёстой. Компани нь ёс зүйн кодексийг бүх захирлууд болон ахлах уридлагын түвшинд нэвтрүүлэн мөрдөж болно. Хараат бус захирлуудыг дэлхийн “хараат бус” тодорхойлолтын дагуу тодруулж, ТУЗ-д томилон ажиллуулах хэрэгтэй.** Хараат бус захирлууд нь “хараат бус”-аар үүрэг гүйцэтгэх талаар сургалтад хамрагдах шаардлагатай байж болно. Юуны өмнө компаниудад үр бүтээлтэй Аудитын Хороог байгуулж, түүний бүрэлдэхүүн, эрх мэдэл, үйл ажиллагааны хүрээг журмаар тогтоох шаардлагатай байна. Захирлууд, ялангуяа Аудитын хорооны гишүүд заавал санхүүгийн мэдлэгтэй байхыг анхааруулах нь зүйтэй.

ТУЗ нь компанийн засаглалын сайн туршлагын талаар мэдлэгтэй, ТУЗ-ийн үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах шаардлагатай. Компанийн сайн засаглал нь компанийн үйл ажиллагаа болон ажлын үр дүн сайн байхын түшиг тулгаар нь болно.

Энэхүү судалгааны явцад манай баг 2014 оны 7 дугаар сарын 8-нд Банкны тухай хуулийн дээр дурдсан “Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг нийтэд мэдээлэх” гэсэн 38 дугаар зүйлийн хэрэгжилтийн цахим хуулсанд суурилсан үнэлгээг Монголд үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа 12 банкинд хийхэд Капитрон банк банкнаас бусад нь 2014 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангаа цахим хуудсандаа байршуулсан, 7 банк /Эрэл банк, Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банк, Тээврийн хөгжлийн банк, Капитрон банк/ банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагын гарын үсгээр баталгаажуулсан ажлын тайлан/38.2.1./-гаа цахим хуудсандаа байршуулаагүй, харин хуулийн этгээдийн

зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний талаарх /38.2.2./ мэдээллээ бүх банкууд байршуулсан, Санхүү, бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналт /38.2.3./-ын талаарх мэдээллээ 3 банкнаас /Хаан банк, Эрэл банк, Тээврийн хөгжлийн банк/ бусад банк оруулсан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, түүний орлогч, ерөнхий нягтлан бодогч, банкны нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүдийн нэрсийг /38.2.4./ 3 банк \Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банк\ бүх мэдээллээ оруулсан байсан бол үлдсэн 9 банк Хяналтын зөвлөлийн гишүүдээс бусад мэдээллээ оруулсан байлаа. Мөн 6 банк /Хасбанк, Чингис хаан банк, Улаанбаатар банк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк/ банкны холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээ /38.2.6/-ний талаарх мэдээллээ байршуулсан бол бусад банкууд байршуулаагүй байлаа. Үүнээс үзвэл **банкууд мэдээллээ ил тод болгох хуулийн шаардлагыг харьцангуй сайн биелүүлж байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Компанийн засаглалын үнэлгээний тайланд тусгагдсан дүгнэлт, зөвлөмж бүрийг сайтар судалж, төр, хувийн хэвшлийн авлигын эсрэг хамтын ажиллагааны нэг хэлбэр болгон ашиглах
- АТГ-ын зүгээс хувийн хэвшлийн байгууллагуудын түвшинд авлигын эсрэг бодлогоо тодорхойлон мөрдөх явдлыг хэвлэл мэдээллээр сурталчлан таниулах зэргээр хөхиүлэн дэмжих
- Хувийн байгууллагууд, ялангуяа нийтийн ашиг сонирхолыг хөнддөг Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, банк, даатгалын зэрэг санхүүгийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангах талаар Авлигатай тэмцэх газрын зүгээс төрийн холбогдох байгууллага, эздийн холбоо зэрэг ТББ-тай хамтран ажиллах талаар хэлэлцэж, доривтой арга хэмжээ авах
- Дээрх чиглэлээр хөндлөнгийн үнэлгээ хийж дүнг нийтэд мэдээлж байх

8.2. (d)хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрлийн талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх; /Конвенцийн 12.2.d/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улс нь хувийн байгууллагуудын үйл ажиллагааг Компанийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудаар зохицуулдаг. Харин тус конвенцийн аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас татаас олгох чиглэлээр **Төсвийн тухай хуульд**¹⁶⁷ заасан. Уг хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон

¹⁶⁷ Төсвийн тухай хууль 2011.12.23

орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна. /3.1/ **Монгол Улсын засгийн газрын тухай хуульд**¹⁶⁸ зааснаар Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно. /19.1/ **Концессийн тухай хуулиар** төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр хөрөнгө оруулагчид олгох уралдаант шалгаруулалт явуулах, концессын гэрээ, түүнийг байгуулах, өөрчлөх, дуусгавар болгох, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. /1.1/ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад гол зорилго нь оршино. /1.1/ **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар** тус Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага /3.1.10/ нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд хамрагдаж тус хуульд заасан 4 чиглэлээр ил тод байдлыг хангаж ажиллахаар заасан нь хууль зүйн хувьд Конвенцийн заалтын шаардлагад нийцэж байна. Харин Конвенцийн тусгай зөвшөөрлийн талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх шаадлагын үүднээс **Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг** авч үзвэл уг хуулиар нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулах /1.1/ бөгөөд тусгай зөвшөөрлийн үйчлэх хүрээ, олгох сунгах хугацаа, журам, баримтлах зарчим, шаардлага, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл зэрэг тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүхий л харилцааг зохицуулсан байна. Уг **хуульд зааснаар төрийн холбогдох байгууллага 18 чиглэлээр, 90-ээд төрлийн тусгай зөвшөөрөл олгож байна.** татаас тусгай зөвшөөрлийг буруугаар ашиглаж нийтийн албан тушаалтан авлига авах зорилгоор хүнд суртал гаргах зэрэг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг **Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудаар зохицуулж байна. Энэ нь конвенцийн 12.2.d-д заасан шаардлагыг эрх зүйн орчны хувьд харгах зохих арга хэмжээ авсан гэж үзэх байна. Практикаас үзвэл хуулийн этгээдийн, эд хөрөнгийн, иргэний бүртгэл зэрэг хуульд зааснаар улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлага тавигддаг харилцаанд**

¹⁶⁸ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль 1993.05.06

бүртгэх байгууллагын ажилтны хүнд суртал, хээл хахуултай холбоотой асуудал зохих хувийг эзэлдэг гэж үзэж байна. Энэ нь 2013 оны 12 дугаар сард явуулсан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийн талаарх судалгаа”-гаар 2007 оны 3, 9 дгээр сар, 2008 оны 9 дүгээр сард бүртгэлийн алба “авлигад хамгийн их өртсөн” 5 салбарын 4 болон 5 дугаарт нэрлэгдсэнээр нотлогдож байна¹⁶⁹. Харамсалтай нь, “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаагаар хамгийн их авлигад өртөмтгий салбар гэдэгт төрийн үйлчилгээ 167.8 хувь “тодорсон” боловч тэдгээрийн дотроос төрийн чухам аль үйлчилгээ илүү их авлигад өртөмтгий болохыг бизнес эрхлэгчдээс тодруулж асуугаагүй байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын зүгээс Конвенцийн 12.2.d: “хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрлийн талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх” гэсний “тусгай зөвшөөрлийн” гэснийг “тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үйлчилгээний” гэж нэмэх саналыг гаргаж болох юм гэж үзэж байна. Түүнчлэн Компанийн тухай хуульд хувьцаат компанийн ТУЗ-ын гишүүн компанийн засаглалын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх авах тухай, мэргэжлийн оролцогч байгууллагын эрх бүхий албан тушаалтан Хорооноос зөвшөөрөл авсан байх тухай, Даатгалын тухай хуульд даатгалын компанийн эрх бүхий албан тушаалтан Хорооноос зөвшөөрөл авсан байх тухай зэрэг нилээдгүй олон хуульд төрийн байгууллагаас “зөвшөөрөл олгох”, “эрх, гэрчилгээ авах” зохицуулалт байдгийг ч Конвенцийн энэ заалтад нэмэх санал дэвшүүлж, зохих мониторинг, судалгаа хийх талаар анхаарахад буруудахгүй.

ЗӨВЛӨМЖ:

- Монгол Улсын зүгээс Конвенцийн 12.2.d: “хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрлийн талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх” гэсэн заалтыг “хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрөл, **зөвшөөрөл, эрх, гэрчилгээ, бүртгэлийн үйлчилгээний** талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх” гэж өөрчлөн найруулах саналыг гаргаж болох юм гэж үзэж байна
- Төрийн хөрөнгө, татаас ашиглах, тусгай зөвшөөрөл олгох явцад хүнд суртал, авлига гарахаас гадна төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, газар өмчлөх, эзэмших, ашиглах зөвшөөрөл авах, зөвшөөрөл, эрх, гэрчилгээ авахад мөн уг асуудал илэрдэг тул Конвенцийн хэрэгжилт болон дүгнэхэд уг асуудлыг нэмэх

¹⁶⁹2013 оны 12 дугаар сард явуулсан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийн талаарх судалгаа” –ны тайлангийн 16 дугаар хуудас

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулиар одоогийн байдлаар 18 төрлийн 90 чиглэлээр тусгай зөвшөөрөл олгож байна.
- **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангаас¹⁷⁰:**

Монгол Улсын Засгийн газар бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, төрийн оролцоог бизнесийн үйл ажиллагаанд зохистой түвшинд хүртэл бууруулах, эрх зүйн болон зохицуулалтын таатай нөхцөл бүрдүүлэх зорилгоор 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарласан бөгөөд энэхүү жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Ерөнхий сайдаар батлуулан мөрдөн ажилласан байна. Уг төлөвлөгөөний 4.3-т “Тусгай зөвшөөрөл, лиценз авахтай холбоотой дүрэм, журам, зааврыг цэгцлэх, 50 хүртэл хувиар цөөлөх үйл ажиллагааг төрийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түүнийг олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг хянан үзэж боловсронгуй болгох талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар захирамжаар байгуулж, ажлын хэсэгт төрийн захиргааны төв байгууллагын удирдах албан тушаалтны зэрэгцээ мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулжээ.

Энэ ажлын хүрээнд нийт **337** зөвшөөрлөөс Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан **39** тусгай зөвшөөрөл, бусад хуульд заасан **32** зөвшөөрөл, хуулиас бусад эрх зүйн актаар зохицуулсан **32** зөвшөөрөл, нийт **101** зөвшөөрлийг хүчингүй болгуулах тухай “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2010 оны 325 дугаар тогтоолыг батлуулсан байна.

Хүчингүй болгуулах шаардлагатай зөвшөөрлийг сонгохдоо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан “нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох”-оор заасныг болон мөн хуулийн 5.2-т “Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн бүртгэх байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно” гэж заасныг гол үзэл баримтлал болгосон байна. Мөн аливаа зөвшөөрөл, эрх зүйн акт нь хууль зүйн үндэслэлтэй эсэх, хууль тогтоомжид тусгайлан заасан эсэхийг гол шалгуур болгожээ.

Хүчингүй болгох зөвшөөрлүүдтэй холбогдуулан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг 21 хуулийн төслийг

¹⁷⁰ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлан

боловсруулж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна.

Мөн дээрх ажлын хүрээнд яам, агентлагуудаас санал авч нийт 10 зөвшөөрөл олгох ажлыг гэрээний үндсэн дээр мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр болсон ба хүчингүй болж байгаа зөвшөөрөлтэй холбоотой Засгийн газрын тогтоол болон тушаал, шийдвэрээ өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосон байна. 2012 онд байгуулагдсан Шинэчлэлийн засгийн газрын зүгээс барига барихад авдаг олон зөвшөөрөл, гарын үсгийг цөөлөх чиглэлэд томоохон алхам хийсэн. Мөн тусгай зөвшөөрлийг бууруулах чиглэлээр ихээхэн анхаарч, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг шинэчлэх ажлыг санаачилж байгаа тухай хэвлэлээр мэдээлж байна.


- **Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал, 2013 оны 12 дугаар сар, судалгааны тайлангаас¹⁷¹:**

Үр ашиггүй саад бэрхшээлийг шийдвэрлэхэд гарч буй зардал

Үр ашиггүй бэрхшээлийг (тухайлбал, зөршөөрлийн хугацаа сунгах, тусгай зөршөөрөлтэй холбоотой албан ёсны хариу авахыг хүлээх г.м) даван туулахад компаниудын зарцуулсан цаг хугацаанд эерэг өөрчлөлттэй байсан өмнөх судалгааны чиг хандлага цаашид байхгүй болсон. 2013 оны 5 дугаар сард хийсэн судалгаагаар ийнхүү үр ашиггүй бэрхшээлийг шийдвэрлэхэд цаг хугацаа зарцуулдаггүй гэж мэдэгдсэн компанийн тоо 10.3 хувиар өссөн юм. Гэтэл энэ удаад ийм мэдэгдэл хийж байгаа компанийн тоо 15.8 хувь болж буурав. Энэхүү үзүүлэлтээс болж үр ашиггүй бэрхшээлийг шийдвэрлэхээр цаг хугацаа зарцуулдаг компанийн тоо өсөхөд хүрэв. Үр ашиггүй бэрхшээлийг шийдвэрлэхээр ажлын цагийнхаа 25 хүртэл хувийг зарцуулдаг компанийн тоо 2013 оны 5 дугаар сард 19.4 хувь байснаа 10 дугаар сард 31.2 хувь болжээ.

Бизнесийн үйл ажиллагаанд учирдаг гол бэрхшээлүүд

¹⁷¹ Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал ном, 7, 11, дугаар хуудас



Бизнес татвар бэрхшээл учруулдаг гэж тооцогддог байсан бүх байгууллага 2012 оны 12 дугаар сараас хойш өөрийн үйл ажиллагааг сайжруулсан байна (зураг 3.5). Татварын газрын талаарх сөрөг ойлголт 12 дугаар сард 35.4 хувь байсан бол 10 дугаар сард 26.7 хувь болжээ. Үүнтэй адилаар мөн хугацаанд Мэргэжлийн хяналтын байгууллага (28 хувиас 19.1 хувь болсон), цагдаа (8.1 хувиас 3.3 хувь болсон) болон орон нутгийн байгууллагын (9.9 хувиас 7.3 хувь болсон) талаарх сөрөг үнэлэмж буурсан байна.

2008 оноос хойш бүртгэлийн байгууллагад мэдээллийн технологи нэвтрүүлэх чиглэлээр Засгийн газрын зүгээс онцгой анхаарч, үе шаттайгаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлж цахимжуулсан нь тэр үеэс хойш бүртгэлийн үйлчилгээ авлигад өртөмтгий 5 салбарын хүрээнд нэрлэгдэхгүй болоход нөлөөлсөн гэж үзэж байна. “Компьютер бол хүн биш учир авлига нэхдэггүй” учир төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг нэвтрүүлэх нь авлигаас урьдчилан сэргийлж, хүнд суртлыг арилгах чухал нөхцөл болохыг нотолж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Татаас /концессийг оролцуулан/, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, гэрчилгээ олгох төрийн аль нэг байгууллагад бүртгүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд дахь авлигын нөхцөл байдал, хүнд суртлын арга хэлбэр, тархалтын талаар бие даасан судалгаа хийж үр дүнгээр зохих арга хэмжээ авах
- Тусгай зөвшөөрөл, бүртгэл олгох, төрийн бусад олон үйлчилгээг цахимжуулах талаар онцгой анхаарч төрийн байгууллага бүр зохих техникийн нөхцөл, хүний нөөцийн бэлтгэлийг хангах үе шаттай арга хэмжээ авах харилцан уялдаатай арга хэмжээг төрийн бүх байгууллагыг хамруулан авах. Үүнтэй холбоотойгоор Мэдээллийн технологи, шуудан, харилцааны газрын статусыг дээшлүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх

8.2. (е) нийтийн албан тушаалтан байсан этгээд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах буюу нийтийн албанаас огцорсон буюу тэтгэвэрт гарсны дараа хувийн хэвшилд ажил эрхлэхэд, хэрэв ийм үйл ажиллагаа буюу ажил нь тэдний ажиллаж байх хугацаандаа хийж байсан буюу удирдаж байсан чиг үүрэгтэй шууд хамааралтай байвал, зохих тохиолдолд, тодорхой хугацааны хязгаарлалт тогтоох замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; /Конвенцийн 12.2.e/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд ашиг сонирхолын зөрчилд орж болзошгүй нөхцөл байдлыг хянах, олж илрүүлэх зорилгоор ашиг сонирхолын зөрчилтэй байдалд орж болзошгүй нийтийн албан тушаалтан уг байдлаас зайлсхийх ёс зүйн үүргийг тодорхойлж мөн ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй байдлыг хориглож, хязгаарласан байна. Энэхүү механизмыг уг хуулийн 2 дугаар бүлэгт Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг, Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах, Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх /Хуулийн 7,8,9-р зүйл/ 3 дугаар бүлгийн 10-22 дугаар зүйлд тус бүр тусгасан тодорхой заалтуудаар нарийвчлан зохицуулсан байна. Тухайлбал:

Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт /11-р зүйл/

- Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш **хоёр жилийн хугацаанд** тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн

байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш **хоёр жилийн хугацаанд** тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны акт гаргахыг хориглоно.

- Энэ хуулийн 11.3-т заасан захиргааны акт гаргах хязгаарлалт нь төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан албан тушаалтанд хамаарахгүй.

Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт /14-р зүйл/

- Албан тушаалтан дараах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө нийтийн албыг төлөөлж болохгүй:
 - өөртэй нь хамаарал бүхий этгээдийн өмнө;
 - өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хүртдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө;
 - албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө.

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт /20-р зүйл/

- Албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй.
- Энэ хуулийн 20.2-т заасан албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд энэ зүйлд заасан үүргийг нийтийн албанаас чөлөөлөгдсөний дараа хоёр жилийн хугацаанд мөн биелүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.
- Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс **хойш хоёр жилийн хугацаанд** албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн

хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.

Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт /21-р зүйл/

- Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш **хоёр жилийн хугацаанд** ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;
 - урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;
 - урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.
- Энэ хуулийн 21.1.2-т заасан хязгаарлалт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдохоос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, контракт, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, контрактад хамаарахгүй.
- Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.
- Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалт зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Бусад орлогын хязгаарлалт /22-р зүйл/

- Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно:
 - шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах;
 - холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах;
 - холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах;
 - холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэх.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтан байсан этгээд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах буюу нийтийн албанаас огцорсон буюу тэтгэвэрт гарсны дараа хувийн хэвшилд ажил эрхлэхэд, хэрэв ийм үйл ажиллагаа буюу ажил нь тэдний ажиллаж байх хугацаандаа хийж байсан буюу удирдаж байсан чиг үүрэгтэй шууд хамааралтай байвал, зохих тохиолдолд, тодорхой хугацааны /хоёр жил/ хязгаарлалт тогтоож, ашиг сонирхлын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх талаарх Конвенцийн 12.2.е заалтын шаардлагыг хангасан байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- **Төрийн албаны зөвлөлийн 2013 оны тайлан:**¹⁷²

Төрийн албан хаагчдийн зэрэг дэв нас хүйс, боловсрол, ажил үүргээр нь ангилсан тоон үзүүлэлтүүд байгаа боловч ажлаас гарсан халагдсан, тэтгэвэрт гарсан ажилтнуудын талаарх тоон мэдээлэл байхгүй байгаа учир хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна. Түүнчлэн төрийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүс тийнхүү чөлөөлөгдсөнөөс хойшхи 2 жилийн хугацаанд сонирхлын зөрчил үүсгэхүйц ажил эрхэлж байгаа эсэх тухай мэдээлэл тун хомс байна. АТГ-ын тайлангаас үзвэл Төрийн албанд орохоосоо өмнө АТГ сонирхлын зөрчил үүсэхээр буй эсэх талаар зохих шалгалт хийж тухайн байгууллагад нь бичгээр мэдэгддэг байх хуулийн заалт зохих ёсоор хэрэгжиж байгаа гэж үнэлж байна. Харин УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнийг хавсран эрхлэхийг хориглосон Үндсэн хуулийн анхны үзэл санааг хуульд өөрчлөлт оруулах “хууль ёсны” мэт аргаар өөрчилснийг Үндсэн хуулийн хэрэгжилтийн судалгааны тайланд нухацтай үнэлсэн байна. Энэ байдлыг засах зорилгоор 2014 оны эхээр Монгол Улсын **Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Зөвхөн Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүний ажил, албан тушаалыг хавсарч болно. Энэ тохиолдолд гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална” гэж өөрчлөн найруулах, үүнтэй уялдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим зүйлийн зохих заалтыг өөрчлөн найруулах хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж өргөн мэдүүлсэн юм.** Хуулийг хэзээнээс хэрэгжүүлж эхлэх вэ гэдэг дээр санал зөрж, Ардчилсан намынхан Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр 2016 оны долдугаар сарын 1-нээс хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэсэн бол МАН-ын гишүүд батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлэх нь зөв гэж үзэж байлаа¹⁷³. Эцэст нь энэхүү санал зөлөдөөнөөс шалтгаалан 2014 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн УИХ-ын чуулганаар Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн төслүүд олонхийн дэмжлэг авч чадалгүй¹⁷⁴ унасан байна. Түүнчлэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны /2014.05.06/ хуралдаанд Авлигатай тэмцэх газраас 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн судалгааны дүнг танилцуулсан байна. Уг судалгааг хийхдээ Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаардаг этгээдийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийн

¹⁷² Төрийн албаны зөвлөлийн 2013 оны тайлан,

http://csc.gov.mn/main/index.php?option=com_content&view=article&id=737

¹⁷³ <http://politics.news.mn/content/165435.shtml> - "Давхар дээл" тодотголтой хуулийн төслийг дэмжлээ

¹⁷⁴ <http://www.polit.mn/content/41369.htm> - "Давхар дээл" тайлах жүжиг эмгэнэлтэй төгслөө

мэдээллийн санд тулгуурлан, Төрийн өмчийн хорооноос холбогдох баримт материалуудыг гаргуулан авсны үндсэн дээр хийсэн байна. Төрийн нарийн бичгийн дарга нар, захиргааны удирдах албан тушаал хашиж байгаа хүмүүс ойролцоогоор 2-3 компанид, хамгийн дээд талдаа 5 компанийн ТУЗ-д гишүүнээр ажилладаг юм байна гэдгийг энэхүү судалгаа нотолсон байна. Хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд: “энэхүү судалгаа, мэдээллийг ирүүлэх нь АТГ-ын хүлээсэн нэг гол үүрэг. Хараат бус гэдгээр төрийн албан хаагч биш хүмүүс аваад, тэр хүмүүс нь ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс ороод ирчихсэн байдаг байна. Түүнийг нь Төрийн өмчийн хороо томилж байгаа нь буруу. Иймд нэн даруй ашиг сонирхлын хуулийг зөрчөөгүй томилгоо хийх үүргийг Засгийн газарт өгөх хэрэгтэй. Ийм сонирхлын зөрчилтэй хүмүүсийг төрийн өмчийн зүгээс ч хувийн зүгээс ч оруулж болохгүй. Мөн намын гишүүн төрийн албан хаагч байдаг бол тэр хүн нам, төр хоёрынхоо аль нэгийг сонгох хэрэгтэй. Энэ асуудлыг 2004 оны хуулиар хориглосон. ТУЗ-д төрийн төлөөлөл болж намын гишүүд орох боломжгүй. Төрийн төлөөлөлдөө тийм хориг тавьж байгаа бол хараат бусдаа мөн адилхан хориглоо тавих хэрэгтэй. Энэ асуудал дээр хууль өөрчлөх шаардлагатай бол Хууль зүйн байнгын хороо хууль санаачилъя” гэсэн байна. Хуралдаанаар судалгааны дүнг хэлэлцээд Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр Засгийн газарт үүрэг, чиглэл өгөхөөр болжээ¹⁷⁵. **“Давхар дээл” гэсэн нэршлээр олны анхаарлыг татсан асуудлаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гараад ч өөрчлөлтөд хүрээгүй, хэдэн жилийн дараа Засгийн газрын тухай хууль, УИХ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах гэсэн Ерөнхийлөгчийн санаачлага гараад ч дэмжлэг аваагүй, яамдын төрийн нарийн бичгийн дарга нар “хэд хэдэн давхар дээлтэй” тухай АТГ-ын судалгааны тайлан зэргээс дүгнэлт хийвэл нийтийн албан тушаалтан хувийн хэвшилд ажил эрхлэхэд, зохих тохиолдолд, тодорхой хязгаарлалт тогтоох замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хүчин төгөлдөр хууль болон Конвенцийн шаардлагыг төрийн албаны дээд түвшиндээ зөрчдөг, “хуулийн аргаар” сонирхлын зөрчлөөсөө салах хүсэлгүй байна гэж үзэхэд хүргэж байна. Энэ бол үнэхээр Монголыг муухай харагдуулж байна. Энэхүү дүгнэлтийг олон нийтийн дунд хийсэн санал асуулга давхар нотолж байна.** “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгааны тайлан \2013 оны 12 дугаар сар\-гийн 5 дугаар талд: “Судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар “улс төр” болон “дээд түвшний авлига” хоорондын хамаарал маш их болж байна гэсэн ойлголт нэмэгдэж байна. Үүний улмаас улс төрийн намууд нь авилгалд хамгийн их өртсөн таван байгууллагын нэгд тооцогдов. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь авлига болон дээд түвшний авлигын эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээг Авлигатай тэмцэх газар (АТГ) тэргүүлэх ёстой гэж итгэж байна” гэжээ.

¹⁷⁵ <http://open.parliament.mn/content/3843.htm>- Авлигатай тэмцэх газар судалгааны дүнг УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулав

ЗӨВЛӨМЖ:

- төрийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүс тийнхүү чөлөөлөгдсөнөөс хойшхи 2 жилийн хугацаанд сонирхлын зөрчил үүсгэхүйц ажил эрхэлж байгаа эсэх тухай мэдээллийг цуглуулах, хэрэгжилтийг хэрхэн хянах механизм тодорхойгүй, статистик мэдээлэл байхгүй байгаа тул цаашид судалгаа хийх, тайлан мэдээлэл авах гэх мэт арга хэмжээ авах;
- Сонирхлын зөрчилтэй хүмүүсийг төрийн өмчийн зүгээс ч, хувийн зүгээс ч төрийн өмчийн компанийн ТУЗ-д оруулахыг хориглосон зохицуулалтыг холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх;
- Төрийн албан хаагч намын гишүүнээс түдгэлзэх талаарх 2004 онд Төрийн албаны тухай хуулийн 10.6-д орсон өөрчлөлтийн хэрэгжилтийн мониторинг хийх;
- “Давхар дээл”-ийг тайлах асуудлыг дахин авч үзэж, төрийн дээд түвшинд авилгалыг бууруулах чиглэлээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг тууштай үргэлжлүүлж 2015 онд Конвенцийн хэрэгжилтийн тайландаа Монгол төр хэлэх үгтэй болохыг зөвлөж байна.

8.2. (f)хувийн байгууллагууд авлигын үйлдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх хангалттай дотоод аудитын хяналттай байх явдлыг тэдгээрийн бүтэц хэмжээг харгалзан хангах, түүнчлэн тэдгээр хувийн байгууллагын данс, шаардлагатай санхүүгийн тайланг аудит, магадлан итгэмжлэлийн зохих журамд хамруулах явдлыг хангах; /Конвенцийн 12.2.f/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Компанийн тухай хуульд хувийн байгууллагын авлигын үйлдлээс урьдчилан сэргийлэх, дотоод аудитын хяналтын талаар хангалттай тусгаагүй боловч Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ. /Хуулийн 81.2./ Тус хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах /Хуулийн 81.4.1, 81.4.2/ чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахаар үүрэг болгон хуулчилсан байна. **Компанийн засаглалын кодекст**¹⁷⁶ Компанийн дотоод хяналтын тогтолцоог /7.1. тусгайлан зааж өгсөн бөгөөд тус тогтолцоо нь

- Хянан шалгах зөвлөл

¹⁷⁶ Компанийн засаглалын кодекс, 2014.05.07, <http://www.frc.mn/index.php/2013-02-18-01-47-04/2013-03-25-08-31-47/2013-04-02-06-44-32>

- ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо

- Гүйцэтгэх удирдлагын удирдлага дор ажиллах дотоод хяналтын алба байх бөгөөд эдгээр нэгжүүд нь харилцан дэмжлэг үзүүлэхээс гадна аливаа хяналтын үр дүнгийн талаар тухай бүр харилцан мэдээлдэг байх, ялангуяа, дотоод хяналтын алба нь ТУЗ-ын дэргэдэх аудитын хороо хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа мэдээ мэдээллийг үнэн зөвөөр, шуурхай гаргаж өгөхөд дэмжлэг үзүүлж ажиллах бөгөөд аудитын хорооны үйл ажиллагааны журмыг дүрэмд заахаас гадна аудитын хороо ДХА-ны үйл ажиллагааны журмыг нарийвчлан баталсан байна. Энэ нь тэдгээрийг чиг үүргээ хэрэгжүүлэх баталгааг бий болгохоос гадна үйл ажиллагааг нь дүгнэх, чиг үүргийн давхардал гаргахгүй байх, үйл ажиллагааны уялдаа холбоог нь хангах, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд ач холбогдолтой юм. Үүнээс гадна тус кодекст тус хороодын бүрэлдэхүүн, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, чиг үүрэг, бүрэн эрхийг тус бүр нарийвчлан зааж өгсөн байна. Харин хөндлөнгийн аудитын хяналтын тухайд бүрэн эрх, чиг үүрэг, компанитай харилцах харилцаа, хориглох зүйл зэргийг нарийвчлан тусгасан байна. **Аудитын тухай хуульд** аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахтай шууд холбоотой бичиг баримтыг холбогдох арилжааны банк, бусад санхүүгийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудаас шаардан авч танилцах /Хуулийн 20.2/ эрхийг аудиторын бүрэн эрх болгон заасан байна. Эдгээрээс үзэхэд **Монгол Улс нь Конвенцийн хувийн байгууллагууд авлигын үйлдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх хангалттай дотоод аудитын хяналттай байх явдлыг тэдгээрийн бүтэц хэмжээг харгалзан хангах, түүнчлэн тэдгээр хувийн байгууллагын данс, шаардлагатай санхүүгийн тайланг аудит, магадлан итгэмжлэлийн зохих журамд хамруулах явдлыг хангах гэсэн заалтыг хууль тогтоомждоо тодорхой хэмжээгээр тусгасан байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Компанийн засаглалын кодексоос зарим зайлшгүй шаардлагатай заалтыг Компанийн тухай хуульд оруулж хуульчлах
- Аудитын тухай хуульд аудитын хяналт шалгалтаар ямар ямар баримт бичгийг нягтлан шалгуулах жагсаалт, авлигаас урьдчилан сэргийлэх аудиторын үүрэг, үйлчлүүлэгчийн хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр тодорхой зохицуулалт нэмж өгөх

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Компанийн засаглалын үнэлгээний тайлан /2011 он/-гаас¹⁷⁷: Тус тайлан нь институтыг бэхжүүлэх, Хувийн хэвшил буюу компанийн төлөвшилийн, Улсын сектор, компанийн хөгжил төлөвшилийн чиглэлээр дараах зөвлөмжийг өгсөн байна.

- Нягтлан бодох бүртгэл болон компанийн тайлан гаргах мэргэжлийн чадвар, нягтлан бодох бүртгэл болон аудитын поактикийн мэргэжлийн

¹⁷⁷ Компанийн засаглалын үнэлгээний тайлан, 14, 15-р хуудас

түвшинг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн өнөөгийн практикийн хэмжээнд хүргэн бэхжүүлэх. ОУСТС болон АОУС-д тавигдаж байгаа сүүлийн үеийн стандартыг Монголд нэвтрүүлэх. Хөндлөнгийн аудитын чанарт тавигдах шаардлагыг бий болгох ба аудитын үл итгэх /эргэлзэх/ эрхийг хангах болон олон улсын аудитын мэдлэг туршлага, практикийг нэвтэрүүлэх;

- ТББ болон хувийн хэвшлийн байгууллагууд /КЗХТ, Худалдааны танхим зэрэг /КЗ-ыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг энэхүү үнэлгээнд тулгуурлан дэмжих. Тийм төлөвлөгөөнд сургалтын хөтөлбөр боловсруулах, тэргүүн туршлагын холбогдол бүхий материал бэлтгэх, Монголд КЗ-ыг хөгжүүлэхэд удирдлага болгох хяналтын хуудас, аудитын хорооны бодлогын загвар болон журам зэрэг болно. Учрах сорилт нь компаниуд болон захирлуудыг хэрхэн идэвхитэй татан оролцуулах вэ гэдэг асуудал байх болно.

Хувийн хэвшил буюу компанийн төлөвшилийн чиглэлээр

- Сайн компанийн КЗ-ын бүтэц, бодлого болон дүрэм журмыг боловсруулан хэвлэн нийтлэх. Жишээ нь: Захирлуудын ёс зүйн кодекс, мэдээллийн бодлого, хөрөнгө оруулагчдын хувьд баримтлах бодлого болон сонирхолын зөрчилтэй хэлэлцээр контрактын талаар баримтлах бодлого зэрэг нь компанийн засаглалыг хэрэгжүүлэх компанийн чин эрмэлзлийг харуулсан компанийн засаглалын компанийн кодексийн бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүд байж болох юм.
- Компанийн зүгээс хөндлөнгийн аудитыг сонгох, томилох, хяналт шалгалт болон компанийн тайланг чанартай боловсруулах практик үйл ажиллагаа, компанийн нээлттэй байдлыг хангахад /байнгын болон шаардлагатай үеийн/ баримтлах тодорхой удирдамжийг компаниуд боловсруулан гаргаж, нийтэд мэдээлэх хэрэгтэй. Түүнчлэн компанийн нийгмийн хариуцлага болон компанийн мэдээллийг нээлттэй болгох компанийн бодлого, хэрэгжүүлэх практик үйл ажиллагааг боловсруулах шаардлагатай.

Улсын сектор, компанийн хөгжил төлөвшилийн чиглэлээр

- Удирдах хувь хүмүүс Компанийн сайн засаглалыг дэмжих мэдэгдлийг олон нийтэд хийх замаар төр нь компанийн сайн засаглалын “аврага” болох ёстой.
- Төр хувьцааны дийлэнхийг эзэмшдэг, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад КЗ-ыг хэрэгжүүлдэг байх ба төрийн өмчийн компанийн захирлуудад өөр өөрсдийн компанийн хувьд компанийн сайн засаглалыг хэрхэн хэрэгжүүлж байгаад нь хариуцлага тооцдог байх.

ЗӨВЛӨМЖ:

- Компанийн засаглалын үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийг ажил хэрэг болгох
- Засаглалын үнэлгээг тогтмол хийж хувийн хэвшлийн илүү олон байгууллагыг хамруулж, үр дүнг нийтэд хүргэдэг болох

8.3. Авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх зорилгоор явуулсан дараах үйлдлийг хориглоход нягтлан бодох бүртгэл тооцоо хөтлөх, санхүүгийн тайланг ил тод болгох, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартын талаарх дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

(а)бүртгэлээс гадуур данс нээх; /Конвенцийн 12.3.a/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор бүртгэлээс гадуур данс нээх үйлдлийг хориглох, гаргахгүй байх чиглэлээр **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд** Нягтлан бодогчийн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч нь албан тушаалаа урвуулан ашиглах, Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд гарсан алдааг залруулахдаа холбогдох баримт материалыг үндэслэн зөв үзүүлэлтийг бичсэн нэмэлт баримт бүрдүүлэн, залруулга хийсэн болон зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулахаар зааснаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн баримт, данс, санхүүгийн тайланг засварлах зэрэг үйлдлийг хориглох заалтаар хязгаарласан бол /20.1.1, 20.1.6/ **Татварын ерөнхий хуульд** татвар төлөгч нь банкинд данс нээсэн болон хаасан тухай татварын албанд тухай бүр мэдэгдэх үүргийг /18.1.12/ мөн банк санхүүгийн болон холбогдох бусад байгууллага нь татвар төлөгч нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу банкинд шинээр данс нээсэн, эсхүл хуучин дансанд өөрчлөлт, хөдөлгөөн хийсэн бол харилцагч банк нь энэ тухай мэдээллийг 10 хоногийн дотор татварын албанд өгөх /71.2.2/ үүргийг тус тус хуульчилсан байна. Энэ нь **“бүртгэлээс гадуур данс нээхийг хориглох” талаарх конвенцийн холбогдох заалтыг бүрэн биш ч тодорхой хэмжээгээр зохицуулсан байна. Харин төрийн албан хаагч гадаадад нээлгэсэн дансны мэдээллээ ХАС\ХОМ-доо мэдүүлэх талаар хууль ойлгомжтой тодорхой тусгаагүй байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, компанийн тухай хууль болон бусад хуулиудад нягтлан бодогч болон компани нь бүртгэлээс гадуур данс нээхийг хориглон хуульчлах
- Төрийн албан хаагч гадаадад нээлгэсэн дансны мэдээллээ ХАС\ХОМ-доо мэдүүлэх талаар холбогдох хуульд ойлгомжтой тодорхой нэмж оруулах

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

“Офшор” дансны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуугиснаас өөр энэ заалтын практик хэрэгжилтийн талаарх мэдээллийг олж судалж амжаагүй.

8.3. (b)бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийх;
/Конвенцийн 12.3.b/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийх үйлдлийг хориглох чиглэлээр **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд** Гүйлгээ нь хуульд нийцэхгүй, алдаатай хийгдсэн нь илэрсэн даруйд холбогдох төсвийн захирагч нь уг гүйлгээг төсөвт буцаах үүрэгтэй гээд тус алдаатай гүйлгээг хэрхэн залруулга хийх, тус орлого зарлагын залруулгын гүйлгээг орлого зарлагад тооцохгүй байх /8-р зүйл/, Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч нь эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх үүрэгтэйг /19.1.5/, хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичихийг хориглох зэргээр хуульчилсан байна. Харин **Татварын ерөнхий хуульд** үндэслэлгүйгээр бусад хуулийн этгээд, хувь хүнд шилжүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын улсын байцаагч торгууль ногдуулахаар заасан байна. ***Дурдсан хуулиудад “бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ” гэдэг нэр томъёо ороогүй бөгөөд эдгээр хуулиудад хэрэглэсэн нэр томъёонууд нь тойруу утгаарч болов бүрэн тодорхойлсон нь гэдэг нь эргэлзээтэй байна. Эдгээрээс үзэхэд тус хуулийн заалтууд нь конвенцийн холбогдох шаардлагыг бүрэн хангаагүй байна.***

ЗӨВЛӨМЖ:

- Татварын ерөнхий хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай , Компанийн тухай , Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай зэрэг болон бусад холбогдох хуульд бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийх тохиолдолд хэрхэн залруулга хийх болон санаатайгаар тийм гүйлгээ хийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэргийг нарийвчлан тусгах

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Монгол Улсад Конвенцийн дээрх заалт буюу 12.3.b. бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийж байсан эсэх энэ талаар шүүхэд хандан шийдвэрлүүлж байсан эсэх тааар судлах үүднээс Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn сайтаас 2012 оны 01 дүгээр сарын 01-нээс 2014 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүртлэх Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрүүдээс “гүйлгээ”, “данс” гэсэн түлхүүр үгээр хайлт хийхэд энэ талаарх маргаан хянан

шийдвэрлэсэн шийдвэр байхгүй байна. Мөн УТЕГ-ын сайтад тухайн байгууллагын тайлан тавигдаагүй тул энэ талаархи мэдээллийг бид олж чадаагүй болно.

ЗӨВЛӨМЖ:

- Бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийхтэй холбоотой мэдээллийг татварын байгууллага, шүүхийн статистикээр тодорхой болгох арга хэмжээг холбогдох байгууллауд хамтрах хэрэгжүүлж, 2015 онд тайлан бэлтгэх хүртэл конвенцийн энэ заалтын шаардлагыг хангах

8.3. (с) гараагүй зардлыг бүртгэх; /Конвенцийн 12.3.с/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцийн гараагүй зардлыг бүртгэж гэмт хэрэг үйлдэхийг хориглох чиглэлээр **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд** хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих /20.1.4/-ийг **Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хориглож өгсөн байна. хэрвээ дээрх заалтыг зөрчсөн тохиолдолд** буруутай албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох хариуцлага хүлээлгэхээр заасан байна. /23.1.1/ Харин **Татварын ерөнхий хуульд** татвар ногддох зүйлийн тоо хэмжээ, үнийг нь нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд багасгаж тусгах, эсхүл ийнхүү багасгахын тулд зардал болон бусад хасагдах зүйлийг өсгөх аргаар татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулахаар /74.1.4/ заасан байна. **Хуурамч бичиг баримт үйлдэх замаар гаргаагүй зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгүүлж улмаар татвар ногдох зардлыг өсгөх тохиолдолд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хуулиар торгуулийн хэмжээг өөр өөрөөр тодорхойлсон нь хуулиудын зөрчил эсхүл нэг зөрчилд давхардсан торгууль оногдуулахаар байна.**

Дээрхийг эс тооцвол конвенцийн холбогдох зүйл заалтыг хууль тогтоомжоороо хангаж өгсөн байна гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Татварын ерөнхий хуулиар ногдуулж буй хариуцлага хүлээлгэж буй үйлдэл болон хариуцлагуудын давхардал хийдлийг судалж арилгах

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Энэ талаар мэдээлэл байх ёстой боловч судалгааны хугацаанд бид мэдээлэл аж амжаагүй. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn, мөн УТЕГ-ын сайтад тухайн байгууллагын тайлан тавигдаагүй тул энэ талаархи мэдээллийг бид олж чадаагүй болно.

ЗӨВЛӨМЖ:

- Конвенцийн 12.3.a-12.3.f-ийг хэрхэн ойлгож хэрэгжүүлж буй талаар судалгаа хийж шаардлагатай арга хэмжээ авах нь зүйтэй.
- Энэ талаарх тайлбар, практикт хэрэглэх аргачлал зэрэг мэдээллийг нэмэгдүүлэх

8.3. (d)объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх; /Конвенцийн 12.3.d/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Конвенцийн тус заалтын хэрэгжилтийг Татварын ерөнхий хуулийн 74.1.9 дүгээр заалтаар буюу хуурамч өглөг үүсгэх аргаар татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна гэсэн заалтаар хангасан байна гэж үнэлж болох юм. Гэвч жишээлбэл, *“барааны үнэ төлсөн” гэхийн оронд “зээл олгосон” гэж бичиж “өглөг үүсгэсэн” зөрчил байж болно. “Объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх” гэсэн нэр томъёо Татварын ерөнхий хуульд байгаа “хуурамч бичиг баримт үйлдэх” гэснийг ерөнхий утгаар нь хуурамч өглөг үүсгэхтэй дүйцүүлж үзэж болох боловч дотоодын хууль тогтоомжид конвенцийн шаардлагын дагуу тодорхойлох шаардлагатай.*

ЗӨВЛӨМЖ:

- “Объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх” гэсэн Конвенцийн хэллэгийг энэ л утгаар нь Нягтлан бодох бүртгэлийн болон Татварын ерөнхий хуульд оруулах шаардлагатай.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Практик мэдээлэл олдоогүй.

ЗӨВЛӨМЖ:

- Конвенцийн 12.3.a-12.3.f-ийг хэрхэн ойлгож хэрэгжүүлж буй талаар судалгаа хийж шаардлагатай арга хэмжээ авах нь зүйтэй.

8.3. (e)хуурамч баримт бичиг ашиглах; /Конвенцийн 12.3.e/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хориглох зүйлд хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих /20.1.4/ гэж зааж тус үйлдлийг үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгасан байна. Мөн **Татварын ерөнхий хуульд** хууран мэхлэх, хүчин төгөлдөр бус гэрээ, хэлцэл хийх үйлдлээр татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна /74.1.8/ гэж тус тус хуульчилсан **“хуурамч бичиг баримт бүрдүүлэх”, “хүчин төгөлдөр бус гэрээ хэлцэл хийх” гэдэг нь “хуурамч бичиг баримт ашиглах” гэдэгтэй утга нэг гэж үзэхэд учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлээгүй, үйлдээгүй атлаа хуурамч гэдгийг мэдсээр байж нягтлан бодох бүртгэлдээ ашиглах үйлдэл орхигдсон байж болохоор байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Дотоодын хууль тогтоомжид Конвенцийн 12.3.е-д **“хуурамч баримт бичиг ашиглах”** гэж зааснаар тодорхойлох нь зүйтэй.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Хэрэгжилтийг үнэлэх мэдээлэл олдоогүй.

ЗӨВЛӨМЖ:

- Конвенцийн 12.3.а-12.3.ф-ийг хэрхэн ойлгож хэрэгжүүлж буй талаар судалгаа хийж шаардлагатай арга хэмжээ авах нь зүйтэй.

8.3. (f)нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хуульд заасан хугацаанаас өмнө санаатайгаар устгах; /Конвенцийн 12.3.ф/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Компанийн тухай хуулиар компани нь компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хадгалах үүрэгтэй /97.1.1, 97.1.6, 97.1.8/ бөгөөд дараах баримт бичгийг хадгалж, хууль болон компанийн дүрэм, журмаар тогтоосон эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах үүрэгтэй: /97.2/

- нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

- төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, шийдвэр;
- анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт.

Мөн компанийн дүрмээс бусад баримт бичгийг компани нь таван жилийн хугацаагаар хадгалах бөгөөд энэ хугацаа дууссаны дараа тэдгээрийг архивт шилжүүлнэ. Ингэхдээ дээрх баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газар буюу хувьцаа эзэмшигчдийн мэдэх, тэдний нэвтрэх боломж бүхий газар хадгална. /97.4, 97.6/

Татварын ерөнхий хуулиар нягтлан бодох болон анхан шатны бүртгэл, татварын тайлан, холбогдох баримт бичгийг устгах, нуух, үгүй болгох /74.1.5/ нягтлан бодох бүртгэл хөтлөхгүй байх, эсхүл холбогдох баримт бичгийг бүрдүүлэлгүй татварын тайлан гаргах боломжгүй болгосон /74.1.7/ тохиолдолд татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна хэмээн заасан байна. **Татварын ерөнхий хуульд Конвенцийн 12.3.f-ийн “хуульд заасан хугацаанаас өмнө” гэдэг санааг орхигдуулсан байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Татварын ерөнхий хуулийн 74.1.5-ы устгах” гэсний өмнө “хуульд заасан хугацаанаас өмнө” гэж нэмэх.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Хэрэгжилтийг үнэлэх мэдээлэл олдоогүй.

ЗӨВЛӨМЖ:

- Конвенцийн 12.3.a-12.3.f-ийг хэрхэн ойлгож хэрэгжүүлж буй талаар судалгаа хийж шаардлагатай арга хэмжээ авах нь зүйтэй.

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Татварын ерөнхий хуулиар татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна. /6.1/ хэмээн хуульчилсан байна. **ААНОАТХ-д конвенцийн энэ заалтыг шууд илэрхийлсэн заалт байхгүй байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд хээл хахуульд өгсөн зардал, авлигын үйлдлийг дэмжсэн бусад зардлыг татвар ногдох орлогоос хасахыг хориглоно гэж нэмж оруулах

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Хэрэгжилтийн талаарх мэдээлэл олдоогүй тул цаашид гүнзгийрүүлж судал шаардлагатай.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ НИЙГМИЙН ОРОЛЦОО

/13 дугаар зүйл/

9.1. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд хувь хүн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн нэгдэл хөдөлгөөнд тулгуурласан байгууллага зэрэг нийтийн албанаас гаднах бүлгийн идэвхитэй оролцоог хөхиүлэн дэмжих бөгөөд бодитоор оршин буй авлига, түүний шалтгаан, ноцтой байдал, аюул заналын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн өөрийн бололцооны хүрээнд авна. Энэхүү оролцоог дараах арга хэмжээгээр бэхжүүлнэ:

(а) шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, түүн дэх олон нийтийн оролцоо, хувь нэмрийг дэмжих; /Конвенцийн 13.1.а/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуульд: Олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ /5.1./:

- Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах;
- авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах;

Төрийн байгууллага авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ /6.1./:

- төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;
- авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих.

Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллана. /27.1./

Олон нийтийн зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийг төлөөлөх иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилно. /27.2./

Олон нийтийн зөвлөлийн гишүүнд төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлэхгүй. /27.3./

Олон нийтийн зөвлөлийн гишүүн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд хамаарах нууцыг задруулахыг хориглоно. /27.4./

Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. /27.5./

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах чиглэлээр шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ гэж заасан байна. /7.1.5/

Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, түүн дэх олон нийтийн оролцоо, хувь нэмрийг дэмжих гэсэн Конвенцийн шаардлагыг Авлигыг эсрэг болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дурдсан заалтуудаар хангаж байна гэж үзэж байна.

ПРАКТИК ОРЧИН

Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхитэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус Олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд 2007 оноос эхлэн ажиллаж эхэлсэн байна. Тус зөвлөл нь 15 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилдог. Олон нийтийн зөвлөлийн 2009 онд томилогдсон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2014 оны 5-р сарын 26-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 62 дугаар зарлигаар шинэчлэн томилсон байна.

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан, Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр, Хэвлэл мэдээллийн албаны дарга П.Сайнбилэг нар шинээр

томилогдсон гишүүдэд танилцуулж, Зөвлөлийн гишүүний үнэмлэхийг гардуулсан байна.

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүн

д/д	Овог, нэр	Байгууллага
1	Т.Хасбаатар	Үндэсний байгаль орчны хамтын ажиллагааны нийгэмлэг
2	П.Эрдэнэжаргал	Нээлттэй нийгэм форум
3	Н.Дорждарь	Орлогын ажиглагч хүрээлэн
4	Л.Төр-Од	Транспаренси Интернейшнл Монгол
5	М.Мөнхбат	МУИС-ийн Хууль зүйн сургууль
6	Д.Цэрэнжав	Ил тод байдал сан
7	Л.Сумати	Сант марал сан
8	Х.Наранжаргал	Глоб Интернейшнл
9	Б.Амар	Зориг сан
10	Н.Урантогтох	Пи Ар боловсрол олгох төв
11	М.Оюунчимэг	Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
12	Р.Батсайхан	Нирум фильм студи
13	М.Уламбадрах	Эн Ти Ви суваг
14	Б.Нямдорж	Өдрийн мэдээ ХХК
15	С.Насанжаргал	25 дугаар суваг

Дээрх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудаснаас авав.

Авилгалтай тэмцэх чиглэлээр бодит алхмууд хийх санал дэвшүүлж, түүнийгээ хэрэгжүүлж буй ТББ-д байдаг. Тухайлбал “Зориг сан”, “Глобинтернэшнл”, “Хэвлэлийн хүрээлэн”, “МННХ-Соросын сан” 22 ТББ-аас бүрдсэн Авилгалын эсрэг ТББ-дын эвсэл гэх мэт. “Зориг сан”, “Глобинтернэшнл”, “Хэвлэлийн хүрээлэн” ТББ-ууд хамтран өнгөрсөн онд “Эрэн сурвалжлах нь” сэдэвт сургалтанд 37, “Авилгалын асуудлыг эрэн сурвалжлах нь” эрэн сурвалжлах эчнээ сургалтанд төвийн хэвлэл, мэдээллийн байгууллагын 20 сэтгүүлч хамруулж зохион байгуулсан байна. Сургалтууд нь улс төрийн сэдвээр болон эрэн сурвалжлах сэдвээр бичигчдэд сэтгүүл зүйн ойлголтыг нь улам лавшруулах, авилгалын асуудлыг эрэн сурвалжлах судалгааны арга ажиллагаанд тодорхой заавар удирдамжийн дагуу сэтгүүлчид суралцах хугацаандаа багаар ажиллах, баг бүр тодорхой асуудлыг эрэн сурвалжилсан гурав, гурван цуврал өгүүллэг гаргах зорилготой юм байна. Мөн “Зориг сан” ТББ-аас өнгөрсөн хугацаанд авилгал, хээл хахуультай тэмцэх улс орны нийгэм эдийн засгийн бүхий л салбар хүрээнд гүн гүнзгий нэвтэрч төр засгийн байгууллага, олон нийт, судлаачдын анхаарлыг хандуулах, сэрэмжлүүлэх, хор уршгийг нь тайлбарлан таниулах зорилго бүхий 6 төслийг санхүүжүүлэгч байгууллагуудын тусламжтай хэрэгжүүлсэн байна. Цаашид ҮЗ-өөс авилгалаас урьдчилан сэргийлэх зорилго бүхий ТББ-дын чадавхийг дээшлүүлэх, сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, санал санаачлагыг нь хэрэгжүүлэх, авилгал, хүнд суртлын эсрэг тэмцэлд төр болон иргэний нийгэм, ТББ-д, хандивлагч орнуудын хүчин чармайлтыг нэгтгэн

зангидах, хамтран ажиллах тал дээр анхаарал хандуулж төслийн хүрээнд нэлээд асуудлууд тусган хэрэгжүүлнэ гэжээ¹⁷⁸.

2013 онд Хуульч эмэгтэйчүүдийн холбоо авлигын эсрэг бодлогын баримт бичгийг боловсруулах, орон даяар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан нь авлигаас урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг тодорхойлох үйл явцал ТББ, олон нийтийг орон даяар хамруулсан чухал арга хэмжээ болсон бөгөөд тус ТББ нь аймаг бүрт салбартай байсан нь ажлын үр дүнд нөлөөлсөн байна. Цаашид авлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг салбаруудтай ТББ-ыг оролцуулах талаар түлхүү анхаарах нь орон нутагт салбаргүй АТГ-ын хувьд чухал болохыг харуулав.

Авлигатай тэмцэх газрын хамтарч ажилладаг байгууллагуудыг энэхүү тайлангийн Нэгдүгээр бүлгийн 4 дэх хэсэг буюу Конвенцийн 5-р зүйлийн 4-ийн Оролцогч улсууд энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өөр хоорондоо болон холбогдох олон улсын ба бүс нутгийн байгууллагатай эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн аль тохирох байдлаар хамтран ажиллана. Ийм хамтын ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, төсөлд оролцох ажил багтаж болох талаарх заалтын практик хэсгээс харна уу.

Манай багаас энэхүү судалгааны явцад хийсэн вэбд суурилсан судалгаанд хамрагдсан төрийн 48 байгууллагын 3 аас бусад нь шийдвэр гаргах явцын ил тод байдлыг хангаж ажилладаггүй болох нь ажиглагдлаа.

ЗӨВЛӨМЖ:

- Яам, агентлагууд шийдвэр гаргах эрх бүхий этгээд шийдвэр гаргах явцдаа төслөөр 30-аас доошгүй хоногт нийтэд ил тод болгон цахим хуудсаараа санал авч хэвших нь зүйтэй байна.
- Цаашид авлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг салбаруудтай ТББ-ыг оролцуулах талаар түлхүү анхаарах нь орон нутагт салбаргүй АТГ-ын хувьд чухал байна.

9.1. (b)олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах;
/Конвенцийн 13.1.b/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуулийн 6.1.4, 6.1.5, 18.1.3, 18.1.5, 18.1.7, 14.5; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн 7.1, 8.1, 9.1, 9.2,

¹⁷⁸ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангийн 95-р хуудас

9.3, 10.1-д заалтуудаас үзвэл олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэн байна. Энэ талаар энэхүү тайлангийн Зургаадугаар бүлгийн 1-ийн (b) буюу Конвенцийн 10.(b)-ын шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг хөнгөвчлөн дэмжихийн тулд захиргааны журмыг зохих тохиолдолд хялбарчлах талаарх мэдээллээс харна уу.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, үйл ажиллагааг нь ил тод, нээлттэй байх зарчмыг үндэслэн үнэлж дүгнэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас санаачлан төрийн байгууллагуудын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд”-ийг боловсруулж, улмаар Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлуулсан байна. Уг тогтоолоор төрийн байгууллагуудын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд”-ийг мэдээллийн нээлттэй, ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв, санхүүгийн ил тод байдал, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал гэсэн 4 үндсэн чиглэлд хуваан тусгасан болно. Төрийн байгууллагуудын “Ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд”-ийг боловсруулан баталсан нь цаг үеэ олсон, шинэлэг ажил болсон төдийгүй ил тод байдлыг хэмжих шалгуур үзүүлэлтэд үндэслэн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх нөхцөл бололцоо бүрдэхийн зэрэгцээ төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлснээр төрийн албаны ажлын үр дүн сайжирч, төрийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой болжээ. /Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангаас/ Үүний дараа 2011 оны 6-р сарын 16-ны өдөр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 2012 оны 1-р сарын 19-ний өдөр Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсан байна.

- Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар байгуулах тухай Засгийн газрын 2004 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 207 тоот тогтоол, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрийг батлах тухай Ерөнхий сайдын 2004 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 95 тоот захирамж тус тус гарч Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар байгуулжээ.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012 он) хөгжлийн бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон, Монгол Улсад мэдлэгт тулгуурласан мэдээлэлжсэн нийгмийг байгуулах зорилго бүхий “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газар 2005 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 216 дугаар тогтоолоороо баталсан байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад цахим засгийг хэрэгжүүлэх, төрийн

байгууллагын үйл ажиллагааг автоматжуулах, иргэндээ хандсан, нэг цэгийн, үр дүнтэй, хэмнэлттэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн. Үүний нэг нь байгууллага бүрт веб сайт, иргэн бүрийг цахим шуудангийн хаягтай болгох, төрийн үйлчилгээг сүлжээгээр дамжуулан онлайн горимоор хүргэх явдал юм. Монгол Улсын бүх яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлаг, 21 аймагт цахим засгийн албан ёсны веб сайтыг ажиллуулах болсон байна.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, үйл ажиллагааг нь ил тод, нээлттэй байх зарчмыг үндэслэн үнэлж дүгнэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас санаачлан төрийн байгууллагуудын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд”-ийг боловсруулж, улмаар Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан байна. Уг тогтоолоор төрийн байгууллагуудын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд”-ийг мэдээллийн нээлттэй, ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв, санхүүгийн ил тод байдал, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал гэсэн 4 үндсэн чиглэлд хуваан тусгасан болно. Төрийн байгууллагуудын “Ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд”-ийг боловсруулан баталсан нь цаг үеэ олсон, шинэлэг ажил болсон төдийгүй ил тод байдлыг хэмжих шалгуур үзүүлэлтэд үндэслэн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх нөхцөл бололцоо бүрдэхийн зэрэгцээ төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлснээр төрийн албаны ажлын үр дүн сайжирч, төрийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой болсон юм.

Энэхүү тогтоолын заалтууд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж, дүгнэх зорилгоор Авлигатай тэмцэх газар /НҮБХХ-ийн санхүүжилт, дэмжлэгтэй/-аас 2010 онд IRIM судалгааны хүрээлэнгээр төрийн байгууллагуудын веб сайтын орчинд мониторингийн ажил хийлгэж, тайланг эмхтгэн нийтийн хүртээл болгожээ.

- Нэгдсэн Үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд анх дэлхий даяар цахим засаглал нэр томъёонд тулгуурлан мэдээллийн технологийн хөгжил дэвшлийг төрийн удирдлагад нэвтрүүлэх ажлыг эрчимтэйгээр зохион байгуулж, 2002 оноос хойш тогтмол мониторинг судалгаа хийж, дэлхийн бүх улс орныг хамруулдаг байна. Хамгийн сүүлийн судалгаа болох 2010 оны цахим засаглалын судалгаанд манай улс 1 бүхэл оноо авах ёстойгоос 0,5243 оноо авч дэлхийн 183 улсаас 53-т жагссан байна. Энэ нь манай улсын хувьд 2008 онд уг судалгаагаар 82 байранд жагсаж байснаас даруй 29 байр урагшилсан амжилттай үзүүлэлт байгаа ч IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн мониторингийн үр дүнгээр манай төрийн байгууллагын цахим хуудсууд байгууллагын сурталчилгааны самбар төдий үүрэг гүйцэтгэж, байгууллагын удирдлагын хийсэн үйлдэл болон, байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээ төдийхнийг мэдээллэдэг хэрэгсэл хэвээр байна гэжээ.

Энэхүү судалгааны асуулгын хүрээнд нэг байгууллагын веб сайт нийт 341 оноо цуглуулах боломжтой бөгөөд хамгийн их оноо болох 171 оноог Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам цуглуулсан байна. Хэдийгээр үндсэн авах ёстой онооны 50 хувийг цуглуулсан ч уг яам нийт судалгаанд

хамрагдсан 65 байгууллагыг тэргүүлсэн байна. Эхний 10 веб сайтыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Байгууллагын нэр	Оноо
1	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	171
2	Цагдаагийн ерөнхий газар	168
3	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	162
4	Гаалийн ерөнхий газар	132
5	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо	111,5
6	Төр засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газар	110
7	Эрчим хүчний газар	102
8	Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газар	100
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	99
10	Нийгмийн даатгалын ерөнхий газар	95

Судалгааны байгууллагаас дараахь Зөвлөмжийг өгсөн болно. Үүнд:

- Стандарт батлах. Төрийн байгууллагын веб сайтад заавал тавигдах ёстой баримт бичиг, мэдээлэл болон тэдгээрийг шинэчилж байх хугацаа, веб сайтны бүтэц зохион байгуулалт зэргийг нарийвчлан тусгасан веб сайтыг нээлттэй, ил тод байдлыг хангах стандарт боловсруулж мөрдүүлэх.
- Бүтцийг хялбарчлах энгийн болгох. Төрийн байгууллагын веб сайтны хэлбэр, бүтцийг хялбаршуулж техник технологийн анхан шатны мэдлэгтэй хүнд ашиглагдахуйц болгох.
- Хариуцсан мэргэжилтэн томилох. Тухайн төрийн байгууллагын цахим хуудсыг хариуцан ажиллах үүрэг бүхий орон тооны ажилтан бий болгох. Эсвэл тус байгууллагын албан хаагч бүр өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь веб сайтанд шинэчлэх оруулж байх үүргийг ажил үүргийн хуваарьт нь албан ёсоор оруулж, түүний хэрэгжилтийг үнэлж байх механизмыг бүрдүүлж өгөх.
- Веб сайтаар үйлчилгээ үзүүлэх. Төрийн байгууллагын зүгээс иргэдэд үзүүлдэг үйлчилгээнээс боломжтой бүх үйлчилгээг веб сайтаар хүргэж байх. Эсвэл үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалт болон төлбөр хураамжийн мэдээлэл, өргөдлийн маягт зэргийг татаж авах, хэвлэх боломжтойгоор веб сайтанд байрлуулдаг байх.
- Оролцоог хангах. Төрийн байгууллагын шийдвэр гаргах явцад веб сайтаар дамжуулан иргэдийн санал авах тогтолцоог болон хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, цуглуулсан саналуудыг шийдвэр гаргах түвшинд авч хэрэгжүүлдэг, тусгадаг болох.
- Тогтмол үнэлгээ. Төрийн байгууллагын веб сайтанд тавих стандарт боловсруулсан тохиолдолд тухайн стандартын дагуу тогтмол давтамжтай үнэлгээ хийдэг байх.
- Сайн туршлагаа хуваалцах. Өөрийн байгууллагын цахим хуудсыг нээлттэй, ил тод болгохын төлөө ажиллаж буй, тодорхой хэмжээний үр дүнд хүрсэн төрийн байгууллагын сайн туршлагыг бусад байгууллагуудад

хуваалцах болон тухайн сайн туршлагыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

- Санхүүжилт шийдэх. Тухайн веб сайтын байнгын ажиллагааг хангахад зориулсан төсөв хөрөнгийг, төсөвт суулгаж төлөвлөх, тэрхүү төсвийг нь эрх бүхий байгууллагаас баталж зориулалтаар нь зарцуулж, зарцуулалтад хяналт тавих.

Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газраас Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, төрийн байгууллага хоорондын өргөдөл, гомдлын урсгалыг хянах цахим тогтолцоонд шилжүүлж, мэдээллийг иргэдэд нээлттэй болгох чиглэлээр “Төрийн байгууллагуудын интернэт, вэб хуудас ажиллуулах журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. Мөн тус газраас “Мидас/Монита” ТББ-тай хамтран төрийн байгууллагуудын вэб хуудсанд мониторинг хийж, санал зөвлөмж гаргасан бөгөөд уг санал зөвлөмжид үндэслэн төрийн байгууллагуудын вэб хуудасны стандартын төслийг боловсруулж байна.

Төрийн байгууллагуудыг вэб хуудастай, ажилтан бүрийг цахим шуудангийн хаягтай болгох ажлын хүрээнд АНУ-ын төслийн багтай хамтран “Жуумла Монгол” өдөрлөг, сургалтыг 2009 оны 9 дүгээр сарын 29-30-нд төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүд, олон нийтийн дунд зохион байгуулсан. 2009 оны эхний хагас жилийн байдлаар “жуумла монгол” системд суурилсан вэб хуудастай 99, РНР програмчлалтай 10, “word press” програмчлалтай 2 төрийн байгууллага байгаа бөгөөд нийтдээ 148 домейн нэр, 1890 мэйл хаяг үүсгэж ашиглалтад оруулсан байна.

Үндэсний дата төвөөс төрийн байгууллагуудын вэб, и-мэйлийн үйлчилгээнд мониторинг хийж алдаа цоорхойг засаж ажиллаж байгаа бөгөөд төрийн байгууллага бүртэй 2010 оны 6 дугаар сараас үйлчилгээний гэрээ байгуулж ажиллаж байна. Тус төвийн стратеги, бизнес төлөвлөгөөнд төрийн байгууллагуудын вэбэд мониторинг хийх талаар тусган тогтмолжуулах талаар ажилласан байна.

Эрүүл мэндийн нэгдсэн тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлэх, түүнийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлэх чиглэлээр томоохон эрүүл мэндийн нэгдлүүдийг жижиг эмнэлгүүдтэй нэгдсэн мэдээллийн системээр холбох, эрүүл мэндийн нэгдсэн өгөгдлийн сан бий болгох, эрүүл мэндийн тогтолцоог бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоотой уялдуулж нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлэх, улмаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шинэ шатанд хүргэх талаар судалж “Цахим эрүүл мэнд” төсөл боловсруулсан байна.

Дээд болон мэргэжлийн боловсролын бүх сургуулийг мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбон, ашиглалт, шугамын түрээс, үйлчилгээний зардлыг төрөөс хариуцах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуулиудыг мэдээллийн сүлжээнд холбох, сургалтын материал хөтөлбөрийг цахим хэлбэрт оруулж зайн сургалт, онлайн сургалт хийх, эцэг эх, сурагч нарыг холбосон мэдээллийн цахим систем

бий болгох зорилготой “Цахим боловсрол” төслийг боловсруулан Дэлхийн банкинд танилцуулж, санхүүжүүлэх асуудлаар санал тавьсан байна.

“Албан хэрэг хөтлөлт, цахим архивын онлайн системийг байгуулах” төслийг хэрэгжүүлж системийг суурилуулан туршсан байна.

Иргэний бүртгэл мэдээллийн төвийн архивын цахим санг үүсгэх ажлын хүрээнд “Иргэний ухаалаг үнэмлэх”, “Хаягжилтийн нэгдсэн тогтолцоо” төслүүдийг өөрийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гүйцэтгэх тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлжээ.

Гамшгийн үеийн холбооны найдвартай ажиллагааг хангах зорилгоор гамшгийн мэдээлэл, холбооны техник, хэрэгслэлийг улам боловсронгуй болгох, шинэчлэх чиглэлээр судалгаа хийж байгаагийн зэрэгцээ үүрэн холбоо, интернэт технологид суурилсан гамшгийн мэдээллийг хүлээн авах, боловсруулах, зарлан мэдээлэх систем бий болгох зорилготой “Тусгай хэрэглээний дэд бүтэц бий болгох” төсөл боловсруулж хэрэгжүүлж эхлээд байна. Тусгай хэрэглээний гамшгийн зарлан мэдээлэх систем нь Онцгой байдлын ерөнхий газрын шууд хяналт, удирдлаган дор байх бөгөөд гамшгийн тухай мэдээллийг ард иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс хүлээн авах, мэдээллийн бааз, нэгдсэн сан үүсгэх, гамшгийн тухай мэдээллийг ард иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд түгээх үйл ажиллагааг дэмжиж ажиллах зорилготой.¹⁷⁹

2013 онд Эм Ди Эс энд Ассошейтс ХХН нь нийт 50 байгууллагын цахим хуудасны мэдээллийг судалж, олон нийтэд толилуулсан мэдээллийг үнэлэх, төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн тайлан, тухайн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой нотлох баримтуудтай танилцаж үнэлгээ өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн билээ. Тус үнэлгээний ерөнхий хүснэгтийг харуулбал:

АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ¹⁸⁰

№	Байгууллагын нэр	Авсан оноо
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	74.5
2	Цөмийн энергийн газар	72.5
3	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам	72.5
4	Хил хамгаалах ерөнхий газар	71
5	Худалдан авах ажиллагааны газар	69.5
6	Санхүүгийн зохицуулах хороо.doc	69
7	Хөдөлмөрийн яам	65.5
8	Төрийн өмчийн хороо	65
9	Сонгуулийн ерөнхий хороо	65
10	Татварын ерөнхий газар	64
11	Зам тээврийн яам	64
12	Үндэсний статистикийн хороо	63.5
13	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	62.5
14	Барилга, хот байгуулалтын яам	62.5

¹⁷⁹ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангийн 27-р хуудас

¹⁸⁰ Төрийн төв байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний тайлангаас

15	Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар	62
16	Хууль зүйн яам	62
17	Нийгмийн даатгалын ерөнхий газар	60.5
18	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	60.5
19	Архивын ерөнхий газар	59.5
20	Мэдээлэл технологи шуудан харилцаа холбооны газар	58.5
21	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар	58.5
22	Сангийн яам	58
23	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	57.5
24	Мал эмнэлэг, үржлийн газар	57.5
25	Цагдаагийн ерөнхий газар	55.5
26	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	55.5
27	Ашигт малтмалын ерөнхий газар	54.5
28	Уул уурхайн яам	53.5
29	Стандартчлал хэмжил зүйн газар	53
30	Зэвсэгт хүчний жанжин штаб	53
31	Иргэний нисэхийн ерөнхий газар	52
32	Боловсрол, шинжлэх ухааны яам	51.5
33	Эрүүл мэндийн яам	51
34	Батлан хамгаалах яам	50.5
35	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар	50.5
36	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	50.5
37	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	50
38	Соёл, спорт, аялал, жуулчлалын яам	46.5
39	Онцгой байдлын ерөнхий газар	43.5
40	Хүний эрхийн үндэсний комисс	43
41	Эдийн засгийн хөгжлийн яам	43
42	Үндэсний аудитын хороо	42.5
43	Хүүхдийн төлөө үндэсний газар	42
44	Төрийн албаны зөвлөл	39.5
45	Эрчим хүчний яам	38
46	Монгол банк	33
47	Гадаад харилцааны яам	32.5
48	Оюуны өмчийн газар	29.5
49	Гаалийн ерөнхий газар	26.5
50	Газрын тосны газар	19.5

Удирдамжийн 3-т заасан 51 төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэхэд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Хил хамгаалах ерөнхий газар, Цөмийн энергийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо эдгээр 7 байгууллага хамгийн өндөр оноо буюу 65.5-аас 74.5 оноо авсан нь хамгийн сайн үнэлгээ болно. Эдгээрээс Цөмийн энергийн газраас бусад байгууллага нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн мэдээллийн ил тод байдлыг 4

төрлөөр нь цахим хуудасдаа олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэсэн нь ийнхүү үнэлэгдэх үндэслэл болж байна. ЭБАТ-уудын нэмэгдлийг авч үзвэл УБЕГ цалингийн 30%, ҮХААЯ, ХХЕГ, ЦЭГ тус бүр 40%-р, ХААГ 15%, СЗХ 10%-р тус тус тогтоосон байна. Эдгээрээс ЭБАТ нь харьцангуй бага нэмэгдэл авч байгаа СЗХ-ы авлигын эсрэг үйл ажиллагаатай газар дээр нь танилцахад цахим хуудсаараа хуулиар тогтоосон мэдээллийг бүрэн толилуулсан, мэдээллийн самбар, өргөдөл, гомдол авах хайрцаг байрлуулж, цахим хуудсаа хөгжүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгө зарцуулсан, бичиг баримтын эмх, цэгц үлгэр жишээ байлаа.

Бидний үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас нийтдээ 37 байгууллага буюу 72% нь 50-аас дээш оноо авсан байна. Үнэлгээний дундаж нь 51хувь байна.

Энэхүү судалгааны явцад хийсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан дөрвөн чиглэлийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгаа талаар Улсын Их Хурлаас байгуулагддаг 7 байгууллага, 16 яам, 26 тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудас

тай танилцан дүгнэлт хийлээ. Энэхүү дүгнэлтээр 7 яам, 16 тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, 4 Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллага ил тод байдлын цэс нээн тодорхой хэмжээнд ажиллуулдаг байна. Дээрх байгууллагуудын цахим хуудсанд хийсэн нэгдсэн дүгнэлтийг дор харуулав.

	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зүйл заалт	Мэдээлэл байршуулсан	Мэдээлэл байршуулаагүй	Булантай ч мэдээлэл байршуулаагүй	Хамаарахгүй
Үйл ажиллагааны Ил тод байдал	Эрхэм зорилго, үйл ажиллагааны страгегийн зорилт, зорилго, тайлан /7.1.1/	40	7	1	-
	Харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь /7.1.2/	44	4	-	-
	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт /7.1.3/	30	11	-	7
	Мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам заавар /7.1.4/	44	3	1	-
	Шийдвэрийн төслийг цахим хуудаснаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулах /7.1.5/	3	45	-	-
	Төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа /7.1.7/	-	-	-	48
	Зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх ажиллагааны	16	10	2	20

	чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа /7.1.8/				
	Хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц /7.1.9/	26	18	4	-
Хүний нөөцийн ил тод байдал	Сул орон тооны зар /8.1.1/	20	25	3	-
	Албан хаагчийн ёс зүйн дүрэм /8.1.2/	26	21	1	-
	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам /8.1.3/	15	27	6	-
	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ /8.1.5/	4	43	1	-
Төсөв, санхүүгийн ил тод байдал	Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл /9.1.1/	36	12	-	-
	Жилийн эцсийн санхүүгийн тайлан /9.1.2/	34	11	3	-
	Аудитын дүгнэлт /9.1.3/	35	13	-	-
	Төсөвт нэмэлт өөрчлөлт орсон /9.1.4/	2	45	1	-
	Хууль тогтоомжинд заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээ /9.1.5/	1	43	2	2
Худалдах авах ажиллагааны ил тод байдал	Худалдан авах ажиллагааны бодлого /10.1.1/	11	35	2	-
	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийг урилга /10.1.2/	28	19	1	-
	Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл /10.1.3/	6	42	-	-
	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /10.1.4/	10	38	-	-
	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан /10.1.5/	21	26	1	-
	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн /10.1.7/	2	43	3	-

Энэхүү тайланг бичих өдрийн байдлаар Зам, тээврийн яам, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын цахим хуудас нь ажиллаж байсан боловч, үнэлгээ хийж байсан үе буюу 2014 оны 6-р сарын 24-ний өдрийн 15 цаг 40 минутын үед ажиллахгүй байсан тул энэхүү 2 газар энэхүү судалгаанд ороогүй болно. Мөн Тахарын ерөнхий газар цахим хуудас нь олдоогүй тул мөн судалгаанд ороогүй.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дөрвөн чиглэлийн ил тод байдал нь дотроо мөн задарсан байгаа юм. Энэхүү задаргаа тус бүрээр нь үнэлгээ хийв.

- Үйл ажиллагааны ил тод байдал

Үнэлгээнд хамрагдсан 48 байгууллагаас эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тайлангаа 7 байгууллага /Оюуны өмчийн газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Төрийн өмчийн хороо, Мал эмнэлэг, үржлийн газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Сонгуулийн ерөнхий хороо, Монгол банк/ , булантай ч мэдээлэл 1 байгууллага /Газрын тосны газар/ байршуулаагүй байв.

Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтаа 11 байгууллага /Худалдан авах ажиллагааны газар, Сангийн яам, Хууль зүйн яам, Архивын ерөнхий газар, Батлан хамгаалах яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Эрүүл мэндийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк, Хүний эрхийн үндэсний комисс/ байршуулаагүй байв.

Шийдвэрийн төслийг цахим хуудсаснаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулах шаардлагыг 3 байгууллага /Стандартчилал, хэмжил зүйн газар, Боловсрол шинжлэх ухааны яам, Хөдөлмөрийн яам/ **хангасан** байна.

Зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг 10 байгууллага /Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газар, Оюуны өмчийн газар, Хууль зүйн яам, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Монгол банк/ 2 байгууллага /Газрын тосны газар, Эдийн засгийн хөгжлийн яам / булантай ч мэдээлэл байршуулаагүй байна.

Тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгүйдэг төрийн байгууллага байхгүй байна.

- Хүний нөөцийн ил тод байдал

Албан хаагчийн ёс зүйн дүрмээ 48 байгууллагаас 22 байгууллага цахим хуудсандаа байршуулаагүй байгаагаас 1 байгууллага /Зэвсэгт хүчний жанжин штаб/ нь булантай боловч мэдээлэл байршуулаагүй байна.

Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмаа 33 байгууллага байршуулаагүй байгаагаас 6 байгууллага /Онцгой байдлын ерөнхий газар, Цаг уур орчны шинжилгээний газар, Гадаад харилцааны яам, Барилга, хот байгуулалтын яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар/ нь булантай ч мэдээлэл байршуулаагүй байна.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг 4 байгууллага /Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам/ -аас бусад байгууллага энэхүү мэдээллээ байршуулаагүй байна.

- Төсөв санхүүгийн ил тод байдал

Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслөө 48 төрийн байгууллагаас 12 нь цахим хуудсандаа байршуулаагүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 14 байгууллага /Тагнуулын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Хууль зүйн яам, Батлан хамгаалахын яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Газрын тосны газар, Мал эмнэлэг, үржлийн газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Хөрөнгө оруулалтын газар, Үндэсний аудитын газар, Монгол банк/ цахим хуудсандаа байршуулаагүйгээс 3 байгууллага /Оюуны өмчийн газар, Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хөдөлмөрийн яам/ булантай ч мэдээллээ байршуулаагүй байна.

Аудитын дүгнэлтээ 13 байгууллага /Тагнуулын ерөнхий газар, Цөмийн энергийн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, , Батлан хамгаалахын яам , Зэвсэгт хүчний жанжин штаб , Иргэний нисэхийн ерөнхий газар, Газрын тосны газар, Мал эмнэлэг, үржлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Үндэсний аудитын газар, Монгол банк / цахим хуудсандаа байршуулаагүй байна.

Хууль тогтоомжинд заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авах, түүний хэмжээг зөвхөн Сангийн яам байршуулсан байна.

- Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Худалдан авах ажиллагааны бодлогоо 48 байгууллагаас 11 байгууллага л цахим хуудсандаа байршуулсан байна.

Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгаа 20 байгууллага байршуулаагүйгээс 1 байгууллага булантай боловч мэдээллээ байршуулаагүй байна. Худалдан авах ажиллагааны газрын цахим хуудсанд мөн энэхүү мэдээллээ байршуулах магадлалтай.

Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэсэлэлээ 6 байгууллагаас бусад нь байршуулаагүй байна.

Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг 10 байгууллага /Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Стандартчилал хэмжил зүйн газар, Худалдан авах ажиллагааны газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Боловсрол шинжлэх ухааны яам, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар, Эрчим хүчний яам, Сонгуулийн ерөнхий хороо/ цахим хуудсандаа **байршуулсан** байна.

Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлангаа 27 байгууллага байршуулаагүйгээс 1 байгууллага нь булантай ч мэдээллээ байршуулаагүй байна.

Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг 2 байгууллага /Боловсрол шинжлэх ухааны яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам/ цахим хуудсандаа **байршуулжээ**.

2014 оны 6-р сарын сүүлчээр хийсэн энэхүү ажиглалтыг өнгөрсөн оны 11-р сард хийсэн дүгнэлттэй харьцуулбал төрийн байгууллагууд мэдээллээ ил тод болгох талаар тодорхой ахиц гарсан байна.

Манай орны аль ч өнцөг буланд байгаа иргэн гар утас, компьютер, нөүтбүүкээсээ төрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломж бүрдсэн. Ямар мэдээлэл тавихыг хуульчилсан өнөөгийн энэ нөхцөлд аль нэгэн төрийн байгууллагын удирдах болон бусад ажилтантай биечлэн уулзаж мэдээлэл хүсэх шаардлагагүй болсон нөхцөлд Конвенцийн хэрэгжилтийн үнэлгээ хийхийн тулд бид аль нэг байгууллагын даргатай уулзаж танай байгууллага юу хийж байна вэ? Гэж уулзах аргыг сонгоогүй болно. Энэ арга нь үнэлгээ “хөндлөнгийн байх” шаардлагыг хангахгүй гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төрийн бүх байгууллагууд хуулийн хэрэгжилтийг жигд хангаж ажиллах нь зүйтэй
- Олон нийт, хөндлөнгийн үнэлгээ хийж буй байгууллага, төрийн бусад байгууллага НҮБ-ийн байгууллагууд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг дэлхийн хаанаас ч авах боломжийг практик дээр бодитоор хангах

9.1. (с) авлигыг үл тэвчих уур амьсгал бий болгоход хувь нэмэр оруулах мэдээллийг олон нийтэд түгээх, түүнчлэн олон нийтийн боловсролын хөтөлбөр, түүний дотор дунд болон их, дээд сургуулийн хөтөлбөр хэрэгжүүлэх; /Конвенцийн 13.1.с/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бага, дунд боловсролын тухай хуулийн 4.1 дэх заалт болох бага боловсролын агуулга, 5.1 дэх заалт болох суурь боловсролын агуулга болон 6.1 дэх болох бүрэн дунд боловсролын агуулга, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9.2 дах заалт болох техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь суралцагчид технологийн процессийг удирдах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэх бөгөөд ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэж, улмаар хэсэг тус бүрийн агуулга, Дээд боловсролын тухай хуулийн 3.2 дах хэсгийн дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэшэх хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр хэсэг тус бүрийн агуулгад “авлигыг үл тэвчих” хандлага, ёс зүйн хүмүүжлийн талаар хангалттай тодорхой байдаггүй тул энэ талаар нэмэлтээр оруулж өгөх шаардалгатай байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 471 дүгээр тушаалын хавсралт¹⁸¹

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм баталсан байна. Уг дүрэмд сургууль нь сургууль хөгжүүлэх хөтөлбөр, стратеги төлөвлөгөөтэй байна. Сургууль хөгжүүлэх хөтөлбөрт үндэслэн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж мөрдөнө. Хөтөлбөр, төлөвлөгөөнд дараах асуудлыг тусган хэрэгжүүлнэ:

- 1/ Сургуулийн хөгжлийн бодлого;
- 2/ Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт;
- 3/ Хүний нөөцийн хөгжил;
- 4/ Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашиг;
- 5/ Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал, оролцоо;
- 6/ Мэдээлэл харилцаа, технологийн хөгжил;
- 7/ Сургуулийн үйл ажиллагаанд дахь олон нийтийн оролцооны хангалт;
- 8/ Санхүүгийн болон материаллаг нөөц.

Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудсанд бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын хөтөлбөр, хичээл бүрийн хөтөлбөрийн минимум шаардлагыг тодорхойлсон мэдээлэл байхгүй байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

- Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2013 оны тайлангаас:
 - Энэ оны хувьд шударга ёсыг бага наснаас нь төлөвшүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд гол зорилтот бүлгийнхээ нэгийг бага болон өсвөр насны хүүхдүүд гэж тодорхойлон эхний хагас жилд эдгээр насны бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн ажлуудыг хийж эхлүүлсэн. Хүүхэд багачуудад шударга ёсны зан үйл төлөвшүүлэх зорилгоор АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хэвлүүлсэн “Шударга мазаалайнууд”, “Найзын яриа” номд дурдсан утга санаа, агуулгыг түгээн дэлгэрүүлэхээр “Зуны даалгавар” арга хэмжээг зохион байгуулав. Нийслэлийн 61, 99, 103, 106, 19 дүгээр цэцэрлэг, 23, 34, 24, “Цэцээ гүн” сургуулийн арга зүйч, нийгмийн ажилтанд албан ёсоор танилцуулж, хүлээлгэн өгсөн болно. Дээрх цэцэрлэг, сургуулийн хүүхдүүд зуны амралтаараа бэлтгэж ирсэн гар зураг, зохион бичлэг, баримал, наамал, хайчилбар зэрэг бүтээлүүдээрээ үзэсгэлэн гаргасан бөгөөд “Шударга мазаалайнууд”, “Найзын яриа” номын утга агуулгыг илэрхийлсэн

¹⁸¹ Эх сурвалжийг <http://www.meds.gov.mn/frontpage>

жүжигчилсэн тоглолт бэлтгэж, зохиосон шүлгээ уншиж үе тэнгийнхэндээ сонирхуулсан нь үр өгөөжтэй ажил болов. “Зуны даалгавар” арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурвалжлуулж мэдээлэх ажлыг зохион байгуулсан нь шударга ёсны үзэл санааг хүүхэд багачуудад түгээн дэлгэрүүлэх үйлсэд бодит хувь нэмэр оруулсан хэмээн үзэж байна. Энэ ажилд Монголын Үндэсний олон нийтийн телевизийн “ММ” агентлаг, UBS телевиз, хүүхэд танин мэдэхүйн “Dream” телевиз, NTV, SBN, TV-5, MN-25 дугаар суваг телевиз, Монголын Үндэсний олон нийтийн радиогийн Хүүхдийн нэвтрүүлгийн алба, мэдээллийн “Хурд” агентлаг, www.news.mn, www.eagle.mn зэрэг хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг татан оролцуулж, хамтран ажилласан юм. “Шударга мазаалайнууд”, “Найзын яриа” номоор цэцэрлэг, сургуулийн хүүхэд багачуудын дунд “Зуны даалгавар” арга хэмжээг зохион байгуулсан нь Авлигатай тэмцэх газрын 2013 онд дэвшүүлсэн эрхэм зорилтыг хангахад чиглэсэн ажил болов.

- Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын хувьд шударга байдлын түвшиний ерөнхий үнэлгээ 2008, 2010, 2012 онуудад хийсэн судалгааны дүнгээр жил ирэх тутам буурч байгаа байдал нь ёс зүй, ёс суртахуун, зан төлөвийн хувьд шударга бус байдалтай эвлэрэх, түүнд дасан зохицох, төлөвших хандлагатай байна хэмээн үзэж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд ёс зүйг дээшлүүлэх тал дээр анхаарал хандуулах, шат дараалсан төлөвлөгөөт арга хэмжээ зохион байгуулах санал боловсруулсан шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагад үндэслэн тус хэлтсээс Хүүхдийн төлөө газартай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхлэв. Төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлсэн эхний ажил бол 2013 – 2014 оны хичээлийн жилийн нээлтийн хичээлийг Монгол улсын Ерөнхийлөгч заадаг бөгөөд орон даяар хүрдэг тул энэхүү хичээлийн сэдэв шударга ёс – ёс суртахууны чиглэлээр хүүхдүүдэд хүрвэл нөлөөллийн сайн арга хэмжээ болох талаар уламжилсныг хүлээн авч шинэ хичээлийн жилийн сэдэв “Хуулийн засаглал ба хүүхдийн оролцоо” сэдвээр явагдсан болно. Энэхүү хичээлийн агуулгад хүүхдийн шударга байдлын түвшин буурч байгаа нь хүүхдүүдийн буруу зүйлийг зөв гэж үзэх хандлагаас шалтгаалдаг талаар тодорхой тусгагдсан, Монгол улсын Ерөнхийлөгч орон даяар хүргэсэн ач холбогдолтой арга хэмжээ болсон гэж үзэж байна. Цаашид энэхүү үйл ажиллагаа нь хүүхдийн төлөө байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдана.
- Өсвөр насны хүүхдүүдэд хууль, эрх зүйн мэдлэгийг энгийн үгээр, сонирхолтой байдлаар эзэмшүүлэх зорилгоор жил бүр Олон улсын хүүхдийн найрамдал төвд зохион байгуулагддаг “Германы долоо хоног” арга хэмжээ зохион байгуулагддаг. Арга хэмжээнд нийслэл болон орон нутгийн нийт 300 гаруй хүүхдүүдэд хамрагддаг бөгөөд тус

арга хэмжээний хүрээнд сурагчдад эрх зүйн мэдлэг олгох мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 09 дүгээр сарын 01-ний өдрийн хичээлийн үеэр өгсөн 5 гэрийн даалгаварыг хийх боломжийг олгохыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хилийн чанад дахь ерөнхий боловсролын сургуулиудын асуудал эрхэлсэн төв газрын даргад хамтран ажиллах талаар санал дэвшүүлсэн ба ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн.

- Хүүхэд залуучуудад шударга ёсыг сурталчилан таниулж, өдөр тутмын амьдралдаа мөрдлөг болгон хэвшүүлэхэд түлхэц өгөх зорилготой “Шударга хүний долоон дадал” лекцэнд Азийн сангийн санхүүжилттэйгээр ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, их дээд сургуулиудын 1 болон 2 дугаар курсын оюутнуудыг хамруулжээ. Илтгэлийг Нийслэлийн Ерөнхий боловсролын 79, 65, 62, 42, 23, 1, 5, 33 Орос 3, Хобби, МУИС-ын лицей Экологийн сургууль, Багахангай дүүргийн “Хангай”, Налайх дүүргийн “Голомт”, Багануур дүүргийн Цогцолбор сургууль, ШУТИС-ийн салбар сургуулиуд, Соёмбо дээд сургууль, Монгол дээд сургууль, Хууль сахиулахын их сургууль, Хилийн цэргийн дээд сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын сургууль, Онцгой байдлын сургууль, Батлан хамгаалахын их сургуулийн Ахлагчийн сургууль, Удирдлагын академи, Шихихутуг хууль зүйн дээд сургууль, Татварын ерөнхий газар зэрэг нийт 4900 гаруй оюутан залуус сурагчдыг лекцэнд хамруулсан байна.
- Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилго бүхий “Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын хамтран ажиллах ажлын хэсэг”-ийг 2008 оноос байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хэсэг нь жил бүр хамтран ажиллах төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий сайдаар батлуулан хэрэгжүүлсэн байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг хөндлөнгөөс хянах, зарим үйл ажиллагааг төрийн байгууллагуудтай хамтран явуулах замаар авлига, хүнд суртлыг бууруулах, таслан зогсоох зорилго бүхий ТББ-уудын сүлжээ 2008 онд 21 аймагт байгуулагдсан бөгөөд уг сүлжээний үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах зорилгоор Авлигатай тэмцэх газраас орон нутаг дахь ТББ-уудын сүлжээ болон аймгийн Засаг даргатай гурвалсан гэрээг 4 жилийн хугацаатай байгуулан ажиллаж байна. Ингэснээр авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах боломжийг бүрдүүлсэн төдийгүй авлигыг бууруулах, улмаар таслан зогсоох ажилд орон нутаг дахь Төрийн бус байгууллагуудын сүлжээ идэвхтэй оролцох болсон байна.

Авлигатай тэмцэх газар Монгол Улсын Засгийн газар, Азийн сантай хамтран авлигад өртөх эрсдлийн үнэлгээг гаргах, авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зорилгоор 2008 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам, төлөвлөлт”, 2009 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, сайжруулах арга зам”, 2010 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний

хэрэгжилтийг үнэлэх аргачлал ба орон нутгийн оролцоог хангах нь” сэдэвт сургалт, семинарыг тус тус зохион байгуулсан. Үүний үр дүнд улсын хэмжээнд Засгийн газрын нийт 74 байгууллага “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2008 онд 26 /яам, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг агентлагууд/, 2009 онд 55 /11 яам, 42 агентлаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба/, 2010 онд 74 /11 яам, 42 агентлаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, 21 аймгийн ЗДТГ/ уг төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Мөн 2010 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд /төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 26 хуулийн этгээд/, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, нийслэлийн 9 дүүрэг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.

Авлигатай тэмцэх газар байгуулагдан ажиллаж эхэлснээс хойших хугацаанд авилгалын асуудлаар улс, бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн хүрээнд иргэд, олон нийтийг хамарсан зөвлөлгөөн, семинар, сургалт зохион байгуулах хүрээнд хэд хэдэн арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулсан байна. Үүнд, 2007 онд “Авлигагүй нийгэм-тогтвортой хөгжлийн гарц” сэдэвт үндэсний бага хурал, 2008 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам, төлөвлөлт” сургалт- семинар, “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, явц байдал, цаашдын хандлага” нээлттэй хэлэлцүүлэг, “Ажил олгогчид, бизнес эрхлэгчид авлигын эсрэг” нээлттэй хэлэлцүүлэг, “Хүнд сурталд гарц бий” нээлттэй хэлэлцүүлэг, 2009 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт болон НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлэх нь” сургалт-семинар, “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангах нь” сургалт-семинар, “Стандарт ба шударга бизнесийн хөгжил” нээлттэй хэлэлцүүлэг, 2010 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх аргачлал болон орон нутгийн оролцоог хангах нь” сургалт-семинар, “Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт” сургалт-семинар, “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт” сургалт-семинар, “Монгол Улсад НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцийн хэрэгжилтийн гаргах арга зам” семинар, “Боловсролын салбарт шударга ёсыг тогтоох нь” нээлттэй хэлэлцүүлэг, “Хүний эрх, шударга ёс, ил тод байдлыг хангах нь” нээлттэй өдөрлөг, “Шударга ёс-миний ирээдүй” нээлттэй өдөрлөг, “Авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагаа, шударга ёсыг бэхжүүлэх нь” сургалт, “Төрийн үйлчилгээний нээлттэй, ил тод байдал” өдөрлөг, “Хувийн хэвшил дэх авлига” нээлттэй хэлэлцүүлэг, “Хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа” нээлттэй хэлэлцүүлэг тус тус зохион байгуулсан. Эдгээр нь нийгмийн зорилтот бүлэг тус бүрийг хамарч чадсан хэмээн үзэж байна гэжээ.

“Авилгалын талаарх олон нийтийн санаа бодол, байр суурь” сэдэвт социологийн судалгааг 1999, 2002 онд хийснээс хойш үндэсний хэмжээнд санал асуулга явагдаагүй байна. Харин Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн дагуу Авлигатай

тэмцэх газар байгуулагдан ажиллаж эхэлснээр уг хуульд зааснаар тус байгууллагаас олон улсын туршлагад үндэслэн, шинжлэх ухааны арга зүйд нийцсэн, үндэсний түвшинд тооцож болохуйц, авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааны үзүүлэлтүүдийг багтаасан Авлигын индекс тооцох аргачлалын төслийг Монгол Улсын хэмжээнд анх удаа боловсруулав. Тус төслийг боловсруулахын тулд гадаадын 11, дотоодын 10 судалгааны үр дүн, арга зүйг судлан үзэж, боловсруулсан арга зүйг үндэсний хэмжээнд 6 удаа туршсан. Боловсруулсан аргачлалын төслийг үндэсний эрдэмтэн, судлаачдаар хэлэлцүүлэн, төрийн байгууллагуудад хүргүүлж холбогдох саналын дагуу засвар, өөрчлөлтийг хийсэн. Аргачлалыг Авлигатай тэмцэх газрын дарга, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар баталгаажуулсан. Ингэснээр авлигын индексийг үндэсний хэмжээнд тооцон гаргах боломжтой болов. Авлигатай тэмцэх газраас авлигын индексийг тооцоход шаардлагатай холбогдох судалгааг явуулж, үр дүнгээр нь авлигын индексийг тооцон 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдөр нийтэд мэдээлсэн. Уг аргачлалын дагуу Авлигын индексийг үндэсний хэмжээнд болон 21 аймаг, нийслэл, 12 салбарын хэмжээнд тооцон гаргасан. Монгол Улсын Авлигын индексийг (үндэсний хэмжээнд) тооцоход 0.64 гарч байна. Цаашид авлигын индексийг хоёр жил тутам тооцож түүний өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тооцож үнэлэлт, дүгнэлт өгөхөд индексийн ач холбогдол оршиж байгаа юм. /Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангаас/

Авлигатай тэмцэх газар нь авлигыг үл тэвчих хүмүүжлийг бага наснаас нь төлөвшүүлэх чиглэлээр дээр дэрдсан олон төрлийн арга хэмжээ авч, сургууль, ТББ, олон улсын байгууллага, Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүртэл оролцуулж байгаа нь сайшаалтай байна. Цаашид төлөвлөгөөт буюу цаг үеийн шинжтэй арга хэмжээнээс тогтмолжсон, системтэй, заавал хэрэгжих түвшинд хүргэх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигыг үл тэвчих хүмүүжлийг нэг бие даасан хичээл болгож оруулах нь ахлах анги, мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд байж болох боловч хүүхдийн оюуны хөгжил, насны онцлогт нь тохирсон хэлбэрээр униших, монгол хэл, хүн нийгэм, иргэний боловсрол, хууль, эдийн засгийн суурь мэдлэг олгох хичээл бүрийн хөтөлбөрт суулгаж өгөх чиглэлээр Авлигатай тэмцэх газар, Боловсрол шинжлэх ухааны яам, ТББ-ууд хамтран ажиллах нь зүйтэй.
- Бүх шатны сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийн минимум шаардлагыг Боловсрол шинжлэх ухааны яам цахим хуудсандаа ил тод байршуулах нь эцэг, эх, сургууль, хүүхдийн хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой
- Хууль зүйн болон эдийн засгийн менежмент, нийгмийн ухааны чиглэлийн боловсролын хөтөлбөрийн агуулгад авлигыг үл тэвчих уур амьсгалыг бий болгоход чиглэсэн сэдвүүдийг түлхүү оруулах

9.1.(d)авлигатай холбоотой мэдээлэл хайх, авах, хэвлэн нийтлэх, түгээх эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах. Тэрхүү эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт тавьж болох боловч хязгаарлалт нь зөвхөн хуульд заасан байх бөгөөд дараах үндэслэлээр шаардлагатай байвал зохино: /Конвенцийн 13.1.d/

(i)бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх; /Конвенцийн 13.1.d.(i)/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Иргэний хууль

Иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглоно. /21.1./

Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ. /21.2./

Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ. /21.3./

Эдийн бус гэм хорыг арилгах /230 дугаар зүйл/

Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй. /230.1./

Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө. /230.2./

Гэм хор учрах буюу түүнээс урьдчилан сэргийлэх, учирсан гэм хороос үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн буюу эрх бүхий этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/ нөлөөлсөн бол гэм хорыг арилгах үүрэг болон түүний хэмжээг тодорхойлохдоо тэдгээрийн гэм буруугийн хэмжээг харгалзана. /230.3.

Эдийн бус гэм хорыг арилгах /511 дүгээр зүйл/

Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ. /511.1./

Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно. /511.2./

Эрүүгийн хууль

Гүтгэх /111 дүгээр зүйл/

Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. /111.1./

Гүтгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. /111.2./ Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ./111.3./

Авлигын эсрэг хуулийн 5.1.6-д аж ахуйн нэгж, байгууллага, иргэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах арга хэмжээ авна гэж заасан байдаг. Энэхүү заалт нь Конвенцийн авлигатай холбоотой мэдээлэл хайх, авах, хэвлэн нийтлэх шаардлагыг хангаж байна гэж үзэж байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн /1998.08.28/ зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино. Уг хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй. / 3.1./ Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй /3.2./ Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно. /4 дүгээр зүйл/ гэж заасан байдаг. Үүнээс үзвэл **хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд ямар нэгэн хязгаарлалт тогтоогоогүй байна. Гэвч Иргэний хуулийн дагуу бусдын нэр төр алдар хүндийг гутаан доромжилж, гүтгэсэн мэдээлэл тараавал иргэний хариуцлага хүлээлгэхээр байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд “бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх” гэдгийг оруулах шаардлагатай
- Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд сэтгүүлчийг эрүүгийн хариуцлагад татдаг явдлыг халахаар хэлэлцүүлэх явцад Конвенцийн энэхүү заалтын бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх талаарх хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд иргэний эрх зүйн хариуцлагаас өөр хариуцлага байх эсэхийг тухайн этгээдийг сэдэлт, зориуд санаатай тохиолдлын талаар нарийвчлан судлаж нэгэн зэрэг шийдвэрлэхийг зөвлөж байна.

ПРАКТИК ОРЧИН

Монгол Улсад эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих эрх зүйн орчин төгс бус. Өөрөөр хэлбэл, мэдээлэл олж авах, эх сурвалжаа хамгаалах, нууцлах, төрийн албан тушаалтны мэдээлэл өгөх эрх, төрийн мэдээлэл нэвтрэх, эрж хайх, түгээх эрх, орчин нь хаагдмал байна. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх хэвлэлийн эздийн хүсэл эрмэлзэл сул. Тодотговол, хэвлэлийн эзэд улс төр, бизнес, сонирхлын бүлэглэлээс хараат байгаа нь сэтгүүлч, ажилтны шударга, үнэнч ажиллах мэргэжлийн зарчимд нөлөөлж, нэг ёсондоо редакцийн хараат бус байдлыг давхар алдагддуулдаг. Сэтгүүлчдийн айдас болгоомжлол, тэдэнд учруулдаг дарамт шахалт их. “Амь насанд хохирол учирч болзошгүй”, “Редакцийн хамгаалалт баталгаагүй”, “Сэтгүүлчийн нийтлэлээр сөхөгдсөн асуудал цагдаа, хууль, шүүхийн өмнө очоод замхардаг”, “Гадны болон эзний дарамт шахалт ирдэг” хэмээх айдас болгоомжлол сэтгүүлчдийн дунд маш их байдаг. Редакци сэтгүүлчээ нэгдүгээрт, шүүхийн өмнө хоёрдугаарт, эрэн сурвалжилсан бүтээлийг нь нийтэлсэн эсэхээр тэднийг хамгаалдаг практик хэвшээгүй байна. Хэрвээ нэгдэх асуудлын тодотгол нь сэтгүүлчийн хариуцлагатай холбоотой гэж үзвэл харин хоёр дахь асуудлын хамаарал нь редакцийн бие даасан байдал болон цензуртэй ихээхэн холбогдож ирнэ. Хуулийн байгууллагын хараат бус, шударга ажиллах байдал алдагдсан. Сэтгүүлчийн сөхөж тавьсан болон илчилж мэдээлсэн асуудлын мөрөөр хууль хяналтынхан ажилладаггүй, харин ч цагдаа, хууль, шүүхийн өмнө очоод замхардаг, эсвэл сэтгүүлчдэд буруу нь тохогддог практик өнөөдөр амь бөхтэй байгаа нь ноцтой асуудал мөн. Энэ нь хараат бус шүүх, хуулийн байгууллагын тогтолцоотой холбоотой. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд сэтгүүлчдэд халгаатай заалт орсон нь тэдэнд “илүү боломж”-ийг олгож байна. Эрхтэн дархтанууд олигархи бүлэглэл, улс төрийн намуудын зүгээс сэтгүүлчдийг хахуульдах замаар худалдан авч дуугүй байлгах, өөрсдийгөө магтуулах хандлага Монголд жилээс жилд газар авч байна. Энэ мэт гадаад, дотоод бодит шалтгаан, бэрхшээл байгаа ч сэтгүүлчид хүчээ нэгтгэвэл авлига, албан тушаалын хэрэг гэх мэт ээдрээтэй олон асуудлыг эрэн сурвалжлах чадвар, хүсэл эрмэлзлэл тэдэнд бий. Сэтгүүлчид хамтран хүчээ нэгтгэн ажиллах гэдэг нь “Эрэн сурвалжлах клуб” байгуулах тухай асуудал бөгөөд олон улсын практикт байдаг басхүү амжилтад хүрсэн тэрхүү үйл ажиллагааг манай сэтгүүлчид ажил хэрэг болговол Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүй цаашид илүү хөгжин, өнөөдрийн нийгэмд газар авч, тогтолцооны шинж нүүрлээд байгаа авилга, хээл хахуулийн эсрэг тэмцэж чадах юм.¹⁸²

¹⁸² Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлангийн 92-р хуудас

Хэвлэл мэдээллийн сургалт, судалгаагаар дагнасан мэргэжлийн байгууллагуудын зохион байгуулж буй авлигатай тэмцэх үйл ажиллагаа харьцангуй цөөн боловч нэлээд бодитой, үр нөлөөтэй байдаг байна. Харин сонин, телевиз зэрэг хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн хувьд олон нийтэд тогтмол давтамжтайгаар авлигын тухай мэдээллийг тасалдалгүй хүргэж буй боловч асуудлыг улстөржүүлэх, захиалгаар баримт, эх сурвалжгүй мэдээлэл уншигчдад өгч тэднийг төөрөгдүүлэх, үзэл бодлоо тулгах зэрэг алдаа гаргаж байна. Харин Авлигатай тэмцэх газар байгуулагдан ажиллаж эхэлснээр авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллүүд албаны эх сурвалжтай болж цэгцрэхийн зэрэгцээ авлигыг бүрдүүлж буй шалтгаан, нөхцөлийг харуулсан мэдээлэл, сурталчилгааны ажил эрчимжиж, энэ чиглэлээр нэлээд дэс дараалалтай арга хэмжээ авагдаж байгааг дурдах нь зүйтэй. Авлигатай тэмцэх газар хэвлэл, мэдээллийн газруудын мэдээ, мэдээллийн эх сурвалжийг ашиглаж, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн хэвлэлтэй хамтран ажиллаж байгаа нь үр ашигтай хэлбэр болж байна гэж үзжээ.

2001-2005 онд гүтгэлэг, нэр төр, доромжлолтой холбоотой 187 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний 151 нь буюу 81 хувь нь хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эсрэг хэрэг байжээ. Эдгээр хэргийн 60 орчим хувь нь улстөрч, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллагын нэхэмжлэлээр шийдвэрлэгдсэн байв. Харин нөгөө хэсэг нь бизнесийн болон улс төрийн бүлэглэл, томоохон албан тушаалтнуудын сүрдүүлэг, заналхийлэл, ноцтой үйлдэлд хүлээстэй сууна. Эндээс дүгнэж үзэхэд, Монголд хэвлэл мэдээллийн салбар далайцтайгаар өсч, хөгжин хууль эрх зүйн орчин бүрдэж буй ч чөлөөт хэвлэл мэдээлэл хавчигдмал байдалд байгаа нь авлига хүрээгээ тэлэх томоохон шалтгаан болж байна.

Монгол Улсад авлигын талаарх мэдээллийг цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг хамгаалах, тэрхүү мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлан шалгах явцад мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангаж, нууцыг чандлан хадгалах тал дээр эрх зүйн баримт бичгийн хүрээнд баталгаажиж хэрэгжсэн зүйл одоогоор алга байна. Мөн Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байгаа аливаа эрүүгийн шинжтэй гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийн эх сурвалжийг хамгаалж, тэдгээрт эрх зүйн туслалцаа үзүүлсэн бодит тохиолдол байхгүй байна. Бид авлигаас ангид байхыг хичээхийг хүсвэл юуны түрүүнд мэдээллийн эх сурвалжийг хамгаалах, аюулгүй байдлыг нь эрх зүйн хүрээнд маш тодорхой зааж өгөх хэрэгтэй бөгөөд энэ нь бусад тогтоол шийдвэр хөтөлбөр зэрэгт туссан хэдий ч хуульд нарийн зааж баталгаажуулаагүй байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид 2005 оны 10-р сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар манай улс нэгдэн орсон байна. Энэхүү конвенцийн 33 дугаар зүйлд “Мэдээлэгч этгээдийг хамгаалах” гэсэн бүхэл заалт орсон бөгөөд энэхүү заалтад “Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга

хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ” гэсэн байна.¹⁸³ Үүний дагуу 2013 оны 7-р сарын 5-ны өдөр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль баталсан байна.

Хууль зүйн яамны Хууль сахиулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Г.Оюунболд “Шинэ хуулиар сэтгүүлчийг шийтгэхээ болино” гэсэн нэртэй ярилцлага өгсөн байна. Шинэ хууль гэдэг нь Гэмт хэргийн тухай хууль юм. Тэрээр хэлэхдээ, “Ардчилсан нийгмийн харилцаанд Үндсэн хуулиар тунхаг-ласан үнэт зүйлсийг Эрүү-гийн хуулиар хамгаалж чадахгүй байна.

Сэтгүүлчийн хуулиар хориглосон үйлдэл хийсэн бол Зөрчлийн хуулиар шийтгэнэ. Харин сэтгүүлч бусдын тухай нотой мэдээ олмогцоо тухайн этгээдийг шантаажилбал энэ нь эрүүгийн хариуцлага байна. Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд Сэтгүүлчийн тухайд бичсэн нийтлэлийнх нь төлөө эрүүгийн хэрэг үүсгэхгүй. Иргэний журмаар шүүхэд гэм хор нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах хуулийн зохицуулалтаар шийдэх бүрэн боломжтой” гэжээ.¹⁸⁴

2013 онд анхан шатны шүүхээр эдийн бус гэм хорын маргаантай 35 хэргийг шийдвэрлэсэн нь судалгаанд хамрагдсан. Судалгаанаас үзвэл дээрх 35 хэргийн 2 хэргийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 20 хэргийг хялбаршуулсан журмаар, эдийн бус гэм хорын хохирол нэхэмжлээгүй /нэр төр сэргээх гэх мэт/ 2 хэргийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, 11 хэргийн нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасныг сэргээж, эдийн бус гэм хорын хохирол гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна.

Эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагын мөнгөн дүн буюу хохирлын хэмжээг нэхэмжлэгч нар 10 саяас 100 сая төгрөг байхаар заасан бөгөөд үндэслэлээ мэдээллийг тараасан хэлбэр, хэрэгсэл, хүрээ, уншигч үзэгчдийн тоогоор тодорхойлсон байна.

Шүүх тухайн хэргийн нөхцөл байдал, мэдээлэл тархсан цар хүрээ, хэлбэр хэрэгсэл, хэвлэлтийн тоо, худалдсан тоо, хэмжээ зэрэгт үндэслэн 100000-40000000 төгрөгийн хэмжээнд хохирлыг хангаж шийдвэрлэсэн байна.

Булган аймаг Сум дундын 4 дүгээр шүүхийн шүүгч Л.Дарьсүрэн бичсэн нийтлэлээс иш татав.¹⁸⁵

ЗӨВЛӨМЖ:

- Нэг үе сэтгүүлчдийг эрүүгийн хэрэгт шийтгэж байсан. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл үүнийг зогсоож байгаа юм байна. Хоёр талруугаа хэт туйлширч байгаад бид болгоомжтой хандаж байна. Сэтгүүлчид худалдагддаг, “хаалтын гэрээ” байгуулдаг явдлаас хэрхэн гарах арга замыг Гэмт хэргийн тухай хуулиар шийдвэрлэж байна уу? Өөр ямар арга хэмжээ хэрэгтэй вэ гэдгийг нарийвчлан судлах шаардлагатай.

¹⁸⁴ Эх сурвалжийг <http://zuuniimedee.essay.time.mn/content/4634.shtml>

¹⁸⁵ Эх сурвалжийг <http://www.court.bu.gov.mn/index.php/news/1671-2014-03-05-04-20-55>

9.1. (d) (ii) үндэсний аюулгүй байдал, олон нийтийн дэг журам, олон нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах. /Конвенцийн 13.1.d.(ii)/

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Үндсэн хууль

4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

5. Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.

3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

1. Ерөнхийлөгч Монгол Улсын Үндэснийн аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх бүрэн эрхтэй.

2. Засгийн газар улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах, төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу үндсэн бүрэн эрхтэй.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар олон нийтийн радио, телевизээр харгислал, ялгаварлан гадуурхал, дайн, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан, иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан агуулгатай нэвтрүүлэг бэлтгэж түгээхийг хориглоно гэж заасан байдаг. /8.3/

ЗӨВЛӨМЖ:

- Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд “үндэсний аюулгүй байдал, олон нийтийн дэг журам, олон нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” харилцааг нэмж тусгах

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Үндэсний аюулгүй байдал, олон нийтийн дэг журам, олон нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахтай холбоотой практик мэдээллийг судалгааны энэхүү богино хугацаанд олж амжаагүй болно.

9.2.Оролцогч улс бүр энэхүү конвенцид заасан авлигатай тэмцэх холбогдох байгууллагын талаар олон нийт мэдэж байх явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авч, энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үүсгэж байна гэж үзэж болох аливаа тохиолдлын талаар мэдээлэхээр эдгээр байгууллагад зохих тохиолдолд хандах боломж /үүнд нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана/-оор хангана. /Конвенцийн 13.2./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Авлигын эсрэг хуульд Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээд заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй, энэхүү үүргээ хэрэгжүүлэхэд төр, байгууллага, Хувь хүний нууцийн тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй гэж заасан байдаг. /8.1, 8.2/

Авлигатай тэмцэх газар нь чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах бүрэн эрхтэй. /18.4.8/

Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно. /9.1./ Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ гэж тус тус заасан. /9.2./

Авлигын эсрэг хуулийн 9.2-т дурдсан холбогдох хууль гэдэг нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль гэж ойлгож байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд өргөдөл, гомдлыг дараах хэлбэрээр гаргана гэж заасан байна /9 дүгээр зүйл/:

- Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар гаргана. Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно. Байгууллага бүр цахим хаягтай байна.

- Төрийн албан ёсны хэлийг мэдэхгүй бол төрөлх хэлээрээ өргөдөл, гомдол гаргаж болно.
- Амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч байгаа этгээд тэмдэглэн авч, өргөдөл, гомдол гаргагчийн гарын үсгийг зуруулна. Гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэнэ.
- Иргэд радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр болон тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргаж болно.
- Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан өргөдөл, гомдолд амаар хариу өгч болох бөгөөд шаардлагатай бол шалгаж тодруулан бичгээр хариу өгч болно.

Мөн хуульд өргөдөл, гомдолд дараах шаардлага тавигдана гэж заасан байна /10-р зүйл/ :

- Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно.
- Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.
- Өргөдөл, гомдол гаргахад энэ зүйлд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд гомдлыг хуульд заасны дагуу хянан үзэж шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана./ /107.1./

Гомдлыг амаар буюу бичгээр гаргах ба амаар гаргасан бол тэмдэглэлд тусгаж, хүлээн авсан албан тушаалтан, гомдол гаргагч гарын үсэг зурна /107.2./ гэж заасан байна.

Авлигатай тэмцэх газар цахим хуудсаараа дамжуулан өөрийн чиг үүрэг, хийж байгаа ажлын талаар тогтмол мэдээллээр хангадаг, мөн олон нийтийн их ашигладаг цахим хуудсуудаар дамжуулан үйл ажиллагаагаа тайлагнадаг нь Конвенцийн авлигатай тэмцэх холбогдох байгууллагын талаар олон нийт мэдэж байх явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авах гэсэн шаардлагыг хангаж байна гэж үзэж байна.

Авлигын эсрэг хуулиар Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгтэй холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах, иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно /9.1/ гэж заасан нь Конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үүсгэж байна гэж үзэж болох аливаа тохиолдлын талаар мэдээлэхээр эдгээр байгууллагад зохих тохиолдолд хандах боломжоор хангана гэсэн шаардлагыг хангаж байгаа боловч нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана гэсэн шаардлагыг хангахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигын эсрэг хуульд Конвенцийн авлигатай холбоотой гэмт хэргийн талаар нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж олгох харилцааг зохицуулсан нэмэлт оруулах нь зүйтэй байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Дараах байгууллагууд иргэдээс хэрхэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авдаг:

- Авлигатай тэмцэх газар нь **Монгол Улсын Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл** /Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, **264 дүгээр зүйл** /Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, **265 дугаар зүйл** /Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, **266 дугаар зүйл** /Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, **268 дугаар зүйл** /Хээл хахууль авах/, **269 дүгээр зүйл** /Хээл хахууль өгөх/, **270 дугаар зүйл** /Хээл хахууль зуучлах/, **270¹ дүгээр зүйл** /Хууль бусаар хөрөнгөжих/, **273 дугаар зүйл** /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авдаг. Мөн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаарх гомдол, мэдээллийг цахим хуудсаар болон 1800-1969 утсаар хүлээн авдаг байна. /АТГ-ын цахим хуудас/ 2008 онд Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээн авах 1969 утсанд төрийн байгууллагуудын ажилтнуудын хүнд суртал, чирэгдлийн талаар иргэдээс ирүүлсэн 69 гомдол, 2009 онд 157 гомдол, 2010 онд 51 гомдол, 2012 онд гомдол, 2013 онд 60 гомдол, мэдээллийг тус тус судлан үзэж, дүн шинжилгээ хийн шийдвэрлэсэн байна.¹⁸⁶ Мөн Авлигатай тэмцэх газрын он оны тайлангуудыг үзэхэд иргэдээс гомдол, мэдээлэл хүлээн авах 1969 утсыг зурагт, радио, сонингоор олон нийтэд хангалттай сайн сурталчилдаг болох нь нотлогдсон. 1969 утсаар иргэн гомдол, мэдээлэл авахад иргэнээс түүний овог, нэр, регистрийн дугаар, иргэний үнэмлэхний дугаар, гэрийн болон ажлын газрын хаяг, утас, гомдол, мэдээллийн утга, үндэслэл зэрэг мэдээллийг шаарддаг.

№	Байгууллагын нэр	Цахим хуудсаар мэдээлэл авдаг эсэх	Утсаар авдаг эсэх	Хүлээн авч уулздаг эсэх
1	Улсын ерөнхий прокурорын газар	Авдаг	260855	Хүлээн авдаг
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Энэ талаар мэдээлэл байсангүй	1800-1286	Энэ талаар мэдээлэл байсангүй

¹⁸⁶ Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2008, 2009, 2010, 2012, 2013 оны тайлангууд

3	Цагдаагийн ерөнхий газар	Авдаг	70121515 126	Хүлээн авдаг
4	Гаалийн ерөнхий газар	Энэ талаар мэдээлэл байсангүй	1800-1281	Энэ талаар мэдээлэл байсангүй
5	Татварын ерөнхий газар	Энэ талаар мэдээлэл байсангүй	1288	Энэ талаар мэдээлэл байсангүй

Энэхүү байгууллагууд дээрх аргаар иргэдээс мэдээлэл авах байдлыг хөнгөвчилсөн нь Конвенцийн заалтад нийцэж байна гэж үзэж байна.

Авлигатай тэмцэх газрын цахим хуудсаар Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын талаарх гомдол, Авлигатай тэмцэх газрын талаарх санал, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл өгөхөд гомдол, мэдээлэл гаргагчийн хувийн мэдээллийг шаарддаг бол Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын талаарх мэдээлэл өгөхөд мэдээлэл гаргагчийн хувийн мэдээллийг шаардахгүй байгаа нь бодит практикт нэргүй мэдээлэл авч Конвенцийн шаардлагыг хангаж байгаа юм байна.

Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гүйцэтгэх ажил явуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах бүрэн эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу сүүлийн 3 жил дараах тоон үзүүлэлттэйгээр эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулжээ:

- 2011 оны байдлаар гомдол, мэдээлэл хүлээн авах төв нь нийт 653 гомдол, мэдээлэл хүлээн авснаас “Гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэл-д гэмт хэргийн шинжтэй 416 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь 2010 оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувиар буурсан байна. Өмнөх жилийн үлдэгдэл 27 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан 416 нийт 443 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 54 гомдол, мэдээлэл буюу 12.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 214 гомдол, мэдээлэл буюу 48.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргах, 164 гомдол, мэдээлэл буюу 37.0 хувийг харъяаллын дагуу шилжүүлж, 3 гомдол мэдээлэл буюу 1.0 хувьд эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж шийдвэрлэсэн бөгөөд ажиллагаанд 8 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 98.2 хувьтай байна.
- 2012 оны байдлаар Тайлангийн хугацаанд хуульд заасан харьяаллын 293 холбогдогчтой 534 үйлдэлтэй, 164 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувиар өссөн байна.
Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг, үйлдлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилвал төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 43 буюу 21.0 хувь, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 24 буюу 11.7 хувь, төрийн бус

байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 13 буюу 6.0 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 3 буюу 1.4 хувь, хээл хахууль авах 24 буюу 11.7 хувь, хээл хахууль өгөх 19 буюу 9.3 хувь, хээл хахуульд зуучлах 4 буюу 1.9 хувь, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 10 буюу 4.9 хувь, бусад 64 буюу 31.3 хувийг эзэлж байна.

- 2013 оны байдлаар хуульд заасан харьяаллын 499 үйлдэлтэй 187 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 2012 оны мөн үетэй харьцуулахад 12.7 хувиар өссөн байна.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл 43 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 22.9 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 23.2 хувиар өссөн, 41 хэргийг буюу 21.9 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 19.5 хувиар өссөн, 30 хэргийг буюу 16 хувийг харьяаллын дагуу шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 16.7 хувиар өссөн, 21 хэргийг буюу 11.2 хувийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 13 хэргийг мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлсэн байна.¹⁸⁷

Авлигын талаар мэдээлэх 1969 утсыг ажиллуулснаар иргэд олон нийт ямар ч хүндрэлгүйгээр авлигын талаар мэдээлэх боломжтой болсон байна. Авлигатай тэмцэх газар 1969 утсыг тогтмол олон нийтэд сурталчилдаг явдал нь энэ ажлыг илүү үр дүнтэй болгож, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх нэгэн том арга хэмжээ юм. Мөн авлигад өртөх эрсдэлтэй зарим нэгэн төрийн байгууллагууд иргэдийн гомдол, мэдээллийг авах боломжийг хөнгөвчилсөн байна. Энэ нь Конвенцийн авлигатай тэмцэх холбогдох байгууллагын талаар олон нийт мэдэж байх явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авч, энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг тэмдэглэх, шалгах нөхцлийг бүрдүүлж байна гэж үзэж болох аливаа тохиолдлын талаар мэдээлэхээр эдгээр байгууллагад зохих тохиолдолд хандах боломжоор хангана гэсэн шаардлагыг хангаж байна гэж үзэж байна.

Авлигын эсрэг хуулиар Авлигатай тэмцэх газарт нэргүй гомдол, мэдээлэл авах эрхийг олгоогүй тул цахим хуудсаар болон 1969 утсаар иргэнээс гомдол, мэдээлэл авахдаа заавал мэдээлэл өгөгчийн хувийн мэдээллийг авдаг. Хэдийгээр нэргүй мэдээлэл авах эрхийг нь хуулиар олгоогүй, тэд авдаггүй гэх боловч Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайланд тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 311 өргөдлөөс 18 буюу 5,7 хувийг нэргүй мэдээлэл ирүүлсэн байна, нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллээс 282 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн, одоо 29 өргөдөл, гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна гэж дурдсанаас гэж үзвэл Авлигатай тэмцэх газар “нэргүй мэдээлэл” авдаг байна.¹⁸⁸

¹⁸⁷ Авлигатай тэмцэх газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан

¹⁸⁸ Авлигатай тэмцэх газрын Хянан шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн 2013 онд хийсэн ажлын тайлан

Энэ нь Конвенцийн “үүнд нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана” гэсэн шаардлагад практик хэрэгжилтээрээ нийцэж байгаа боловч Авлигын эсрэг хуульд тодорхой зааж суулгаж өгөөгүй байгаа нь Конвенцийн шаардлагыг хангахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Авлигатай тэмцэх газарт гомдол, мэдээлэл өгөхөд гомдол, мэдээлэл гаргагч хувийн мэдээллээ нууцалдаг байх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй

АРАВДУГААР БҮЛЭГ

МӨНГӨ УГААХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

/14 дүгээр зүйл/

10.1. Оролцогч улс бүр:

(а) мөнгө угаах бүх хэлбэрийг таслан зогсоох болон илрүүлэхийн тулд банк болон банк бус санхүүгийн байгууллага, түүний дотор мөнгө буюу бусад үнэт зүйлийн шилжүүлгийн албан буюу албан бус үйлчилгээ үзүүлдэг хувь хүн буюу хуулийн этгээд, түүнчлэн ялангуяа мөнгө угаахад өртөх эрсдэлтэй бусад байгууллагад зохих тохиолдолд зохицуулалт, хяналтын дотоодын иж бүрэн дэглэмийг эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоох бөгөөд ийм дэглэм нь харилцагч болон зохих тохиолдолд жинхэнэ өмчлөгчийн хэн болохыг тогтоох, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавих шаардлагыг онцлон тогтооно; /Конвенцийн 14 дүгээр зүйлийн 14.1.а./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад 2006 оны 7 дугаар сард **"Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай"** хууль батлагдаж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны үндэс суурь тавигдсан.

Энэ хуулийн дагуу 2006 оны 11 дүгээр сарын 29 -нд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн алба (СМА) Монголбанкны бүтцэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна¹⁸⁹. Улмаар 2013 оны мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдөр хэлэлцэн баталсан. Энэхүү

¹⁸⁹ Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны танилцуулга, Монгол Банкны цахим хуудас, <http://www.mongolbank.mn/listCMA.aspx?did=4>

хуулийн ач холбогдол нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хяналтын тогтолцоогоо сайжруулах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид дотоодын хууль тогтоомжоо нийцүүлэхэд оршино¹⁹⁰.

Дараах байгууллага, албан тушаалтанг мөнгө угаахад өртөх эрсдэлтэй гэж үзэн сэжигтэй гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл өгөх үүрэгтэй байхаар хуульд тусгасан:

1. банк;
2. банк бус санхүүгийн байгууллага;
3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
4. хөрөнгө оруулалтын сан;
5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
6. хадгаламж, зээлийн хоршоо;
7. үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага;
8. нотариатч.

Мэдээлэл өгөх үүрэг бүхий дээрх байгууллага, албан тушаалтан нь харилцагчийг таньж мэдэх, мөнгөний жинхэнэ өмчлөгчийг хэн болохыг тогтоох зорилгоор харилцагчтайгаа санхүүгийн харилцаа үүсгэхийн өмнө, шинээр 20 хүртэл сая төгрөгийн гүйлгээ хийх, эсхүл 24 цагийн дотор гүйлгээ тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөг хүрэхгүй боловч нийт дүнгээрээ 20 сая төгрөгтэй дүйцэх хэмжээний хэд хэдэн гүйлгээ хийх, түүнчлэн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэх, харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд харилцагчаас доорх мэдээллийг заавал гаргуулж авна:

- иргэн бол түүний овог, нэр, төрсөн огноо, иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспортны хуулбар;
- хуулийн этгээд бол түүний нэр, хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, удирдлага, эцсийн өмчлөгчийн талаар танилцуулга, мэдээлэл;
- банк, санхүүгийн байгууллагын хоорондын шилжүүлэгч, хүлээн авагчийн овог нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, утасны дугаар.

Гадаад гуйвуулга, шилжүүлэг, төлбөр тооцоо хийх зорилгоор гадаад улсын банкинд харилцах данс нээхээс өмнө дараах мэдээллийг олж авна:

- тухайн банкны үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох мэдээлэл;
- тухайн банкны харьяалагдах гадаад улсын холбогдох эрх бүхий байгууллага болон олон нийтийн мэдээллийн эх үүсвэрээс тухайн банк, байгууллагын нийтэд танигдсан байдлын талаарх мэдээлэл;

¹⁹⁰ “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн товч танилцуулга”, МУ-ын УИХ-ын цахим хуудас, <http://www.parliament.mn/news/info/categories/209/pages/6565>

- тухайн банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, дотоод хяналтын хөтөлбөртэй эсэх;
- тухайн банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд холбогдож, шалгагдаж байсан эсэх талаарх лавлагаа.

Түүнчлэн мэдээлэх үүрэгтэй байгууллага, албан тушаалтан дараах гүйлгээг тусгайлан хянаж, холбогдох материалыг хадгална:

- огцом өөрчлөгдсөн их дүнтэй;
- эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;
- улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн;
- мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын тогтолцоо муутай улсаар дамжуулан хийсэн.

20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор¹⁹¹, хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол дээрх мөнгө угаахад өртөх эрсдэлтэй этгээд энэ тухай 24 цагийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ¹⁹². Мэдээллийг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр Санхүүгийн мэдээллийн албанд түүний баталсан маягт, журмын дагуу хүргүүлнэ.

Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөл ажилладаг. Хамтын ажиллагааны зөвлөлд гадаад харилцаа, санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл ажиллах бөгөөд чиг үүргийг Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлнэ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг биелүүлэхэд дээрх байгууллагаас гадна Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаархи хууль тогтоомжийг сахин биелүүлэх үүрэг хүлээж, ажилладаг.¹⁹³

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А-77 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн Мэдээллийн Албанд Банкнаас Мэдээлэл Ирүүлэх Журам”-аар банкнаас сэжигтэй гүйлгээ, 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй

¹⁹¹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 7.1

¹⁹² Мөн хуулийн 7.2

¹⁹³ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 36.1.

бэлэн мөнгө, гадаад төлбөр тооцооны гүйлгээний талаар Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулсан.

Уг журмын 2 дугаар зүйлд Банк дараах тохиолдолд сэжигтэй гүйлгээний тайланг данс, гүйлгээний мөнгөн дүн, хэлбэр, төрлөөс үл хамааран, 24 цагийн дотор Санхүүгийн Мэдээллийн Албанд ирүүлнэ¹⁹⁴:

- Банкны эсрэг эсхүл банкыг ашиглан гэмт хэрэг үйлдэж байж болзошгүй гэж банк, түүний удирдлага, ажилтан үзсэн;
- Эрүүгийн болон бусад хууль тогтоомжийг зөрчиж олсон орлого гэдгийг банк, түүний удирдлага, ажилтан мэдсэн, сэжиглэсэн, үзсэн;
- Мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хөрөнгө, мөнгө, орлого байж болзошгүй гэдгийг банк, түүний удирдлага, ажилтан мэдсэн, сэжиглэсэн, үзсэн;
- Харилцагчийн хийх гэж байгаа болон хийсэн гүйлгээ нь гэмт хэргийн хэлбэр, загвар мөн гэж банк, түүний удирдлага үзсэн;
- Банкны ажилтан гэмт хэргийн үйлдэл хийж байгаа эсхүл түүнийг үйлдэхэд туслаж байна гэж банкны удирдлага, ажилтан мэдсэн, үзсэн.

Банк нь Сэжигтэй Гүйлгээний тайлантай хамт ирүүлээгүй, сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээллийг Санхүүгийн Мэдээллийн Албанаас шаардсан үед цахим хэлбэрээр 24 цагийн дотор ирүүлэх¹⁹⁵ үүрэгтэй бөгөөд Нэмэлт мэдээлэл гэдэгт сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлантай холбоотой харилцагч хувь хүн, хуулийн этгээлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг ойлгодог байна.

Бусад гүйлгээг мэдээлэх журмын хувьд Банк нь дараах мэдээллийг гүйлгээ хийснээс хойш ажлын 5 (таван) өдрийн дотор Санхүүгийн Мэдээллийн Албанд ирүүлнэ¹⁹⁶:

- 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний дотоод гүйлгээний мэдээллийг Бэлэн Мөнгөний Гүйлгээний тайлангийн дагуу ирүүлнэ;
- Ажлын нэг өдрийн дотор хийсэн хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийн дүн 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют)-аас бага боловч нийт гүйлгээний дүн нь 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй бол уг бэлэн мөнгөний дотоод гүйлгээ тус бүрийг БМГ тайлангийн дагуу ирүүлнэ;
- 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй гадаад төлбөр тооцооны гүйлгээний мэдээллийг Гадаад Төлбөр Тооцооны Гүйлгээний тайлангийн дагуу ирүүлнэ;

¹⁹⁴ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А-77 дугаар тушаалын хавсралт “Санхүүгийн Мэдээллийн Албанд Банкнаас Мэдээлэл Ирүүлэх Журам” 2 дугаар зүйлийн 2.1

¹⁹⁵ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А-77 дугаар тушаалын хавсралт “Санхүүгийн Мэдээллийн Албанд Банкнаас Мэдээлэл Ирүүлэх Журам” 2 дугаар зүйлийн 2.3

¹⁹⁶ Мөн журмын 3 дугаар зүйл

- Ажлын нэг өдрийн дотор хийсэн хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гадаад төлбөр тооцооны гүйлгээ тус бүрийн дүн 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют)-аас бага боловч нийт гүйлгээний дүн нь 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй бол уг гадаад төлбөр тооцооны гүйлгээ тус бүрийг Гадаад Төлбөр Тооцооны Гүйлгээний тайлангийн дагуу ирүүлнэ.

Ийнхүү мэдээлэл ирүүлэхдээ Сэжигтэй болон бусад гүйлгээний талаарх мэдээлэлд тавигдах шаардлагыг хангасан байна. Санхүүгийн Мэдээллийн Албанд тайлангаа ирүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байна¹⁹⁷:

- Сэжигтэй гүйлгээний тайлан, Бэлэн Мөнгөний Гүйлгээний тайлан болон Гадаад Төлбөр Тооцоо Гүйлгээний тайланг (Юникод) Unicode Монгол гарын драйвер ашиглан бэлтгэх;
- Сэжигтэй гүйлгээний тайлан, Бэлэн Мөнгөний Гүйлгээний тайлан болон Гадаад Төлбөр Тооцоо Гүйлгээний тайланд улс орны нэрийг ISO 3166-1 (4 дүгээр хавсралт) Улс орнуудын нэр болон болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бэлтгэх;
- Сэжигтэй гүйлгээний тайлан тайлан, Бэлэн Мөнгөний Гүйлгээний тайлан болон Гадаад Төлбөр Тооцоо Гүйлгээний тайланд гүйлгээ хийсэн валютын төрлийг ISO 4217 (5 дугаар хавсралт) Улс орнуудын мөнгөн тэмдэгтийн нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандартын дагуу бэлтгэх;
- Сэжигтэй гүйлгээний тайлан тайлан, Бэлэн Мөнгөний Гүйлгээний тайлан болон Гадаад Төлбөр Тооцоо Гүйлгээний тайланг Эксел валидатор програм эсхүл Санхүүгийн Мэдээллийн Албаннаас гаргасан бусад тайлан шалгах програмаар шалгаж, алдаагүй болгож ирүүлнэ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А-77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Сэжигтэй гүйлгээний тайлангийн маягт, 2 дугаар хавсралтаар Бэлэн мөнгөний гүйлгээний маягт, 3 дугаар хавсралтаар Гадаад төлбөр тооцооны гүйлгээний маягтыг тус тус батлаж, банкууд тус маягтын дагуу мэдээллээ Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлж байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23 ний өдрийн 253 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхээс Сэргийлэх, Харилцагчийг Таньж Мэдэх, Сэжигтэй Болон Бэлэн Мөнгөний Гүйлгээг Мэдээлэх Журам” – аар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, сэжигтэй гүйлгээний болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд дамжуулахтай холбоотой Санхүүгийн зохицуулах хороонд харьяалагдах мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаа, харилцааг зохицуулсан.

Тус журмаар Банк бус санхүүгийн байгууллага, Даатгалын компани, Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, Хадгаламж, зээлийн

¹⁹⁷ Мөн журмын 5 дугаар зүйлийн 5.2

хоршоо зэрэг байгууллагууд /"Мэдээлэх үүрэгтэй этгээд"/ Санхүүгийн зохицуулах хороонд харьяалагдах мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамаарах бөгөөд харилцагчийг таньж мэдэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн үйлчилгээ үзүүлэхийн өмнө дараах мэдээллийг харилцагчаас гаргуулж авна¹⁹⁸:

- Харилцагч нь иргэн бол түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар,
- Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг,
- Мэдээлэх үүрэгтэй этгээд харилцах, хадгаламж, гишүүнчлэл эсхүл зээлийн данс нээсэн, гэрээ байгуулсан этгээд нь иргэн бол түүний иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хуулийн этгээд бол түүний улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хувь нийлүүлэгч, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга,
- Гүйлгээний утга, хийгдсэн гэрээ, хүлээн авагчийн тухай мэдээлэл,
- Бусдын өмнөөс гүйлгээ хийж байгаа тохиолдолд төлөөлүүлж байгаа этгээдийн талаарх мэдээлэл;
- Бэлэн бус шилжүүлэг хийсэн этгээдийн тухай мэдээлэл.

Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бэлтгэх, шилжүүлэх, гүйлгээг тусгайлан хянах, түдгэлзүүлэх тухай мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг нууцын тухай хууль тогтоомжийн дагуу чанд хадгална¹⁹⁹.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, тогтоомжийн дагуу сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланд дурдсан мэдээллийг хуулийн байгууллагаар шалгуулах шаардлагатай гэж үзвэл, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх ба Санхүүгийн мэдээллийн албанд нэг хувийг хүргүүлнэ²⁰⁰.

Монгол Банкны Ерөнхийлөгч, Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргын 2011 оны 03 сарын 18-ны өдрийн 156/45 дугаар тушаалын хавсралтаар "Мөнгө Угаах болон Терроризмтой Тэмцэх Чиглэлээр Банкнаас Бусад Мэдээлэх Үүрэгтэй Этгээдэд Хяналт Шалгалт Хийх Журам" батлагдсан. Тус журмаар Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хууль, түүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол, Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан заавар, журмыг мэдээлэх үүрэгтэй этгээд хүрэхэн хэрэгжүүлж байгаад зайнаас болон газар дээр нь хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

¹⁹⁸ Санхүүгийн Зохицуулах Хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23 ний өдрийн 253 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхээс Сэргийлэх, Харилцагчийг Таньж Мэдэх, Сэжигтэй Болон Бэлэн Мөнгөний Гүйлгээг Мэдээлэх Журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1

¹⁹⁹ Санхүүгийн Зохицуулах Хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23 ний өдрийн 253 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхээс Сэргийлэх, Харилцагчийг Таньж Мэдэх, Сэжигтэй Болон Бэлэн Мөнгөний Гүйлгээг Мэдээлэх Журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1

²⁰⁰ Мөн журмын 5 дугаар зүйлийн 5.2

Хяналт шалгалтыг газар дээрх хяналт шалгалт, зайнаас тавих хяналт гэж арга хэлбэрийн хувьд 2 ангилал бөгөөд Газар дээрх хяналт шалгалт нь хуваарийн дагуу болон гэнэтийн шалгалт гэсэн 2 хэлбэртэй байна.

Хуваарийн дагуу хийгдэх шалгалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан газар дээрх шалгалтын хуваарийн дагуу хийнэ. Шаардлагатай гэж үзвэл Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Албаны хянан шалгагч шалгалтын хэсэгт орж ажиллаж болно²⁰¹. Гэнэтийн шалгалтыг тодорхой мэдээллийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр СМА-ны хянан шалгагч хийнэ²⁰². Зайнаас тавих хяналтыг Санхүү Мэдээллийн Албаны хянан шалгагч гүйцэтгэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч нар шаардлагатай мэдээллийг Мэдээллэх Үүрэгтэй ЭТГЭЭД буюу Банк бус санхүүгийн байгууллага, Даатгалын компани, Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, Хадгаламж, зээлийн хоршоо зэрэг байгууллагуудаас гаргуулан авч Санхүү Мэдээллийн Албанд ирүүлэх хэлбэрээр хамтран ажиллана. Зайнаас хяналт тавихдаа Мэдээллэх Үүрэгтэй ЭТГЭЭДэд холбогдолтой дараахь тайлан, мэдээллийг ашиглана²⁰³:

- Газар дээрх хяналт шалгалтын дүгнэлт, акт материал;
- Өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтийн талаарх тайлан, мэдээлэл;
- Мэдээллэх Үүрэгтэй ЭТГЭЭДИЙН ТУЗ, хувь нийлүүлэгч, хяналтын зөвлөл, удирдлагад гарсан өөрчлөлтийн талаар тухай бүр нь ирүүлсэн мэдээлэл;
- Хэрэгжилтэд хяналт тавих ажилтны улирал тутам хийх ажлын төлөвлөгөө, хийсэн ажлын тайлан;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдолтой Мэдээллэх Үүрэгтэй ЭТГЭЭДИЙН дотоод журам, бодлого болон хөтөлбөрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланд гарсан өөрчлөлт, мэдээллийн чанарын талаар Санхүүгийн Мэдээллийн Албаны шинжээч нарын гаргасан статистик судалгаа;
- Мэдээллэх Үүрэгтэй ЭТГЭЭДИЙН хяналтын зөвлөл, дотоод хяналтын нэгжийн хийсэн шалгалтын дүгнэлт, тайлан;
- Бусад мэдээлэл. /Шүүх, хууль хяналтын байгууллагаас Мэдээллэх Үүрэгтэй ЭТГЭЭДтэй холбоотой гаргасан шийдвэр, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр гарсан мэдээлэл, хөндлөнгийн аудитын дүгнэлт зэрэг/

Тайлан, мэдээллийг ирүүлээгүй эсхүл ирүүлсэн тайлан, мэдээлэл нь тавигдсан шаардлагыг хангаагүй бол СМА-ны хянан шалгагч нь шаардах, улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлэх, захиргааны хариуцлага ногдуулах арга хэмжээг шат дараалуулан авна²⁰⁴. **Мөнгө угаах бүх хэлбэрийг таслан зогсоох болон илрүүлэхийн тулд банк болон банк бус санхүүгийн**

²⁰¹ Монгол Банкны Ерөнхийлөгч, Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргын 2011 оны 03 сарын 18-ны өдрийн 156/45 дугаар тушаалын хавсралтаар “Мөнгө Угаах болон Терроризмтой Тэмцэх Чиглэлээр Банкнаас Бусад Мэдээлэх Үүрэгтэй ЭТГЭЭДэд Хяналт Шалгалт Хийх Журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1

²⁰² Мөн журмын 2 дугаар зүйлийн 2.1.2

²⁰³ Монгол Банкны Ерөнхийлөгч, Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргын 2011 оны 03 сарын 18-ны өдрийн 156/45 дугаар тушаалын хавсралтаар “Мөнгө Угаах болон Терроризмтой Тэмцэх Чиглэлээр Банкнаас Бусад Мэдээлэх Үүрэгтэй ЭТГЭЭДэд Хяналт Шалгалт Хийх Журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2

²⁰⁴ Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.4

байгууллага, түүний дотор мөнгө буюу бусад үнэт зүйлийн шилжүүлгийн албан буюу албан бус үйлчилгээ үзүүлдэг хувь хүн буюу хуулийн этгээд, түүнчлэн ялангуяа мөнгө угаахад өртөх эрсдэлтэй бусад байгууллагад зохих тохиолдолд зохицуулалт, хяналтын дотоодын иж бүрэн дэглэмийг эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоох бөгөөд ийм дэглэм нь харилцагч болон зохих тохиолдолд жинхэнэ өмчлөгчийн хэн болохыг тогтоох, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавих шаардлагыг онцлон тогтооно гэсэн Конвенцийн 14 дүгээр зүйлийн 14.1.а-д заасан эрх зүйн орчныг бүрдүүлэх үе шаттай арга хэмжээг төр засгаас авсаар байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Мөнгө угаах болон санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх тухай хууль 2006 онд батлагдсанаар Монгол улсын банк санхүүгийн системийн эрүүл, тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн байна²⁰⁵. Монгол банкны дэргэд ажилладаг сэжигтгэтэй гүйлгээний мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага болох Санхүүгийн Мэдээллийн Алба идэвхитэй үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг боловсруулах чиг үүрэгтэй Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бүлэг (ФАТФ)-ээс манай улсад тавьж байгаа хяналтын хүрээнд 2012, 2013 оны турш Монголбанк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол улсын хууль тогтоомжийг олон улсын стандарт (ФАТФ-ын 40 зөвлөмж)-д нийцүүлэхтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах ажлыг Санхүүгийн Мэдээллийн Алба нь Хууль Зүйн Яам, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн байна. Үүний үр дүнд **УИХ-ын чуулганы 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар 2006 онд батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2004 онд батлагдсан Терроризмтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, 2003 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг тус тус баталсан.**


ФАТФ-тай тохирсон төлөвлөгөөний дагуу 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Терроризмтэй тэмцэх тухай хуулийн холбогдох нэмэлт өөрчлөлт, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан 1267, 1373 дугаар тогтоолуудад үндэслэн “Террористуудын жагсаалтыг гаргах, тэдгээрийн хөрөнгийг битүүмжлэх, хянах журам”-ыг батлуулсан. Түүнчлэн, 2014 оны 1 дүгээр

²⁰⁵ Авлигатай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн Хэрэгжилтийн Дүн Шинжилгээний Тайлан, 2012, 72 дахь тал;

сарын 16-ны өдөр УИХ-аар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулинд тус тус холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улс ФАТФ-тай тохирсон ажлуудыг бүгдийг хийсэнд тооцсон байна. Ингэснээр 2014 оны 2 дугаар сарын 17-нд Францын Парис хотноо болсон ФАТФ-ын 22 дугаар чуулга уулзалтын үеэр энэ чиглэлд манай улсын гаргасан ахицыг өндрөөр үнэлж, Монгол Улсыг “хар саарал жагсаалт”-аас гаргаж зэрэглэлийг нь дээшлүүлсэн²⁰⁶ тухай ололт амжилтыг Санхүүгийн Мэдээллийн Албаны тайланд дурьдсан байна.

Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны Үйл ажиллагааны Статистик Мэдээллийн сүүлийн 3 жилийн мэдээг түүвэрлэн авч судлавал 2011 оны IV улирлын статистик мэдээлэлд Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 71, Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 57²⁰⁷, 2012 оны IV улирлын статистик мэдээлэлд Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 158, Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 110²⁰⁸, 2013 оны IV улирлын статистик мэдээлэлд Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 285, Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 180²⁰⁹ байсан байна.

Дээрх статистикийг графикаар харуулвал:



Сүүлийн 3 жилийн статистик мэдээллээс үзвэл Мөнгө угаах үйл ажиллагаатай холбоотой байж болох сэжигтэй гүйлгээний тоо, хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Ийнхүү сэжигтэй гүйлгээний тоон

²⁰⁶ Санхүүгийн Мэдээллийн Албаны 2013 оны жилийн тайлангийн хэсгээс 5.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ

²⁰⁷ Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны 2011 оны Үйл ажиллагааны Статистик Мэдээлэл;

²⁰⁸ Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны 2012 оны Үйл ажиллагааны Статистик Мэдээлэл;

²⁰⁹ Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны 2013 оны Үйл ажиллагааны Статистик Мэдээлэл;

үзүүлэлт өсөн нэмэгдэж байгаагийн учир шалтгаан нь Банкууд мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, мэдээллээ нээлттэй, ил тод болгон тогтмол, шуурхай Санхүүгийн Мэдээллийн Албанд хүргүүлдэг болсон мөн хууль зүйн орчин шинэчлэгдэж 20 хүртэл сая төгрөгийн гүйлгээ хийхээс гадна 24 цагийн дотор гүйлгээ тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөг хүрэхгүй боловч нийт дүнгээрээ 20 сая төгрөгтэй дүйцэх хэмжээний хэд хэдэн гүйлгээ хийх тохиолдлыг хуульд суулгасан зэрэг хүчин нөлөөллөөс болсон байна гэж дүгнэж болох бөгөөд үүгээр Банкны салбарт Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сэжигтэй гүйлгээг хянан шалгах ажиллагаа идэвхитэй хэрэгжиж байгаа нь харагдаж байна.

Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд Сэжигтэй гүйлгээний статистик мэдээний тоон үзүүлэлт дараах байдалтай байна²¹⁰.

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН							
ОН	2008	2009	2010	2011	2012	2013	Нийт
ББСБ						2	2
Брокер дилер					2		2
Нийт банкнаас бусад	0	0	0	0	2	2	4
БУСАД							
Төрийн байгууллага	10	13	8	1		1	33
Иргэн			1				1
Нийт бусад	10	13	9	1	0	1	34
Нийт ирүүлсэн СГТ	12	51	24	71	158	285	601

Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд Сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэл банкны салбарыг бодвол маш доогуур үзүүлэлттэй байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаахтай холбогдох сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг олж цуглуулан дараах эрх бүхий хууль сахиулах байгууллагуудад хууль тогтоомжийн дагуу хүргүүлдэг байна.

- Тагнуулын Ерөнхий Газар /үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар мэдээлэл боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах чиг үүргийн хүрээнд/,
- Эрүүгийн Цагдаагийн Газар /Эрүүгийн хуулийн 166¹ дугаар зүйлийн хүрээнд/,
- Авлигатай тэмцэх газар /Авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах /

²¹⁰ Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны 2013 оны бүтэн жилийн, 2014 оны хагас жилийг тайлан

- Прокурорын байгууллага /Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүргийн хүрээнд/
- Шүүхийн байгууллага /Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд/

Санхүүгийн Мэдээллийн Албаны 2013 бүтэн жил, 2014 оны хагас жилийн ажлын тайлан

Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны 2014 оны I улирлын статистикийн мэдээлэл					
Дотоод хамтын ажиллагааны мэдээлэл					
Үзүүлэлтүүд	2014 оны I улирлын дүн	2013 оны нийт дүн	2012 оны нийт дүн	2008-2011 онуудын дүн	Онуудын дүн /өссөн дүнгээр/
СМА-наас дотоодын хууль сахиулах байгууллагуудад шалгуулахаар шилжүүлсэн мэдээллийн тоо	2	10	94	95	201
Мэдээлэл авах зорилгоор дотоодын эрх бүхий байгууллагуудаас СМА-нд ирүүлсэн хүсэлтийн тоо	77	1,197	501	328	2,103
Дотоодын эрх бүхий байгууллагуудаас СМА-нд ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо	72	1,066	511	306	1,955

Санхүүгийн Мэдээллийн Алба нь хууль тогтоомжид заасан Банк болон Банкаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд газар дээрх болон зайны хяналт шалгалт хийх үүргийнхээ хүрээнд хийсэн ажлын тоон үзүүлэлтийг доорх хүснэгтээс харж болгоор байна.

Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны 2014 оны I улирлын статистикийн мэдээлэл						
Хяналт шалгалтын тайлан						
№	Үзүүлэлтүүд	2014 оны I улирлын дүн	2013 оны нийт дүн	2012 оны нийт дүн	2008-2011 онуудын дүн	Онуудын дүн /өссөн дүнгээр/
20.	Банк болон Банкнаас бусад Мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийгдсэн хяналт шалгалтын тоо	16	163	28	32	239
20.1	Банкинд хийгдсэн хяналт шалгалтын тоо	1	0	2	29	32
20.2	Банкнаас бусад Мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийгдсэн хяналт шалгалтын тоо	15	163	26	3	207

21. Банк болон Банкнаас бусад Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан актын тоо		1	2	4	27	34
21.1.	Банкинд тавигдсан актын тоо	1	0	2	27	30
21.2.	Банкнаас бусад Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан актын тоо	3	2	2	0	7
22. Банк болон Банкнаас бусад Мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгаврын тоо		218	77	211	143	649
22.1.	Банкинд өгсөн хугацаат үүрэг даалгаврын тоо	7	0	17	120	144
22.2.	Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгаврын тоо	211	77	194	23	505

Дээрх бүгдээс дүгнэвэл **Монгол Улс Мөнгө угаах ажиллагааны эсрэг хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, өөрийн орны санхүүгийн байгууллагын тогтолцоондоо нийцүүлэн Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг дотоодын дэглэмийг бий болгосон, тухайн үйл ажиллагааны эсрэг судалгаа, шинжилгээ, мэдээ мэдээлэл, баримт сэлт судлаж, бэлгэдэг тусгай бие даасан алба болох Монгол Банкны дэргэдэх Санхүүгийн Мэдээллийн Алба идэвхитэй үйл ажиллагаа явуулж, хууль сахиулах эрх бүхий байгууллагуудад мэдээлэл хүргэж байгаа хэдий ч Монгол Улсын аль ч шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 166¹ зүйл буюу Мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилж, хэрэг хянан шийдвэрлэсэн практик шүүхэд байхгүй байна. Монгол Улс авлигын индексээрээ дээгүүрт жагсдаг орны хувьд авлигын замаар олсон хууль бус мөнгөний эх үүсвэр хэрхэн, ямар замаар эргэж, угаагддаг болох нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ тал дээр ямар нэгэн судалгааны хийгдээгүй байна.**

ЗӨВЛӨМЖ:

- Монгол Улсын аль ч шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 166¹ зүйл буюу Мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилж, хэрэг хянан шийдвэрлэсэн практик шүүхэд байхгүй байгааг энэ төрлийн хэрэг огт гардаггүй гэсэн үг биш бөгөөд энэ нь Монгол Улс авлигын индексээрээ дээгүүрт жагсдаг орны хувьд олон улсын үнэлгээ давхар нотолж байх тул, шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын мэдлэг мэдээллийг дээшлүүлэх системтэй арга хэмжээг харилцан уялдаатай авч хэрэгжүүлэх
- Авлигын замаар олсон хууль бус мөнгөний эх үүсвэр хэрхэн, ямар замаар эргэж, угаагддаг болох нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ тал дээр нухацтай ажиглалт, судалгааг төрийн холбогдох байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хийж, түүний дүгнэлт, зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээ авах

10.2. (b) энэхүү конвенцийн 46 дугаар зүйлийг үл хөндөн, захиргаа, зохицуулалт, хууль сахиулах болон мөнгө угаахтай тэмцдэг эрх бүхий бусад байгууллага (дотоодын хуулийн дагуу зохих тохиолдолд шүүхийн эрх бүхий байгууллага) нь дотоодын хуульд заасан нөхцлийн хүрээнд үндэсний болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой байх явдлыг хангах бөгөөд үүний тулд мөнгө угааж байж болзошгүй гэсэн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх зорилго бүхий үндэсний төв болох санхүүгийн мэдээллийн нэгж байгуулах асуудлыг авч үзнэ. /Конвенцийн 14 дүгээр зүйлийн 14.1.b./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой байх явдлыг хангах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн алба нь ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшний, гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах²¹¹ эрх зүйн орчинг хуулиар бүрдүүлсэн байна. Санхүүгийн мэдээллийн алба нь гадаад улсын болон олон улсын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн түүнд шаардлагатай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч болох²¹² талаар хуулинд тусгасан байна.

Хийгдэхээр хүлээгдэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй гүйлгээний талаар гадаад, дотоодын холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээлэл цуглуулах арга хэмжээг Санхүүгийн Мэдээллийн Алба авах эрхтэй²¹³ байхаар хуульд заасан.

Санхүүгийн Мэдээллийн Албаны чиг үүрэгт мөнгө угаахад өртөх эрсдэлтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх²¹⁴ чиг үүрэг хамаардаг.

2013 онд шинэчлэгдэн батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулиар мөнгө угаах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагад үндэсний болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой байх, гадаадын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн орчныг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн байна.

²¹¹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1

²¹² Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2

²¹³ Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1

²¹⁴ Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Анх 2004 онд АНУ-ын муж улсуудын шүүхийн үндэсний төвөөс Монголд хэрэгжүүлж буй “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” Хууль зүйн үндэсний төвтэй хамтран “Хуульчийн ёс зүй” сэдэвт сургалт семинар, мөн “Эрх чөлөө эрх зүйт ёс холбоо”-той хамтран “Мөнгө угаах гэмт хэрэг ба санхүү, аж ахуйн гэмт хэргийг мөрдөн байцаах ажиллагаа” сэдэвт сургалтад Улсын ерөнхий прокурорын газар болон нийслэл, дүүргийн прокурор, мөрдөн байцаагчдыг хамруулж²¹⁵ байсан бол мөн оны 6 сараас эхлэн Монгол Улс нь ФАТФ-ын үйл ажиллагааг бүс нутагт явуулдаг Ази, номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг буюу APG (Asia/Pacific Group on Money Laundering) –д гишүүнээр элссэн бөгөөд энэ бүлэгт тогтмол ахиц дэвшлээ тайлагнаж, энэ байгууллагаар үйл ажиллагаагаа үнэлүүлдэг. Энэ байгууллага нь гишүүн орнуудаа ФАТФ-ын 49 зөвлөмжийн дагуу үнэлдэг. Энэхүү үнэлгээний нэг хэсэг нь Санхүүгийн Мэдээллийн Албаны үйл ажиллагаа хамардаг бөгөөд түүний бүтэц, зохион байгуулалт, бие даасан байдал, төсөв төлөвлөгөө гэх мэт олон зүйлийг харгалздаг болсон. Иймд, манай улс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоотой болохын тулд дээрх олон улсын стандартуудыг хичээнгүйлэн биелүүлж тогтолцоогоо хөгжүүлэн²¹⁶ ажиллаж байгаа юм байна.

Дээрх хуулийн төслүүдийг боловсруулахад Дэлхийн банк, ОУВС, НҮБ-ын терроризмын эсрэг хяналтын баг, Ази Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хяналтын бүлэг зэрэг олон улсын байгууллагуудтай Монголбанк нягт хамтарч ажилласан. 2013 онд Монголбанк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулинд орох нэмэлт, өөрчлөлтийн талаар гаргаж байгаа ахиц дэвшлийн талаар ФАТФ, APG байгууллагад улирал бүр бичгээр болон амаар танилцуулж, тайлагнаж ирсэн. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкны бүтцэд ажилладаг, санхүүгийн байгууллагуудаас мөнгө угаах, эсхүл терроризмыг санхүүжүүлэх сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, хууль сахиулах байгууллагуудад дамжуулах чиг үүрэгтэй Санхүүгийн мэдээллийн алба /CMA/-ны орон тоо, чадавхийг дээшлүүлэхтэй холбоотой ажлуудыг хэрэгжүүлэв. Үүний үр дүнд Ази Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаахтай тэмцэх тогтолцоонд хийсэн 2012 оны харилцан үнэлгээний дагуух үнэлгээ (mutual evaluation follow up)-гээр CMA-ны үйл ажиллагааг, ялангуяа түүний дүн шинжилгээ хийх, орон тоог нэмэгдүүлэх, хяналт шалгалтын чадавхийг сайжруулах чиглэлээр хийсэн ажлуудыг “хангалттай” түвшинд хүрсэн гэж үнэлсэн байна. 2013 онд санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан зайнаас болон газар дээрх хяналт шалгалтын хөтөлбөр, журам боловсруулахад ОУВС-гаас Техникийн тусалцаа авч, энэ талаарх Монголбанк, Санхүүгийн

²¹⁵ Авлигатай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн Хэрэгжилтийн Дүн Шинжилгээний Тайлан, 2012 он

²¹⁶ Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн албанаас мэдээлсэн “ФАТФ-ын Зөвлөмж”, Монгол Банкны цахим хуудас, <http://www.mongolbank.mn/listCMA.aspx?did=6>

мэдээллийн албаны хяналт шалгалтын чадавхийг сайжруулах ажлуудыг зохион байгууллаа²¹⁷.

Түүнчлэн Монгол Улс нь 2009 оны 5 дугаар сарын 25-ны өдөр СМА нь олон улсын Санхүүгийн мэдээллийн албадын бүлэг болох Эгмонт бүлэгт элссэнээр Монголын Санхүүгийн Мэдээллийн Алба бусад 118 орны Санхүүгийн мэдээллийн албадтай шууд харилцаж мэдээлэл солилцох боломжоор хангагдсан. Үүний үр дүнд Санхүүгийн Мэдээллийн Алба нь 6 орны Санхүүгийн мэдээллийн албанд тодорхой дүн шинжилгээ болон бусад байгууллагаас ирүүлсэн лавлагааны хүрээнд тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар мэдээлэл ирүүлэх хүсэлт явуулсан бөгөөд 3 орны СМА-наас хариу ирүүлсэн²¹⁸.

Мөн түүнчлэн, Эгмонтын гишүүн бус боловч манай Санхүүгийн Мэдээллийн Албатай мэдээлэл солилцох хоёр талын Санамж бичиг зурсан гадаадын байгууллагууд байх бөгөөд Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны Үйл ажиллагааны 2013 оны IV улирлын Статистик Мэдээлэлд Санхүүгийн Мэдээллийн Албаны гадаадын байгууллагуудтай шинээр байгуулсан санамж бичгийн тоо 2008-2011 онуудын хооронд 11, 2012 онд 5 санамж бичиг нийт 16 гадаадын байгууллагуудтай санамж бичиг байгуулж, Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байна²¹⁹.

СМА-ны 2013 бүтэн жил, 2014 оны хагас жилийн ажлын тайлангаас Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хийсэн ажлын тоон үзүүлэлтийг доорх хүснэгтээс харж болно.

Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны 2014 оны I улирлын статистикийн мэдээлэл					
Үзүүлэлтүүд	2014 оны I улирлын дүн	2013 оны нийт дүн	2012 оны нийт дүн	2008-2011 онуудын дүн	Онуудын дүн /өссөн дүнгээр/
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн тоо	1	20	8	11	40
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариуны тоо	4	17	6	6	33
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-нд ирүүлсэн хүсэлтийн тоо	1	11	14	32	58

²¹⁷ Санхүүгийн Мэдээллийн Албаны 2013 оны жилийн тайлангийн 5 дугаар зүйлийн 5, 6, 7, 8 дугаар мөр;

²¹⁸ “Санхүүгийн Мэдээллийн Албаны 2009 оны I улирлын байдлаарх үйл ажиллагааны тайлан” 2 дугаар хуудас;

²¹⁹ Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны Үйл ажиллагааны 2013 оны IV улирлын Статистик Мэдээлэл, Монгол Банкны цахим хуудас, <http://www.mongolbank.mn/documents/cma/news/201304.pdf>

Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-нд ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо	1	4	8	12	25
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас СМА-нд шалгуулахаар ирүүлсэн мэдээллийн тоо	0	0	3	2	5

Энэхүү судалгаанаас үзвэл, СМА гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцох хамтын ажиллагаа аажмаар төлөвшиж байна. Энэхүү үнэлгээний явцад шүүх болон хууль сахиулах байгууллагын мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр гадаадын ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл солилцсон талаар тодорхой мэдээлэл бидэнд олдоогүй болно. Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны цахим хуудсанд “Мөнгө, угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан хууль журмууд” гэсэн цэс байх боловч бидний судалгаа хийх хугацаанд “засвар хийгдэж байна гэсэн байдалтай” 2 долоо хоногийг өнгөрөөсөн. Санхүүгийн Мэдээллийн Албаны үйл ажиллагааны дүрэм, журам олдоогүй болно.

ЗӨВЛӨМЖ:

- Шүүх болон хууль сахиулах байгууллагын мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр гадаадын ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл солилцсон талаарх нууцад хамаарахаас бусад тоон болон чанарын мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх
- Санхүүгийн Мэдээллийн Албаны дээр дурдсан тус цэсийг ажилладаг болгох, нууцад хамаарахаас бусад мэдээллийг ил тод болгох. Нь тухайн байгууллагын талаарх төрийн бусад байгууллага, олон нийтийн ойлголтыг бий болгох авлига, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогддог тэмдэглэж байна.

10.3. 2. Оролцогч улсууд хилийг нь дамжих бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах санхүүгийн зохих хэрэгслийн хөдөлгөөнийг илрүүлж, хянах талаар боломжит арга хэмжээ авах асуудлыг авч үзэх бөгөөд ингэхдээ мэдээллийг зохистойгоор ашиглах явдлыг хангах баталгааг мөрдөж, хөрөнгийн хууль ёсны хөдөлгөөнд саад болохгүй. Эдгээр арга хэмжээнд хувь хүн болон аж ахуйн нэгжийн их хэмжээний бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах санхүүгийн зохих хэрэгслийг хил дамжуулан шилжүүлсэн талаар

мэдээлж байх шаардлага багтаж болно. /Конвенцийн 14 дүгээр зүйлийн 14.2./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах харилцаа нь **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн** 15 дугаар зүйлээр зохицуулагдаж байна. Зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй. Энэхүү мэдүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийг гаалийн байгууллага нэгтгэж, сар бүр холбогдох журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлдэг.

Бэлэн болон бэлэн бус мөнгөн гүйлгээний мэдээллийг нууцлах асуудлын хувьд мөнгө угаахад өртөх эрсдэлтэй этгээд болон Санхүүгийн мэдээллийн алба нь эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад этгээдэд харилцагчийн гүйлгээний талаарх мэдээлэл өгөх, дамжуулахыг хориглоно²²⁰. Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хянан шалгагч, шинжээч, ажилтан албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчийн гүйлгээтэй холбогдох мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно²²¹.

Монгол Банкны Ерөнхийлөгч, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Даргын хамтарсан 2008 оны 11 сарын 28-ны өдрийн 515/760 тоот тушаалын хавсралтаар “Монгол Банк, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Хооронд Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Талаар Хамтран Ажиллах тухай журам” батлагдсан. Энэхүү журамд 2013 оны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн шинэчлэгдсэн найруулгын нэмэлт, өөрчлөлт ороогүй, 2006 оны хүчингүй болсон хуулийн зохицуулалтаар хэрэгжиж байгаа журам боловч одоогийн байдлаар дээрх хоёр байгууллагын хоорондын харилцааг зохицуулж, хэрэгжиж байгаа журам болно.

Энэхүү журмаар Зорчигч Монгол Улсын хилээр бэлэн мөнгө, гадаад валют оруулахад, гаргахад Гаалийн байгууллага болон Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албаны эрх үүргийг тодорхойлж, хамтран ажиллах харилцааг зохицуулсан байна. Тухайлбал:

Гаалийн байгууллагын эрх, үүрэг²²²

²²⁰ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 13.1.

²²¹ Мөн хуулийн 13.2.

²²² Монгол Банкны Ерөнхийлөгч, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Даргын хамтарсан 2008 оны 11 сарын 28-ны өдрийн 515/760 тоот тушаалын хавсралтаар “Монгол Банк, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Хооронд Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Талаар Хамтран Ажиллах тухай журам”-ын 3 дугаар зүйл.

- Монгол Улсын хилийн боомтуудад итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох, чөлөөлөх ба энэ талаархи шийдвэрийг ажлын 3 хоногийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх;
- "Зорчигчийн гаалийн мэдүүлэг"-ийн маягтыг хэвлүүлж, хилийн гаальд хүргүүлэх, маягтыг хилээр нэвтрэх зорчигчдоор бөглүүлэх ажлыг зохион байгуулах;
- Улсын хилээр нэвтрэх зорчигчдоор мэдүүлэг бөглүүлэх, "5 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ эсхүл түүнээс дээш хэмжээний бэлэн мөнгөний мэдүүлэг бүртгэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;
- Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь "5 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ эсхүл түүнээс дээш хэмжээний бэлэн мөнгөний мэдүүлгийг бөглөсөн зорчигчдын тухай мэдээллийг нэгтгэн сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Улсын гаалийн ерөнхий газарт хүргүүлнэ. Улсын гаалийн ерөнхий газар нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн ирүүлсэн уг мэдээллийг нууцлал. аюулгүй байдлыг хангаж, бичгээр, факсаар эсхүл цахим сүлжээгээр Санхүүгийн мэдээллийн албанд ажлын 5 хоногийн дотор хүргүүлэх;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн тухай хэвлэмэл, цахим сургалчилгааны материал болон мэдүүлгийг хилээр зорчигчдод ил харагдах газарт байрлуулах;
- Банкны байгууллага зузаатгалын бэлэн мөнгийг "Зорчигчийн гаалийн мэдүүлэг" болон "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг"-т нэрлэсэн үнээр мэдүүлнэ.
- Улсын гаалийн ерөнхий газар нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтарч удирдан зохион байгуулах, Санхүүгийн мэдээллийн албатай харилцан мэдээлэл солилцоно.
- Улсын гаалийн ерөнхий газар нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрийн нэг бүрчилсэн, нэгтгэсэн мэдүүлгийн тоо, илрүүлсэн хэрэг зөрчлийн талаар судалгаа гаргаж улирал тутам Санхүүгийн мэдээллийн албанд өгнө.

Санхүүгийн мэдээллийн албаны эрх, үүрэг²²³

- Улсын гаалийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- Мэдээллийг хүлээн авах, нэгтгэх, боловсруулах, боловсронгуй болгох зориулалтын програм хангамжийг зохиох, хангах
- Итгэмжлэгдсэн төлөөлөгч болон гаалийн холбогдох бусад ажилтнуудад мөнгө угаах болоп терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлаар сургалт зохион байгуулах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хүрээнд гаалийн байгууллага болон итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хамтарч ажиллан, мэдээлэл солилцоно.

²²³ Монгол Банкны Ерөнхийлөгч, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Даргын хамтарсан 2008 оны 11 сарын 28-ны өдрийн 515/760 тоот тушаалын хавсралтаар "Монгол Банк, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Хооронд Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Талаар Хамтран Ажиллах тухай журам"-ын 4 дугаар зүйл.

- Монголбанк итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ажил, албан тушаал хавсран ажилласны нэмэгдэл хөлсийг Улсын гаалийн ерөнхий газраар дамжуулан үндсэн цалингийн 20 хүртэл хувиар тооцож сар бүр олгоно.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авсан мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс мэдээллийг нуун дарагдуулах буруу мэдээлэх, нууц задруулахыг хориглох²²⁴ бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна²²⁵.

Монгол Банк, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Хооронд Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Талаар Хамтран Ажиллах тухай журам нь 2008 оны 11 сарын 28-ны өдрийн 515/760 тоот тушаалын хавсралтаар батлагдсан бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан өөрчлөлт оруулаагүйгээс хүчингүй болсон хуулийн 15 дугаар зүйлд заасан мөнгөн дүнгийн хэмжээ буюу 5 сая төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютыг хилээр гаргадаа мэдүүлэх тухай шинэ хуульд нийцээгүй заалтаа мөрдсөн хэвээр байна.

ЗӨВЛӨМЖ:

- Монгол Банк, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Хооронд Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Талаар Хамтран Ажиллах тухай 2006 онд батлагдсан журмаа яаралтай шинэчлэх.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны Үйл ажиллагааны 2013 оны IV улирлын Статистик Мэдээлэлд Гаалийн мэдүүлгийн тайлангийн тоо 2008-2010 оны хооронд 7666 байсан бол, 2011 онд 2376, 2012 онд 2,796, 2013 онд 3,259, 2014 оны I улирлын тайлангийн дүнгээр 653 байна.

ОН	2014 оны I улирлын дүн	2013 оны нийт дүн	2012 оны нийт дүн	2011 оны нийт дүн	2008-2010 оны дүн	Онуудын дүн /өссөн дүнгээр/

²²⁴ Мөн журмын 5 дугаар зүйлийн 5.1. заалт

²²⁵ Мөн журмын 5 дугаар зүйлийн 5.2. заалт

ГААЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТАЙЛАНГИЙН ТОО	653	3,259	2,796	2 376	7 666	16,750
--	-----	-------	-------	-------	-------	--------

Монгол Банкны Ерөнхийлөгч, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Даргын хамтарсан 2008 оны 11 сарын 28-ны өдрийн 515/760 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Монгол Банк, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Хооронд Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Талаар Хамтран Ажиллах тухай журам”-ын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн, хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаар мэдээлэл хомс байна.

ЗӨВЛӨМЖ:

- Эрх зүйн орчны хүрээнд Монгол банкны ерөнхийлөгч болон Гаалийн газрын дарга нарын хамтран баталсан тушаалыг 2013 онд шинэчлэгдэн батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуульднийцүүлэн “Хөрөнгийн чөлөөт хөдөлгөөн”-ий босго шалгуурт нийцүүлэн, нэмэлт өөрчлөлт оруулах, ийнхүү өөрчлөлт оруулахдаа 15 сая төгрөг түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаас гадна санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг нэмж тусгах оруулах.

10.4. 3. Оролцогч улсууд санхүүгийн байгууллага, үүний дотор мөнгө гуйвуулдаг байгууллагад дараах шаардлага тавих талаар хэрэгжих боломжтой бөгөөд зохих арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг авч үзнэ: (а) мөнгөний цахим шилжүүлгийн маягт болон холбогдох мэдээнд шилжүүлэгчийн талаар үнэн зөв бөгөөд чухал мэдээллийг тусгах; /Конвенцийн 14.3.а./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Шилжүүлэгчийн талаар үнэн зөв бөгөөд чухал мэдээллийг тусгахын тулд харилцагчийг таньж мэдэх ажиллагаа хэрэгжидэг. Харилцагчийг таньж мэдэхийн тулд **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд** зохицуулснаар дараах мэдээллийг заавал мэдэх шаардлагатай:

- харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй

хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах²²⁶;

- харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг гаргуулж авах²²⁷;
- эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх, ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго, гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах²²⁸;
- харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах²²⁹;
- харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах²³⁰;
- банк, санхүүгийн байгууллагын хоорондын шилжүүлэг хийгч, хүлээн авагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, харилцах утасны дугаарыг тодруулах²³¹.

Банк, Эрх Бүхий Хуулийн Этгээдийн Мөнгөн Хадгаламж, Төлбөр Тооцоо, Зээлийн Үйл Ажиллагааны тухай хуулиар цахим данс нээх, хаахтай холбоотой харилцааг 12¹ -т зохицуулсан. Иргэн, хуулийн этгээд тогтоосон журмын дагуу банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд данс нээлгэж, төлбөр тооцооны үүрэг гүйцэтгүүлэх эрхтэй. Хуулийн этгээд данс нээлгэхийн тулд дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

- өргөдөл;
- улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний баталгаатай хуулбар, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар;
- мөнгөн хөрөнгө захиран зарцуулах албан тушаалтны овог нэр, төлбөр тооцооны баримтад зурах гарын үсгийн маяг. Гарын үсгийн маяг нь нотариатын баталгаатай байна;
- тамга, тэмдгийн дардас.

Иргэн данс нээлгэхийн тулд дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

- өргөдөл;
- мөнгөн хөрөнгө захиран зарцуулах тухай мэдүүлэг, төлбөр тооцооны баримтад зурах гарын үсгийн маяг.

²²⁶ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.2.1

²²⁷ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.2.2

²²⁸ Мөн хуулийн 5.2.3

²²⁹ Мөн хуулийн 5.2.4

²³⁰ Мөн хуулийн 5.2.5

²³¹ Мөн хуулийн 5.2.6

Банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд дээр дурдсан баримт бичгийг хянан үзээд 10 хоногийн дотор данс нээх буюу дээрх баримт бичгүүд эргэлзээтэй бол данс нээхээс татгалзах эрхтэй. Төлбөр тооцооны гүйлгээ хийхэд Банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь иргэн, хуулийн этгээд оролцсон төлбөр тооцоог гүйцэтгэхдээ уг төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг шалгах үүрэгтэй. Төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрт уг баримтыг бичсэн он, сар, өдөр, төлбөр хүлээн авагч, төлбөр хариуцагчийн дансны дугаар, нэр, тэдгээрийг үйлчлэгч банкны нэр, гүйлгээний утга, мөнгөний дүнг тоо болон үсгээр бичиж, баталгаатай гарын үсэг зурж, тамга эсхүл тэмдэг дарсан байх шаардлагатай²³² байдаг.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 312 дугаар тушаалын хавсралтаар “Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхээс Сэргийлэх, Түүнтэй Тэмцэхэд Харилцагчийг Таньж Мэдэх Талаар Банкны Баримтлах Журам” батлагдсан ба уг журмаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс сэргийлэхэд банкны хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахдаа 1 дүгээр зүйлийн 1.5-д: “Банк нь МУТС-тэй тэмцэх талаарх өөрийн дотоод журмын дагуу харилцагчийн эрсдлийн ерөнхий түвшинг тогтоох, их хэмжээний эрсдэл дагуулсан харилцагчийн дансыг тусгайлан хянах, тогтсон хэм хэмжээнээс гадуурхи гүйлгээг нягтлан шалгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.”, мөн 1.6-д: “Банк, түүний нэгжийн хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээ, байршил, төрлөөс шалтгаалж харилцагчийг таньж мэдэх шаардлага өөр байж болно.” 2 дугаар зүйлийн 2-т: “... гүйлгээ хийх болон санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс өмнө ... харилцагчаас дараах мэдээллийг гаргуулж авна:

- Харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар;
- Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн нэр, хаягийг авна;
- Гүйлгээний мөнгөн дүн, утга, төлбөр хүлээн авагчийн тухай мэдээлэл;
- Бэлэн бус шилжүүлэг хийсэн этгээдийн тухай мэдээлэл;
- Данс нээх үед дээрх мэдээллээс гадна харилцагч нь иргэн бол түүний иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хуулийн этгээд бол түүний улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаархи дэлгэрэнгүй танилцуулгыг авна. – гэсэн зэргээс харах

юм бол цахим хэлбэрээр шилжүүлэгдэх мөнгөн гүйлгээнд тухайн шилжүүлэгчийн талаарх шаардлагатай бүхий л мэдээллийг тусгах эрх зүйн орчинг банкны салбарт бүрдүүлсэн байна.

²³² Банк, Эрх Бүхий Хуулийн Этгээдийн Мөнгөн Хадгаламж, Төлбөр Тооцоо, Зээлийн Үйл Ажиллагааны тухай хуулийн 17.1.

Цахим шилжүүлгийн тогтолцоонд бусад санхүүгийн үйл ажиллагааны нэгэн адил мөнгөний цахим шилжүүлгийн маягт болон холбогдох мэдээнд шилжүүлэгчийн талаар үнэн зөв бөгөөд чухал мэдээллийг цуглуулах, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжоор өөрийн орны эрх зүйн тогтолцоо, банк, санхүүгийн байгууллагуудын тогтолцоо, онцлогт нийцүүлэн бүрдүүлсэн байна.

Практик хэрэгжилтийг судлан шинжлэх хүрээ өргөн, банк болон банкаас бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай тус бүртэй нь танилцах, судлах боломж хомс тул практик хэрэгжилтийг судлах боломжгүй байна. Энэ нь мэдээллийн нууцлалыг хадгалах шаардлагаас үүдэлтэй байж болох юм.

10.5. (b) ийм мэдээллийг төлбөр хийх явцыг бүх шатанд хадгалах; /Конвенцийн 14 дүгээр зүйлийн 14.3.б./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А202 дугаар тушаалын хавсралтаар “Монголбанкнаас Төлбөрийн Системийн Талаар Баримтлах Бодлого” батлагдсан. Уг бодлогоор Монгол УЛсын төлбөрийн системийн зорилго, түүний бүтэц бүрэлдэхүүн, оролцогч талуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон. Бодлогын 2 дугаар зүйлийн 2.4-т: “Төлбөрийн систем нь дараах төлбөр тооцооны системээс бүрлэнэ:

- Их дүнтэй төлбөр тооцооны систем
- Бага дүнтэй төлбөр тооцооны систем
- Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцооны бусад систем” – гэж Монгол Улсын төлбөрийн системийн

бүрэлдэхүүнийг тодорхойлсон. Бодлогын баримт бичиг нь 2012 оны 12 сард батлагдсан ч Их дүнтэй төлбөр тооцооны журам, Бага дүнтэй төлбөр тооцооны журам, Төлбөрийн картын үйлчилгээний журам гэсэн 3 үндсэн төлбөр тооцооны системийн журмыг дээрх бодлогын баримт бичиг гархаас өмнө Монголбанкны ерөнхийлөгч баталж, мөрдүүлж байсан ба 2013, 2014 онуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь оруулсан байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 245 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Банк Хоорондын Бага Дүнтэй Төлбөр Тооцооны Журмын 3.1.5-д зааснаар “Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны системд оролцогч тал илгээсэн гүйлгээнийхээ тоо ширхэг ба үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.”, мөн 4.1.5-д зааснаар “Төлбөр илгээгч тал өөрийн болон төлбөр хүлээн авагч талын харилцагчийн дансны дугаар, дансны нэрийг үнэн, зөв илгээнэ.” – гэсэн.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А-51 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Төлбөрийн Системийн Оролцогч Хоорондын Их Дүнтэй Төлбөр Тооцооны Журмын 12.3-д: “Оролцогч илгээсэн гүйлгээнийхээ тоо баримт, өгөгдлийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.” – гэсэн.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23 ний өдрийн 253 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхээс Сэргийлэх, Харилцагчийг Таньж Мэдэх, Сэжигтэй Болон Бэлэн Мөнгөний Гүйлгээг Мэдээлэх Журмын 5 дугаар зүйлд “Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг факс, цахим хэлбэрээр эсхүл бичгээр нууцлал, аюулгүй байдлыг хангаж Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхдээ Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бичгээр ирүүлбэл, гарын үсгээр баталгаажуулж, тэдгээрийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах.” – гэсэн зэргээс харах юм бол төлбөр тооцооны аль ч шатанд мэдээлэл үнэн зөв байх асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулсан байна.

Банкны төлбөр тооцооны системийнн тогтолцооныхоо аль ч бүрэлдэхүүнд буюу Их дүнтэй төлбөр тооцооны систем, Бага дүнтэй төлбөр тооцооны системд оролцогч тал төлбөр тооцооны гүйлгээнийхээ тоо баримт, үнэн, зөв мэдээллийг өөрөө хариуцах шаардлагыг хуульд болон эрх бүхий байгууллагаас баталсан журмаар зохицуулсан байна.

Практик хэрэгжилтийн хувьд судлан шинжлэх хүрээ өргөн, банк болон банкаас бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай тус бүртэй нь танилцах, судлах боломж хомс тул практик хэрэгжилтийг судлах боломжгүй байна.

10.6. (с) шилжүүлэгчийн талаар бүрэн мэдээлэл байхгүй мөнгөн шилжүүлгийн талаар нарийн шалгалт явуулах; /Конвенцийн 14.3.с./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн 5.3-т: “Харилцагчийн талаарх мэдээллийг нарийвчлан шалгахтай холбоотой бусад шаардлагыг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан журмын дагуу зохицуулна”, 5.8-д: “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй гэж тодорхойлсон бизнесийн харилцаа, гүйлгээнд холбогдох харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.” – гэж тус тус заасан.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 312 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхээс Сэргийлэх, Түүнтэй Тэмцэхэд Харилцагчийг Таньж Мэдэх Талаар Банкны Баримтлах Журам”-аар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс сэргийлэхэд банкны хэрэгжүүлэх үйл

ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулсан. Тус журмын 3 дугаар зүйлийн 3.1-т зааснаар Банк дор дурдсан данс, гүйлгээг тусгайлан хянах үүрэгтэй:

- 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ
- Тухайн гүйлгээний утга нь тодорхой бус,
- Бэлэн бус шилжүүлэг хийсэн, эсхүл шилжүүлэг хийлгэсэн этгээдийн тухай бүрэн мэдээлэлгүй,
- МУТС-тэй тэмцэх тогтолцоо хангалтгүй, МУТС гэмт хэрэг их гардаг улс, бүс нутагт оршин суудаг харилцагчийн дансанд,
- Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан жагсаалтад орсон гадаад улсын төрийн албан тушаалтан болон улс төрийн намын удирдлагын нэр дээр хийгдэх гүйлгээ,
- Тухайн харилцагчийн урьд нь хийж байснаас өөр бөгөөд утга нь тодорхойгүй гүйлгээ.

Банк дээрх гүйлгээний талаар нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах зэргээр бололцоотой бүх арга хэмжээг авна²³³. Банк нь ХТМ шаардлагын хүрээнд түүний эрсдлийн түвшинг тогтоож, өндөр эрсдэлтэй харилцагчийн данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавина. /3.3/ Харилцагчаас банкинд нэмэлт мэдээлэл, тайлбар өгөхөөс татгалзаж байвал банк харилцагчтай байгуулсан гэрээг цуцлах эрхтэй. /3.4/

Шилжүүлэгчийн талаар бүрэн мэдээлэл байхгүй мөнгөн шилжүүлгийг нарийн шалгах харилцааг хуулиар, журмаар тодорхой хэмжээнд зохицуулсан байх бөгөөд сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг Санхүүгийн Мэдээллийн Албанд мэдээлэх журмыг Монголбанкны Ерөнхийлөгч баталсан. Тус журмын талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 10.1 дэх хэсгээс харна уу.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ-ийн талаарх мэдээлэл хомс байна. Зохих нууцлалыг хадгалах баталгааны үндсэн нарийвчилсан судалгаа шинжилгээ хийхийг зөвлөж байна.

10.7. 4. Энэ зүйлийн нөхцлийн дагуу зохицуулалт, хяналтын дотоодын дэглэм тогтоохдоо бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагаас мөнгө угаахын эсрэг холбогдох санаачлагыг удирдлага болгохыг улсуудад энэхүү конвенцийн аливаа бусад зүйлийг зөрчихгүйгээр уриалж байна. /Конвенцийн 14 дүгээр зүйлийн 14.4./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д: “Олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой байх явдлыг хангах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн

²³³ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 312 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхээс Сэргийлэх, Түүнтэй Тэмцэхэд Харилцагчийг Таньж Мэдэх Талаар Банкны Баримтлах Журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2

алба нь ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшний, гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана” – гэж заасан.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бүлэг /ФАТФ/-ээс манай улсад тавьж байгаа хяналтын хүрээнд 2012, 2013 оны турш Монголбанк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол улсын хууль тогтоомжийг олон улсын стандарт /ФАТФ-ын 40 зөвлөмж/-д нийцүүлэхтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах ажлыг Хууль Зүйн Яам, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран УИХ-ын чуулганы 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Терроризмтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг тус тус баталсан.

ФАТФ-тай тохирсон төлөвлөгөөний дагуу 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Терроризмтэй тэмцэх тухай хуулийн холбогдох нэмэлт өөрчлөлт, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан 1267, 1373 дугаар тогтоолуудад үндэслэн “Террористуудын жагсаалтыг гаргах, тэдгээрийн хөрөнгийг битүүмжлэх, хянах журам”-ыг батлуулсан.

Түүнчлэн, 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр УИХ-аар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулинд тус тус холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улс ФАТФ-тай тохирсон ажлуудыг бүгдийг хийсэнд тооцсон байна. Ингэснээр 2014 оны 2 дугаар сарын 17-нд Францын Парис хотноо болсон ФАТФ-ын 22 дугаар чуулга уулзалтын үеэр энэ чиглэлд манай улсын гаргасан ахицыг өндрөөр үнэлж, Монгол Улсыг “хар саарал жагсаалт”-аас гаргаж зэрэглэлийг нь дээшлүүлсэн тухай өмнөх хэсгүүдэд дурьдаж байсан.

Түүнчлэн, Санхүүгийн Мэдээллийн Албанаас ирүүлсэн 2013 оны тайлангийн 5.1 дэх хэсэгт: “Дээрх хуулийн төслүүдийг боловсруулахад Дэлхийн банк, ОУВС, НҮБ-ын терроризмын эсрэг хяналтын баг, Ази Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хяналтын бүлэг зэрэг олон улсын байгууллагуудтай Монголбанк нягт хамтарч ажилласан. 2013 онд Монголбанк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулинд орох нэмэлт, өөрчлөлтийн талаар гаргаж байгаа ахиц дэвшлийн талаар ФАТФ, APG байгууллагад улирал бүр бичгээр болон амаар танилцуулж, тайлагнаж ирсэн. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкны бүтцэд ажилладаг, санхүүгийн байгууллагуудаас мөнгө угаах, эсхүл терроризмыг санхүүжүүлэх сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, хууль сахиулах байгууллагуудад дамжуулах чиг үүрэгтэй Санхүүгийн мэдээллийн алба /СМА/-ны орон тоо, чадавхийг дээшлүүлэхтэй холбоотой ажлуудыг хэрэгжүүлэв. Үүний үр дүнд Ази Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаахтай тэмцэх тогтолцоонд хийсэн 2012 оны харилцан үнэлгээний дагуух үнэлгээ (mutual evaluation follow up)-гээр СМА-ны үйл ажиллагааг, ялангуяа

түүний дүн шинжилгээ хийх, орон тоог нэмэгдүүлэх, хяналт шалгалтын чадавхийг сайжруулах чиглэлээр хийсэн ажлуудыг “хангалттай” түвшинд хүрсэн гэж үнэлсэн байна. 2013 онд санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан зайнаас болон газар дээрх хяналт шалгалтын хөтөлбөр, журам боловсруулахад ОУВС-гаас Техникийн туслалцаа авч, энэ талаарх Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албаны хяналт шалгалтын чадавхийг сайжруулах ажлуудыг зохион байгууллаа.” – гэсэн зэргээс харах юм бол **Монгол Улс бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагаас мөнгө угаахын эсрэг холбогдох санаачлагыг удирдлага болгон ажиллах талаар шаардлагатай, өөрөөс шалтгаалах хүчин чармайлт гаргаж байна гэж үзэж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүчин чармайлтаа үндэсний түвшинд холбогдох бүх байгууллагын үйл ажиллагаатай уялдуудах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна.**

10.8. 5.Оролцогч улсууд мөнгө угаахтай тэмцэхийн тулд шүүх, хууль сахиулах болон санхүүгийн зохицуулалтын эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэлхийн, бүс нутгийн, дэд бүсийн болон хоёр талын хэмжээнд хөгжүүлж, дэмжихийг чармайна. /Конвенцийн 14 дүгээр зүйлийн 14.5./

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Шүүхийн захиргааны тухай хууль /2012 он/, Монгол Улсын Шүүхийн тухай хууль /2012 он/-уудад мөнгө угаах үйл ажиллагаатай холбоотой, энэ чиглэлээр олон улсын, бүс нутгийн, дэд бүсийн болон хоёр талын хэмжээнд хамтын ажиллагаа, харилцаа холбоо тогтоох, хөгжүүлэх талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Монгол Удсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д: “Ерөнхий шүүгч тухайн шүүхийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх эрхтэй” – гэж зааснаас өөрөөр Шүүх байгууллагыг гадаад харилцааг зохицуулсан зохицуулалт хуулинд алга байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2013 оны 05 сарын 31-ий өдрийн Дугаар 04 тогтоолоор “Ажлын албаны үйл ажиллагааны дүрэм” батлагдсан байна. Тус тогтоолын үндэслэх хэсэгт Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1²³⁴, 14 дүгээр 14.2²³⁵, 15 дугаар зүйлийн 15.2²³⁶ дахь хэсгүүдийг үндэслэл болгосон байх бөгөөд тус дүрмийн 10 дугаар зүйлд Шүүхийн гадаад харилцааны хэлтсийн чиг үүргийн талаар зохицуулжээ. 10 дугаар зүйлийн 10.2-т: “Ерөнхий зөвлөлийн төлөвлөгөөнд гадаад харилцааны чиглэлээр тусгагдсан олон улсын болон бүс нутаг, хоёр талын хамтын ажиллагаатай байгууллага хоорондын арга

²³⁴ Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1. Ерөнхий зөвлөл шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: шүүхийн захиргаа, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон стандарт, дүрэм, журам батлан мөрдүүлэх;

²³⁵ Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т: Ерөнхий зөвлөл бүтэц, зохион байгуулалтаа өөрөө тогтоох бөгөөд ажлын албаны үйл ажиллагааг дүрмээр зохицуулна.

²³⁶ Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т: Ерөнхий зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлыг энэ хуулийн 15.1-д заасан хуралдаанаар хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол батална.

хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулах.”, 10.5-д: “Гадаад улс орны шүүх, шүүхийн захиргааны байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох ажлыг судалж санал боловсруулах.” – гэж заасан нь шүүхийн байгууллага мөнгө угаах үйл ажиллагаа, гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинж чанар, түүнийг хянан шийдвэрлэх арга зүй зэрэг шүүхийн шийдвэр гаргахад шаардлагатай онолын болон практикийн туршлага олон улсын байгууллагуудаас олж авах боломж бололцоог бүрдүүлж байна.

Прокурорын байгууллагын тухай хууль /2002 он/-д мөнгө угаах үйл ажиллагаа, түүний эсрэг авах арга хэмжээ, санхүүгийн зохицуулалтын байгууллагатай харилцах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй хэдий ч Прокурорын байгууллагын гадаад харилцааг зохицуулсан хууль зүйн орчин байна. Үүнд: “Улсын ерөнхий прокурор өөрийн эрх хэмжээний хүрээнд гадаад улсын ижил төстэй байгууллага, олон улсын байгууллагатай шууд харилцаж хамтран ажиллах, тэдэнтэй эрх зүйн туслалцаа үзүүлэх буюу гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар хэлэлцээр байгуулж болно²³⁷.” – гэсэн нь Прокурорын байгууллагыг мөнгө угаах гэмт хэргийн эсрэг гадаад улсын байгууллагууд болон ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага мэдээлэл солилцох хууль зүйн орчинг бүрдүүлж байна.

Цагдаагийн албаны тухай хууль /2013 он/-д мөнгө угаах гэмт хэргийг судлах, илрүүлэхтэй холбоотой тусгайлсан зохицуулалт байхгүй боловч олон улсын цагдаагийн байгууллага (интерпол)-ын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, гадаад орны цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн нийт байгууллагыг хангах²³⁸ чиг үүргийг Цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлэх, 29 дүгээр зүйлийн 29.3-т: “Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсын хууль сахиулах байгууллага болон олон улсын цагдаагийн байгууллагад тэдгээрийн хүсэлтээр мэдээллийн сангаас мэдээлэл өгч болно.” – гэж тус тус зохицуулсан нь мөнгө угаах гэмт хэргийн эсрэг гадаад улсын байгууллагууд болон ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага мэдээлэл солилцох боломжийг хууль зүйн хувьд бүрдүүлж байна.

Тагнуулын байгууллагын тухай хууль /1999 он/-д мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой тусгайлсан зохицуулалт байхгүй хэдий ч Тагнуулын ерөнхий газар нь эрх тэгш байх, харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох зарчмын үндсэн дээр гадаад улсын тусгай алба, байгууллагатай хамтран ажиллах эрхтэй²³⁹ гэж зохицуулснаар мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой хэрэгт гадаадын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох эрх зүйн орчинг хуульд тусгасан байна.

Авлигын эсрэг хууль /2006/-д мөнгө угаах гэмт хэрэгтэй хобогдуулан тусгайлсан зохицуулалт байхгүй ч гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл

²³⁷ Прокурорын байгууллагын тухай хууль, 2002 он, 49 дүгээр зүйлийн 49.1;

²³⁸ Цагдаагийн албаны тухай хууль, 2013 он, 13 дугаар зүйлийн 13.4.5;

²³⁹ Тагнуулын байгууллагын тухай хууль, 1999 он, 12 дугаар зүйлийн 12.1.11

солилцох эрхийг²⁴⁰ Авлигатай тэмцэх газарт олгосон нь гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, мөнгийг угаах үйлдлийн эсрэг гадаад улсын байгууллагууд болон ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага мэдээлэл солилцох боломжийг Авлигатай тэмцэх газарт хууль зүйн хувьд бүрдүүлж байна.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ

УЕПГ, Монгол банк, Азийн хөгжлийн банк хамтарсан Монгол улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх техникийн туслалцааны төслийн хүрээнд **“Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх нь”** сэдэвт сургалтыг 2014 оны 04-р сарын 9,11-ны өдрүүдэд УЕПГ-ын дэргэдэх “Сургалт судалгааны төв”-ийн байранд зохион байгуулан явуулсан байна²⁴¹. Энэ талаар энэхүү илтгэлийн холбогдох хэсэгт тодорхой авч үзэж, зохих зөвлөмжүүд тусгагдсан болно.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Ерөнхий дүгнэлт

Ил тод байдал бол авлигаас урьдчилан сэргийлэх гол хүчин зүйл мөн. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Нийтийн албанд нийтийн ба хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тухай хууль батлагдаж бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар авлигаас урьдчилан сэргийлэх хувьсгалын шинжтэй өөрчлөлт болсон гэж үзэж байна. Уг хуулиудын хэрэгжилт ахицтай байна. Төрийн болон хувийн хэвшилд сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн таатай орчин бүрдэж байна. Одоо нийтийн албанаас гадна хувийн хэвшилд ил тод байдлыг хөхиүлэн дэмжих, сонирхлын зөрчлөөс урьдчилан бодитой хийгдэхээр хүлээгдэж байна. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн асуудлыг төрийн болоод төрийн бус байгууллага, хувийн хэвшил олон нийтийн анхаарлын төвд оруулж, 2015 онд уг Конвенцийн хэрэгжилтийн тайлан өгөх хүртэл эрх зүйн болоод хуулийн хэрэгжилтийн хүрээнд анхаарвал зохих асуудалд энэхүү үнэлгээний тайлан чиглэгдлээ. Ерөнхийд нь дүгнэвэл сүүлийн хэдэн жилийн турш авлигаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгож эрх зүйн орчны хувьд авлигын шаардлагыг хангах чиглэлд төр засгийн зүгээс дорвитой алхамууд хийгдсэн гэж үзэж байна. Харин эдгээр хуулиудын хэрэгжилтийг хангах талаар бүх оролцогч талуудын анхаарлыг хандуулж, үйл ажиллагааны уялдаа холбоо бүхий төрийн байгууллагуудын үндэсний, бүс нутгийн, олон улсын хэмжээний хамтын ажиллагааг идэвхитэй өрнүүлэх нь зүйтэй байна. Мэдээллийн технологийн өндөр хөгжлийн орчин үед цахим хуудсаараа үйл ажиллагаагаа ил тод болгож, олон нийтэд 24 цагийн турш тайлагнах бодит орчин бүрдсэн байна. Энэхүү таатай орчин нь төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагууд ашиглан авлигаас урьдчилан сэргийлэх, зохистой засаглалыг хөгжүүлэх гол хэрэгслээ болгож дадах нь чухал байна.

²⁴⁰ Авлигын эсрэг хууль, 2006 он, 18 дугаар зүйлийн 18.4.17;

²⁴¹ Улсын Ерөнхий Прокурорын Газрын цахим хуудас <http://prokuror.mn/?p=7924>

Манай багийн туршлагаас үзвэл иймэрхүү нийгмийн бүх хүрээг хамарсан үнэлгээ, судалгааны ажлыг хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлэх нь үнэлгээг бодитой болгох ач холбогдолтой. Цаашид үнэлгээ хийх хөндлөнгийн этгээдийг эцсийн тайлан хүлээж авахаас зургаан сараас нэг жилийн өмнө сонгон шалгаруулж, мэдээлэл цуглуулах, ажиглалт хийх, шаардлагатай тохиолдолд сэдэвчилсэн судалгаанууд хийх, цугларсан материал дээр бүх талын анализ хийх цаг хугацааны боломжийг олгох нь үнэлгээний чанарт зайлшгүй сайнаар нөлөөлнө гэж үзэж байна.

Энэхүү үнэлгээг явуулах зарчим, аргачлалын талаар удирдлага хэсэгт тусгасан болно. Үнэлгээний тайлангийн энэхүү хэсэгт ерөнхий дүгнэлт, цаашид анхаарвал зохих асуудлаас гадна Конвенцийн зүйл тус бүрийн агуулгыг бүрэн хэмжээгээр оруулж тухайн зүйлийн хувьд эрх зүйн болон практик хэрэгжилтийн талаар өгсөн гол дүгнэлт тухайн анализ, дүгнэлтээс гарах зөвлөмжүүдийг дор сийрүүлэв.

Конвенцийн 5 дугаар зүйл Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа

- 5.1. Оролцогч улс бүр нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжсэн, хууль дээдлэх ёс, нийтийн хэрэг болон нийтийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, үнэнч шудрага, ил тод байх, хариуцан тайлагнах зарчмыг тусгасан авлигын эсрэг үр дүнтэй, уялдаа холбоо бүхий бодлогыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.**
- 5.2. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй практик үйл ажиллагааг тогтоож, хөхиүлэн дэмжихийг чармайна.**
- 5.3. Оролцогч улс бүр холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээгээ авлигаас урьдчилан сэргийлж, түүнтэй тэмцэхэд хангалттай байгаа эсэхийг нь тодорхойлох зорилгоор тогтмол үнэлж дүгнэж байхыг чармайна.**
- 5.4. Оролцогч улсууд энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өөр хоорондоо болон холбогдох олон улсын ба бүс нутгийн байгууллагатай эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн аль тохирох байдлаар хамтран ажиллана. Ийм хамтын ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, төсөлд оролцох ажил багтаж болно.**

Монгол Улс нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжсэн, хууль дээдлэх ёс, нийтийн хэрэг болон нийтийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, үнэнч шудрага, ил тод байх, хариуцан тайлагнах зарчмыг тусгасан авлигын эсрэг бодлого явуулах хүсэл зоригоо Үндсэн хууль, бусад хууль, төрийн эрх барих дээд байгууллагаас батлан гаргасан удаа дараагийн баримт бичгээрээ нотолсон гэж үзэж байна.

Холбогдох төрийн байгууллага Авлигатай тэмцэх хөтөлбөрт тодорхой түвшинд үнэлгээ хийж, санал зөвлөмж нь хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-д зааснаар салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын

талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэн үйл ажиллагааны ил тод байдлаа хангах төрийн байгууллагын хууиар тогтоосон шаардлага хангагдахгүй байна.

Конвенцийн 5 дугаар зүйлийн 1-д заасан нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжсэн, хууль дээдлэх ёс, нийтийн хэрэг болон нийтийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, үнэнч шудрага, ил тод байх, хариуцан тайлагнах зарчмыг тусгасан авлигын эсрэг бодлого нь тодорхой цаг хугацаагаар тодорхойлогдсон зорилт, үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлсон богино болон дунд, урт хугацааны хөтөлбөрийн баримт бичгээр тодорхойлогдох нь төрийн үйл ажиллагаанд түгээмэл байна. Гэтэл 2010 онд хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш өнөөдрийн байдлаар шинээр хөтөлбөр батлагдаагүй байна.

- Авилгалтай тэмцэх үндэсний хэмжээний үйл ажиллагааг эрчимтэй явуулах үүднээс Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тасралтгүй байдлыг хангах
- “Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөрийг нэн даруй өргөн барьж, Улсын Их хурлаар батлуулах
- Хөтөлбөрөөр дэвшүүлэх зорилт, зорилгыг оновчтой тодорхойлж, тухайн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүнг үнэлэх үзүүлэлтийг нарийвчлан тусгах
- Монгол төрийн 2002 оноос хойшхи авлигатай тэмцэх бодлого, зорилт, хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж, 2002-2010 онд хэрэгжүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн тайланг АТГ, Засгийн газрын ХЭГ-ыг цахим хуудсанд байршуулан олон нийтийн мэдээллийг сайжруулах
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-д заасны шаадлагын дагуу бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг байнга шинэчилж, олон нийтэд нээлттэй болгож байх

Монгол Улсын холбогдох хуулиар авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй практик үйл ажиллагааг тогтоож, хөхиүлэн дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Орон нутагт чиглэсэн орон нутгийн байгууллагуулын оролцоог хангасан, идэвх санаачлага дээр тулгуурласан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын илүү их үр дүнтэй, далаацтай хэлбэр, төрөл үгүйлэгдэж байна.

- Авлигын шалтгаан нөхцлийг арилгахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээний ажил, арга хэмжээг тодорхой судалгаан дээр тулгуурласан байх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан урьдчилан сэргийлэх ажлын тодорхой төрлүүдийг сонгож, тодорхой зорилготой байх.
- Орон нутагт дээрх ажил илүү өргөн цар хүрээтэй явагдах тогтолцоог бүрдүүлэх

Авлигын Эсрэг Үндэсний Хөтөлбөрийн Хэрэгжилтэд Хийсэн Судалгааны үр дүнгийн талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 1.1-ийн Практик шаардлагад дурьдсан болно. /22-р хуудсыг харна уу/

Монгол Улс хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж нь авлигаас урьдчилан сэргийлж, түүнтэй тэмцэхэд хангалттай байгаа эсэхийг нь байнга

үнэлж дүгнэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах буюу шаардлагатай хуулийг шинээр баталж, эрх зүйн орчныг сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авч байна.

- Хууль тогтоомжийн боловсронгуй болгохдоо хүчин төгөлдөр хуулиудын уялдааг хангах, нэр томъёог нэгтгэх арга хэмжээг хамтад нь авах нь зүйтэй
- Авлигын эсрэг шинээр батлагдсан хуулиудын заалт бүрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг тайлагнуулж авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажил хэрэг болгох;
- Хуульд заасан 4 чиглэлээр цахим хуудсандаа байршуулбал зохих мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж тухай бүр шинэчилж байх.

Оролцогч улсууд энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өөр хоорондоо болон холбогдох олон улсын ба бүс нутгийн байгууллагатай эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн аль тохирох байдлаар хамтран ажиллахад шаардлагатай бүрэн эрх Авлигатай тэмцэх газарт дээр дурдсан хуулиар олгогдсон нь Конвенцийн үзэл санаанд нийцэж байна.

- Хоёр хөрш, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөн хүрээнд хөгжүүлж байгаа бусад гол гол улсуудтай хэрхэн хамтран ажиллаж, шаардлагатай мэдээлэл, туршлага солилцох талаарх хоёр талын хүлээн зөвшөөрсөн, илүү тодорхой баримт бичгийн түвшинд хүртэл хөгжүүлэх.
- Олон улсын хурал, семинар, арга хэмжээнд оролцсоны дагуу ямар төсөл хөтөлбөр хамтын ажиллагааг эхлүүлсэн, хөгжүүлсэн, ямар шинэ туршлагыг Монголд нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзсэн талаар оролцогч бүр тухайн үед нь тайлан бичих буюу жилийн эцсийн тайландаа тодорхой зүйл заалт болгон тусгаж байх
- Төсөв санхүүгийн хүндрэлийн улмаас тодорхой төсөл хөтөлбөрт оролцож амждаггүй бол энэ тухайгаа тайланд тусгаж байх

Монгол Улс авлигатай тэмцэх чиглэлээр олон улсын болон бус нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох талаар зохих хүчин чармайлт гаргаж байна. Түүнчлэн Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын хөгжлийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай авлигатай тэмцэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахад зохих анхаарал тавьж байна.

- Авлигатай тэмцэх дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний чадавхийг бэхжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, хэрэгжилтийн байдлыг тайлан мэдээлэлдээ тодорхой тусгах;
- АТГ нь хөдөө орон нутагт өөрийн салбар нэгжгүй учир аймаг, орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, үр дүнгийн талаарх мэдээллээ нийтэд хүргэх, сайн туршлагыг нэвтрүүлэх.

Конвенцийн 6 дугаар зүйл

Авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага

- 6.1. Оролцогч улс бүр авлигаас дор дурдсан арга хэлбэрээр урьдчилан сэргийлэх байгууллага буюу байгууллагуудыг /аль тохирохыг/ байлгах явдлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хангана:
 - 6.1.(a). энэхүү конвенцийн 5 дугаар зүйлд дурдсан бодлогыг хэрэгжүүлэх, зохих тохиолдолд уг бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, уялдуулан зохицуулах;
 - 6.1.(b). авлигаас урьдчилан сэргийлэх талаархи мэдлэгийг нэмэгдүүлж, түгээх;
- 6.2. Оролцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага буюу байгууллагуудыг чиг үүргээ үр дүнтэйгээр, аливаа зүй бус нөлөөллөөс ангид биелүүлэхэд шаардлагатай хараат бус байдлаар эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хангана. Шаардлагатай материаллаг нөөц болон мэргэшсэн ажилтнаар хангахаас гадна тухайн ажилтныг чиг үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдаж болох бэлтгэлээр хангах нь зүйтэй.
- 6.3. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд нь бусад оролцогч улсад тусалж болох эрх бүхий байгууллага буюу байгууллагуудын нэр, хаягыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлнэ;

- Практик хэрэгжилт хэсэгт зарим хууль сахиулах байгууллагуудын тайланг судлах явцад тайлангуудад авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой тусгагдаагүй байна. Энэ тухай уг чиглэлээр хийсэн ажлын хэрэгжилтийг үнэлэх боломжгүйд хүргэж байна.
- Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг цахим хуудсандаа байршуулах эсвэл байгууллагуудын жилийн эцсийн тайланд нэг зүйл болгон оруулж хэвшүүлэхийг зөвлөж байна.
- Урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйлчилгээнд буюу хаалга, мэдээллийн самбар, веб сайтад энэ талаар тогтмол мэдээлэх цонхтой болгох, иргэдэд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг таниулан улмаар авлига өгөхгүйгээр төрийн байгууллагуудаар үйлчлүүлэх боломжтойг ухуулан таниулах.
- Иргэдэд хамгийн их бухимдуулж, хүндрэл, чирэгдэл учруулдаг салбаруудруу чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг илүү цэгцтэй бодлогын хүрээнд явуулах, үйл ажиллагаа төсөв төлөвлөгөөг нь илүү иргэдэд ил тод болгох.
- Хүүхэд залуусыг бага наснаас нь төлөвшүүлж, ёс зүйн боловсрол олгож, авлигыг үл тэвчих, шударга ёсыг эрхэмлэх үзэлтэй болгох зорилгоор 12 жилийн сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгах.

Авлигатай тэмцэх газар хуульд заасан чиг үүргээ орон нутагт хэрэгжүүлэхдээ цаг үеийн шинжтэйгээр буюу тодорхой хугацаанд орон нутагт ажиллах хэлбэрээр хэрэгжүүлж байгаа нь Конвенцийн “чиг үүргээ үр дүнтэйгээр” биелүүлэх гэсэн агуулгад төдийлөн нийцэхгүй байна. Нөгөө талаар, орон нутагт ажиллах дээр дурьдсан үйл ажиллагааны хэлбэр нь ихээхэн цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулахад хүргэж байна.

- Авлигатай тэмцэх газрын ажилтныг бэлтгэх, тэдгээрийг мэргэшүүлэх, давтан сургалтанд хамруулах нэгдсэн системтэй холбоотой зохицуулалтыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.
 - Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрхийг орон нутагт хэрэгжүүлэх бүтэц /ажилтан/-ийн асуудлыг нарийвчлан судлаж зохих түвшинд шийдвэрлэх
 - Байгууллагуудын тайланд ЭБАТ-ын тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлыг оруулах, авлигатай тэмцэх чиглэлээр хийсэн ажлыг дэлгэрэнгүй нотлох баримтын хамт оруулж байвал дараа дараагийн судалгаа хийхэд хялбар болох боломжтой байна;
 - Авлигатай тэмцэх газрын хүний нөөцийн ур чадварыг тодорхойлох боломжтой болох;
 - Авлигатай тэмцэх газар өөрөө сонирхолын зөрчлийн мэдэгдэл, нөлөөлийн мэдүүлэг гаргадаг эсэх талаарх мэдээлэлээ ил болгох.
- Авлигаас урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд бусад оролцогч улсад тусалж туслалцаа үзүүлэх байгууллагыг тодорхойлох гэсэн Конвенцийн 6.3 дах заалт хэрэгжсэн гэж үзэхээр байна.

Конвенцийн 7 дугаар зүйл

Нийтийн алба

- 7.1. Оролцогч улс бүр нийтийн албан тушаал, зохих тохиолдолд түүнчлэн сонгогддоггүй нийтийн бусад албан тушаалтныг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх талаар дор дурдсан тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэхийг зохих тохиолдолд, эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн чармайна:**
- 7.1.(a).** үр ашигтай, ил тод байх болон мэдлэг чадвар, эрх тэгш байдал, авъяас зэрэг бодит шалгуурын зарчимд үндэслэсэн;
- 7.1.(b).** ялангуяа авлигад өртөмтгий гэж тооцогдох нийтийн албан тушаалд хувь хүнийг сонгон авах, сургах, мөн зохих тохиолдолд тэдгээр хувь хүнийг өөр албан тушаалд шилжүүлж байх талаар хангалттай журмыг багтаасан;
- 7.1.(c).** оролцогч улсын эдийн засгийн хөгжлийн түвшинг харгалзан хангалттай урамшуулал, тэгш шударга цалингийн түвшинг дэмжсэн;
- 7.1.(d).** тэднийг нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх шаардлагыг хангахуйц боловсролын болон сургалтын хөтөлбөрийг хөхиүлэн дэмжсэн, түүнчлэн чиг үүргээ биелүүлэхэд нь гарч болзошгүй авлигын эрсдлийн талаархи мэдлэгийг нь дээшлүүлэх мэргэшсэн бөгөөд зохих тусгай сургалтаар хангасан. Ийм хөтөлбөр нь холбогдох салбарт мөрддөг ёс зүйн дүрэм, стандартаас иш татсан байж болно.

- 7.2. Оролцогч улс бүр нийтийн албан тушаалд нэр дэвших, сонгох шалгуурыг тогтоох зорилгоор хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг мөн авч үзнэ.
- 7.3. Оролцогч улс бүр сонгогддог нийтийн албан тушаалд нэр дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг мөн авч үзнэ.
- 7.4. Оролцогч улс бүр ил тод байдлыг хөхиүлэн дэмжих болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэхийг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн чармайна.

- Төрийн албаны тухай хуулийн энэ заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай. Хуульч сонгон шалгаруулах тухай хууль нь 2012 оны 3-р сарын 7-ны өдөр хүчингүй болсонд тооцогдсон. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс дагаж мөрдөнө. Иймд энэхүү заалтыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19.6-д заасан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үндсэн дээр хуульч нь өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллана.” гэсэн заалтыг дагаж мөрдөнө гэж ойлгож байна.

Конвенцид заасан “үр ашигтай” гэсэн зарчим нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд тусгагдаагүй, төрийн алба тогтвортой байх, төрийн албан хаагч албан тушаал дэвших карьерийн бодлогын талаар тодорхой зохицуулалтгүй байна.

- Албан тушаалтныг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх “үр ашигтай” тогтолцоог бий болгох чиглэлээр Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.
- Төрийн албаны тухай хуулийн 17.9-д Хуульч сонгон шалгаруулах тухай хууль нь хүчингүй болсон тул энэхүү алдааг залруулах нь зүйтэй.

Төрийн захиргааны байгууллагууд сул ажлын байр гармагц ажлын байрны захиалгаа Төрийн албаны зөвлөлд хүргүүлдэг тул Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар ажлын байрны зар гардаг байна. Иймд иргэн бүр энэхүү зартай танилцахтай боломжтой байгаа нь ил тод байдлыг хангаж байна гэж үзэж байна.

- Шинэ дарга томилогдоход “өөрийн” хүнээ албан тушаалд томилдог байдлыг цэгцлэх шаардлагатай. Төрийн албан хаагчид шахалт үзүүлэн өөрөөр нь ажлаас чөлөөлөгдөх өргөдөл бичүүлэх явдал нилээн түгээмэл байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн “тогтвортой байх” зарчмыг зөрчиж байна. Иймд Төрийн албан хаагчийн карьерийн бодлогыг тодорхойлж хуульчлан батлах нь зүйтэй.

Конвенцийн “авлигад өртөмтгий гэж тооцогдох нийтийн албан тушаал” гэдэгт ямар ажил, албан тушаал хамааруулах талаарх ойлголтыг тодорхойлоогүй,

авлигад өртөмтгий албан тушаалд сонгон авахад тавигдах шаардлага, мөн тэрхүү ажилтныг сургах, сэлгэн ажиллуулах чиглэлээр зохицуулсан нарийвчилсан хуулийн зохицуулалт болон журам байдаггүй байна.

- Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- Төрийн албаны тухай хуулийн 22.2 болон Гаалийн тухай хуулийн 274.3 заалтууд дах төрийн албан хаагчийг 2 жил хүртэлх хугацаагаар сэлгэн ажиллуулж болно, гаалийн байцаагчийг 2 жил хүртэлх хугацаагаар сэлгэн ажиллуулж болно гэсэн хоёр заалт нь давхцаж байна. Гаалийн байцаагч нь төрийн албан хаагч мөн тул Төрийн албаны тухай хуулиараа зохицуулагдана гэж үзэж байна. Иймд дээрх хоёр хуулийн давхардлыг арилгах
- Мөн авлигад хамгийн их өртөх эрсдэлтэй байгууллагууд салбарынхаа хуулинд яг ямар албан тушаал дээр ажиллаж байгаа албан хаагчдаа хэдэн жил тутамд сэлгэн ажиллуулах талаар нарийвчлан оруулж өгөх нь зүйтэй.
- Судалгаагаар газрын алба хамгийн авлигад өртөмтгий салбар гэж тооцогддог. Тэдэнд чиглэсэн эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй байна.
- Дээрх хүснэгтэд дурдсан зургаан төрийн байгууллагыг хамгийн их авлигад өртөх эрсдэлтэй гэж үздэг. Иймд энэхүү байгууллагууд албан хаагчдаа тогтмол хугацаанд сэлгэн ажиллуулснаар авлигаас урьдчилан сэргийлж чадна гэж үзэж байгаа учир сэлгэн ажиллуулах журам баталсан бол тэрхүү журмаа идэвхитэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй байна.
- Төрийн байгууллагууд өөрийн байгууллагад авлигад өртөх эрсдэлтэй ажлын байрны жагсаалт батлан, тэрхүү албан тушаалд хувь хүн шалгаруулж авах тусгайлсан журам батлах, тухайн хүний ажилд авсны дараа эсхүл ажилд сонгон шалгаруулсны дараа тусгайлсан сургалтанд хамруулдаг байх.
- Авлигатай тэмцэх газрын хувьд авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалтнуудыг ажилд орох үед хамрагдах сургалтын хөтөлбөр бэлдэж, зохион байгуулах
- Төрийн албан хаагчийн урамшуулал, цалингийн талаар олон хуульд янз бүрээр томъёолж оруулсан нь давхардал үүсгэж байна. Төрийн албаны хуульд үндсэн зохицуулалтаа тусгаж, бусад хуульд зөвхөн онцлогтой нь уялдсан урамшуулал, цалинтай холбоотой зохицуулалтыг тусгах

2013 онд Шүүгчдийн цалинг нэмсэн явдлыг маш оновчтой шийдвэр болсон гэж үзэж байна. Үндсэн хуульд шүүгчийг хараат бус байж, гагцхүү хуулинд захирагдана гэж заасан байдаг. Үндсэн хуулийн дагуу шүүгч нь хараат бус байхын тулд хангалттай эдийн засгийн баталгаагаар хангагдах ёстой тул тэдний цалинг нэмсэн явдлыг Конвенцид нийцэж байна гэж үзэж байна. Төрийн албан хаагчийн цалингийн өнөөгийн түвшин, тэдний амьжиргаанд хүрэлцэхээргүй байна гэж үзэж байна. Цалин бага байгаа учир төрийн байгууллагын албан тушаалтан авлигад өртөх магадлал маш өндөр юм. Иймд Конвенцийн шаардлагад нийцэхгүй байна гэж үзэж байна.

- Төрийн албан хаагчийг авлигаас урьдчилан сэргийлэх нэг гол хэрэгсэлт нь тэдгээрийн цалин хөлс болох зарчмыг нийт төрийн албан хаагчдын хүрээнд бүрэн хэрэгжүүлэх

Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсролын хуульд авлигыг үл тэвчих хүмүүжил олгох агуулга тодорхой тусгагдаагүй байна.

Монгол Улсын хууль тогтоомжид Конвенцийн төрийн албан хаагчаас нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх шаардлагыг хангахуйц боловсролын болон сургалтын хөтөлбөрийг хөхиүлэн дэмжсэн зохицуулалт байдаггүй байна. Авлигын эсрэг хуулиар Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудад авлигатай тэмцэх, хөрөнгө орлогын мэдүүлгээ хэрхэн мэдүүлэх талаар сургалт явуулах үүргийг өгсөн нь Конвенцийн чиг үүргээ биелүүлэхэд нь гарч болзошгүй авлигын эрсдлийн талаархи мэдлэгийг нь дээшлүүлэх мэргэшсэн бөгөөд зохих тусгай сургалтаар хангасан байх шаардлагад нийцэж байна гэж үзэж байна. Авлигатай тэмцэх газрын сургалт явуулдаг ажилтнууд нь авлигын чиглэлээр мэргэшсэн байдаг тул мэргэжлийн түвшинд төрийн албан хаагчид сургалт явуулдаг гэж үзэж байна.

- Төрийн албаны тухай хуулинд төрийн албанд анх орж байгаа иргэдийг сургалтанд хамруулдаг байх, уг сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх, гарч болзошгүй авлигын эрсдлийн талаарх зохих агуулгыг тусгасан байх шаардлагатай.

Авлигатай тэмцэх газраас ажилчдаа мэргэшүүлэх олон төрлийн сургалтанд идэвхтэй хамруулдаг, мөн түүнчлэн бусад төрийн албан хаагчийг авилгаас ангид байх сургалт явуулдаг боловч системтэй, тодорхой хөтөлбөр бүхий сургалт үгүйлэгдэж байна.

- Харин төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институт нь удирдлагын чиглэлийн сургалт голчлон заадаг бөгөөд нийтийн албан хаагчийг давтан сургах гол чиг үүрэгтэй Удирдлагын академийн ёс зүйн хичээлийн агуулгад авлигаас урьдчилан сэргийлэх, гарч болзошгүй авлигын эрсдэлийн талаарх зохих агуулгыг оруулах
- Төрийн албаны институт, Удирдлагын академтэй Авлигатай тэмцэх газрын зүгээс хамтран ажиллан, сургалтын агуулыг Конвенцийн заалтад нийцүүлэх арга хэмжээ авах
- Авлигатай холбоотой байж болох, эсхүл ёс зүйн шаардлага зөрчсөн ажилтныг ёс зүйн сургалтанд албан ёсоор суулгах арга хэмжээ авч болохыг судалж шийдвэрлэх /Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29.7/
- Авлигаас ангид байх ёс зүйг төлөвшүүлэх сургалтыг системтэй, тодорхой хөтөлбөрийн дагуу явуулах
- Төрийн албаны тухай хуулийн 26.2-д “Энэ зүйлийн 26.1-д заасан сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй” гэсэн заалт нь Гаалийн тухай хуулийн 284.2-д “284.2.Энэ хуулийн

284.1-д заасан сахилгын шийтгэлийг гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан ногдуулах бөгөөд сахилгын шийтгэлийг дэс дараалан хэрэглэх шаардлагагүй.” гэсэн хоёр хуулийн заалт нь хуулийн давхардал үүссэн байна. Гаалийн байгууллага нь төрийн албанд хамаарах тул Гаалийн тухай хуулийн энэхүү заалтыг хасан Төрийн албаны тухай хуулиас иш хийх;

- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29.7-той төсөөтэй байдлаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулан “ёс зүйн сургалтад албадан суулгах” шийтгэлийн төрлийг нэвтрүүлэх.
- Тайлангаа цахим хуудсандаа тавьж хэвших
- Гурван сонгуулийн хуулиуд нь заалтууд нь хоорондоо давхцаж байгаа бөгөөд үүнийг нэгдсэн байдлаар нэг хууль болгон шинэчлэн найруулж тусгай, онцлог зохицуулалтуудыг нь дотор нь ялгаж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.
- Эсхүл нэг хуулиасаа ишлэл хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Сонгуульд оролцсон намууд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулиар заасан сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх зохицуулалтаа хэрэгжүүлдэг гэж үзэж байна. Ийнхүү хүргүүлсэн тайланг Сонгуулийн ерөнхий хороо цахим хуудсаараа нийтэд мэдээлдэг нь Конвенцийн сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангаж байна гэж үзэж байна.

- Аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороод, нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан нийтэд ил тод болгох шаардлагатай
- Судалгааны дүнгээр сонгуулийн хандивыг авлигын нэг хэлбэр болгодог гэж үзэж буй талаар судалгаа хийх
- Төрийн албан хаагч “off shore” бүсэд, гадаадад нээсэн дансаа мэдүүлдэг байх талаар хуульд нэмэлт оруулах
- Авлигын эсрэг эрх зүйн шинэ орчинд нийцүүлэн “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага: MNS 6285:2011”-ыг нэн даруй шинэчлэхийг зөвлөж байна. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын зүгээс төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжүүлэх болон асуудал хариуцсан ажилтнуудыг чиглүүлэх, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг төлөвлөгөөндөө тусган эрчимтэй зохион байгуулах нь зүйтэй байна.

Конвенцийн 8 дугаар зүйл Нийтийн албан тушаалтны ёс зүйн дүрэм

- 8.1. Авлигатай тэмцэхийн тулд оролцогч улс бүр нийтийн албан тушаалтныхаа дунд шударга, үнэнч, хариуцлагатай байх явдлыг бусад зарчмын хамт эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хөхиүлэн дэмжинэ.**
- 8.2. Ялангуяа, оролцогч улс бүр нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх ёс зүйн дүрэм буюу стандартыг өөрийн**

институцийн болон эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд хэрэглэхийг чармайна.

- 8.3. Энэ зүйлийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор оролцогч улс бүр Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 51/59 дугаар тогтоолын хавсралтад орсон Нийтийн албан тушаалтны ёс зүйн олон улсын дүрэм зэрэг бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагын холбогдох санаачлагыг зохих тохиолдолд, эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн анхааралдаа авна.
- 8.4. Оролцогч улс бүр нийтийн албан тушаалтан нь чиг үүргээ биелүүлэх явцад өөрт нь мэдэгдсэн авлигын үйлдлийн талаар эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог тогтоох асуудлыг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ.
- 8.5. Оролцогч улс бүр зохих тохиолдолд болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн, нийтийн албан тушаалтан нь чиг үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлого зэргийнхээ талаарх зохих эрх бүхий байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог тогтоохыг чармайна.
- 8.6. Оролцогч улс бүр энэ зүйлийн дагуу тогтоосон ёс зүйн дүрэм буюу стандартыг зөрчсөн нийтийн албан тушаалтанд сахилгын буюу бусад арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг авч үзнэ.

- Төрийн өндөр албан тушаалтны бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэсэн заалттай уялдуулан нарийвчлан судлах.

"Төрийн Улс төрийн албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, стандартыг хууль тогтоомжоор тогтоох тухай" Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг бүрэн хэрэгжихгүй байна.

Төрийн тусгай албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, стандартыг хууль тогтоомжоор тогтоох тухай Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг бүрэн хэрэгжихгүй байна.

- Төрийн улстөрийн болон тусгай албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нэн даруй тогтоож, дүрмийг батлах.
- Ёс зүйн дүрмийг ил тод болгох
- Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаар зөрчлийн асуудлаас гадна тодорхой мэдээллийг тайланд тусгаж байх

ОУ-ын ёс зүйн дүрэмд тусгагдсан зарим ач холбогдол бүхий зохицуулалтууд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэмд тусгагдаагүй байна.

- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг Нийтийн албаны ёс зүйн тухай Олон Улсын стандарт дүрмийн шаарлагатай зүйл, заалт, улмаар Авлигын хуулийн дүгээр зүйлийн агуулгад нийцүүлэх.

Авлигын талаар болон ёс зүйн хэм хэмжээ, стандарт зөрчсөн нийтийн албан хаагчийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог эрх зүйн баримт бичгийн түвшинд оновчтой тодорхой зохицуулаагүй гэж үзэхээр байна.

Олон нийтэд нээлттэй байгаа мэдээллийн хүрээнд авлигын үйлдлийн талаар эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог тогтоох тухай Конвенцийн заалт практик хэрэгжилтийн түвшинд хангалтгүй гэж дүгнэхээр байна.

- Авлигын үйлдлийн талаар мэдээлэх журмыг хөнгөвчлөх, хялбаршуулах тогтолцоог бүрдүүлэх, түүнийхээ тухай олон нийтэд нээлттэйгээр мэдээлж байх нэгдсэн зөвлөмж, журам гаргаж мөрдүүлэх асуудлыг Авлигатай тэмцэх газрын түвшинд шийдвэрлэх

УИХ-ын гишүүний давхар эрхэлж болох ажлыг УИХ-ын тухай хуулиар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулиар Үнлсэн хуульд зааснаас өргөн хүрээнд хуульчилсан байх бөгөөд эдгээр хуулиудын зохицуулалт ч өөр хоорондоо зөрчилтэй байна.

Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой зөрчлийн 82 хувийг Авлигтай тэмцэх газрын тодорхой түвшний хяналт шалгалтаар илрүүлсэн нь тус байгууллагаас хуульд заасан нэг гол чиг үүргээ зохих түвшинд хэрэгжүүлж байгааг илэрхийлж байна.

1996 оны Авилгалтай тэмцэх тухай хуулиар албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, олон нийтэд мэдээлэх тогтсон систем бүрдээгүй байсан.

Нийтийн албан тушаалтан нь чиг үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлого зэргийнхээ талаарх зохих эрх бүхий байгууллагад мэдүүлж байх Конвенцийн шаардлага, нийтийн албан тушаалтан Хөрөнгө, орлогын мэдүүлгээ Авилгалтай тэмцэх газар мэдээлж байх Авилгын эсрэг хуульд Нийтийн албан хаагчид мэдүүлгээ гаргаж хэвшиж байгааг тусгасан байна.

- Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх, түүнчлэн санаатай болон болгоомжгүйгээр худал мэдээлэх үйлдлийг бууруулах чиглэлээр зөвхөн хариуцлага тооцохоос гадна нөлөөллийн тодорхой ажил зохион байгуулах.

Дээрх хүснэгт бүхий судалгаанаас үзэхэд 2013 онд Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос нийт 118 албан тушаалтны ёс зүйн зөрчилд

хариуцлага ногдуулсан байх бөгөөд үүнээс 89 нь анх удаа, 29 давтан ёс зүйн зөрчил гаргасан байна. Энэ нь албан тушаалтанаас ёс зүйн зөрчлийг давтан үйлдсэн хувь маш өндөр гэж үзхээр байна.

- Нийтийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагын үр нөлөөтэй хэлбэрийг сонгоход ач холбогдол бүхий нарийвчилсаг судалгаа хийх, зөрчил нь ёс зүйн зөрчил гэдэг утгаар ёс зүйн зөрчил гаргасан нийтийн албан хаагчийг хамт олны өмнө буруу шаах, олон нийтэд мэдээлэх зэрэг тухайн хүний нэр хүндэд халдсан арга төрөл бүрийн арга хэмжээг түлхүү хэрэглэх нь зүйтэй байна.
- Ёс зүйн хороодын үйл ажиллагааг идэвхижүүлэх, сургалт зөвлөгөөг сайтар өгөхөд анхаарч ёс зүйн хэсэгчилсэн сургалтуудыг Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институтээрээ дамжуулан зохион байгуулах талаар энэ онд онцгойлон анхаарах

Конвенцийн 9 дүгээр зүйл
Нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан
авах, нийтийн санхүүг удирдах

- 9.1. Оролцогч улс бүр ил тод байх, өрсөлдөөний зарчим, шийдвэр гаргах бодит шалгуурт үндэслэсэн бөгөөд авлигаас урьдчилан сэргийлэх зэрэгт үр дүнтэй үйлчлэхүйц нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зохих тогтолцоог тогтоох талаар шаардлагатай арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна. Ийм тогтолцоог хэрэглэхэд босго үзүүлэлтийг харгалзаж болох бөгөөд уг тогтолцоонд тухайлбал дараах зүйл хамаарна:
- 9.1.(a). тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж, ирүүлэхэд хангалттай хугацаа олгох зорилгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам болон гэрээнд хамаарах мэдээллийг, түүний дотор тендерийн урилга болон гэрээ байгуулах эрх олгох талаарх холбогдох буюу тохирох мэдээллийг олон нийтэд тараах;
- 9.1.(b). тендерт оролцох нөхцөл, түүний дотор сонгон шалгаруулах ба эрх олгох шалгуур, тендер шалгаруулалтын дүрмийг урьдчилан тогтоож, тэдгээрийг нийтлэх;
- 9.1.(c). дүрэм буюу журмыг зөв хэрэглэсэн эсэхийг дараа нь нягтлан шалгахыг хөнгөвчлөн дэмжих зорилгоор, нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэрийг гаргахад бодит бөгөөд урьдчилан тогтоосон шалгуурыг хэрэглэх;
- 9.1.(d). энэ хэсэгт заасны дагуу тогтоосон дүрэм буюу журмыг мөрдөөгүй тохиолдолд хуулиар хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх дотоодын хяналтын үр дүнтэй тогтолцоо, түүний дотор давж заалдах үр дүнтэй тогтолцоо;
- 9.1.(e). бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтантай холбогдох асуудлыг зохицуулах арга хэмжээ, тухайлбал нийтийн өмчийн хөрөнгөөр тодорхой бараа, ажил, үйлчилгээ

- худалдан ажиллагаанд ямарваа ашиг сонирхол байгаа эсэхээ мэдүүлэх, үзлэг шалгалтын журам, бэлтгэл сургалтын шаардлага;
- 9.2. Оролцогч улс бүр нийтийн санхүүгийн удирдлагад ил тод байх, хариуцан тайлагнах явдлыг хөхиүлэн дэмжих талаар зохих арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна. Ийм арга хэмжээ нь дараах зүйлийг бусад зүйлийн хамт хамаарна:
- 9.2.(a). үндэсний төсөв батлах ажиллагаа;
- 9.2.(b). орлого, зарлагыг цаг тухайд нь тайлагнах;
- 9.2.(c). нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоо;
- 9.2.(d). эрсдлийн удирдлага, дотоодын хяналтын үр дүнтэй бөгөөд үр ашигтай тогтолцоо;
- 9.2.(e). зохих тохиолдолд, энэ хэсэгт тогтоосон шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд засаж залруулах арга хэмжээ;
- 9.3. Оролцогч улс бүр улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байж болох иргэний эрх зүйн болон захиргааны арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна;

Конвенцийн тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж, ирүүлэхэд хангалттай хугацаа олгох зорилгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам болон гэрээнд хамаарах мэдээллийг, түүний дотор тендерийн урилга болон гэрээ байгуулах эрх олгох талаарх холбогдох буюу тохирох мэдээллийг олон нийтэд тараах чиглэлээр Монгол Улсад эрх зүйн орчин бүрдсэн байна гэж үзэж байна.

- Авлигатай тэмцэх газрын зүгээс Худалдан авах ажиллагаа түүний дотор орон нутгийн худалдан авах ажиллагаа буюу тендерийн талаар зохих арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Учир нь дээрх судалгаанаас үзвэл орон нутгийн худалдан авалт, тендер нь Авлигад хамгийн их өртсөн салбарын жагсаалтын гуравдугаарт 2012, 2013 онд тогтвортой нэрлэгдсэн байна.
- Олон нийтийн зүгээс тендер хэлбэрийн төдий ил тод явагддаг. Цаагуураа тендерийн ялагч урьдаас тодорхой байдаг гэсэн шүүмжлэл байсаар байна.
- Хуулийн хэрэгжилтийг хангах төрийн бусад худалдан авах ажиллагааны талаар үйл ажиллагааны тайландаа тодорхой тусгаж, цахим хуудсандаа хуулийн хугацаанд тавьж хэвшүүлэх

Конвенцийн нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэрийг гаргахад бодит бөгөөд урьдчилан тогтоосон шалгуурыг хэрэглэх гэсэн заалтийн шаардлагыг хууль тогтоомжоороо хангаж байна гэж үзэж байна.

Худалдан авах ажиллагааг хангалттай хуульчилж өгсөн ч худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, эрх олгох процесс зарим тохиолдолд шударга бус болдог байна.

- Тендер шалгаруулалтын үр дүн үйл явцыг хуулиар хатуу зааж хариуцлагыг чангаруулах

- Тендерт оролцогчдод сургалт зохион байгуулах
- Үнэлгээний хорооны гишүүдэд тавигдах шаарлага хариуцлагыг чангатгах
- Тендер шалгаруулалттай холбоотой гарч байгаа маргаан, зөрчилтэй холбоотойгоор хуулийн холбогдох заалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал асуулга явуулах
- Тендерийн талаарх маргааныг богино хугацаанд шийдвэрлэх чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох
- Худалдан авах ажиллагааны нөхцөл байдлын талаар олон нийт, нийтийн албан тушаалтны гэсэн 2 ангилалаар судалгаа хийж харьцуулан дүгнэж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Зураг төсөл нь батлагдаагүй барилгыг төсөвт тусган батална гэдэг нь УИХ мөн хууль зөрчсөн гэж үнэлэгдэхээр байна. Мэдээж хэрэг, УИХ-аас байгуулагдсан ҮАГ нь ийм дүгнэлт хийх нь зохимжгүй. Олон жил он дамжиж төсвийг “сааж” байгаа 272 барилгын 72 хувийг зураг төсөлгүйгээр эх үүсвэрийг нь төсөвт тусгах үе шат бүрт оролцсон төрийн албан хаагчид бүгдээрээ УИХ-ыг хуурсан уу? гэдгийг холбогдох төрийн байгууллагуудаас олон нийт асуух эрхтэй. Олон жил ужгирсан энэ үзэгдэл авлигаас ангид байсан уу гэдгийг авлигаас урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах бүрэн эрх олгогдсон АТГ-аас бас асуух ёстой байх. Гол нь цаашид ийм зөрчил гаргахгүй байх нэгдсэн ойлголтонд хүрч, ижил тэгш, хууль ёсны, шударга шаардлагыг оролцогч бүр өөртөө, бие биедээ тавих нь зүйтэй.

Зохих эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэдэг нь сайн хэрэг. Харин баталсан хуулиа тендерт оролцогч компанийн эрх бүхий албан тушаалтан, Үнэлгээний хорооны гишүүнээс эхлээд УИХ-ын гишүүн бүр ягштал хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Хамгийн бага үнийн шалгуурыг хуульчилсан нь яам хийгээд тендер авах эрмэлзэлтэй оролцогчдын хувьд төсөвтөө багтааж үүргээ биелүүлэх боломжгүйд хүргэдэг байх магадлалтай тул хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай;
- Үнэлгээний хороонд ажилласан хүмүүсийн дунд нэргүй асуулга явуулж, тэдэнд тулгардаг бэрхшээл, нийгмийн ямар бүлгийн зүгээс \тендерт оролцогчид, эсхүл дарга нар гм\ хөндлөнгөөс нөлөөлдөг эсэх талаарх судалж, үр дүнгээр зохих арга хэмжээ авах
- Тендерт оролцогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх системтэй арга хэмжээ авах шаардлагатай;
- Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхолын мэдүүлгийг бичгээр гаргаж хэвших, энэ тухай олон нийтэд нээлттэй тоо баримтаар мэдээлж хэвшүүлэх.
- Тендерт оролцогч компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээний хорооны гишүүнээс эхлээд УИХ-ын гишүүн бүр авлигыг үл тэвчих хандлагаар худалдан авах ажиллагаа, төсөв батлах ажиллагаанд хуулиа дээдэлж, УИХ-аас хууль ёсны шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх
- Үндэсний төсөв батлах үйл ажиллагаанд илүү олон талыг оролцуулах талаарх санаачлагыг улам өргөжүүлэх
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах техник, зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх

- Уг хуулийн олон нийтэд өргөн сурталчлах ажлыг АТГ тэргүүлэх зохион байгуулах арга хэмжээ авах
- Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлийн судалгаа, ажиглалт хийх талаар ТББ, хөндлөнгийн байгууллагууд мэргэшихэд харьцангуй урт хугацаатай гэрээ байгуулах замаар чадавхижуулах, өрсөлдөөнийг бий болгох талаар төрийн байгууллагууд анхаарах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрснээ энэ дашрамд тэмдэглэж байна.
- Тагнуулын ерөнхий газар, Цөмийн энергийн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб зэрэг байгууллагын төсвийн мэдээлэл нь төрийн нууцтай холбоотой байдаг бол Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар тогтоосон шаардлагаас чухам аль заалт нь хамааралтай болохыг судалж, шаардлагатай бол зарим заалт эдгээр байгууллагуудад хамаарахгүй байхаар уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
- Үндэсний аудитын газрын санхүүгийн тайланд аль байгууллага аудит хийх талаарх зохицуулалтыг хийдэлтэй орхих нь зөв үү гэдгийг судалж шийдвэрлэх. Шардлагатай бол Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зарим шаардлага тус байгууллагад хамаарахгүй гэдэг өөрчлөлтийг нэмж оруулах
- Монгол банкны цахим хуудас нь улс орны санхүү, эдийн засгийн байдлын талаарх баялаг мэдээлэлтэй цаг үеэ мэдэрсэн маш сайн сайт гэж үнэлэгддэг. Гэвч Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар шаардсан мэдээлэл тэнд байдаггүй. Бид 2013 оны эцсээр хийсэн үнэлгээнд ч энэ талаар дурдаж байсан. Хэрэв Төв банкны онцгой статустай холбоотойгоор мэдээлэл нь нууц байх ёстой бол уг хуульд энэ талаар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.
- Төрийн дээд байгууллагууд хуулиа мөрдөөгүй гэдэг үнэлгээг дахин дахин өгөх нь манай багийн хувьд ч тун зохимжгүй байлаа.

Шилэн дансны тухай хууль батлагдсанаар орлого, зарлагыг цаг тухайд нь ил тод болгох Конвенцийн шаарлагыг эрх зүйн орчны хувьд манай улс хангаад байна.

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах техникийн нөхцлийг байгууллага бүр бүрдүүлэх. Үүнд, Сангийн яам, Мэдээллийн технологийн газар, төв орон нутгийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, санхүүгийн болон мэдээллийн технологи хариуцсан ажилтнуудын нэгдсэн ойлголт чухал тул хуулийг сурталчлах, хэрэгжилтийн хангах эрх зүй, зохион байгуулалтын ажлыг шахуу төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай
- Энэхүү хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн оролцоог хангахад чиглэсэн гарын авлага, сурталчилгааны мэдээлэл, материал бэлтгэх, түгээхэд АТГ, СЯ, ХЗЯ, Мэдээллийн технологийн газар зэрэг байгууллага бүр өөрийн чиг үүргийн дагуу шаардлагатай арга хэмжээ авах, энэ оны 12 дугаар сард хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хэрхэн хангагдсан талаар хэлэлцүүлэг хийж, ажлын уялдааг хангах
- Хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох субъектүүд орлого, зарлагаа цаг тухайд нь ил тод болгон хуулиа хэрэгжүүлэх нь авлигаас урьдчилан сэргийлэх чухал алхам болно.

- Орлого зарлага бүр олон нийтэд ил тод болгох техник технологийн, хүний нөөцийн нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ эртнээс авах нь зүйтэй.

Конвенцийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоог Монгол Улс нь эрх зүйн тулгуур зарчмаараа дамжуулан бэхжүүлэх зохих алхамууд хийсээр байна.

“Дуусаагүй барилгын асуудал” нь Конвенцийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоог эрх зүйн хувьд бүрдүүлж байгаа боловч практик дээр төрийн аудитын байгууллагын үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоог эрх зүйн орчны хувьд бүрдүүлж, төрийн аудитын тогтолцоог бүрдүүлсэн боловч хэрэгжилт жигд биш, ил тод байдлыг хангах явдал төдийлөн хангалттай биш байна.

- Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа ТББ болон төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хийх төрийн аудитын хүртээмжийг өргөжүүлж, энэ талаарх мэдээллийг нэмэгдүүлэх
- Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ын хөндлөнгийн аудиторгоо сонгох эрхийн талаарх Компанийн тухай хууль болон Төрийн аудитын хууль, тэдгээрийн хэрэгжилтийн механизмыг судалж, зохицуулалтыг боловсронгуй болгох замаар давхардал, хийдлийг арилгах шаардлагатай
- Төрийн байгууллага бүр санхүүгийн болон үйл ажиллагааны талаарх аудитын дүгнэлтээ хуульдт заасан хугацаанд цахим хуудсандаа байршуулж хэвших
- Төрийн байгууллагуудын дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг тогтворжуулах, үр нөлөөг дээшлүүлэх, дотоод аудитын чиглэлээр хийсэн ажлыг жилийн эцсийн тайландаа тодорхой тусгадаг болгож хэвшүүлэх
- Төрийн байгууллагууд эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх, тухайн байгууллагын онцлог чиг үүрэгтэй уялдуулсан эрсдлийн удирдлагын бодлого, зайны хяналтыг хэрэгжүүлэх шалгуур, системийг боловсруулж хэрэгжүүлэх
- Тухайн төрийн байгууллагын албан хаагч авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон тохиолдолд дотоод хяналтаараа илрүүлж чадсан эсэхийг дотоод хяналтын нэгжийн ажлын гол үзүүлэлт болгон үнэлдэг байх
- Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын чиглэлээрх төрийн байгууллагуудын туршлага солилцох, дотоод хяналт хариуцсан ажилтнуудын давтан сургалтыг АТГ-ийн зүгээс Төрийн удирдлагын академитэй хамтран системтэйгээр зохион байгуулж байх
- Төсөв батлахад олон нийтийн оролцоог хэрхэн хангаж буй талаар Сангийн яам тусгайлсан тайлан гаргадаг байх;
- Орлого зарлагыг цаг тухайд нь тайлагнадаг байх Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн болон техникийн нөхцлийг хангаж Конвенцийн шаардлагыг практикт эхнээс нь сайн хангах;

- Төрийн аудитын, Аудитын, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн тухай статистик мэдээллийг ил болгох;
- Нийтийн санхүүгийн эрсдлийн удирдлагын үр дүнтэй арга, аргачлал, тогтолцоог бий болгох үе шаттай арга хэмжээ авах;
- Зайны хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр төрийн байгууллага бүр тодорхой арга хэмжээ авах.

Конвенцийн 9.3 дугаар зүйлийн шаардлагыг одоогийн хууль тогтоомжоороо хангалттай хэмжээнд хангаагүй байгаа ч батлагдахаар хэлэлцэж байгаа Зөрчлийн тухай хуулийн төсөл, Шилэн дансны тухай хууль батлагдсанаар энэ талаар Конвенцийн шаардлага хангагдана гэсэн хүлээлттэй байгаа.

- Санхүүгийн гүйлгээ бүрийг зөвхөн уг гүйлгээний үр дүнг шууд хүртэх этгээдийн нэрээр хийх шаардлагыг хуульчлах. Энэ талаар БНСУ-ын Real Name Financial Transaction Act зэрэг олон улсын туршлагыг судалж хуульчлах нь авлигаас урьдчилан сэргийлэх үндсийн үндэс болно
- Улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн байдал татварын хяналт шалгалтаар хэрхэн илэрдэг талаархи мэдээллийг ил тод болгох
- Авлига, хээл хахуулын болон татвар төлөхөөс зайлсхийх, мөнгө угаах гэмж хэргийн илрүүлэлт, энэ төрлийн гэмт хэргүүдийн хувьд нэг нь нөгөөгийнхөө суурь болох магадлалын талаар АТГ, ҮТЕГ, холбогдох бусад байгууллагын харилцан мэдээлэл солилцох, ажлын уялдааг хангах талаар зохистой арга хэмжээ авч, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэх шаардлагатай.

Конвенцийн 10 дугаар зүйл

Олон нийтэд тайлагнах

- 10.1. Авлигатай тэмцэх хэрэгцээг харгалзан үзэж оролцогч улс бүр нийтийн захиргаандаа, түүний дотор зохион байгуулалт, чиг үүргээ хэрэгжүүлэх болон шийдвэр гаргах явцдаа ил тод байдлыг сайжруулахад шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн зохих тохиолдолд авна. Эдгээр арга хэмжээнд бусад зүйлийн хамт дараах зүйл багтана:**
- 10.1.(a).** нийтийн захиргааныхаа зохион байгуулалт, чиг үүргээ хэрэгжүүлэх болон шийдвэр гаргах явц, түүнчлэн хувийн амьдрал, хувийн мэдээ баримтыг хамгаалахыг зохих ёсоор харгалзахын сацуу иргэдийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр, эрх зүйн актын талаарх мэдээллийг зохих тохиолдолд олж авах боломжийг иргэдэд олгосон дүрэм буюу журам батлах;
- 10.1.(b).** шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг хөнгөвчлөн дэмжихийн тулд захиргааны журмыг зохих тохиолдолд хялбарчлах;

10.1.(с). Төрийн захиргаанд нь авлига гарах эрсдлийн талаарх тогтмол илтгэлийг багтааж болох мэдээллийг хэвлэн нийтлэх;

Монгол Улс Конвенцийн 10.1.а заалтыг эрх зүйн зохицуулалтаараа хангаж байна.

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан 4 чиглэлээрх мэдээллийг цахим хуудсанд 10 хүртэл жилээр архивлан хадгалах заалтыг хуульд нэмж оруулах
- Төрийн байгууллагуудын цахим хуудсанд тавигдах мэдээллийн стандарт баталсан “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага: MNS 6285:2011”- ыг шинэ дурдсан 2 хуулийн агуулгад нийцүүлэн хэрэглэхэд хялбар, ойлгомжтой болгон шинэчлэн батлах ажлыг яаравчлах

Практик хэрэгжилтүүд нь Конвенцийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг хөнгөвчлөн дэмжих шаардлагад нийцэж байна гэж үзэж байна.

- Төрийн байгууллагын цахим хуудсандаа хуулиар тавихыг шаардсан мэдээллийг хуулийн хугацаанд, бүрэн тавьж хэвшихийн зэрэгцээ утас, интернетээр мэдээлэл авах бүх боломжийг дайчлах
- Нэг цэгийн үйлчилгээ, цахим ТҮЦ гэх мэт санаачлагыг өргөжүүлэх
- Нийслэлийн “ухаалаг Улаанбаатар” санаачлагын явцыг үнэлж бусад аймаг, сум, дүүргийг түгээн дэлгэрүүлэх
- Авлигын эсрэг хуульд Авлигатай тэмцэх газар болон төрийн байгууллагууд судалгааны дүнг үндэслэн авлига гарах эрсдлийг бууруулах тодорхой арга арга хэмжээг зорилтот бүлэгт чиглүүлэн авдаг байх үүргийг нэмж тусгах

Авлигатай тэмцэх газраас хуульд заасан судалгааг тогтмолжуулан олон нийтийн мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн энэхүү ажлын хүрээнд олон нийтлэлүүдийг хэвлүүлсэн байдаг. Цахим ертөнц хөгжсөнтэй холбогдуулан тус байгууллага судалгаа, илтгэлүүдээ цахим ертөнц, зурагт, радио олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэж байна. Гэвч судалгааны дүгнэлт дээр суурилсан дараагийн алхамыг тодорхойлж авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, зорилтот бүлэг /эрсдэл бүхий төрийн байгууллага, салбар/-т чиглэсэн үр дүнтэй ажил үгүйлэгдэж байна.

Судалгаа явуулах хөндлөнгийн байгууллагыг ядавхижуулах, өрсөлдөөн бий болгох нь зүйтэй байна. Судалгааны агуулга тогтмол байх нь харьцуулалт хийх, өөрчлөлтийг орхигдуулах эрсдэлтэй байна.

- Судалгааны дүнгээр Авлигатай тэмцэх газар, төрийн холбогдох байгууллага тодорхой арга хэмжээ авч байх нь зүйтэй. Газрын алба, уул уурхайн салбар нь хамгийн их авлигад өртсөн гэсэн дүгнэлт удаа дараагийн судалгаагаар нотлогдсон байтал уг салбарт чиглэсэн авлигаас урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээг Авлигатай тэмцэх газар, Газрын алба, Нийслэлийн засаг дарга, Уул уурхайн яам авсан бэ гэдэг талаар бидэнд мэдээлэл олдоогүй.
- Түүнчлэн Авлигатай тэмцэх газрын зүгээс авлига гарах эрсдлийг хожим нь тодорхойлж, дүгнэх биш, урьдчилан тооцож, угтуулсан арга хэмжээ авч байх шаардлагатай. Жишээ нь, тухайн аль нэг яам өндөр үнийн дүнтэй, хэд хэдэн тендер зарлах гэж байгаа бол яамны холбогдох /авлигад өртөж

болзошгүй/ албан тушаалтан, Худалдан авах ажиллагааны газар, үнэлгээний хорооны хүмүүстэй уулзалт, ярилцлага хийх \ мэдээж дотоод ажилд нь оролцохгүй\, хуулийн холбогдох заалтыг сануулсан захидал илгээх гэх мэт арга хэмжээ авах нь авлигаас урьдчилан сэргийлэх хүчтэй хэрэгсэл болно гэж үзэж байна

- Тодорхой төрийн байгууллага том хэмжээний худалдан авалт хийж байгаа, олон тооны ажилтан шалгаруулж авч байгаа зэрэг ажлыг зохион байгуулах явцад тухай бүр нь Авлигатай тэмцэх газар зохих мэдээлэлтэй байж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд, шаардлагатай тохиолдолд зохих хяналт явуулж байгаа талаар олон нийтэд мэдээлдэг байж болохоор байна.
- Дээрх зорилгоор томоохон худалдан авалт хийж байгаа төрийн байгууллага, Төрийн албаны зөвлөл зэрэг холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох, байнгын ажиглалт хийх ажилтан томилох, аргачлал гарган ашиглах зэрэг арга хэмжээ авч болох юм.
- Олон нийтийн дунд АТГ-ын чиг үүргийг ойлгосон, хүндэтгэсэн хандлага дээшилж байгааг судалгаа нотолж байна. Дээр дурдсан зөвлөмжүүд нь тус газрын энэхүү эерэг нэр төрд үндэслэж байгаа бөгөөд жорыг нь хэтрүүлж болохгүй гэдгийг хатуу санах нь зүйтэй. АТГ-ын ажилтны ялимгүй ч гэлээ хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, ёс зүйгүй үг, үйлдэл бүр тус байгууллагыг хүндэтгэх хандлагыг “үл итгэх, эсхүл айдас”-ын хандлага болгон эргүүлэх аюултайг онцлон тэмдэглэж байна.

Конвенцийн 11 дүгээр зүйл

Шүүх, прокурорын байгууллагад хамаарах арга хэмжээ

- 11.1. Оролцогч улс бүр шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэлд шүүхийн шийдвэрлэх үүрэгтэйг харгалзан шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын үнэнч шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр авна. Эдгээр арга хэмжээнд шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын ёс зүйн дүрэм багтаж болно.
- 11.2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу авсантай адил үр нөлөөтэй арга хэмжээг шүүхийн тогтолцоонд хамрагддаггүй атлаа шүүхийн байгууллагатай адил хараат бус эрх зүйн байдалтай прокурорын байгууллага бүхий тэрхүү оролцогч улсын прокурорын байгууллагад нэвтрүүлэн хэрэглэж болно.

Монгол Улс шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэлд шүүхийн шийдвэрлэх үүрэгтэйг харгалзан шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын үнэнч шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр авах хууль зүйн орчин бүрдсэн байна. Эдгээр арга хэмжээнд шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын ёс зүйн дүрэм багтаж байгаа бөгөөд ёс зүйн дүрмээ Шүүгчийн болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу шинэчлэн батлаад байна.

- Төрийн албаны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Прокурорын байгууллагын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Нийтийн албанд нийтийн ба хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тухай, Авилгын эсрэг зэрэг холбогдох хуулиудад төрийн албан хаагчийн үүрэг, түүнд хориглох, хязгаарлах зүйл, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулж буй талаар, мөн Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай зэрэг хуулиудад тусгагдсан мэдээллийг ил тод болгох цагалбар, хугацааны хувьд хэрхэн уялдаж, хэрэгжих боломж хангагдаж байгаа талаарх давхардал, хийдэл, зөрчлийн судалгаа хийж, аль хууль нь тухайн харилцааг зохицуулах гол хууль болох, бусад хуульд хэрхэн давхардалгүйгээр ишлэл хийх талаар нухацтай анализ хийж, хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах арга хэмжээ авах.

Шүүх авлигад өртөмтгий салбаруудын нэлээд дээгүүрт ордгийг удаа дараагийн судалгаа харуулдаг. Иймд шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлж байсан талуудыг оролцуулсан илүү нарийвчилсан ажиглалт, ярилцлага, судалгаа явуулах шаардлагатай байна. Магадгүй, шүүгчийн ёс зүйн асуудлыг илчлэх нь хэзээ нэгэн цагт өөрт болон үр хүүхдэд муугаар нөлөөлнө гэж үздэг ч байж болох талтай. Ямартай ч нэг талаас судалгааны дүн, нөгөө талаас сахилгын хорооны шийдвэр, шүүгчийн талаар гомдол гаргахгүй шахам байгаа эсрэг тэсрэг нөхцөл байдлын шалтгааныг тогтоох нь зүйтэй.

- Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлж байсан талуудыг оролцуулсан илүү нарийвчилсан ажиглалт, ярилцлага, судалгаа явуулах шаардлагатай байна. Магадгүй, шүүгчийн ёс зүйн асуудлыг илчлэх нь хэзээ нэгэн цагт өөрт болон үр хүүхдэд муугаар нөлөөлнө гэж үздэг ч байж болох талтай. Ямартай ч судалгаа ба сахилгын хорооны шийдвэр, шүүгчийн талаар гомдол гаргахгүй шахам байгаа эсрэг тэсрэг нөхцөл байдлын шалтгааныг тогтоох нь зүйтэй
- Авлига буурахгүй байсаар байгааг судалгаа нотлоод байхад Төрийн албан хаагч, ялангуяа хууль сахиулах байгууллагын ажилтны хууль бус буюу ёс зүйн асуудлаар АТГ болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагын нэгдсэн ойлголтын үндсэн дээр иргэд гомдол гаргах, мэдээлэх явдал хангалтгүй байдгийн шалтгааныг тогтоох, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор харьцангуй урт хугацаанд хэд хэдэн үе шаттай асуулгын судалгаа, ажиглалт, тандалт хийх, тодорхой тохиолдолд туршилт хийх зэрэг төрөл бүрийн арга зүйд тулгуурласан бодитой судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх
- Цахим хуудсаа мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай зэрэг хуулийн шаардлагын дагуу мэдээллээ наанадаж сүүлийн 3 жилийн байдлаар бүрэн байршуулахыг УЕПГ-т зөвлөж байна
- Авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий голлох байгууллагуудын нэгийн хувьд УЕПГ нь үйл ажиллагааныхаа тайланд Конвенцийн 11.1, 11.2-т заасан шаардлагын дагуу болон байгууллага системийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төрийн байгууллагуудын авлигын эсрэг хамтын ажиллагаа,

ажлын уялдааг хангахад оруулсан хувь нэмрийн талаар тодорхой бүлэг болгон тусгаж байх

Конвенцийн 12 дугаар зүйл

Хувийн хэвшил

- 12.1. Оролцогч улс бүр хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг сайжруулах, түүнчлэн ийм арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд үр нөлөөтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг гаргуулахгүй байх нөлөө үзүүлэхүйц иргэний эрх зүйн, захиргааны болон эрүүгийн зохих хариуцлагыг оногдуулах арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.
- 12.2. Эдгээр зорилгод хүрэх үүднээс дараах арга хэмжээг бусад арга хэмжээний хамт авч болно:
- 12.2.(a) хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих;
- 12.2.(b) хувийн холбогдох байгууллагуудын үнэнч шударга байдлыг хамгаалахад чиглэсэн стандарт, журам, түүний дотор бизнесийн болон холбогдох бусад мэргэжлийн төлөөлөгчдийн үйл ажиллагааг зөв, нэр төртэй, зохистойгоор явуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнчлэн аж ахуйн нэгж хоорондын болон тэдгээрийн гэрээний журмаар төртэй харилцах бизнесийн сайн дадлыг хэвшүүлэн хэрэглэхийг дэмжихэд чиглэсэн ёс зүйн дүрэм боловсруулахыг хөхиүлэн дэмжих;
- 12.2.(c) хувийн байгууллагуудын дунд ил тод байдлыг хөхиүлэн дэмжих, түүний дотор зохих тохиолдолд компани, аж ахуйн нэгж байгуулж, удирдахтай холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг ялгаж тогтоох арга хэмжээ;
- 12.2.(d) хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрлийн талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх;
- 12.2.(e) нийтийн албан тушаалтан байсан этгээд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах буюу нийтийн албанаас огцорсон буюу тэтгэвэрт гарсны дараа хувийн хэвшилд ажил эрхлэхэд, хэрэв ийм үйл ажиллагаа буюу ажил нь тэдний ажиллаж байх хугацаандаа хийж байсан буюу удирдаж байсан чиг үүрэгтэй шууд хамааралтай байвал, зохих тохиолдолд, тодорхой хугацааны хязгаарлалт тогтоох замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- 12.2.(f) хувийн байгууллагууд авлигын үйлдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх хангалттай дотоод аудитын хяналттай байх явдлыг тэдгээрийн бүтэц хэмжээг харгалзан хангах, түүнчлэн тэдгээр хувийн байгууллагын данс, шаардлагатай санхүүгийн тайланг аудит, магадлан итгэмжлэлийн зохих журамд хамруулах явдлыг хангах;

12.3. Авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх зорилгоор явуулсан дараах үйлдлийг хориглоход нягтлан бодох бүртгэл тооцоо хөтлөх, санхүүгийн тайланг ил тод болгох, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартын талаарх дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

12.3.(a) бүртгэлээс гадуур данс нээх;

12.3.(b) бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийх;

12.3.(c) гараагүй зардлыг бүртгэх;

12.3.(d) объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх;

12.3.(e) хуурамч баримт бичиг ашиглах;

12.3.(f) нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хуульд заасан хугацаанаас өмнө санаатайгаар устгах;

12.4. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн 15, 16 дугаар зүйлийн дагуу тогтоосон гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг болох хээл хахуульд өгсөн зардал болон зохих тохиолдолд авлигын үйлдлийг дэмжсэн бусад зардлыг татвар ногдох зардлаас хасч тооцохыг үл зөвшөөрнө.

- Хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон хөндлөнгийн аудитын хяналтын талаар холбогдох хууль тогтоомжид илүү дэлгэрэнгүй хуульчлах.
- Аудитын тухай хуульд аудитор болон аудитын байгууллага аудит хийх явцдаа авлигын шинжтэй зөрчил илэрвэл зохих байгууллагад мэдээлэх үүргийн талаар заалт байхгүй байгааг олон улсын жишигт нийцүүлэн нэмж оруулах.

Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг сайжруулах, түүнчлэн ийм арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд үр нөлөөтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг гаргуулахгүй байх нөлөө үзүүлэхүйц иргэний эрх зүйн, захиргааны болон эрүүгийн зохих хариуцлагыг оногдуулах арга хэмжээг хуульчилсан боловч эдгээр хуулийн хэрэгжилтийг харуулсан мэдээлэл хомс байна. Тухайлбал, дээр дурдсан хуулиудад заасан захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тоо, хэрхэн илрүүлсэн, аудитор ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн тухай мэдээлэл байхгүй байна. Үндэсний татварын ерөнхий газрын цахим хуудсанд тус байгууллагын тайлангууд байгаагүй учир нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөрчлийн төрөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл олдоогүй.

- Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг сайжруулахтай холбоотой Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Компанийн тухай хуулийн тодорхой зохицуулалтын хэрэгжилтийн талаар судалгаа үнэлгээ хийх;

- Хуулийн хэрэгжилтийн талаар холбогдох төрийн байгууллага чиг үүргийнхээ дагуу статистик мэдээллийг ил тод болгох арга хэмжээ авах шаардлагатай.

Цагдаагийн албаны тухай хуульд гэмт хэрэг, зөрчил гарсан болон үйлдэхээр бэлтгэж байгаа, үйлдсэн этгээдийн талаар цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлэх; гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх зэргээр иргэн, байгууллага, албан тушаалтны зүгээс цагдаагийн байгууллагад туслалцаа үзүүлэх талаар тусгаж, эдгээр үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон иргэнд холбогдох хуульд заасны дагуу урамшил олгож болохоор заасан байна \уг хуулийн 26.2.2, 26.3\.

Авлигын гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, үйлдсэн этгээдийн талаар иргэн цагдаагийн байгууллагад хандалгүйгээр шууд АТГ-т мэдээлэл өгөх зэрэг Цагдаагийн албаны тухай хуульд заасан дээрх туслалцаа АТГ-т үзүүлсэн иргэнд АТГ урамшил олгох боломжийг Авлигын эсрэг хуульд тусгаагүй байна. Түүнчлэн татвар төлөхөөс зайлсхийх үйлдэл нь авлига, мөнгө угаах хэрэгтэй зарим тохиолдолд холбоотой байх магадлал өндөр тул татвар төлөхөөс зайлсхийсэн тухай мэдээлэл өгсөн иргэнийг ч урамшуулдаг байх зохицуулалтыг Татварын ерөнхий хууль, Гаалийн хуульд оруулсан байх нь хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих иглэлээр хангалттай хуульчилсан байх Конвенцийн 12.2.а-д заасан шаардлагыг бүрэн хангах ач холбогдолтой гэж үзэж байна.

- Хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр зохих судалгаа хийх
- Авлигын гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн этгээдийн талаар үнэн зөв, шуурхай мэдээлэл өгөх зэргээр авлигатай тэмцэх байгууллагад туслалцаа үзүүлсэн иргэнд урамшил олгож болох бүрэн эрхийг тус байгууллагад олгох чиглэлээр Авлигын эсрэг хуульд зохих нэмэлт оруулах
- Дээрхтэй төсөөтэй зохицуулалтыг Гаалийн болон Татварын ерөнхий хуульд оруулах боломжийг судалж шийдвэрлэх

Хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн хэвшлийн байгууллага хоорондын авлигын эсрэг хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих чиглэлээрх ажил практик дээр эхлэлийн төдий байна.

- Тангараг өргөсөн төрийн албан хаагч төрийн албыг хувьдаа урвуулан ашигласан нь тогтоогдвол дахин төрийн албанд ажиллуулахгүй байх зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмж оруулах
- Шударга нийгмийг тогтоох, авлигын эсрэг үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийг оролцоог өргөжүүлэх талаар АТГ-аас гадна ТЕГ, УТЕГ, ГЕГ, УНДЕГазар зэрэг холбогдох төрийн байгууллагуудыг татан оролцуулж, үндэсний зөвшилцлөлийг бий болгох
- Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд, банк санхүүгийн байгууллагуудыг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд түлхүү оролцуулах чиглэлээр АТГ нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж, Компанийн засаглалын кодекс зэрэг зохистой засаглалыг

дэмжсэн бодлогын баримт бичигт энэ зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал солилцох, ажил хэрэг болгох

- Төрийн албан хаагчид хүнд сурталтай байна, хээл хахууль нэхэж байна, авлигад өртөмтгий байна гэсэн шүүмжлэл гаргаад байдаг хувийн хэвшлийнхэн өөрсдөө авлигын эсрэг санаачлагатай ажиллах, шаардлагатайг өргөнөөр сурталчлах

Компанийн тухай хуульд хувийн байгууллагуудын удирдах албан тушаалтан ажил үүргээ зохих зөвшөөрлийн дагуу үнэнч шударгаар биелүүлэх нөхцлийг хуульчилсан гэж үзэж байна. Гэвч хуульд “үнэнч шударгаар” гэдэг үг шууд тусгаагүй байгаад бид шүүмжлэлтэй хандаж байна.

Компанийн засаглалын кодекст Гүйцэтгэх удирдлага ба удирдлагын багийн гишүүд компанийн төлөө үнэнч шударгаар ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана /6.1.3/ гэж заасан нь нь компанийн удирдлага нь төрийн ашиг сонирхолыг харгалзан үйл ажиллагаагаа удирдана гэдгийг тодорхойлсон боловч “төртэй харилцах бизнесийн сайн дадал” гэж юу болохыг тодорхойлсон хэрэг биш юм.

Ёс зүйн дүрмийг боловсруулахыг хөхиүлэн дэмжих чиглэлээр Аудитын тухай хуульд Мэргэшсэн нягтлан бодогч ёс зүйн дүрэмтэй байна. /15.3./ Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага үнэлгээчний ёс зүйн дүрмийг баталж, мөрдүүлнэ. Үнэлгээчний ёс зүйн дүрэм нь олон улсын үнэлгээний стандартад нийцсэн байна. /12.1, 12.2/ Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд Татварын мэргэшсэн зөвлөх нь татварын мэргэшсэн зөвлөхийн ёс зүйн дүрмийг мөрдөх үүрэгтэй. /16.1.6./ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд Монгол Улсын үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагын бүрэн эрхийг Хороонд бүртгүүлсэн хуулийн этгээд хэрэгжүүлнэ. /69.1/ Энэхүү байгууллага нь зохицуулалттай хуулийн этгээд болон энэ хуулийн 35.1-д заасан эрх авсан мэргэжилтнүүдээс бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий мэргэжлийн холбоо, хөрөнгийн бирж, үнэт цаасны тооцооны байгууллага болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага байна. /69.2/ мөн Банкны тухай хуулиар банкны ТУЗ-ын гишүүн, гүйцэтгэх удирдлага, Монголбанкны ажилтанд ёс зүйн шаардлага тавьсан зэргээр тус тус хуульчилсан нь эдгээр хуулиудын хүрээнд Конвенцийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж байна гэж үзэж байна.

Компанийн засаглалын кодексийн “оролцогч талууд” гэсэн 10 дугаар бүлэгт төрийн тухай тусгаагүй байгаад бид шүүмжлэлтэй хандаж байна.

- Компанийн эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаагаа “үнэнч, шударгаар” явуулах чиглэлээр Компанийн тухай хуульд тодорхой заах. Эхний ээлжинд Компанийн засаглалын кодексийн тав, зуравдугаар бүлэгт оруулах чиглэлээр АТГ-ыг зүгээс СЗХ-той зөвлөлдөх, зохих арга хэмжээ авах, Монголбанкт ч энэ чиглэлээр хамтран ажиллах
- Компанийн засаглалын кодекс, Банкны салбарын компанийн засаглалын баримт бичигт хувийн байгууллагуудын төртэй харилцах бизнесийн сайн дадлын талаар илүү тодорхой тусгах, энэ талаар OECD-ийн зарчмыг судалж нэвтрүүлэх

Олон улсын бизнесийн ажиллагаанд гадаадын албаны хүмүүсийг хахуульдахын эсрэг тэмцэх тухай OECD-ийн 1997 оны конвенцид дэлхийн 40-өөд орон /Япон, Солонгос зэрэг/ нэгдэн орсон байна. Энэхүү Конвенцийн нэгдэн орох нь OECD-тай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нэгэн чухал чиглэл бөгөөд авлигын эсрэг тусламж дэмжлэг авахад тус дэмтэй.

Монгол Улсын гадаад эдийн засгийн харилцаа өргөжиж, худалдаа хөрөнгө оруулалт нэн өсч байгаа нь олон улсын бизнесийн хүрээнд гадаадын албан тушаалтантай холбогдох авлигын эрсдэл манай оронд улам өндөр байх магадлалыг лавшруулж байгааг бодолцон тус конвенцид элсэх талаар шуурхай ажиллах шаардлагатай байна.

- Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагууд, Татварын мэргэшсэн зөвлөхүүдийн байгууллага, Арилжаа эрхлэгчдийн холбоо, Банкуудын холбоо зэрэг ёс зүйн дүрэмтэй байгууллагууд ёс зүйн дүрмийн хэрэгжилт, дүрмээ зөрчсөнд хүлээлгэх хариуцлагын талаар цахим хуудсандаа тогтмол мэдээлж хэвшүүлэх
- Хувийн байгууллагуудын төртэй харилцах бизнесийн сайн дадлын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх
- Тодорхой мэргэжлийн хүрээний ёс зүйн дүрэмд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой тусгах
- Хувийн хэвшил түүний дотор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн авлигаас урьдчилан сэргийлэх бодлогын талаар мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, тийм бодлого боловсруулж мөрдөх явдлыг хөхиүлэн дэмжих
- Энэ чиглэлээр Авлигатай тэмцэх газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж Компанийн засаглалын кодекст нэмэлт оруулж төртэй харилцах сайн дадал, авлигатай тэмцэх бодлогын талаар тодорхой тусгах
- Хувийн байгууллагууд мэдээллээ ил тод болгохыг шаардсан зохицуулалт нилээд хуульд тусгагдсан боловч төрөөс “хөхиүлэн дэмжих” механизм тодорхой хуульчлагдаагүй байх тул хэрхэн хөхиүлэн дэмжих вэ гэдэг чиглэлд анхаарал хандуулах нь зүйтэй.
- Худалдан авах ажиллагаанд оролцох компаниудад “бага үнийн” шалгуур тавихаас илүүтэйгээр “хуулиар тогтоосон мэдээллээ ил тод болгосон, засаглал сайтай, биржид бүртгэлтэй” гэдэг шалгуурт давуу байдал олгосон зохицуулалтыг бий болгох нь авлигаас урьдчилан сэргийлэх чухал алхам болно. Тендерт гол төлөв ардаа “сайн авилгач мотортой” биржид бүртгэлгүй, гол нь санхүүгийн мэдээллээ ил тод болгох үүргийг хуулиар хүлээдэггүй ХХК оролцдог болохыг хэдийгээр бүх 272 барилга, объектын тендерийг авсан компаниудын мэдээлэл хэвлэлээр бүрэн хэмжээнд цацагдаагүй ч “дуусаагүй барилгын” гэх дуулианд холбогдсон компаниуд дотор биржид бүртгэлтэй, TOP 20 индекст багтсан компанийн нэр сонсогдохгүй байгаагаар нотлогдох талтай байна.

Монголд компанийн засаглалын тухай ойлголтыг зөвхөн компанийн засаглалын гол тоглогчид (захирлууд, хувьцаа эзэмшигчид болон зохицуулагчид) төдийгүй, бусад нөлөөлөгчдийн хувьд (хэвлэл, мэдээлэл

аудиторууд, хувьцаа эзэмшигч бүлгүүд) гүнзгийрүүлэх хэрэгтэй. Бүх бүлэг бүрт тохирсон сургалт явуулахыг зөвлөмж болгож байна.

Аудитын хуулийн дагуу компаниуд нь бие даасан аудитын тайлан гаргаж байх шаардлагатай. Гэхдээ, олонхи тохиолдолд, аудиторын хараат бус байдлыг төдийлөн авч үзэхгүй байна. Компанийн тухай хуулийн дагуу компаниуд нь сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн талаар баримтлах бодлого боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөх шаардлагатай. Судалгаанд хамрагдсан олонхи компани үүнийг дагаж мөрдөхгүй байна.

Судалгаанд хамрагдсан компаниудын хувьд мэдээлэл хаанаас авах, түүнд нь нэвтрэхэд хүндрэлтэй байсан ба энэ нь материалыг хэд хэдэн газраас цуглуулах шаардлага гарч байсантай холбоотой. Чанартай бэлтгэгдсэн, компанийн вэбсайтад байршуулсан мэдээлэл нь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад онцгой ач холбогдолтой ба сайн мэдээлэл нь компанийн хэмжээнд мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлнэ. Тийм мэдээлэл нь бусад улс оронд заавал дагаж мөрдөж байгаагийн адил Жилийн ажлын иж бүрэн тайлан орох бөгөөд түүнд санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэнд аудиторын шалгалтын тайлан, компанийн тодорхой стратеги, учирч байгаа бизнесийн эрсдэл, санхүүгийн завсрын мэдээлэл, компанийн КЗ-ын бүтцийг тайлбарласан компанийн засаглалын тайлан, компаниас КЗ-ын Кодексийн шаардлагыг ямар байдлаар нэвтрүүлж байгаа болон хэрэв КЗ-ын кодексийн заалтыг мөрдөөгүй бол бодитой тайлбарыг өгөх ёстой. Түүнчлэн, компанийн вэбсайтад байршуулсан мэдээлэлд том хувьцаа эзэмшигчдийн талаархи иж бүрэн мэдээлэл болон компанийн засаглал, компани хувьцаа эзэмшигчдийн харилцаа, мэдээллийн нээлттэй байдлыг ханган түгээх, сонирхлын зөрчил болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл, дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцохтой холбогдсон компанийн бодлогыг хамруулан оруулна.

Монголын ТУЗ-ийн үйл ажиллагааг дэлхийн хэмжээнд тавигддаг ТУЗ-ийн үүрэг хариуцлагатай харьцуулж үзэхэд, Монгол дахиад л хоцорч явна. Тэд нар компанийн удирдагч гэдэг утгаараа компанийн сайн засаглал болон ёс зүйг эрхэмлэх “үлгэр дууриалыг дээрээс” тогтоон харуулах ёстой. Компани нь ёс зүйн кодексийг бүх захирлууд болон ахлах уридлагын түвшинд нэвтрүүлэн мөрдөж болно. Хараат бус захирлуудыг дэлхийн “хараат бус” тодорхойлолтын дагуу тодруулж, ТУЗ-д томилон ажиллуулах хэрэгтэй.

Банкууд мэдээллээ ил тод болгох хуулийн шаардлагыг харьцангуй сайн биелүүлж байна.

- Компанийн засаглалын үнэлгээний тайланд тусгагдсан дүгнэлт, зөвлөмж бүрийг сайтар судалж, төр, хувийн хэвшлийн авлигын эсрэг хамтын ажиллагааны нэг хэлбэр болгон ашиглах
- АТГ-ын зүгээс хувийн хэвшлийн байгууллагуудын түвшинд авлигын эсрэг бодлогоо тодорхойлон мөрдөх явдлыг хэвлэл мэдээллээр сурталчлан таниулах зэргээр хөхиүлэн дэмжих
- Хувийн байгууллагууд, ялангуяа нийтийн ашиг сонирхолыг хөнддөг Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, банк, даатгалын зэрэг санхүүгийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангах

талаар Авлигатай тэмцэх газрын зүгээс төрийн холбогдох байгууллага, эздийн холбоо зэрэг ТББ-тай хамтран ажиллах талаар хэлэлцэж, доривтой арга хэмжээ авах

- Дээрх чиглэлээр хөндлөнгийн үнэлгээ хийж дүнг нийтэд мэдээлж байх Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудаар зохицуулж байна. Энэ нь конвенцийн 12.2.d-д заасан шаардлагыг эрх зүйн орчны хувьд харгах зохих арга хэмжээ авсан гэж үзэх байна. Практикаас үзвэл хуулийн этгээдийн, эд хөрөнгийн, иргэний бүртгэл зэрэг хуульд зааснаар улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлага тавигддаг харилцаанд бүртгэх байгууллагын ажилтны хүнд суртал, хээл хахуултай холбоотой асуудал зохих хувийг эзэлдэг гэж үзэж байна. Энэ нь 2013 оны 12 дугаар сард явуулсан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийн талаарх судалгаа”-гаар 2007 оны 3, 9 дгээр сар, 2008 оны 9 дүгээр сард бүртгэлийн алба “авлигад хамгийн их өртсөн” 5 салбарын 4 болон 5 дугаарт нэрлэгдсэнээр нотлогдож байна. Харамсалтай нь, “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаагаар хамгийн их авлигад өртөмтгий салбар гэдэгт төрийн үйлчилгээ \67.8 хувь\ “тодорсон” боловч тэдгээрийн дотроос төрийн чухам аль үйлчилгээ илүү их авлигад өртөмтгий болохыг бизнес эрхлэгчдээс тодруулж асуугаагүй байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын зүгээс Конвенцийн 12.2.d: “хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрлийн талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх” гэсний “тусгай зөвшөөрлийн” гэснийг “тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үйлчилгээний” гэж нэмэх саналыг гаргаж болох юм гэж үзэж байна. Түүнчлэн Компанийн тухай хуульд хувьцаат компанийн ТУЗ-ын гишүүн компанийн засаглалын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх авах тухай, мэргэжлийн оролцогч байгууллагын эрх бүхий албан тушаалтан Хорооноос зөвшөөрөл авсан байх тухай, Даатгалын тухай хуульд даатгалын компанийн эрх бүхий албан тушаалтан Хорооноос зөвшөөрөл авсан байх тухай зэрэг нилээдгүй олон хуульд төрийн байгууллагаас “зөвшөөрөл олгох”, “эрх, гэрчилгээ авах” зохицуулалт байдгийг ч Конвенцийн энэ заалтад нэмэх санал дэвшүүлж, зохих мониторинг, судалгаа хийх талаар анхаарахад буруудахгүй.

- Монгол Улсын зүгээс Конвенцийн 12.2.d: “хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрлийн талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх” гэсэн заалтыг “хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, гэрчилгээ, бүртгэлийн үйлчилгээний талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх” гэж өөрчлөн найруулах саналыг гаргаж болох юм гэж үзэж байна
- Төрийн хөрөнгө, татаас ашиглах, тусгай зөвшөөрөл олгох явцад хүнд суртал, авлига гарахаас гадна төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, газар өмчлөх, эзэмших, ашиглах зөвшөөрөл авах, зөвшөөрөл, эрх,

гэрчилгээ авахад мөн уг асуудал илэрдэг тул Конвенцийн хэрэгжилт болон дүгнэхэд уг асуудлыг нэмэх

2008 оноос хойш бүртгэлийн байгууллагад мэдээллийн технологи нэвтрүүлэх чиглэлээр Засгийн газрын зүгээс онцгой анхаарч, үе шаттайгаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлж цахимжуулсан нь тэр үеэс хойш бүртгэлийн үйлчилгээ авлигад өртөмтгий 5 салбарын хүрээнд нэрлэгдэхгүй болоход нөлөөлсөн гэж үзэж байна. “Компьютер бол хүн биш учир авлига нэхдэггүй” учир төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг нэвтрүүлэх нь авлигаас урьдчилан сэргийлж, хүнд суртлыг арилгах чухал нөхцөл болохыг нотолж байна.

- Татаас /концессийг оролцуулан/, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, гэрчилгээ олгох төрийн аль нэг байгууллагад бүртгүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд дахь авлигын нөхцөл байдал, хүнд суртлын арга хэлбэр, тархалтын талаар бие даасан судалгаа хийж үр дүнгээр зохих арга хэмжээ авах
- Тусгай зөвшөөрөл, бүртгэл олгох, төрийн бусад олон үйлчилгээг цахимжуулах талаар онцгой анхаарч төрийн байгууллага бүр зохих техникийн нөхцөл, хүний нөөцийн бэлтгэлийг хангах үе шаттай арга хэмжээ авах харилцан уялдаатай арга хэмжээг төрийн бүх байгууллагыг хамруулан авах. Үүнтэй холбоотойгоор Мэдээллийн технологи, шуудан, харилцааны газрын статусыг дээшлүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтан байсан этгээд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах буюу нийтийн албанаас огцорсон буюу тэтгэвэрт гарсны дараа хувийн хэвшилд ажил эрхлэхэд, хэрэв ийм үйл ажиллагаа буюу ажил нь тэдний ажиллаж байх хугацаандаа хийж байсан буюу удирдаж байсан чиг үүрэгтэй шууд хамааралтай байвал, зохих тохиолдолд, тодорхой хугацааны \хоёр жил\ хязгаарлалт тогтоож, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх Конвенцийн 12.2.е заалтын шаардлагыг хангасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Зөвхөн Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүний ажил, албан тушаалыг хавсарч болно. Энэ тохиолдолд гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр халдгална” гэж өөрчлөн найруулах, үүнтэй уялдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим зүйлийн зохих заалтыг өөрчлөн найруулах хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж өргөн мэдүүлсэн юм.

“Давхар дээл” гэсэн нэршлээр олны анхаарлыг татсан асуудлаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гараад ч өөрчлөлтөд хүрээгүй, хэдэн жилийн дараа Засгийн газрын тухай хууль, УИХ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах гэсэн Ерөнхийлөгчийн санаачлага гараад ч дэмжлэг аваагүй, яамдын төрийн нарийн бичгийн дарга нар “хэд хэдэн давхар дээлтэй” тухай АТГ-ын судалгааны тайлан зэргээс дүгнэлт хийвэл нийтийн албан тушаалтан хувийн хэвшилд ажил эрхлэхэд, зохих тохиолдолд, тодорхой хязгаарлалт тогтоох замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хүчин төгөлдөр хууль болон Конвенцийн шаардлагыг төрийн албаны дээд түвшиндээ зөрчдөг, “хуулийн аргаар” сонирхлын зөрчлөөсөө салах хүсэлгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

Энэ бол үнэхээр Монголыг муухай харагдуулж байна. Энэхүү дүгнэлтийг олон нийтийн дунд хийсэн санал асуулга давхар нотолж байна.

- төрийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүс тийнхүү чөлөөлөгдсөнөөс хойшхи 2 жилийн хугацаанд сонирхлын зөрчил үүсгэхүйц ажил эрхэлж байгаа эсэх тухай мэдээллийг цуглуулах, хэрэгжилтийг хэрхэн хянах механизм тодорхойгүй, статистик мэдээлэл байхгүй байгаа тул цаашид судалгаа хийх, тайлан мэдээлэл авах гэх мэт арга хэмжээ авах
- Сонирхлын зөрчилтэй хүмүүсийг төрийн өмчийн зүгээс ч, хувийн зүгээс ч төрийн өмчийн компанийн ТУЗ-д оруулахыг хориглосон зохицуулалтыг холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх
- Төрийн албан хаагч намын гишүүнээс түдгэлзэх талаарх 2004 онд Төрийн албаны тухай хуулийн 10.6-д орсон өөрчлөлтийн хэрэгжилтийн мониторинг хийх
- “Давхар дээл”-ийг тайлах асуудлыг дахин авч үзэж, төрийн дээд түвшинд авилгалыг бууруулах чиглэлээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг тууштай үргэлжлүүлж 2015 онд Конвенцийн хэрэгжилтийн тайландаа Монгол төр хэлэх үгтэй болохыг зөвлөж байна

Монгол Улс нь Конвенцийн хувийн байгууллагууд авлигын үйлдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх хангалттай дотоод аудитын хяналттай байх явдлыг тэдгээрийн бүтэц хэмжээг харгалзан хангах, түүнчлэн тэдгээр хувийн байгууллагын данс, шаардлагатай санхүүгийн тайланг аудит, магадлан итгэмжлэлийн зохих журамд хамруулах явдлыг хангах гэсэн заалтыг хууль тогтоомждоо тодорхой хэмжээгээр тусгасан байна.

- Компанийн засаглалын кодексоос зарим зайлшгүй шаардлагатай заалтыг Компанийн тухай хуульд оруулж хуульчлах
- Аудитын тухай хуульд аудитын хяналт шалгалтаар ямар ямар баримт бичгийг нягтлан шалгуулах жагсаалт, авлигаас урьдчилан сэргийлэх аудторын үүрэг, үйлчлүүлэгчийн хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр тодорхой зохицуулалт нэмж өгөх
- Компанийн засаглалын үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийг ажил хэрэг болгох
- Засаглалын үнэлгээг тогтмол хийж хувийн хэвшлийн илүү олон байгууллагыг хамруулж, үр дүнг нийтэд хүргэдэг болох

“Бүртгэлээс гадуур данс нээхийг хориглох” талаарх конвенцийн холбогдох заалтыг бүрэн биш ч тодорхой хэмжээгээр зохицуулсан байна. Харин төрийн албан хаагч гадаадад нээлгэсэн дансны мэдээллээ ХАСХОМ-доо мэдүүлэх талаар хууль ойлгомжтой тодорхой тусгаагүй байна.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, компанийн тухай хууль болон бусад хуулиудад нягтлан бодогч болон компани нь бүртгэлээс гадуур данс нээхийг хориглон хуульчлах
- Төрийн албан хаагч гадаадад нээлгэсэн дансны мэдээллээ ХАСХОМ-доо мэдүүлэх талаар холбогдох хуульд ойлгомжтой тодорхой нэмж оруулах

Дурдсан хуулиудад “бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ” гэдэг нэр томъёо ороогүй бөгөөд эдгээр хуулиудад хэрэглэсэн нэр томъёонууд нь тойруу утгаарч болов бүрэн тодорхойлсон нь гэдэг нь эргэлзээтэй байна.

Эдгээрээс үзэхэд тус хуулийн заалтууд нь конвенцийн холбогдох шаардлагыг бүрэн хангаагүй байна.

- Татварын ерөнхий хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Компанийн тухай, Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай зэрэг болон бусад холбогдох хуульд бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийх тохиолдолд хэрхэн залруулга хийх болон санаатайгаар тийм гүйлгээ хийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэргийг нарийвчлан тусгах
- Бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийхтэй холбоотой мэдээллийг татварын байгууллага, шүүхийн статистикээр тодорхой болгох арга хэмжээг холбогдох байгууллагууд хамтрах хэрэгжүүлж, 2015 онд тайлан бэлтгэх хүртэл конвенцийн энэ заалтын шаардлагыг хангах

Хуурамч бичиг баримт үйлдэх замаар гаргаагүй зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгүүлж улмаар татвар ногдох зардлыг өсгөх тохиолдолд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хуулиар торгуулийн хэмжээг өөр өөрөөр тодорхойлсон нь хуулиудын зөрчил эсхүл нэг зөрчилд давхардсан торгууль оногдуулахаар байна.

Дээрхийг эс тооцвол конвенцийн холбогдох зүйл заалтыг хууль тогтоомжоороо хангаж өгсөн байна гэж үзэж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Татварын ерөнхий хуулиар ногдуулж буй хариуцлага хүлээлгэж буй үйлдэл болон хариуцлагуудын давхардал хийдлийг судалж арилгах
- Конвенцийн 12.3.a-12.3.f-ийг хэрхэн ойлгож хэрэгжүүлж буй талаар судалгаа хийж шаардлагатай арга хэмжээ авах нь зүйтэй.
- Энэ талаарх тайлбар, практикт хэрэглэх аргачлал зэрэг мэдээллийг нэмэгдүүлэх

“Барааны үнэ төлсөн” гэхийн оронд “зээл олгосон” гэж бичиж “өглөг үүсгэсэн” зөрчил байж болно. “Объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх” гэсэн нэр томъёо Татварын ерөнхий хуульд байгаа “хуурамч бичиг баримт үйлдэх” гэснийг ерөнхий утгаар нв хуурамч өглөг үүсгэхтэй дүйцүүлж үзэж болох боловч дотоодын хууль тогтоомжид конвенцийн шаардлагын дагуу тодорхойлох шаардлагатай.

- “объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх” гэсэн Конвенцийн хэллэгийг энэ л утгаар нь Нягтлан бодох бүртгэлийн болон Татварын ерөнхий хуульд оруулах шаардлагатай
- Конвенцийн 12.3.a-12.3.f-ийг хэрхэн ойлгож хэрэгжүүлж буй талаар судалгаа хийж шаардлагатай арга хэмжээ авах нь зүйтэй.

“Хуурамч бичиг баримт бүрдүүлэх”, “хүчин төгөлдөр бус гэрээ хэлцэл хийх” гэдэг нь “хуурамч бичиг баримт ашиглах” гэдэгтэй утга нэг гэж үзэхэд учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлээгүй, үйлдээгүй атлаа хуурамч гэдгийг мэдсээр байж нягтлан бодох бүртгэлдээ ашиглах үйлдэл орхигдсон байж болохоор байна.

- Дотоодын хууль тогтоомжид Конвенцийн 12.3.e-д “хуурамч баримт бичиг ашиглах” гэж зааснаар тодорхойлох нь зүйтэй.

Татварын ерөнхий хуульд Конвенцийн 12.3.f-ийн “хуульд заасан хугацаанаас өмнө” гэдэг санааг орхигдуулсан байна.

- Татварын ерөнхий хуулийн 74.1.5-ы устгах” гэсний өмнө “хуульд заасан хугацаанаас өмнө” гэж нэмэх

ААНОАТХ-д конвенцийн энэ заалтыг шууд илэрхийлсэн заалт байхгүй байна.

- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд хээл хахуульд өгсөн зардал, авлигын үйлдлийг дэмжсэн бусад зардлыг татвар ногдох орлогоос хасахыг хориглоно гэж нэмж оруулах

Конвенцийн 13 дугаар зүйл

Нийгмийн оролцоо

13.1. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд хувь хүн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн нэгдэл хөдөлгөөнд тулгуурласан байгууллага зэрэг нийтийн албанаас гаднах бүлгийн идэвхитэй оролцоог хөхиүлэн дэмжих бөгөөд бодитоор оршин буй авлига, түүний шалтгаан, ноцтой байдал, аюул заналын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн өөрийн бололцооны хүрээнд авна. Энэхүү оролцоог дараах арга хэмжээгээр бэхжүүлнэ:

13.1.(a). шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, түүн дэх олон нийтийн оролцоо, хувь нэмрийг дэмжих;

13.1.(b). олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах;

13.1.(c). авлигыг үл тэвчих уур амьсгал бий болгоход хувь нэмэр оруулах мэдээллийг олон нийтэд түгээх, түүнчлэн олон нийтийн боловсролын хөтөлбөр, түүний дотор дунд болон их, дээд сургуулийн хөтөлбөр хэрэгжүүлэх;

13.1.(d). авлигатай холбоотой мэдээлэл хайх, авах, хэвлэн нийтлэх, түгээх эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах. Тэрхүү эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт тавьж болох боловч хязгаарлалт нь зөвхөн хуульд заасан байх бөгөөд дараах үндэслэлээр шаардлагатай байвал зохино:

13.1.(d).(i). бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх

13.1.(d).(ii) үндэсний аюулгүй байдал, олон нийтийн дэг журам, олон нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

13.2. Оролцогч улс бүр энэхүү конвенцид заасан авлигатай тэмцэх холбогдох байгууллагын талаар олон нийт мэдэж байх явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авч, энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үүсгэж байна гэж үзэж болох аливаа тохиолдлын талаар мэдээлэхээр эдгээр байгууллагад зохих

тохиолдолд хандах боломж /үүнд нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана/-оор хангана.

Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, түүн дэх олон нийтийн оролцоо, хувь нэмрийг дэмжих гэсэн Конвенцийн шаардлагыг Авлигыг эсрэг болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дурдсан заалтуудаар хангаж байна гэж үзэж байна.

2013 онд Хуульч эмэгтэйчүүдийн холбоо авлигын эсрэг бодлогын баримт бичгийг боловсруулах, орон даяар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан нь авлигаас урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг тодорхойлох үйл явцал ТББ, олон нийтийг орон даяар хамруулсан чухал арга хэмжээ болсон бөгөөд тус ТББ нь аймаг бүрт салбартай байсан нь ажлын үр дүнд нөлөөлсөн байна. Цаашид авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг салбаруудтай ТББ-ыг оролцуулах талаар түлхүү анхаарах нь орон нутагт салбаргүй АТГ-ын хувьд чухал болохыг харуулав.

Авлигатай тэмцэх газрын хамтарч ажилладаг байгууллагуудыг энэхүү тайлангийн Нэгдүгээр бүлгийн 4 дэх хэсэг буюу Конвенцийн 5-р зүйлийн 4-ийн Оролцогч улсууд энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өөр хоорондоо болон холбогдох олон улсын ба бүс нутгийн байгууллагатай эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн аль тохирох байдлаар хамтран ажиллана. Ийм хамтын ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, төсөлд оролцох ажил багтаж болох талаарх заалтын практик хэсгээс харна уу.

Манай багаас энэхүү судалгааны явцад хийсэн вэбд суурилсан судалгаанд хамрагдсан төрийн 48 байгууллагын 3 аас бусад нь шийдвэр гаргах явцын ил тод байдлыг хангаж ажилладаггүй болох нь ажиглагдлаа.

- Яам, агентлагууд шийдвэр гаргах эрх бүхий этгээд шийдвэр гаргах явцдаа төслөөр 30-аас доошгүй хоногт нийтэд ил тод болгон цахим хуудсаараа санал авч хэвших нь зүйтэй байна.
- Цаашид авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг салбаруудтай ТББ-ыг оролцуулах талаар түлхүү анхаарах нь орон нутагт салбаргүй АТГ-ын хувьд чухал байна

Авлигын эсрэг хуулийн 6.1.4, 6.1.5, 18.1.3, 18.1.5, 18.1.7, 14.5; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн 7.1, 8.1, 9.1, 9.2, 9.3, 10.1-д заалтуудаас үзвэл олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Удирдамжийн 3-т заасан 51 төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэхэд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Хил хамгаалах ерөнхий газар, Цөмийн энергийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо эдгээр 7 байгууллага хамгийн өндөр оноо буюу 65.5-аас 74.5 оноо авсан нь хамгийн сайн үнэлгээ болно. Эдгээрээс Цөмийн энергийн газраас бусад байгууллага нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн

мэдээллийн ил тод байдлыг 4 төрлөөр нь цахим хуудасдаа олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэсэн нь ийнхүү үнэлэгдэх үндэслэл болж байна. ЭБАТ-уудын нэмэгдлийг авч үзвэл УБЕГ цалингийн 30%, ҮХААЯ, ХХЕГ, ЦЭГ тус бүр 40%-р, ХААГ 15%, СЗХ 10%-р тус тус тогтоосон байна. Эдгээрээс ЭБАТ нь харьцангуй бага нэмэгдэл авч байгаа СЗХ-ы авлигын эсрэг үйл ажиллагаатай газар дээр нь танилцахад цахим хуудсаараа хуулиар тогтоосон мэдээллийг бүрэн толилуулсан, мэдээллийн самбар, өргөдөл, гомдол авах хайрцаг байрлуулж, цахим хуудсаа хөгжүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгө зарцуулсан, бичиг баримтын эмх, цэгц үлгэр жишээ байлаа.

Бидний үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас нийтдээ 37 байгууллага буюу 72% нь 50-аас дээш оноо авсан байна. Үнэлгээний дундаж нь 51хувь байна.

2014 оны 6-р сарын сүүлчээр хийсэн энэхүү ажиглалтыг өнгөрсөн оны 11-р сард хийсэн дүгнэлттэй харьцуулбал төрийн байгууллагууд мэдээллээ ил тод болгох талаар тодорхой ахиц гарсан байна.

Манай орны аль ч өнцөг буланд байгаа иргэн гар утас, компьютер, нөүтбүүкээсээ төрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломж бүрдсэн. Ямар мэдээлэл тавихыг хуульчилсан өнөөгийн энэ нөхцөлд аль нэгэн төрийн байгууллагын удирдах болон бусад ажилтантай биечлэн уулзаж мэдээлэл хүсэх шаардлагагүй болсон нөхцөлд Конвенцийн хэрэгжилтийн үнэлгээ хийхийн тулд бид аль нэг байгууллагын даргатай уулзаж танай байгууллага юу хийж байна вэ? Гэж уулзах аргыг сонгоогүй болно. Энэ арга нь үнэлгээ “хөндлөнгийн байх” шаардлагыг хангахгүй гэж үзэж байна.

- Төрийн бүх байгууллагууд хуулийн хэрэгжилтийг жигд хангаж ажиллах нь зүйтэй
- Олон нийт, хөндлөнгийн үнэлгээ хийж буй байгууллага, төрийн бусад байгууллага НҮБ-ийн байгууллагууд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг дэлхийн хаанаас ч авах боломжийг практик дээр бодитоор хангах

Бага, дунд боловсролын тухай хуулийн 4.1 дэх заалт болох бага боловсролын агуулга, 5.1 дэх заалт болох суурь боловсролын агуулга болон 6.1 дэх болох бүрэн дунд боловсролын агуулга, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9.2 дах заалт болох техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь суралцагчид технологийн процессийг удирдах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэх бөгөөд ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэж, улмаар хэсэг тус бүрийн агуулга, Дээд боловсролын тухай хуулийн 3.2 дах хэсгийн дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр хэсэг тус бүрийн агуулгад “авлигыг үл тэвчих” хандлага, ёс зүйн хүмүүжлийн талаар хангалттай тодорхой байдаггүй тул энэ талаар нэмэлтээр оруулж өгөх шаардлагатай байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудсанд бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын хөтөлбөр, хичээл бүрийн хөтөлбөрийн минимум шаардлагыг тодорхойлсон мэдээлэл байхгүй байна.

Авлигатай тэмцэх газар нь авлигыг үл тэвчих хүмүүжлийг бага наснаас нь төлөвшүүлэх чиглэлээр дээр дэрдсэн олон төрлийн арга хэмжээ авч, сургууль, ТББ, олон улсын байгууллага, Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүртэл оролцуулж байгаа нь сайшаалтай байна. Цаашид төлөвлөгөөт буюу цаг үеийн шинжтэй арга хэмжээнээс тогтмолжсон, системтэй, заавал хэрэгжих түвшинд хүргэх шаардлагатай.

- Авлигыг үл тэвчих хүмүүжлийг нэг бие даасан хичээл болгож оруулах нь ахлах анги, мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд байж болох боловч хүүхдийн оюуны хөгжил, насны онцлогт нь тохирсон хэлбэрээр униших, монгол хэл, хүн нийгэм, иргэний боловсрол, хууль, эдийн засгийн суурь мэдлэг олгох хичээл бүрийн хөтөлбөрт суулгаж өгөх чиглэлээр Авлигатай тэмцэх газар, Боловсрол шинжлэх ухааны яам, ТББ-ууд хамтран ажиллах нь зүйтэй.
- Бүх шатны сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийн минимум шаардлагыг Боловсрол шинжлэх ухааны яам цахим хуудсандаа ил тод байршуулах нь эцэг, эх, сургууль, хүүхдийн хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой
- Хууль зүйн болон эдийн засгийн менежмент, нийгмийн ухааны чиглэлийн боловсролын хөтөлбөрийн агуулгад авлигыг үл тэвчих уур амьсгалыг бий болгоход чиглэсэн сэдвүүдийг түлхүү оруулах

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд ямар нэгэн хязгаарлалт тогтоогоогүй байна. Гэвч Иргэний хуулийн дагуу бусдын нэр төр алдар хүндийг гутаан доромжилж, гүтгэсэн мэдээлэл тараавал иргэний хариуцлага хүлээлгэхээр байна.

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд “бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх” гэдгийг оруулах шаардлагатай
- Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд сэтгүүлчийг эрүүгийн хариуцлагад татдаг явдлыг халахаар хэлэлцүүлэх явцад Конвенцийн энэхүү заалтын бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх талаарх хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд иргэний эрх зүйн хариуцлагаас өөр хариуцлага байх эсэхийг тухайн этгээдийг сэдэлт, зориуд санаатай тохиолдлын талаар нарийвчлан судлаж нэгэн зэрэг шийдвэрлэхийг зөвлөж байна.
- Нэг үе сэтгүүлчдийг эрүүгийн хэрэгт шийтгэж байсан. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл үүнийг зогсоож байгаа юм байна. Хоёр талруугаа хэт туйлширч байгаад бид болгоомжтой хандаж байна. Сэтгүүлчид худалдагддаг, “хаалтын гэрээ” байгуулдаг явдлаас хэрхэн гарах арга замыг Гэмт хэргийн тухай хуулиар шийдвэрлэж байна уу? Өөр ямар арга хэмжээ хэрэгтэй вэ гэдгийг нарийвчлан судлах шаардлагатай.
- Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд “үндэсний аюулгүй байдал, олон нийтийн дэг журам, олон нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” харилцааг нэмж тусгах

Үндэсний аюулгүй байдал, олон нийтийн дэг журам, олон нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахтай холбоотой практик мэдээллийг судалгааны энэхүү богино хугацаанд олж амжаагүй болно.

Авлигатай тэмцэх газар цахим хуудсаараа дамжуулан өөрийн чиг үүрэг, хийж байгаа ажлын талаар тогтмол мэдээллээр хангадаг, мөн олон нийтийн их ашигладаг цахим хуудсуудаар дамжуулан үйл ажиллагаагаа тайлагнадаг нь Конвенцийн авлигатай тэмцэх холбогдох байгууллагын талаар олон нийт мэдэж байх явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авах гэсэн шаардлагыг хангаж байна гэж үзэж байна.

Авлигын эсрэг хуулиар Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгтэй холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах, иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно /9.1/ гэж заасан нь Конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үүсгэж байна гэж үзэж болох аливаа тохиолдлын талаар мэдээлэхээр эдгээр байгууллагад зохих тохиолдолд хандах боломжоор хангана гэсэн шаардлагыг хангаж байгаа боловч нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана гэсэн шаардлагыг хангахгүй байна.

- Авлигын эсрэг хуульд Конвенцийн авлигатай холбоотой гэмт хэргийн талаар нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж олгох харилцааг зохицуулсан нэмэлт оруулах нь зүйтэй байна.

Энэхүү байгууллагууд дээрх аргаар иргэдээс мэдээлэл авах байдлыг хөнгөвчилсэн нь Конвенцийн заалтад нийцэж байна гэж үзэж байна.

Авлигатай тэмцэх газрын цахим хуудсаар Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын талаарх гомдол, Авлигатай тэмцэх газрын талаарх санал, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл өгөхөд гомдол, мэдээлэл гаргагчийн хувийн мэдээллийг шаарддаг бол Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын талаарх мэдээлэл өгөхөд мэдээлэл гаргагчийн хувийн мэдээллийг шаардахгүй байгаа нь бодит практикт нэргүй мэдээлэл авч Конвенцийн шаардлагыг хангаж байгаа юм байна.

Энэ нь Конвенцийн “үүнд нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана” гэсэн шаардлагад практик хэрэгжилтээрээ нийцэж байгаа боловч Авлигын эсрэг хуульд тодорхой зааж суулгаж өгөөгүй байгаа нь Конвенцийн шаардлагыг хангахгүй байна.

- Авлигатай тэмцэх газарт гомдол, мэдээлэл өгөхөд гомдол, мэдээлэл гаргагч хувийн мэдээллээ нууцалдаг байх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй

**Конвенцийн 14 дүгээр зүйл
аравдугаар бүлэг
мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

14.1. Оролцогч улс бүр:

14.1.(a). мөнгө угаах бүх хэлбэрийг таслан зогсоох болон илрүүлэхийн тулд банк болон банк бус санхүүгийн байгууллага, түүний дотор мөнгө буюу бусад үнэт зүйлийн шилжүүлгийн албан буюу албан бус үйлчилгээ үзүүлдэг хувь хүн буюу хуулийн этгээд, түүнчлэн ялангуяа мөнгө угаахад өртөх эрсдэлтэй бусад байгууллагад зохих тохиолдолд зохицуулалт, хяналтын дотоодын иж бүрэн дэглэмийг эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоох бөгөөд ийм дэглэм нь харилцагч болон зохих тохиолдолд жинхэнэ өмчлөгчийн хэн болохыг тогтоох, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавих шаардлагыг онцлон тогтооно;

14.1.(b). энэхүү конвенцийн 46 дугаар зүйлийг үл хөндөн, захиргаа , зохицуулалт, хууль сахиулах болон мөнгө угаахтай тэмцдэг эрх бүхий бусад байгууллага (дотоодын хуулийн дагуу зохих тохиолдолд шүүхийн эрх бүхий байгууллага) нь дотоодын хуульд заасан нөхцлийн хүрээнд үндэсний болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой байх явдлыг хангах бөгөөд үүний тулд мөнгө угааж байж болзошгүй гэсэн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх зорилго бүхий үндэсний төв болох санхүүгийн мэдээллийн нэгж байгуулах асуудлыг авч үзнэ.

14.2. Оролцогч улсууд хилийг нь дамжих бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах санхүүгийн зохих хэрэгслийн хөдөлгөөнийг илрүүлж, хянах талаар боломжит арга хэмжээ авах асуудлыг авч үзэх бөгөөд ингэхдээ мэдээллийг зохистойгоор ашиглах явдлыг хангах баталгааг мөрдөж, хөрөнгийн хууль ёсны хөдөлгөөнд саад болохгүй. Эдгээр арга хэмжээнд хувь хүн болон аж ахуйн нэгжийн их хэмжээний бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах санхүүгийн зохих хэрэгслийг хил дамжуулан шилжүүлсэн талаар мэдээлж байх шаардлага багтаж болно.

14.3. Оролцогч улсууд санхүүгийн байгууллага, үүний дотор мөнгө гуйвуулдаг байгууллагад дараах шаардлага тавих талаар хэрэгжих боломжтой бөгөөд зохих арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг авч үзнэ:

14.3.(a). мөнгөний цахим шилжүүлгийн маягт болон холбогдох мэдээнд шилжүүлэгчийн талаар үнэн зөв бөгөөд чухал мэдээллийг тусгах;

14.3.(b). ийм мэдээллийг төлбөр хийх явцыг бүх шатанд хадгалах;

14.3.(c). шилжүүлэгчийн талаар бүрэн мэдээлэл байхгүй мөнгөн шилжүүлгийн талаар нарийн шалгалт явуулах;

14.4. Энэ зүйлийн нөхцлийн дагуу зохицуулалт, хяналтын дотоодын дэглэм тогтоохдоо бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагаас мөнгө угаахын эсрэг холбогдох санаачлагыг удирдлага болгохыг улсуудад энэхүү конвенцийн аливаа бусад зүйлийг зөрчихгүйгээр уриалж байна.

14.5. Оролцогч улсууд мөнгө угаахтай тэмцэхийн тулд шүүх, хууль сахиулах болон санхүүгийн зохицуулалтын эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэлхийн, бүс нутгийн, дэд бүсийн болон хоёр талын хэмжээнд хөгжүүлж, дэмжихийг чармайна.

Мөнгө угаах бүх хэлбэрийг таслан зогсоох болон илрүүлэхийн тулд банк болон банк бус санхүүгийн байгууллага, түүний дотор мөнгө буюу бусад үнэт зүйлийн шилжүүлгийн албан буюу албан бус үйлчилгээ үзүүлдэг хувь хүн буюу хуулийн этгээд, түүнчлэн ялангуяа мөнгө угаахад өртөх эрсдэлтэй бусад байгууллагад зохих тохиолдолд зохицуулалт, хяналтын дотоодын иж бүрэн дэглэмийг эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоох бөгөөд ийм дэглэм нь харилцагч болон зохих тохиолдолд жинхэнэ өмчлөгчийн хэн болохыг тогтоох, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавих шаардлагыг онцлон тогтооно гэсэн Конвенцийн 14 дүгээр зүйлийн 14.1.(а)-д заасан эрх зүйн орчныг бүрдүүлэх үе шаттай арга хэмжээг төр засгаас авсаар байна.

УИХ-ын чуулганы 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар 2006 онд батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2004 онд батлагдсан Терроризмтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, 2003 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг тус тус баталсан.

Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны Үйл ажиллагааны Статистик Мэдээллийн сүүлийн 3 жилийн мэдээг түүвэрлэн авч судлавал 2011 оны IV улирлын статистик мэдээлэлд Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 71, Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 57, 2012 оны IV улирлын статистик мэдээлэлд Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 158, Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 110, 2013 оны IV улирлын статистик мэдээлэлд Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 285, Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 180 байсан байна.

Монгол Улс Мөнгө угаах ажиллагааны эсрэг хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, өөрийн орны санхүүгийн байгууллагын тогтолцоондоо нийцүүлэн Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг дотоодын дэглэмийг бий болгосон, тухайн үйл ажиллагааны эсрэг судалгаа, шинжилгээ, мэдээ мэдээлэл, баримт сэлт судлаж, бэлгэдэг тусгай бие даасан алба болох Монгол Банкны дэргэдэх Санхүүгийн Мэдээллийн Алба идэвхитэй үйл ажиллагаа явуулж, хууль сахиулах эрх бүхий байгууллагуудад мэдээлэл хүргэж байгаа хэдий ч Монгол Улсын аль ч шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 1661 зүйл буюу Мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилж, хэрэг хянан шийдвэрлэсэн практик шүүхэд байхгүй байна. Монгол Улс авлигын индексээрээ дээгүүрт жагсдаг орны хувьд авлигын замаар олсон хууль бус мөнгөний эх үүсвэр хэрхэн, ямар замаар эргэж, угаагддаг болох нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ тал дээр ямар нэгэн судалгааны хийгдээгүй байна.

- Монгол Улсын аль ч шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 1661 зүйл буюу Мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилж, хэрэг хянан шийдвэрлэсэн практик шүүхэд байхгүй байгааг энэ төрлийн хэрэг огт гардаггүй гэсэн үг биш бөгөөд энэ нь Монгол Улс авлигын индексээрээ дээгүүрт жагсдаг орны хувьд олон улсын үнэлгээ давхар нотолж байх тул, шүүх, хууль сахиулах

байгууллагын ажилтнуудын мэдлэг мэдээллийг дээшлүүлэх системтэй арга хэмжээг харилцан уялдаатай авч хэрэгжүүлэх

- Авлигын замаар олсон хууль бус мөнгөний эх үүсвэр хэрхэн, ямар замаар эргэж, угаагддаг болох нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ тал дээр нухацтай ажиглалт, судалгааг төрийн холбогдох байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хийж, түүний дүгнэлт, зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээ авах

2013 онд шинэчлэгдэн батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулиар мөнгө угаах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагад үндэсний болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой байх, гадаадын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн орчныг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн байна.

Энэхүү судалгаанаас үзвэл, СМА гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцох хамтын ажиллагаа аажмаар төлөвшиж байна. Энэхүү үнэлгээний явцад шүүх болон хууль сахиулах байгууллагын мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр гадаадын ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл солилцсон талаар тодорхой мэдээлэл бидэнд олдоогүй болно. Монгол Банкны Санхүүгийн Мэдээллийн Албаны цахим хуудсанд “Мөнгө, угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан хууль журмууд” гэсэн цэс байх боловч бидний судалгаа хийх хугацаанд “засвар хийгдэж байна гэсэн байдалтай” 2 долоо хоногийг өнгөрөөсөн. Санхүүгийн Мэдээллийн Албаны үйл ажиллагааны дүрэм, журам олдоогүй болно.

- Шүүх болон хууль сахиулах байгууллагын мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр гадаадын ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл солилцсон талаарх нууцад хамаарахаас бусад тоон болон чанарын мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх
- Санхүүгийн Мэдээллийн Албаны дээр дурдсан тус цэсийг ажилладаг болгох, нууцад хамаарахаас бусад мэдээллийг ил тод болгох. Нь тухайн байгууллагын талаарх төрийн бусад байгууллага, олон нийтийн ойлголтыг бий болгох авлига, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогддог тэмдэглэж байна.

Монгол Банк, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Хооронд Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Талаар Хамтран Ажиллах тухай журам нь 2008 оны 11 сарын 28-ны өдрийн 515/760 тоот тушаалын хавсралтаар батлагдсан бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан өөрчлөлт оруулаагүйгээс хүчингүй болсон хуулийн 15 дугаар зүйлд заасан мөнгөн дүнгийн хэмжээ буюу 5 сая төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютыг хилээр гаргадаа мэдүүлэх тухай шинэ хуульд нийцээгүй заалтаа мөрдсөн хэвээр байна.

Монгол Банкны Ерөнхийлөгч, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Даргын хамтарсан 2008 оны 11 сарын 28-ны өдрийн 515/760 тоот тушаалын хавсралтаар

батлагдсан “Монгол Банк, Улсын Гаалийн Ерөнхий Газрын Хооронд Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Талаар Хамтран Ажиллах тухай журам”-ын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн, хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаар мэдээлэл хомс байна.

- Эрх зүйн орчны хүрээнд Монгол банкны ерөнхийлөгч болон Гаалийн газрын дарга нарын хамтран баталсан тушаалыг 2013 онд шинэчлэгдэн батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуульднийцүүлэн “Хөрөнгийн чөлөөт хөдөлгөөн”-ий босго шалгуурт нийцүүлэн, нэмэлт өөрчлөлт оруулах, ийнхүү өөрчлөлт оруулахдаа 15 сая төгрөг түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаас гадна санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг нэмж тусгах оруулах.

Цахим шилжүүлгийн тогтолцоонд бусад санхүүгийн үйл ажиллагааны нэгэн адил мөнгөний цахим шилжүүлгийн маягт болон холбогдох мэдээнд шилжүүлэгчийн талаар үнэн зөв бөгөөд чухал мэдээллийг цуглуулах, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжоор өөрийн орны эрх зүйн тогтолцоо, банк, санхүүгийн байгууллагуудын тогтолцоо, онцлогт нийцүүлэн бүрдүүлсэн байна.

Практик хэрэгжилтийг судлан шинжлэх хүрээ өргөн, банк болон банкаас бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай тус бүртэй нь танилцах, судлах боломж хомс тул практик хэрэгжилтийг судлах боломжгүй байна. Энэ нь мэдээллийн нууцлалыг хадгалах шаардлагаас үүдэлтэй байж болох юм.

Банкны төлбөр тооцооны системийнн тогтолцооныхоо аль ч бүрэлдэхүүнд буюу Их дүнтэй төлбөр тооцооны систем, Бага дүнтэй төлбөр тооцооны системд оролцогч тал төлбөр тооцооны гүйлгээнийхээ тоо баримт, үнэн, зөв мэдээллийг өөрөө хариуцах шаардлагыг хуульд болон эрх бүхий байгууллагаас баталсан журмаар зохицуулсан байна.

Практик хэрэгжилтийн хувьд судлан шинжлэх хүрээ өргөн, банк болон банкаас бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай тус бүртэй нь танилцах, судлах боломж хомс тул практик хэрэгжилтийг судлах боломжгүй байна.

Шилжүүлэгчийн талаар бүрэн мэдээлэл байхгүй мөнгөн шилжүүлгийг нарийн шалгах харилцааг хуулиар, журмаар тодорхой хэмжээнд зохицуулсан байх бөгөөд сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг Санхүүгийн Мэдээллийн Албанд мэдээлэх журмыг Монголбанкны Ерөнхийлөгч баталсан. Тус журмын талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 10.1 дэх хэсгээс харна уу.

ПРАКТИК ХЭРЭГЖИЛТ-ийн талаарх мэдээлэл хомс байна. Зохих нууцлалыг хадгалах баталгааны үндсэн нарийвчилсан судалгаа шинжилгээ хийхийг зөвлөж байна.

2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр УИХ-аар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулинд тус тус холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улс ФАТФ-тай тохирсон ажлуудыг бүгдийг хийсэнд тооцсон байна. Ингэснээр 2014 оны 2 дугаар сарын 17-нд Францын Парис хотноо болсон ФАТФ-ын 22 дугаар чуулга уулзалтын үеэр энэ чиглэлд манай улсын гаргасан ахицыг өндрөөр үнэлж, Монгол Улсыг “хар саарал жагсаалт”-аас гаргаж зэрэглэлийг нь дээшлүүлсэн.

Монгол Улс бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагаас мөнгө угаахын эсрэг холбогдох санаачлагыг удирдлага болгон ажиллах талаар шаардлагатай, өөрөөс шалтгаалах хүчин чармайлт гаргаж байна гэж үзэж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүчин чармайлтаа үндэсний түвшинд холбогдох бүх байгууллагын үйл ажиллагаатай уялдуудах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна.

Прокурорын байгууллагын тухай хууль /2002 он/-д мөнгө угаах үйл ажиллагаа, түүний эсрэг авах арга хэмжээ, санхүүгийн зохицуулалтын байгууллагатай харилцах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй хэдий ч Прокурорын байгууллагын гадаад харилцааг зохицуулсан хууль зүйн орчин байна. Үүнд: “Улсын ерөнхий прокурор өөрийн эрх хэмжээний хүрээнд гадаад улсын ижил төстэй байгууллага, олон улсын байгууллагатай шууд харилцаж хамтран ажиллах, тэдэнтэй эрх зүйн туслалцаа үзүүлэх буюу гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар хэлэлцээр байгуулж болно.” – гэсэн нь Прокурорын байгууллагыг мөнгө угаах гэмт хэргийн эсрэг гадаад улсын байгууллагууд болон ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага мэдээлэл солилцох хууль зүйн орчинг бүрдүүлж байна.

Цагдаагийн албаны тухай хууль /2013 он/-д мөнгө угаах гэмт хэргийг судлах, илрүүлэхтэй холбоотой тусгайлсан зохицуулалт байхгүй боловч олон улсын цагдаагийн байгууллага (интерпол)-ын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, гадаад орны цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн нийт байгууллагыг хангах чиг үүргийг Цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлэх, 29 дүгээр зүйлийн 29.3-т: “Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсын хууль сахиулах байгууллага болон олон улсын цагдаагийн байгууллагад тэдгээрийн хүсэлтээр мэдээллийн сангаас мэдээлэл өгч болно.” – гэж тус тус зохицуулсан нь мөнгө угаах гэмт хэргийн эсрэг гадаад улсын болон ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага мэдээлэл солилцох боломжийг хууль зүйн хувьд бүрдүүлсэн байна.